БУДДАГИЙН СУРГААЛ

Дэлгэрэнгүй Хүүрнэл
Ботийн
Дээж

АРВАН СУДАР

Dīgha Nikāya

Паали Судруудын
Орчуулга

Bhikkhu Javana Ñāṇa

БУДДАГИЙН СУРГААЛ

Дэлгэрэнгүй Хүүрнэл
Ботийн
Дээж

АРВАН СУДАР

Dīgha Nikāya

Паали Судруудын
Орчуулга

Bhikkhu Javana Ñāṇa

ЗОХИОГЧИЙН ЭРХ

АРВАН СУДАР

Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн Дээж Арван Судар

Паали-Монгол орчуулга

Орчуулагч: Хувраг Жавана Ньяана
ORCID: 0009-0000-6271-4162
Хэвлэн нийтлэгч: Шан Мужийн Буддын Их Сургууль (SSBU)
Анхны цахим хэвлэл: 2026
Хувилбар: 1.0
Эх хэл: Паали
Орчуулгын хэл: Монгол
Зохиогчийн эрх: CC0 1.0 Universal

Энэхүү монгол орчуулгыг CC0 1.0 Universal Public Domain Dedication-ийн дагуу олон нийтийн өмч болгож байна. Хуулиар зөвшөөрөгдөх хэмжээнд орчуулагч энэхүү бүтээлд хамаарах зохиогчийн эрх болон холбогдох эрхүүдээс татгалзсан болно. Энэхүү орчуулгыг зөвшөөрөл авах шаардлагагүйгээр хуулбарлах, түгээх, дахин хэвлэх, өөрчлөх, орчуулах болон бусад хэлбэрээр ашиглах боломжтой.

Энэ орчуулга нь Паали Сударт (Pāḷi Canon) тулгуурласан бөгөөд Pali Text Society (PTS), World Tipiṭaka Mahāsaṅgīti, Chaṭṭha Saṅgāyana болон тэдгээрийн англи хэл дээрх эх сурвалжуудыг харьцуулан ашигласан болно.

Ten Selected Suttas from the Dīgha Nikāya: Mongolian Translation

Pāli-Mongolian translation

Translator: Bhikkhu Javana Ñāṇa
ORCID: 0009-0000-6271-4162
Publisher: Shan State Buddhist University (SSBU)
First digital edition: 2026
Version 1.0
Original language: Pāli
Translation language: Mongolian
License: CC0 1.0 Universal

About This Edition:

This volume presents a Mongolian translation of ten selected discourses from the Dīgha Nikāya (Collection of Long Discourses), one of the five collections of the Sutta Piṭaka of the Pāli Canon. This translation is grounded in the Pāli Canon and uses a comparative approach, drawing on the editions of the Pali Text Society (PTS), the World Tipiṭaka Mahāsaṅgīti, the Chaṭṭha Saṅgāyana, and English translations of these sources.

The volume contains translations of DN 1, DN 2, DN 9, DN 15, DN 16, DN 22, DN 26, DN 28, DN 29, and DN 31. The translations were prepared primarily from Pāli editions of the Dīgha Nikāya, with reference to traditional commentarial literature and selected modern translations and scholarly resources. The volume includes an account of the translator's methodological and terminological principles, together with notes, indexes, and bibliographical references intended to facilitate further study.

The translation seeks to render the Pāli texts into contemporary Mongolian while preserving important doctrinal and technical terminology. Pāli terms are retained where appropriate, particularly in notes and discussions of terminology, to facilitate comparison with the original texts and other translations. This is the first digital edition (Version 1.0), published in 2026. The Mongolian translation is dedicated to the public domain under the CC0 1.0 Universal Public Domain Dedication.

ТАЛАРХЛЫН ҮГ

Дэлгэрэнгүй Хүүрнэл Боть судруудын орчуулгыг Монгол уншигчдын гар дээр үнэ төлбөргүй хүргэх номын буяны ариун үйлсэд сэтгэл санаа болоод эд материалын туслалцаа үзүүлсэн Мьянмар улсын иргэд, У Зоу Мёо Аун болон Мө Мө Кайн нарын гэр бүлд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Ahaṃ pāḷipiṭakato Mongolia-bhāsaṃ parivattetvā Mongolia-raṭṭhikānaṃ dhammadānatthāya catupaccayanavakammato vā cittabalato vā dadantānaṃ Myanmar-raṭṭhato U Zaw Myo Aung kulānaṃ ca Daw Moe Moe Khaing kulānaṃ ca visesato bahūpakārabhāvaṃ kathemi, iminā puññakammena ca tāni kulāni atisīghaṃ visesādhigamaṃ sammā jānantūti patthanaṃ karomi.

ဘာသာပြန်သူအနေဖြင့် ပါဠိတော်မှ မွန်ဂိုးလီးယား ဘာသာသို့ ပြန်ဆိုပြီး မွန်ဂိုးလီးယားနိုင်ငံသားများအားလုံး မြတ်ဗုဒ္ဓရဲ့ တရားတော်ကို ဓမ္မဒါနပြုနိုင်ရန် အတွက် ပစ္စည်းအင်အား၊ စိတ်ခွန်အား စသည်ဖြင့် အဖက်ဖက်မှ ကူညီပေးခဲ့ကြသော ဦးဇော်မျိုးအောင် မိသားစု၊ ဒေါ်မိုးမိုးခိုင် မိသားစုတို့အား အထူးကျေးဇူး တင်ရှိပါသည်။ ဤကောင်းမှု၏ အဖို့ဘာဂကြောင့် မိသားစုဝင်များအားလုံး မဂ် ဖိုလ် နိဗ္ဗာန်သို့ မျက်မှောက်ပြုနိုင်ကြပါစေကြောင်း ဆုမွန်ကောင်း တောင်းအပ်ပါသည်။

ГАРЧИГ

Танилцуулга ix

Орчуулагчийн Үг xiii

Номын Хөтөч xiv

1. Бярман Тэнгэрийн Урхи Судар (Brahmajālasutta) xiv
2. Даянч Замналын Үр Өгөөж Судар (Sāmaññaphalasutta) xiv
3. Поттхапаада Судар (Poṭṭhapādasutta) xv
4. Хамаг Учир Шалтгаан Судар (Mahānidānasutta) xv
5. Агуу Нирваанд Нэгмөсөн Одохуй Судар (Mahāparinibbānasutta) xv
6. Агуу Дүүрэн-Анхаарал Суулгахуй Судар (Mahāsatipaṭṭhānasutta) xvi
7. Хүрд-Эргүүлэгч Судар (Cakkavattisutta) xvi
8. Итгэл Төрүүлэх Судар (Sampasādanīyasutta) xvi
9. Тааламжит Судар (Pāsādikasutta) xvii
10. Сигаалад Өгсөн Зөвлөмж Судар (Sigālovādasutta) xvii

Товчлол xviii

Паали Судрууд xviii
Англи Орчуулгууд xviii
Тайлбар Судрууд xix
Бусад xix

Аргачлал ба Нэр Томьёо xx

Аргачлал xx
Зарим Нэр Томьёоны Тайлбар xxii

DN 1. Бярман Тэнгэрийн Урхи Судар (Brahmajālasutta) 1

1.1. Тэнүүлч Бадарчдын Яриа (Paribbājakakathā) 1
1.2. Сахил-Ухамсар Хэсэг (Sīlakkhandha Vagga) 3
1.3. Өнгөрснийг Таамаглагч (Pubbantakappika) 14
1.4. Ирээдүйг Таамаглагч (Aparantakappika) 33
1.5. Өөрийн-Оршихуйн Нийтлэг Ойлголтын Үндэс (Attālokapaññattivatthu) 46

DN 2. Даянч Замналын Үр Өгөөж Судар (Sāmaññaphalasutta) 52

2.1. Сайд Нарын Мэдэгдэл (Rājāmaccakathā) 52
2.2. Жийвака Комаарабхаччагийн Өчил (Komārabhaccajīvakakathā) 54
2.3. Даянч Замналын Үр Өгөөжийн Тухай Асуулт (Sāmaññaphalapucchā) 55
2.4. Даянч Замналын Үр Өгөөж (Sāmaññaphala) 65
2.5. Ажаатасатту Хаан Шавь Болсноо Зарлав (Ajātasattuupāsakattapaṭivedanā) 97

DN 9. Поттхапаада Судар (Poṭṭhapādasutta) 99

9.1. Бадарчин Поттхапаада (Poṭṭhapādaparibbājakavatthu) 99

9.2. Читта Хаттхисаарипуттагийн Тухай (Cittahatthisāriputtapoṭṭhapādavatthu).......................122

DN 15. Хамаг Учир Шалтгаан Судар (Mahānidānasutta)...134
15.1. Учир Хамааралтай Уг Гарал (Paṭiccasamuppāda)...134
15.2. Өөрийн-Оршихуйг Төсөөлөхүй (Attapaññatti)...142
15.3. Өөрийн-Оршихуйг Эс Төсөөлөхүй (Naattapaññatti)...144
15.4. Өөрийгөө Эргэцүүлэн Тунгаахуй (Attasamanupassanā)......................................145
15.5. Оюун-Ухамсрын Долоон Орон (Sattaviññāṇaṭṭhiti)...148
15.6. Найман Ангижрал (Aṭṭhavimokkha)...151

DN 16. Агуу Нирвааанд Нэгмөсөн Одохуй Судар (Mahāparinibbānasutta)...............................153
16.1. Бярман Вассакаара (Vassakārabrāhmaṇa)...153
16.2. Доройтлоос Сэргийлэх Долоон Зүйлс (Rājaaparihāniyadhamma)..........................154
16.3. Хувраг Доройтохоос Сэргийлэх Долоон Зүйл (Bhikkhuaparihāniyadhamma)...........156
16.4. Саарипуттагийн Тунхаглал (Sāriputtasīhanāda)..163
16.5. Ухамсаргүй Байхуйн Үр-Дагавар (Dussīlaādīnava)..166
16.6. Ухамсартай Байхуйн Өгөөж (Sīlavantaānisaṁsa)..167
16.7. Паатали Цайзыг Босгосон нь (Pāṭaliputtanagaramāpana)......................................167
16.8. Гэгээнтний Үнэний Сургаал (Ariyasaccakathā)...170
16.9. Хойд Дүрд Төрөхгүйгээр Төгс Гэгээрэх Тавилан (Anāvattidhammasambodhiparāyaṇa)....172
16.10. Үнэнийг Тольдох Сургаал (Dhammādāsadhammapariyāya)....................................174
16.11. Эелдэг Эмэгтэй Амбапаалий (Ambapālīgaṇikā)...177
16.12. Велува Дахь Бороооны Улирлын Бясалгал (Veḷuvagāmavassūpagamana)................180
16.13. Илт Санаа Өгсөн нь (Nimittobhāsakathā)..183
16.14. Маарагийн Хүсэлт (Mārayācanakathā)..185
16.15. Амьдралын Үргэлжлэлээс Татгалзахуй (Āyusaṅkhāraossajjana).............................188
16.16. Агуу Газар Хөдлөлтийн Найман Шалтгаан (Mahābhūmicālahetu).............................188
16.17. Найман Чуулган (Aṭṭhaparisā)..189
16.18. Төгөлдөр Найман Орон (Aṭṭhaabhibhāyatana)..192
16.19. Найман Ангижрал (Aṭṭhavimokkha)..194
16.20. Аанандагийн Хүсэлт (Ānandayācanakathā)...198
Гэгээрлийн Гучин Долоон Зүйл (Bodhipakkhiyādhammā)..202
16.21. Зааны Адил Ширтэхүй (Nāgāpalokita)...204
16.22. Эрхэм Дөрвөн Шалгуур (Catumahāpadesakathā)...206
16.23. Дархны Хүү Чундагийн Түүх (Kammāraputtacundavatthu).......................................209
16.24. Ундны Ус Авчрав (Pānīyāharaṇa)..211
16.25. Малла Пуккусагийн Түүх (Pukkusamallaputtavatthu)...212
16.26. Ихэр Сал Модод (Yamakasālā)...218
16.27. Ахмад Хувраг Упаваана (Upavāṇatthera)..219
16.28. Сүсэг Бадраах Дөрвөн Газар (Catusaṁvejanīyaṭhāna)..220

16.29. Аанандагийн Асуултууд (Ānandapucchākathā)........221
16.30. Суварга Босгох Дөрвөн Хүмүүн (Thūpārahapuggala)........222
16.31. Аанандагийн Бишрэм Чанарууд (Ānandaacchariyadhamma)........223
16.32. Махаасудассанагийн Түүх (Mahāsudassanasuttadesanā)........226
16.33. Маллачуудын Мөргөл (Mallānaṁvandanā)........227
16.34. Бадарчин Субхадда (Subhaddaparibbājakavatthu)........228
16.35. Буддагийн Сүүлчийн Үгс (Tathāgatapacchimavācā)........232
16.36. Эцсийн Нирваан (Parinibbutakathā)........234
16.37. Буддагийн Шарилыг Дээдлэн Хүндлэхүй (Buddhasarīrapūjā)........237
16.38. Ахмад Хувраг Махаакассапагийн Тухай (Mahākassapattheravatthu)........239
16.39. Гэгээнтний Чандрыг Хуваарилсан нь (Sarīradhātuvibhajana)........241
16.40. Гэгээнтний Чандрыг Дээдлэхүй (Dhātuthūpapūjā)........243

DN 22. Агуу Дүүрэн-Анхаарал Суулгахуй Судар (Mahāsatipaṭṭhānasutta)........246
22.1. Биеийг Ажихуй (Kāyānupassanā)........247
22.2. Мэдрэмжүүдийг Ажихуй (Vedanānupassanā)........256
22.3. Сэтгэлийг Ажихуй (Cittānupassanā)........257
22.4. Үзэгдлүүдийг Ажихуй (Dhammānupassanā)........259
22.5. Дүүрэн-Анхаарал Суулгах Бясалгалын Үр Шим (Satipaṭṭhānabhāvanānisaṃsa)........282

DN 26. Хүрд-Эргүүлэгч Судар (Cakkavattisutta)........285
26.1. Өөртөө Авралын Арал Болохуй (Attadīpasaraṇatā)........285
26.2. Хүрд-Эргүүлэгч Далханеми Хаан (Daḷhanemicakkavattirājā)........286
26.3. Хүрд-Эргүүлэгчдийн Залгамжлал (Dutiyādicakkavattikathā)........290
26.4. Доройтлын Үе (Āyuvaṇṇādiparihānikathā)........290
26.5. Хүний Нас Арав Болох Цаг (Dasavassāyukasamaya)........293
26.6. Хөгжлийн Эрин (Āyuvaṇṇādivaḍḍhanakathā)........294
26.7. Санкха Хааны Үе (Saṅkharājauppatti)........295
26.8. Меттейяа Будда Төрөхүй (Metteyyabuddhuppāda)........296
26.9. Хувраг Хүний Урт Нас Хийгээд Гоо Үзэмж (Bhikkhunoāyuvaṇṇādivaḍḍhanakathā)........297

DN 28. Итгэл Төрүүлэх Судар (Sampasādanīyasutta)........300
28.1. Саарипуттагийн Тунхаглал (Sāriputtasīhanāda)........300
28.2. Хосгүй Гайхамшигтай (Acchariyaabbhuta)........315

DN 29. Тааламжит Судар (Pāsādikasutta)........317
29.1. Төгс Гэгээрээгүй Нэгний Сургаал (Asammāsambuddhappaveditadhammavinaya)........319
29.2. Төгс Гэгээрсэн Нэгний Сургаал (Sammāsambuddhappaveditadhammavinaya)........321
29.3. Шавь Нар Шаналахуй (Sāvakānutappasatthu)........322
29.4. Шавь Нар Эс Шаналахуй (Sāvakānanutappasatthu)........323
29.5. Төгс Бус Ариуслын-Замналын Сургаал (Brahmacariyaaparipūrādikathā)........324

29.6. Чуулан Дуудах Сургаал (Saṅgāyitabbadhamma)....328
29.7. Гажсан Ойлголтыг Засахуй (Saññāpetabbavidhi)....329
29.8. Хэрэгтэйг нь Олгохуй (Paccayānuññātakāraṇa)....330
29.9. Жаргал Эдлэхүй (Sukhallikānuyoga)....331
29.10. Жаргал Эдлэхүйн Ач Тус (Sukhallikānuyogānisaṁsa)....333
29.11. Төгсөрсөн Нэгний Хэрхэвч Үйлдэхгүй Үйл (Khīṇāsavaabhabbaṭhāna)....334
29.12. Асуултад Хариулахуй (Pañhābyākaraṇa)....335
29.13. Тунхаглаагүй Зүйлс (Abyākataṭṭhāna)....337
29.14. Тунхагласан Зүйлс (Byākataṭṭhāna)....338
29.15. Өнгөрсний Таамаглалаас Үүдсэн Үзэл (Pubbantasahagatadiṭṭhinissaya)....339
29.16. Ирээдүйн Тухай Таамаглалаас Үүдсэн Үзэл (Aparantasahagatadiṭṭhinissaya)....342

DN 31. Сигаалад Өгсөн Зөвлөмж Судар (Sigālovādasutta)....345
31.1. Зургаан Зүг (Cha disā)....345
31.2. Сэтгэлийн-Хирийн Дөрвөн Үйл (Cattāro kammakilesā)....346
31.3. Дөрвөн Хүчин Зүйлс (Catuṭhānaṁ)....347
31.4. Гарлагын Үүдийг Нээгч Зургаан Үйл (Cha apāyamukhāni)....347
31.5. Согтууруулах Ундаанаас Үүсэх Зургаан Үр-Дагавар (Surāmerayassa cha ādīnavā)....348
31.6. Зохисгүй Цагаар Гадуур Зугаалахын Зургаан Үр-Дагавар (Vikālacariyāya cha ādīnavā)....348
31.7. Үзвэр Цэнгээнд Үргэлж Автахын Зургаан Үр-Дагавар (Samajjābhicaraṇassa cha ādīnavā)....348
31.8. Мөрийтэй Тоглоомын Зургаан Үр-Дагавар (Jūtappamādassa cha ādīnavā)....349
31.9. Муу Нөхдийн Зургаан Үр-Дагавар (Pāpamittatāya cha ādīnavā)....349
31.10. Залхуугийн Зургаан Үр-Дагавар (Ālasyassa cha ādīnavā)....350
31.11. Хуурамч Найз (Mittapatirūpaka)....351
31.12. Жинхэнэ Найз (Suhadamitta)....353
31.13. Тэнгэрийн Зургаан Хаяа Зовхист Аврал Одуулахуй (Chaddisāpaṭicchādanakaṇḍa)....354

Нэр Томьёоны Лавлах....360

Индекс....374

Ном Зүй....384
Паали Эх Сурвалж....384
Англи Орчуулга....384
Судалгааны болон Тайлбар Бүтээл....385
Цахим Эх Сурвалж....386
Тайлбар....386

Төгсгөл Үг....387

Холбоос....388

ТАНИЛЦУУЛГА

МЭӨ 483 онд буюу Готама Будда Эцсийн Нирвaанд одсоноос даруй 90 хоногийн дараа хүндэт хувраг Махаакассапагийн[1] удирдан хөтөлсөн, Буддагийн шавь хуврагуудын Анхдугаар Чуулган Раажагахад[2] болсон байна. Энэ хуралдаан дээр эрхэм хувраг Аананда[3] Судрын Аймгийн Багц (*Suttanta Piṭaka*) судруудыг, эрхэм хувраг Упаали[4] Сахилын Аймгийн Багц (*Vinaya Piṭaka*) судруудыг цээжээр айлджээ. Буддаг үгүй болсон цагаас эхлэн түүний номыг өөрчлөх, өөрөөр тайлбарлах, сахил санваарыг сулруулах, багасгаж цөөлөх гэх зэрэг хандлага цухалзаж эхэлсэн бөгөөд энэ явдлыг цэгцлэх үүднээс Будда амьд ахуйдаа айлдсан гол номыг энэ хоёр эрхэм хувраг эмхэтгэн айлдсан хэрэг. Иймээс эдгээр хоёр багц судрууд нь Будда шавь нартаа чухам өөрөө айлдсан байж болох хамгийн эртний судрууд болж түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байна. Тэгвэл Дэлгэрэнгүй Хүүрнэл Боть (*Dīgha Nikāya*) нь Судрын Аймгийн Багцын нийт таван ботийн эхний боть нь юм.

Анхны чуулганаас 200 орчим жилийн дараа буюу МЭӨ 250 оны үед Ашока[5] хааны ивээл дор зохиогдсон Хуврагийн III Чуулган нь *Abhidhamma Piṭaka* буюу Дээд Номын Багц судруудыг дээрх хоёр судрын багцад нэмсэн байна. Буддын хамгийн эртний болох, магадгүй хамгийн бага нэмэлт өөрчлөлт орсон, Tipiṭaka буюу “Гурван Сагс” гэж нэрлэгдсэн Паали Судар (Pāḷi Canon) нь ийнхүү тулгын гурван чулуу мэт биеийг олж бидэнд өвлөгдөн ирэх болсон түүхтэй аж. Эдгээр гурван багц судрууд нь “буддизм” гэж өөрийгөө тодорхойлдог буддын бүх урсгалд, Готама Буддагийн заасан ном хэмээн хүлээн зөвшөөрөгддөг байна.

Дийлэнх монголчуудын буддын ном сургаалын талаарх ойлголт нь МЭ I зууны үеэс үүсэлтэй Их Хөлгөний[6] урсгал, түүнчлэн XIV зуунаас Төвөдөд дэлгэрсэн Гэлүгва[7] ёс буюу Шарын шашны сургаал, ёс заншил, зан үйлтэй холбоотой байсаар ирсэн гэж хэлж болох юм. МЭ VIII зуунаас эхлэн эртний Энэтхэгийн буддын янз бүрийн урсгалын судрууд, тайлбаруудыг Энэтхэг болон Төв Азийн хэлнээс төвөд хэл рүү орчуулж эхэлсэн байдаг. Эдгээрийн зарим нь хятад болон самгарди хэл дээр хадгалагдан үлдсэн судруудтай (хят. 長阿含經; сам. *Dīrgha Āgama*) утга агуулгын хувьд ойролцоо юм. Гэвч эдгээр судрын төвөд орчуулгын уламжлалд зарим тохиолдолд хожуу үед бий болсон утга санаа, нэмэлт тайлбарын шинж тусгагдсан байж болох талаар орчин цагийн буддын судлалд хэлэлцдэг байна.

---

1 *Mahākassapatthera*—“хүндэт хувраг Махаакассапа”. Төгс Гэгээнтэн, Буддагийн арван шадар хуврагийн нэг.

2 *Rājagaha*—“Раажагаха”. Эртний Магадха улсын нийслэл буюу одоогийн Энэтхэгийн Бихар мужийн Ражгир хот.

3 *Ānandatthera*—“эрхэм хувраг Аананда”. Буддагийн үеэл, шадар туслах, хосгүй ой тогтоолттой, Төгс Гэгээрсэн 500 Арахантуудын нэг.

4 *Upālitthera*—“эрхэм хувраг Упаали”. Буддагийн ахмад арван хуврагийн нэг. Хуврагийн дээд сахилын өндөр мэдлэгтэй, үсчин доод анги давхаргаас гаралтай, Төгс Гэгээрсэн 500 Арахантуудын нэг.

5 *Aśoka Maurya*. Магадха улсын хаан (МЭӨ 268-232) бөгөөд Буддагийн номыг түгээхэд их хувь нэмэр оруулсан нэгэн гэж түүхэнд тэмдэглэгдэж үлджээ.

6 Их Хөлгөн. па. сам. *Mahāyāna* буюу “Агуу Хөсөг Тэрэг” гэсэн утгатай. МЭ эхний зуунуудын үед Энэтхэгт үүсэж хөгжсөн Буддын томоохон урсгал (Encyclopedia Britannica, “Mahayana”, 2026).

7 Гэлүгва. Төвөдийн Буддизмын гол урсгалуудын нэг. XIV-XV зууны үед Зонховын уламжлалаас үүссэн бөгөөд “Шар малгайтны урсгал” гэж нэрлэх нь бий (Encyclopedia Britannica, “Tibetan Buddhism”, 2026).

Улмаар төвөд хэлнээс монгол хэл рүү дамнан орчуулагдсан Ганжуур[8], Данжуурын[9] түүвэр судрууд нь буддын сургаалын гол эх сурвалж мэтээр танигдаж, эртний паали хэл (*pāḷi*) дээр хадгалагдан үлдсэн эртний буддын сургаалын хамгийн эртний давхаргад хамаарна гэж үздэг Паали Судрын талаарх мэдлэг, ойлголт нь манай сүсэгтэн олны дунд өнөөг хүртэл хомс байсаар иржээ. Тэгвэл энэхүү Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн судрууд нь паали эхээ шууд дагасан орчуулга бөгөөд судар тус бүрийн агуулга, тоо хэмжээ, дараалал нь хятад, самгарди судрууд болон төвөд Ганжуурын хувилбаруудаас нэлээд ялгаатай юм. Тэр утгаараа энэ орчуулга нь Буддагийн сургаалын эртний уламжлалтай илүү ойр хэлбэрийг, паали эхэд тулгуурласан байдлаар уншиж судлах, улмаар өнөөгийн хэвшмэл ойлголттой харьцуулан шинжлэх боломжийг монгол уншигч, судлаачдад анх удаа нээж өгч буйгаараа онцгой ач холбогдолтой байж болох юм.

Готама Будда ном сургаалаа зааж, амьдран сууж, аялан даянчилж асан газар нутаг болох эртний Магадха (*Magadha*) улс болон ойр орчмын олон овог аймгийн эх хэл нь болох магадхи пракрит (анг. *magadhi prakrit*, па. *māgadhī*) хэлнээс паали хэлийг үүссэн гэж дийлэнх хэл шинжээч, эрдэмтэд үзэх бөгөөд харин орчин үед паали хэл нь ердөө судрын хэл болж үлдсэн байна. Зарим судлаачид Будда номоо паали хэл дээр айлдсан гэж үздэг ч өнөө цагт үүнийг шууд батлан харуулах боломжгүй зүйл болжээ. Учир нь өнөөдөр магадхи пракрит эсвэл паали хэлээр ярьдаг улс үндэстэн гэж нэгэнт үгүй болсон юм. Паали хэл нь магадхи пракрит хэлнийхээ бичгийн хэл нь юм, эсвэл паали хэл нь эртний магадхи пракрит хэлнээсээ ихэд хувьсан өөрчлөгдсөн, бүр эсвэл хоёр хэл хоорондоо тун бага ялгаатай гэх зэрэг санаан дээр эрдэмтдийн байр суурь зөрүүтэй байна. Ямартаа ч магадхи пракрит буюу паали хэл нь Энэтхэг-Европ хэлний язгуурын, Энэтхэг-Ари (анг. *Indo-Aryan*) аялгуунд хамаарах хэл бөгөөд энэ утгаараа самгарди, синхал, мьянмар, тай болон уг язгуурын орос, герман, англи хэлтэй хэлзүйн зарим түвшинд ижил төстэй хэл юм.

Түүнчлэн, Сахилын Аймгийн Багцын сударт[10], Буддагийн сургаалыг аливаа нэг газар орны хүмүүс өөрсдийн хэл аялгаар цээжилж уламжлуулахыг зөвшөөрсөн тухай гардаг. Ямэлу, Тэкула хэмээх хоёр бярман гаралтай хувраг Буддагийн сургаалыг “чандаса” (*chandasa*) хэлбэрт оруулахыг хүсэхэд Будда үүнийг хориглосон тухай тэмдэглэгдэн үлджээ. “Чандаса” гэх үгийг орчин үеийн судлаачид ведийн хэл найруулга, самгарди хэл, эсвэл шүлэглэсэн уншлагын хэлбэр гэх мэтээр ялгаатай тайлбарладаг боловч, дийлэнх тохиолдолд Будда сургаалыг тухайн үеийн бярман шашны тарни маани, утга зохиолын хэв маягт оруулахыг дэмжээгүй хэмээн үздэг байна. Харин “өөр өөрсдийн хэл аялгаар” (*sakāya niruttiyā*) сургаалыг цээжилж уламжлуулахыг зөвшөөрсөн явдал бол эртний буддын сургаал нь эгэл ард олны өдөр тутмын хэл ярианд илүү ойр байсан байж болохыг илтгэнэ.

---

8 Ганжуур: *Kangyur*—བཀའ་འགྱུར། (төв. “Зарлиг буулгасан үгс”). Энэтхэг хэлүүдээс төвөд рүү XIV зуунд Будон Ринчэн Дүв эмхэтгэж, XVIII зуунд эцсийн байдлаар засан тохируулагдсан (Encyclopedia of Buddhism, 2026).

9 Данжуур: *Tengyur*—བསྟན་འགྱུར། (төв. “Шастирын орчуулга”). XIV-XVIII зуунд Будон Ринчэн Дүв, Чонэй Лама Дагва Шадүв нар эмхэтгэсэн тайлбар бүтээлүүдийн цогцолбор (Encyclopedia of Buddhism, 2026).

10 *Vinaya Piṭaka, Cullavagga* V.33.

Буддагийн заасан энэхүү номыг орчин цагийн бидэнд өвлүүлэн үлдээхийн тулд, өнөө цагт бид Судрын Аймгийн Багц (нийт 5 боть[11]), Сахилын Аймгийн Багц (нийт 5 боть[12]) гэж нэрлээд байгаа эдгээр судруудыг хуврагууд[13] боть тус бүрийн нэрээр өөр өөр бүлгэм болон хуваагдаж, өөрийн бүлгэмийн номоо цугтаа дуудан уншдаг тогтсон уламжлалтай байж. Ингэснээр цаас хараахан үүсээгүй байсан тэр эрт цагаас эхэлсэн энэ нэн урт хугацааны туршид хийдэд шинээр нэгдэн ирсэн шинэ хуврагууд, номоо цээжээр дууддаг хуучин хуврагуудаасаа номыг сонсголоороо цээжлэн авч дараа дараагийн үедээ өвлүүлэн явсаар иржээ. Эдгээр нийтээрээ дууддаг уншлага нь ямар нэгэн “шидэт” тарни маани огтоос биш бөгөөд энэ л Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн судрууд болон бусад судруудын нэгэн адил, эгэл жирийн паали үг хэлээр тайлбарласан, Буддагийн заасан аман сургаал нь юм. Энэ уламжлал өнөө цагт ч Мьянмар болон Шри Ланкад оршсоор байгаа билээ.

Монголчууд айраг таргийн хөрөнгөө идээ сайтай айлаас залж өөрийн сааль сүүтэйгээ хольж тогтсон зөв аргачлалаар нь боловсруулснаар, яг л тэр хөрөнгө авсан айлынхаа идээ ундаатай нь ижил болгодог уламжлалтай нэгэн адил, сургаал номыг уламжлуулах тийм уламжлал олон зууныг дамжин өвлөгдсөөр иржээ. Хийдэд сахил аван нэгдсэн шинэ хувраг төдийгүй, Буддагийн заасан номын дагуу шинэ газар оронд хийд байгуулж буй хүмүүс ч мөн ялгаагүй, тэрхүү ёс уламжлалаа хуучнаар нь өвлөн авч яваа, цээжилсэн судар нь зөв үнэнд тооцогдох, сахил санваар, явдал суудал нь ариун ахмад хуврагуудаас, тэдний хийдээс эдгээр ном уламжлалыг өвлөн авч нутагшуулдаг байж.

Хуврагуудад номыг цээжлэхэд хялбар байлгах үүднээс дийлэнх судрууд, тэр дундаа Дэлгэрэнгүй Хүүрнэл Боть нь их хэмжээний дахилт давталттай, бүр нуршилт ихтэй ч гэмээр шинжтэй болсон гэж олон судлаачид үздэг байна. Түүнчлэн, паали хэл дээр байгаа эдгээр судрууд нь уг хэлний өөрийн онцлог шинж байдал, мөн сүүл холболт (анг. *rhyme*) гэмээр хэсгүүд, тэр дундаа үйл үгийн өнгөрсөн цагийн төгсгөлийн өөр хоорондоо тун ойролцоо сонсогдох авиа дуудлага их байгаа юм. Тиймдээ ч эдгээр судруудыг нийтээрээ уншин дуудаж байгаа хуврагууддаа ч, энэ дууг нь сонсож байгаа хүмүүстээ ч, энэхүү ном нь чихнээ сонсголонтой, утга уянгатай, төгс яруу мэдрэмжийг өгөхүйц өвөрмөц шинжийг агуулжээ. Энэхүү аман уламжлалын хажуугаар навч, модон дээр бичих, сийлэх арга байсан ч халуун орны өндөр чийгшилтэй газар оронд эдгээр нь удаан тэсдэггүй байсан төдийгүй хуучин хуулбараас шинэ хуулбарт буулгах явцад судрын агуулгад засвар өөрчлөлт орох тохиолдол гарах сул тал ч байжээ. Зарим судлаачид, аман уламжлал нь бичгийн уламжлалаасаа илүү итгэл найдвартай байдлаар, номын үг өгүүлбэр нь хуучин хэвээр уламжлагдах сайн талтай байсан гэж дүгнэсэн байна.

---

11 Үүнд: 1. *Dīgha Nikāya* (Дэлгэрэнгүй Хүүрнэл Боть); 2. *Majjhima Nikāya* (Дунд Хүүрнэл Боть); 3. *Saṃyutta Nikāya* (Уялдаа Бүхий Боть); 4. *Aṅguttara Nikāya* (Тоон Боть); 5. *Khuddaka Nikāya* (Жижиг Боть).

12 Үүнд: 1. *Pārājika Pāḷi;* 2. *Pācittiya Pāḷi;* 3. *Mahāvagga Pāḷi;* 4. *Cūḷavagga Pāḷi;* 5. *Parivāra Pāḷi.*

13 *Bhikkhu*—Хувраг (сам. *bhikṣu*). Үгчилбэл, “гуйлгачин”. Буддагийн шавь болж хуврагийн Дээд Сахил (па. *Upasampadā*) авсан, ариун ёсны 227 сахил сахигч. Энэ орчуулгад зөвхөн Буддагийн шавь хуврагт “хувраг”-ийг хэрэглэнэ.

Энэхүү эрт үеэс өвлөн аваад элдэв нэмэлт өөрчлөлт оруулаагүй багц судрууд нь Тхераваада Буддизм[14] (Theravāda Buddhism) буюу "Ахмадын Сургаал" гэж орчуулагддаг, зарим тохиолдолд "Эртний Буддизм" гэж нэрлэгддэг энэ урсгалын дагаж мөрддөг гол ном нь, Буддагийн захиж үлдээсэн ариун зарлиг нь болжээ. МЭӨ нэн эрт цагаасаа уламжлал нь тасраагүй, Буддагийн унаган номын утгыг өөрчлөөгүй, шинээр ном судар нэмж зохиогоогүй, хэн нэгэн гэгээнтэн гэгдсэн хожуу цагийн лам, хар хүмүүсийн номлол хийгээд нөлөөнд автаагүй байж болох Эртний Буддизм нь өнөө цагийн Мьянмар, Шри Ланка, Тайланд, Лаос, Камбож зэрэг улсуудын албан ёсны шашин төдийгүй Их Британи, Австрали, Канад, АНУ болон Европын олон оронд сүүлийн үед хурдацтай түгэн дэлгэрээд байна. Барууны орны олон тооны аялагч, номлогч, судлаачид 1800-аад оны үеэс эдгээр Зүүн Өмнөд Азийн орнуудаар аялж амьдарч, тэр бүү хэл зарим нь хийдэд шавилан сууж Паали Судрыг сурснаар Буддагийн энэ ном герман, англи хэлэнд орчуулагдаж эхэлсэн ба энэ явдал нь өнөө цагийн барууны орны залуучуудад Эртний Буддизм болон Буддагийн заасан ариуслын замналыг сэтгэлийн угаас итгэн дагах гол гүүрийг тавьж өгчээ. Түүнчлэн Паали Судрын орчуулгын үр өгөөжөөр орчин цагийн *Mindfulness* Бясалгал, *Vipassanā*[15] бясалгал болон бусад сэтгэл заслын олон арга туршлага эрүүл мэндийн салбарын хэрэглээнд ч өргөн нэвтэрч эхэлсэн билээ.

---

14 Энэ урсгалыг "Бага Хөлгөн" ("*Hinayana*") гэж нэрлэх явдал байдаг нь уг нэршлийн түүхэн болон хэл шинжлэлийн ташаа ойлголттой хүмүүсийн дунд голдуу ажиглагддаг. Монгол хэлэнд "бага хөлгөн" гэж орчуулагдсан, самгарди хэлээр "жижигхэн, өчүүхэн хөсөг тэрэг" гэх утгатай *hinayana* гэх энэ үг нь эрт цагийн доромж нэршил юм. Буддаг Нирваанд одсоноос 600-1000-аад жилийн дараа үүсэн бий болсон шашны шинэ хөдөлгөөн, урсгалууд (Их Хөлгөн г.м.) нь хуучны уламжлалаа дагагч урсгалуудаа (*Sarvāstivāda*, *Vātsīputrīya*, *Mahāsāṃghika* г.м.) ийм нэрээр доромжлон нэрлэх болсон байна. 1950 онд Коломбод болсон Дэлхийн Буддистуудын Чуулганаар (WFB) энэ нэршлийг ямар нэг байдлаар хэрэглэхийг хориглож Theravāda нэршлээр солихыг бүх нийтийн саналаар дэмжсэн шийдвэр гарсан байдаг. Монгол улс энэ байгууллагын албан ёсны гишүүн юм. Тэр утгаараа "*Hinayana*" эсвэл "Бага Хөлгөн" гэх нэршлийг орчин цагийн Буддын сургаал, сурах бичиг, мэдээллийн талбарт хэрэглэх нь түүхэн болон ёсзүйн хувьд тун зохисгүй үйлдэл болох юм.

15 *Vipassanā*—"илтэд харахуй", "саруул тунгалгаар харахуй". Орчин үеийн *Vipassana* бясалгал гэх ойлголт нь *Mahāsatipaṭṭhānasutta,* эсвэл *Visuddhimagga* тайлбар судар болон бусад аргачлалд суурилсан бясалгалын нэг хэлбэрт өгсөн хожуу цагийн нэршил. Зарим олон улсын сүлжээ бясалгалын газрууд нь XIX-XX зуунаас үүссэн байж болох ийм бясалгалын төрлийг "Випашяна", "Амьдрах Урлаг", "MBSR" гэх зэргээр нэрлэсэн нь бий.

ОРЧУУЛАГЧИЙН ҮГ

Энэхүү Арван Судар нь *Dīgha Nikāya* буюу Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн нийт гучин дөрвөн судраас сонгож авсан, утга агуулга болоод ач холбогдлын хувьд шилэгдмэл хэмээн үзэж болохуйц, дээж нь гэж үнэлэхүйц арван судрын орчуулга юм. Энэхүү орчуулгыг хийхдээ Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн паали эхүүд болох “Pali Text Society” (PTS), “World Tipiṭaka Mahāsaṅgīti”, “Chaṭṭha Saṅgāyana” хувилбаруудыг гол эхээ болгон ашигласан бөгөөд эдгээрийн дижитал болон хэвлэмэл англи орчуулгуудыг нэгэн зэрэг харьцуулан авч үзэв. Англи эх сурвалжийн хувьд, Bhikkhu Bodhi (1989), Bhikkhu Sujato (2018), Myanmar Pitaka Association (2010), Maurice Walshe (1987), Rhys Davids, T. W. & Rhys Davids, C. A. F. (1899-1921) нарын орчуулгуудтай тулган орчуулсан болно.

Энэ орчуулгыг хийхдээ эх хувилбарын үг өгүүлбэрийн үндсэн бүтэц, шинж байдлыг аль болох хэвээр нь хадгалахыг оролдсон ба утгад суурилсан аргачлал ашиглаж орчин цагийн энгийн ярианы монгол хэлэнд буулгах гэж зорьсон юм. Цөөнгүй паали нэр томьёог “монголчилсон” бөгөөд ингэхдээ Монголд байгаа зарим буддын шашны урсгалын тогтсон үг хэллэгийг ашиглаагүй болно. Учир нь тэдгээр тогтсон үг хэллэгүүдийн зарим нь орчин цагийн монгол хэлний энгийн ярианы хэрэглээнд эзлэх байр суурь нь багассан гэж үзсэн, мөн тэдгээртэй дүйцэх паали үгийн утгыг тайлбарласан нэр хүндтэй судлаачдын хувилбартай утга агуулга нь яв цав нийлэхгүй байсантай холбоотой юм.

Түүнчлэн, дийлэнх зүүлт тайлбарт (анг. *footnote*) паали эх үгийг нь хавсаргасан явдал нь уншигч, судлаач хүмүүст уг үгийг өөр бусад эх сурвалжаас илүү гүнзгий судлах боломжийг олгох гэсэн хэрэг билээ. Эдгээр зүүлт тайлбаруудыг хэлзүйн болон утгын, мөн харьцуулсан орчуулгын тайлбарууд гэж ойлгож болох юм. Зарим орчуулгад паали эх хувилбарын нэгэн онцлог болох маш олон дахилт давталттай хэсгүүдийг хасах товчлох явдал түгээмэл байдаг ч, энэ орчуулгад ямар нэг дахилт давталт хэсгийг огт хасалгүй бүрнээр нь оруулсан билээ. Эртний уламжлалыг бүрэн гүйцэд хадгалсан гэж үздэг Tipiṭaka-гийн нэгээхэн хэсэг болох энэ судрын орчуулгыг хийхдээ ямар нэг хэмжээгээр хэт үгчилсэн, эсвэл шашны туйлширсан байр сууринаас хандах нь өөрөө эргээд уг номын гүнзгий утгыг алдагдуулах эсвэл бүр энэ номоо устгах ч тал бий гэж үзсэн юм. Ийм ч болохоор орчуулгыг хийхдээ Буддагийн сургаал номыг ойлгох явдал нь нэн чухал гэсэн байр суурин дээр зогссон гэдгээ хэлэх юун. Нөгөө талаас гэвэл, энэ орчуулга бол эртний Паали Судрын төгс монгол хувилбар бус, харин цаашдын шүүн тунгаалт, эрдэм шинжилгээний хэлэлцүүлэгт нээлттэй эх сурвалж болгох зорилготой гэж үзэж болно.

Өнөө цагт эдгээр судрын орчуулга нь англи, орос, герман, франц, унгар, чех, эстони зэрэг 20 гаруй хэл дээр орчуулагдсан байгаа тул тэдгээр хэлийг сайтар эзэмшсэн хүмүүсийн хувьд, уг номыг харьцуулан харж ойлгох эсвэл зөвхөн тэдгээр хэл дээр ч эдгээр эртний судруудыг илүү гүнзгий түвшинд судлах боломж нээгдсэн билээ.

Хуврag Жавана Ньяана
(Bhikkhu Javana Ñāṇa)

НОМЫН ХӨТӨЧ

Эдгээр арван судрыг Эртний Буддизмын амин сүнсийг өөртөө агуулсан, анхлан суралцагчдад ул суурьтай мэдлэг болж болохоор, бясалгал болон гүн ухаан сонирхогчдод үнэтэй мэдээлэл болж чадахаар утга агуулгыг өөртөө шингээсэн байна гэж үзээд сонгосон бөгөөд энэхүү Номын Хөтөч хэсэгт уг номд багтсан арван судрын ерөнхий агуулга, түүхэн байр суурь, мөн уншигч эрхэм анхаарвал зохилтой байж болох зарим онцлогийг тун товч танилцуулав.

1. Бярман Тэнгэрийн Урхи Судар—DN 1. Brahmajāla Sutta

Бярман Тэнгэрийн Тор ч гэж нэрлэж болох энэ судрын зарим хэсэг нь Буддагийн шавь гэж өөрийгөө үзэж буй хувраг болон шавь хүмүүний дагах учиртай сахил санваарын тухай ба дийлэнх хэсэг нь биднийг дараа төрлийн чиг хандлагыг тодорхойлоод байгаа урхи тор мэт 62 буруу үзэл, мөн эдгээрийн учир шалтгааны тухай юм. Эдгээр буруу үзлүүд нь ангилал, дэс дараалалтайгаар нэг судартбүгд багтан тайлбарлагдсан тохиолдол бол Паали Судрын дотроос зөвхөн энэ DN 1 болж таарах юм. Энэ судар бол маргаангүй нэн эртний судар бөгөөд паали үг хэллэг нь хүртэл энэхүү эртний гэсэн санааг батлах мэт харьцангуй хожуу үеийн (МЭӨ 250 оны үеийн *Abhidhamma Piṭaka* г.м.) судруудаас нэлээд ялгаатай байна.

2. Даянч Замналын Үр Өгөөж Судар—DN 2. Sāmaññaphala Sutta

Энэ судар нь мөн адил Буддагийн шавь гэж өөрийгөө үзэж буй хувраг болон шавь хүмүүний дагах учиртай сахил ёс болон буруу үзэлд автсан зургаан багшийн жишээ, түүнчлэн гэгээрлийн замаар замнахын учир шалтгаан, үүний үр өгөөж, хувраг хүний шат түвшин ахидаг ариусал бясалгалын тухай юм. Энэ судар бол Буддын олон урсгал үүсэхээс өмнөх цаг үед хамаарах, мөн маргаан үгүй нэн эртний судар билээ. Үүний нэг жишээ нь л гэхэд энэ судартБудда, хувраг хүн эзэмшиж болох хоёр л зүйл байх тухай дурдсан байна. Тэр хоёр нь ердөө бие халхлах орхимж даавуу болон бадар гуйх вааран сав (Бадрын аяга) юм гэжээ. Эрт цагт үүнээс өөр эд хөрөнгө гэх зүйлс хувраг хүмүүнд байдаггүй, байх ч учиргүй байжээ хэмээн үүнийг ойлгож болохоор байна. Тэгвэл арай хожуу үед хамаарах *Vinaya* ёсонд хувраг хүн найман эд зүйлийг (гурван орхимж даавуу, аяга, сахлын хутга, зүү утас, бүс, ус шүүгч) өмчилж болдог тухай байна. Аль ч утгаараа DN 2 бол Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн шигтгээ болсон, хувраг хүний ариун замналыг тайлбарласан, нэн чухал судар мөн юм.

3. Поттхапаада Судар—DN 9. Poṭṭhapāda Sutta

Өмнөх хоёр судартзаасан Буддагийн шавь хүмүүний дагах учиртай сахил энд мөн давтагдах бөгөөд энэхүү сахилаас үүсэн бий болдог төвлөрөл, мөн энэхүү төвлөрлөөс үүсэн бий болдог бясалгалын өөр өөр танин мэдэхүйн шат түвшин зэрэг юм. Хожуу үеийн судруудаас ялгаатай нь энд зарим бясалгалын түвшнийг цөөн шаттайгаар нэрлээд, эдгээр шат түвшин нь бясалгагч хүмүүн, тэр дундаа гэгээрлээр

замнагчийн сэтгэл хорогдох зүйлс биш тухай дэлгэрэнгүй яриа гарна. Түүнчлэн, хүмүүний "сүнс" гээч ойлголтын тухай, дараа төрөл, хойд дүр зэрэг философийн гэж хэлж болох гүнзгий сэдэв рүү орсон олон тайлбар яриа багтжээ.

4. Хамаг Учир Шалтгаан Судар—DN 15. Mahānidāna Sutta

Учир Хамааралтай Үг Гарал буюу алдарт *Paṭiccasamuppāda* сургаалын тухай гарах энэ судар нь уламжлалт 12 хэлхээ (па. *nidāna*) загвараас харьцангуй өөр буюу 9 хэлхээг Аанандад Будда тайлбарлаж байгаагаар гардаг. Энэ нь зарим (AN, MN, SN г.м.) судруудаас өмнө цаг үед хамаарах, магадгүй нэн эртний гэж үздэг *Sutta Nipāta* судрын хэмжээнд дүйж очихоор эртний шинжтэй юм. Учир нь 12 хэлхээг эртний сударт, зарим тохиолдолд 5 хэлхээгээр ч тайлбарлах явдал байдаг билээ. Хүслээс бүгд хамаардаг энэ орчлонд, бид чухам яагаад үхэх төрөхийн эргэлтээр бэдэрч явааг нарийвчлан тайлбарласан энэ судар нь "өөрийн" (*attā*) тухай үзэл бодлын сэдэв рүү ч мөн орж, эдгээр ойлголтуудаас хүн хэрхэн ангид тусдаа байснаар ангижрал ухаарлыг олдог тухай дэлгэрэнгүй хүүрнэл яриа гарах болно.

5. Агуу Нирваанд Нэгмөсөн Одохуй Судар—DN 16. Mahāparinibbāna Sutta

Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн хамгийн агууламж ихтэй, олон хэсэг бүлэгтэй энэ судар нь Буддагийн Нирваанд одохын өмнөх болон дараах мөчүүдийн тухай дэлгэрэнгүй байдлаар гарна. Энэ судартмаш олон утга санааг шигтгэн оруулж, тэгснээр энэ судар нь дангаараа бие даасан ном болж чадахуйц хэмжээнд байлгахыг зорьсон болов уу гэхээр аж. Энд гарах дийлэнх үйл явдал нь олон (MN, SN, AN, KN, *Vinaya Piṭaka* г.м.) судруудад байгаа үг өгүүлбэр, үйл явдалтай бараг яв цав адил юм. Орчин үеийн буддын судлалд энэхүү судрын зарим хэсэг, ялангуяа магтаалын шинжтэй шүлэглэл, давталттай хэсгүүд, мөн дээд зэргийн сүр жавхлантайгаар харуулсан зарим дүрслэл, утга санаа бүхий үйл явдал зэрэг нь хожуу үеийн нэмэлт найруулгын шинжтэй байж болох талаар хэлэлцдэг байна. Гэвч эдгээр хэсэг нь эртний боть судруудын нэгэн хэсэг болон уламжлагдан ирсэн тул, энэ орчуулгад тэдгээрийг хасалгүйгээр бүрэн оруулсан бөгөөд тухайн хэсэг тус бүр дээр тусгайлан тайлбар зүүлт хийхээс энэ удаа зайлсхийсэн болно.

6. Агуу Дүүрэн-Анхаарал Суулгахуй Судар—DN 22. Mahāsatipaṭṭhāna Sutta

Гэгээрэл өөд шууд хөтлөх бясалгалыг маш нарийн түвшинд заасан, бүрэн хэмжээний паали судрыг нэрлээ гэвэл ердөө энэ DN 22-ийг л заан хэлж болох бөгөөд энэ судар бол яах аргагүй эрт цагаас өнөө цагт бидэнд өвлөгдөн ирсэн, Буддагийн заасан бясалгалын үндсэн утга санаа, чиг хандлагыг тодорхойлох, тулгын чулуунд яах аргагүй тооцогдох судар юм. Тиймдээ ч, орчин цагийн төрөл бүрийн бясалгалын газрууд энэхүү судраар гол ном заавраа хийх чиг хандлага нь 1800-аад оноос эрчимжсэн түүхтэй. Тэдгээр газрууд нь харьцангуй хожуу цагт бичигдсэн *Aṭṭhakathā* болон *Visuddhimagga* судруудын санаа болох, "энэхүү бясалгал нь ариуслын ямар ч түвшний, төвлөрөл суусан, эс суусан, ариун сахилыг тогтвортой

сахидаг, эс сахидаг, бүх л төрлийн хүмүүст таарч тохирох аргачлал юм” гэсэн санаан дээр бий болсон гэж нэг талаас харж болох юм. Нөгөө талаас гэвэл, судлаач хувраг B. Anālayo[16], орчуулагч хувраг B. Ṭhānissaro[17] болон Мьянмар, Тайландын зарим багш, судлаачдын байр сууриудад, энэ судар нь ахисан түвшний сахил сахигч бясалгагч хүмүүнд л тохирно, эсвэл зөвхөн сахилтан хувраг хүмүүний бясалгал болно гэх юм уу, бүр эсвэл дор хаяж Гэгээрлийн нэгдүгээр зэрэгт[18] очсон хүмүүний шатаа ахиулах бясалгал ч гэж үзэх хандлага байна.

7. Хүрд-Эргүүлэгч Судар—DN 26. Cakkavatti Sutta

Улс төр, нийгмийн асуудлын өнгө аяс агуулсан гэж хэлж болох энэ судар нь Далханеми (*Daḷhanemi*) хааны жишээн дээр сэдэвчилсэн байдлаар гарах хэдий ч, ёс суртахуун, үйлийн үр, хүний амьдрах нас, өнгөрсөн ба ирээдүйн явдал зэрэг үлгэрчилсэн гэмээр хэлбэрээр өрнөнө. Энэ судар нь зарим хожуу цагийн судрын (Ja г.м.) шинж байдлыг өөртөө агуулсан хэдий ч, эртний судрын хувьд тун ховорт тооцогдох, Буддагийн өнгөрсөн хийгээд ирээдүйн тухай зөгнөсөн шинжтэй яриа ба энэ дэлхийд морилон ирэх дараагийн Буддагийн тухай тун анхаарал татам зүйлсийн тухай дурдагддаг үйл явдал, хүүрнэл яриатай юм.

8. Итгэл Төрүүлэх Судар—DN 28. Sampasādanīya Sutta

Буддаг Нирваанд нэгмөсөн одохоос өмнөхөн эрхэм хувраг Саарипутта, Будда дээр хүрч ирэн, агуу багшдаа бүрэн итгэж байгаагаа илэрхийлсэн сэтгэл хөдөлгөм үгс, агуу тунхаглалыг хэлэх бөгөөд эрхэм хувраг Саарипутта өнгөрсөн, одоо, ирээдүйн цаг үеийн ямар ч багш бээр Буддагаас илүү байж чадахгүй гэсэн өөрийн итгэл үнэмшлээ Буддагийн арван зургаан сайн чанарыг (*ānuttariya*) илчлэн ярих маягаар өрнөх судар юм. Энэхүү гүн гүнзгий тунхаглалаар дамжуулан эрхэм хүндэт Саарипутта, хувраг хүн Буддагийн Сургаалыг үнэнчээр даган хэрэгжүүлснээр энэ насандаа оюун санаа, саруул ухааны хир буртаггүй ангижралыг хэрхэн олж авч болохыг тайлбарлана.

9. Тааламжит Судар—DN 29. Pāsādika Sutta

Энэ сударт гарах хүүрнэл нь Жайн шашны удирдагч гэгдэх, Нигантха Наатапутта буюу “Наатикагийн нүцгэн даянч” нас барсны дараах цаг үе буюу Буддагийн амьдралын төгсгөл хэсэгт, Готама Будда өөрийн угсаа гарал нэг хүмүүсийн дунд амьдарч байх цаг үед тохионо. Жайн шашны удирдагчийн энэ үхлийн дараа үүссэн эмх замбараагүй байдалтай харьцуулахад, өөрийн хуврагууд нь зөв тогтвортой, сайн төлөвшилтэй байгааг Будда онцлон хүүрнэж буй байдлаар өрнөнө. Тэрээр ариуслыг эрэлхийлж буй

[16] Bhikkhu Anālayo, *Satipaṭṭhāna: The Direct Path to Realization* (2003).
[17] Bhikkhu Ṭhānissaro, *Wings to Awakening* (1996).
[18] *Sotāpanna*—“Урсгалд Орогч”. Гэгээрлийн нэгдүгээр зэрэг.

хүмүүст зориулж бүх сайн чанарыг өөртөө агуулсан, цогц гэгээрлийн замналын тухай ярихдаа, төгс гэгээрээгүй багш, төгс гэгээрсэн багш нар, мөн тэдгээр багш нарын шавь нарын ялгамжаан дээр жишээ загвар болгон Сургаалаа айлдаж байгаагаар үргэлжилнэ. Будда юуг заасан, юуг заагаагүй тухай, мөн зарим буруу үзлийн тухай асуудлууд ч энэ судалт багтсан байна.

10. Сигаалад Өгсөн Зөвлөмж Судар—DN 31. Sigālovāda Sutta

Паали Судрын дийлэнх хэсэгт Будда өөрийн хуврагууддаа Сургаалаа айлдаж байгаагаар гардаг бол харин энэ судрын ховор гэмээр нэг агууламж нь, өөд болсон эцгээ хүндэтгэхийн тулд тухайн цагийн элдэв шашны зан үйл хийх Сигаала гэх залуутай Будда таарснаар, тэдний хүүрнэл хар хүмүүний ёс суртахууны утга учиртай зан үйлийн зөвлөмж сургаал болон хувирдаг явдал юм. Ёс суртахуунгүй үйлдэл гэж юу болох, хор хөнөөлтэй үйлийн учир шалтгаан юу болох, тэр ч бүү хэл хар хүмүүний мөнгө санхүү, ахуй амьдралтай холбоотой сургамж зөвлөгөө энд орсон байдаг нь энэ судрыг тун сонирхолтой уншвар болгох нь зүйн хэрэг юм. Судрын агууламж эцэг эх, багш, эхнэр нөхөр, найз нөхөд, зарц ажилтан, сахилтан хүмүүсийн өмнө хүлээх нийгмийн үүргээ биелүүлэх тухай хар амьдралын зөвлөгөө болох ба одоо цагт үүнийг буддын шашны эгэл хар хүмүүсийн ёс зүйн үндсэн дүрэм болгон авч үзэх хандлага түгээмэл байдаг байна. Тухайн цагийн, тэнгэрийн хаяа зовхисыг тахин шүтэх, тэнгэр бурхдаас аврал ивээл гуйх элдэв зан үйл дээр нь тулгуурлан, тэдгээрийг гэгээнтэн хүмүүн хэрхэн үйлдвэл зохилтойг, илүү оюунлаг бөгөөд ёс суртахуунлаг байдлаар Будда зааж өгөх болно.

ТОВЧЛОЛ

Паали Судрууд

Abh	*Abhidhamma Piṭaka*
AN	*Aṅguttara Nikāya*
DN	*Dīgha Nikāya*
DN 1	*Dīgha Nikāya* 1. *Brahmajāla Sutta*
DN 2	*Dīgha Nikāya* 2. *Sāmaññaphala Sutta*
DN 9	*Dīgha Nikāya* 9. *Poṭṭhapāda Sutta*
DN 15	*Dīgha Nikāya* 15. *Mahānidāna Sutta*
DN 16	*Dīgha Nikāya* 16. *Mahāparinibbāna Sutta*
DN 22	*Dīgha Nikāya* 22. *Mahāsatipaṭṭhāna Sutta*
DN 26	*Dīgha Nikāya* 26. *Cakkavatti Sutta*
DN 28	*Dīgha Nikāya* 28. *Sampasādanīya Sutta*
DN 29	*Dīgha Nikāya* 29. *Pāsādika Sutta*
DN 31	*Dīgha Nikāya* 31. *Sigālovāda Sutta*
KN	*Khuddaka Nikāya*
MN	*Majjhima Nikāya*
SN	*Saṃyutta Nikāya*
Vin	*Vinaya Piṭaka*

Англи Орчуулгууд

BB Bodhi, Bhikkhu, trans. *The Discourse on the All-Embracing Net of Views: The Brahmajāla Sutta and Its Commentaries*. Kandy: Buddhist Publication Society, 1989.

BB Bodhi, Bhikkhu, trans. *The Great Discourse on Causation: The Mahānidāna Sutta and Its Commentaries*. Kandy: Buddhist Publication Society, 1984.

BN Ñāṇamoli, Bhikkhu & Bodhi, Bhikkhu, trans. *Middle Length Discourses of the Buddha*. Boston: Wisdom Publications, 1995.

BS Sujato, Bhikkhu, trans. *The Long Discourses of the Buddha*. Online edition, SuttaCentral, 2018–2024.

BT Ṭhānissaro, Bhikkhu, trans. *Selected translations from the Dīgha Nikāya*. Online edition, Access to Insight/dhammatalks.org.

MPA Myanmar Pitaka Association, trans. *Ten Suttas from Dīgha Nikāya: Collection of Long Discourses of the Buddha.* Myanmar Ministry of Religious Affairs and Culture, 2010.

MW Walshe, Maurice, trans. *The Long Discourses of the Buddha: A Translation of the Dīgha Nikāya*. Boston: Wisdom Publications, 1987. (Revised ed. 1995)

RD Rhys Davids, T. W. & Rhys Davids, C. A. F., trans. *Dialogues of the Buddha*, Vols. I–III. London: Pali Text Society, 1899–1921.

Тайлбар Судрууд

Aṭṭhakathā Traditional Pāli commentaries on the Dīgha Nikāya.

Bv Buddhavaṃsa. *In The Minor Anthologies of the Pali Canon* (Khuddaka Nikāya), Part III. Translated by Bhikkhu Ñāṇamoli. London: Pali Text Society, 1975.

DA Buddhaghosa. *Sumaṅgalavilāsinī: Buddhaghosa's Commentary on the Dīgha Nikāya*. Vol. 1. Edited by T. W. Rhys Davids and J. Estlin Carpenter. 2nd ed. London: Pali Text Society, 1968.

VM Ñāṇamoli, Bhikkhu, trans. *The Path of Purification* (Visuddhimagga), Kandy: Buddhist Publication Society, 1975.

Бусад

BA Anālayo, Bhikkhu. *Satipaṭṭhāna: The Direct Path to Realization*. Birmingham: Windhorse Publications, 2003.

BD Buddhadatta, A. P. Mahāthera. *Concise Pāli-English Dictionary*. Colombo: The Colombo Apothecaries' Co., Ltd., 1957.

NPG Ñāṇamoli, Bhikkhu. *A Pali-English Glossary of Buddhist Technical Terms*. Edited by Bhikkhu Bodhi. Kandy: Buddhist Publication Society, 1994.

Энэ жагсаалт нь бүрэн ном зүй бус, харин уг орчуулгад шууд болон зүүлт тайлбарт ашигласан эхүүдийн товчилсон лавлах болно.

АРГАЧЛАЛ БА НЭР ТОМЬЁО

Аргачлал

Энэ номын судрууд нь шашны болон бясалгалын нарийн түвшний, гүн гүнзгий утга агуулгатай үгээр баялаг бөгөөд тэдгээр үгсийг монгол хэлний дан ганц үгийг сонгон орчуулгад хэрэглэх нь утгын хувьд уншигчийг төөрөгдүүлэх, ташааруулах магадлал байна гэж үзэв. Мөн түүнчлэн орчуулгын үгийн сонголтод хэрэглэж болох олон монгол үгс нь хоорондоо утга санаа тун ойролцоо байх аж. Гэтэл чухам өөрийн биеэр туулсан бясалгалын туршлагагүй хүмүүст тайлбарлан ойлгуулахад нэн ярвигтай, хүмүүний сэтгэл санааны байдлын тун нарийн мэдрэмж байдлыг илэрхийлсэн тэдгээр үгс нь буддын номоор мэргэшсэн хувраг хүмүүс, бясалгалын хувьд туршлагажсан хар хүмүүсийн хувьд, мөн Паали Судрын орчуулгад гаршсан эрдэмтэн, судлаачдын хувьд нэлээд ялгамжаатай нэр томьёонууд болж таардаг. Түүгээр зогсохгүй, ариуслын замналаар уйгагүй замнагч, энэ амьдралаа бясалгал болгосон хүмүүсийн хувьд тэдгээр үгийн утгыг хольж хутгаж ойлгох нь асар хохиролтой явдал болох нь гарцаагүй юм.

Иймээс нэр томьёоллын шинж чанартай гэж үзсэн цөөнгүй үгс байгааг ихэвчлэн холбоо үг, хоршоо үгийг сонгож хэрэглэсэн бөгөөд ингэхдээ дийлэнх тохиолдолд тэдгээр хос үгийг зураасаар хооронд нь холбож, “нэг үг” хэлбэрт оруулж энэ орчуулгад ашиглав. Ингэснээр уншигч та эл үгийг мөнөөх нэр томьёо маань байна гэж таних учиртай юм. Эдгээр үгсийн зарим нь 100 гаруй удаа судартдавтагдан орсон болно. Нэг жишээ авбал, “дүүрэн-анхаарал” гэж оруулсан үг байна. Энэ бол *sati* (анг. *mindfulness*) гэдэг паали үгэнд оноосон нэр томьёо болно. Энэ үгийг “дүүрэн анхаарал” гэж хэрэв оруулсан бол уншигч этгээд, эгэл ахуйн, ердийн ярианы “анхааралтай байх” гэх ойлголтоор бодож, эсвэл бүр энэ үгийг эс анзаараад өнгөрөх тохиолдол ч гарч болох байсан биз. Тиймээс ийм аргачлалаар уншигчийг энэ номын нарийн утгад, ахисан түвшний ойлголтод аваачих гэсэн хэрэг юм.

Энэхүү орчуулгын ном нь Олон Улсын Буддын Судлалын (International Buddhist Studies) эрдэм шинжилгээний жишиг, ялангуяа Паали эх бичвэр судлалын нийтлэг стандартыг баримталсан болно. Мянга дөхөх хуудас бүхий Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийг орчин цагийн эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, цахим болон хэвлэмэл хэлбэрээр түгээхдээ, бичвэр зүйн нэгдмэл байдлыг хангах үүднээс дараах зарчмыг баримтлав. Үүнд:

- Хашилт тэмдэг: Олон улсын эрдэм шинжилгээний бүтээлүүдэд, паали болон англи хэл дээрх ишлэл, нэр томьёог тэмдэглэхдээ, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт хашилт буюу “...” болон ‘...’ (анг. *double* болон *single quotation marks*) тэмдэглэгээг ашигладаг. Энэ нь эх бичвэр болон тайлбар зүүлт хоорондын уялдааг тодорхой болгох, мөн орчин үеийн дижитал номын сангийн (EPUB, Metadata г.м.) хайлтын системд эх сурвалжийг оновчтой танихад чухал ач холбогдолтой байдаг тул, уг тэмдэглэгээгээр эх бичвэрийг бүхэлд нь жигдлэв.
- Эх сурвалж ба товчлол: Эх сурвалж болон ном зүйн тэмдэглэгээг Паали Эх Бичвэрийн Нийгэмлэг (Pali Text Society) болон Чикаго Академик Стандартын (Chicago Manual of Style)

дагуу гүйцэтгэсэн болно. Ингэснээр, монгол хэл дээрх уг орчуулгыг олон улсын бусад орчуулгуудтай харьцуулан судлахад эрдэмтэн, судлаачдад дөхөм болгосон хэрэг юм.

- Зүүлт тайлбар: Зүүлт тайлбарыг хийхдээ, дүйх самгарди үг, бясалгагч болон судлаачдын хувьд хэдийнээ тогтсон хэллэг болсон англи нэр томьёо болон шаардлагатай зарим тохиолдолд латин, орос хэл дээрх нэр томьёог хавсаргасан болно. Зүүлт тайлбарт паали эх үгийг эх сурвалж болгон оруулахдаа, зарим тохиолдолд тийн ялгалаар хувирсан байдлаар нь буюу сударт яг байгаа байдлаар нь оруулсан болно. Харин нэр томьёо болгон тайлбар хийх, эсвэл гарчиг болгон оруулахдаа паали хэлний нэрлэхийн тийн ялгалаар хувираагүй, олон улсад тогтсон уламжлал болсон нэршлээр нь оруулсан болно.

- Зарим тохиолдолд өмнөх зүүлт тайлбар болон Нэр Томьёоны Лавлахад (цаашид “Лавлах”) багтсан, ач холбогдлын зэрэг өндөртэй, нэр томьёонд хамаарах үгийг оноосон нэрийн адил үгийн эхний үсгийг томоор бичив. Энэ нь мөн л ялгаагүй тухайн үгийг сударт хэрэглэгдсэн ердийн ярианы яг ижил бичилттэй өөр бусад үгнээс ялгах зорилгоор ийн томьёолсон хэрэг. Өөр бусад шалтгаан бол тэдгээр үгс нь цаанаа гүн хүндэтгэлийг илэрхийлсэн байдаг, мөн орчин цагийн барууны орнуудын буддын судалгааны бичиг баримтын тогтсон хэв загвар нь болсон байдаг зэргээс үүдсэн, тэрхүү ёс уламжлалыг дагасан болно.

Жишээ авбал, “...Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай...”. Энд, “Зүйлс” гэж томоор бичсэн явдал нь, нэгдүгээрт “*dhamma*” гэдэг олон утгатай үгийн “зүйлс” гэх нэг л үгийг нь авч хэрэглэж байгаагаа, хоёрдугаарт ердийн утгаар өгүүлбэрт хэрэглэгдэж болох бусад “зүйлс” гэдэг үгээс ялгаруулж харуулах үүднээс, гуравдугаарт уншигч хүнд энэ үгэнд өөр өөр утга байж болно гэдгийг сануулах үүднээс ийм аргачлалыг ашигласан болно. Энэ үгийн үндсэн утга болох “сургаал”-ыг маш олон тохиолдолд “Сургаал” гэж томоор бичсэн болно. Хэрэв уншигч та гярхай бөгөөд ой тогтоолт муугүй нэгэн аваас мөнөөх л *dhamma*-гийн өөр хувилбар нь энд “Сургаал”, эсвэл “Зүйлс” гэж хэрэглэгдсэн байна гэдгийг өмнөх зүүлт тайлбарт орсон байсныг нь харсан болохоор, мөн мөнөөх үг маань томоор бичигдсэн байгаа зэргээс нь хараад дор нь таних учиртай юм. Ингэж уншигч суралцагч нэгэнд тухайн үгийг өөрийн ухаан зоригоороо ухан ойлгох сонголтыг мөн үлдээж буй болно.

Түүнчлэн, сударт гарах ром үсгээр (*romanized Pāḷi* бичгээр) буй паали оноосон нэрсийг, авиа зүйн талаас нь зөв байлгах үүднээс, “ā”, “ī”, “ū” зэрэг уртаар дуудагддаг эгшгүүдийг “аа”, “ий”, “уу” гэж, “ya”-г “яа” гэх мэт байдлаар галиглан оруулсан болно. Харин бүх гийгүүлэгчдийг, зөв бичих дүрэм талаасаа зөв байлгах үүднээс, тухайн латин үсгийн дүйцэх кирилл үсгээр галиглаж оруулав. Эдгээр оноосон нэр тус бүрд зүүлт тайлбар хийгдсэн байгаа.

Өмнө нь хэлсэнчлэн, Паали Судар бол Буддагийн аман айлдварууд бөгөөд удаан хугацааны турш голдуу аман уламжлалаар өвлөгдөн ирсэн сургаал билээ. Тэгвэл “судар” (па. *sutta* сам. *sūtra*) хэмээх паали эсвэл самгарди хэлнээс монгол хэлэнд орж ирсэн энэ үгийн эртний утга нь цаасан ном бичиг бус, харин

“айлдвар”, “сургамж”[19] гэсэн утгатай үг юм. Иймдээ ч, судрууд тэр чигээрээ эгэл хар ярианы өнгө аяс, хэл найруулгатай юм. Тиймээс энэ хэлбэр байдлыг нь хэвээр үлдээхийн тулд зарим дүрмийн бус, бичгийн хэлэнд зохимжгүй гэж үзэж болох хар ярианы үг, өгүүлбэрийн бүтэц, хэл найруулгыг оруулсан байж болохыг анхаарна уу.

Өгүүлбэр тус бүрийг, эсвэл догол мөр тус бүрийг дугаарладаг Паали Судрын уламжлалыг дагаагүй болно. Учир нь энэхүү орчуулгыг хэд хэдэн паали эхийг харьцуулан хийсэн бөгөөд тэдгээр эхүүдийн дугаарлалт нь хоорондоо яв цав таардаггүйтэй холбоотой болно. Түүнчлэн уншигч, судлаачдад илүү ойлгомжтой байж болох үүднээс, эх судартүргэлжилсэн үгийн хэлбэртэй байсан, дугаарлагдаагүй зарим хэсгийг энэ орчуулгад жагсаалт болгож, дугаарласан хэлбэрт оруулан буулгав.

Дээр дурдсан, нэр томьёо хэлбэрт оруулсан бүх үгээс гадна бусад тогтсон нэр томьёо, нэмэлт тайлбар, Дээд Номын Багцын зарим тайлбарыг Лавлахад бүгдийг нь нэгдсэн жагсаалт болгож оруулсан болно.

Зарим Нэр Томьёоны Тайлбар

Цаашид “Тайлбар” гэж товчилно. Энэ номын зүүлт тайлбарт буй, ач холбогдлын хувьд нэлээд чухалд тооцогдох цөөнгүй нэр томьёонууд байгааг энэ хэсэгт нэгтгэсэн байдлаар тайлбар болгож оруулахыг зорьсон болно. Мөн уг номд хэрэглэсэн зарим нийтлэг нэр томьёоны талаарх товч тайлбарыг энд шигтгэн оруулав.

Будда—Buddha

(анг. *Buddha*, сам. *Buddha*)

Судартт Сиддхаттха Готамаг (түүний төрөхдөө авсан нэр: па. *Siddhattha Gotama*, сам. *Siddhārtha Gautama*) нэрийдэх 40 орчим ялгаатай нэршил Паали Судартт бий.

Тэдгээр нь:

- Сэрсэн Нэгэн (*Buddha*);
- Төгс Гэгээрсэн Нэгэн (*Arahant*);
- Ерөөлтэй Нэгэн (*Bhagavā*);
- Тийн Одогч эсвэл Тийн Ирэгч (*Tathāgata*);
- Эрхэм Багш (*Bhaddante*);
- Төгс Сэрсэн Будда (*Sammāsambuddha*);
- Готама (*Gotama*);
- Зөвөөр Одогч (*Sugata*);

[19] Үгчилбэл, “утас, мяндас, хэлхээ” г.м.

- Хорвоог Ухаарагч (*Lokavidū*);
- Эгнэшгүй Нэгэн (*Anuttaro*);
- Ухаарах Учиртайг Ухааруулах Сургагч (*Purisadammasārathī*);
- Бурхад Хийгээд Хүмүүсийн Багш (*Satthā Devamanussānaṃ*);
- Сакягийн Мэргэн (*Sakyamuni*);
- Даянч Готама (*Samaṇo Gotamo*) гэх мэт юм.

Ийм олон нэршил уншигчийг төөрүүлэхээс сэргийлж, энэ орчуулгад "Будда" нэршлийг голчлон хэрэглэхийг зорив.

Эдгээрээс, монголчуудын "Шагжамуни" (эсвэл Шакьямуни) гэж дууддаг *Sakyamuni* болон даянч Готама гэх зэрэг нэршил нь голдуу Буддагийн шавь бус хүмүүс түүнийг тухайн цаг үедээ нэрлэн хэрэглэж байсан нэршил болохыг судрат гарах үйл явдал харуулдаг. Харин түүнд итгэн бишрч, сахил авсан хүмүүс нь нэн хүндэтгэлтэй нэр цол хэрэглэх бөгөөд шавь хуврагууд нь түүнийг гол төлөв "*Bhante*" ("Эрхэм Багш", "Эрхэм") хэмээн дуудаж буйгаар судрат гарна.

Эртний Буддизмын номоор[20] бол бид нийт хорин найман Будда[21] урьд цагт энэ хорвоод лавтай мэндэлсэн гэж үзэх ба манай энэ галавт[22] хамаарах таван Будда байгаа юм.

Тэд бол:

1. *Kakusandha Buddha*
2. *Koṇāgamana Buddha*
3. *Kassapa Buddha*
4. *Gotama Buddha* (Готама Будда)
5. *Metteyya Buddha* (ирээдүйн Майдар Будда) юм.

Будда нар бол ердөө нэг Төгс Гэгээнтэн (па. *Arahant,* сам. *Arhat*) бус, энэ дэлхийд асар олон тэрбум жилд тун цөөн төрдөг, нэн ховор тохиол юм. Учир нь тэд саруул ухааны бүх сайн шинжийг өөртөө цогцлоосон байх төдийгүй өөрийн ухаарч ойлгосон номоо бусдад төгс төгөлдөр байдлаар заадаг учиртай гэдэг. Мөн нэг Будда үгүй болж дараагийн Будда буух цаг хүртэл асар олон тэрбум жил, зарим тохиолдолд тоогоор илэрхийлэхийн аргагүй, үлэмж их хугацаа болно гэж үздэг.

Эртний Буддизмын ойлголтоор, Будда нар дотроо хоёр үндсэн төрөлд ангилагдаж болох бөгөөд энэ нь:

1. "Төгс Сэрсэн Будда" (па. *Sammāsambuddha*, сам. *Samyaksambuddha*);

---

[20] Паали Судар болон *Buddhavaṃsa*.

[21] 1. *Taṇhaṅkara*; 2. *Medhaṅkara*; 3. *Saraṇaṅkara*; 4. *Dīpaṅkara*; 5. *Koṇḍañña*; 6. *Maṅgala*; 7. *Sumana*; 8. *Revata*; 9. *Sobhita*; 10. *Anomadassī*; 11. *Paduma*; 12. *Nārada*; 13. *Padumuttara*; 14. *Sumedha*; 15. *Sujāta*; 16. *Piyadassī*; 17. *Atthadassī*; 18. *Dhammadassī*; 19. *Siddhattha*; 20. *Tissa*; 21. *Phussa*; 22. *Vipassī*; 23. *Sikhī*; 24. *Vessabhū*; 25. *Kakusandha*; 26. *Koṇāgamana*; 27. *Kassapa*; 28. *Gotama* (Bv).

[22] *Bhaddakappa*—"Хувь ерөөлтэй галав" (сам. *bhadrakalpa*). "Галав"-ыг DN 1.3.1-ийн зүүлт тайлбарт үз.

2. “Өөрөө Сэрсэн Будда” (па. *Paccekabuddha*, сам. *Pratyekabuddha*)

юм. Эхний “Төгс Сэрсэн Будда” нар нэгэнт мартагдсан Гэгээнтний Дөрвөн Үнэнийг өөрөө илрүүлэн гэгээрээд, өрөөл бусдад энэхүү замнал, ном сургаалыг төгс зөвөөр заадаг бөгөөд үүнд манай цагийн Готама Будда хамаардаг. Удаах “Өөрөө Сэрсэн Будда” нар өөрөө гэгээрэх замналыг олж илрүүлэн гэгээрэх боловч, бусдад ёс суртахуун, буяны тухай заах зэргээр хязгаарлагдаж, гэгээрлийн замналыг Төгс Сэрсэн Будда нарын адил бүрэн тогтолцоотойгоор тайлбарлан заадаггүй, Хуврагийн Чуулган байгуулдаггүй гэж үздэг. Тэд ихэвчлэн олны хөлөөс алс, зэрлэг байгальд орь ганцаар (“ганц эвэрт хирс мэт”—*khaggavisāṇa*) амьдрах тул хүмүүс тэднийг “ариуссан хүмүүн” эсвэл “бясалгагч нэгэн” төдийгөөр харах ба төгс гэгээрсэн Будда гэдгийг нь мэддэггүй гэдэг. Ийм төрлийн “нууцат” Будда нар “Төгс Сэрсэн Будда”-гийн Сургаал (*sāsana*) номыг нэгэнт үгүй болсон цаг үед төрнө гэж үздэг (DA).

Зарим тохиолдолд Буддаг бурхан мэтээр тайлбарлах, эсвэл “бурхан” гэж зааж нэрлэх, оноож дуудах явдал байдаг. Гэвч эртний Паали Судартт Буддаг “*deva*” буюу тэнгэр бурхдын төрөлд хамааруулан тайлбарладаггүй болно. Орчин цагийн монгол хэлний “бурхан” бол ерөнхий утгаараа “лус бурхан, бурхан тэнгэр” гэсэн утгатай бөгөөд тиймдээ ч бусад олон шашин шүтлэг, соёл уламжлалын бурхдыг (Зевс бурхан, Христийн бурхны сүм г.м.) нэрлэхэд ч мөн өргөн хэрэглэгддэг гэдгийг бид мэднэ.

Зарим судлаачид энэ үгийг хятад (хят. 佛—*buddha*) эсвэл төвөд, хэлнээс монгол хэлэнд орж ирсэн ба ингэхдээ “будда” болон “бурхад” гэсэн давхар утгыг нь агуулж байсан, эсвэл “будда” гэдэг үг нь хэлзүйн хувьд “бурхан” гэдэг үг болж хувирсан гэх мэт санааг дэвшүүлдэг. Харин нөгөө хэсэг судлаачид “бурхан” гэдэг үгийг Шарын шашин Монголд орж ирэхээс өмнө, эртний монгол хэлний үгийн санд “тэнгэр бурхан” гэсэн утгаар оршиж байсан бөгөөд үүний нотолгоог эртний түрэг (түрк. *burqan*), уйгур хэлнээс харж болно гэж үздэг. Үүний нэг жишээ нь бөөгийн шашин шүтэж байсан Чингис хааны онгон шүтээн орших “Бурхан Халдун” уулын нэршил юм.

Гэвч энэ үг хэрхэн үүссэн, аль хэлнээс орж ирсэн байхаас үл хамааран, өнөө цагийн монгол хэлтний дунд “бурхан” гэдэг үг ямар утгаар ойлгогдож, хэрхэн хэрэглэгдэж буй нь илүү чухал юм. Тэгвэл бидний үгийн санд одоо байгаа “лус, бурхан, тэнгэр” гэсэн ерөнхий утгыг илэрхийлдэг үгээр Буддаг нэрлэж, хэрэглэх нь утгын хувьд төөрөгдөл үүсгэх магадлалтай.

Паали Судартт бурхан (па. *deva,* сам. *deva,* анг. *god* эсвэл *deva,* ор. *бог* г.м.) гэх ойлголт нь ертөнцийн олон төрөлт бодгалиудын зөвхөн нэг ангилалд хамаарах бөгөөд үүнийг дараах “Буддын уламжлалт ертөнцийн тогтолцоо”-ноос харж болно.

Бярман Тэнгэрийн Оронд (*Brahmaloka*):

1. Танихуй-Бухий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орон (*Nevasaññānāsaññāyatana*)
2. Огт-Оргүйн Орон (*Ākiñcaññāyatana*)
3. Хязгааргүй Ухамсрын Орон (*Viññāṇañcāyatana*)
4. Хязгааргүй Орон Зайн Орон (*Ākāsānañcāyatana*)
5. Харьцуулшгүй Орон (*Akaniṭṭhābhūmi*)
6. Саруул Мэлмийн Орон (*Sudassībhūmi*)

7. Үзэсгэлэнт Орон (*Sudassābhūmi*)
8. Эс Түвдэх Орон (*Atappābhūmi*)
9. Эс Унах Орон (*Avihābhūmi*)
10. Танихуй-Үгүйн Орон (*Asaññasattāyatana*)
11. Их Өгөөжийн Орон (*Vehapphalābhūmi*)
12. Үзэсгэлэнт Туяаны Орон (*Subhakiṇṇābhūmi*)
13. Хязгааргүй Суу Алдрын Орон (*Appamāṇasubhābhūmi*)
14. Хязгаарлагдмал Суу Алдрын Орон (*Parittasubhābhūmi*)
15. Урсгал Туяаны Орон (*Ābhassarābhūmi*)
16. Хязгааргүй Туяаны Орон (*Appamāṇābhābhūmi*)
17. Хязгаарлагдмал Туяаны Орон (*Parittābhābhūmi*)
18. Бярман Дээд Тэнгэрийн Орон (*Mahābrahmābhūmi*)
19. Бярман Тэнгэрийн Сайд Нарын Орон (*Brahmapurohitābhūmi*)
20. Бярман Тэнгэрийн Туслахуудын Орон (*Brahmapārisajjābhūmi*)

Бурхдын Оронд (*Devaloka*):

21. Бусдын Бүтээсэн Жаргалд Умбагчдын Орон (*Paranimmitavasavattibhūmi*)
22. Жаргалаа Бүтээгчдийн Орон (*Nimmānaratibhūmi*)
23. Сэтгэл Хангалуун Орон (*Tusitabhūmi*)
24. Тэмцэл Үгүй Орон (*Yāmabhūmi*)
25. Гучин Гурван Тэнгэрийн Орон (*Tāvatiṃsabhūmi*)
26. Агуу Дөрвөн Хаадын Орон (*Cātumahārājikabhūmi*)

Үлдсэн таван орон бол:

27. Хүн (*Manussa*)
28. Асура[23] (*Asura*)
29. Амьтан (*Tiracchāna*)
30. Өлсгөлөн-Сүнс[24] (*Petā*)
31. Там (*Niraya*)

Эдгээр гучин нэгэн төрөл дундах доороосоо VI-XI зэрэгт хамаарах "бурхад" хэмээн нэрлэгдэх эдгээр төрөл нь мөнх бус бөгөөд төгс гэгээрэлд хүрээгүй бодгалиуд болно. Тэдгээрийн доторх нэг жишээ бол домог ёсоор Сиддхаттха Готамаг яг гэгээрэхээс өмнө түүний урд гарч ирж, түүний гэгээрэлд саад болохыг оролддог "Маара" чөтгөр (па. *Māra*) юм. Тэр бол бурхдын орны хамгийн дээд зиндаа, *Paranimmitavasavatti*-гийн захирагч бурхан гэдгийг энд онцлон авч үзүүштэй. Түүнчлэн, бурхдаас ч

[23] *Asura*—"Асура" (сам. *asura*, анг. *demigod* эсвэл *titan*). Хүн болон амьтны төрлийн завсар эрэмбэлэгдэх, атаа хорслын улмаас автсан төрөл. Бурхадтай арцалдаж, дэлхий дээрх лус бурхадтай зэрэгцэн оршино.

[24] *Petā*—"Өлсгөлөн-Сүнс" (сам. *preta,* анг. *hungry ghost*). Өөрөөр, "хоргодсон сүнс". Энгэл нүдэнд үл үзэгдэх, нэг төрөл. Шунал, муу сэтгэлийн үрээр энэ төрөлд төрнө. Эд хөрөнгөндөө хоргодож байр саванд орогнодог гэж үзэх нь түгээмэл.

хүчтэй, бурхдыг захирдаг, ялгамжаатай 20 өөр зиндааны Бярман Тэнгэрүүд (*Brahma*) байгаа нь Буддын ном ёсоор "бурхан" гэдэг ойлголт нь бүхний дээд нь биш гэдгийг улам тодорхой болгоно.

Тэгвэл Готама Будда бол төгс гэгээрлийг олж, Нирваанд одсон буюу тэр энэ хорвоог тэр чигт нь ялж, энэ хорвоогийн тэдгээр 31 төрлийн алинд нь ч хамааралгүй болсон нэгэн юм. Тэр мөн Бярман Тэнгэрүүд болон бурхдын багш юм. Зөвхөн Дэлгэрэнгүй Хүүрнэл боть судруудад л гэхэд, Буддаг "Бурхад хийгээд хүмүүсийн багш" ("*Satthā devamanussānaṃ*") гэж гуч гаруй удаа нэрлэсэн байна.

Түүнээс гадна, Буддын сургаал дахь "Будда" гэх ойлголт нь ердийн бүтээгч-бурхан төвтэй шашны ойлголтоос нэлээд ялгаатай агуулгатай болно. Иймд Буддаг "бурхан" гэж нэрлэх, эсвэл бурхан гэж бодох явдал нь хэл шинжлэлийн хувьд ч, утга зүйн хувьд ч эртний Паали Судрын утга санаатай бүрэн нийцэхгүй бөгөөд ташаарал үүсгэх магадлалтай гэж энэ орчуулгад авч үзсэн болно.

"Сэрсэн Нэгэн" гэсэн утгыг илэрхийлэх "Будда" нэршил нь дэлхий нийтийн бүх хэлэнд энэ хэлбэрээрээ хэрэглэгддэг, олон улсын хэмжээнд тогтсон нэр томьёо юм. Төгс гэгээрсэн нэгэнд оноосон, гүнзгий утга санаа, гүн хүндэтгэлийг нэгэнт өөртөө агуулсан энэ үгийг ташааралд хүргэхүйц утга санаа бүхий, өөр ямар нэг үгээр орлуулах нь тун зохисгүй хэрэг болно гэж үзээд энэ орчуулгад "Будда" нэршлийг Буддад хэрэглэсэн болно.

Сургаал—Dhamma

(анг. *The Teachings of the Buddha*, сам. *Dharma*)

Энэ үгэнд:

- Буддагийн ном, сургаал;
- Хорвоогийн жам, ёс, зарчим, хууль;
- Бодит үнэн, туйлын үнэн;
- Хорвоогийн үзэгдэл, байдал;
- Эд юм, эд зүйл, ямар нэг юм;
- Бодит байдал, байгаа байдал, үнэн чанар;
- Чанар, сайн чанар;

гэх зэрэг цөөнгүй утга бий.

Энэ үг судрат гарах олон тохиолдол тус бүрдээ чухам ямар утгаар хэрэглэгдсэн бэ гэдэг асуудал дээр, хувраг болон судлаач эрдэмтэд санал зөрөлдөх хандлага байдаг. Тийм ч болохоор, уг орчуулгад, энэ үгийг нийтлэг байдлаар "Сургаал" гэж оруулсан хэдий ч, цөөнгүй тохиолдолд, "Зүйлс", "Жам", "Чанар", "Үзэгдэл", "Төсөөлөл", "Үнэн" гэсэн байдлаар уг үгийг анхааруулах үүднээс томоор эхлүүлэн бичиж томьёолж оруулав. Ингэснээр, орчуулагчийн энэхүү оноосон орчуулгын хувилбараас гадна өөр утгууд байгааг сануулж, өөрийнхөө сонголтоо хийх боломжийг олгож буй хэрэг юм.

Нөгөө талаас, бүр гүнзгий түвшинд эргэцүүлэн авч үзвэл, энэхүү *dhamma* гэх үг маань тийм ч олон утгатай бус ердөө нэг утгатай ч гэж хэлж болохоор юм. Учир нь тэр нэг л утга гээд байгаа зүйл нь Буддагийн заасан ном, түүний тайлбарлаад байгаа зүйлс, түүний бидэнд ойлгуулах гээд байгаа энэ хорвоогийн жам, үнэн чанар, энэ хорвоогийн юмс үзэгдэл, энэ хорвоогийн үнэн буюу Буддагийн үнэн ном нь юм.

Хуврагийн Чуулган—Bhikkhusaṅgha

(анг. *Community of Monks*, сам. *Bhikṣusaṃgha*)

Буддагийн шавь болж хуврагийн дээд сахил авсан хуврагуудын нэгдэл, чуулган, хурал гэсэн утгатай энэ үгийг хэд хэдэн өөр тохиолдолд энэ нэг л үгээр дуудах бөгөөд тэдгээр байж болох тохиолдол нь: 1. энд байгаа нийт хуврагууд; 2. хийдийн хуврагууд; 3. бүх хувраг хүмүүс гэх зэрэг юм. Үүнээс гадна, судартаа *bhikkhusaṅgha*-г "Чуулган" (*saṅgha*—цуглаан, нэгдэл, хуралдаан) гэж хэрэглэх нь түгээмэл.

Мөн судартаа[25] *sāvakasaṅgho* буюу "шавь нарын чуулган" гэх нэршил байгаа нь зөвхөн гэгээрсэн шавь нар болох "дөрвөн хос, найман гэгээрлийн зэрэгт хамаарах хүмүүс" (*cattāri purisayugāni aṭṭha purisapuggalā*) юм. Түүнчлэн "чуулган" ойлголтод хамаарах өөр нэг үг байгаа нь *ariyasaṅgha* буюу "Ариуссан Хуврагийн Чуулган" бөгөөд үүнийг гэгээрлийг олсон хуврагуудын чуулганд оноон хэрэглэдэг утга санаа болно. Тэр нь чухамдаа:

> "Будда, Сургаал, Чуулган"—"*Buddha, Dhamma, Saṅgha*"

гурвын "Чуулган"-д нь хамааруулж ойлгохыг хэлж буй хэрэг юм. Энэ бол манай сүсэгтнүүдийн дунд түгээмэл хэрэглэгддэг "лам гурван эрдэнэ" гэх мэт олон янз хувилбараар хэлэгддэг үгийн унаган хэлбэр юм. Үүнийг "Гурван Нөмөр" буюу *Tisaraṇa* гэж хүндэтгэн дууддаг (зарим тохиолдолд: *Tiratana*—"Гурван Эрдэнэ"). Үүнийг Буддагийн шавь, түүний номыг дагагч болж, сахил авч буй нэгэн бээр:

> "Буддагийн нөмөрт[26] очиж байна. Сургаалын нөмөрт очиж байна. Чуулганы нөмөрт очиж байна."
> *Buddhaṃ saraṇaṃ gacchāmi, Dhammaṃ saraṇaṃ gacchāmi, Saṅghaṃ saraṇaṃ gacchāmi*

гэж хэлээд сахилаа авдаг уламжлалтай юм.

Тэр утгаараа, нэгд, энэ нь хэн нэг лам багш, эсвэл ямар нэг бурханд мөргөж дагаар орох тухай бус, харин төгс гэгээрсэн Буддагийн ивээл нөмөрт очихыг хэлсэн болно. Хоёрт, энэ нь ямар нэг номыг ойлгохгүйгээр, ердөө үүнийг шүтэж мөргөх тухай бус, харин Буддагийн заасан Сургаал номыг ойлгож, үүнийг дагаснаар, зовлонгоос нэгэнт аврагдахуйн талаар хэлсэн болно. Гуравт, энэ нь ямар нэгэн дан ганц ламын тухай бус, харин Гэгээрсэн Хуврагийн Чуулганыг хүндлэн биширч, тэдний замналд итгэж буйгаа

---

25 DN 16.10 г.м.

26 *Saraṇaṃ*—"нөмөрт". *Saraṇa* гэдэг үгийн утга нь "саравч", "хоргодох газар", "аюулгүй газар".

илэрхийлсэн хэллэг болно. Тэр утгаараа, энэ бүгд ердөө л нэг мухар сүсгээр мөргөж залбирах, сохроор дагаж шүтэх тухай бус, харин энэ Гурван Эрдэнийн билэг ухаан, сахил номын нөмөр нөөлөгт орж, аюулаас өөрөө өөрийгөө аварч, ариусал гэгээрлийн замналаар амьдрахаа амлан хэлж буй үйлдэл болдог. Мөн үүнд, ямар нэг ид шид, арга жатга, тарни мааниар бус, харин Буддагийн гэгээрлээр, түүний заасан ном ёсоор, гэгээрсэн хувраудын үлгэр жишээгээр, зөвхөн өөрийн хичээл зүтгэлээр энэ насандаа амжиж Нирваныг ухаарахуйн тухай санаа агуулагдаж байна гэж үзэж болно.

Нирваан—Nibbāna

(анг. *Nirvana,* сам. *Nirvāṇa*)

Энэ үг нь үгчилбэл, гал эсвэл гэрлийг "унтраах" гэсэн утгатай боловч гүнзгий утгаараа, Гэгээрэл, ангижрал, ариусалд хүрэх, зовлонг нэгмөсөн устгах, нэгэнт эцэс болгох, унтраах, устгах гэсэн утга санааг илэрхийлнэ. Тиймдээ ч Нирваны Тухай Асуулт Судартࠀ[27] Будда:

> "Хүсэл шуналын төгсгөл, уур хилэнгийн төгсгөл, мунхаглал төөрөгдлийн төгсгөл, үүнийг Нирваан гэнэ."
> *Rāgakkhayo dosakkhayo mohakkhayo—idaṃ vuccati nibbānaṃ.*

хэмээн хэлсэн бөгөөд эдгээрийг дүрэлзэх галтай зүйрлэсэн байна.

Түүнчлэн, Нирваныг ухаарч ойлгосноор, тэр хүн бээр тэнгэр, бурхан, хүмүүн, амьтан, өлсгөлөн-сүнс, тамын ямар ч төрөлд төрөхгүй болж, дахин төрөл авах явдлыг нэгэнт үгүй хийж, энэ хорвоог нэгэнт орхих явдлыг хэлнэ гэж паали судруудад олонтоо тайлбарласан байна.

Өрнөл талаас нь тайлбарлавал, энэ насандаа төгс гэгээрлийг хэн нэгэн хүн олсон бол, тэр хүн энэ амьдрах насандаа огт зовох зовлонгүй болж, өчүүхэн ч төдий хүсэл шунал, уур хорсол, мунхаглал төөрөгдөлгүйгээр амьдраад, үхэхийн цагт тэрбээр нэгмөсөн Нирваанд одно гэсэн үг болно. Мөн энэ санаа бол "мөнх амьдрал, мөнх сүнс" гэх мэт ойлголт нь ташаарал болохыг илтгэдэг. Мөнх мэт дахин дахин төрөөд, төрөл аван үргэлжлэх энэ амьдралын урсгалын нөхцөлт (па. *saṅkhata*) шалтгаан бол угтаа бидний хүсэл юм. Тийм ч болохоор хүсэл үгүй болж гэмээ нь, энэ зовлонт хорвоо буюу энэ нөхцөлт оршихуйн урсгал, хэлхээ үгүй болох юм.

Тэгвэл хожуу үүссэн зарим нэг шашны урсгалд Нирваныг янз бүрээр тайлбарлах явдал байдаг. Төгс гэгээрсэн хүн дараа төрөлдөө диваажин руу яваад бурхан болдог мэт, эсвэл дахиад хүний төрөл аваад хойд дүрийг олдог мэт, эсвэл нүдэнд үзэгддэг үзэгддэггүй янз бүрийн төлөв байдал руу ордог мэт элдэв янзын ойлголт байдаг ч, тэр бүх санаа нь олон судартࠀ[28] буй Буддагийн айлдсан үгийн утга санаатай зөрчилдөж болох юм. Жишээ татвал:

[27] SN 38.1, *Nibbānapañhāsutta.*
[28] SN 22.59, MN 26, Vin, i.14/35/183 г.м.

> "Дахин төрөхүй нь устсан, туулсан амьдрал нь ариуссан, гүйцээх учиртай нь гүйцсэн."
> *Khīṇā jāti, vusitaṃ brahmacariyaṃ, kataṃ karaṇīyaṃ.*

гэсэн байдаг. Тэгвэл хэн нэг "гэгээнтэн" дахиад төрчихсөн, хойд дүрд орчихсон, энэ хорвоо дээр явж байх боломжгүй гэсэн санааг энэ судрын хэсэг илэрхий харуулж байна гэж дүгнэхээр байна.

Түүнчлэн монголчууд, "нирваан дүрийг үзүүлэх", "нирваан дүртэй" гэх мэтээр ярих явдал байдаг нь номын утга талаасаа нэлээд зөрчилдөөнтэй ойлголт ч болж болох талтай. Учир нь Нирваан бол ямар нэг "дүрийг үзүүлдэг", "дүрийг эсгэдэг", "дүрд ордог" зүйл огт биш юм. Нирваан нь ямар нэг чанараараа гадаад дүр байдалтай холбоотой, гаднаа илэрдэг шинж чанар бус харин тухайн гэгээрсэн хүн зөвхөн өөрөө, өөрийн "шууд-билгүүн" (па. *abhiññā*)-ээр ухаарч таньдаг, дотоод шинж чанарын ойлголт юм. Иймээс төгс гэгээрсэн хүнийг, гаднах царай төрх, гадаад дүр байдлаар нь таних боломжгүй юм.

Нирваан гэдэг нь, эсвэл Нирваан руу явах гэдэг нь, эсвэл Нирвааныг "харах", "мэдрэх" гэдэг нь хүн, амьтан, бурхан, Тэнгэр, өлсгөлөн-сүнс, тамд зовогсод, бид бүгдийн хамтдаа амьдран буй энэ хорвоогоос нэгэнт "гарахыг" хэлж буй хэрэг гэж маш болхи үгсээр тайлбарлая. Нөгөө талаас, Нирвааныг хүмүүст үгээр тайлбарлаад шууд ойлгуулчих боломжгүй гэж үздэг. Энэ нь яг л төрөлхийн хараагүй сохор хүнд, нүдээр энэ хорвоог үзэх харах ямар байдгийг тайлбарлаад, түүнд үүнийг шуудхан ойлгуулчихтай адил зүйл болох биз. Нирваан бол энэ хорвоогийн нөхцөлт зүйлстэй (*saṅkhata*) огт адилгүй тул Нирвааныг оноод тайлбарлаад ойлгуулчих үг энэ хорвоод байхгүй юм гэж хэлсэн ч мөн ташаарахгүй. Өөрөөр хэлбэл, бидний энэ эгэл ертөнцийн л шинж чанарыг тайлбарлаж, нэрлэж, оноож бий болгосон бидний үгийн санд Нирвааны шинж чанартай яг дүйж очих, төгс тайлбарлах үгс нь байхгүй юм. Эдгээр бичсэн зүйрлэл маань ч өөрөө мөн төгс сайн зүйрлэл болж чадахгүй.

Хожуу цагийн зарим философичид Нирвааныг "хоосон чанар" (па. *suññatā,* сам. *śūnyatā*) гэсэн ойлголтыг бий болгосноор, үүнийхээ үүднээс тайлбарлах хандлагатай болсон байдаг. Тэгвэл энэ нь хожуу үеийн системчилсэн "хоосон чанар" (*suññatā*) гэсэн философи ойлголт хэлбэрээр Паали Судартхэрэглэгддэггүй бөгөөд харин "хоосон" (*suñña*) гэдэг үгийн хэрэглээ бол байгаа юм. Гэвч Паали Судартбайгаа *suñña* буюу "хоосон" гэдэг үгийг тодорхой нэг л гол санааг илэрхийлэхэд өргөн хэрэглэсэн байдаг. Тэр санааг:

> "Энэ хорвоо нь ямар нэгэн 'өөрийн-оршихуйгаар' (*attā*), мөн энэ 'өөрийн-оршихуйд' (*attā*) хамаарах зүйлээр хоосон юм."
> *Suññam idaṃ attena vā attaniyena vā.*

гэсэн байгаа "Хоосон Бол Хорвоо" Судар[29] дахь жишээгээр харж болно. Хорвоо нь "би", мөн "минийх" гэх зүйлээр хоосон буюу, өөрийн гэсэн тогтвортой "өөрийн-оршихуй" (*attā*) гэж үгүй болохыг илэрхийлэхдээ л, энэхүү *suñña* гэдэг үгийг хэрэглэж тайлбарласан байна. Хорвоо нь "би" болон "минийх" гэх буруу төсөөллөөр хоосон байгаа гэсэн санааг Нирваантай шууд адилтган авч үзэх нь таарамжгүй,

[29] SN 35.85, *Suññatalokasutta*.

судрын хэмжээнд хүрэх төгс тайлбар болж чадахгүйгээр барахгүй, зарим тохиолдолд ойлголтын зөрүү үүсгэх магадлалтай юм.

Паали судруудад, Нирваан, төгс гэгээрэл болон зарим гэгээрлийн түвшнийг олон өөр үгээр, эсвэл хэд хэдэн үгийг хамт нь хэрэглэж нэрлэх ба тэдгээрийн заримыг жагсаан үзүүлбэл:

Дангаар:

- “амгалан”—*santi*;
- “ангижрал” (эрх чөлөө)—*vimutta*, *vimutti, vimokkha*;
- “аюулгүй амгалан”—*khema*;
- “төгсгөл” (үгүй болох)—*nirodha*;
- “Нирваан” (үгүй болох)—*Nibbāna*;
- “Эцсийн Нирваан” (нэгэнт үгүй болох)—*parinibbāna*;
- “эс сэдэгдсэн-цогцолсон”—*asaṅkhata*;
- “үхэшгүй” болохуй—*amata*;

Цогц байдлаар:

- “алмайрал-үгүй” болохуй—*nibbida*;
- “амгаланг-олохуй”—*upasama*;
- “салж-ангижрахуй”—*virāga*;
- “тэр зэрэгт хүрэх”—*upasampajja*;
- “төгсгөл”—*nirodha*;
- “шууд-билгүүнийг өөрийн биеэр ухаарах”—*abhiññā sacchikatvā*;

Дангаар хэрэглэгддэг үг нь Нирвааны нэр, чанарыг, харин цогц байдлаар, хамтдаа хэрэглэгддэг үгс нь Нирваанд хүрэх үйл явц, дарааллыг илэрхийлсэн байдаг.

Өөрийн-Оршихуй—Attā

(анг. *self, myself, soul,* сам. *ātman*).

Хэл шинжлэлийн талаас авч үзвэл, паали хэлний *attā* нь “өөрөө”, “өөрийн” гэсэн үндсэн санааг илэрхийлдэг. Үүнийг “өөрийн-оршихуй” хэмээн нэр томьёо болгон оруулсан энэхүү үгийн ерөнхий болон гүнзгий утга санааг хүмүүс харин ч янз бүрээр өөртөө тусган авч, өөр өөрийн ойлголтоор тайлбарладаг. Олон хүмүүс “миний-сүнс”, “миний-оршихуй”, “би”, “би-өөрөө”, “өөрийн-гэсэн-оршихуй”, “өөрөө”, “дотор-хүн-минь” гэх мэт байдлаар энэ үгийн гол санааг нэрлэж магадгүй юм.

Энэ гүнзгий утга бүхий нэр томьёо бол Буддагийн заасан номын хамгийн чухал санааг тайлбарлахад түлхүүр үг нь болдог. Ерөнхийдөө, бидний дотор, далд байж байдаг, биднийг үхэх хийгээд төрөхөд бидний оюунд ч юм уу байж байдаг, зарим хүмүүсийн хувьд харагддаг гэж үздэг, эсвэл харагдахгүй гэж үздэг, нэг төрөлд үхэж дараа төрөлд төрөхөд нь “дахиад сэргэдэг” гэж зарим нь үздэг, дахин дахин төрөх

байдлаар мөнхөд үргэлжилнэ ч үздэг, магадгүй бидний зарим нь үүнийг жинхэнэ "өөрийгөө" гэж боддог, эсвэл зарим шашны урсгалд "хойд дүр" гэх мэтээр нэрлэдэг, тэр нэг зүйлийг энэ номд "өөрийн-оршихуй" гэсэн нэр томьёо болгож хэрэглэсэн юм. Хүмүүсийн зарим хэсэг зөвхөн материал дээр суурилсан үзэл бодол, байр суурьтай байдаг тул энэ үгийн шашинлаг (*spiritual*) утга санааг эрс үгүйсгэдэг. Тиймээс ч, энэ үгийг магадгүй "ухамсар", "ой санамж", "би" гэх мэт байдлаар тусгаж авах нь тэдгээр хүмүүсийн хувьд дөхөм сонголт байж болох юм.

Энэ номын багагүй хэсэг нь зөвхөн энэ "өөрийн-оршихуй"-г Будда янз бүрийн арга хэлбэрээр ярьж тайлбарлах болно. Тэдгээр тохиолдол бүрд голчлон "өөрийн-оршихуй"-г хэрэглэсэн бөгөөд зөвхөн энэ л үгээ хэрэглэх нь утгын хувьд зохимжгүй гэж үзсэн цөөнгүй тохиолдолд, "Сүнс", "би", "би-өөрөө", "өөрийн-гэсэн-оршихуй", "Өөрөө" гэсэн нэр томьёог хэрэглэж, тухай бүрд нь зүүлт тайлбараар үүнийг сануулах гэж оролдсон билээ.

Энэ үгийг өмнөх хэсэгт оруулсан хорвоогийн 31 төрлүүдийн нэг "өлсгөлөн-сүнс" (*petā*)-ээс өөр зүйл гэдгийг уншигч та ойлгож байгаа гэж найдна. Монголчууд бидний "нэг сүнс харагдлаа", "сүнс хоргодсон байшин" гэх мэт санааг илэрхийлэхэд хэрэглэдэг "сүнс" бол үндсэндээ Эртний Буддизмын номоор "өлсгөлөн-сүнс" болж таарах юм. Харин нь "сүнс нь зайлсан", "сүнс сүлд нь байхгүй болсон" гэдэгт хэрэглэж буй "сүнс" нь "өөрийн-оршихуй" нэр томьёоны үндсэн утгатай илүү дүйж очих юм.

Цаашилбал, энгийн ярианд "өөрийгөө мөнхлөх", "өөрийгөө таньсан", "өөрийгөө олсон" гэх мэт хэллэгүүд хэрэглэгддэг боловч, эдгээр нь угтаа метафизик санаа болох *attā*-г илэрхийлэхгүй бөгөөд, харин зарим тохиолдолд сэтгэлзүйн болон ёс суртахууны утга санааг агуулсан байдаг.

Мөн Латин хэлний "эго" (лат. *ego*—"би") гэдэг үг нь эртний Ромын үед (жишээ нь Цицероны бичвэрүүдэд) энгийн "би" гэсэн утгаар хэрэглэгдэж байсан бол, XX зууны эхэн үед Зигмунд Фрейд (Sigmund Freud)-ийн сэтгэл судлалын онолоор дамжин орчин үеийн "эго", "эгоизм" гэх мэт тусгай мэргэжлийн нэр томьёо болж өргөн дэлгэрсэн байна. Энэхүү сэтгэл судлалын салбарт хэрэглэгдэж буй ойлголтууд нь өнгөц харахад "би"-тэй холбоотой мэт боловч, өнө мөнхийн, өөрөөрөө тусгаар орших "би" буюу *attā* гэсэн метафизик ойлголттой ижил ойлголт болж чаддаггүй. Энэ тал дээр Буддын сургаал нь тийм төрлийн мөнхийн, бие даасан "би" (*attā*)-г үгүйсгэснээс бус харин бидний энгийн хэл ярианы "би" эсвэл сэтгэлзүйн "эго"-ний тухай асуудал биш юм.

Бидний, "өөрийн-оршихуй", "миний-сүнс", эсвэл "би" гэж нэрлээд байгаа энэ ойлголт бол чухамдаа, материал, мэдрэмж, ойлголт, сэдэл, ухамсар тавын бүрдэл (па. *pañcakhandha*)-ийн ямагт хувьсан өөрчлөгдөж буй харилцан хамааралт үйл явц юм.

Paramattha-sacca буюу туйлын үнэн талаас авч үзвэл, хувь хүний дотор байнгын, тогтвортой, эс өөрчлөгдөх *attā* буюу "сүнс", өөрийн-оршихуй эсвэл "би" гэдэг нь үнэндээ олдохгүй бөгөөд "өөрийн-оршихуй" гэдэг зүйл нь тогтоон барих боломжгүй зүйл юм. Энэ утгаараа, үүнийг "өөрийн-оршихуй-бус" (*anattā*) гэж хэлсэн хэрэг.

Өөрийн-Оршихуй-Бус—Anattā

(анг. *no-self, not-self*, сам. *anātman*)

Өмнөх хэсэгт тайлбарласан *attā*-г үгүйсгэх талаас нь буюу үүнийг олдохгүй байгаа чанарт нь өгсөн нэршил болох *anattā*-г “өөрийн-оршихуй-бус”, эсвэл “би-үгүй”, “би-бус”, “өөрөө-үгүй”, “өөрийн-гэсэн-оршихуй-бус” гэх мэт байдлаар нэг үг болгон томьёолж болохоор юм. Зүүд, зэрэглээ мэт энэ “би” (*attā*)-тэй зууралдах нь, үүнийг мөнх гэж бодох нь, үүнийг шүтэх нь, үүнд автах нь, биднийг улам зовлонд зүдүүрт унагаж, биднийг гэгээрлээс улам холдуулж байдаг. Харин, юмс үзэгдлийн таагүй, зовлонтой, тогтворгүй, мөнхийн бус байдлыг хүлээн зөвшөөрөх нь, хорвоог энэ талаас нь харах нь, үүнийг ухаарч замнах нь зовлонг эцэслэж, ангижралд хүрэх түлхүүр нь болно гэж үздэг. Тиймдээ ч, энэ нь Готама Буддагийн дурдсан Ертөнцийн Гурван Шинж (*Tilakkhaṇa*)-ийн нэг шинж нь болдог. Тэдгээр нь:

1. мөнхийн-бус (*anicca*);
2. зовлонтой (*dukkha*);
3. өөрийн-оршихуй-бус (*anattā*).

Attā-гийн олдохгүй байгаа шинж буюу *attā*-гийн үндсэн шинж бол үнэндээ хоосон (па. *suññatā*) чанар юм гэдэг санааг дэвшүүлсэн, тийм утга бүхий тайлбар судерт олон байна. Тэгвэл бидний “би”, эсвэл “өөрийн-оршихуй” гэж нэрлэдэг, боддог, төсөөлдөг зүйлийг томьёолон хэлье гэвэл, *attā* гэдэг бол чухамдаа байнгын өөрчлөлтөд орших таван-цул (*pañcakhandha*) бөгөөд энэ нь гарын таван хурууг базаж атгаад зангидсан нударга болгохтой адил, эсвэл таван зэв сум нийлж нэгдээд таван хошуу болсонтой адил, тийм нэгэн нэгдмэл ойлголт болох юм.

Таван-Цул—Pañcakhandha

(цул—па. *khandha,* анг. *aggregate, heap,* сам. *skandha*)

Khandha буюу “цул” гэдэг үгээр томьёолсон энэ үгийн утга нь “цул”, “бүхэл”, “бүрдэл” юм. Энэ таван-цул гэж нэрлээд байгаа ойлголт бол ухамсарт бодгалиудын мөн чанарыг (зан чанарыг) нь бүрдүүлж буй, мөнхийн-бус (*anicca*) болон өөрийн-оршихуй-бус (*anattā*) шинж чанараар нь онцлон авч үзсэн таван цул зүйлийг хэлээд байгаа нэршил юм.

Тэдгээр таван цулууд бол:

1. Бие-дүрс (*rūpa*)—материал, материаллаг байдал.
2. Мэдрэмж (*vedanā*)—а. таатай, б. таагүй, в. төв-оршихуй.
3. Танин-мэдэхүй (*saññā*)—ойлголт, мэдлэг, танихуй, мэдэхүй.
4. Сэдэхүй-цогцлохуй (*saṅkhāra*)—сэдэхүй, нөхцөлдөхүй, бүрэлдэхүй, цогцлохуй.
5. Оюун-ухамсар (*viññāṇa*)—ухамсар, ухамсарлах оюун.

Эдгээр болно.

Юун түрүүн дээрх таван нэр томьёог цухас боловч тайлбарлая.

Танин-мэдэхүй (*saññā*), оюун-ухамсар (*viññāṇa*) хоёрт оноосон нэр томьёонууд уншигчдыг төөрөгдөлд оруулж болох тул нэгэн жишээг энд оруулъя. Хэн нэг хүн багшийнхаа ярих дуу хоолойг сонслоо гэж бодъё. Энэ тохиолдолд:

- Танин-мэдэхүй: “Энэ бол манай багшийн хоолой байна.” гэж таних бол,
- Оюун-ухамсар: “Чимээ сонсогдлоо.” л гэж ухамсарлах юм.

Энэ жишээгээр, “таних”, “мэдэх” гэсэн ерөнхий санааг аль аль нь агуулсан энэ хоёр нэр томьёоны нарийн ялгааг арай дөхөм байдлаар ойлгож болох юм. Мөн түүнчлэн, тун цөөн тохиолдолд “танин-мэдэхүй”-г номын утга санаанд илүү дөхөм болгох үүднээс “ой санамж”гэж, эсвэл “ой санамж, танин-мэдэхүй” гэсэн байдлаар оруулж, хэрэглэсэн болно.

Үндсэндээ “ухамсар” гэж ойлгож болох “оюун-ухамсар” үгийн хэрэглээ нь сэтгэл, оюун, мэдрэхүйн үйл ажиллагааны улам нарийн түвшний ойлголтод чухал байр суурь эзэлнэ. Учир юу гэвэл, “мэдрэхүйн үйл явц” гэж нэрлэж болох Мэдрэхүйн-харилцаа (*phassa*)-г:

1. Мэдрэхүйд тусах зүйл (1. үзэгдэл; 2. чимээ; 3. үнэр; 4. амт; 5. хүрэлцэл; 6. төсөөлөл);
2. Оюун-ухамсар (1. нүдний-ухамсар; 2. чихний-ухамсар; 3. хамрын-ухамсар; 4. хэлний-ухамсар; 5. биеийн-ухамсар; 6. оюуны-ухааны-ухамсар);
3. Мэдрэхүйн-хүрээ (*āyatana*);

эдгээр гурвын уулзах агшин гэж Эртний Буддизмд үздэг. Үүнийг бүр задалж тайлбарлаж болох ч, энгийн хүүрнэл яриа хэлбэртэй эртний сургаал бүхий энэхүү номын үндсэн санаа, хэлбэр байдлаас хальж, Дээд Номын Багц (*Abhidhamma Piṭaka*) судруудын номлол руу орох тул энд хүрээд зогсъё.

Өөрийн-Оршихуй-Бусын Шинж Судартˆ[30], Будда:

> “Бие-дүрс нь өөрийн-оршихуй-бус... мэдрэмж нь өөрийн-оршихуй-бус... танин-мэдэхүй нь өөрийн-оршихуй-бус... сэдэхүй-цогцлохуй нь өөрийн-оршихуй-бус... оюун-ухамсар нь өөрийн-оршихуй-бус...”
> *Rūpaṃ anattā ... vedanā anattā ... saññā anattā ... saṅkhārā anattā ... viññāṇaṃ anattā.*

гэж хэлжээ. Үүнийг арай өөрөөр буулгавал, “Биет юмс бол өөрийн гэсэн, өөрөөрөө орших, тусгаар тогтносон оршихуй бол биш юм (мэдрэмж бол... танин-мэдэхүй бол... сэдэхүй-цогцлохуй бол... оюун-ухамсар бол...).” гэсэн хувилбар байж болох юм.

Эндээс өмнөх хэсэгт гарсан “өөрийн-оршихуй-бус” болон “таван-цул”-ын тухай санааг ойлгох гэж оролдож болохоор юм.

Зовлон гэдэг бол эдгээр байнгын өөрчлөгдөж байдаг цулуудад бид автахаас л үүдэлтэй юм. Хүмүүн бид энэ таван-цулыг шүтэж, үүнд автаж, хорвоог үүний нүдээр харж байгаагаас болж бид зовлон зовуурийг

[30] “*Anattalakkhana*”, мөн SN 22.59; MN 109; SN 23.1 г.м.

эдлэн амьдрах ба бидний энэ таван-цулд автах явдал маань үгүй болж гэмээ нь гэгээрнэ гэж үздэг. Эсвэл арай өөрөөр хэлбэл, бид төгс гэгээрсний дараа энэхүү "таван-цул" гэгч зүйл нь донтох шунахын үндэс байхаа нэгэнт болино гэж тайлбарлаж болох юм. Биднийг хүсэл шуналд "автахад хүргээд байгаа" зүйл бол энэ таван-цул юм. Тиймээс, сударт таван-цулыг:

> "Хуврагууд аа, шуналын таван цулууд байдаг..."
> *Pañcime bhikkhave upādānakkhandhā...*[31]

хэмээн хэлсэн байна. Өөрөөр үгчилбэл, "Хуврагууд аа, шунахуйн цулууд бол эдгээр тав юм...". Тэдгээр тав нь дээр жагсаасан: бие-дүрс, мэдрэмж, танин-мэдэхүй, сэдэхүй-цогцлохуй, оюун-ухамсар болно. Товчхондоо, бидний шунал гэж нэрлээд байгаа зүйл бол эдгээр таван цулууд юм.

Мөн энэ утгаараа бидний хүсэл шунал энэ тавтай наалдах тусам, үүнд автах тусам, үүний хараат байх тусам, бид тэр хэмжээгээр зовлонд унаж, таагүй байдал биднийг тэр хэмжээгээр эзэмдэн дарлах болно. Эх сударт, мөнөөх таван зүйлийг хэдийгээр зөвхөн "цулууд" буюу *khandhā* гэсэн нэг үгээр бичсэн байдаг ч, эдгээр тохиолуудыг жигдлэн, мөн уншигчдад ялгаруулан таниулах үүднээс "таван-цул" гэсэн нэр томьёог дийлэнхдээ хэрэглэсэн болно.

Сэдэхүй-Цогцлохуй—Saṅkhāra

(анг. *volitional formation*, сам. *saṃskāra*)

Сэдэхүй-цогцлохуйг шуналын таван-цулын нэг цул нь болдог гэдгийг өмнөх хэсгээс мэдсэн. Ингээд энэ үгийн утга, тайлбар руу оръё.

Сэтгэлд өрнөх "төлөвлөхүй", "сэтгэхүй", "сэдэхүй", "цогцлоохуй", "хэлбэржүүлэхүй", "нөхцөлдүүлэхүй" оюуны үйл хөдөлгөөн, явцыг *saṅkhāra* гэж хэлж болох юм. "Цогцлохуй" гэсэн үндсэн санаа бүхий энэ үгийг нэр томьёо болгон энэ номд хэрэглэхдээ урд нь "сэдэхүй"-г хавсаргаж, улмаар *saṅkhāra* -г "сэдэхүй-цогцлохуй" болгосон нь орчин цагт, барууны орчуулгын нэг түгээмэл хувилбар болсон "нөхцөлдсөн юмс" (анг. *formations*, *conditioned things* г.м.) нэр томьёоны хэрэглээнээс аль болох зайлсхийхийг оролдсон явдлаас үүдэлтэй. Учир нь хэрэв энэ үгийг "нөхцөлдсөн-юмс" гэх мэт байдлаар нэр томьёо болгосон бол энэ үгтэй далд явж байдаг хамгийн чухал санаа болох "сэдэл", "зорилго" нь үгүй болох байсан гэж болгоомжилсон хэрэг. Өөрөөр хэлбэл энэ үгэнд "сэдэл" болон "цогцлохуй" гэсэн хоёр ч утга байгаа гэж үзсэн юм.

Энэ хорвоогийн бүхий л юмс үзэгдэл бол санаа сэдэл, оюун бодлоос л үүсэлтэй байдгийг Будда сударт олонтоо хэлсэн байдаг. Жишээ нь алдарт "Үнэний Харгуй" (*Dhammapada*) судрын эхэнд:

> "Бүхий л юмс үзэгдлийн эхлэл нь оюун ухаан юм. Оюун ухаан бүхний жанжин, бүхнийг бүтээгч."

---

[31] AN 9.66, *Upādānakkhandhasutta.*

Manopubbaṅgamā dhammā, manoseṭṭhā manomayā;

хэмээн хэлсэн байдаг.[32]

Saṅkhāra бол үйлдэл, байдал илэрхийлж буй нэр үг бөгөөд тэмдэг нэрийн болон нэр үгийн үүргээр, бусдаар үйлдүүлсэн шинж бүхий өнгөрсөн цагийн үйлт нэр байдал руу орсон хэлбэр нь *saṅkhata* юм. Тэгвэл *saṅkhata*-г "сэдэгдсэн-цогцолсон" гэж уг орчуулгад хэрэглэсэн болно. Өмнөх Нирваан хэсэгт, судstreet олонтоо хэрэглэгддэг, энэ үгийн үгүйсгэсэн хэлбэр болох *asaṅkhata*-г "эс сэдэгдсэн-цогцолсон" гэж оруулсан байсныг гярхай уншигч анзаарсан байх.

Сэдэхүй-цогцлохуй нь бие, хэл, сэтгэлийн үйл ажиллагааг "сэдэж-цогцлоох" шинжтэй үйл явц бөгөөд, ялангуяа сэтгэлд үүсэх сэдэл, чиглэлийг илэрхийлнэ. Үйл (па. *kamma,* сам. *karma*) нь санаа сэдлээс үүсэн бий болж, улмаар үүнээс "үйлийн үр" (па. *kamma-vipāka*) боловсрох нөхцөл болдог. Үүнийг номын үгээр хэлбэл, мунхаг-төөрөгдөл болон хүсэл шуналаас үүдэн, үйлийн үр хийгээд дахин дахин төрөхүйн шалтгааныг таригч, сэдэхүй, зорихуй, тусгахуйн шинж чанар бүхий тэрхүү хэлбэржих, цогцлох үйлийг энэ орчуулгад "сэдэхүй-цогцлохуй" гэж томьёолсон хэрэг.

Эртний сударт[33] үүнийг арай өөр байдлаар:

> "Ямар ч зовлон байдаг бай, тэр бүгд сэдэхүй-цогцлохуйгаас шалтгаалж үүсдэг. Сэдэхүй-цогцлохуй төгссөнөөр зовлонгийн үүсэл үгүй болно."
> *Yaṃ kiñci dukkhaṃ sambhoti, sabbaṃ saṅkhāra-paccayā; saṅkhārānaṃ nirodhena n'atthi dukkhassa sambhavo.*

хэмээн хэлсэн байдаг нь уг үг дээр сайн тайлбар болдог.

Ижил утга санаа бүхий *saṅkappa* гэсэн паали үг байдаг нь "зорилго, сэдэл" гэсэн утгатай. Хэдийгээр язгуур, гарал үүсэл нь хэл шинжлэлийн хувьд ижил гэж шууд үзэх боломжгүй ч, энэ орчуулгад утгын холбоог нь хадгалах үүднээс *saṅkappa* болон *saṅkhāra* хоёрыг ойролцоо уншигдах, ойлгогдох байдалд нийцүүлсэн юм. Түүнчлэн, Гэгээнтний Найман Замналын хоёр дахь шат бол "Зөв Сэдэл" (*sammā saṅkappa*). "Зөв сэдэл" нь "сэдэхүй-цогцлохуй"-тай нь утгаараа ижилсэх боловч практик түвшинд тусдаа байдлаар тодорхойлогддог ойлголт болдог.

Цаашилбал ерөнхий утгаараа, "сэдэхүй-цогцлохуй" нь үхэх төрөхийн эргэлт (*saṁsāra*) дотор эргэлдсээр байх үндэс суурийг бүрдүүлдэг, мөнхийн-бус (*anicca*) болон зовлонт (*dukkha*) шинж чанартай юмс үзэгдлүүдийг хамардаг. Энэ орчуулгад ийм өргөн хүрээтэй хэрэглэгдсэн буюу сударт олон тоон дээр бичигдсэн ("*saṅkhārā*" гэж) байгаа тэдгээр хувилбарыг "сэдэхүй-цогцлохуй бүхэн" гэсэн байдлаар томьёолон оруулсан болно.

---

32 "Оюун ухаан" гэдэг нь "оюун бодол, сэтгэл санаа, бодол санаа" гэдэг утгаар. Энэ номд "*mano*"-г оюун-ухаан гэж томьёолсон болно. Лавлахад *mano*-г дэлгэрэнгүй үз.

33 *Sutta Nipāta, Verse* 731.

Энэхүү орчуулга нь *saṅkappa*, *saṅkhāra*, *saṅkhata* гэсэн үгсийн хоорондын холбоог монгол нэр томьёонуудад зориудаар хадгалах гэж оролдсон болно. Орчуулагчийн хувьд Паали Судартбуй чухал ойлголтын нэг хэсэг мөн гэж ойлгосон зүйлээ тусгахын тулд нийтлэг язгуур болох "сэд-"-ийг тэдгээр томьёололдоо суурь болгон оруулсан юм. Тэдгээр нь:

saṅkappa—"сэдэл";
saṅkhāra—"сэдэхүй-цогцлохуй";
saṅkhārā—"сэдэхүй-цогцлохуй бүхэн";
saṅkhata—"сэдэгдсэн-цогцолсон";

Энэ нь эдгээр нэр томьёоны тохиолдол бүр нь утга зүйн хувьд ижил гэсэн санаа биш бөгөөд харин орчуулгын нэгэн аргачлал байсныг тэмдэглэж буй хэрэг юм.

"Сэдэхүй-цогцлохуй бүхэн"-ий мөн чанарыг Будда нэгэн судартbr[34] ийнхүү айлджээ:

> "'Сэдэхүй-цогцлохуй бүхэн мөнхийн-бус[35]' хэмээн тэр саруул ухаанаар харна. Тэр л үед тэрбээр зовлонд татагдахаа болих ба, үүнийг ариусахуйн замнал гэнэ."
> *"Sabbe saṅkhārā aniccā"ti, yadā paññāya passati; Atha nibbindati dukkhe, esa maggo visuddhiyā.*

Энэ бол ердөө нэг гүн ухааны тодорхойлолт бус, харин бясалгагч хүмүүн өөрийн сэдэхүй-цогцлохуй буюу нөхцөлдөн бий болсон юм бүхнийг ажиглах явцад, тэдгээр нь хэрхэн үүсэн бий болж, хэрхэн замхран алга болж буй мөнх бус, тогтворгүй, найдваргүй шинж чанарыг бодитоор харах тухай юм.

Тэдгээр цогцолсон үзэгдлүүд нь эцсийн Нирваанд нэгмөсөн хүрснээр цаашид дахин үүсэх шалтгаангүй болж, *saṅkhārā*-гийн урсгал хэлхээ нь нэгмөсөн тасардаг. Сэдэхүй-цогцлохуйн энэхүү хөдөлгөөн зогсож, сэдэхүй-цогцлохуйн юм бүхнээс ангижрахыг "*saṅkhāra-upasama*" буюу сэдэхүй-цогцлохуйн намжихуй, унтрахуй гэх бөгөөд энэ нь Нирвааны өөр нэгэн нэршил ч болдог. Тиймээс энэ орчуулгад *saṅkhārā*-г "сэдэхүй-цогцлохуй" болон "сэдэгдсэн-цогцолсон" гэсэн байдлаар буулгахдаа уншигчийг өөрийн сэтгэлийн гүн дэх тэрхүү "бүтээгч" үйлдлийг ажиглах болон ерөөс энэ хорвоогийн сэдэхүй-цогцлохуйн бүх юмсыг илтэд харахад нь туслахыг зорьсон хэрэг юм.

Бярман Тэнгэр—Brahmā

(анг. *Brahma*, сам. *Brahmā*)

Энэ хорвоогийн 31 орны дээд зиндаа болох Бярман Тэнгэрийн Оронд, 20 ялгаатай орон байдгийг "Будда" хэсэгт тайлбарласан. Энэ оронд хамаарах бодгалиуд буюу *Brahmā*-г "Бярман Тэнгэр", эсвэл "Тэнгэр", харин *Mahābrahmā*-г "Бярман Дээд Тэнгэр" гэж томьёолсон байдлаар тус орчуулгад хэрэглэсэн болно. Бярман тэнгэрийн орны Тэнгэрүүд бол энэ хорвоо ертөнцийн хамгийн дээд төрөл юм.

---

[34] *Dhammapada Verse* 277.
[35] "Мөнхийн-бус" (*aniccā*)-ыг Лавлахад үз.

Мөн үүнтэй хэлбэр, гарал ойролцоо дараах үгс сударт олонтоо гарах ба тэдгээр нь утгаараа нэлээд ялгаатай. Үүнд:

1. *brahma*—тэнгэрлэг, ариун;
2. *brāhmaṇadhamma*—Бярман шашны ёс, сургаал;
3. *brāhmaṇa*—

- бярман анги давхарга;
- бярман анги давхаргын хүн;
- бярман лам, даянч, номлогч;
- ариуссан, гэгээрсэн нэгэн (Буддын номоор);
- мэргэн ухаант хүмүүн.

Монгол хэлэнд байгаа "бярман" нь жинхэнэ нэр болон тэмдэг нэрийн аль алинд нь хэрэглэгддэг. Мөн бярман (*brāhmaṇa*) гэдэг үгийг сударт хоёр өөр үндсэн утга санаагаар хэрэглэдэг болохыг уншигч нэгэн анхаарвал зохилтой юм. Үүнд, нэг нь шашин, нийгмийн анги давхаргыг заасан уламжлалт утга, нөгөө нь ёс суртахуун, оюуны ариуслыг илэрхийлсэн утга байгаа юм. Бярман анги давхарга нь голдуу бярман шашны зан үйл эрхлэгч лам, тахилч нараас бүрдэх боловч, тэдэн дунд лам бус, бярман угсааны хар хүмүүс нь мөн багтаж байгаа болно. Энэ бярман шашны уламжлал нь хожим Хинду шашны тогтолцоонд шингэн хөгжсөн гэж түүхэн талаас нь авч үздэг.

Готама Будда бол бярман шашинтай язгууртан анги давхаргын гэр бүлд төрсөн хүн. Тэрбээр зарим бярман лам нарыг, эсвэл энэ шашны зан үйлийг нь олонтоо шүүмжилж, буруушааж буйгаар судар гарах хэдий ч, мөн гэгээрсэн, ариуссан хүмүүсийг ч бас "жинхэнэ бярман" (*visuddhibrāhmaṇa*) гэх мэт хэллэгээр ярьж, "бярман" үгийг ашигладаг байж. Өөрөөр хэлбэл, "бярман" гэдэг нь зөвхөн төрсөн гарал, анги давхарга бус, харин хүний дотоод ариусал, зан чанарыг илэрхийлэх утгаар ч мөн хэрэглэгдэж байж.

Буддын сургаалд дээд анги гарал, сайн удам угсаа, хөрөнгө баялаг зэрэг нь ариун, гэгээн гэж тооцогдох, эсвэл тийм болох шалтгаан нь болдоггүй бөгөөд харин хүний өөрийн үйлдэл, ёс суртахуун, ухаарал нь чухал гэж үздэг санааг Ваасеттха[36] Сударт:

> "Төрөл гарлаараа бярманд тооцогдохгүй, төрөл гарлаараа бярман бусд тооцогдохгүй. Хийсэн үйлээрээ бярманд тооцогдож, хийсэн үйлээрээ бярман бусд тооцогдоно."
> *Na jaccā brāhmaṇo hoti, na jaccā hoti abrāhmaṇo; kammunā brāhmaṇo hoti, kammunā hoti abrāhmaṇo.*

хэмээн тодорхой хэлсэн байдаг. Энэ жишээнээс "бярман"-ыг Будда хэл яриандаа хэрхэн ашиглаж ярьдаг байсныг харж болох юм.

[36] MN 98, *Vāseṭṭha Sutta.*

Ариуссан, Гэгээнтэн—Ariya

(анг. *noble*, сам. *ārya*)

Түүхэн талаас нь авч үзвэл, “*ariya*” гэх нэршил нь эртний Энэтхэг, иран хэл соёлын хүрээнд, угсаа язгуур, уламжлал соёлын шинжтэй нэршил байдлаар хэрэглэгдэж байсан гэж үздэг. Тэгвэл энэ угсаа гарлын хүн болох Готама Буддагийн цаг үед энэ үг нь анхдагч утгаа алдаагүй байсан хэдий ч, Паали Судрт ариусал гэгээрэлтэй холбоотой нэн чухал байр суурь бүхий “Гэгээнтэн”, “Гэгээнтэн хүний”, “Ариуссан хүмүүний”, “Ариуссан” гэх зэрэг утгыг голчлон илэрхийлэх болсон байна.

Өөрөөр хэлбэл, *ariya* нь угсаа гарал, эд хөрөнгө, нийгмийн зэрэг зиндааг илэрхийлсэн үг гэхээсээ илүүтэй, сэтгэл санааны ариусал, ангижрал, гэгээрлийг илэрхийлдэг, гэгээрсэн хүмүүн, эсвэл гэгээрэх замдаа орсон хүнийг нэрлэж байсан ойлголт гэдгийг эртний судрууд илтгэн харуулдаг. Жишээлбэл, Гэгээрсэн Шавь Сударт[37]:

> “Хуврагууд аа, гэгээрсэн шавь бээр Гэгээнтний зөв үзлийг[38] ойлгох цагт... түүнийг гэгээрсэн шавь, Урсгалд Орогч хэмээн нэрийддэг...”
> *Yato kho, bhikkhave, ariyasāvako ariyaṃ sammādiṭṭhiṃ pajānāti ... ayaṃ vuccati, bhikkhave, ariyasāvako sotāpanno ...*

гэжээ.

Зарим номд энэ үгийг “хутагт” хэмээн орчуулсан байдаг нь орчин цагийн монгол хэлний ойлголттой тодорхой хэмжээнд зөрчилдөх талтай. Учир нь дийлэнх хүмүүсийн хувьд, “хутагт” гэдэг үгийг түүхэн утгаараа, дээд язгуур угсаа, баян чинээлэг анги давхарга, эсвэл ямар нэг ер бусын чадвартай хүнтэй холбон ойлгох нь элбэг. Мөн албан ёсны Монгол хэлний тайлбар толийг үзвэл, “хутагт” гэдэг нь “хутаг” (хувь зохиол олох, их буянтан болж, зол жаргалыг эдлэх... г.м.)-ийг олсон хүн, мөн өөрөөр “шашны ёсны сайны хутаг олсон хувилгаадад олгох цол” хэмээн тайлбарласан байгааг үзвэл, эртний судрын энэ үгийн үндсэн утгатай бүрэн нийцэхгүй байж болохоор байна.

Иймээс Паали Судрын утга санааг орчин цагийн уншигчдад илүү ойлгомжтой, харьцангуй оновчтой хүргэх үүднээс *ariya*-г дараах байдлаар энэ орчуулгад буулгасан болно. Үүнд:

- “Гэгээнтний Дөрвөн Үнэн”—*cattāri ariyasaccāni*;
- “Гэгээнтний Найман Замнал”—*ariyo aṭṭhaṅgika magga*;
- “Ариуссан Хуврагийн Чуулган”—*ariya-saṅgha*;
- “гэгээрсэн шавь”—*ariya-sāvaka*;
- “гэгээрсэн хүмүүн”—*ariya-puggala*;

---

[37] SN 12.49. *Ariyasāvakasutta.*

[38] Гэгээнтний Найман Замналын хамгийн эхний шат нь. Аливаа хүмүүн Урсгалд Орогч болох үед Гэгээнтний Найман Замналын эхний шат, Зөв Үзэл (*Sammā-diṭṭhi*)-ийг яг чухам үнэнээр нь ухаарах буюу Зөв Үзэл гэдэг нь Гэгээнтний Дөрвөн Үнэнийг бүхэлд нь, өөрийн биеэр ойлгосон хүмүүний хорвоог үзэх үзэл юм (SN 12.49).

- “Гэгээнтэн”, “ариун”—*ariya* г.м.

Гэгээнтний Дөрвөн Үнэн, Гэгээнтний Найман Замналыг: “Гэгээрлийн Дөрвөн Үнэн”, “Гэгээрлийн Найман Замнал”, эсвэл “Ариуссан Дөрвөн Үнэн”, “Ариуссан Найман Замнал” гэж орчуулахад утгын хувьд буруудахгүй, мөн уншигчдын сэтгэлд буухад илүү дөхөм байж болох талтай. Гэсэн хэдий ч, уг нэр томьёо нь Паали хэлний бүтцэд нэр үгийн шинжтэй байгааг нь харгалзан үзэж, эх хэлний хэлзүйн шинжийг нь дагасан болно.

Түүнчлэн Буддын сургаалд, гэгээрлийн замаар замнагч бээр ямар ч овог аймгийн, ямар ч анги давхаргын хүн байж болох ба хамгийн гол нь зөв замыг ойлгож ухаарч, Сургаал номыг дагаж, үүнийгээ хэрэгжүүлснээр л *ariya* болох боломжтой байдгийг заасан байна. Үүний жишээг өмнөх Бярман хэсэгт дурдсан Ваасеттха Судраас харж болно.

Иймээс энэ номд “*ariya*”-г “ариун”, “ариуслын”, эсвэл “Гэгээнтэн”, “Гэгээнтний” гэх мэтээр тухайн нөхцөлд тохируулан оруулсан болно.

Мунхаг-Төөрөгдөл—Avijjā

(анг. *ignorance*, сам. *avidyā*)

“*Avijjā*” гэдэг нь аливаа зүйлсийг туйлын үнэн талаас харахгүй, хорвоог буруугаар ойлгож, гүнзгий төөрсөн байгааг хэлнэ. Ялангуяа зовлон (*dukkha*), түүний шалтгаан, төгсгөл, төгсгөлд хүргэх зам буюу Гэгээнтний Дөрвөн Үнэнийг үл ойлгох, буруу ойлгохыг илэрхийлнэ.

Энэ үгийг “тэнэг мунхаг” гэх мэтээр доромж өнгө аяс бүхий утгаар ойлгож болохгүй юм. Буддын сургаалд *avijjā* нь хүнийг буруутгах, дорд үзэх ойлголт биш бөгөөд харин аливаа гэгээрээгүй хүний бодит байдлыг буруу харах, эндүүрэлд автах байдлыг хэлдэг. Жишээлбэл, Паали Судалт[39]:

> “Судар номд суралцаагүй, гэгээрээгүй эгэл хүн... мунхаг-төөрөгдөлд сохорсон, хүсэл шуналд хүлэгдсэн байдаг.”
> *Assutavā puthujjano... avijjānīvaraṇo taṇhāsaṃyojano.*

хэмээн хэлсэн байна.

Иймээс “мунхаг-төөрөгдөл” гэдэг нь оюуны чадвар дутмаг гэсэн утга биш бөгөөд харин туйлын үнэн, туйлын бодит байдлыг буруугаар харж буй гүн гүнзгий төөрөгдөл юм. Ийм мунхаг-төөрөгдлөөс үүдэн “сэдэхүй-цогцлохуй” (*saṅkhārā*) бий болж, улмаар үхэх төрөхийн эргэлт (*saṁsāra*) үргэлжилдэг. Иймээс *avijjā* нь учир шалтгаанаар урган бий болохуйн (*paṭiccasamuppāda*) хэлхээний эхлэл болдог. *Avijjā* гэдэг нь зөвхөн мэдлэггүй байхыг хэлэхгүй, харин аливааг буруу танин мэдэх, эндүүрэлд автах, бодит байдлыг гажуудуулан ойлгох бөгөөд эсрэг ойлголт нь “*vijjā*” буюу зөв мэдлэг, ухаарал юм.

---

39 SN 12.61, *Assutavāsutta.*

Энэ номд ойролцоо утгатай ойлгогдож болох хэд хэдэн үг байгааг дараах байдлаар томьёолсон болно.

- “мунхаг-төөрөгдөл”—*avijjā*. Дөрвөн оюуны-хорлолын нэг, Арван сэтгэлийн-хүлээсний нэг, сэтгэлийн уг гүнд орших төөрсөн байдал;
- “төөрөгдөл”—*moha*. Арван сэтгэлийн-хирийн нэг, мунхаг-төөрөгдлийн илрэл, төөрсөн, андуурсан, эндүүрсэн байдал;
- “мунхаг”—*bāla*. Балай, ухаан хомс гэсэн утга;
- “буруу үзэл”—*micchā-diṭṭhi*. DN 1-д гарах 62 буруу үзэлд хамаарах ойлголт.

Зарим Ойролцоо Утгатай Үгс

(Цаашид “Ойролцоо Үг” гэж товчилно)

Сэтгэлийн таатай хийгээд таагүй байдал, эерэг сөрөг хандлагыг илэрхийлэх болон бусад ойролцоо утгатай олон үг Паали Судартгарах бөгөөд орчин цагийн Буддын судлалд тэдгээр үгс нь ялгамжаатай нэр томьёо болж хэрэглэгддэг. Тэдгээр үгийн ялгааг харуулах, мөн тэдгээрт өргөн утга буйг илэрхийлэх үүднээс тусгай нэр томьёо хэлбэрт оруулж энэ орчуулгад хэрэглэв. Эдгээр үгс нь ихэвчлэн нэг ижил утгаар орчуулагдах хандлагатай боловч, паали эхэд өөр өөр сэтгэлзүйн болон ёс суртахууны нарийн ялгааг илэрхийлдэг. Тэдгээрийг энд товч байдлаар жагсаая.

Сөрөг талаас:

- “зүхэл хорсол үгүй”—*averena*;
- “хар-санаа, хорлол үгүй”—*abyāpajjena*;
- “гомдол”—*āghāto*;
- “унтуучал”—*appaccayo*;
- “дургүйцэл”—*anabhiraddhi*;
- “зэвүүцэл”—*paduṭṭhacitta*;
- “санаа зөрөх”—*arati*;
- “зөрчил-хорсол”—*paṭigho*;
- “хар-санаа”—*byāpāda*;
- “зовнил-гуниг”—*domanassa*;
- “уур-хилэн”—*dosa*;
- “харгис-санаа”—*vihiṃsa*.

Нэр томьёо болгосон эдгээр үг нь бүгд хольж сольж болохуйц нэг ижил утгатай гэж тооцогдохгүй бөгөөд сэтгэлийн эерэг сөрөг төлөв байдлын ялгамжаатай өнгө аясыг илэрхийлнэ. Тиймдээ ч, олон улсын буддын судлалд, эдгээр үгийн зарим нь дангаараа нэг бие даасан нэр томьёо болж хэрэглэгддэг болохыг анхааралтай авч үзэх хэрэгтэй юм.

Тухайлбал, Агуу Дүүрэн-Анхаарал Суулгахуй Судар (DN 22. *Mahāsatipaṭṭhāna Sutta*)-т, “Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж...” гэсэн хэсэг байдгийн “зовнил-гуниг”-ийг

шууд байгаагаар нь, зөвхөн "зовнил", эсвэл зөвхөн "гуниг" гэж ойлгож болохгүй юм. Учир нь "зовнил-гуниг"-ийг Лавлахад: "Аливаад дургүй, таагүй байх, бухимдах, зовуурилах, мөн уйтгар гуниг, уй гашуу зэрэг сэтгэлийн эс нийцэх, зовуурь бүхий таагүй байдлыг нийтэд нь хамруулан хэлсэн үг." хэмээн нэлээн өргөн хүрээг хамруулан тайлбарласан байгаа юм.

Өөр нэгэн жишээг татвал, Учир Хамааралтай Уг Гарал (*Paṭiccasamuppāda*) болон сэтгэлийн төлөв байдлыг ангилан тайлбарлахад чухал ач холбогдолтой байдаг. Жишээ авбал, Хамаг Учир Шалтгаан Сударт[40], дон-шунал (*upādāna*) нь хүсэл-цангаа (*taṇhā*)-аас нөхцөлдөн бий болдог тухай байна. Гэтэл энгийн ярианд дон, шунал, эсвэл хүсэл, цангаа гэх үгсийн хооронд томоохон ялгаа бараг үгүй мэт боловч, харин Паали Судрын хувьд эдгээр нь нэлээд ялгаатай ухагдахуунууд болдог. Тиймээс үүнийг тэмдэглэх үүднээс ийм нэр томьёо болгосон хэрэг.

Эерэг талаас[41]:

- "хичээл зүтгэл"—*ātappa*;
- "хүчин чармайлт"—*padhāna*;
- "чин эрмэлзэл"—*anuyoga*;
- "уйгагүй мэрийлт"—*appamāda*;
- "таатай байдал"—*assāda*;
- "сэтгэл ханамж"—*santosa*;
- "хүсэл-эрмэлзэл"—*chando*;
- "хүсэл-мөрөөсөл"—*abhijjha*;
- "мэдрэхүйн-таашаал"—*kāma*;
- "мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл"—*kāmacchando*;
- "дур-хүсэл"—*rāga*;
- "хүсэл-цангаа"—*taṇhā*;
- "хүсэл-тачаал"—*chandarāga;*
- "шунан-дурлахуй"—*ajjhosāna*;
- "шунал"—*lobha*;
- "дон-шунал"—*upādāna*;

гэх мэт байдлаар томьёолсон цөөнгүй үг бий.

Дээрх нэр томьёонуудыг үгийн утгынх нь хүчдэлээр нь жагсаах гэж оролдсон бөгөөд сэтгэл мэдрэмжийн нарийн байдлыг тусгахад үг тус өөрийн гэсэн ялгамжаатай зэрэг түвшнийг илэрхийлдэг.

Гэвч заавал сануулах учиртай нэг тохиолдол гэвэл, DN 2 судрын "таван-саад" ойлголтод хүсэл-мөрөөсөл (*abhijjhā*)-ийг хэрэглэсэн байдаг бол, харин DN 22 судрын "таван-саад" ойлголтод, энэ үгийн оронд

---

[40] DN 15, *Mahānidānasutta*.

[41] Эдгээр үгс бол зарим нь хичээл зүтгэл, зарим нь хүсэл шуналтай холбоотой бөгөөд бүгдийг нь эерэг сайн үйл гэдэг утгаар ангилаагүй болохыг анхаарна уу.

"мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл" (*kāmacchando*)-ийг хэрэглэсэн байдаг. Иймээс энэ хоёр үгийг утга зүйн хувьд ойролцоо үгүүд гэж авч үзэж болно.

Цаашилбал, "хүсэл-цангаа" (*taṇhā*) нь аливаа зүйлийг хүсэх, түүгээр дутагдах гэсэн ерөнхий утгатай гэж үзвэл, харин "хүсэл-тачаал" (*chandarāgo*) нь хүсэл-цангаанаас илүү хүчтэй дур тачаал гэж үзэж болно. Тэгвэл "шунан-дурлахуй" (*ajjhosāna*)-г аливаад дурлаж, шунах, "өөрийн болгох хүсэлд автах" гэх мэт утгатай гэж үзэх бөгөөд энэ үг нь "хүсэл-цангаа"-аас бол хавьгүй хүчтэй юм. Шунан-дурлахуйг "дон-шунал" (*upādāna*)-тай ойролцоо гэж харж болох ч, арай ч тийм хүчтэй биш ч гэж үзнэ.

Харин жагсаалтад орсон "шунал" (*lobha*) нь энэ номын паали эхэд хараахан байхгүй үг ч, зүүлт тайлбарт цөөнгүй хэрэглэгдсэн, голдуу ерөнхий нэршил байдлаар Буддын сургаалд хэрэглэгддэг үг болно. Иймээс дундуур зураас хэрэглэж нэр томьёо болгосон үгийг тэр тусмаа анхаарч авч үзэх нь зүйтэй юм.

Цаашилбал:

- "мэдрэмж"—*vedanā*;
- "мэдрэхүйн-харилцаа"—*phassa*;
- "мэдрэхүйн-харилцааны хүрээ"—*phassāyatana*;
- "мэдрэхүйн-хүрээ"—*āyatana*;
- "нүдний-ухамсар"—*cakkhuviññāṇa*;
- "оюун-ухаан"—*mano*;
- "оюун-ухамсар"—*viññāṇa*;
- "саруул-ухаан"—*paññā*;
- "сэтгэл"—*citta (ceto)*;
- "сэтгэлийн-хир"—*kilesā*;
- "оюуны-хорлол"—*āsava*;
- "сэтгэлийн-хүлээс"—*saṁyojana*;

гэх зэрэг, номын хувьд нэлээд чухалд тооцогдох үгс байна. Эдгээр үг бүрийн утгыг зүүлт тайлбар болон Лавлахаас харах боломжтой.

Иймд тухайн үгийг орчуулж ойлгохдоо зөвхөн монгол үгийн өнгө аяс, эсвэл энгийн ярианы утгаар нь бус, харин тухайн сургаал доторх агуулга, мөн тайлбар сэлтэд байгаа нарийвчлан тодорхойлсон утгуудыг хамтад нь авч үзэх, мөн тэдгээрийг санаж байх нь номыг гүнзгий түвшинд ухан ойлгох хүсэлтэй сонирхогч болон судлаач нарт илүү оновчтой байх болно гэдгийг хэлье. Ингэснээр паали эх үгсийн ялгааг илүү нарийвчилсан байдлаар тусган авах боломжтой болох болов уу. Бүх нэр томьёоны тайлбар сэлт нь Судрын Аймгийн Багц, Сахилын Аймгийн Багц, Дээд Номын Багц болон зарим тайлбар судрууд, мөн орчин цагийн судалгааны ном, бүтээлүүдээс иш татаж хийгдсэн болно.

Хэдийгээр эдгээр олон үгийг дундуур зураас хэрэглэж, Тайлбар, Лавлахаас нягтлах шаардлагатай нэр томьёо хэлбэрт оруулсан ч, уншигдах байдлаараа эдгээр үг нь гаргах гэсэн санаагаа ямар нэг хэмжээгээр өөртөө агуулж байгаа гэж нөгөө талаас үзэж болно. Учир нь олон уншигчийн хувьд, тэр болгон үг бүрийг энэ Тайлбар, зүүлт, Лавлах хэсгээс шүүж харах, бүр эсвэл үг бүрийг цээжээр санах боломжгүй байж болох

юм. Эсвэл зарим уншигчдын хувьд маш энгийн байдлаар, нэр томьёонд ач холбогдол өгөлгүйгээр гүйлгэн унших ч сонирхол байж болох юм гэж орчуулагчийн зүгээс үзсэн тал байгаа. Тэдгээр уншигчдын хувьд зураасаар холбосон, том үсгээр эхлүүлсэн эдгээр нэр томьёонд онц ач холбогдол өгөлгүйгээр үргэлжлүүлэн уншихад ч ном ойлгогдох боломжтой байж болох юм.

Ингээд таныг Дэлгэрэнгүй Хүүрнэл Ботийн дээж нь болох арван судрыг уншиж судлахад урин залж байна.

БЯРМАН ТЭНГЭРИЙН УРХИ СУДАР
DN 1. BRAHMAJĀLASUTTA

1. Тэнүүлч Бадарчдын Яриа (Paribbājakakathā)

БИ ИЙН СОНССОН ЮМ.[1]

Нэгэн удаа Будда таван зуу орчим хувраг бүхий Хуврагийн Чуулганы хамтаар Раажагаха, Нааландаа хоёрын хоорондох гол замаар явж байлаа. Тэр үед Бярман шашны бадарчин[2] Суппияа[3], мөн Раажагаха, Нааландаа хоёрын хоорондох тэр замаар өөрийн шавь Брахмадаттагийн хамтаар явж байв. Замдаа бадарчин Суппияа нь Будда, түүний Сургаал, мөн Хуврагийн Чуулганыг олон янзаар доромжилж байв. Гэвч түүний шавь, залуу Брахмадатта нь харин Будда, түүний Сургаал, мөн Хуврагийн Чуулганыг олон янзаар магтан сайшааж ярих аж. Ийнхүү багш шавь хоёр Будда болон хуврагуудын араас даган явах зуураа бие биетэйгээ илт зөрчилдөн мэтгэлцэж байв.

Дараа нь Будда хуврагуудын хамт Амбалаттхикаа хэмээх хаадын цэцэрлэгт хүрээлэн уруу, хоног төөрүүлэхээр оров. Бадарчин Суппияа өөрийн шавь Брахмадаттагийн хамт шөнийг өнгөрөөхөөр мөн тэр Амбалаттхикаа нэртэй хаадын цэцэрлэгт хүрээлэн рүү явж орлоо. Тэнд мөнөөх Суппияа бас л үргэлжлүүлэн Будда, түүний Сургаал, мөн Хуврагийн Чуулганыг олон янзаар доромжилж байсан бол түүний шавь Брахмадатта харин тэднийг олон янзаар магтан сайшааж ярьж байлаа. Ийнхүү багш шавь хоёр бие биедээ илт зөрчилдсөн мэдэгдэл хийж, хамтдаа тэнд суух аж.

Үүр цайхад хэд хэдэн хуврагууд босож асарт цуглав. Тэднийг хамтдаа сууж байтал дунд нь дараах яриа өрнөв:

“Анд нөхөд өө, Эрхэм Буддагийн мэдсэн хийгээд ухаарсан нь, төгс гэгээрсэн түүний энэ ертөнцийн бүхий л бодгалийн шинж чанарын олон талт байдалд хэр гүнзгий нэвтэрсэн нь гайхалтай бөгөөд агуу билээ. Шавь Брахмадатта нь Будда, түүний Сургаал, мөн Хуврагийн Чуулганыг олон талаас нь магтан сайшааж ярьж байхад харин түүний багш, бадарчин Суппияа Будда, түүний Сургаал, мөн Хуврагийн Чуулганыг олон янзаар хэлж, доромжилж байна. Энэхүү багш шавь хоёр биднийг ийм ойрхон даган явах атлаа илтэд бие биетэйгээ зөрчилдөж, маргалдаж байдаг шүү.” гэцгээв.

Тэгтэл Будда тэдний яриа хааш эргэхийг анзаараад, асарт орж ирээд, бэлдсэн олбог суудал дээр суугаад, хуврагуудад хандан ийн өгүүлрүүн:

---

1. *Evam me suttaṃ*— “БИ ИЙН СОНССОН ЮМ”. Үгчилбэл, “Ингэж надад сонсогдсон юм”. Паали Судрын уламжлалт эхлэл. Судруудыг Аананда бээр Буддагийн амнаас өөрөө ийн сонссон гэдгээ илтгэн хэлж буй санаа бөгөөд DN-ийн бүх судар энэ хэллэгээр эхэлнэ.
2. *Paribbājaka*—“бадарчин”. Сүсэг бишрэлийн шалтгаанаар бадар барин амьдрагч, даянч, тэнүүлч, бадарч хүн.
3. Тэрээр Санжаяа Белаттхипуттагийн (DN 2.3.6-г үз.) дагалдагч юм. Буддагийн шадар хувраг Саарипутта (*Mahā Sāriputta*), Моггаллаана (*Mahā Moggallāna*) нар анх Санжаягийн шавь нар байсан ба тэд Буддад “урвасан” явдал нь Санжаягийн нэр хүндэд нөлөөлснөөс гадна уг явдал нь Суппияаг Буддад хорсоход хүргэсэн гэдэг (DA).

"Хуврагууд аа, та нар яг одоо юун тухай, ямар яриа хөөрөөг өрнүүлж байна вэ? Та нарын яриа хөөрөөний сэдэв юун тухай байв даа?" гэхэд, хуврагууд өгүүлрүүн:

"Эрхэм Багш аа[4], үүр цайхад бид босож асарт цугласан юм. Биднийг энд сууж байхад бидний дунд дараах яриа өрнөлөө:

'Эрхэм Буддагийн мэдсэн хийгээд ухаарсан нь, төгс гэгээрсэн түүний энэ ертөнцийн бүхий л бодгалийн шинж чанарын олон талт байдалд хэр гүнзгий нэвтэрсэн нь гайхалтай бөгөөд агуу билээ. Шавь Брахмадатта нь Будда, түүний Сургаал, мөн Хуврагийн Чуулганыг олон талаас нь магтан сайшааж ярьж байхад харин түүний багш, бадарчин Суппияа Будда, түүний Сургаал, мөн Хуврагийн Чуулганыг олон янзаар хэлж, доромжилж байна. Энэхүү багш шавь хоёр биднийг ийм ойрхон даган явах атлаа илтэд бие биетэйгээ зөрчилдөж, маргалдаж байдаг шүү.' Биднийг яг ийн ярилцаж байхад Багш аа, та энд ирлээ." гэхэд,

"Хуврагууд аа, хэрэв бусад хүмүүс Буддаг[5], түүний Сургаалыг, мөн Хуврагийн Чуулганыг доромжлон гутааж ярих аваас, энэ явдлаас болж та зүрх сэтгэлдээ гомдол, унтууцал, дургүйцэл, алинд нь ч автаж болохгүй юм.

Хуврагууд аа, хэрэв бусад хүмүүс Буддаг, түүний Сургаалыг, мөн Хуврагийн Чуулганыг доромжлон гутааж ярих аваас, энэ явдлаас болж та зүрх сэтгэлдээ гомдол, унтууцал, дургүйцэлд автах юм бол энэ нь зөвхөн танд л хохиролтой байх болно.

Хуврагууд аа, хэрэв бусад хүмүүс Буддаг, түүний Сургаалыг, мөн Хуврагийн Чуулганыг доромжлон гутааж ярих аваас, энэ явдлаас болж та зүрх сэтгэлдээ гомдол, унтууцал, дургүйцэлд автах юм бол эдгээр хүмүүсийн хэлсэн үгний зөвийг нь буруугаас нь ялгаж салгаж өгөх сэхээтэй байж чадах болов уу?" гэхэд,

"Мэдээж үгүй, Багш аа." хэмээн, хуврагууд хариулав.

"Хуврагууд аа, хэрэв бусад хүмүүс Буддаг, түүний Сургаалыг, мөн Хуврагийн Чуулганыг доромжлон ярих аваас, худал зүйлийг нь худал байна гэж ялгаж салгаж: 'Ийм зүйл байдаггүй. Энэ бол үнэн биш юм. Ийм шалтгаанаар энэ нь үнэн биш юм. Тийм зүйл манай ном дотор байдаггүй. Ийм зүйл бидний дунд байдаггүй.' хэмээн тайлбарлаж өгөх учиртай билээ.

Хуврагууд аа, хэрэв бусад хүмүүс Буддаг, түүний Сургаалыг, мөн Хуврагийн Чуулганыг магтан сайшааж ярих аваас, энэ явдлаас болж та баяр баясал, таатай сайхан, сэтгэлийн цэнгэлд автаж болохгүй юм.

---

4 *Bhante*—"Эрхэм Багш" (анг. *Venerable Sir*, сам. *Bhadanta*). Хуврагууд нэг нэгнээ, эсвэл хар хүмүүс хувраг хүмүүсийг хүндэтгэн дуудах тогтсон нэршил. Зарим тохиолдолд "Эрхэм" гэж хэрэглэв.

5 Энэ тохиолдолд *Tathāgata*-г "Будда" гэж хэрэглэв. Будда өөрийн тухай ярих тохиолдолд ихэвчлэн III бие дээр ярьж байгаагаар судар дээр гарна. Үүний шалтгаан нь эдгээр тохиолдлын дийлэнхэд нь тэрбээр Сиддхаттха Готама гэдэг хувь хүний талаар бус харин нийт Будда нарын тухай, эсвэл Төгс Гэгээрсэн хүмүүсийг хамруулан ярьж буйтай холбон тайлбарладаг.

Хуврагууд аа, хэрэв бусад хүмүүс Буддаг, түүний Сургаалыг, мөн Хуврагийн Чуулганыг магтан сайшааж ярих аваас, энэ явдлаас болж та баяр баясал, таатай сайхан, сэтгэлийн цэнгэлд автах юм бол энэ нь зөвхөн танд л хохиролтой байх болно.

Хуврагууд аа, хэрэв бусад хүмүүс Буддаг, түүний Сургаалыг, мөн Хуврагийн Чуулганыг магтан сайшааж ярих аваас, үнэн зүйлийг нь үнэн байна гэж ялгаж салгаж: ‘Ийм зүйл байдаг. Энэ бол үнэн юм. Ийм шалтгаанаар энэ нь үнэн юм. Тийм зүйл манай ном дотор байдаг. Ийм зүйл бидний дунд байдаг.’ хэмээн тайлбарлаж өгөх учиртай билээ.

2. Сахил-Ухамсар Хэсэг (Sīlakkhandha Vagga)

2.1. Анхан Шатны Сахил-Ухамсар (Cūḷasīla)

Хуврагууд аа, эгэл жирийн хүн[6] Буддаг магтан сайшаахдаа, энгийн сахил-ухамсрын[7], ердөө л, анхан шатны, асар жижиг зүйлүүдийг нь ярьдаг. Тэгвэл тэр эгэл жирийн хүн Буддаг магтан сайшаахдаа ярьдаг, энгийн ухамсар ёс суртахууны, анхан шатны, асар жижиг зүйлүүд гэдэг нь юу байх бол?

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

‘Даянч Готама амьд биетийн амийг таслах[8] үйлийг нэгмөсөн орхисон, амь таслахыг ямагт тэр цээрлэдэг. Тэрээр, мод шийдэм хийгээд хутга сэлмийг нэгэнт орхиж, энэ хорвоогийн бүхий л амьд биетэд ухамсар ухаан, хайр энэрэл, өгөөмөр нинжин сэтгэлээр хандан, амьдран суудаг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

‘Даянч Готама хэн нэгний өгөөгүй зүйлийг[9] авах аливаа үйлийг нэгмөсөн орхисон бөгөөд ямарваа нэг өөрт нь өгөөгүй зүйлийг өөрийн болгохыг ямагт тэр цээрлэдэг. Тэрээр зөвхөн бусдын өгснийг авч, өгсөн зүйлийг нь хүлээн зөвшөөрдөг. Тэрбээр, хулгайн үйлээс ангид, цэвэр ариун байдлыг оршоон суудаг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

---

[6] *Puthujjano*—“эгэл жирийн хүн”. Гэгээрээгүй хүмүүс буюу сэтгэлийн-хүлээснээс хараахан салаагүй хүмүүс. Энэ үг нь гэгээрээгүй хүмүүсийг нэрлэдэг тогтсон нэршил болно.

[7] *Sīla*—“сахил-ухамсар”. Үндсэн утга: “сахил”, “сахилга”, “дээд ухамсар”, “өндөр ёс суртахуун”, “дэг” г.м. Аливаа хүмүүний бусдад харагдах гаднах байдал гэхээс илүү сэтгэлийн дотоод төлөв байдал, мөн чанар, итгэл үнэмшил бүхий өндөр дээд ухамсар, өөрөө өөртөө үнэнчээр даган биелүүлэх, сэтгэлийн, дотоод ухамсрын зөв төлөвшил. Хар хүний “таван сахил” *Pañcasīla* (Монголчуудын хэлж заншсан “гэнэн сахил”) бол аливаа хүнд ухамсар суулгах анхан шатны сахил юм. *Sīla*-г зарим тохиолдолд “ухамсар ёс суртахуун”, “сахил санваар”, “ухамсар” гэж хэрэглэв.

[8] *Pāṇātipāta*—“амьд биетийн амийг таслах”. Аливаа амьсгалдаг биетийг алах, амийг нь авах (NPG).

[9] *Adinnādāna*—“өгөөгүй зүйлийг авах”. Зарим бичвэрт “хулгай” гэж хэрэглэх явдал байх ч, паали эхэд “тухайн хүнд гардан өгөөгүй зүйл”-ийг хэлсэн байна.

‘Даянч Готама аливаа ариун-бус явдлыг[10] нэгмөсөн орхисон бөгөөд бэлгийн харилцааны ямарваа нэг үйлийг ямагт тэр цээрлэдэг. Тэр бол, хар хүмүүний үйлддэг бэлгийн харилцааны бүхий л үйлээс татгалзсан, ариун-явдалт нэгэн[11], нүглээс алс буйд[12] амьдран суугч билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

‘Даянч Готама үнэн бус, худал яриаг нэгмөсөн орхисон бөгөөд үнэн бус, худал яриаг ямагт тэр цээрлэдэг. Тэр бол итгэл эвдэгч нэгэн огт биш бөгөөд үнэнийг өгүүлэгч, үгэндээ эзэн, итгэл даахуйц, чин шударга нэгэн билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

‘Даянч Готама гүтгэлэг хийгээд бусдыг хагаралдуулсан яриаг нэгмөсөн орхисон бөгөөд гүтгэлэг хийгээд бусдыг хагаралдуулсан яриаг ямагт тэр цээрлэдэг. Бусдыг талцуулах үрийг тарьж, энэ талаас сонссон зүйлээ тэр талд нь ярьдаггүй. Бусдын эвдрэлцүүлэх үрийг тарьж, тэр талаас сонссон зүйлээ энэ талд нь ярьдаггүй юм. Ийм болохоор тэр бол харин ч бүр эвдрэлцсэн хүмүүсийг эвлэрүүлэгч, эвтэй хүмүүсийг эс эвдрүүлэгч нэгэн юм. Тэрбээр, эв эеийг эрхэмлэн сайшааж, эв найрамдлыг бататгах яриаг ярьж, энх тайвныг оршоон суудаг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

‘Даянч Готама бүдүүлэг болон дээрэнгүй яриаг нэгмөсөн орхисон бөгөөд бүдүүлэг болон дээрэнгүй яриаг ямагт тэр цээрлэдэг. Тэрбээр, эелдэг дотно, яруу ялдам, мэргэн цэцэн, утга уянгатай, сонорыг мялаах, хүний сэтгэл зүрхэнд хүрэх, түмний хүлээн зөвшөөрч сонсох, тийм үгсийг хэлдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

‘Даянч Готама хов жив хийгээд явган яриаг нэгмөсөн орхисон бөгөөд ямарваа нэг хов жив хийгээд явган яриаг ямагт тэр цээрлэдэг. Тэрбээр, цагаа олсон үед нь, үнэн баримттай, өгөөж тустай зүйлийг Сургаал номд нийцүүлж, сахил номын багшийн[13] ёсонд тааруулж, учир шалтгаанд суурилж, чухамхүү нүдээ олсон цагт нь, үнэнхүү цаг нь тохирсон үед нь, учир зүйгээр баталгаажихуйц, улмаар нэгийг

---

[10] *Abrahmacariya*—“ариун-бус явдал” (анг. *unchastity*). Ариуслын-замналд эс нийцэх “ариун-бус үйл”, “нүгэл”, “садар самуун” буюу аливаа бэлгийн харилцааны үйл (санаатайгаар үрийн шингэн гаргах), ялангуяа хурьцлыг хэлнэ. Энэ нь хуврагхүний хувьд засагдахгүй алдаа бөгөөд сахилаа шууд алдаж, энэ насандаа дахин сахил авах эрхгүй болно (Vin; DA).

[11] *Brahmacārī*—“ариун-явдалт нэгэн”. Аливаа бэлгийн харилцааны үйлээс нэгэнт татгалзсан, гэгээрэл өөд чиглэсэн, ариун ёсны амьдрал, ариуслын-замналаар замнагч, ариун-сахилтан. Эртний Буддизмаар энэ нь ердөө сахилын хориг бус, харин бясалгалын даян, самади-төвлөрөлд орох практик суурь болдог. Хэрэв энэ “ариун-явдал” алдагдвал мэдрэхүйн таашаалд хүлэгдэж, анхаарал туйлын нарийн тунгалаг төлөвт шилжих боломжгүй болно (Vin; DA). Улмаар сарууул-ухааныг олох нөхцөл эс хангагдана.

[12] *Ārācārī*—“нүглээс алс буйд”. Зарим орчуулгад “эм хүнээс алс хол” гэжээ (BB).

[13] *Vinayavādī*—“сахил номын багш”. Будда өөрийн шавь хуврагууддаа зарлигдсан сахил санваар буюу Винаяа (па. *Vinaya Piṭaka*) судар номыг заадаг хүн. Зарим Монгол бичвэрт уг судрыг “Винайн Судар”, “Винайн Ёс” гэж нэрлэсэн нь бий.

тунгаахуйц, хүрээ хязгаарт нь таарахуйц, хүмүүнийг сайн сайханд хөтлөхүйц, тийм л үгсийг хэлдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж:

‘Даянч Готама ургамлын амьдрал хийгээд түүний үрийг гэмтээхийг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама өдөрт нэг удаа л хооллож, үдшийн цагаар хооллох, буруу цагаар[14] идэхийг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама бүжиглэх, дуулах, хөгжимдөх, цэнгээн үзвэр[15] үзэхийг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама зүүлт зүүх, сүрчиг цацах, тос түрхэх, өөрийгөө гоёх, өөрийгөө тордох ямарваа нэг үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама өндөр суудал, өргөн ор хэрэглэхийг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама алт болон мөнгийг[16] өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама болгоогүй будааг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама болгоогүй махыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама эмэгтэйчүүд, охидыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама эм боол, эр боолыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама хонь, ямааг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама тахиа, гахайг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама заан, үнээ, адуу, гүүг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама газар нутаг, тариан талбайг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама бусдын өмнөөс мэдээ зөөх, тушаал даалгавар дамжуулах явдалд оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама худалдаж авах, зарж борлуулах үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама хуурамч жинлүүр, хуурамч зоос[17], хуурамч хэмжүүрийг[18] ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама хээл хахууль, заль мэх, хуйвалдаан луйварт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Даянч Готама цавчих, цаазлах, эд эрхтэн тайрах, хорих хүлэх, тонох хулгайлах, булаах дээрэмдэх, харгислах хүчирхийлэхийг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшаахдаа иймэрхүү л байдлаар ярих болов уу.

Анхан Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

---

14 *Vikālabhojanā*—“буруу цагаар”. Үд дундаас ирэх өглөөний нар мандах хүртэлх хугацаа (MPA).

15 *Visūka*—“цэнгээн үзвэр”. Зарим эх сурвалжид “ёс бус” эсвэл “утга учиргүй” зугаа цэнгээн гэж орчуулсан байна (BB).

16 Энд ‘мөнгө’ гэх металлыг хэлсэн ба цаасан мөнгө үүсээгүй, зоосон мөнгө дөнгөж хэрэглээнд орж эхэлж байсан цаг үе болохыг анхаарна уу.

17 *Kaṁsakūṭa*—“хуурамч зоос”. Зарим эх сурвалжид “хуурамч металлууд” гэж орчуулсан байна (BS).

18 Урт өргөн, жин, эзлэхүүнийг хэмжих ямар нэг хэмжүүр.

2.2. Дунд Шатны Сахил-Ухамсар (Majjhimasīla)

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш[19], даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч ургамлын амьдрал хийгээд тэдгээрийн үрийг гэмтээх явдалд гар бие оролцдог. Эдгээр үйлдлүүд нь болбоос үндэснээс ургуулах, ишнээс ургуулах, мөчрөөс ургуулах, залгаж ургуулах, үрээс ургуулах зэрэг таван үйл билээ. Харин даянч Готама ургамлын амьдрал хийгээд тэдгээрийн үрийг гэмтээхийг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч хоол хүнс, идээ ундаа, гутал хувцас, тээврийн хэрэгсэл, ор дэр, үнэртэн сүрчиг, элдэв тансаглалыг өөртөө зориулан хурааж хадгалдаг. Харин даянч Готама тийм эд агуурс цуглуулах, хөрөнгө зоорь хураах үйлийг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч ёс суртахууны түвшин ахихад тээг саад болдог цэнгээн үзвэрт оролцдог. Тэдгээр нь:

- Бүжиг, дуу, хөгжим бүхий цэнгээн үзвэр;
- Жүжиглэл бүхий цэнгээн үзвэр;
- Уран зохиол, үлгэр, түүх бүхий цэнгээн үзвэр;
- Алга ташилт, цан, бөмбөр бүхий цэнгээн үзвэр;
- Зураг, урлаг, гоо сайхны үзвэр[20] цэнгээн;
- Үсрэх, харайх, авирах үзүүлбэр бүхий цэнгээн үзвэр;
- Үхэгсдийн ясыг угаах[21] цэнгээн үзвэр;
- Заан, морь, үхэр, бух, ямаа, хуц, тахиа, бөднө шувууны тэмцэлдээн, уралдаан;
- Саваан тулалдаан, нударган зодолдоон, бөхийн барилдаан, жүжиглэсэн байлдаан[22], цэргийн бэлтгэл[23], цэргийн байлдааны жагсаал, цэргийн ёслолын жагсаал;

[19] *Bhonto*—“лам багш”. Ихэс дээдэс, лам хувраг хүмүүсийг хүндэтгэн дуудах паали нэршил (BD).

[20] *Sobhanakaṁ*—“гоо сайхны үзвэр”. Ямар нэг чимэглэл, будаг шунх, гоёл өмсгөл, бүжиглэл бүхий үзвэр (BS).

[21] *Caṇḍālaṁ vaṁsaṁ dhovanaṁ*—“үхэгсдийн ясыг угаах зан үйл”. Доод анги давхаргын хүмүүс шарилын ясыг угаадаг зан үйл байжээ (BS).

[22] *Uyyodhikaṁ*—“жүжиглэсэн байлдаан”. Зарим сурвалжид жинхэнэ байлдааныг зугаа болгож харах гэжээ (BS).

[23] *Balaggaṁ*—“цэргийн бэлтгэл”. Жагссан цэргүүдийг, нэг нэгээр нь нэрсийг дуудах, цэргийн бэлтгэл үйл ажиллагаа.

гэх зэрэг болно. Харин даянч Готама, ийм цэнгээн үзвэрт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, энгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч хэнэггүй байдлыг бий болгодог мөрийтэй тоглоомуудаар[24] тоглодог. Тэдгээр нь:

- Найман хөлөгт шатар даам;
- Арван хөлөгт шатар даам;
- Хийсвэр хөлөгт[25] шатар даам;
- Газар зураад харайх[26] тоглоом;
- Саваа сугалах[27] тоглоом;
- Шоогоор тоглох тоглоом;
- Савхаар цохих[28] тоглоом;
- Будгаар тоглох[29] тоглоом;
- Бөмбөгөөр наадах тоглоом;
- Навчаар шүгэлдэх[30] тоглоом;
- Газар хагалах[31] тоглоом;
- Тонгорч үсрэх[32] тоглоом;
- Салхин сэнсний[33] тоглоом;
- Жинлүүрт тоглоом;
- Хөсөг тэрэг[34] тоглоом;
- Тоглоомон нум суман тоглоом;

---

24 *Jūta*—“мөрийтэй тоглоомууд”. Зарим эх сурвалжид “тоглоомууд” гэж орчуулсан байна (BB).

25 *Ākāsa*—“хийсвэр хөлөгт”. Шатар даамны хөлгийг агаарт төсөөлөн бодож тоглох хэлбэр (MW).

26 *Parihārapatha*—“газар зураад харайх”. Газар хүснэгт зураад дээгүүр нь үсэрч харайх тоглоом. Монголчууд “черта” (ор. *черта;* анг. *hopscotch*) гэж нэрлэдэг тоглоомтой дүйх тоглоом (BS).

27 *Santika*—“савх сугалах”. Модоор хийсэн нэгэн ижил савх эсвэл дүрсийг эвийг нь олж өрсний дараа, бүгдийг нуралгүйгээр, өрсөн савхнуудаас нэг нэгээр нь эвтэйхэн сугалах тоглоом (BB).

28 *Ghaṭika*—“савхаар цохих”. Жижиг савхыг том савхаар оножт, цохидог нэгэн төрлийн тоглоом (BB).

29 *Salākahattha*—“будгаар тоглох”. Гараа будаг, зосонд дүрээд, газар, хана руу савах ба тоглоомд оролцогчид заан, морь г.м. амьтдын дүрсийг үзүүлэх, илэрхийлэх даалгавар бүхий тоглоом (BB).

30 *Paṅgacīra*—“навчаар шүгэлдэх”. Навчаар шүгэл хийж шүгэлдэх эсвэл навчаар ямар нэг юм хийж үлээх тоглоом (BB).

31 *Vaṅkaka*—“газар хагалах”. Тоглоомон анжсаар эсвэл ямар нэг юмаар газар хагалах, сэндийчих тоглох (BB).

32 *Mokkhacika*—“тонгорч үсрэх”. Сойлт эргэх (ор. *сальто*) буюу урагш, арагш 360 хэм бүтэн эргэлт хийж үсрэх (BB).

33 *Ciṅgulika*—“салхин сэнс”. Цаасаар, навчаар сэнс хийж, үүнийг үлээх, эсвэл салхин эсрэг барьж сэнсрүүлэн эргүүлэх.

34 *Rathaka*—“хөсөг тэрэг”. Хүүхдийн тоглоомон сүйх тэрэг, тоглоомон хөсөг тэрэг г.м.

- Үгийн тааварт тоглоом;
- Бодлын тааварт тоглоом;
- Өрөөл татанхай болж жүжиглэх тоглоом;

гэх зэрэг болно. Харин даянч Готама хэнэггүй байдлыг бий болгодог, эдгээр мөрийтэй тоглоомд оролцохыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өндөр бөгөөд тансаг олбог суудал, ор дэр хэрэглэдэг. Тэдгээр нь:

- Өргөн буйдан;
- Амьтны сийлбэр, хээ хуар бүхий сэнтий; үслэг бүтээлэг;
- Өнгө алаглуулан шоолж хийсэн бүтээлэг; цагаан ноос ноолууран хучлага;
- Цэцэг шигтгээ бүхий ноос ноолууран хучлага, хөвөнгөөр зузаалсан хөнжил;
- Амьтны дүрсэн хээ, шигтгээ бүхий ноос ноолууран хучлага;
- Нэг эсвэл хоёр талдаа үслэг, ноос ноолууран хучлага;
- Үнэт чулуун шигтгээ бүхий орны хучлага;
- Торгон хучлага;
- Хивс, ширдэг;
- Заан, морин сүйх тэрэгний шалавч; гөрөөсний арьсан шалавч;
- Кадали бугын[35] арьсан шалавч, бүтээлэг;
- Улаан саравч, халхавч бүхий сэнтий;
- Улаан өнгийн, гарын тавиур, хөлийн гишгүүр бүхий, зөөлөн сэнтий, буйдан;

гэх зэрэг болно. Харин даянч Готама өндөр бөгөөд тансаг олбог суудал, ор дэр хэрэглэхийг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өөрийгөө гоёж, биеэ торддог. Тэдгээр зүйлүүд нь: сүрчиг цацах, тосон иллэг хийлгэх, анхилуун усанд орох, гар хөлийн иллэг хийлгэх, толь хэрэглэх, тос түрхэх, зүүлт зүүх, үнэртэн хэрэглэх, нүүрээ будах[36], энгэсэг түрхэх, бугуйвч зүүх, үс толгойн тууз зүүх, чамин ганган таяг тулах, эмийн бортого[37] хөөрөг хэрэглэх, гоёлын хутга зүүж явах, нарны халхавч хэрэглэх, гоёлын шаахай өмсөх, өндөр

---

[35] *Kadalimiga*—“кадали буга”. Арьс нь асар өндөр үнээр зарагддаг гэх нэгэн төрөл буга. Зарим эртний бичвэрт домгийн амьтан гэсэн бол зарим эхэд Зүүн өмнөд азийн нэн ховордсон самбар буга (лат. *rusa unicolor*) гэжээ.

[36] *Mukhacuṇṇaṁ*—“нүүрээ будах”. Орчин цагийн энгэсэг (ор. *пудра*)-тэй дүйх, нүүрэнд түрхэх бүтээгдэхүүн.

[37] *Nāḷikaṁ*—“эмийн бортого”. Мод, чулуу, шил, шаазан, хув, ясаар хийсэн эм, тамхи хийх зориулалттай, таглаатай чамин тансаг ухмал сав, хөөрөг.

сүрлэг малгай өмсөх, үнэт эдлэл хэрэглэх, титэм зүүх, дэвүүр сэвүүр хэрэглэх, элбэг сүрлэг цагаан дээл орхимж өмсөх гэх зэрэг болно. Харин даянч Готама өөрийгөө гоёх, биеэ тордох явдлыг ямагт цээрлэдэг билээ.' гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

'Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дэмий яриа[38] ярьдаг. Тэдгээр нь: хаад ноёд, хулгайч луйварчид, сайд түшмэлүүдийн тухай яриа; цэрэг зэвсэг, аюул занал, дайн дажны тухай яриа; хоол хүнс, идээ ундаа, гутал хувцас, ор дэр, үнэт эдлэл, үнэртэн сүрчгийн тухай яриа; хамаатан садан, тээврийн хэрэгсэл, хот хөдөө, улс орны тухай яриа, охид хүүхнүүдийн тухай яриа; эрэлхэг баатруудын тухай яриа; гудамжны яриа, дошны яриа; нас нөхцөгсдийн тухай яриа; шивэр авир, явган яриа; гадаад далай, газар орны тухай таамаг яриа; тийм сайн дараа төрлийг авсан, ийм муу дараа төрлийг олсон[39] гэх зэрэг элдвийн дэмий яриа болно. Харин даянч Готама, эдгээр хэрэггүй дэмий яриаг ямагт цээрлэдэг билээ.' гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

'Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өөр хоорондоо ном хаялцан[40] маргалдаж:

"Чи энэ Сургаал, Сахилыг[41] ойлгодоггүй юм байна. Би энэ Сургаал, Сахилыг ойлгодог билээ.",

"Чи энэ Сургаал, Сахилыг чухам яаж ойлгоод байна?",

"Чиний дасгал, бясалгал бол буруу. Миний дасгал, бясалгал бол зөв.",

"Би оройд нь гарч ойлгоод байна. Чи оройд нь гарч ойлгохгүй байна.",

"Чи эцэст нь хэлэх ёстойгоо эхэнд нь хэлээд, эхэнд нь хэлэх ёстойгоо эцэст нь хэлээд байна.",

"Чиний удаан бодож тунгаасан номлол төөрөлдсөн зүйл байна.",

"Чиний номлол няцаагдлаа. Чи мэтгэлцээнд ялагдлаа. Чи эндээс яв одоо. Эсвэл чаддаг юм бол яг одоо энд зангилааг нь гаргачих." гэх зэргээр мэтгэлцэх аж.

Харин даянч Готама ийм ном хаялцсан, цэц булаалдсан яриаг ямагт цээрлэдэг билээ.' гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

---

38 *Tiracchānakathā*—"дэмий яриа". Зарим эх сурвалжид "адгуусны яриа", "доод түвшний яриа" (анг. *animal-talk*) гэжээ (MW).

39 *Bhavābhava*—"тийм сайн дараа төрлийг авсан, ийм муу дараа төрлийг олсон". Зарим эх сурвалжид, "олз гарзны тухай яриа" гэжээ (BB).

40 *Viggāhikakathā*—"ном хаялцах". Ямар нэг сэдэв асуудлаар маргалдах буюу энэ тохиолдолд номын талаар маргах.

41 *Dhammavinaya*—"Сургаал, Сахил". Буддагийн заасан бүх Сургаал болон Сахил ёс, сахил-ухамсрыг нэгтгэн хэлсэн үг.

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч, ‘энд ир, тэнд оч, үүнийг ав, түүнийг хүргэ’ гэх мэт, хаад ноёд, сайд түшмэд, язгууртнууд[42], бярман болон хар хүмүүс[43], хүүхэд залуусын хоорондох захиа мэдээ, тушаал даалгавар дамжуулах аж. Харин даянч Готама ийм мэтийн захиа мэдээ, тушаал даалгавар дамжуулах үйл хэрэгт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өргөл барьц авахын тулд зальдаж мэхлэх, зусардаж бялдуучлах, далдуур санаа өгөх, дарамт шахалт үзүүлэх, ямар нэг эд зүйл өгөөд илүү их өргөл барьц авах элдэв заль мэх хийдэг. Харин даянч Готама ийм мэтийн заль мэхийн үйл хэрэгт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшаахдаа ийм л байдлаар ярих болов уу.

Дунд Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

2.3. Дээд Шатны Сахил-Ухамсар (Mahāsīla)

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Хүний наслах нас, эсвэл үхэх цагийг, сэргэн мандах, эсвэл уруудан доройтохыг, гар хөл, биеийн мэнгээр нь мэргэлэн зөгнөх;
- Далдын ёр, шинж тэмдгийг тодорхойлох;
- Аянга цахилгаан, тэнгэрийн дуугаар элдэв ёр зөн хэлэх;
- Хар дарсан зүүд, зүүдний тайлал хийх;
- Биеийн шинж тэмдгээр мэргэлэх;
- Хулгана мэрсэн хувцас даавуун дээрээс мэргэ төлөг буулгах;
- Галын тахилга, өргөл хийх;
- Цацлаар[44] өргөл хийх;
- Хивэг, гурил, тариа, өөх, шар тосоор бурхдад өргөл өргөх;
- Амаараа тургиж өргөл өргөх;

---

42 *Khattiya*—“язгууртнууд” (сам. *kshatriya*). Тухайн цагийн дайчин омгийн, улсаа удирддаг, язгууртны анги давхаргыг нэрлэсэн нэр. Сиддхаттха Готамагийн мэндэлсэн гэр бүл мөн энэ анги давхарга юм.

43 *Gahapatikānaṁ*—“хар хүмүүс”. Сахилтан бус, гэр оронтой, гэр бүлтэй, ажил төрөл, ахуй амьдралтай хүмүүс.

44 *Dabbihomaṁ*—“цацлаар” (эсвэл “цацлын модоор”). Цацал өргөх зориулалттай модон халбага, шанагаар.

- Амьтнаар тахилга хийх;
- Хурууны өндөг, алганы хээгээр мэргэлэх;
- Баригдах байшин, газар талбай, шарилын газрын өлзийтэй сайн эсэхийг шинжих;
- Төрийн түшмэдэд зориулан мэргэ төлөг хэлж өгөх;
- Оршуулгын газрын албин чөтгөрийг зайлуулах арга жатга хийх;
- Гүйдэл, дайрлагад[45] дайруулсан хүний албин чөтгөрийг зайлуулах арга жатга хийх;
- Шороон байшинд суугчдын тарни шившлэг[46] буюу арга жатгыг хэрэглэх;
- Могойн хороор эмчлэх, могойд хазуулсан хүнийг эмнэх домнох;
- Хор хийх, хороор эмчлэх, хордлого тайлах;
- Хилэнцэт хорхой, харханд хазуулсан хүнийг эмнэх домнох;
- Шувуу, хэрээний дуу чимээ, гуагалалтаар зөгнөх ёрлох;
- Хүний амьдрах насны тоог хэлэх, зөгнөх;
- Сум зэвээс хамгаалах тарни шившлэг хийх;
- Амьтны хэл чимээгээр зөгнөх ёрлох;

гэх зэрэг болно.

Харин даянч Готама эдгээр дорой аргаар, буруу замаар амь амьжиргаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.' гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

'Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь эд зүйлсийг өнгө, дүрс болон бусад шинж чанараар нь шинжиж эздэдээ аз хийморь, эсвэл золгүй явдал авчрах эсэхийг хэлж өгөх дорой арга буюу: эрдэнийн чулуу, гутал хувцас, таяг, сэлэм, жад, нум сум, өөр бусад зэр зэвсэг, хүүхнүүд, эрчүүд, хөвгүүд, охид, боол эрс, боол эмс, заан, адуу, үхэр, бух, үнээ, ямаа, хуц, тахиа, бөднө, гүрвэл, туулай, яст мэлхий болон бусад амьтад юм. Харин даянч Готама тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.' гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

'Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Тэр хаан довтлох болно;
- Тэр хаан довтлохгүй;

---

[45] *Bhūtavijjā*—"гүйдэл, дайрлага". Эсвэл "өлсгөлөн-сүнс, чөтгөр зайлуулах мэдлэг".

[46] *Bhūrivijjā*—"шороон байшинд суугчдын тарни шившлэг". Шавар шороогоор хийсэн байр сууцанд амьдрагч, тарни, шившлэгээр элдэв дом, арга жатга хийгч хүмүүс байсан бололтой (MW).

- Манай хаан довтолж, дайсны хаан ухрах болно;
- Дайсны хаан довтолж, манай хаан ухрах болно;
- Манай хаан ялж, дайсны хаан ялагдана;
- Дайсны хаан ялж, манай хаан ялагдана;
- Тэр тал ялж, энэ тал нь ялагдана;

гэх зэрэг юм. Харин даянч Готама тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Нар, сар, оддын хиртэлт болно;
- Нар, сар жамаараа эргэлдэнэ;
- Нар, сарны эргэлтийн гажуудал бий болно;
- Од гаригууд жам ёсоороо эргэлдэнэ;
- Од гаригийн гажуудал үүсэх болно;
- Солир унана, тэнгэрийн хаяа улайна[47], газар хөдөлнө;
- Газар ангайна;
- Нар, сар, од гаригууд мандана, жаргана, харанхуйлна, гэрэлтэнэ;
- Нар, сарны хиртэлтийн улмаас ийм тийм зүйл учирна, тохионо;
- Нар, сар, од гаригуудын мандах ба жаргах, харанхуйлах ба тодрох шинж байдал нь ийм тийм учралыг авчирна;

гэх мэтээр зөгнөх, ёрлох, мэргэлэх юм. Харин даянч Готама тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь дараах зүйлс болно:

- Хур ус элбэг байна;
- Ган гачиг болно;
- Ургац арвин байна;

---

[47] *Disāḍāho bhavissati*—“тэнгэрийн хаяа улайна”. Өөрөөр, “тэнгэр хилэгнэнэ”, “тэнгэрийн хаяа тэр чигтээ гал улаан болно”. BS болон зарим Мьянмар эх сурвалжид “галав юүлнэ” (анг. *æon rolls out*, эсвэл *aeon spills out*) гэсэн байна.

- Өлсгөлөн болно;
- Энх тунх болно;
- Аюул занал бий болно;
- Өвчин зовлон ирэх болно;
- Эрүүл энх болно гэх зэргээр мэргэлэх, зөгнөх, таамаглах;
- Эсвэл тэд нягтлан бодох, тооцоолон бодох, тоо бодох, шүлэг найраг зохиох, мөн хорвоо ертөнцийн талаар элдэв таамаглал хэлэх зэрэг юм.

Харин даянч Готама тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь:

- Хурим хийх, бэр гуйх, охиноо хадамд гаргах өдөр сарыг шинжих;
- Сүй тавих, гэр бүл салгах өдөр сарыг шинжих;
- Орлогын үүд, эсвэл гарлагын үүдийг дуудах тарни шившлэг хийх;
- Хүний аз хийморь, эсвэл золгүйдэлт бүтэлгүйдэлд тарни шившлэг хийх;
- Үргүй эмэгтэйчүүдэд үрийн заяа дуудах;
- Хүний хэл ам, хөл гар, эрүүг нь татуулах, эсвэл дүлий болгох тарни шившлэг хийх;
- Толь, чөтгөр, шулмаас, эсвэл бурхдаас шийдэл зөвлөгөө асуух;
- Нарыг тахих, шүтэх;
- Бярман Дээд Тэнгэрийг[48] тахих, шүтэх;
- Галаар тургих арга жатга хийх;
- Азын Тэнгэр[49] дуудах;

гэх зэрэг болно.

Харин даянч Готама тийм дорой аргаар, ийм буруу замаар, амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшааж,

---

[48] *Mahābrahmā*—“Бярман Дээд Тэнгэр”. Бярман тэнгэрийн орны захирагч хаан, Бярман Тэнгэр (Тайлбарт Будда болон Бярман-ыг үз.)

[49] *Sirivhāyanaṁ*—“Азын Тэнгэр”. Эсвэл “Азын (охин тэнгэр) Бурхан *Siri*”-ээс гуйх, хүсэх, түүнийг дуудах (BS).

‘Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч брахман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь:

- Ач тусын хариуд бурхдад өргөл амлах;
- Тэр амлалтаа биелүүлэх;
- Албин чөтгөртэй холбогдох;
- Орон байрны тарни шившлэг хийх;
- Үргүйдэл, бэлгийн сулрал засах;
- Барилга барих газрыг бэлдэх, ариусгах;
- Ам зайлах, усанд оруулах ариусгал ёслол хийх;
- Галын тахилга хийх;
- Бөөлжүүлэх, дотор цэвэрлэх, цэр ховхлох, цэр хөөх эм өгөх;
- Чих, хамраар хэрэглэх эм өгөх;
- Анагаах тосон түрхлэг өгөх;
- Нүд, чихэнд нарийн мэс засал хийх;
- Ерөнхий мэс засал хийх;
- Хүүхдийн эмчилгээ хийх;
- Эмийн ургамлын үндсээр эмчилгээ хийх;
- Эмийн ургамлаар боолт хийх;

гэх зэрэг болно.

Харин даянч Готама тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.’ гэж ярих болов уу.

Хуврагууд аа, эгэл жирийн хүн Буддаг магтан сайшаахдаа ийм л байдлаар ярих болов уу.

Хуврагууд аа, эдгээр дурдсан бүх зүйлүүд бол эгэл жирийн хүн Буддаг магтан сайшаахдаа ярьдаг, энгийн ухамсар ёс суртахууны анхан шатны, асар жижиг зүйлүүд нь билээ.

Дээд Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

3. Өнгөрснийг Таамаглагч (Pubbantakappika)

Хуврагууд аа, эдгээр сахил-ухамсраас гадна, гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах,

Будда өөрийн шууд-билгүүнээр[50] ухаарсан, тийм Зүйлс[51] байгаа билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

Тэгвэл тэдгээр Зүйлс нь юу байх бол?

Хуврагууд аа, арван найман үндэслэл дээр, өнгөрсний талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг[52], өнгөрснийг таамаглагч[53], өнгөрсний талаар үзэл баримтлагч, зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юун дээр үндэслэн эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

3.1. Мөнх Үзэл: 1–4 (Sassatavāda)

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, өөрийн-оршихуй[54] болон хорвоо ертөнцийг[55] мөнх гэж зарлан тунхагладаг, мөнх үзэлтэн[56], зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын[57] өндөр түвшинд хүрч, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санадаг.

---

50 *Abhiññā*—“шууд-билгүүн”. Өөрөөр, “дээд мэдлэг”, “шууд ухаарсан мэдлэг”, “төгс ухаарал” г.м. Үндсэн утга нь эгэл танин мэдэхүйгээс хальсан, гэгээрлийн мөчид өөрийн биеэр шууд ухаарсан мэдлэг, ухаарал. Паали Судартт, тэр тундаа Будда болон Арахантуудын гэгээрлийг “*sayaṁ abhiññā sacchikatvā*” буюу “өөрийн биеэр шууд-билгүүнийг ухаарснаар” зэрэг хэллэгт олонтоо хэрэглэнэ. Англи орчуулгад “шууд мэдлэг” (анг. *direct knowledge,* BB), “ухаарал” (анг. *insight*, BS), “Төгс Билгүүн” (анг. *Perfect Wisdom*, MPA). Харин хожуу үеийн олон тайлбарт, ид-чадал, зөн билэг, дээд мэдлэг (*chaḷabhiññā*) гэж тайлбарлаж, техникийн нэр томьёо болгон тогтсон байна.

51 *Dhammā*—“Зүйлс”. Эсвэл “Үнэн” гэж оруулсан ч утгын хувьд төөрөхгүй болно. Зарим орчуулгад “Зарчим”, “Жам” (анг. *principle*) гэжээ (BS). (Тайлбарт Сургаал хэсгийг үз.)

52 *Paññapenti*—“зарлан тунхагладаг”. Өөрөөр, “зааж сургадаг”, “номлодог”.

53 *Pubbantakappikā*—“өнгөрснийг таамагласан”. Өнгөрсөн цаг үеийг таамагласан үзэл онол. Зарим орчуулгад, “ертөнцийн үүсэл” (анг. “*first beginning*”, BS)

54 *Attā*—“өөрийн-оршихуй”. (Тайлбарт Өөрийн-оршихуй хэсгээс дэлгэрэнгүй үз.)

55 *Loka*—“хорвоо ертөнц”. Өөрөөр, “хорвоо”, “ертөнц” г.м.

56 *Sassatavādā*—“мөнх үзэлтэн” (анг. *eternalists*). Хүний өөрийн-оршихуйг мөнхөд оршино гэсэн үзэл санааг баримтлагчид. Өөрөөр “Мөнх Үзэл” (анг. *eternalism*).

57 *Samādhi*—“төвлөрөл бясалгал”. Төвлөрлийн, оюуны нэгдлийн бясалгал. Судрын энэ хэсэгт төвлөрлийн бясалгалын арга гэсэн ерөнхий агуулгаар. (“самади-төвлөрөл”-ийг Лавлахад үз.)

Тэрбээр, урдах төрлөө, урьдын хоёр, гурав, дөрөв, эсвэл таван төрлөө, арав, хорь, гуч, дөч, эсвэл тавин төрлөө, зуу, мянга, эсвэл зуун мянган төрлөө, эсвэл бүр хэдэн зуун мянган төрлөө, олон зуун мянган төрлөө эргэн санахдаа:

‘Тэр урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн билээ.’ гэх зэргээр эргэн санадаг.

Ийм маягаар, тэрбээр, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь, эргэн санана.

Тиймээс тэрээр:

‘Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд[58] хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн[59], нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл би, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрсэн тул, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санах чадвартай билээ.

Би, урд өмнөх төрлөө, урьдын хоёр, гурав, дөрөв, эсвэл таван төрлөө, арав, хорь, гуч, дөч, эсвэл тавин төрлөө, зуу, мянга, эсвэл зуун мянган төрлөө, эсвэл бүр хэдэн зуун мянган төрлөө, олон зуун мянган төрлөө эргэн санахдаа:

“Урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр

[58] *Sattā*—“бодгаль”. Ямар нэг амьд биет, өлсгөлөн-сүнс, адгуус, хүмүүн, лус, бурхан, Тэнгэр г.м. бидний дараа төрөлдөө авч болох, урд төрөлдөө байсан байж болох, энэ хорвоогийн бүхий л амьтан бодгалийг хамруулан хэлсэн үг. Зарим шашны урсгал эсвэл Монгол хэлний тайлбар толиноос энэ нэршил зөрж болохыг анхаарна уу.

[59] *Saṁsaranti*—“үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн”. *Saṁsara*—“үхэх-төрөхийн эргэлт” (сам. *saṁsāra*). Үндсэн утга “хэрэн тэнэхүй”, “хорвоогийн эргэлтээр тэнэхүй” буюу “дахин дахин үхэх, төрөхийн эргэлтээр явахуй”. Там, өлсгөлөн-сүнс, амьтан, асура, хүмүүн, лус, бурхан, Тэнгэр г.м. олон янз төрөлд, үйлийн үрээр зогсолтгүй үхэж төрсөөр тэнүүчлэн явахуйн эргэлт. Зарим монгол орчуулгад “сансар” гэх нь бий. Гэвч орчин цагийн монгол хэлний “сансар огторгуй” г.м. орон зайн утгатай дүйхгүй тул “сансар”-ыг хэрэглэхгүй.

төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн.” гэдгээ эргэн санадаг. Ийм маягаар, би олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санадаг.

Тийм болохоор би:

Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно гэдгийг би мэдэж байна.’ гэж хэлдэг.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарлан тунхагладаг, мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын эхний үндэслэл нь юм.

Хоёр дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарим нэр хүндтэй даянч болон бярман нар зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санана.

Тэрбээр, нэгэн галавын[60] мөхөл хийгээд сэхэл, эсвэл хоёр галавын, эсвэл гурван галавын, эсвэл дөрвөн галавын, эсвэл таван галавын, бүр эсвэл арван галавын мөхөл сэхлийн эргэлтүүдийг эргэн санахдаа:

‘Тэр урд төрөлдөө би тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн билээ.’ гэх зэргээр эргэн санадаг.

Ийм маягаар, тэрбээр олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санана.

Тиймээс тэрээр:

‘Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно.

Яагаад тэр билээ?

---

[60] *Kappa*—“галав” (сам. *kalpa*). Нэг галав нь асар том уулыг нэг зуун жилд нэг л удаа даавуугаар арчих ба тэр зарчмаар тэр уулыг элээж дуусгах тэр урт цаг хугацаанаас ч удаан үргэлжлэх асар урт цаг хугацаа (SN 15.5). Монгол хэлний тайлбар толь болон ШУ-ны нэр томьёоллоос зөрж болохыг анхаарна уу.

Яагаад гэвэл би, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрсэн тул, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санах чадвартай билээ.

Би, нэгэн галавын мөхөл хийгээд сэхэл, эсвэл хоёр галавын, эсвэл гурван галавын, эсвэл дөрвөн галавын, эсвэл таван галавын, бүр эсвэл арван галавын мөхөл сэхлийн эргэлтүүдийг эргэн санахдаа:

“Урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн.” гэдгээ эргэн санадаг.

Ийм маягаар, би, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь, эргэн санадаг.

Тийм болохоор би:

Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно гэдгийг би мэдэж байна.’ гэж хэлдэг.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарлан тунхагладаг, мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын хоёр дахь үндэслэл нь юм.

Гурав дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарим нэр хүндтэй даянч болон бярман нар зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санана.

Тэрбээр, арван галавын мөхөл хийгээд сэхэл, эсвэл хорин галавын, эсвэл гучин галавын, бүр эсвэл дөчин галавын мөхөл сэхлийн эргэлтүүдийг эргэн санахдаа:

‘Тэр урд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн билээ.’ гэх зэргээр эргэн санадаг.

Ийм маягаар, тэрбээр олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санана.

Тиймээс тэрээр:

‘Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл би, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрсэн тул, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санах чадвартай билээ.

Би, арван галавын мөхөл хийгээд сэхэл, эсвэл хорин галавын, эсвэл гучин галавын, бүр эсвэл дөчин галавын мөхөл сэхлийн эргэлтүүдийг, эргэн санахдаа:

“Урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн.” гэдгээ эргэн санадаг. Ийм маягаар, би олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санадаг.

Тийм болохоор би:

Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно гэдгийг би мэдэж байна.’ гэж хэлдэг.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарлан тунхагладаг, мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын гурав дахь үндэслэл нь юм.

Дөрөв дэх нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарим нэр хүндтэй даянч болон бярман нар зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч хийгээд бярман нар учир шалтгаан болон ухан шинжихүйд тулгуурладаг. Тэрээр, олон янзын аргаар, учир шалтгааны үүднээс эргэцүүлэн тунгааж, ухан шинжээд, өөрийн үзлээ:

‘Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно гэдгийг би мэдэж байна.’ гэж хэлдэг.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарлан тунхагладаг, мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын дөрөв дэх үндэслэл нь юм.

Хуврагууд аа, ийм дөрвөн үндэслэл дээр, мөнх үзэлтэн болох зарим даянч болон бярман нар, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх хэмээн зарлан тунхагладаг.

Хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш, эдгээр дөрвөн үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирваанаг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

Нэгдүгээр уншлага хэсэг өндөрлөв.

3.2. Заримдаг Мөнх Үзэл: 5–8 (Ekaccasassatavāda)

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, заримдаг мөнх үзэлтэн[61], зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

[61] *Ekaccasassatikā*—“заримдаг мөнх үзэлтэн”. *Ekaccasassatavāda*—“Заримдаг Мөнх Үзэл”. Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж үзэх үзэл.

Хуврагууд аа, урт удаан хугацааны дараа, эрт орой хэзээ нэгэн цагт энэ дэлхий ертөнц сөнөж мөхөх цаг нь болдог. Дэлхий ертөнц сөнөж мөхөх тэр цагт бодгалиуд ихэвчлэн Аабхассара[62] Тэнгэрүүдийн ертөнцөд дахин төрдөг. Тэнд тэд, оюунаар-бүтсэн[63], хөөр-баяраар[64] хооллосон, өөрөөсөө гэрэлтсэн, агаарт дүүлсэн, сүр жавхлантай байдлаар амьдрах бөгөөд тэд асар удаан хугацааны турш ийн оршдог.

Гэвч, урт удаан хугацааны дараа эрт орой хэзээ нэгэн цагт энэ дэлхий ертөнц сэргэх, тэлэх цаг нь болдог. Энэхүү өргөжин буй хорвоо ертөнцөд Бярман Тэнгэрийн нэгэн хоосон ертөнц шинээр бий болдог. Тэгээд аль нэг бодгаль нь амьдралын хугацаа нь дуусах, эсвэл буян[65] нь барагдсанаас болж Аабхассарагийн ертөнцөөс унаж, тэрхүү хоосон Бярман Тэнгэрийн ертөнцөд төрдөг. Тэнд тэрээр, оюунаар-бүтсэн, хөөр-баяраар хооллосон, өөрөөсөө гэрэлтсэн, агаарт дүүлсэн, сүр жавхлантай байдлаар амьдардаг бөгөөд тэрээр мөн асар удаан хугацааны турш ийн оршдог.

Тэгвэл асар удаан хугацаанд ганцаараа байсан энэ бодгальд сэтгэл эс ханах, тэсэж ядах байдал бий болж, тэрээр: ‘Ай халаг, өөр ямар нэг бодгаль энд ирдэг ч болоосой!’ хэмээн гаслан суух болно. Мөн бусад бодгалиудын амьдралын мөчлөг нь дуусах, эсвэл буян нь барагдах зэргээс болж Аабхассарагийн ертөнцөөс унаж, Бярман Тэнгэрийн энэ ертөнцөд тэрхүү бодгалийн хань хамтрагч болон төрдөг. Тэнд тэд, оюунаар-бүтсэн, хөөр-баяраар хооллосон, өөрөөсөө гэрэлтсэн, агаарт дүүлсэн, сүр жавхлантай байдлаар амьдардаг бөгөөд тэд мөн асар удаан хугацааны турш ийн оршдог.

Тэгээд, тэнд анх ирсэн мөнөөх бодгаль:

‘Би бол Бярман Тэнгэр, Дээд Тэнгэр, Эзэн Тэнгэр, Эс Ялагдагч, Бүхнийг Мэдэгч, Бүхнийг Чадагч, Эрхэм Дээдэс, Төвхнүүлэгч ба Бүтээгч, Захирагч, Томилогч, Захиалагч, Эрт Эдүгээгийн Бүх Бодгалийн Эцэг. Эдгээр бодгалиудыг би бүтээсэн.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл, надад анх ийм бодол төрсөн юм: “Ай халаг, өөр бодгаль энд ирдэг ч болоосой!” Энэ бол миний чин хүсэл байсан бөгөөд үүний дараа л эдгээр бодгалиуд энд гарч ирсэн болно!’ хэмээн боддог байна.

Харин, дараа нь гарч ирсэн тэдгээр бодгалиуд: ‘Энэ бол Бярман Тэнгэр, Дээд Тэнгэр, Эзэн Тэнгэр, Эс Ялагдагч, Бүхнийг Мэдэгч, Бүхнийг Чадагч, Эрхэм Дээдэс, Төвхнүүлэгч ба Бүтээгч, Захирагч, Томилогч, Захиалагч, Эрт Эдүгээгийн Бүх Бодгалийн Эцэг Тэнгэр байж таарна шүү дээ.

---

62 *Ābhassara, Ābhassarasaṁvattanikā*—“Аабхассара”. “Урсгал Туяаны Орон” буюу бясалгалын II Даяаныг оршоосноор хүрдэг гэж үздэг Бярман тэнгэрийн орон (MPA).

63 *Manomayā*—“оюунаар-бүтсэн”. “Оюун-ухаан” (*mano*)-аар бүтээсэн, бий болгосон. Зарим тайлбарт, “урьдын сайн үйлийн үрээр” бүтсэн гэжээ (MPA). (“Оюун-ухаан”-ыг Лавлахад үз.)

64 *Pīti*—“хөөр-баяр”. I, II даянд үүсэх, мөн тустай сайн үйлээс үүсэх дээд зэргийн баяр хөөр. Энэ тохиолдолд даяаны буюу бясалгалын баяр хөөрөөр “хооллох” гэсэн санаа. (“хөөр-баяр”-ыг DN.2.10-14-д дэлгэрүүлж үз.)

65 *Puñña*—“буян” (сам. *puṇya*). Гол төлөв таатай төрөл авахад тустай, таатай үйлийн үрийг бий болгох, бие хэл, сэтгэлийн аливаа эерэг үйлдэл.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл, түүнийг энд хамгийн түрүүнд байсныг, бид түүний дараа энд төрснийг бид өөрсдөө харцгаасан шүү дээ.' хэмээн бодоцгоодог байна.

Тэгэхээр энд хуврагууд аа, анх ирсэн тэр бодгаль нь бусдаасаа илүү урт настай, илүү үзэсгэлэнтэй, илүү эрх дархтай оршдог.

Харин тэгвэл хуврагууд аа, зарим бодгалиуд нас барснаар тэр биеэсээ салж, энд төрөх боломжтой. Энд төрсөн тэрбээр, эгэл хүмүүний амьдралаа орхиж, гэр оронгүй даянч болдог. Даянч болсны дараа тэрээр, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, оршин байсан үеэ эргэн санадаг боловч түүнээс өмнөхийг санадаггүй.

Тэгээд тэрбээр:

'Тэр бол Бярман Тэнгэр, Дээд Тэнгэр, Эзэн Тэнгэр, Эс Ялагдагч, Бүхнийг Мэдэгч, Бүхнийг Чадагч, Эрхэм Дээдэс, Төвхнүүлэгч ба Бүтээгч, Захирагч, Томилогч, Захиалагч, Эрт Эдүгээгийн Бүх Бодгалийн Эцэг. Тэр биднийг бүтээсэн бөгөөд тэр бол тогтвортой, хөдөлшгүй, үүрдийн, хувиршгүй Чанартай, мөнхийн[66] билээ. Гэвч, Бярман Тэнгэрийн бүтээсэн бид мөнхийн-бус[67], хувирамтгай, нас охор, дуусдаг Жамтай, энэ ертөнцөд ирцгээсэн юм.' хэмээн ярьдаг аж.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, заримдаг мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын эхний үндэслэл нь юм.

Хоёр дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарим даянч болон бярман нар зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, 'Жаргалд Худалдагдсан'[68] гэж нэрлэгдэх зарим бурхад[69] байдаг. Тэд хэт их цагийг инээд наргиа, наадам цэнгэлд автаж донтож өнгөрөөх ба ингэснээр тэд сэрэмж анхаарлаа алдаж, улам ихээр сэрэмж анхааралгүй болох тусам, улмаар тэдгээр бодгалиуд тэр ертөнцөөсөө унадаг.

---

66 *Niccā*—"мөнхийн" (анг. *stable* эсвэл *permanent*). "Мөнхийн-бус" (*aniccā*)-ын эсрэг утга буюу, "тогтвортой", "нэг янзаараа", "найдвартай", "өөрчлөгддөггүй", "хувиршгүй". Зөвхөн цаг хугацааны тухай ойлголт биш гэдгийг анхаар.

67 *Aniccā*—"мөнхийн-бус" (анг. *unstable* эсвэл *impermanent*). Өөрөөр "тогтворгүй", "нэг янзаараа бус", "найдваргүй", "байнга өөрчлөгддөг", "хувирамтгай" зэрэг санаа. *Aniccā*-г "мөнх бус" г.м. байдлаар оруулаагүй шалтгаан нь, энэ үг зөвхөн цаг хугацааны талаарх ойлголт бус, "тогтворгүй" г.м. утгууд буйг сануулах гэж, мөн судрын бусад ойролцоо утга бүхий үгс (*asassata*, *vayadhamma, antānantaṁ* г.м.)-ээс ялган харуулах гэсэн зорилго болно.

68 *Khiḍḍāpadosikā*—"Жаргалд Худалдагдсан". Зугаа цэнгэлд худалдагдсан, авлигажсан, жолоогоо алдсан г.м. Энэ диваажингийн нэр өөр судрат дурдагдаагүй байна.

69 *Devā*—"бурхад" (сам. *deva*). Хүмүүний ертөнцөөс дээгүүр, Тэнгэрүүдээс доогуур ертөнцөд хамаарах бодгалиуд. Зарим лус, чөтгөр (*Māra*) үүнд орно. (Бүрэн жагсаалтыг Тайлбарт Будда хэсгийг үз.)

Харин тэгвэл хуврагууд аа, тэдгээр бодгалиуд нас барснаар тэр биеэсээ салж, энд төрөх боломжтой. Энд төрсөн тэрбээр, эгэл хүмүүний амьдралаа орхиж, гэр оронгүй даянч болдог. Даянч болсны дараа тэрээр, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, оршин байсан үеэ эргэн санадаг боловч түүнээс өмнөхийг санадаггүй.

Тэгээд тэрбээр:

‘Хүндлэл хайрыг хүлээхүйц, хүсэл шуналд эс автсан, тэдгээр бурхад аливаа цагийг инээд наргиа, наадам цэнгэлд огтхон ч автаж донтож өнгөрүүлдэггүй бөгөөд ингэснээр тэдний сэрэмж анхаарал сайжирдаг тул, тэдгээр бурхад тэндээ мөнх оршдог. Тэд бол мөнхийн, хөдөлшгүй, үүрдийн, хувиршгүй Чанартай, мөнхийн билээ.

Харин бид бол инээд наргиа, наадам цэнгэлд худалдагдсан бурхад байсан. Ихэнх цагийг бид инээд наргиа, наадам цэнгэлд автаж донтож өнгөрүүлсэн. Тиймээс сэрэмж анхаарлаа алдаж, улам ихээр сэрэмж анхааралгүй болох тусам, улмаар тэр ертөнцөөсөө унаж, энэ ертөнцөд ирснээр бид мөнхийн-бус, хувирамтгай, нас охор, дуусдаг Жамтай, энэ ертөнцөд ирцгээсэн юм.’ гэж ярьдаг.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, заримдаг мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын хоёр дахь үндэслэл нь юм.

Гурав дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарим даянч болон бярман нар зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, ‘Оюун-Ухаан Бохирдсон’[70] гэж нэрлэгдэх зарим бурхад байдаг. Тэд бие биеэ атаархлын харцаар ширтэж, бодон зэвүүцэж, ихэнх цагийг өнгөрөөдөг. Ингэснээр тэдний оюун бодол нь нэг нэгнээ зэвүүцсэн атаа хорсолд бүрэн автдаг. Ийнхүү тэдний оюун бодол нь атаа хорсолд бүрэн автсанаар тэдний бие хийгээд сэтгэл нь үгүйрдэг. Улмаар тэдгээр бодгалиуд тэр ертөнцөөсөө унадаг.

Харин тэгвэл хуврагууд аа, тэдгээр бодгалиуд нас барснаар тэр биеэсээ салж, энд төрөх боломжтой. Энд төрсөн тэрбээр, эгэл хүмүүний амьдралаа орхиж, гэр оронгүй даянч болно. Даянч болсны дараа тэрээр хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, оршин байсан үеэ эргэн санадаг боловч түүнээс өмнөхийг санадаггүй.

Тэгээд тэрбээр:

‘Олны хүндлэл хүлээх, оюун бодол нь эвдрээгүй, тэдгээр бурхад хэзээ ч бие биеэ атаархлын харцаар ширтэж, бодон зэвүүцэж, цагийг өнгөрөөдөггүй. Ингэснээр тэдний оюун бодол нь нэг нэгнээ зэвүүцсэн

---

70 *Manopadosikā*—“Оюун-Ухаан Бохирдсон”. Эсвэл “Оюун-Ухаан нь Авлигажсан”, “Муу Санаат” г.м. утгаар. (“оюун-ухаан”-ыг үз.) Хүний ертөнцийн дээр байрлах харьцангуй доогуур зиндааны бурхдын оронд хамаарна (DA).

атаа хорсолд хэзээ ч автдаггүй. Ийнхүү тэдний оюун бодол нь атаа хорсолд автахгүй байснаар тэдний бие хийгээд сэтгэл нь эс үгүйрдэг. Тиймээс тэдгээр бурхад тэндээ мөнх оршдог. Тэд бол тогтвортой, хөдөлшгүй, үүрдийн, хувиршгүй Чанартай, мөнхийн билээ.

Харин бид бол муу санаанд автсан бурхад байсан. Бид бие биеэ атаархлын харцаар ширтэж, бодон зэвүүцэж, ихэнх цагийг өнгөрөөсөн. Ингэснээр бидний санаа бодол нэг нэгнээ зэвүүцсэн атаа хорсолд бүрэн автсан. Ийнхүү бидний санаа бодол атаа хорсолд бүрэн автсанаар бидний бие хийгээд сэтгэл үгүйрсэн. Улмаар бид тэр ертөнцөөсөө унаж, энэ ертөнцөд ирээд, мөнхийн-бус, хувирамтгай, нас охор, дуусдаг Жамтай, энэ ертөнцөд ирцгээсэн юм.' хэмээн ярьдаг байна.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, заримдаг мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын гурав дахь үндэслэл нь юм.

Дөрөв дэх нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарим даянч болон бярман нар зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар бол задлан шинжээч, учир зүйч нар юм. Тэд учир шалтгааны дагуу тайлж, өөрийн үзэл бодол, дүн шинжилгээндээ тулгуурлан:

'"Нүд", "чих", "хамар", "хэл", "бие" гэж нэрлэгддэг эдгээр өөрийн-оршихуй бол мөнхийн-бус, хувирамтгай, нас охор, дуусдаг Жамтай билээ.

Харин, "сэтгэл"[71], "оюун-ухаан"[72], "оюун-ухамсар"[73] гэж нэрлэгддэг эдгээр өөрийн-оршихуй бол тогтвортой, хөдөлшгүй, үүрдийн, хувиршгүй Чанартай, мөнхийн билээ.' хэмээн ярьдаг байна.

Энэ бол хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, заримдаг мөнх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын дөрөв дэх үндэслэл нь юм.

Хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш, эдгээр дөрвөн үндэслэлийг л, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

---

71 *Citta*—"сэтгэл" (анг. *mind*; сам. *citta*). Оюун санаа, зүрх сэтгэл болон бодол санааны төлөв байдлыг илэрхийлнэ. Эртний Буддизмд сэтгэл гэдэг нь бие даасан тогтвортой зүйл биш, харин агшин зуур төрж, устдаг сэтгэхүйн нэгж төлөвүүдийн (*cittas*) тасралтгүй урсгал (*citta-santāna*) юм.

72 *Mano*—"Оюун-ухаан" (сам. *mano*). Оюун санаа, оюун ухаан буюу тархины үйл ажиллагаатай холбосон, эрхтэн талаас нь онцлон нэрлэсэн үг. Зургаан мэдрэхүйн-чадвар (*indriya*)-ын нэг бөгөөд зарим тохиолдолд сэтгэл болон оюун-ухамсартай ойролцоо утгаар хэрэглэгдэх нь бий.

73 *Viññāṇa*—"оюун-ухамсар" (сам. *vijñāna*). Зарим тохиолдолд "ухамсар". (Тайлбарт буй Таван-Цул болон DN 15.1-г үз.)

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирваныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

3.3. Хязгаартай ба Хязгааргүйн Үзэл: 9–12 (Antānantavāda)

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, хязгаартай ба хязгааргүйн үзэлтэн[74], зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрэх ба тэрээр хорвоо ертөнцийг хязгаартай юм хэмээн ойлгодог.

Тэрээр:

‘Хорвоо ертөнц бол хэмжээтэй, хязгаартай.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл би, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, энэ хорвоо ертөнцийг хэмжээтэй, хязгаартай оршдогийг нь ойлгож мэдсэн юм.

Тийм болохоор би:

---

[74] *Antānantikā*—“хязгаартай ба хязгааргүйн үзэлтэн”. Өөрөөр “хүрээ хязгааргүй эсвэл хүрээ хязгаартай” г.м. буюу орон зайн ойлголт. *Antānantavāda*—“хязгаартай ба хязгааргүйн үзэл”. Зарим орчуулгад, “тэлэлтийн онол, тэлэлтийн онолч” (анг. *extensionalism*; *extensionist*, BB).

“Хорвоо ертөнц бол хэмжээтэй, хязгаартай” гэж мэдэж байна.’ гэж хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, хязгаартай ба хязгааргүйн үзэлтэн, зарим даянч болон бярман нарын эхний үндэслэл нь юм.

Хоёр дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, зарим нэр хүндтэй даянч болон бярман нар хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрэх ба тэрээр хорвоо ертөнцийг хязгааргүй юм хэмээн ойлгодог.

Тэрээр:

‘Хорвоо ертөнц бол хэмжээлшгүй бөгөөд хязгааргүй. Хорвоо ертөнцийг хэмжээтэй, хязгаартай гэж хэлж буй даянч болон бярман нар алдаж байна. Хорвоо ертөнц бол хэмжээлшгүй бөгөөд хязгааргүй.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл би, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрсэн тул, энэ хорвоо ертөнцийг хязгааргүй юм гэдгийг ойлгож мэдсэн юм.

Тийм болохоор би:

“Хорвоо ертөнц бол хэмжээлшгүй бөгөөд хязгааргүй” гэж мэдэж байна.’ гэж хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, зарим даянч болон бярман нарын хоёр дахь үндэслэл нь юм.

Гурав дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, зарим нэр хүндтэй даянч болон бярман нар хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрэх ба тэрээр хорвоо ертөнцийг босоогоороо бол хязгаартай, харин хөндлөнгөөрөө бол хязгааргүй юм хэмээн ойлгодог.

Тэрээр:

‘Хорвоо ертөнц бол босоогоороо хязгаартай, харин хөндлөнгөөрөө хязгааргүй.

“Хорвоо ертөнцийг хэмжээтэй, хязгаартай” гэж буй, мөн “хорвоо ертөнцийг хэмжээлшгүй бөгөөд хязгааргүй” гэж үзэж байгаа даянч болон бярман нар аль аль нь алдаж байна.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл би, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрсэн тул, энэ хорвоо ертөнцийг босоогоороо бол хязгаартай, харин хөндлөнгөөрөө бол хязгааргүй гэдгийг ойлгож мэдсэн юм.

Тийм болохоор би:

“Хорвоо ертөнц босоогоороо бол хязгаартай, харин хөндлөнгөөрөө бол хязгааргүй” гэж мэдэж байна.’ гэж хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, зарим даянч болон бярман нарын гурав дахь үндэслэл нь юм.

Дөрөв дэх нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, зарим нэр хүндтэй даянч болон бярман нар хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар бол задлан шинжээч, учир зүйч нар юм. Тэд учир шалтгааны дагуу тайлж ойлгон, өөрийн дүн шинжилгээ, үзэл бодлынхоо дагуу:

‘Хорвоо ертөнц бол хязгаартай ч биш, хязгааргүй ч биш. Хязгаартай гэж байгаа нь буруу ба хязгааргүй гэж байгаа нь ч мөн буруу. Хязгаартай мөртөө хязгааргүй гэж хэлж байгаа нь ч мөн буруу. Энэ хорвоо хязгаартай хийгээд хязгааргүйн аль нь ч биш билээ.’ гэж хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, зарим даянч болон бярман нарын дөрөв дэх үндэслэл нь юм.

Хуврагууд аа, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш, эдгээр дөрвөн үндэслэлийг л, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирваныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

3.4. Эцэс Төгсгөлгүй Салаа Утгаар Хариулах Үзэл: 13–16 (Amarāvikkhepavāda)

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагчид[75] байдаг. Тэднээс энэ тэр зүйлсийн талаар асуухад, тэд дөрвөн үндэслэл дээр, бултсан мэдэгдэл хэлж, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар бултсан мэдэгдэл хэлж, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулдаг юм бол?

Үүн дээр хуврагууд аа, зарим даянч болон бярман нар аливаа зүйлийг тустай-сайн[76], эсвэл тусгүй-муу[77] гэдгийг үнэн мөнөөр нь ойлгодоггүй.[78]

Тэрээр:

‘Би юу тустай-сайн, юу тусгүй-муу вэ гэдгийг ойлгохгүй юм. Хэрэв би, эдгээрийг ойлгохгүйгээр, мэдэхгүйгээр аливаа нэгэн юмыг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэж зарлавал энэ явдал нь үнэн бусыг ярьсан үйлдэл болно. Тэгсэн тохиолдолд, үнэн бусыг ярьсан явдал бол намайг зовлонд унагаж, энэ зовлон нь надад тээг саадыг үүсгэж болох юм.’ хэмээн боддог.

Тиймээс тэрээр, үнэн бусыг хэлэх айдас болон жигшлээс үүдэн аливаа зүйлийг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэж зарладаггүй. Харин энэ тэр юмны талаар асуувал элдэв аргаар бултаж, салаа утгаар:

‘“Тийм байна” гэдэг нь миний үзэл биш. “Тийм болохоор” гэдэг нь ч миний үзэл биш. “Аль эсвэл” гэдэг нь ч миний үзэл биш. “Тийм биш” гэдэг ч миний үзэл биш. “Тийм биш нь ч биш” гэдэг ч миний үзэл биш.’ гэж тэд хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч, зарим даянч болон бярман нарын эхний үндэслэл нь юм.

Хоёр дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулдаг юм бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар аливаа зүйлийг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэдгийг үнэн мөнөөр нь ойлгодоггүй.

---

75 *Amarāvikkhepikā*—“эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч”. Үгчилбэл, “могой загас шиг мурилзагч”. *Amarāvikkhepa*—“Эцэс Төгсгөлгүй Салаа Утгаар Хариулах Үзэл”.

76 *Kusala*—“тустай-сайн”. Нирвааныг ухаарах замналд тустай, хэрэгтэй, сайн гэдэг утгаар хэрэглэгддэг үг. Зарим тохиолдолд “буянтай” (па. *puñña*—буян) гэх үгтэй ташаарах явдал байдаг. Буян үйлдэх нь голдуу сайн төрөл авах, сайн үйлийн үр нь өөрт ирэх зэрэгт өгөөжтэй байдаг бол, “тустай-сайн” үйл нь зөвхөн Гэгээрэлд тустай үйл байдаг гэдгээрээ онцгой ялгаатай болно (Abh; VM).

77 *Akusala*—“тусгүй-муу”. Нирвааныг ухаарах замналд тусгүй муу, саад үүсгэхүйц гэдэг утгаар хэрэглэгддэг үг. Зарим тохиолдолд “нүгэлтэй” (*apuñña*) гэх үгтэй ташаарах явдал байдаг (Abh; VM).

78 Мьянмар эхэд энэ хоёр үгийг: буян (*dāna, sīla, bhāvanā*) ба буян бус (*akusala kammapatha*) гэж оруулсан байна (MPA).

Тэрээр:

‘Би юу тустай-сайн, юу тусгүй-муу вэ гэдгийг ойлгохгүй юм. Хэрэв би, эдгээрийг ойлгохгүйгээр, мэдэхгүйгээр аливаа нэгэн юмыг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэж зарлавал надад хүсэл-эрмэлзэл[79], эсвэл дур-хүсэл[80], эсвэл уур-хилэн[81], эсвэл зөрчил-хорсол[82] бий болгож болох юм. Хэрэв надад хүсэл-эрмэлзэл, дур-хүсэл, уур-хилэн, зөрчил-хорсол бий болбол, энэ нь миний хувьд дон-шунал[83] болох болно. Тэгсэн тохиолдолд, дон-шунал намайг зовлонд унагаж, энэ зовлон нь надад төвөг бэрхшээл үүсгэж болох юм.’ хэмээн боддог.

Тиймээс тэрээр дон-шуналаас айж, дон-шуналыг жигшиж, аливаа зүйлийг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэж зарладаггүй. Харин энэ тэр юмны талаар асуувал элдэв аргаар бултаж, салаа утгаар:

‘“Тийм байна” гэдэг нь миний үзэл биш. “Тийм болохоор” гэдэг нь ч миний үзэл биш. “Аль эсвэл” гэдэг нь ч миний үзэл биш. “Тийм биш” гэдэг ч миний үзэл биш. “Тийм биш нь ч биш” гэдэг ч миний үзэл биш.’ гэж тэд хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч, зарим даянч болон бярман нарын хоёр дахь үндэслэл нь юм.

Гурав дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулдаг юм бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар аливаа зүйлийг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэдгийг үнэн мөнөөр нь ойлгодоггүй.

Тэрээр:

‘Би юу тустай-сайн, юу тусгүй-муу вэ гэдгийг ойлгохгүй юм. Гэвч, ширхэг үсийг ч тэг дундуур нь харваж чадах онч мэргэн харваач мэт мэргэн цэцэн, үүгээр түүгээр явж бусдын үзэл онолыг няцаадаг, маргалдаан мэтгэлцээнд туршлагажсан даянч болон бярман нар байдаг. Хэрэв би, эдгээрийг ойлгож мэдэхгүйгээр аливаа зүйлийг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэж зарлавал тэд, учир шалтгааны ухаанаар намайг шүүж, миний үзэл онолыг элдвээр сөргүүлэн асууж шалгааж, намайг няцааж болох юм. Тэгээд би хэлэх үггүй болж болох юм. Тэгсэн тохиолдолд, хэлэх үггүй болох явдал намайг зовлонд унагаж, энэ зовлон нь надад тээг саадыг үүсгэж болох юм.’ хэмээн боддог.

---

79 *Chando*—“хүсэл-эрмэлзэл”. Эерэг, сөрөг аль ч утгатай байж болох, нэгэн зорилго руу чиглэсэн хүсэл. (Сургаал номыг сурах ойлгох хүсэл-эрмэлзэл г.м.)

80 *Rāgo*—“дур-хүсэл”. Үүнд: 1. мэдрэхүйн дур-хүсэл (*kāma-rāga*); 2. Нарийн-биеийн Орон (*rūpa-loka*)-д оршихуйн дур-хүсэл (*rāga*); 3. Бие-бусын Орон (*arūpa-loka*)-д оршихуйн дур-хүсэл (*rāga*) хамаарна. (Лавлахад нэр томьёонуудыг үз.)

81 *Doso*—“уур-хилэн”. Түлхэх, зайлуулах хандлага, дургүйцэл, ааг омог бүхий байдал. Арван Сэтгэлийн-хирийн нэг.

82 *Paṭigho*—“зөрчил-хорсол”. Эсэргүүцсэн, тэрсэлдсэн, зөрчилдсөн, мөргөлдөөнт сэтгэлийн байдал.

83 *Upādāna*—“дон-шунал”. Хүсэл-цангаа (*taṇhā*)-аас үүдэн бий болж улам хүчтэй автаж зууралдсан, гүн гүнзгий шунал, дон. Энэ хорвоод дахин дахин төрөх, хамаг зовлонд унагах үндсэн шалтгаан. (DN 15-г үз.)

Тиймээс тэрээр, сөргүүлсэн асуултаас айх айдас болон жигшлээс үүдэн аливаа зүйлийг тустай-сайн, эсвэл тусгүй-муу гэж зарладаггүй. Харин энэ тэр юмны талаар асуувал элдэв аргаар бултаж, салаа утгаар:

'"Тийм байна" гэдэг нь миний үзэл биш. "Тийм болохоор" гэдэг нь ч миний үзэл биш. "Аль эсвэл" гэдэг нь ч миний үзэл биш. "Тийм биш" гэдэг ч миний үзэл биш. "Тийм биш нь ч биш" гэдэг ч миний үзэл биш.' гэж тэд хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч, зарим даянч болон бярман нарын гурав дахь үндэслэл нь юм.

Дөрөв дэх нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулдаг юм бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар мааннаг, мунхаг байдаг. Маанаг, мунхаг байдлаас үүдэн энэ тэр юмны талаар асуувал элдэв аргаар бултаж, салаа утгаар:

1. 'Хэрвээ надаас нөгөө ертөнц[84] байдаг эсэхийг асуулаа гэж бодъё. Хэрвээ үнэхээр тийм ертөнц байна гэж итгэсэн бол би, нөгөө ертөнц байгаа л гэж хэлэх болно. Гэхдээ "Тийм байна" гэдэг нь миний үзэл биш. "Тийм болохоор" гэдэг нь ч миний үзэл биш. "Аль эсвэл" гэдэг нь ч миний үзэл биш. "Тийм биш" гэдэг ч миний үзэл биш. "Тийм биш нь ч биш" гэдэг ч миний үзэл биш.' гэх мэтээр хариулна.

Мөн ялгаагүй, тэднээс дараах:[85]

2. Нөгөө ертөнц байдаггүй гэж үү?
3. Нөгөө ертөнц байгаа байхгүй хоёул гэж үү?
4. Нөгөө ертөнц гэж байгаа байхгүй аль нь ч биш гэж үү?

1. Аяндаа төрдөг бодгаль[86] гэж байдаг уу?[87]
2. Аяндаа төрдөг бодгаль гэж байдаггүй юу?
3. Аяндаа төрдөг бодгаль гэж байгаа байхгүй хоёул гэж үү?
4. Аяндаа төрдөг бодгаль гэж байгаа байхгүй аль нь ч биш гэж үү?

1. Муу эсвэл сайн үйлийн[88] үрээр үүссэн зовлон эсвэл жаргал гэж байдаг уу?
2. Муу эсвэл сайн үйлийн үрээр үүссэн зовлон эсвэл жаргал гэж байдаггүй юу?
3. Муу эсвэл сайн үйлийн үрээр үүссэн зовлон эсвэл жаргал гэж байгаа байхгүй хоёул гэж үү?

---

84 Энд "нөгөө ертөнц" (па. *paro loko*) буюу үхлийн дараах ертөнцийг хэлсэн болно.

85 Энэ нь эртний Энэтхэгийн "логик дөрвөл" (па. *catuskoti,* ор. *тетралемма*, грек. *tetralemma*) хувилбар: 1. тийм; 2. үгүй; 3. тийм үгүй хоёул; 4. тийм үгүй аль нь ч биш юм. Тиймээс дөрөвлөсөн дугаарлалтыг үүнтэй холбож оруулсан болно.

86 *Opapātikā*—"аяндаа төрдөг бодгаль". Эсвэл "өөрөө, аяндаа төрдөг бодгаль" буюу хүмүүний нүдэнд харагдахгүй төрөл юм. Үүнд: 1. Тэнгэр, бурхад; 2. Тамд зовогсод; 3. Өлсгөлөн-сүнснүүд; 4. Зарим нэг хүмүүс буюу Эс Эргэн Ирэгч Гэгээрэлд хүрсэн хүмүүс орно. Энэ утгаараа энэ бол бидний нүдэнд эс үзэгддэг бодгаль байдаг эсэхийг асуусан асуулт болно.

87 Мьянмар эхэд "бодгалиудад үхлийн дараах амьдрал гэж байдаг уу?" гэсэн утгаар оруулсан байна (MPA).

88 *Камма*—"үйл" (сам. *karma*). Бие, хэл, сэтгэлээр үйлдэх ямар нэгэн үйлдэл. Энэ утгаараа энэ бол "үйлийн үр" гэж байдаг эсэхийг асуусан асуулт болно. Үйлийн үрийг Лавлахад үз.

4. Муу эсвэл сайн үйлийн үрээр үүссэн зовлон эсвэл жаргал гэж байгаа байхгүй аль нь ч биш гэж үү?

1. Будда[89] үхсэний дараа оршсоор байдаг уу?
2. Будда үхсэний дараа оршин байхгүй гэж үү?
3. Будда үхсэний дараа орших эс оршихуйн аль аль төлөвт байдаг гэж үү?
4. Будда үхсэний дараа орших эс оршихуйн аль ч төлөвт байдаггүй гэж үү?

гэсэн асуултуудыг асуухад, тэд мөн л элдэв аргаар бултаж, салаа утгаар:

‘Хэрвээ надаас өөр ертөнц байдаг эсэхийг асуувал, хэрвээ үнэхээр тийм ертөнц байна гэж харах юм бол, тийм өөр ертөнц байгаа гэж би хэлэх болно. Гэхдээ “Тийм байна” гэдэг нь миний үзэл биш. “Тийм болохоор” гэдэг нь ч миний үзэл биш. “Аль эсвэл” гэдэг нь ч миний үзэл биш. “Тийм биш” гэдэг ч миний үзэл биш. “Тийм биш нь ч биш” гэдэг ч миний үзэл биш.’ гэж тэд хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч, зарим даянч болон бярман нарын дөрөв дэх үндэслэл нь юм.

Хуврагууд аа, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш, эдгээр дөрвөн үндэслэлийг л, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирваaныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

---

[89] *Tathāgato*—“Будда”. “Тийн Одогч”-ыг “Будда” хэмээн энд болон бусад ижил хэсэгт оруулав. Энд шинж чанар талаасаа бүх Будда нарыг нийтэд нь хамруулан авч үзсэн санаа.

3.5. Шалтгаангүй Үүслийн Үзэл: 17–18 (Adhiccasamuppannavāda)

Хуврагууд аа, хоёр үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн гэж зарлан тунхагладаг, шалтгаангүй үүслийн онолч[90], зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, 'Танихуй-үгүй Бодгалиуд'[91] гэж нэрлэгдэх, зарим нэг бурхад байдаг. Тэдэнд ухаан мэдээ үүсмэгц тэдгээр бурхад тэр ертөнцөөсөө унадаг.

Хуврагууд аа, тэр бодгаль төрөл доошилж унасныхаа дараа энэ ертөнцөд төрөл авдаг. Энэ ертөнцөд ирснийхээ дараа тэрээр, эгэл хүмүүний амьдралаа орхиж, гэр оронгүй даянч болж болно. Даянч болсны дараа тэрээр хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, оршин байсан үеэ эргэн санадаг боловч түүнээс өмнөхийг санадаггүй.

Тэгээд тэрээр:

'Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол шалтгаангүйгээр үүссэн.

Яагаад тийм гэж үү?

Яагаад гэвэл би, түүнээс өмнө оршин байгаагүй билээ. Оргүй хоосноос би, гэнэт л харваж бий болсон юм.' гэж хэлдэг.

Энэ бол, хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн гэж зарлан тунхагладаг, шалтгаангүй үүслийн онолч, зарим даянч болон бярман нарын эхний үндэслэл нь юм.

Хоёр дахь нь, хуврагууд аа, юунаас улбаалан, юутай холбон, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн гэж, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар бол задлан шинжээч, учир зүйч нар байдаг. Тэд өөрсдийн ухаан бодолдоо нягуур дүн шинжилгээ хийж, учир шалтгааныг ухан үзсэний эцэст:

'Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн.' хэмээн зарлан тунхагладаг.

Энэ бол, хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн гэж зарлан тунхагладаг, шалтгаангүй үүслийн онолч, зарим даянч болон бярман нарын хоёр дахь үндэслэл нь юм.

---

[90] *Adhiccasamuppannikā*—"шалтгаангүй үүслийн онолч". Аливаа зүйлс ямарваа нэг тодорхой учир шалтгаангүйгээр, санамсаргүйгээр үүсдэг, тохиодог гэж үздэг үзэлтэн (анг. "*fortuitous originationists*", BB). *Adhiccasamuppannavāda* —"Шалтгаангүй Үүслийн Үзэл". Өөрөөр "Санамсаргүй Үүслийн Онол" ("*doctrines of anomalous origination",* BS).

[91] *Asaññasattā*—"Танихуй-үгүй Бодгалиуд". Танин-мэдэхүй байхгүй, эсвэл "ухаан мэдээгүй", "мэдээгүй" бодгалиуд буюу Танихуй-Үгүйн Орны бодгалиуд үүнд хамаарна. (Тайлбарт Будда хэсгийг, "танин-мэдэхүй"-г Лавлахад үз.)

Хуврагууд аа, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн гэж зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд л ямар нэг өөр үндэслэлийг биш, энэ хоёр үндэслэлийг л, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирвааныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

Хоёрдугаар уншлага хэсэг өндөрлөв.

4. Ирээдүйг Таамаглагч (Aparantakappika)

Хуврагууд аа, дөчин дөрвөн үндэслэл дээр, ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, ирээдүйг таамаглагч[92], ирээдүйн талаар үзэл баримтлагч, зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

---

[92] *Aparantakappika*—“ирээдүйг таамаглагч”. Ирээдүй цаг үеийн талаар элдвийг таамаглагч. Зарим орчуулгад, “ертөнцийн төгсгөл” (анг. “*final end*”, BS)

4.1. Танихуй-Бүхий Үзэл: 19–34 (Saññīvāda)

Хуврагууд аа, арван зургаан үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий[93] байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий амьдралын онолч[94], зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Тэд, 'Үхлийн дараа, өөрийн-оршихуй нь танихуй-бүхий байдлаар, эрүүл саруул:

1. Бие-дүрст[95] байдлаар,
2. Бие-бус[96] байдлаар,
3. Бие-дүрст бие-бус хавсарсан байдлаар,
4. Бие-дүрст бие-бус аль нь ч бус байдлаар,

1. Хязгаартай[97] байдлаар,
2. Хязгааргүй[98] байдлаар,
3. Хязгаартай, хязгааргүй хавсарсан байдлаар,
4. Хязгаартай, хязгааргүй аль нь ч биш байдлаар,

1. Нэг ой санамжтайгаар[99],
2. Холимог ой санамжтайгаар,
3. Хязгаарлагдмал ой санамжтайгаар,
4. Хязгааргүй ой санамжтайгаар,

1. Үнэнхүү аз жаргалтайгаар,
2. Үнэнхүү зовлонтойгоор,
3. Жаргал зовлон холилдсон байдлаар,

---

93 *Saññī*—"танихуй-бүхий". Өөрөөр "танин-мэдэхүйтэй", "танин-мэдэхүйтэй нэгэн". *Saññā*—"танин-мэдэхүй" (сам. *saṃjñā*). Ухаан мэдээ, ой санамж, ухаан мэдлэг, танихуй, ойлгохуй г.м. утга. Танин-мэдэхүй нь таван-цулын нэг. Мөн ялгаатай орон ертөнц (дараа төрөл авах), зарим бясалгалын түвшин болон аргачлалын нэр томьёонд хэрэглэгдэнэ. Жиш: 1. "танихуй-бүхий" (*saññī*); 2. "танихуй-үгүй" (*asaññī*); 3. "танихуй-бүхий танихуй-үгүй хавсарсан" (*saññī ca asaññī ca*); 4. "танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус" (*nevasaññī nāsaññī*). Зарим хэсэгт "ой санамж" гэж оруулав. (Тайлбарт хар.)

94 *Uddhamāghātanikā saññīvādā*—"үхлийн дараах танихуй-бүхий амьдралын онолч". Үхлийн дараа, өөрийн-оршихуй нь ямар нэг байдлаар, танин-мэдэхүйтэйгээ үргэлжлүүлэн амьдарсаар байх болно гэж үзэх үзэлтэн.

95 *Rūpī (rūpa)*—"Бие-дүрст". Бие, дүрс, хэлбэр бүхий, нүдэнд харагдахуйц, ямар нэг материалаас бүтсэн, хүний мэдрэхүйд ямар нэг байдлаар танигдахуйц юмс; Нарийн-биеийн Орон; мөн өнгө, үнэр, гэрэл г.м. орно. Зарим тохиолдолд "бие-дүрс" гэж оруулав.

96 *Arūpa*—"Бие-бус". "Бие-дүрст" биш, "бие-дүрс" байхгүй, биегүй, хэлбэргүй, дүрсгүй, материаллаг биш.

97 *Antavā*—"Хязгаартай". Өөрөөр "хүрээ хязгаартай", "эцэс төгсгөлтэй", "хэмжээтэй" г.м. орон зайн ойлголт.

98 *Anantavā*—"Хязгааргүй". Өөрөөр "хүрээ хязгааргүй", "эцэс төгсгөлгүй", "хэмжээлшгүй" г.м. орон зайн ойлголт.

99 Энд, "танин-мэдэхүй"-г "ой санамж" гэж хэрэглэв.

4. Жаргалтай, зовлонтой аль нь ч биш байдлаар, амьдарсаар байх болно.’ гэдэг.

Эдгээр нь, хуврагууд аа, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий амьдралын онолч, зарим даянч болон бярман нарын арван зургаан үндэслэл нь юм.

Хуврагууд аа, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд л ямар нэг өөр үндэслэлийг биш, энэ арван зургаан үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирвааныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

4.2. Танихуй-Үгүй Үзэл: 35–42 (Asaññīvāda)

Хуврагууд аа, найман үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-үгүй[100] байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-үгүй амьдралын онолч[101], зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Тэд, ‘Үхлийн дараа, өөрийн-оршихуй нь танихуй-үгүй байдлаар, эрүүл саруул:

---

[100] *Asaññī*—“танихуй-үгүй”. Танин-мэдэхүйгүй. Эсвэл ой санамжгүй, ухаан мэдээгүй, мэдлэг ухаангүй, танихуй байхгүй, ойлгохуй байхгүй гэдэг утгаар. “Танин-мэдэхүй байхгүй” гэсэн утгатай энэ үгийг зарим тохиолдолд “танихуй-үгүй” гэж хэрэглэнэ.

[101] *Uddhamāghātanikā asaññīvādā*—“үхлийн дараах танихуй-үгүй амьдралын онолч”. Үхлийн дараа, өөрийн-оршихуй нь ямар нэг байдлаар, танин-мэдэхүйгүй байдлаар үргэлжлүүлэн амьдарсаар байх болно гэж үзэх үзэлтэн.

1. Бие-дүрст байдлаар,
2. Бие-бус байдлаар,
3. Бие-дүрст бие-бус хавсарсан байдлаар,
4. Бие-дүрст бие-бус аль нь ч бус байдлаар,

1. Хязгаартай байдлаар,
2. Хязгааргүй байдлаар,
3. Хязгаартай, хязгааргүй хавсарсан байдлаар,
4. Хязгаартай, хязгааргүй аль нь ч биш байдлаар, амьдарсаар байх болно.' гэдэг.

Эдгээр нь, хуврагууд аа, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-үгүй байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-үгүй амьдралын онолч, зарим даянч болон бярман нарын найман үндэслэл нь юм.

Хуврагууд аа, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-үгүй байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай тэд бүгд л, ямар нэг өөр үндэслэлийг биш энэ найман үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирвааныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

4.3. Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бус Үзэл: 43–50 (Nevasaññīnāsaññīvāda)

Хуврагууд аа, найман үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус[102] байдлаар амьдарсаар байх болно хэмээн зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус амьдралын онолч, зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Тэд, 'Үхлийн дараа, өөрийн-оршихуй нь танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус байдлаар, эрүүл саруул:

1. Бие-дүрст байдлаар,
2. Бие-бус байдлаар,
3. Бие-дүрст бие-бус хавсарсан байдлаар,
4. Бие-дүрст бие-бус аль нь ч бус байдлаар,

1. Хязгаартай байдлаар,
2. Хязгааргүй байдлаар,
3. Хязгаартай, хязгааргүй хавсарсан байдлаар,
4. Хязгаартай, хязгааргүй аль нь ч биш байдлаар, амьдарсаар байх болно.' гэдэг.

Эдгээр нь, хуврагууд аа, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус байдлаар амьдарсаар байх болно хэмээн зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус амьдралын онолч, зарим даянч болон бярман нарын найман үндэслэл нь юм.

Хуврагууд аа, өөрийн-оршихуй нь үхлийн дараа танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш, энэ найман үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирвааныг өөр дээрээ ухаардаг билээ.

---

102 *Nevasaññīnāsaññī*—“танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус”. Өмнөх тайлбарт дурдсан *Тетралемма*-гийн дөрөв дэх хувилбарыг ой санамж, танин-мэдэхүй дээр хэрэглэсэн байдал.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

4.4. Мөхлийн Үзэл: 51–57 (Ucchedavāda)

Хуврагууд аа, долоон үндэслэл дээр, үхлийн дараа, одоо байгаа амьд биет[103] нь мөхөж, сөнөж, алга болдог гэж зарлан тунхагладаг, мөхлийн үзэлтэн[104], зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, тэдгээр үзлийг баримтлагч зарим даянч болон бярман нар:

‘Эрхэм ноёнтон минь, аливаа өөрийн-оршихуй бол ерөөсөө л, бие-дүрст, язгуур дөрвөн махбодоос[105] бүтсэн, мөн эцэг эхээс мэндэлсэн болохоор, бие цогцос задрах цагт мөхөж, сөнөж, үхсэний дараа үгүй болдог бөгөөд харин тэр л үед энэ өөрийн-оршихуй нь нэгмөсөн мөхдөг.’ гэдэг.[106]

Ийм байдлаар үхлийн дараа, одоо байгаа амьд биет юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг.

Түүнд өөр хэн нэгэн ингэж хэлнэ:

‘Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ тэдгээр өөрийн-оршихуй нь, тэр үедээ шууд мөхдөг гэсэн үг биш юм. Учир юу гэвэл, бие-дүрстэй[107],

---

103 *Sato sattassa*—“одоо байгаа амьд биет”. Өөрөөр “одоо амьд байгаа, амьд бодгалиуд”. Өмнөх хэсэгт “өөрийн-оршихуйн” (*attā*) тухай ярьж байсан бол энэ хэсэгт “амьд биет”, “бодгаль” (*satta*) өөр дүйцэх нэршлээр ярьж байгааг анзаар. Өөрийн-оршихуйг хүмүүс өөрөө өөрийнхөөрөө ойлгож ярих тул энд мөн боломжит нэгэн хувилбараар ярьжээ.

104 *Ucchedavādā*—“мөхлийн үзэлтэн” (анг. *annihilationism*). Өөрөөр “Мөхлийн Онол”. Үхлийн дараа, одоо байгаа амьд биетүүд, өөрийн- мөхөж, сөнөж, алга болдог гэж үзэх үзэл; ийм үзэлтэн.

105 *Cātumahābhūtiko*—“язгуур дөрвөн махбод”. Язгуур махбод (па. *mahābhūta*) буюу үндсэн бодис, үндсэн элемент, үндсэн төлөв, сууръ эд эс, материал г.м. Паали Сударт язгуур махбодыг дөрөв (1. Гал; 2. Ус; 3. Газар; 4. Агаар) байна гэж үздэг нь Монголчуудын “таван махбод” гэх түгээмэл ойлголтоос ялгаатай байдгийг анхаарна уу.

106 Үүнийг зарим судлаачид материалист үзэл гэж тайлбарладаг.

107 “Бие-дүрс” (*rūpa*) боловч энэ удаад улам нарийн төлөвийг (па. *sukhumarūpa*) илэрхийлж, өнгө, гэрлийн тухай буюу зарим гэрэл, туяа зэргээр илрэх тэнгэр бурхдын талаар яригдаж буй болно.

Мэдрэхүйн Оронд[108] хамаарах, бие-дүрст хоолоор хооллодог, өөр нэгэн тэнгэрлэг[109] өөрийн-оршихуй байдаг билээ.

Та энэ өөрийн-оршихуйг харж, эсвэл мэдэж чадахгүй ба харин би харж, бас мэдэж байгаа билээ. Эрхэм ноёнтон минь, аливаа өөрийн-оршихуй бол ерөөсөө л, бие цогцос задрах цагт мөхөж, сөнөж, үхсэний дараа үгүй болдог болохоор, харин тэр л үед энэ өөрийн-оршихуй нь нэгмөсөн мөхдөг.'

Ийм байдлаар үхлийн дараа, одоо байгаа амьд биет юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг.

Түүнд өөр хэн нэгэн ингэж хэлнэ:

'Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ тэдгээр өөрийн-оршихуй нь, тэр үедээ шууд мөхдөг гэсэн үг биш юм. Учир юу гэвэл, бие-дүрст, оюунаар-бүтсэн, эд эрхтэн цөм бүтэн, мэдрэхүйн чадвар бүгд бүрэн, өөр бас тийм тэнгэрлэг өөрийн-оршихуй байдаг билээ.

Та энэ өөрийн-оршихуйг харж, эсвэл мэдэж чадахгүй ба харин би харж, бас мэдэж байгаа билээ. Эрхэм ноёнтон минь, аливаа өөрийн-оршихуй бол ерөөсөө л, бие цогцос задрах цагт мөхөж, сөнөж, үхсэний дараа үгүй болдог болохоор, харин тэр л үед энэ өөрийн-оршихуй нь нэгмөсөн мөхдөг.'

Ийм байдлаар үхлийн дараа, одоо байгаа амьд биет юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг.

Түүнд өөр хэн нэгэн ингэж хэлнэ:

'Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ тэдгээр өөрийн-оршихуй нь, тэр үедээ шууд мөхдөг гэсэн үг биш юм. Учир юу гэвэл, бие-дүрст юмсын танихуйн ойлголтоос нэгэнт хальсан, "орон зай хязгааргүй"[110]-г оршоон бясалгаснаар хүрдэг, юмсын төрөл зүйлийг танихуйд анхаарал эс хандуулснаар хүрдэг, аливаад үзүүлэх хариу үйлдэл үгүй болсноор хүрдэг, Хязгааргүй Орон Зайн Орны[111] өөрийн-оршихуй гэж байдаг билээ.

Та энэ өөрийн-оршихуйг харж, эсвэл мэдэж чадахгүй ба харин би харж, бас мэдэж байгаа билээ. Эрхэм ноёнтон минь, аливаа өөрийн-оршихуй бол ерөөсөө л, бие цогцос задрах цагт мөхөж, сөнөж, үхсэний дараа үгүй болдог болохоор, харин тэр л үед энэ өөрийн-оршихуй нь нэгмөсөн мөхдөг.'

Ийм байдлаар үхлийн дараа, одоо байгаа амьд биет юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг.

---

108 *Kāmāvacaro*—"Мэдрэхүйн Орон". Сайн муу үйлийн үр, мэдрэхүйн-таашаал, хүслийн улмаас төрдөг 11 орон (1. там; 2. өлсгөлөн-сүнс; 3. амьтан; 4. асура; 5. хүн; 6-11. бурхдын зургаан орон). (Бурхдын 6 орныг Тайлбарын Будда хэсэгт үз.)

109 *Dibbo*—"тэнгэрлэг". Эсвэл "бурханлаг", "Тэнгэрийн орны", "диваажингийн".

110 *"Ananto ākāso"*—"орон зай хязгааргүй". "Орон зай бол хязгааргүй юм." хэмээн оюундаа оршоон бясалгахуй.

111 *Ākāsānañcāyatana*—"Хязгааргүй Орон Зайн Орон". Бие-бусын Орон, Бие-бусын даяаныг үз.

Түүнд өөр хэн нэгэн ингэж хэлнэ:

‘Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ тэдгээр өөрийн-оршихуй нь, тэр үедээ шууд мөхдөг гэсэн үг биш юм. Учир юу гэвэл, Хязгааргүй Орон Зайн Орноос нэгэнт хальж, “ухамсар хязгааргүй”[112]-г оршоон бясалгаснаар хүрдэг, Хязгааргүй Ухамсрын Орны[113] өөрийн-оршихуй гэж байдаг билээ.

Та энэ өөрийн-оршихуйг харж, эсвэл мэдэж чадахгүй ба харин би харж, бас мэдэж байгаа билээ. Эрхэм ноёнтон минь, аливаа өөрийн-оршихуй бол ерөөсөө л, бие цогцос задрах цагт мөхөж, сөнөж, үхсэний дараа үгүй болдог болохоор, харин тэр л үед энэ өөрийн-оршихуй нь нэгмөсөн мөхдөг.’

Ийм байдлаар үхлийн дараа, одоо байгаа амьд биет юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг.

Түүнд өөр хэн нэгэн ингэж хэлнэ:

‘Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ тэдгээр өөрийн-оршихуй нь, тэр үедээ шууд мөхдөг гэсэн үг биш юм. Учир юу гэвэл, Хязгааргүй Ухамсрын Орноос нэгэнт хальж, “оргүй хоосон”[114]-ыг оршоон бясалгаснаар хүрдэг, Огт-Оргүйн Орны[115] өөрийн-оршихуй гэж байдаг билээ.

Та энэ өөрийн-оршихуйг харж, эсвэл мэдэж чадахгүй ба харин би харж, бас мэдэж байгаа билээ. Эрхэм ноёнтон минь, аливаа өөрийн-оршихуй бол ерөөсөө л, бие цогцос задрах цагт мөхөж, сөнөж, үхсэний дараа үгүй болдог болохоор, харин тэр л үед энэ өөрийн-оршихуй нь нэгмөсөн мөхдөг.’

Ийм байдлаар үхлийн дараа, одоо байгаа амьд биет юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг.

Түүнд өөр хэн нэгэн ингэж хэлнэ:

‘Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ тэдгээр өөрийн-оршихуй нь, тэр үедээ шууд мөхдөг гэсэн үг биш юм. Учир юу гэвэл, Огт-Оргүйн Орноос нэгэнт хальж, “энэ бол амар амгалан, энэ бол үнэн гайхамшиг”[116]-ийг оршоон бясалгаснаар хүрдэг, Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орны[117] өөрийн-оршихуй гэж байдаг билээ.

---

[112] *“Anantaṁ viññāṇan”*—“ухамсар хязгааргүй”. “Ухамсар бол хязгаар үгүй юм.” хэмээн оюундаа оршоон бясалгахуй.

[113] *Viññāṇañcāyatana*—“Хязгааргүй Ухамсрын Орны”. Бие-бусын Орон, Бие-бусын даяаныг үз.

[114] “*Natthi kiñci*”—“оргүй хоосон”. “Оргүй хоосон, юу ч үгүй байдлыг” оюундаа оршоон бясалгахуй.

[115] *Ākiñcaññāyatana*—“Огт-Оргүйн Орон”. Бие-бусын Орон, Бие-бусын даяаныг үз.

[116] “*Santametaṁ paṇītametan*”—“энэ бол амар амгалан, энэ бол үнэн гайхамшиг”. “Энэ бол амар амгалан. Энэ бол үнэн гайхамшиг юм.” хэмээн оюундаа оршоон бясалгахуй.

[117] *Nevasaññānāsaññāyatana*—“Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орны”. Хорвоогийн хамгийн дээд орон. Бие-бусын даяаныг оршоосноор хүрнэ. Энэ бодгалиуд бие-дүрсгүй, танин-мэдэхүйгүй, ухаан мэдээгүй шахам төлөвт 84 000 их галавын турш оршино (Abh; DA). (Тайлбарт Буддаг, Бие-бусын орон, даяаныг Лавлахад үз.)

Та энэ өөрийн-оршихуйг харж, эсвэл мэдэж чадахгүй ба харин би харж, бас мэдэж байгаа билээ. Эрхэм ноёнтон минь, аливаа өөрийн-оршихуй бол ерөөсөө л, бие цогцос задрах цагт мөхөж, сөнөж, үхсэний дараа үгүй болдог болохоор, харин тэр л үед энэ өөрийн-оршихуй нь нэгмөсөн мөхдөг.'

Ийм байдлаар үхлийн дараа, одоо байгаа амьд биет нь юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг.

Эдгээр нь, үхлийн дараа, одоо байгаа амьд биет нь юу ч үгүй устаж, сөнөж, мөхдөг гэж зарлан тунхагладаг, мөхлийн үзэлтэн, зарим даянч болон бярман нарын долоон үндэслэл юм.

Хуврагууд аа, амьд биетийг үхлийн дараа юу ч үгүй устаж, мөхөж, сөнөдөг тухай онолоо зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш энэ долоон үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирваaныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

4.5. Энэ Насны Нирваан Үзэл: 58–62 (Diṭṭhadhammanibbānavāda)

Хуврагууд аа, таван үндэслэл дээр, одоо байгаа амьд биетийн энэ насны төгс Нирваан хэмээн зарлан тунхагладаг, энэ насны Нирваан[118] хэмээх үзэлтэн, зарим даянч болон бярман нар байдаг.

Юунаас улбаалан, юутай холбон, эдгээр нэр хүндтэй даянч болон бярман нар тэдгээр үзлээ зарлан тунхагладаг бол?

Хуврагууд аа, зарим даянч болон бярман нар:

[118] *Diṭṭhadhammanibbānaṁ*—“энэ насны Нирваан”. Өөрөөр, “Нирваан гэээч энд байна”, “энэ насны Нирваан” буюу монголчуудын “амьд насны диваажин”, “амьд насны диваажиндаа очих” г.м. ойлголттой дүйх утгатай үзэл баримтлал.

‘Эрхэм ноёнтон минь, таван мэдрэхүйн-таашаалт зүйлээр[119] дүүрэн хангаж, бүрэн умбуулах тэр үед, өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд хүрдэг.’ гэдэг.

Ийм маягаар хуврагууд аа, одоо байгаа амьд биет нь энэ насандаа төгс Нирвааныг үздэг гэж зарлан тунхагладаг.

Түүнд өөр хэн нэгэн ингэж хэлнэ:

‘Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд тэгж хүрдэггүй юм.

Яагаад гэж үү?

Яагаад гэвэл, эрхэм ноёнтон минь, мэдрэхүйн-таашаал[120] бол мөнхийн-бус, зовлонтой[121], хувирамтгай Чанартай[122] бөгөөд тэрхүү хувьсан өөрчлөгддөг, нэг янзаараа бус байдлаас харуусал, шаналал, зовуурь, гашуудал хийгээд зовлон зүдүүр үүсдэг. Гэвч хэрэв энэхүү өөрийн-оршихуй нь мэдрэхүйн-таашаалаас салснаар, тусгүй-муу Зүйлээс[123] салснаар, улмаар зурвас-бодол бүхий[124], эргэцүүлсэн-бодол бүхий[125], ганцаар-ахуйгаас[126] үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий[127], нэгдүгээр даян[128] зэрэгт хүрч, оршин байх бөгөөд, харин яг тэр үед л өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд хүрдэг.’ гэж хэлдэг.

Ийм маягаар хуврагууд аа, одоо байгаа амьд биет нь энэ насандаа төгс Нирвааныг үздэг гэж зарлан тунхагладаг.

Өөр нэг нь түүнд бас ингэж хэлнэ:

‘Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд тэгж хүрдэггүй юм.

---

119 *Kāmaguṇehi*—“мэдрэхүйн-таашаалт зүйл”. Үгчилбэл, “мэдрэхүйд таашаал өгөх зүйлс, юмс”. “Мэдрэхүйн-таашаал”-ыг үз.

120 *Kāma*—“мэдрэхүйн-таашаал”. Өөрөөр, “таван мэдрэхүйн хүсэл, таашаал”. Таван мэдрэхүйд (1. харах; 2. сонсох; 3. үнэрлэх; 4. амтлах; 5. хүрэлцэх) мэдрэгдэх зүйлсэд татагдах хүсэл. Судрын зарим хэсэгт “таван мэдрэхүйн таашаал” гэж оруулав.

121 *Dukkhā*—“зовлонтой”. Өөрөөр: таагүй, зовлонгийн шинжтэй, төвөгтэй байдал; зовлон, зовуурь г.м.

122 *Vipariṇāma-dhammā*—“хувирамтгай Чанартай”. Өөрөөр, мууддаг, элэгддэг, хуучирдаг чанартай.

123 *Dhammehi*—“Зүйлээс”. (Тайлбарт Сургаал хэсгийг үз.)

124 *Savitakkaṁ*—“зурвас-бодол бүхий” (анг. *applied thought* эсвэл *initial application*). Оюун санаанд ямар нэг бодол, санаа, мэдрэмж зурсхийх, ямар нэг зурвасхан ч атугай бодол, санаа, мэдрэмж байхуй. DN 2.4.10-15-д дэлгэрүүлж үз.

125 *Savicāraṁ*—“эргэцүүлсэн-бодол бүхий”. (анг. *sustained thought* эсвэл *sustained application*). Оюун санаанд ямар нэг эргэцүүлсэн, тунгаасан бодол, санаа, мэдрэмж байхуй. DN 2.4.10-15-д дэлгэрүүлж үз.

126 *Vivekajaṁ*—“ганцаар-ахуйгаас”. *Viveka*—“ганцаар-ахуй” (анг. *seclusion* эсвэл *solitude*). Орь ганцаар байдал, бүхнээс тусгаарлагдсан байдал, бүгдээс салж ангижирсан байдал. DN 2.4.10-15-д дэлгэрүүлж үз.

127 *Pītisukhaṁ*—“хөөр-баяр аз-жаргал бүхий”. Бясалгалаас үүсэх дээд зэргийн жаргалантай мэдрэмж (DN 2.4.10-15-д дэлгэрүүлж үз. Хөөр-баяр, аз-жаргалыг тус тус Лавлахад үз.)

128 *Jhāna*—“даяан” (сам. *dhyāna*). Сахил-ухамсрыг суулгасан, таван-саад-ыг давсан үедээ *samādhi* бясалгалыг зөв хийснээр хүрэх бясалгалын ахисан түвшин. Зарим монгол бичвэрт “дияан” гэж байх ч Я. Цэвэлийн толь, бусад албан эх сурвалжид ийм үг байхгүй тул “даяан”-ыг хэрэглэнэ. DN 2.4.11-14-д дэлгэрүүлж үз.

Яагаад гэж үү?

Яагаад гэвэл, эрхэм ноёнтон минь, тэр даяан нь зурвас-бодол болон эргэцүүлсэн-бодлыг агуулсан байдаг. Тийм болохоор, энэ нь болхи гэж тооцогддог юм. Гэвч, хэрэв энэхүү өөрийн-оршихуй нь зурвас-бодол, эргэцүүлсэн-бодол намжиж, самади-төвлөрлөөс үүссэн[129] хөөр-баяр аз-жаргал бүхий, дотоод амар-амгалан[130], оюуны-нэгдэл[131] бүхий хоёрдугаар даяан зэрэгт хүрч, оршин байх бөгөөд, харин яг тэр үед л өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд хүрдэг.' гэж хэлдэг.

Ийм маягаар хуврагууд аа, одоо байгаа амьд биет нь энэ насандаа төгс Нирвааныг үздэг гэж зарлан тунхагладаг.

Өөр нэг нь түүнд бас ингэж хэлнэ:

'Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд тэгж хүрдэггүй юм.

Яагаад гэж үү?

Яагаад гэвэл, эрхэм ноёнтон минь, тэр даянд чинь хөөр-баяр болон сэтгэл хөөрөл байсаар байна. Тийм болохоор энэ нь болхи гэж тооцогддог юм. Гэвч, хэрэв энэхүү өөрийн-оршихуйн хөөр-баяраас салж-ангижирснаар, дүүрэн-анхаарал[132], тунгалаг-оюун[133] бүхий төв-оршихуйд[134] байж, бөгөөд бие махбодоороо аз-жаргалыг[135] мэдрэх ба үүнийг Гэгээнтнүүд[136] "Төв-оршихуйд, дүүрэн-анхааралтай, аз-жаргалд умбав" хэмээн нэрийдэх буюу ингэж гуравдугаар даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байх бөгөөд, харин яг тэр үед л өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд хүрдэг.' гэж хэлдэг.

---

[129] *Samādhijaṁ*—"самади-төвлөрлөөс үүссэн". *Samādhi*—Даяан, ариуслын-замнал, төвлөрлийн бясалгалаас үүдэн, мөн таван-саад-ыг давах үед оюун санаа нь бясалгалын гүн төвлөрөлд орохуй, сатааралтгүй болохуй; оюуны-нэгдэл-д орохуй; сэтгэл санаа нэн тогтох байдал; бясалгалын ахисан төлөв.. DN 2.4.10-15-д дэлгэрүүлж үз.

[130] *Sampasādana*—"дотоод амар-амгалан". Бясалгалаас (II даянаас) сэттэлийн дотор үүсэх, гэрэл гэгээтэй, итгэл үнэмшил бүхий амар амгалан байдал. DN 2.4.10-15-д дэлгэрүүлж үз.

[131] *Ekodibhāvaṁ*—"оюуны-нэгдэл" (па. *ekaggatā*, сам. *ekāgratā*, анг. *one-pointedness* эсвэл *unification of mind)*. Оюун санаа өөр юунд ч эс сатаарсан, юунд ч эс анхаарсан, оюун санаа дангаараа өөрөө нэгэн нэгдэл зүйл болсон (нэг зүйлд төвлөрсөн), нэн амгалан байдал. DN 2.4.11-14-д дэлгэрүүлж үз.

[132] *Sati*—"дүүрэн-анхаарал" (анг. *mindfulness*). Ариуслын-замналын үндсэн хэсэг болох сахил-ухамсар, самади-төвлөрөл, саруул-ухаанаар анхаарлаа дүүрэн байлгахуй, эдгээрийг ямагт санаж байхуй, эс умартахуй. Судартгол төлөв "тунгалаг-оюун"-тай хоршуулан хэрэглэсэн байна. Дэлгэрэнгүйг DN 2.4.8; DN 22.4.9; Лавлахад үз.

[133] *Sampajāno*—"тунгалаг-оюун" (анг. *clear comprehension*). Аливааг бүрэн сэрэмжтэйгээр, саруул-ухаанаар, саруул тунгалгаар харах. Дэлгэрэнгүйг DN 2.4.8-15; Лавлахад үз.

[134] *Upekkhako*—"төв-оршихуйг". *Upekkha*—"төв-оршихуй". Мэдрэмж бол: 1. таатай, 2. таагүй, 3. төв-оршихуй гэсэн гурван л төлөвтэй ба төв-оршихуй нь таатай ч биш, таагүй ч биш мэдрэмж, байдал юм. Өөрөөр "төлөвгүй төлөв", "төв сэтгэл". Дэлгэрэнгүйг DN 2.4.10-15; Лавлахад үз.

[135] *Sukha*—"аз-жаргал". I-III даянд үүсэх, нэн жаргалантай байдал. Хөөр-баяр-аас хавьгүй хүчтэй мэдрэмж. Сахилыг дээд зэргээр оршоох, таван-саад-ыг давах, самади-төвлөрөл-д орох үед мэдрэгдэх хосгүй аз жаргал. DN 2.4.10-15; Лавлахад дэлгэрүүлж үз.

[136] *Ariyā*—"Гэгээнтнүүд". Гэгээрлийг олсон, ариуссан хүмүүс. (Тайлбарт дэлгэрэнгүй үз.)

Ийм маягаар хуврагууд аа, одоо байгаа амьд биет нь энэ насандаа төгс Нирвааныг үздэг гэж зарлан тунхагладаг.

Өөр нэг нь түүнд бас ингэж хэлнэ:

‘Эрхэм ноёнтон минь, таны хэлсэн шиг тийм өөрийн-оршихуй байдаг. Түүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд тэгж хүрдэггүй юм.

Яагаад тийм гэж үү?

Яагаад гэвэл, эрхэм ноёнтон минь, тэр даянд чинь жаргал болон сэтгэлийн цэнгэл байгаад байна. Тийм болохоор, энэ нь болхи гэж тооцогддог юм. Гэвч, хэрэв энэхүү өөрийн-оршихуй нь жаргалаас салж-ангижирснаар, зовлонгоос салж-ангижирснаар, урьдын таатай хийгээд таагүй байдал алга болсноор, жаргал зовлонгийн аль нь ч бус, төв-оршихуйгаас үүссэн дүүрэн-анхаарлын ариусал, дөрөвдүгээр даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байх бөгөөд, харин яг тэр үед л өөрийн-оршихуй нь энэ насны төгс Нирваанд хүрдэг.’ гэж хэлдэг.

Ийм маягаар хуврагууд аа, одоо байгаа амьд биетийн энэ насны төгс Нирваан хэмээн зарлан тунхагладаг.

Эдгээр нь, хуврагууд аа, одоо байгаа амьд биетийн энэ насны төгс Нирваан хэмээн зарлан тунхагладаг, энэ насны Нирваан хэмээх үзэлтэн, зарим даянч болон бярман нарын таван үндэслэл нь юм.

Хуврагууд аа, одоо байгаа амьд биетийн энэ насны төгс Нирваан хэмээн зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд л ямар нэг өөр үндэслэлийг биш энэ таван үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь л гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирвааныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, энгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

Эдгээр нь хуврагууд аа, ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, ирээдүйг таамаглагч, ирээдүйн талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нарын дөчин дөрвөн үндэслэл юм.

Хуврагууд аа, ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай, тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш, эдгээр дөчин дөрвөн үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирвааныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

Энэ бүгд бол хуврагууд аа, өнгөрсөн болон ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, өнгөрсөн болон ирээдүйн талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нарын жаран хоёр үндэслэл юм.

Хуврагууд аа, өнгөрсөн болон ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, ямар ч даянч хийгээд бярман бай тэд бүгд ямар нэг өөр үндэслэлийг биш, эдгээр жаран хоёр үндэслэлийг, эсвэл аль нэгийг нь гаргаж тавьдаг билээ. Эдгээрээс өөр хувилбар байдаггүй.

Хэрэв, хуврагууд аа, эдгээр үзлийг барьж авсан хийгээд эдгээртээ автаж, уягдсан бол энэ үзэлд баригдаж, хүлэгдсэн тэр хүмүүний дараа төрлийн очих газрыг Будда мэддэг билээ.

Будда үүнийг ойлгож мэдсэн төдийгүй, үүнээс хальсныг ч мөн ойлгож мэдсэн юм. Гэвч тэр ойлгож мэдсэн зүйлтэйгээ барьж зууралдаагүй бөгөөд барьж зууралдаагүй хүн л Нирвааныг өөр дээрээ ухаардаг билээ.

Мэдрэмжүүдийн учир шалтгааныг, тэдгээрийн алга болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ойлгож мэдсэнээр, Будда шунаж зууралдалгүйгээр ангижралыг олсон билээ.

Хуврагууд аа, эдгээр нь мөнөөх гүн гүнзгий, олж харахад хэцүү, ойлгоход бэрх, амгалан тайван бөгөөд агуу сүрлэг, эгэл ухаанаас хальсан, ихэд нарийн, зөвхөн хурц ухаант хүмүүн ухаарч чадах, Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсан, тэдгээр Зүйлс билээ. Эдгээрийг Будда өөрийн шууд-билгүүнээр ухаарсныхаа дараа бусдад дэлгэж заасан билээ. Буддаг үнэн бодитоор үнэлэн сайшаах хүмүүс, эдгээр Зүйлсийг л чухам зөвөөр нь ярих учиртай.

5. Өөрийн-Оршихуйн Нийтлэг Ойлголтын Үндэс (Attālokapaññattivatthu)

5.1. Сандрал Үймрэл (Paritassitavipphanditavāra)

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарлан тунхагладаг, мөнх үзэлтэн, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд[137] нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, заримдаг мөнх үзэлтэн, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, хязгаартай ба хязгааргүйн үзэлтэн, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, энэ тэр зүйлсийн талаар асуухад, тэд дөрвөн үндэслэл дээр, бултсан мэдэгдэл хэлж, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулдаг, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, хоёр үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн гэж зарлан тунхагладаг, шалтгаангүй үүслийн онолч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

---

[137] *Taṇhāgatānaṁ*—"хүсэл-цангаанд автсан". *Taṇhā*—"хүсэл-цангаа". Үүнд: 1. мэдрэхүйн хүсэл-цангаа (*kāma-taṇhā*) буюу таван мэдрэхүйгээр мэдэрч болох зүйлийн хүсэл; 2. оршихуйн хүсэл-цангаа (*bhava-taṇhā*) буюу оршин байх, эсвэл ямар нэг төрөл авах, эсвэл хэн нэгэн болох хүсэл; 3. эс оршихуйн хүсэл-цангаа (*vibhava-taṇhā*) буюу дахин төрөл авахгүй байх эсвэл оршихгүй байх хүсэл.

Хуврагууд аа, арван найман үндэслэлээр, өнгөрсний талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, өнгөрсний талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, арван зургаан үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий амьдралын онолч, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, найман үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-үгүй байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-үгүй амьдралын онолч, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, найман үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус байдлаар амьдарсаар байх болно хэмээн зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус амьдралын онолч, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, долоон үндэслэл дээр, үхлийн дараа, одоо байгаа амьд биет нь мөхөж, сөнөж, алга болдог гэж зарлан тунхагладаг, мөхлийн үзэлтэн, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, таван үндэслэл дээр, одоо байгаа амьд биетийн энэ насны төгс Нирваан хэмээн зарлан тунхагладаг, энэ насны Нирваан хэмээх үзэлтэн, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, дөчин дөрвөн үндэслэл дээр, ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, ирээдүйг таамаглагч, ирээдүйн талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

Хуврагууд аа, жаран хоёр үндэслэл дээр, өнгөрсөн болон ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, өнгөрсөн болон ирээдүйн талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, тэдгээр ухаарахгүй байгаа, харахгүй байгаа хүмүүсийн, хүсэл-цангаанд нэгэнт автсан, ердөө л сандрал үймрэлээс нь үүссэн мэдрэмж юм.

5.2. Мэдрэхүйн-Харилцааны Нөлөөлөл (Phassapaccayavāra)

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж зарлан тунхагладаг, мөнх үзэлтэн, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны[138] нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж зарлан тунхагладаг, заримдаг мөнх үзэлтэн, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, дөрвөн үндэслэл дээр, хорвоо ертөнцийг хязгаартай эсвэл хязгааргүй хэмээн зарлан тунхагладаг, хязгаартай ба хязгааргүйн үзэлтэн, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, энэ тэр зүйлсийн талаар асуухад, тэд дөрвөн үндэслэл дээр, бултсан мэдэгдэл хэлж, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулдаг, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, хоёр үндэслэл дээр, өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг шалтгаангүйгээр үүссэн гэж зарлан тунхагладаг, шалтгаангүй үүслийн онолч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, арван найман үндэслэлээр, өнгөрсний талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, өнгөрсний талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, арван зургаан үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий амьдралын онолч, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

---

[138] *Phassa*—“мэдрэхүйн-харилцаа”. Мэдрэхүйн үйл явц гэж нэрлэж болох мэдрэхүйн-харилцаа гэдэг нь: нэгд, мэдрэхүйд тусах зүйл (1. үзэгдэл; 2. чимээ; 3. үнэр; 4. амт; 5. хүрэлцэл; 6. төсөөлөл), хоёрт оюун-ухамсар (1. нүдний-ухамсар; 2. чихний-ухамсар; 3. хамрын-ухамсар; 4. хэлний-ухамсар; 5. биеийн-ухамсар; 6. оюуны-ухааны-ухамсар), гуравт мэдрэхүйн-хүрээ, энэ гурав уулзах агшин юм.

Хуврагууд аа, найман үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-үгүй байдлаар амьдарсаар байх болно гэж зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-үгүй амьдралын онолч, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, найман үндэслэл дээр, үхлийн дараа өөрийн-оршихуй нь танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус байдлаар амьдарсаар байх болно хэмээн зарлан тунхагладаг, үхлийн дараах танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус амьдралын онолч, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, долоон үндэслэл дээр, үхлийн дараа, одоо байгаа амьд биет нь мөхөж, сөнөж, алга болдог гэж зарлан тунхагладаг, мөхлийн үзэлтэн, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, таван үндэслэл дээр, одоо байгаа амьд биетийн энэ насны төгс Нирваан хэмээн зарлан тунхагладаг, энэ насны Нирваан хэмээх үзэлтэн, зарим даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, дөчин дөрвөн үндэслэл дээр, ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, ирээдүйг таамаглагч, ирээдүйн талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

Хуврагууд аа, жаран хоёр үндэслэл дээр, өнгөрсөн болон ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, онолыг зарлан тунхагладаг, өнгөрсөн болон ирээдүйн талаар үзэл баримтлагч, даянч болон бярман нар байгаа энэ явдал нь, мэдрэхүйн-харилцааны нөлөөллөөр бий болсон байдаг. Тэд мэдрэхүйн-харилцаагүйгээр энэхүү мэдрэмжийг мэдэрчихдэг тийм тохиолдол гэж байх боломжгүй юм.

5.3. Оршихуйд Уягдах Шалтгаан Болдог Үзлийн Тухай (Diṭṭhigatikādhiṭṭhānavaṭṭakathā)

Ийм болохоор хуврагууд аа, дөрвөн үндэслэлээр өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх гэж тайлбарлаж буй, дөрвөн үндэслэлээр өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаар мөнх, зарим талаар мөнх бус гэж тайлбарлаж буй, дөрвөн үндэслэлээр хорвоо ертөнцийг хязгаартай хийгээд хязгааргүй гэж тайлбарлаж буй, энэ тэр зүйлсийн талаар асуухад тэд дөрвөн үндэслэлээр бултсан мэдэгдэл хэлж, эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулж буй, хоёр үндэслэлээр өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг санамсаргүй, шалтгаангүй үүссэн гэж тайлбарлаж буй, арван найман үндэслэлээр өнгөрсний талаар янз бүрээр тайлбарлаж буй, арван зургаан үндэслэлээр үхлийн дараах амьдралын хувьд

өөрийн-оршихуй нь танихуй-бүхий байдаг мөнх үзлийг тайлбарлаж буй, найман үндэслэлээр үхлийн дараах амьдралын хувьд өөрийн-оршихуй нь танихуй-үгүй байдаг мөнх үзлийг тайлбарлаж буй, найман үндэслэлээр үхлийн дараах амьдралын хувьд өөрийн-оршихуй нь танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус мөнх үзлийг тайлбарлаж буй, долоон үндэслэлээр үхлийн дараа, одоо байгаа амьд биет нь мөхөж, сөнөж, алга болдог үзлийг тайлбарлаж буй, таван үндэслэлээр одоо байгаа амьд биетийн энэ насны төгс Нирваан хэмээх онол дэвшүүлж буй, дөчин дөрвөн үндэслэлээр ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, үзлийг тайлбарлаж буй, жаран хоёр үндэслэлээр өнгөрсөн болон ирээдүйн талаар төрөл бүрийн таамаглал, үзлийг тайлбарлаж буй, тэдгээр бүх даянч болон бярман нар, ердөө л зургаан мэдрэхүйн-харилцааны хүрээгээр[139] давтан давтан холбогдсоны улмаас үүнийг мэдэрч буй хэрэг юм.

Тэдний мэдрэмжээс шалтгаалан хүсэл-цангаа[140], хүсэл-цангаанаас шалтгаалан дон-шунал, дон-шуналаас шалтгаалан оршихуй[141], оршихуйгаас шалтгаалан төрөхүй[142], төрөхүйгээс шалтгаалан өтлөхүй хийгээд үхэхүй, харуусал, гашуудал, зовуурь, шаналал, цөхрөл урган гардаг билээ.

5.4. Уяанаас Суллагдахуй (Vivaṭṭakathādi)

Хуврагууд аа, хувраг хүн, тэрхүү зургаан мэдрэхүйн-харилцааны хүрээний үүсэл гарлыг, тэдгээрийн үгүй болохуйг, тэдгээрийн таатай байдлыг, тэдгээрийн үр-дагаврыг, тэдгээрээс холдон салахуйг чухам үнэнээр нь ухаарч ойлгосон тэр л үедээ, тэр хүмүүн тэдгээр бүх л үзэл баримтлалаас хальж, давж ухаарлыг олох болно.

Өнгөрсний талаар эсвэл ирээдүйн талаар, эсвэл аль алиных нь талаар таамаглал дэвшүүлдэг, ямар ч даянч болон бярман бай, өнгөрсөн хийгээд ирээдүйн тал дээр хөдөлшгүй үзэл баримтлалтай, энэ талаар ямар ч үзэл онол тайлбарладаг хэн ч бай, тэдгээр бүх хүмүүс эдгээр жаран хоёр салаа уяа урхинд баригдаж, хаашаа ч гарах гэж оролдсон бай тэрхүү урхи торны аль нэг хэсэгт нь эргэн орооцолдож, тэрхүү урхи торон дотроо үлддэг билээ.

---

139 *Phassāyatana*—“мэдрэхүйн-харилцааны хүрээ”. Мэдрэхүйн-харилцаа явагдах хүрээ, талбар, суурь, орон. Үүнд: 1. нүдний 2. чихний 3. хамрын 4. хэлний 5. биеийн 6. оюун-ухааны 6 хүрээ хамаарна. Зарим тохиолдолд сударт *āyatana* (мэдрэхүйн-хүрээ)-г, мэдрэхүйн-харилцаа (*phassa*) үүсэх нөхцөл болох талаас нь авч үзэхдээ *phassāyatana* (мэдрэхүйн-харилцааны хүрээ) хэмээн нэрлэх нь бий.

140 *Taṇhā*—“хүсэл-цангаа”. Үүнд: 1. мэдрэхүйн хүсэл-цангаа (*kāma-taṇhā*) буюу таван мэдрэхүйгээр мэдэрч болох зүйлийн хүсэл; 2. оршихуйн хүсэл-цангаа (*bhava-taṇhā*) буюу оршин байх, эсвэл ямар нэг төрөл авах, эсвэл хэн нэгэн болох хүсэл; 3. эс оршихуйн хүсэл-цангаа (*vibhava-taṇhā*) буюу дахин төрөл авахгүй байх эсвэл оршихгүй байх хүсэл.

141 *Bhava*—“оршихуй”. Ерөнхий утга “оршин байхуй” эсвэл “хэн нэгэн болохуй”. Нэг төрөлд үхээд дахин төрөл авч амьдрал үргэлжлэхүй буюу оршин байхуй. Энэ төрөлдөө, эсвэл дараа төрөлдөө хэн нэгэн болохуй. Дон-шуналаас оршихуй үүсэхийг DN 15-д дэлгэрэнгүй үз.

142 *Jāti*—“төрөхүй” (анг. *birth* эсвэл *rebirth*). Энэ хорвоод, ямар нэгэн төрөлд төрөх, мэндлэх буюу “дахин төрөх” (Энэ хорвоод төрж буй бүхэн ямар нэг төрөлд үхсэнээр, өөр нэг төрөлд дахин төрж буй тул). Номын өөр хэсэгт, “дахин төрөх, төрлийг олох” г.м. байдлаар оруулав. Мөн DN 15.1; DN 22.4.6; Тайлбарт нэмж үз.

Нэгэн хашир туршлагатай загасчин байг гэж бодъё. Эсвэл туршлагагүй, шинэхэн загасчин байг гэж бодъё. Жижигхэн цөөрмийн усанд тун нарийн сүлжиж хийсэн тороо хаяад: 'Энэ усанд ямар ч хэмжээтэй амьтан байгаа бай, бүгд энэ торонд минь орж, энэ торноос минь гарахгүй баригдах нь лавтай.' хэмээн бодож болох юм.

Яг үүний адилаар, тэдгээр даянч болон брман нар жаран хоёр салаа, ийм урхи торонд орсон юм. Тэд хаашаа ч гарах гэж оролдсон бай, тэрхүү урхи торны аль нэг хэсэгт нь эргэн орооцолдож, тэрхүү урхи торон дотроо үлддэг билээ.

Хуврагууд аа, Буддагийн бие махбод оршиж байгаа хэдий ч, түүний оршихуйн хүлээс нэгэнт тасарсан[143] билээ. Бие цогцос нь амьд байгаа энэ цагт бурхад хийгээд хүмүүс түүнийг харж болох юм. Гэвч, тэр өөд болж, бие цогцос нь задрах цагт бурхад хийгээд хүмүүс түүнийг дахин харахгүй юм.

Хуврагууд аа, яг л, мөчир дүүрэн манго жимсийг таслан авахад, энэ иш мөчиртэй холбогдсон бүх манго жимс хамт ханаран унадаг.

Яг л үүний нэгэн адил, Буддагийн бие махбод оршиж байгаа хэдий ч, түүний оршихуйн хүлээс нэгэнт тасарсан билээ. Бие цогцос нь амьд байгаа энэ цагт бурхад хийгээд хүмүүс түүнийг харж болох юм. Гэвч, тэр өөд болж, бие цогцос нь задрах цагт бурхад хийгээд хүмүүс түүнийг дахин харахгүй юм."

Ийнхүү түүнийг ярьж дуусахад Эрхэм Аананда Буддад хандан:

"Гайхамшигтай, Эрхэм Багш аа, үнэхээр гайхалтай! Эрхэм Багш аа, энэ айлдвар сургаалыг юу гэж нэрлэх бол?" хэмээн асуув.

"Аананда, энэ сургаалыг 'Утга Санааны Урхи Тор[144]' ч гэж, 'Юмс Үзэгдлийн[145] Урхи Тор' ч гэж, 'Бярман Тэнгэрийн Урхи Тор' ч гэж, 'Үзэл Бодлын Урхи Тор' ч гэж санаж магадгүй юм. Эсвэл бүр үүнийг 'Тулааны Эгнэшгүй Ялалт' ч гэж санаж болох юм." хэмээн Будда хариулав.

Будда ийн айлдав.

Сэтгэл өндөр болсон хуврагууд Буддагийн айлдварт догдлон баярлав. Будда энэхүү сургаалаа айлдах тэр үед арван мянган[146] дэлхий ертөнц[147] чичрэн доргив.

Бярман Тэнгэрийн Урхи Судар энд өндөрлөв.

---

143 *Ucchinnabhavanettiko*—"оршихуйн хүлээс нэгэнт тасрах". "Оршихуй" (*bhava*)-г Лавлахад үз.

144 *Jāla*—"Урхи Тор". Өөрөөр, "Урхи", "Тор". Энэ нь загасчны сүлжмэл тор боловч "тор" дангаараа судрын "тэдгээрт тээглэж, орооцолдож, урхидуулсан" утгыг гүйцэд гаргахгүй байна гэж үзсэн тул "урхи" санааг нэмж оруулсан болно.

145 *Dhamma*—"Юмс Үзэгдлийн". Өөрөөр, "Сургаалын", "Үнэний", "Жам Ёсны". (Тайлбарт буй Сургаал хэсэгт дэлгэрэнгүй үз.)

146 *Dasasahassī*—"арван мянган". Эсвэл "олон мянган".

147 *Lokadhātu*—"дэлхий ертөнц". Зарим орчуулгад, "гаригийн тогтолцоо" (анг. *world system*. BB); "галактик" (анг. *galaxy*. BS).

ДАЯАНЧ ЗАМНАЛЫН ҮР ӨГӨӨЖ СУДАР
DN 2. SĀMAÑÑAPHALASUTTA

1. Сайд Нарын Мэдэгдэл (Rājāmaccakathā)

БИ ИЙН СОНССОН ЮМ.

Нэгэн удаа Будда нэг мянга хоёр зуун тавин хуврагийн хамтаар, Раажагахагийн ойролцоох Жийвака Комаарабхаччагийн[148] манго төгөлд[149] амьдарч байжээ. Дөрөв дэх сарын уламжлалт упосатха[150] өдөр буюу комудий[151] тэргэл сартай тэр шөнө, Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту[152] ордныхоо дээд давхрын индэр тавцан дээр сайд нараараа хүрээлүүлэн сууж байв.

Тэнд хаан дараах үгийг хөөр баяртайгаар хэлж байна.

"Эрхэм нөхөд өө, эгэлгүй сайхан гэж энэ сартай шөнийг л хэлнэ! Гоо үзэсгэлэн гэж энэ сартай шөнийг л хэлнэ! Дур булаам гэж энэ сартай шөнийг л хэлнэ! Амар амгалан байдал гэж энэ сартай шөнийг л хэлнэ! Аз завшаантай гэвэл, энэ сартай шөнийг л хэлнэ! Энэ үдэш бид очиж бараалхвал, миний дотор амар амгаланг гийгүүлж чадах хэн нэгэн даянч эсвэл бярман лам байгаа болов уу?"

Тэгтэл, түүний сайд нарын нэг нь:

"Эрхэм дээдэс ээ, шашны урсгал үндэслэгч, энэ урсгалынхаа тэргүүн нь, энэ урсгалынхаа удирдагч нь, энэ урсгалынхаа багш нь, алдар нэртэй, тахин шүтэгдсэн, нийтээрээ түүнийг гэгээнтэн гэж үздэг, ихийг үзэж туулсан, насаараа лам байсан, туршлага хураасан, одоо өтөл насандаа очсон Пуурана Кассапа[153] гэж байдаг. Эрхэм дээдэс минь, та түүнтэй л уулзах хэрэгтэй болов уу. Магадгүй тэр таны сэтгэлд амар амгаланг авчирч болох юм."

Гэвч үүнийг хэлэхэд Ажаатасатту хаан чимээгүй суусаар байлаа.

Тэгвэл өөр нэгэн сайд нь:

---

148 *Jīvakassa komārabhaccassa*—"Жийвака Комаарабхачча". Буддагийн шавь асан, Будда болон Бимбисаара (*Bimbisāra*) хааны эмч нь байсан гэх Жийвака Комаарабхаччаг Бимбисаара хааны хүү Абхаяа (*Abhaya*) бээр нярай, өнчин байхад нь олж тэжээсэн гэдэг (DA).

149 *Ambavane*—"манго төгөлд". Тухайн цагт Будда болон хуврагуудын суудаг газар нь хот тосгон бус, харин ширэнгэн ой, бут төгөл дунд байрладаг байж. Цөөнгүй манго төгөл Паали Судрт гарна.

150 *Uposatha*—"упосатха". Упосатха бол шинийн нэгний, шинийн арван тавны, шинийн наймны, улирах наймны сартай өдрүүдэд тохиох, хийдийн бүх хувраг цуглан бие, хэл, сэтгэлийн ариун бус үйлдэл гаргасан бол түүнийгээ наманчилдаг, хуврагийн 227 ариун сахилаа (*Patimokkha*) нийтээрээ уншдаг, хуралдан чуулдаг хуваарьт өдөр.

151 *Komudī*—"комудий". Комудий бол борооны улирлын сүүлийн сард (па. *kattikā*—X сард) тохиох бүтэн сар.

152 *Ajātasattu*—"Ажаатасатту". Үгийн утга: "төрөөгүй дайсан". Ажаатасатту бол Бимбисаара хааны хүү, Магадха (*Magadha*) улсын Харьянка (*Haryaṅka*) эзэнт гүрний угсаа залгамжлагч хаан.

153 *Pūraṇa Kassapa*—"Пуурана Кассапа". *Akiriyavāda* (анг. *amoralism*) буюу ёс суртахуунт үйлдэл, үрийн үрийг үгүйсгэсэн онолыг заасан, бярман давхаргаас гаралтай багш.

“Эрхэм дээдэс ээ, шашны урсгал үндэслэгч, энэ урсгалынхаа тэргүүн нь, энэ урсгалынхаа удирдагч нь, энэ урсгалынхаа багш нь, алдар нэртэй, тахин шүтэгдсэн, нийтээрээ түүнийг гэгээнтэн гэж үздэг, ихийг үзэж туулсан, насаараа лам байсан, туршлага хураасан, одоо өтөл насандаа очсон Маккхали Госаала[154] гэж байдаг. Эрхэм дээдэс минь, та түүнтэй л уулзах хэрэгтэй болов уу. Магадгүй тэр таны сэтгэлд амар амгаланг авчирч болох юм.”

Гэвч үүнийг хэлэхэд Ажаатасатту хаан чимээгүй суусаар байлаа.

Тэгтэл бас өөр нэг сайд нь:

“Эрхэм дээдэс ээ, шашны урсгал үндэслэгч, энэ урсгалынхаа тэргүүн нь, энэ урсгалынхаа удирдагч нь, энэ урсгалынхаа багш нь, алдар нэртэй, тахин шүтэгдсэн, нийтээрээ түүнийг гэгээнтэн гэж үздэг, ихийг үзэж туулсан, насаараа лам байсан, туршлага хураасан, одоо өтөл насандаа очсон Ажита Кесакамбала[155] гэж байдаг. Эрхэм дээдэс минь, та түүнтэй л уулзах хэрэгтэй болов уу. Магадгүй тэр таны сэтгэлд амар амгаланг авчирч болох юм.”

Гэвч үүнийг хэлэхэд Ажаатасатту хаан чимээгүй суусаар байлаа.

Бас нэг сайд нь:

“Эрхэм дээдэс ээ, шашны урсгал үндэслэгч, энэ урсгалынхаа тэргүүн нь, энэ урсгалынхаа удирдагч нь, энэ урсгалынхаа багш нь, алдар нэртэй, тахин шүтэгдсэн, нийтээрээ түүнийг гэгээнтэн гэж үздэг, ихийг үзэж туулсан, насаараа лам байсан, туршлага хураасан, одоо өтөл насандаа очсон Пакудха Каччааяана[156] гэж байдаг. Эрхэм дээдэс минь, та түүнтэй л уулзах хэрэгтэй болов уу. Магадгүй тэр таны сэтгэлд амар амгаланг авчирч болох юм.”

Гэвч үүнийг хэлэхэд Ажаатасатту хаан чимээгүй суусаар байлаа.

Ингээд өөр нэгэн сайд нь:

“Эрхэм дээдэс ээ, шашны урсгал үндэслэгч, энэ урсгалынхаа тэргүүн нь, энэ урсгалынхаа удирдагч нь, энэ урсгалынхаа багш нь, алдар нэртэй, тахин шүтэгдсэн, нийтээрээ түүнийг гэгээнтэн гэж үздэг, ихийг үзэж туулсан, насаараа лам байсан, туршлага хураасан, одоо өтөл насандаа очсон Нигантха Наатапутта[157]

---

[154] *Makkhali Gosāla*—“Маккхали Госаала”. Аажийвака (па. *ājīvaka,* анг. *fatalism* эсвэл *determinism*) шашны урсгалын үүсгэгч, удирдагч, *Niyativāda* буюу “хувь төөрөгт захирагдах” номлолыг сургадаг, даяанч, багш.

[155] *Ajita Kesakambala*—“Ажита Кесакамбала”. *Kesakambala* үгийн утга: хүний үсээр хийсэн нөмрөг. Өөрийгөө хэт тарчлаах даянчлалаар замнасан тэрээр өмхий үнэртэй, хүний үсэн нөмрөг нөмөрч явдаг байж. *Ucchedavāda* (анг. *annihilationism*) буюу материалист үзлийг номлогч, үйлийн үр, хойд нас, дараа төрлийг үгүйсгэгч, даяанч номлогч.

[156] *Pakudha Kaccāyana*—“Пакудха Каччааяана”. Долоон махбодын онол (анг. *atomism*)-ыг номлогч, бодит байдал нь эс хувирах долоон элементээс бүрддэг, эдгээр нь харилцан үйлчлэлцдэггүй тул аливааг алах, эвдлэх боломжгүй гэх үзлийг заадаг, бярман гаралтай багш.

[157] *Nigaṇṭha Nātaputta*—“Нигантха Наатапутта”. Үгчилбэл, “Наатикагийн хүү, нүцгэн даянч”. Наатика овгоос гаралтай, Жайн шашны удирдагч, номлогч, нүцгэн даянч. Тэрээр өөрийгөө зовоох аргаар (*attakilamatha*) урьдын үйлийн үрийг устгах боломжтой гэж номлодог багш.

гэж байдаг. Эрхэм дээдэс минь, та түүнтэй л уулзах хэрэгтэй болов уу. Магадгүй тэр таны сэтгэлд амар амгаланг авчирч болох юм.”

Гэвч үүнийг хэлэхэд Ажаатасатту хаан чимээгүй суусаар байлаа.

Тэгтэл, дахиад нэг сайд нь:

“Эрхэм дээдэс ээ, шашны урсгал үндэслэгч, энэ урсгалынхаа тэргүүн нь, энэ урсгалынхаа удирдагч нь, энэ урсгалынхаа багш нь, алдар нэртэй, тахин шүтэгдсэн, нийтээрээ түүнийг гэгээнтэн гэж үздэг, ихийг үзэж туулсан, насаараа лам байсан, туршлага хураасан, одоо өтөл насандаа очсон Санжаяа Белаттхипутта[158] гэж байдаг. Эрхэм дээдэс минь, та түүнтэй л уулзах хэрэгтэй болов уу. Магадгүй тэр таны сэтгэлд амар амгаланг авчирч болох юм.”

Гэвч үүнийг хэлэхэд Ажаатасатту хаан чимээгүй суусаар байлаа.

2. Жийвака Комаарабхаччагийн Өчил (Komārabhaccajīvakakathā)

Энэ бүх хугацаанд Жийвака Комаарабхачча, хаан Ажаатасаттугаас холгүйхэн, чимээ аниргүй сууж байлаа. Тэгтэл хаан түүнд хандан:

“Жийвака анд минь, чи яагаад дуугүй сууна вэ?” гэхэд, Жийвака өгүүлрүүн:

“Эрхэм дээдэс ээ, Ерөөлтэй Нэгэн[159], Төгс Гэгээрсэн Нэгэн[160], Төгс Сэрсэн Будда, нэг мянга хоёр зуун тавин хуврагийн хамтаар миний манго төгөлд амьдарч байгаа билээ. Түүний тухай таатай сайн мэдээ: ‘Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда, саруул ухаан хийгээд сахил ёсыг оршоосон, Зөвөөр Одогч, Хорвоог Ухаарагч, Эгнэшгүй Нэгэн, Ухаарах Учиртайг Ухааруулах Сургагч, Бурхад Хийгээд Хүмүүсийн Багш, Сэрсэн Нэгэн, Ерөөлтэй Нэгэн, энэхүү Тийн Одогч энэ хорвоод төржээ.’ хэмээн[161] хүмүүс хоорондоо ярьж байна. Эрхэм дээдэс ээ, Та тэрхүү Ерөөлтэй Нэгэнд бараалхан очих хэрэгтэй болов уу. Магадгүй, түүн дээр та очвол тэр л таны сэтгэлд амар амгаланг гийгүүлж болох юм.”

“Тэгвэл миний заан хөсгийг бэлдээрэй, анд Жийвака минь.” гэв.

---

[158] *Sañjaya Belaṭṭhiputta*—“Санжаяа Белаттхипутта”. Эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч (па. *amarāvikkhepika*) буюу *Ajñāna* (анг. *agnosticism* эсвэл *skepticism*) номлолыг баримтлагч.

[159] *Bhagavā*—“Ерөөлтэй Нэгэн”. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн, дээд ухамсрыг олсон, хосгүй ухааныг цогцлоосон ховорхон учрал ерөөлийг олсон нэгэн тул Будда нарыг ийн нэрийднэ.

[160] *Arahaṁ*—“Төгс Гэгээрсэн Нэгэн”. Төгс Гэгээрлийг олсон нэгэн. Арахант (*arahant*. сам. *arhat*). Гэгээрлийн дөрвөн зэргийн дээд зэрэг. Арахант нар бол Будда биш боловч Гэгээрлийн түвшнийхээ хувьд Буддатай дүйхүйц зэрэг. Харин Будда нар бол бүгд Арахант буюу Төгс Гэгээрсэн Нэгэн юм. Энэ утгаараа Готама Будда бол Будда бөгөөд мөн Арахант юм. Будда нар тун ховор буюу тэрбум тэрбумаар тоологдох галавт ховорхон нэг төрдөг бол, харин Арахант гэдэг нь та бид энэ насандаа Сахил болон Сургаалыг дагаснаар, чухам өөрийн хичээл зүтгэлээр хүрч болох Гэгээрлийн дээд зэрэг.

[161] Эдгээр нэршлийн талаар Тайлбарт буй Будда-гаас үз.

"Тэгье ээ, Эрхэм дээдэс ээ!" гэж Жийвака хариулав. Дараа нь тэрээр таван зуун эм заан, мөн хааны өөрийн бух зааныг бэлтгээд, хаантанд: "Эрхэм дээдэс ээ, Таны заан хөсөг бэлэн боллоо. Та таалллаараа болгооно уу." гэв.

Ингээд Ажаатасатту хаан өөрийн таван зуун эмс хүүхнийг эм заан дээр нэг нэгээр нь суулгах ба өөрөө хувийн бух заандаа мордов. Тэрбээр, бамбар барьсан зарц боолуудынхаа хамтаар, бүхэл бүтэн хааны гэр бүл тэр аяараа, сүр жавхлантайгаар Раажагахагаас гарч, Жийвакагийн Манго Төглийн зүг хөдөлцгөөлөө.

Тэгтэл, хаан Ажаатасатту, манго төгөлөөс холгүйхэн явах зуур гэнэт айдас хүйдэст автаж, түүний хамаг биеийнх нь үс бослоо. Түгшин сандарч, айдас хүйдэст автсан тэрээр, Жийвакад хандан:

"Анд Жийвака, чи намайг хуурч байгаа юм биш биз? Анд Жийвака, чи надаас урвасан юм биш биз? Анд Жийвака, чи намайг дайснууд руу минь хөтөлж байгаа юм биш биз? Мянга хоёр зуун тавин хувраг, тийм олуулаа суугаа гэхэд энд найтаах, ханиах ч чимээ алга. Огтхон ч дуу шуугиангүй ийм байна гэж яахан байж болох билээ?" хэмээв.

"Бүү ай, агуу хаантан минь. Бүү сандар их хаантан минь. Эрхэм дээдэс ээ, Би таныг хуурч, танаас урваж, атаатан дайсан руу таныг хөтөлж байгаа хэрэг огтоос үгүй юм шүү. Урагшлаарай, агуу хаантан минь! Эгц урагш яваарай! Тэр алсад, тэдний хурал бясалгалын танхимд нь асаж байгаа гэрэл дэнлүү нь харагдаж байна шүү дээ." гэв.

3. Даянч Замналын Үр Өгөөжийн Тухай Асуулт (Sāmaññaphalapucchā)

Тэгээд Ажаатасатту хаан зааны хөлөөр хүрч чадах газар хүртэл яваад, улмаар бууж, явган явсаар ном бясалгалын танхимын үүдэнд дөхөж очлоо. Тэрээр Жийвакад ойртож ирээд, түүнээс: "Жийвака, ингэхэд нөгөө Ерөөлтэй Нэгэн хаана байна вэ?" гэхэд,

"Ерөөлтэй Нэгэн тэнд байна, хаантан минь. Тэнд байгаа дунд баганаас чанх зүүн талд, хувраугудын өөдөөс харан сууж байна." гэв.

Тэгэхэд нь Ажаатасатту хаан, Буддад ойртож очоод, түүний дэргэд нь зогслоо. Тэрбээр тэнд зогсоод, нам гүмхэн нуурын адил чимээ аниргүй сууж буй хувраугудын хүрээллийг ажиглан харах зуураа,

"Миний хүү Удааеибхадда[162] хунтайж, эдгээр хувраугудын хамтдаа оршоон буй ийм амар амгаланг мөн тэдэнтэй адил ийн эдлэн суух болтугай!" гэж бахдалтайгаар хэллээ.

"Ерөөлөөр болог хаантан минь! Та хайртай нэгнээ санаа юу даа?" гэхэд,

[162] *Udāyibhadda*—"Удааеибхадда". Ажаатасатту хааны хүү. Ажаатасатту хаан бээр өөрийн эцэг Бимбисаараг хөнөөж хаан ширээг нь авсны адил, Удааеибхадда бол мөн өөрийн эцэг Ажаатасаттуг егүүтгэж хаан ширээг авсан нэгэн юм (BS).

“Эрхэм Багш аа, би өөрийн хүү Удааеибхадда залуу ханхүүдээ хайртай. Тэр минь эдгээр хуврагуудын хамтдаа оршоон буй ийм амар амгаланг мөн тэдэнтэй адил ийн эдлэн суух болтугай!” гэв.

Ингээд Ажаатасатту хаан, Буддад хүндэтгэл үзүүлээд, мөн хуврагуудад мэхийн ёслоод, хажуу талд нь суугаад, Буддад хандан өгүүлрүүн:

“Эрхэм Багш аа, би танаас нэгэн зүйлийн талаар асуумаар байна. Миний асуултад хариулах цаг гаргах сан болов уу?”

“Их хаан та, юу хүссэнээ асууж болно.” гэв.

“Эрхэм багш минь, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч, нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даяанч болон бярман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяныг бүтээж байдаг хүмүүс билээ.

Хүндэт Багш аа, үүний нэгэн адил, даяанч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөж нь ер нь юу байдаг юм бэ?” гэж асуув.

“Их хаантан минь, та энэ асуултаа урьд нь өөр хэн нэгэн даяанч болон бярман нараас асууж байв уу?”

“Тийм ээ. Эрхэм ээ, би энэ асуултыг тэдэнд тавьж байсан билээ.”

“Их хаантан минь, танд хэрэв төвөгтэй биш бол, тэд үүнд хэрхэн хариулсныг нь надад хэлж болох сон болов уу?”

“Надад юун төвөг байх билээ. Би танд хэлэхгүй бол өөр хэнд хэлэх билээ. Эрхэм ээ.”

“За тэгвэл, их хаантан минь, надад түүнийгээ хэлэгтүн.” гэв.

3.1. Пуурана Кассапагийн Сургаал (Pūraṇakassapavāda)

“Эрхэм Багш аа, нэгэн удаа би, Пуурана Кассапатай уулзахаар очсон юм. Эелдэг найрсгаар бид мэнд ус мэдсэний дараа би түүний хажууд нь суугаад:

‘Хүндэт Кассапа минь, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч,

нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даянч болон брахман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяныг бүтээж байдаг хүмүүс билээ. Хүндэт багш аа, үүний нэгэн адил, даянч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөж нь ер нь юу байдаг юм бэ?' гэж асуусан билээ.

Үүнд, эрхэм Пуурана Кассапа ингэж хариулсан юм:

'Их хаантан минь, аливаа үйлийг өөрөө үйлдэх, эсвэл өрөөлөөр үйлдүүлэх, өөрөө цавчих, эсвэл өрөөлөөр цавчуулах, өөрөө тамлах, эсвэл өрөөлөөр тамлуулах, өөрөө зовоох, эсвэл өрөөлөөр зовоолгох, өөрөө үймээн дэгдээх, эсвэл өрөөлөөр үймээн дэгдээлгэх, өөрөө заналхийлэх, эсвэл өрөөлөөр заналхийлүүлгэх, өөрөө амь таслах, эсвэл өрөөлөөр амь таслуулах, өөрөө хулгайлах, эсвэл өрөөлөөр хулгайлуулах, өөрөө тонох, эсвэл өрөөлөөр тонуулах, өөрөө айл ухах, эсвэл өрөөлөөр ухуулах, өөрөө тосгон дээрэмдэх, эсвэл өрөөлөөр дээрэмдүүлэх, өөрөө завхайрах, эсвэл өрөөлийг завхайруулах, өөрөө худал ярих, эсвэл өрөөлөөр худал яриулах, эдгээрийн аль нь ч муу нүгэлд тооцогдохгүй. Хурц хутга шиг иртэй дугуйгаар, хурсан олныг дайрч алаад, энэ дэлхийн хүн амьтныг махан овоо болгож овоолоод, тоог нь багасгаж цөөрүүлсэн ч, тэр үйлдэл нүгэл хилэнцэд тооцогдохгүй. Ганга мөрний өмнө эрэгт амьдардаг хэн нэгэн, өөрөө алж хядаж, эсвэл өрөөлөөр алуулж хядуулж, өөрөө цавчиж, эсвэл өрөөлөөр цавчуулж, өөрөө тамлаж, эсвэл өрөөлөөр тамлуулж явсан ч, тэр хүний үйлдэл нүгэлд хилэнцэд тооцогдохгүй, тэр нүгэл хураахгүй. Ганга мөрний хойд эрэгт амьдардаг хэн нэгэн, өөрөө өргөл барьц өргөж, эсвэл өрөөлөөр өргөл барьц өргүүлж, өөрөө их буян хийж, эсвэл өрөөлөөр их буяныг хийлгүүлсэн ч, түүний үйлдэл буян болохгүй, тэр буяны үрийг хүртэхгүй. Сайн буяныг үйлдэж, хүсэл шуналаа дарж, сахил ёс суртахууныг дагаж, чин үнэнийг өгүүлэн явсан ч, тэр хүнд очих буян гэж байдаггүй юм. Буяны үрийг хүртэнэ гэж зүйл байдаггүй юм.'

Эрхэм Багш аа, ийнхүү Пуурана Кассапагаас би, даянч байхын, даянч замналын энэ насандаа хүртэж болох эрхэм үр өгөөжийн талаар асуухад, үйлийн үр гэж байдаггүй тухай, учир шалтгаан гэж байдаггүй тухай онолоо ухуулан надад тайлбарласан юм. Энэ нь яг л, би түүнээс манго модны тухай асуухад надад лабужа модны[163] тухай ярих мэт, эсвэл би түүнээс лабужа модны тухай асуухад надад манго модны тухай ярих мэт, Пуурана Кассапагаас даянч байхын, даянч замналын, энэ насандаа хүртэж болох, эрхэм үр өгөөжийн талаар асуухад, үйлийн үр гэж байдаггүй тухай, учир шалтгаан гэж байдаггүй тухай онолоо ухуулан надад тайлбарласан билээ.

Эрхэм Багш минь, энэ үед надад:

---

[163] *Labuja*—“лабужа мод” (лат. *artocarpus*; анг. *breadfruit*). Халуун орны бүсэд түгээмэл ургадаг, ялам модны бүлийн, цардуурлаг, жимсний мод.

'Над шиг хаан хүн, эзэмшил нутаг дээр нь амьдардаг эдгээр даянч, бярман нарыг ингэж зовоох хэрэг ч байна уу даа?' гэсэн бодол төрсөн юм.

Тиймээс би Пуурана Кассапагийн үгийг тийм гэж дэмжээгүй, мөн үгүй гэж няцаагаагүй юм. Түүний ярьсан зүйлд эвгүйцэх сэтгэл төрсөн ч түүнийгээ би илэрхийлж элдэв юм хэлээгүй билээ. Би түүний үзлийг хүлээн зөвшөөрөлгүй, түүний онолыг сайшаан дэмжилгүй тэнд хэсэг сууж байгаад түүнийг орхин явсан билээ.

3.2. Маккхали Госаалагийн Сургаал (Makkhaligosālavāda)

Эрхэм Багш аа, нэгэн удаа би, Маккхали Госаалатай уулзахаар очсон юм. Эелдэг найрсгаар бид мэнд ус мэдсэний дараа би түүний хажууд нь суугаад:

'Хүндэт Госаала минь, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч, нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даянч болон бярман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяныг бүтээж байдаг хүмүүс билээ. Хүндэт багш аа, үүний нэгэн адил, даянч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөж нь ер нь юу байдаг юм бэ?' гэж асуусан билээ.

Үүнд, эрхэм Маккхали Госаала ингэж хариулсан юм:

'Их хаантан минь, ямар нэг бодгалийг бузарлах[164] хүчтэй, ямар ч учир шалтгаан, үүсгүүр нөхцөл гэж байхгүй. Тийм гэх учир шалтгаан, үүсгэгч нөхцөлгүйгээр, тэд өөрөө л бузартчихдаг юм. Аливаа нэг бодгалийг, ариусгах[165] гэгээрүүлэх чадалтай учир шалтгаан, үүсгүүр нөхцөл ч гэж бас байдаггүй юм. Тийм гэх учир шалтгаан, үүсгэгч нөхцөлгүйгээр, өөрөө л ариусчихдаг юм. Хүний өөрийн үйлдсэн үйл, бусдын үйлдсэн үйл, хүний өөрийн эрч хүч, хүч чадал, мэрийлт чармайлт, хүний чадамж гэх зүйлс огт байдаггүй юм.

Бүхий л бодгаль, амьтай юм бүхэн, бүхий л амьтан, бүхий л сүнс, эдгээр нь эрч хүчгүй, хүч чадалгүй, мэрийлт чармайлтгүй бөгөөд бүх юм цаанаасаа, байгалиасаа тохиож, төөргөөрөө болж, өөрийнхөө

---

[164] *Saṅkilesāya*—"бузарлах". "сэтгэлийг бузарлах", "сэтгэлийг хиртүүлэх". ("Сэтгэлийн-хир"-ийг үз.)

[165] *Visuddhiyā*—"ариусгах". Муу сэтгэлийг үгүй болгох.

золоор өрнөж байдаг юм. Тэд, заяа төөргөө өөрөө удирдан жолоодох, эсэргүүцэх боломжгүйгээр үндсэн зургаан анги давхаргад төрөл авч, зовлон жаргалыг эдэлж байдаг юм.

Бодгалиудын төрөл авдаг оршихуйн нэг сая дөрвөн зуун мянган үндсэн төрөл, өөр бас зургаан мянга, өөр бас зургаан зуун хэлбэр гэж байдаг. Үйлийн үрийн таван зуун төрөл, үйлийн үрийн өөр бас таван зүйл, мөн бүтэн үйлийн үрийн, хагас үйлийн үрийн, үйлдлийн үрийн гэсэн, гурван төрөл үйлийн байдаг юм.

Жаран хоёр шашны урсгал, жаран хоёр галав, хүний зургаан анги давхарга, хүний хөгжлийн найман үе шат, дөрвөн мянга есөн зуун амьдралын хэлбэр, дөрөв мянга есөн зуун даянч төрөл, дөрвөн мянга есөн зуун луу могойн төрөл, хоёр мянган бурхны төрөл, гурван мянган тамын төрөл, гучин зургаан шороон төрөл, танихуй-бүхий оршихуйн долоон тойрог, танихуй-үгүй долоон тойрог, ангижирсан долоон, долоон өөр зиндаатай бурхдын, хүмүүсийн, чөтгөрийн төрлүүд, их нуурын долоон төрөл, хүйтэй их долоон төрөл, хүйтэй бага долоон зуун төрөл, долоон их, долоон жижиг хад асга, долоон их мөрөөдөл, долоон зуун жижиг мөрөөдөл гэж байдаг юм. Мөн тэнд байгаа найман сая дөрвөн зуун мянган галавыг тэнэг мунхаг хийгээд мэргэн ухаантай хэн бүхэн, зовлонгоо нэгмөсөн дуусгах хүртлээ тэр бүх үе шатыг дамжин явж, үйлийн үрээ эдэлдэг учиртай.

Тэгвэл, хэн нэгэн нь:

“Сэтгэлээ хатамжлах, бясалгал хийх, сахил сахих, эсвэл ариун амьдралаар амьдрах зэргээр, би боловсроогүй үйлийн үрээ боловсруулна, эсвэл боловсорсон үйлийн үрээ болох цагт нь устгана.” гэж бодож болох юм. Тийм зүйл байдаггүй юм. Зовлон хийгээд жаргал гэдэг чинь тогтоочихсон хэм хэмжээтэй зүйл байдаг юм. Учир нь, зовлон хийгээд жаргалын хэмжээ бол төрөх үхэхийн нийт тоогоор л хэмжигддэг юм. Тийм болохоор, буян нүглийн нийлбэр хэмжигдэхүүнд тооны нөлөө, чанарын нөлөө огт үзүүлж чаддаггүй юм. Ороолттой утсан бөмбөгийг шидэхэд, задарч дуусах хүртлээ өнхөрдөгтэй адилхан, мунхаг хийгээд мэргэн хүмүүс эдлэх үйлийн үрээ эдэлж дуусах хүртлээ энэ хорвоогоор тэнэсээр төөрсөөр явдаг юм.’ гэж надад ярьсан билээ.

Эрхэм Багш аа, ийнхүү Маккхали Госаалагаас би, даянч байхын, даянч замналын энэ насандаа хүртэж болох эрхэм үр өгөөжийн талаар асуухад, үхэх-төрөхийн эргэлтээр тэнэж, эдлэх үйлээ эдэлж дуусгадаг гэсэн онолоо ингэж надад тайлбарласан юм. Энэ нь яг л, би түүнээс манго модны тухай асуухад надад лабужа модны тухай ярих мэт, эсвэл би түүнээс лабужа модны тухай асуухад надад манго модны тухай ярих мэт, Маккхали Госаалагаас даянч байхын, даянч замналын, энэ насандаа хүртэж болох, эрхэм үр өгөөжийн талаар асуухад, үхэх-төрөхийн эргэлтээр тэнэж, эдлэх үйлээ эдэлж дуусгадаг гэсэн онолоо ингэж надад тайлбарласан билээ.

Эрхэм Багш минь, энэ үед надад:

‘Над шиг хаан хүн, эзэмшил нутаг дээр нь амьдардаг эдгээр даянч, бярман нарыг ингэж зовоох хэрэг ч байна уу даа?’ гэсэн бодол төрсөн юм.

Тиймээс би Маккхали Госаалагийн үгийг тийм гэж дэмжээгүй, мөн үгүй гэж няцаагаагүй юм. Түүний ярьсан зүйлд эвгүйцэх сэтгэл төрсөн ч түүнийгээ би илэрхийлж элдэв юм хэлээгүй билээ. Би түүний үзлийг хүлээн зөвшөөрөлгүй, түүний онолыг сайшаан дэмжилгүй тэнд хэсэг сууж байгаад түүнийг орхин явсан билээ.

3.3. Ажита Кесакамбалагийн Сургаал (Ajitakesakambalavāda)

Эрхэм Багш аа, нэгэн удаа би, Ажита Кесакамбалатай уулзахаар очсон юм. Эелдэг найрсгаар бид мэнд ус мэдсэний дараа би түүний хажууд нь суугаад:

‘Хүндэт Ажита минь, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч, нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даянч болон бярман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяны бүтээж байдаг хүмүүс билээ. Хүндэт багш аа, үүний нэгэн адил, даянч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөж нь ер нь юу байдаг юм бэ?’ гэж асуусан билээ.

Үүнд, эрхэм Ажита Кесакамбала ингэж хариулсан юм:

‘Их хаантан минь, өглөг буян, өргөл тахилга, өргөдөг цацал[166] гэж байдаггүй юм. Сайн үйлийн эсвэл муу үйлийн үр өгөөж, эсвэл үр дагавар гэж юм үнэхээр байдаггүй юм. Энэ төрөл, эсвэл дараа төрөл гэж байхгүй. Ээж гэж байхгүй, эцэг гэж байхгүй. Хойд нас гэж байхгүй. Энэ хорвоод, яг өөрийн мэдлэг, яг өөрийн шууд-билгүүнээрээ ухаарсны үндсэн дээр энэ төрөл, дараа төрлийг тайлбарладаг, зөв гэгээрлийг олсон, зөв дасгалыг оршоосон, тийм даянч эсвэл бярман гэж байхгүй. Хүн гэдэг бол язгуур дөрвөн махбодоос бүрддэг. Үхэх цагт, газар нь газартаа, ус нь усандаа, гал нь галдаа, агаар нь агаартаа эргэж шингээд алга болдог юм. Оюун мэдрэмж нь огторгуйд уусаад алга болдог юм. Үхсэн хүний шарилыг дөрвөн хүн дамнуурга дээр үүрч, тав дахь нь болох оршуулагч нь хамт дагалдах бөгөөд тэд чандарлах газар руу явцгаана. Түүний шарил тэнд, яс болон хувхайрч, түүний хийсэн буян үнс болж дуусдаг. Тэр өглөг буян гэдгийг чинь тэнэг хүмүүс л ярьдаг юм. Дараа төрөл ярьдаг хүмүүсийн сургаал даанч учир утгагүй, худлаа хоосон яриа байдаг юм. Мунхаг нь ч тэр, мэргэн нь ч тэр, бие цогцос нь эвдэрч, нэгэнт үхэх цагт, тэд устаж мөхдөг, сөнөж төгсдөг жамтай.’

---

[166] *Hutaṁ*—“цацал”. Ямар нэг байдлаар хэн хэн нэгэнд, лус бурхад эсвэл Тэнгэрт өргөл хийх гэсэн санаа. Зарим орчуулгад “галын тахилга, ёслол” гэжээ.

Эрхэм Багш аа, ийнхүү Ажита Кесакамбалагаас би, даянч байхын, даянч замналын энэ насандаа хүртэж болох эрхэм үр өгөөжийн талаар асуухад, сүйрэл мөхлийн онолоороо хариулсан юм. Энэ нь яг л, би түүнээс манго модны тухай асуухад надад лабужа модны тухай ярих мэт, эсвэл би түүнээс лабужа модны тухай асуухад надад манго модны тухай ярих мэт, Ажита Кесакамбалагаас даянч байхын, даянч замналын, энэ насандаа хүртэж болох, эрхэм үр өгөөжийн талаар асуухад, сүйрэл мөхлийн онолоороо хариулсан билээ.

Эрхэм Багш минь, энэ үед надад:

‘Над шиг хаан хүн, эзэмшил нутаг дээр нь амьдардаг эдгээр даянч, бярман нарыг ингэж зовоох хэрэг ч байна уу даа?’ гэсэн бодол төрсөн юм.

Тиймээс би Ажита Кесакамбалагийн үгийг тийм гэж дэмжээгүй, мөн үгүй гэж няцаагаагүй юм. Түүний ярьсан зүйлд эвгүйцэх сэтгэл төрсөн ч түүнийгээ би илэрхийлж элдэв юм хэлээгүй билээ. Би түүний үзлийг хүлээн зөвшөөрөлгүй, түүний онолыг сайшаан дэмжилгүй тэнд хэсэг сууж байгаад түүнийг орхин явсан билээ.

3.4. Пакудха Каччааянагийн Сургаал (Pakudhakaccāyanavāda)

Эрхэм Багш аа, нэгэн удаа би, Пакудха Каччааянатай уулзахаар очсон юм. Эелдэг найрсгаар бид мэнд ус мэдсэний дараа би түүний хажууд нь суугаад:

‘Хүндэт Каччааяана минь, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч, нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даянч болон бярман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяныг бүтээж байдаг хүмүүс билээ. Хүндэт багш аа, үүний нэгэн адил, даянч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөж нь ер нь юу байдаг юм бэ?’ гэж асуусан билээ.

Үүнд, эрхэм Пакудха Каччааяана ингэж хариулсан юм:

‘Их хаантан минь, бүтээгч эзнээр бүтээгдээгүй, зохиогдоогүй, урлагдаагүй, нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, өнө мөнх оршин байдаг долоон бие гэж байдаг юм. Тэд алга болохгүй, хувирч өөрчлөгдөхгүй, бие биедээ саад болдоггүй, мөн бие биедээ зовлон, эсвэл жаргал, эсвэл аль алиныг нь бий болгож чадахгүй оршдог билээ.

Тэдгээр долоон бие нь юу гээч?

Газрын бие, усан бие, галын бие, агаарын бие болон жаргал, зовлон, амь, энэ долоо юм.

Эдгээр нь бүтээгч эзнээр бүтээгдээгүй, зохиогдоогүй, урлагдаагүй, нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, өнө мөнх оршин байдаг долоон бие юм. Тэд алга болохгүй, хувирч өөрчлөгдөхгүй, бие биедээ саад болдоггүй, мөн бие биедээ зовлон, эсвэл жаргал, эсвэл аль алиныг нь бий болгож чадахгүй оршдог билээ.

Иймээс эдгээр долоон биеийн хувьд алдаг нэгэн, эсвэл алуулдаг нэгэн, сурагч нэгэн, эсвэл сургагч нэгэн, ухаарагч нэгэн, эсвэл ухааруулагч нэгэн гэж байхгүй юм. Хурц илдээр хүний толгойг цавчсан хүн, хэний ч амийг хөнөөхгүй. Тэр хурц илд бол тэдгээр долоон биеийн нарийн завсраар нь зүгээр л урсан гарч байгаа хэрэг юм.'

Эрхэм Багш аа, ийнхүү Пакудха Каччааяанагаас би, даянч байхын, даянч замналын энэ насандаа хүртэж болох эрхэм үр өгөөжийн талаар асуухад, огт хамааралгүй зүйлсээр надад хариулсан юм. Энэ нь яг л, би түүнээс манго модны тухай асуухад надад лабужа модны тухай ярих мэт, эсвэл би түүнээс лабужа модны тухай асуухад надад манго модны тухай ярих мэт, Пакудха Каччааяанагаас даянч байхын, даянч замналын, энэ насандаа хүртэж болох, эрхэм үр өгөөжийн талаар асуухад, огт хамааралгүй зүйлсээр надад хариулт өгсөн билээ.

Эрхэм Багш минь, энэ үед надад:

'Над шиг хаан хүн, эзэмшил нутаг дээр нь амьдардаг эдгээр даянч, бярман нарыг ингэж зовоох хэрэг ч байна уу даа?' гэсэн бодол төрсөн юм.

Тиймээс би Пакудха Каччааяанагийн үгийг тийм гэж дэмжээгүй, мөн үгүй гэж няцаагаагүй юм. Түүний ярьсан зүйлд эвгүйцэх сэтгэл төрсөн ч түүнийгээ би илэрхийлж элдэв юм хэлээгүй билээ. Би түүний үзлийг хүлээн зөвшөөрөлгүй, түүний онолыг сайшаан дэмжилгүй тэнд хэсэг сууж байгаад түүнийг орхин явсан билээ.

3.5. Нигантха Наатапуттагийн Сургаал (Nigaṇṭhanāṭaputtavāda)

Эрхэм Багш аа, нэгэн удаа би, Нигантха Наатапуттатай уулзахаар очсон юм. Эелдэг найрсгаар бид мэнд ус мэдсэний дараа би түүний хажууд нь суугаад:

'Хүндэт Наатапутта минь, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч, нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз

жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даянч болон бярман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяныг бүтээж байдаг хүмүүс билээ. Хүндэт багш аа, үүний нэгэн адил, даянч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөж нь ер нь юу байдаг юм бэ?' гэж асуусан билээ.

Үүнд, эрхэм Нигантха Наатапутта ингэж хариулсан юм:

'Их хаантан минь, Нигантха би, хураангуй дөрвөл сахилыг[167] сахиж байгаа билээ.

Ямар хураангуй дөрвөл сахил гэж үү?

Энэ бол их хаантан минь, Нигантха би, бүх л сахих ёстойгоо сахихуй, бүх л сахих ёстойдоо хазаарлагдахуй, бүх л сахих ёстой зүйлийн ад зэтгэрийг зайлуулахуй, бүх л сахих ёстойдоо уусахуй юм. Эдгээр нь хураангуй дөрвөл сахил юм. Их хаантан минь, Нигантха би, энэхүү хатуу чанд, хураангуй дөрвөл сахилд байгаа тул Нигантха нь олон түмэнд өөрийгөө зангираанаас гаргасан, өөрийгөө төгс төгөлдөр болгосон, өөрийгөө бүрэн хатамжилсан, өөрийгөө бүтээсэн хэмээх энэхүү нэр цолыг олсон билээ.'

Эрхэм Багш аа, ийнхүү Нигантха Наатапуттагаас би, даянч байхын, даянч замналын энэ насандаа хүртэж болох эрхэм үр өгөөжийн талаар асуухад, эдгээр хураангуй дөрвөл сахилын талаар ингэж л надад тайлбарласан юм. Энэ нь яг л, би түүнээс манго модны тухай асуухад надад лабужа модны тухай ярих мэт, эсвэл би түүнээс лабужа модны тухай асуухад надад манго модны тухай ярих мэт, Нигантха Наатапуттагаас даянч байхын, даянч замналын, энэ насандаа хүртэж болох, эрхэм үр өгөөжийн талаар асуухад, эдгээр хураангуй дөрвөл сахилын талаар, ингэж л надад тайлбарласан билээ.

Эрхэм Багш минь, энэ үед надад:

'Над шиг хаан хүн, эзэмшил нутаг дээр нь амьдардаг эдгээр даянч, бярман нарыг ингэж зовоох хэрэг ч байна уу даа?' гэсэн бодол төрсөн юм.

Тиймээс би Нигантха Наатапуттагийн үгийг тийм гэж дэмжээгүй, мөн үгүй гэж няцаагаагүй юм. Түүний ярьсан зүйлд эвгүйцэх сэтгэл төрсөн ч түүнийгээ би илэрхийлж элдэв юм хэлээгүй билээ. Би түүний үзлийг хүлээн зөвшөөрөлгүй, түүний онолыг сайшаан дэмжилгүй тэнд хэсэг сууж байгаад түүнийг орхин явсан билээ.

3.6. Санжаяа Белаттхипуттагийн Сургаал (Sañjayabelaṭṭhiputtavāda)

Эрхэм Багш аа, нэгэн удаа би, Санжаяа Белаттхипуттатай уулзахаар очсон юм. Эелдэг найрсгаар бид мэнд ус мэдсэний дараа би түүний хажууд нь суугаад:

---

[167] *Cātuyāmasaṁvarasaṁvuto*—"хураангуй дөрвөл сахил". Жайн (анг. *jainism*) шашны хураангуй дөрвөн сахил (MN 12.44.1).

‘Хүндэт Санжаая минь, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч, нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даяанч болон бярман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяныг бүтээж байдаг хүмүүс билээ. Хүндэт багш аа, үүний нэгэн адил, даянч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөж нь ер нь юу байдаг юм бэ?’ гэж асуусан билээ.

Үүнд, эрхэм Санжаая Белаттхипутта ингэж хариулсан юм:

‘Их хаантан минь, та надаас:

1. “Нөгөө ертөнц гэж байдаг уу?”[168] гэж асууж болох юм. Би хэрвээ, үнэхээр байгаа гэж үзэх юм бол, тийм өөр ертөнц байна аа л гэж танд зарлах болно. Гэхдээ би үүнийг тийм гэж хэлэхгүй. Би үүнийг тийм биш ч гэж хэлэхгүй. Эсвэл өөр хувилбараар би юм хэлэхгүй. Тийм үгүй хоёулаа ч гэж би хэлэхгүй. Үүнийг би, тийм үгүйн аль нь ч биш гэж бас хэлэхгүй. Үүний нэгэн адил, бас ингэж ч та асууж болох юм:

2. “Нөгөө ертөнц байдаггүй гэж үү?
3. Нөгөө ертөнц байгаа байхгүй, аль аль нь бий гэж үү?
4. Нөгөө ертөнц гэж байгаа байхгүйн, аль нь ч биш гэж үү?

1. Аяндаа төрдөг бодгаль гэж байдаг уу?
2. Аяндаа төрдөг бодгаль гэж байхгүй юу?
3. Аяндаа төрдөг бодгаль гэж байгаа байхгүй, аль аль нь бий гэж үү?
4. Аяндаа төрдөг бодгаль гэж байгаа байхгүйн, аль нь ч биш гэж үү?

1. Сайн, муу үйлийн үрээр жаргал, зовлон гэж ирэх үү?
2. Сайн, муу үйлийн үрээр жаргал, зовлон гэж ирэхгүй юу?
3. Сайн, муу үйлийн үрээр жаргал, зовлон гэж ирэх, ирэхгүй, аль аль нь байх уу?
4. Сайн, муу үйлийн үрээр жаргал, зовлон гэж ирэх, ирэхгүй гэж аль нь ч байхгүй гэж үү?

1. Будда үхлийн дараа оршин байдаг уу?
2. Будда үхлийн дараа оршин байхгүй юу?
3. Будда үхлийн дараа орших, эс оршихуйн аль аль төлөвт байдаг уу?
4. Будда үхлийн дараа орших, эс оршихуйн аль ч төлөвт байхгүй юу?”

[168] Энэ хэсгийг DN 1.3.4-ийн 16 асуулттай харьцуулан хар.

Би хэрвээ, үнэхээр байгаа гэж үзэх юм бол тийм өөр ертөнц байна аа л гэж танд зарлах болно. Гэхдээ би үүнийг тийм гэж хэлэхгүй. Би үүнийг тийм биш ч гэж хэлэхгүй. Эсвэл өөр хувилбараар би юм хэлэхгүй. Тийм үгүй хоёулаа ч гэж би хэлэхгүй. Үүнийг би, тийм үгүйн аль нь ч биш гэж бас хэлэхгүй.'

Эрхэм Багш аа, ийнхүү Санжаяа Белаттхипуттагаас би, даянч байхын, даянч замналын энэ насандаа хүртэж болох эрхэм үр өгөөжийн талаар асуухад, эцэс төгсгөлгүй салаа утгаар, ингэж л надад тайлбарласан юм. Энэ нь яг л, би түүнээс манго модны тухай асуухад надад лабужа модны тухай ярих мэт, эсвэл би түүнээс лабужа модны тухай асуухад надад манго модны тухай ярих мэт, Санжаяа Белаттхипуттагаас даянч байхын, даянч замналын, энэ насандаа хүртэж болох, эрхэм үр өгөөжийн талаар асуухад, эцэс төгсгөлгүй салаа утгаар, ингэж л надад тайлбарласан билээ.

Эрхэм Багш минь, энэ үед надад:

'Над шиг хаан хүн, эзэмшил нутаг дээр нь амьдардаг эдгээр даянч, бярман нарыг ингэж зовоох хэрэг ч байна уу даа?' гэсэн бодол төрсөн юм.

Тиймээс би Санжаяа Белаттхипуттагийн үгийг тийм гэж дэмжээгүй, мөн үгүй гэж няцаагаагүй юм. Түүний ярьсан зүйлд эвгүйцэх сэтгэл төрсөн ч түүнийгээ би илэрхийлж элдэв юм хэлээгүй билээ. Би түүний үзлийг хүлээн зөвшөөрөлгүй, түүний онолыг сайшаан дэмжилгүй тэнд хэсэг сууж байгаад түүнийг орхин явсан билээ.

4. Даянч Замналын Үр Өгөөж (Sāmaññaphala)

4.1. Даянч Замналын Эхний Үр Өгөөж (Paṭhamasandiṭṭhikasāmaññaphala)

Ийм болохоор, Эрхэм Багш аа, би танаас асууя:

Эрхэм ээ, их л олон төрлийн ажил хөдөлмөр байдаг: заан сургагч, морь сургагч, сүйх тэрэгч, харваач, тугч, цэргийн жанжин, хааны торгон цэрэг, манлайд тулалдагч баатар эрс, бух хөллөгч цэрэг эрс, дайны баатар эрс, хуягт цэргүүд болоод гэрийн боол үйлчлэгч, үсчин, усны газрын үйлчлэгч, нарийн боовчин, тогооч, гар урлаач, угаагч, нэхмэлчин, сагсчин, ваарчин, нярав, нягтлан бодогч гээд. Эдгээр бүх хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө гарт баригдаж, нүдэнд үзэгдэх үр шимийг энэ насандаа хүртэж байдаг билээ. Тэд энэ ажил хөдөлмөрийнхөө үр өгөөжөөр өөрсдийгөө тэжээгээд аз жаргалтай, эцэг эхээ тэжээгээд аз жаргалтай, эхнэр хүүхдээ тэжээгээд аз жаргалтай, найз нөхдөө тэжээгээд аз жаргалтай, хамт олноо ч тэжээгээд аз жаргалтай амьдардаг. Тэд сайн үйлийг үйлдэж, даянч болон бярман нарт өглөг барьц өргөж, улмаар диваажинд хөтлөх аз жаргалыг цогцлоон, цаашилбал тэнгэр диваажинд төрөл авахуйц, их буяныг бүтээж байдаг хүмүүс билээ.

Хүндэт Багш аа, үүний нэгэн адил, даянч болох энэ замналын энэ насандаа хүртэх ашиг тус, үр өгөөжийг та надад хэлж чадах уу?" хэмээн асуув.

"Би танд хэлж чадна. Их хаантан минь, гэхдээ танаас юун түрүүн хэдэн зүйлийг эхлээд асууя. Та өөрийнхөө таалаар хариулна уу.

Та юу гэж бодож байна, хаантан минь? Танаас эртлэн босож, таныг унтсан хойно унтаж, аль хүссэнийг тань гүйцэлдүүлдэг, аль хүссэнээр тань байдаг, тантай үргэлж ялдам харьцдаг, таны сэтгэлд үргэлж нийцүүлдэг нэгэн зарц боол байлаа гэж бодъё.

Түүнд хэзээ нэгэн цагт:

'Энэ, хүний хийсэн буян нь хүндээ эргээд ирнэ гэдэг чинь ямар гайхалтай, ямар сайхан хэрэг вэ! Ажаатасатту хаан ч хүн. Би ч бас хүн. Гэсэн хэдий ч, Ажаатасатту хаан, бурхан шиг жаргаж, таван мэдрэхүйн таашаалаар дүүрэн хангагдаж, бүрэн умбадаг. Харин би, түүнээс эртлэн босож, түүнийг унтсан хойно унтаж, хүссэн бүхнийг нь хийж, аль хүссэнийг нь гүйцэлдүүлж, аль хүссэнээр нь байж, түүнтэй үргэлж ялдам харьцаж, түүний сэтгэлд үргэлж нийцүүлдэг, түүний зарц боол нь. Хэрвээ буяныг ихээр үйлдвэл хэт нь би түүн шиг л болох юм. Би тэгвэл, үс сахлаа хусаад, зосон[169] орхимж[170] өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй[171], сахилтан[172] болдог хэрэг.' гэсэн бодол төрж болох юм.

Хэсэг хугацааны дараа тэр, үс сахлаа хусаад, зосон орхимж өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй сахилтан даянч болдог. Сахил авсан тэрээр, бие, хэл, сэтгэлийг хатамжлан, эгэл даруу хоол хүнс, энгийн байр оромж, ганцаар-ахуйд[173] оюун санаа нь уужран амьдрах болно. Таны хүмүүс, тэрхүү таны зарц боол байсан хүний энэхүү явдлын талаар таны сонорт хүргэлээ гэж бодъё.

Та тэдэнд:

'Түүнийг, над дээр буцаагаад авчрагтун хүмүүс ээ. Түүнийг, надаас эртлэн босгож, намайг унтсан хойно унтуулж, аль хүссэнийг минь гүйцэлдүүлдэг, аль хүссэнээр минь байдаг, надтай үргэлж ялдам харьцдаг, миний сэтгэлд үргэлж нийцүүлдэг зарц боол эргүүлээд болго!' гэж та хэлэх үү?"

"Мэдээж би тэгэхгүй, Эрхэм Багш аа. Харин ч бид түүнд их хүндэтгэл үзүүлж, түүнийг хүндлэн суудлаасаа босож, түүнийг суудалд урьж, орхимжийн даавуу, хоол унд, орон байр, эм тан зэргийг өргөл

---

169 *Kāsāyāni*—"зосон" (анг. *saffron, ochre*). Боровтор, улаавтар, шаравтар, шороон будгийн өнгө. Зарим газарт шавар шороонд, зарим газарт модны холтост орхимж даавуугаа чанаж энэ өнгийг оруулдаг. Энэ өнгө нь Буддагийн хуврагуудын бусад шашны даянчдаас ялгарах өнгө нь байж.

170 *Vatthāni*—"орхимж". Эсвэл "даавуу", "нөмрөг". Тухайн цагтаа гэрээ орхисон сахилтан хуврагууд шарилын газраас эсвэл энд тэндээс олж цуглуулсан даавууны өөдсөө залгаж оёод орны бүтээлгээс том хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй зүйл болгоод, зосон будагт оруулаад нөмрөн явдаг байж.

171 *Anagāriyaṁ*—"орон гэргүй". Эсвэл "гэр оронгүй гуйлгачин бадарч болж". Ариуслын зорилгоор хувраг болох хүмүүс "гэрээ орхигч" (па. *anagāriya)* буюу гэр бүл, хамаатан садан, эд хөрөнгөө нэгэнт орхих шатыг заавал дамждаг байж.

172 *Pabbajito*—"сахилтан". Үг үгийн утга нь: "урагш явсан", "урагш явсан нэгэн", "гарсан нэгэн" боловч энэ үг албан ёсоор сахил авсан хувраг, даянч нарт хэрэглэгддэг үг (анг. *one who has gone forth*).

173 *Viveka*—"ганцаар-ахуй". Орь ганцаар байдал, бүхнээс тусгаарлагдсан байдал, бүгдээс салж ангижирсан байдал. Сахил сахихад, улмаар самади-төвлөрөл, даянд ороход, ариусал бясалгалын түвшин ахихад, сарууль-ухаан, Гэгээрлийг олоход гол суурь болдог нэг хүчин зүйл гэж Эртний Буддизмд үзнэ.

барьцад авахыг түүнээс хүсэх болно. Мөн бид түүнд зохих ёсны хамгаалалт, аюулгүй байдал, бусад хэрэгтэй зүйлийг олгох болно.” гэв.

“Та юу гэж бодож байна, их хаантан минь? Тэгвэл ийм байгаа тохиолдолд даяанч замналд үзэгдэж харагдах үр шим байна уу, үгүй юу?”

“Үнэхээр байхаар байна. Эрхэм Багш аа.”

“Их хаантан минь, энэ бол даяанч замналаас гарах, энэ насанд үзэгдэж харагдах эхний үр шим гэж, үүнийг би танд хэлэх болно.”

4.2. Даяанч Замналын Дараагийн Үр Өгөөж (Dutiyasandiṭṭhikasāmaññaphala)

“Эрхэм Багш аа, даяанч замналаас гарах, энэ насанд үзэгдэж харагдах өөр үр өгөөж юу байгааг, үүнийг хэлнэ гээд надад зааж нэрлэж болох уу?”

“Их хаантан минь, гэхдээ танаас юун түрүүн, хэдэн зүйлийг эхлээд асууя. Өөрийнхөө бодож байгаагаар та хариулаарай.

Та юу гэж бодож байна, хаантан минь?

Агуу хаантны сан хөмрөгийг өсгөх гэж алба гувчуур төлдөг ажилчин тариачин байлаа гэж бодъё. Түүнд хэзээ нэгэн цагт:

‘Энэ, хүний хийсэн буян нь хүндээ эргээд ирнэ гэдэг чинь ямар гайхалтай, ямар сайхан хэрэг вэ! Ажаатасатту хаан ч хүн. Би ч бас хүн. Гэсэн хэдий ч, Ажаатасатту хаан, бурхан шиг жаргаж, таван мэдрэхүйн таашаалаар дүүрэн хангагдаж, бүрэн умбадаг. Харин би, түүний сан хөмрөгийг өсгөх гэж алба гувчуур төлдөг, ажилчин тариачин хүн нь. Хэрвээ буяныг ихээр үйлдвэл хэт нь би түүн шиг л болох юм. Би тэгвэл, үс сахлаа хусаад, зосон орхимж өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй сахилтан болдог хэрэг.’ гэсэн бодол төрж болох юм.

Хэсэг хугацааны дараа тэр, үс сахлаа хусаад, зосон орхимж өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй сахилтан даянч болдог. Сахил авсан тэрээр, бие, хэл, сэтгэлийг хатамжлан, эгэл даруу хоол хүнс, энгийн байр оромж, ганцаар-ахуйд оюун санаа нь уужран амьдрах болно. Таны хүмүүс, тэрхүү таны ажилчин тариачин байсан хүний энэхүү явдлын талаар таны сонорт хүргэлээ гэж бодъё.

Та тэдэнд:

‘Түүнийг, над дээр буцаагаад авчрагтун хүмүүс ээ. Түүнийг, сан хөмрөгийг минь өсгөх гэж алба гувчуур төлдөг ажилчин тариачин эргүүлээд болго!’ гэж та хэлэх үү?”

“Мэдээж би тэгэхгүй, Эрхэм Багш аа. Харин ч бид түүнд их хүндэтгэл үзүүлж, түүнийг хүндлэн суудлаасаа босож, түүнийг суудалд урьж, орхимжийн даавуу, хоол унд, орон байр, эм тан зэргийг өргөл

барьцад авахыг түүнээс хүсэх болно. Мөн бид түүнд зохих ёсны хамгаалалт, аюулгүй байдал, бусад хэрэгтэй зүйлийг олгох болно.” гэв.

“Та юу гэж бодож байна, их хаантан минь? Тэгвэл ийм байгаа тохиолдолд даянч замналд үзэгдэж харагдах үр шим байна уу, үгүй юу?”

“Үнэхээр байхаар байна. Эрхэм Багш аа.”

“Их хаантан минь, энэ бол даянч замналаас гарах, энэ насанд үзэгдэж харагдах хоёр дахь үр шим гэж, үүнийг би танд хэлэх болно.”

4.3. Даянч Замналын Дээд Зэргийн Үр Өгөөж (Paṇītatarasāmaññaphala)

“Эрхэм Багш аа, даянч замналаас гарах, энэ насанд үзэгдэж харагдах, өмнөх хоёроос өөр илүү дээр ямар үр өгөөж байгааг, үүнийг хэлнэ гээд надад зааж нэрлэж болох уу?”

“Би танд хэлж чадна. Их хаантан минь, та намайг тун анхааралтай сонсоорой. Би одоо хэлье.” гэхэд,

“За, Эрхэм Багш аа.” хэмээн Ажаатасатту хаан хариулав.

Будда ийн айлдав:

“Их хаантан минь, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда, саруул ухаан хийгээд сахил ёсыг оршоосон, Зөвөөр Одогч, Хорвоог Ухаарагч, Эгнэшгүй Нэгэн, Ухаарах Учиртайг Ухааруулах Сургагч, Бурхад Хийгээд Хүмүүсийн Багш, Сэрсэн Нэгэн, Ерөөлтэй Нэгэн, энэхүү Тийн Одогч энэ хорвоод төржээ. Бурхан, Чөтгөр[174], Тэнгэр, даянч болоод бярман, хаад ноёд хийгээд харц ард бүхий энэ цаг үеийнхний хамтдаа амьдран буй эл хорвоог, өөр дээрээ тэрээр шууд-билгүүнээр ухаарснаар, үүнийг олонд түгээн таниулдаг. Эхэндээ ч зөв сайн, дундаа ч зөв сайн, эцэстээ ч мөн зөв сайн, эш утга бүхий, үг хэллэг бүхий, бүрэн төгс, бүхэлдээ ариун, ариуслын-замналыг[175] тэр илчлэн заадаг.

Энэхүү Сургаалыг, гэр оронтой хүмүүн[176], эсвэл гэр оронтой хүмүүний хүү, аль эсвэл хаа нэгтээ төрсөн хэн нэгэн олж сонсох болно. Энэ Сургаалыг сонссоноор тэр хүмүүн, Буддад итгэх итгэлийг өөртөө олж авна. Ийм итгэлийг олж авсан болохоор, энэ хүмүүн:

174 *Māra*—“Чөтгөр”. Өөрөөр “Маара чөтгөр”, “Маара чөтгөрүүд”. Үгчилбэл, “алуурчин”, “үхэл”. Буддаг гэгээрэхийн урд түүнд саад болдог “чөтгөр”. Маара бол Мэдрэхүйн Орны хамгийн дээд диваажингийн захирагч бурхан. Энэ бол ямар нэг бодгаль бус, харин бодгалиуд нь солигддог “албан тушаал”. Эрт нэгэн цагт Буддагийн шадар хувраг Моггаллаана (*Mahā Moggallāna*) бээр Дуси нэртэй Маара чөтгөр байсан гэдэг (MN 50).

175 *Brahmacāriya*—“ариуслын-замнал” (анг. *holy life*). Ариун-явдалт нэгний гэгээрэл өөд чиглэсэн замнал. Буддагийн Сургаалын гэгээрэлд хүрэх замналыг ерөнхий утгаар хэрэглэсэн нэршил. Үүнд “ариун-явдал” салшгүй хэсэг болж багтах боловч, үүнээс гадна дүүрэн-анхаарал, тунгалаг-оюун, даяан бясалгал, саруул-ухаан, бүгдийг нь хамруулан авч үзнэ.

176 *Gahapati*—“гэр оронтой хүмүүн”. Эсвэл “хар хүмүүн”. Сахилтан бус, гэр оронтой, гэр бүлтэй, ахуй амьдралтай, ажил төрөлтэй хүн.

‘Хар хүмүүний амьдрал бужигнаан шуугиантай, буртаг тоостой, харин сахилтны замнал хавьгүй уужим тэнүүн юм. Гэртээ суугаад амьдрах нэгэнд, зүлгэсэн хясаа[177] шиг төгс төгөлдөр, төгс ариунаар ариуслын-замналаар замнах нь амаргүй хэрэг юм. Тэгвэл магад би, үс сахлаа хусаад, зосон орхимж өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй сахилтан болбол дээргүй юу.’ гэж эргэцүүлж тунгаах болно.

Хэсэг хугацааны дараа, тэрбээр их бага хөрөнгөө орхиж, олон цөөн хамаатнаа орхиж, үс сахлаа хусаад, зосон орхимж өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй сахилтан болдог.

Ингэж тэрээр гэрээ орхисон сахилтан даянч болсноор, хуврагийн дээд сахил, Хураангуй Дүрмийг[178] даган мөрдөж, зөв авиртай, зөв явдалтай нэгэн болж, өчүүхэн жижиг алдаа дутагдал дунд ч аюул бүйг олж харж, авсан сахил номын дагуу өөрийгөө сургаж, бие, хэл, сэтгэлийн тустай-сайн барилд өөрийгөө оршоож, амьжиргаа нь нэгэнт ариусаж[179], сахил-ухамсрыг дадуулж, мэдрэхүйн үүдээ үргэлжид сахин хамгаалснаар[180], дүүрэн-анхаарал тунгалаг-оюунтай[181] байж, тэр сэтгэл хангалуун болдог.

4.4. Анхан Шатны Сахил-Ухамсар (Cūḷasīla)

Их хаантан минь, хувраг хүн сахил-ухамсрыг хэрхэн өөртөө суулгадаг бол?[182]

Их хаантан минь, хувраг хүн, амь таслах үйлийг нэгмөсөн орхиж, амь таслахыг ямагт тэр цээрлэдэг. Тэрээр, мод шийдэм хийгээд хутга сэлмийг нэгэнт орхиж, энэ хорвоогийн бүхий л амьд биетэд ухамсар ухаан, хайр энэрэл, өгөөмөр нинжин сэтгэлээр хандан, амьдран сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, хэн нэгний өгөөгүй зүйлийг авах аливаа үйлийг нэгмөсөн орхиж, ямарваа нэг өөрт нь өгөөгүй зүйлийг өөрийн болгохыг ямагт тэр цээрлэдэг. Тэрээр, зөвхөн бусдын өгснийг авч, өгсөн зүйлийг нь хүлээн зөвшөөрдөг. Тэрбээр, хулгайн үйлээс ангид, цэвэр ариун байдлыг оршоон сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

---

177 *Saṅkhalikhitaṁ*—“зүлгэсэн хясаа”. “Өндөг шиг өөгүй” гэж монголчууд ярьдаг шиг *Māgadhī* хэл соёлд өөлөх юмгүй зүйлийг “зүлгэсэн хясаа шиг” хэмээн зүйрлүүлнэ.

178 *Pāṭimokkha*—“Хураангуй Дүрэм” (сам. *Prātimokṣa*). Буддад шавь орж, хуврагийн дээд сахил авсан хүний дагах ёстой, гэгээрэлд хүргэхэд нэн тустай, 227 зүйл бүхий сахил-ухамсар, ёс зүйн дүрэм.

179 *Parisuddhājīvo*—“амьжиргаа нь нэгэнт ариусаж”. Зэвсэг, хор, мах, боол, согтууруулах, мансууруулах бодис, бусад сахилд заасан зүйлүүд (мөнгөн, хориотой өргөл барьц, мэргэ төлөг, тахилга, хулгай дээрэм г.м.)-ийн орлогоос ангид байж, зөвхөн өглөг, бадраар амьдарч ариусах. *Ājīvo*—амьжиргаа. Гэгээнтний Найман Замналын нэг шат (*sammā-ājīvo*).

180 *Indriyesu guttadvāro*—“мэдрэхүйн үүдээ сахин хамгаалах”. *Indriyesu*—мэдрэхүй, чадвар, мэдрэхүйн чадвар (1. нүдний; 2. чихний; 3. хамрын; 4. хэлний; 5. биеийн; 6. оюун-ухааны). *guttadvāro*—үүд манах цагдах, харж хамгаалах.

181 *Satisampajaññena*—“дүүрэн-анхаарал тунгалаг-оюун”. “дүүрэн-анхаарал” болон “тунгалаг-оюун”-ыг хамтад нь хэлсэн ойлголт. (Дэлгэрэнгүйг DN 2.4.8; DN 22; Лавлахад үз.)

182 DN 2-ын 4.4.-4.6. нь үндсэн агуулгаараа DN 1-ийн 2.1.-2.3. тай ижил тул зүүлт тайлбарыг тэндээс үз.

Хувраг хүн, ариун-бус явдлыг нэгмөсөн орхиж, аливаа бэлгийн харилцааны ямарваа үйлийг ямагт тэр цээрлэдэг. Тэр бол хар хүмүүний үйлддэг бэлгийн харилцааны бүхий л үйлээс татгалзсан, ариун-явдалт нэгэн бөгөөд нүглээс алс буйд амьдран сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, үнэн бус, худал яриаг нэгмөсөн орхиж, үнэн бус, худал яриаг ямагт тэр цээрлэдэг. Тэр бол итгэл эвдэгч нэгэн огт биш, үнэнийг өгүүлэгч, үгэндээ эзэн, итгэл даахуйц, чин шударга нэгэн байна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, гүтгэлэг хийгээд бусдыг хагаралдуулсан яриаг нэгмөсөн орхиж, гүтгэлэг хийгээд бусдыг хагаралдуулсан яриаг ямагт тэр цээрлэдэг. Бусдыг талцуулах үрийг тарьж, энэ талаас сонссон зүйлээ тэр талд нь ярьдаггүй. Бусдын эвдрэлцүүлэх үрийг тарьж, тэр талаас сонссон зүйлээ энэ талд нь ярьдаггүй юм. Ийм болохоор тэр бол харин ч бүр эвдрэлцсэн хүмүүсийг эвлэрүүлэгч, эвтэй хүмүүсийг эс эвдрүүлэгч нэгэн юм. Тэрбээр, эв эеийг эрхэмлэн сайшааж, эв найрамдлыг бататгах яриаг ярьж, энх тайвныг оршоон сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, бүдүүлэг болон дээрэнгүй яриаг нэгмөсөн орхиж, бүдүүлэг болон дээрэнгүй яриаг ямагт тэр цээрлэдэг. Тэрбээр, эелдэг дотно, яруу ялдам, мэргэн цэцэн, утга уянгатай, сонорыг мялаах, хүний сэтгэл зүрхэнд хүрэх, түмний хүлээн зөвшөөрч сонсох, тийм л үгсийг хэлнэ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, хов жив хийгээд явган яриаг нэгмөсөн орхиж, ямарваа нэг хов жив хийгээд явган яриаг, ямагт тэр цээрлэдэг. Тэрбээр, цагаа олсон үед нь, үнэн баримттай, өгөөж тустай зүйлийг, Сургаал номд нийцүүлж, Сахил номд тааруулж, учир шалтгаанд суурилж, чухамхүү нүдээ олсон цагт нь, үнэнхүү цаг нь тохирсон үед нь, учир зүйгээр баталгаажихуйц, улмаар нэгийг тунгаахуйц, хүрээ хязгаарт нь таарахуйц, хүмүүнийг сайн сайханд хөтлөхүйц, тийм л үгсийг хэлнэ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, ургамлын амьдрал хийгээд түүний үрийг гэмтээхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, өдөрт нэг удаа л хооллож, үдшийн цагаар хооллох, буруу цагаар идэхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, бүжиглэх, дуулах, хөгжимдөх, цэнгээн үзвэр үзэхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, зүүлт зүүх, сүрчиг цацах, тос түрхэх, өөрийгөө гоёх, өөрийгөө тордох ямарваа нэг үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, өндөр суудал, өргөн ор хэрэглэхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, алт болон мөнгийг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, болгоогүй будааг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, болгоогүй махыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, эмэгтэйчүүд, охидыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, эм боол, эр боолыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, хонь, ямааг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, тахиа, гахайг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, заан, үнээ, адуу, гүүг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, газар нутаг, тариан талбайг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, бусдын өмнөөс мэдээ зөөх, тушаал даалгавар дамжуулах явдалд оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, худалдаж авах, зарж борлуулах үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, хуурамч жинлүүр, хуурамч зоос, хуурамч хэмжүүрийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, хээл хахууль, заль мэх, хуйвалдаан луйварт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, цавчих, цаазлах, эд эрхтэн тайрах, хорих хүлэх, тонох хулгайлах, булаах дээрэмдэх, харгислах хүчирхийлэхийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Анхан Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

4.5. Дунд Шатны Сахил-Ухамсар (Majjhimasīla)

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах болович ургамлын амьдрал хийгээд тэдгээрийн үрийг гэмтээх явдалд гар бие оролцдог.

Эдгээр үйлдлүүд нь чухамдаа, үндэснээс ургуулах, ишнээс ургуулах, мөчрөөс ургуулах, залгаж ургуулах, үрээс ургуулах зэрэг таван үйл билээ. Харин хувраг хүн ургамлын амьдрал хийгээд тэдгээрийн үрийг гэмтээхийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах болович хоол хүнс, идээ ундаа, гутал хувцас, тээврийн хэрэгсэл, ор дэр, үнэртэн

сүрчиг, элдэв тансаглалыг өөртөө зориулан хурааж хадгалдаг. Харин хуврag хүн, тийм эд агуурс цуглуулах, хөрөнгө зоорь хураах үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч ёс суртахууны түвшин ахихад тээг саад болдог цэнгээн үзвэрт оролцдог. Тэдгээр нь:

- Бүжиг, дуу, хөгжим бүхий цэнгээн үзвэр;
- Жүжиглэл бүхий цэнгээн үзвэр;
- Уран зохиол, үлгэр, түүх бүхий цэнгээн үзвэр;
- Алга ташилт, цан, бөмбөр бүхий цэнгээн үзвэр;
- Зураг, урлаг, гоо сайхны цэнгээн үзвэр;
- Үсрэх, харайх, авирах үзүүлбэр бүхий цэнгээн үзвэр;
- Үхэгсдийн ясыг угаах цэнгээн үзвэр;
- Заан, морь, үхэр, бух, ямаа, хуц, тахиа, бөднө шувууны тэмцэлдээн, уралдаан;
- Саваан тулалдаан, нударган зодолдоон, бөхийн барилдаан, жүжиглэсэн байлдаан, цэргийн бэлтгэл, цэргийн байлдааны жагсаал, цэргийн ёслолын жагсаал;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, ийм цэнгээн үзвэрт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч хэнэггүй байдлыг бий болгодог мөрийтэй тоглоомуудаар тоглодог. Тэдгээр нь:

- Найман хөлөгт шатар даам;
- Арван хөлөгт шатар даам;
- Хийсвэр хөлөгт шатар даам;
- Газар зураад харайх тоглоом;
- Саваа сугалах тоглоом;
- Шоогоор тоглодог тоглоом;
- Савхаар цохих тоглоом;
- Будгаар тоглох тоглоом;
- Бөмбөгөөр наадах тоглоом;
- Навчаар шүгэлдэх тоглоом;
- Газар хагалах тоглоом;
- Тонгорч үсрэх тоглоом;

- Салхин сэнсний тоглоом;
- Жинлүүрт тоглоом;
- Хөсөг тэрэг тоглоом;
- Тоглоомон нум суман тоглоом;
- Үгийн таавварт тоглоом;
- Бодлын таавварт тоглоом;
- Өрөөл татанхай болж жүжиглэх тоглоом;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, хэнэггүй байдлыг бий болгодог, эдгээр мөрийтэй тоглоомд оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өндөр бөгөөд тансаг, олбог суудал, ор дэр хэрэглэдэг. Тэдгээр нь:

- Өргөн буйдан;
- Амьтны сийлбэр, хээ хуар бүхий сэнтий; үслэг бүтээлэг;
- Өнгө алаглуулан шоолж хийсэн бүтээлэг; цагаан ноос ноолууран хучлага;
- Цэцэг шигтгээ бүхий ноос ноолууран хучлага, хөвөнгөөр зузаалсан хөнжил;
- Амьтны дүрсэн хээ, шигтгээ бүхий ноос ноолууран хучлага;
- Нэг эсвэл хоёр талдаа үслэг, ноос ноолууран хучлага;
- Үнэт чулуун шигтгээ бүхий орны хучлага;
- Торгон хучлага;
- Хивс, ширдэг;
- Заан, морин сүйх тэрэгний шалавч; гөрөөсний арьсан шалавч;
- Кадали бугын арьсан шалавч, бүтээлэг;
- Улаан саравч, халхавч бүхий сэнтий;
- Улаан өнгийн, гарын тавиур, хөлийн гишгүүр бүхий, зөөлөн сэнтий, буйдан;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, өндөр бөгөөд тансаг олбог суудал, ор дэр хэрэглэхийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өөрийгөө гоёж, биеэ торддог.

Тэдгээр зүйлүүд нь: сүрчиг цацах, тосон иллэг хийлгэх, анхилуун усанд орох, гар хөлийн иллэг хийлгэх, толь хэрэглэх, тос түрхэх, зүүлт зүүх, үнэртэн хэрэглэх, нүүрээ будах, энгэсэг түрхэх, бугуйвч зүүх, үс толгойн тууз зүүх, чамин ганган таяг тулах, эмийн бортого хөөрөг хэрэглэх, гоёлын хутга зүүж явах,

нарны халхавч хэрэглэх, гоёлын шаахай өмсөх, өндөр сүрлэг малгай өмсөх, үнэт эдлэл хэрэглэх, титэм зүүх, дэвүүр сэвүүр хэрэглэх, элбэг сүрлэг цагаан дээл орхимж өмсөх, гэх зэрэг болно. Харин хувраг хүн, өөрийгөө гоёх, биеэ тордох явдлыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах болович дэмий яриа ярьдаг.

Тэдгээр нь: хаад ноёд, хулгайч луйварчид, сайд түшмэлүүдийн тухай яриа; цэрэг зэвсэг, аюул занал, дайн дажны тухай яриа; хоол хүнс, идээ ундаа, гутал хувцас, ор дэр, үнэт эдлэл, үнэртэн сүрчгийн тухай яриа; хамаатан садан, тээврийн хэрэгсэл, хот хөдөө, улс орны тухай яриа, охид хүүхнүүдийн тухай яриа; эрэлхэг баатруудын тухай яриа; гудамжны яриа, дошны яриа; нас нөхцөгсдийн тухай яриа; шивэр авир, явган яриа; гадаад далай, газар орны тухай таамаг яриа; тийм сайн дараа төрлийг авсан, ийм муу дараа төрлийг олсон гэх зэрэг элдвийн дэмий яриа болно. Харин хувраг хүн, эдгээр хэрэггүй дэмий яриаг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах болович өөр хоорондоо ном хаялцан маргалдаж:

‘Чи энэ Сургаал, Сахилыг ойлгодоггүй юм байна. Би энэ Сургаал, Сахилыг ойлгодог билээ.’,

‘Чи энэ Сургаал, Сахилыг чухам яаж ойлгоод байна?’,

‘Чиний дасгал, бясалгал бол буруу. Миний дасгал, бясалгал бол зөв.’,

‘Би оройд нь гарч ойлгоод байна. Чи оройд нь гарч ойлгохгүй байна.’,

‘Чи эцэст нь хэлэх ёстойгоо эхэнд нь хэлээд, эхэнд нь хэлэх ёстойгоо эцэст нь хэлээд байна.’,

‘Чиний удаан бодож тунгаасан номлол төөрөлдсөн зүйл байна.’,

‘Чиний номлол няцаагдлаа. Чи мэтгэлцээнд ялагдлаа. Чи эндээс яв одоо. Эсвэл чаддаг юм бол яг одоо энд зангилааг нь гаргачих.’ гэх зэргээр мэтгэлцэх аж. Харин хувраг хүн, ийм ном хаялцсан, цэц булаалдсан яриаг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах болович ‘энд ир, тэнд оч, үүнийг ав, түүнийг хүргэ’ гэх зэргээр, хаад ноёд, сайд түшмэд, язгууртнууд, бярман болон хар хүмүүс, хүүхэд залуусын хооронд, захиа мэдээ, тушаал даалгавар дамжуулах аж. Харин хувраг хүн, ийм мэтийн захиа мэдээ, тушаал даалгавар дамжуулах үйл хэрэгт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даяанч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өргөл барьц авахын тулд, зальдаж мэхлэх, зусардаж бялдуучлах, далдуур санаа өгөх, дарамт шахалт үзүүлэх, ямар нэг эд зүйл өгөөд илүү их өргөл барьц авах, элдэв заль мэхэнд оролцдог. Харин хувраг хүн, ийм мэтийн заль мэхийн үйл хэрэгт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Дунд Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

4.6. Дээд Шатны Сахил-Ухамсар (Mahāsīla)

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даяанч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Хүний наслах нас, эсвэл үхэх цагийг, сэргэн мандах, эсвэл уруудан доройтохыг, гар хөл, биеийн мэнгээр мэргэлэх зөгнөх;
- Далдын ёр, шинж тэмдгийг тодорхойлох;
- Аянга цахилгаан, тэнгэрийн дуугаар элдэв ёр зөн хэлэх;
- Хар дарсан зүүд, зүүдний тайлал хийх;
- Биеийн шинж тэмдгээр мэргэлэх;
- Хулгана мэрсэн хувцас даавуун дээрээс мэргэ төлөг буулгах;
- Галын тахилга, өргөл хийх;
- Цацлаар өргөл хийх;
- Хивэг, гурил, тариа, өөх, шар тосоор бурхдад өргөл өргөх;
- Амаараа тургиж өргөл өргөх;
- Амьтнаар тахилга хийх;
- Хурууны өндөг, алганы хээгээр мэргэлэх;
- Баригдах байшин, газар талбай, шарилын газрын, өлзийтэй сайн эсэхийг шинжих;
- Төрийн түшмэдэд зориулан мэргэ төлөг хэлж өгөх;
- Оршуулгын газрын албин чөтгөрийг зайлуулах арга жатга хийх;
- Гүйдэл, дайрлагад дайруулсан хүний албин чөтгөрийг зайлуулах арга жатга хийх;
- Шороон байшинд суугчдын тарни шившлэг буюу арга жатгыг хэрэглэх;
- Могойн хороор эмчлэх, могойд хазуулсан хүнийг эмнэх домнох;
- Хор хийх, хороор эмчлэх, хордлого тайлах;
- Хилэнцэт хорхой, харханд хазуулсан хүнийг эмнэх домнох;
- Шувуу, хэрээний дуу чимээ, гуагалалтаар зөгнөх ёрлох;

- Хүний амьдрах насны тоог хэлэх зөгнөх;
- Сум зэвээс хамгаалах тарни шившлэг хийх;
- Амьтны хэл чимээгээр зөгнөх ёрлох;

гэх зэрэг болно.

Харин хуврага хүн, эдгээр дорой аргаар, буруу замаар амь амьжиргаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь, эд зүйлсийг өнгө, дүрс болон бусад шинж чанараар нь шинжиж, эздэдээ аз хийморь, эсвэл золгүй явдал авчрах эсэхийг хэлж өгөх дорой арга буюу: эрдэнийн чулуу, гутал хувцас, таяг, сэлэм, жад, нум, сум, өөр бусад зэр зэвсэг, хүүхнүүд, эрчүүд, хөвгүүд, охид, боол эрс, боол эмс, заан, адуу, үхэр, бух, үнээ, ямаа, хуц, тахиа, бөднө, гүрвэл, туулай, яст мэлхий, болон бусад амьтад юм. Харин хуврага хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Тэр хаан довтлох болно;
- Тэр хаан довтлохгүй;
- Манай хаан довтолж, дайсны хаан ухрах болно;
- Дайсны хаан довтолж, манай хаан ухрах болно;
- Манай хаан ялж, дайсны хаан ялагдана;
- Дайсны хаан ялж, манай хаан ялагдана;
- Тэр тал ялж, энэ тал нь ялагдана;

гэх зэрэг юм. Харин хуврага хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Нар, сар, оддын хиртэлт болно;
- Нар, сар жамаараа эргэлдэнэ;
- Нар, сарны эргэлтийн гажуудал бий болно;
- Од гаригууд жам ёсоороо эргэлдэнэ;

- Од гаригийн гажуудал үүсэх болно;
- Солир унана, тэнгэрийн хаяа улайна, газар хөдөлнө;
- Газар ангайна;
- Нар, сар, од гаригууд мандана, жаргана, харанхуйлна, гэрэлтэнэ;
- Нар, сарны хиртэлтийн улмаас ийм тийм зүйл тохионо;
- Нар, сар, од гаригуудын мандах ба жаргах, харанхуйлах ба тодрох шинж байдал нь ийм тийм учралыг авчирна;

гэх мэтээр зөгнөх, ёрлох, мэргэлэх юм. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь дараах зүйлс болно:

- Хур ус элбэг байна;
- Ган гачиг болно;
- Ургац арвин байна;
- Өлсгөлөн болно;
- Энх тунх болно;
- Аюул занал бий болно;
- Өвчин зовлон ирэх болно;
- Эрүүл энх болно гэх зэргээр мэргэлэх, зөгнөх, таамаглах;
- Эсвэл тэд, нягтлан бодох, тооцоолон бодох, тоо бодох, шүлэг найраг зохиох, мөн хорвоо ертөнцийн талаар элдэв таамаглал хэлэх зэрэг юм. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь:

- Хурим хийх, бэр гуйх, охиноо хадамд гаргах өдөр сарыг шинжих;
- Сүй тавих, гэр бүл салгах өдөр сарыг шинжих;
- Орлогын үүд, эсвэл гарлагын үүдийг дуудах тарни шившлэг хийх;
- Хүний аз хийморь, эсвэл золгүйдэлт бүтэлгүйдэлд тарни шившлэг хийх;
- Үргүй эмэгтэйчүүдэд үрийн заяа дуудах;

- Хүний хэл ам, хөл гар, эрүүг нь татуулах, эсвэл дүлий болгох тарниившлэг хийх;
- Толь, чөтгөр, шулмаас, эсвэл бурхдаас шийдэл зөвлөгөө асуух;
- Нарыг тахих, шүтэх;
- Бярман Дээд Тэнгэрийг тахих, шүтэх;
- Галаар тургих арга жатга хийх;
- Азын Тэнгэр дуудах;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь:

- Ач тусын хариуд, бурхдад өргөл амлах;
- Тэр амлалтаа биелүүлэх;
- Албин чөтгөртэй холбогдох;
- Орон байрны тарни шившлэг хийх;
- Үргүйдэл, бэлгийн сулрал засах;
- Барилга барих газрыг бэлдэх, ариусгах;
- Ам зайлах, усанд оруулах ариусгал ёслол хийх;
- Галын тахилга хийх;
- Бөөлжүүлэх, дотор цэвэрлэх, цэр ховхлох, цэр хөөх эм өгөх;
- Чих, хамраар хэрэглэх эм өгөх;
- Анагаах тосон түрхлэг өгөх;
- Нүд, чихэнд нарийн мэс засал хийх;
- Ерөнхий мэс засал хийх;
- Хүүхдийн эмчилгээ хийх;
- Эмийн ургамлын үндсээр эмчилгээ хийх;
- Эмийн ургамлаар боолт хийх;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Их хаантан минь, ийнхүү эдгээр сахилаа ямагт дагаж мөрдсөнөөр, сахил-ухамсрыг нэгэнт өөртөө суулгасан хувраг хүн, сахил-ухамсрын тал дээр огтхон ч түгших, эмээх зүйлгүй болдог билээ.

Их хаантан минь, энэ яг л, дайснаа нэгэнт дарсан, дархан цолыг олсон баатар хунтайж, атаатан дайсны тал дээр огтхон ч түгших, эмээх зүйл олж харахгүйн адил, эдгээр сахилаа ямагт дагаж мөрдсөнөөр, сахил-ухамсрыг нэгэнт өөртөө суулгасан хувраг хүн, сахил-ухамсрын тал дээр огтхон ч түгших, эмээх зүйлгүй болдог билээ.

Энэхүү Гэгээнтний[183] сахил-ухамсрыг цогцоор нь өөртөө суулгасан тэр хувраг хүн буруу нь үгүй аз-жаргалыг[184] өөрийн дотор мэдэрдэг.

Их хаантан минь, хувраг хүн сахил-ухамсрыг ингэж өөртөө суулгадаг билээ.

Дээд Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

4.7. Мэдрэхүйн Чандлал-Хатамжлал (Indriyasaṃvara)

Тэгвэл хаантан минь, хувраг хүн мэдрэхүйн үүд хаалгаа хэрхэн сахин хамгаалдаг бол?

Энэ тал дээр, их хаантан минь, хувраг хүн, үзэгдэх ямар нэг дүрс нүдэнд туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, харааны үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол, тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл[185], зовнил-гуниг[186] түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, харааны мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг[187] үргэлж дасгалжуулан үйлдсэнээр харааны мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хувраг хүн, сонсогдох ямар нэг чимээ чихэнд туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, сонсголын мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, сонсголын мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр сонсголын мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хувраг хүн, үнэртэх ямар нэг үнэр хамарт туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, үнэрлэх мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс

183 *Ariyena*—“Гэгээнтний”. Өөрөөр, “Гэгээрлийн”, “Ариуслын” г.м. (Тайлбарт Ариуссан хэсгийг үз.)

184 *Anavajjasukhaṁ*—“буруу нь үгүй аз-жаргал”. Өөрөөр “буруудахгүй аз-жаргал”. “Буруу нь үгүй” гэдэг нь муу үйлийн үрийг үүсгэхгүй, тусгүй-мууд эс тооцогдох гэсэн санаа болно.

185 *Abhijjhā*—“хүсэл-мөрөөсөл”. Бусдын эд зүйл, эзэмшлийг хүсэх, шунах хэлбэрийн сэтгэл (ихэвчлэн сөрөг утгаар хэрэглэгдэнэ). Таван-саадын нэг. DN 22-ын Таван-саадад “хүсэл-мөрөөсөл” (*abhijjhā*) биш харин “мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл” (*kāmacchando*) гэж хэрэглэсэн байдаг тул энэ хоёр үгийг утга зүйн хувьд тун ойролцоо гэж үзэж болно.

186 *Domanassa*—“зовнил-гуниг”. Аливаад дургүй, таагүй байх, бухимдах, зовуурилах, мөн уйтгар гуниг, уй гашуу зэрэг сэтгэлийн эс нийцэх, зовуурь бүхий таагүй байдлыг нийтэд нь хамруулан хэлсэн үг.

187 *Saṁvarāya*—“чандлал-хатамжлалыг”. Самгарди хэлээс орж ирсэн байж болох “санваар” (па. *saṁvara* сам. *saṃvara*)-ын “хатуу хяналт, хамгаалан сахих” утгыг дагаж, мөн бусад ойролцоо үгээс ялгах үүднээс “чандлал-хатамжлал” гэнэ.

тэр, үнэрлэх мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр үнэрлэх мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хуврага хүн, амтагдах ямар нэг амт хэлэнд туссанаар, түүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, амтлах мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, амтлах мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр амтлах мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хуврага хүн, хүрэлцэх ямар нэг зүйл биед туссанаар, түүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, хүрэлцэх мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, хүрэлцэх мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр хүрэлцэх мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хуврага хүн, ямарваа нэг бодол оюун-ухаанд бууснаар, түүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, оюун-ухааны мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, оюун-ухааны мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр оюун-ухааны мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Мэдрэхүйн зургаан үүдийг сахин хамгаалах энэхүү Гэгээнтний чандлал-хатамжлалыг өөртөө суулгасан тэр хуврага бохирдоогүй аз-жаргалыг[188] өөрийн дотор мэдэрдэг.

Их хаантан минь, энэ бол хуврага хүний мэдрэхүйн үүд хаалгаа сахин хамгаалахуй нь юм.

4.8. Дүүрэн-Анхаарал Тунгалаг-Оюун (Satisampajañña)

Тэгвэл хаантан минь, тэр хуврага хүн дүүрэн-анхаарал[189] тунгалаг-оюуныг[190] хэрхэн дадуулдаг бол?[191]

Энэ тал дээр, их хаантан минь, хуврага хүн урагш явсан ч, эсвэл ухарч явсан ч тунгалаг-оюуныг оршоож[192] үйлддэг, урагш харсан ч, эсвэл эргэн тойрноо харсан ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

---

188 *Abyāsekasukhaṁ*—"бохирдоогүй аз-жаргал". Зугаа цэнгэлээс бус, цэвэр ариун үйлээс үүсэх, цэвэр ариуны аз жаргал.

189 *Sati*—"дүүрэн-анхаарал" (анг. *mindfulness*). Ариуслын-замналын үндсэн хэсэг болох сахил-ухамсар, самади-төвлөрөл, саруул-ухаанаар анхаарлаа дүүрэн байлгахуй, эдгээрийг ямагт санаж байхуй, эс умартахуй. Судarт гол төлөв "тунгалаг-оюун"-тай хоршуулан хэрэглэнэ. Мөн DN 22.4.9; Лавлахад үз.

190 *Sampajañña*—"тунгалаг-оюун" (анг. *clear comprehension*). Аливааг бүрэн сэрэмж, эрүүл ухаан, саруул тунгалаг, саруул-ухаанаар харах (өөрийн бие, сэтгэлийн үйлээ Гэгээрэл өөд чиглэсэн зорилготойгоо уялдуулан), Зарим орчуулгад "нөхцөл байдлын сэрэмж" (анг. *situational awareness.* BS).

191 *Satisampajañña*—"дүүрэн-анхаарал тунгалаг-оюун". Дүүрэн-анхаарал болон тунгалаг-оюуныг тус тус Лавлахад үз.

192 *Sampajānakārī*—"тунгалаг-оюуныг оршоож". "Тунгалаг-оюун"-ыг өөртөө бий болгож, үүсгэж гэсэн санаа. "Тунгалаг-оюун"-ыг Лавлахад үз.

Мөчөө нугалахдаа ч, эсвэл мөчөө тэнийлгэхдээ ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Хувцсаа өмсөхдөө ч, эсвэл бадрын аягаа[193] барихдаа ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Хоолоо идэхдээ ч, ундаа уухдаа ч, зажлахдаа ч, эсвэл амтлахдаа ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Хөнгөн бие засахдаа ч, эсвэл хүндээр бие засахдаа ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Алхахдаа ч, зогсохдоо ч, суухдаа ч, унтахдаа ч, сэрэхдээ ч, ярихдаа ч, эсвэл чимээгүй байх үедээ ч, тэрээр тунгалаг-оюуныг оршоож энэ бүгдийг үйлдэнэ.

Их хаантан минь, ингэж хувраг хүн дүүрэн-анхаарал тунгалаг-оюуныг өөрт дадуулдаг билээ.

4.9. Сэтгэл Ханамж (Santosa)

Тэгвэл хаантан минь, тэр хувраг хүн хэрхэн сэтгэл ханамжтай байдаг бол?

Энэ тал дээр их хаантан минь, хувраг хүн, биеийг хамгаалах орхимж, ходоодыг цатгах өглөгийн хоол хоёртоо л сэтгэл ханамжтай байдаг билээ. Тэрээр хаашаа ч явсан байлаа, орхимж, аяга хоёроо л өөртөө авч явдаг билээ.

Шувуу гэдэг амьтан хаашаа ч одсон байлаа, хоёр далавчаа л өөртөө авч яван, үүгээрээ дүүлэн нисдэгтэй адил, хувраг хүн мөн адил хаашаа ч явсан байлаа, орхимж, аяга хоёроо л өөртөө авч явдаг билээ.

Их хаантан минь, ингэж л хувраг хүн сэтгэл ханамжтай байдаг юм.

4.10. Таван-Саадыг Арилгахуй (Nīvaraṇapahāna)

Тэрбээр, Гэгээнтний сахил-ухамсрыг бүхэлд нь дадуулснаар, зургаан мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах, тэрхүү Гэгээнтний чандлал-хатамжлалыг өөртөө суулгаснаар, тэрхүү Гэгээнтний дүүрэн-анхаарал тунгалаг-оюуныг дадуулснаар, тэрхүү Гэгээнтний сэтгэл ханамжийг олсноор, энэ хувраг ой мод, модны хонгил[194], уулын энгэр, уулын хавцал, уулын агуй, оршуулгын газар[195], шигүү ширэнгэн ой, ил задгай газар, өвсөн бухал зэрэг олны хөлөөс алс буйд газар орь ганцаар амьдарна. Тэрээр бадар барьж[196] ирээд,

[193] *Patta*—“бадрын аяга”. Хувраг хүн бадар барин (хоол гуйж) явахдаа, хоолоо идэхдээ хэрэглэдэг вааран эсвэл төмөр сав. Эртний ёсоор хувраг хүний эзэмшиж, өмчилж болох хоёр л зүйлийн нэг нь. Нөгөө нь орхимж.

[194] *Rukkhamūlaṁ*—“модны хонгил”. Эсвэл “модны ёроол”. Халуун орны лужир том хөгшин моддын доод хормой ангайж, хүн орж суухаар зай үүсдэг. Мөн зарим төрлийн моддын үндэс нь газраас алд, тохой хэртэй өндөртэй овойж, ил гарсан байдаг нь завсар хооронд нь хүн орж суух, “орогнож” болох зай болдог (Орч).

[195] *Susānaṁ*—“оршуулгын газар”. Өөрөөр “хүн тавих газар”, “хүүрийн газар”.

[196] *Piṇḍapāta*—“бадар барих”. Хувраг хүн хоолоо олж идэх үндсэн хэлбэр буюу ойролцоох тосгон суурин очиж, бадрын аягаа барин, хоол горилж явах.

хоолоо идэж дуусаад, хоёр хөлөө хөндлөн зөрүүлээд, биеэ эгцлэн завилан суугаад, дүүрэн-анхаарал өмнөө[197] үүсгэнэ.

1. Энэ хорвоогийн хүсэл-мөрөөслөө үгүй хийснээр, тэрээр хүсэл-мөрөөслөөс ангижирсан сэтгэлийг оршооно. Тэрээр хүсэл-мөрөөсөлтэй сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

2. Хар-санаа[198], уур-хилэнг үгүй хийснээр, тэрээр хорвоогийн амьтан[199] бүгдэд хайр энэрэл, нинжин сэтгэлтэй оршино. Тэрээр хар-санаа, уур-хилэнт сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

3. Хойрго-нойрмог[200] байдлыг үгүй хийснээр, тэрээр хойрго нойрмог байдалгүй, саруул тунгалаг, дүүрэн-анхаарал тунгалаг-оюунтай оршино. Тэрээр хойрго-нойрмог сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

4. Түгшүүр-зовнилоо[201] үгүй хийснээр, тэрээр сэтгэл дотроо амар тайван, аюул түгшүүргүй оршино. Тэрээр түгшүүр-зовнилтой сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

5. Эргэлзээ-тээнэгэлзээг[202] үгүй хийснээр, тэрээр тустай-сайн Чанаруудад[203] эргэлзэж тээнэгэлзэлгүй, эргэлзээгээ-тээнэгэлзээг нэгэнт давсан хүний ёсоор оршино. Тэрээр эргэлзээ-тээнэгэлзээтэй сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

Хаантан минь, хэн нэгэн хүн өр зээл тавьж гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, зээлийн мөнгөө ажил хэрэгтээ зарцуулаад, ажил хэрэг нь ч бүтэмжтэй болоод, авсан өр зээлээ бүр хүүтэй нь хамт төлөөд, тэр ч бүү хэл эхнэртээ гоёл чимэглэл авч өгөх хангалттай мөнгийг олсон байж. Энэ болсон явдлаа тэр: “Би өр зээл тавьсан. Би зээлийн мөнгөө ажил хэрэгтээ зарцуулж, ажил хэрэг минь ч бүтэмжтэй болж, авсан өр зээлээ, бүр хүүтэй нь хамт төлж, тэр ч бүү хэл эхнэртээ гоёл чимэглэл авч өгөх хангалттай мөнгийг олсон шүү.” хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Хаантан минь, мөн нэгэн хүн, хүнд өвчин тусч гэж бодъё. Хоол ундаа ч идэх чадалгүй, тамир тэнхээ нь доройтсон байж. Хэсэг хугацааны дараа тэр, энэхүү хүнд өвчнөөсөө салаад, хоол ундаа иддэг болоод, болоогүй бүр, тамир тэнхээ нь эргэн цогцолсон байж. Энэ болсон явдлаа тэр: “Би хүнд өвчин тусч билээ. Хоол ундаа ч идэх чадалгүй, тамир тэнхээ минь доройтсон байсан. Гэхдээ хэсэг хугацааны дараа, энэ хүнд өвчнөөсөө салж, хоол ундаа иддэг болоод, болоогүй бүр тамир тэнхээ минь эргэн цогцолсон шүү.” хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

---

197 *Parimukhaṁ*—“өмнөө” (*pari*—“орчимд”, *mukha*—“ам, нүүр”). Энэ үгийг DN 22.1.1-д “ам хамар орчимдоо” гэж оруулав.

198 *Byāpādā*—“хар-санаа”. Бусдад мууг хүсэх, хор хүргэх, эс хайрласан, дайсагнасан, атгаг муу, хилэнт сэтгэл санаа. (Тайлбарт ойролцоо үг үз.)

199 *Pāṇabhūta*—“амьтан”. Амьсгалдаг бүх амьд биет.

200 *Thīnamiddha*—“хойрго-нойрмог” (*thīna*—залхуу, хойрго байдал; *middha*—нойрмог, лазан, унжгар байдал).

201 *Uddhaccakukkucca*—“түгшүүр-зовнил” (*uddhacca*—сэтгэлийн түгшүүр; *kukkucca*—сэтгэл зовнил).

202 *Vicikiccha*—“эргэлзээ-тээнэгэлзээ”. Эртний Буддизмд үүнийг Буддагийн Гэгээрэл, түүний Сургаал, Гэгээрсэн хуврагууд, Үйлийн Үрийн Хууль, Учир шалтгааны номлол (*Paṭiccasamuppāda*), ариуслын-замнал зэрэгт үл итгэх, эргэлзэх, тээнэгэлзэх байдал гэж үздэг.

203 *Dhammesu*—“Чанаруудад”. Тайлбарт буй Сургаал хэсгийг үз.

Хаантан минь, мөн нэгэн хүн, шоронд орчихлоо гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, элдэв бэртэл гэмтэлгүй, эд хөрөнгөө ч алдалгүй, болоогүй бүр шоронгоосоо суллагдсан байж. Энэ болсон явдлаа тэр: "Би шоронд орчхож билээ. Хэсэг хугацааны дараа би, элдэв бэртэл гэмтэлгүй, эд хөрөнгөө ч алдалгүй, болоогүй бүр шоронгоосоо суллагдсан шүү." хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Хаантан минь, мөн нэгэн хүн, өөрийн гэсэн эрх чөлөөгүй, бусдаар удирдуулж захируулдаг, хүссэн зүгтээ ч явж болдоггүй, зарц боол байжээ гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, зарцлалт боолчлолоосоо чөлөөлөгдөж, эрх чөлөөг олсон байг. Тэр цагаас хойш, бусдад нэгэнт захирагдахаа больж, болоогүй бүр хүссэн зүгтээ явж болдог эрх чөлөөт нэгэн болж гэнэ. Энэ болсон явдлаа тэр: "Би өөрийн гэсэн эрх чөлөөгүй, бусдаар удирдуулж захируулдаг, хүссэн зүгтээ ч явж болдоггүй, зарц боол байсан билээ. Хэсэг хугацааны дараа би, зарцлалт боолчлолоосоо чөлөөлөгдөж, эрх чөлөөг олсон. Тэр цагаас хойш би, бусдад нэгэнт захирагдахаа больж, болоогүй бүр хүссэн зүгтээ явж болдог эрх чөлөөт нэгэн болсон шүү." хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Хаантан минь, эд баялаг, хөрөнгө чинээтэй мөн нэг хүн, хоол хүнс ч олдохооргүй, аюул түгшүүрээр дүүрэн, эзгүй хээрийн замаар аялж байлаа гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, элсэн цөлийг гатлаад, амар амгалан, аюул түгшүүргүй нэгэн тосгонд эсэн мэнд ирсэн байг. Энэ болсон явдлаа тэр: "Би, хоол хүнс ч олдохооргүй, аюул түгшүүрээр дүүрэн, эзгүй хээрийн замаар аялж байсан билээ. Хэсэг хугацааны дараа би, тэр элсэн цөлийг гатлаад, амар амгалан, аюул түгшүүргүй нэгэн тосгонд эсэн мэнд хүрч ирсэн шүү." хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Яг үүний адилаар, их хаантан минь, хувраг хүн өөрийн дотор эдгээр таван-саадыг[204] арилаагүй байгааг мэдэх үедээ, үүнийг өр шир, өвчин зовлон, шорон гяндан, зарцлалт боолчлол, элсэн цөл, эдгээртэй зүйрлүүлэн хардаг учиртай.

Их хаантан минь, хувраг хүн өөрийн дотор эдгээр таван-саадыг арилсан байгааг мэдэх үедээ, үүнийг өр ширгүй, өвчин зовлонгүй, шоронгоос суллагдсан, эрх чөлөөтэй, аюул заналгүй болсонтой зүйрлүүлэн хардаг учиртай.

Тэр хувраг хүн, өөрийн дотор эдгээр таван-саадыг арилсан байгааг мэдэх үед, түүний дотор баярлах мэдрэмж төрдөг. Энэ баярлах мэдрэмжээс түүний дотор хөөр-баяр төрдөг. Түүний сэтгэл хөөр-баяраар дүүрэх үед, түүний бие амар тайван болдог. Тэрээр биеийн амар-амгалан[205], аз-жаргалыг мэдэрнэ. Тийн жаргалтай болсон хүний сэтгэл санаа нь самади-төвлөрөлд[206] оршдог.

---

204 *Nīvaraṇa*—"таван-саад". Үгийн утга "тээг, саад, садаа" г.м. Таван-саад: 1. хүсэл-мөрөөсөл; 2. хар-санаа уур-хилэн; 3. хойрго-нойрмог; 4. түгшүүр-зовнил; 5. эргэлзээ-тээнэгэлзээ.

205 *Passaddhakāyo*—"биеийн амар-амгалан". Өөрөөр, "бие махбодын амар-амгалан байдал". Сахил, бясалгалын үрээр бие махбод нэн амар амгалан болохуй. Лавлахад "амар-амгалан"-г үз.

206 *Samādhi*—"самади-төвлөрөл" (анг. *concentration* эсвэл *immersion*). Өөрөөр даяан бясалгалын төвлөрөл. Ариуслын-замнал, төвлөрлийн бясалгалаас үүдэн, мөн таван-саадыг давах үед оюун санаа нь бясалгалын гүн төвлөрөлд орох, сатааралтгүй болох, сэтгэл санаа тогтох байдал, бясалгалын төлөв.

4.11. Нэгдүгээр Даяан (Paṭhamajhāna)

Мэдрэхүйн-таашаалаас салснаар, тусгүй-муу Зүйлээс салснаар, тэрбээр зурвас-бодол бүхий, эргэцүүлсэн-бодол бүхий, ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр аз-жаргал[207] бүхий нэгдүгээр даяан зэрэгт хүрснээр тэр оршин байна.[208] Тэр хувраг өөрийн биедээ, тэрхүү ганцаар-ахуйгаас үүссэн[209] хөөр-баяр аз-жаргалыг нэлэнхийд нь тарааж, нэвт шингээж, бүтэн дүүргэж, бүхэлд нь тарааж өгдөг бөгөөд ингэснээр түүний биед энэ хөөр-баяр аз-жаргалд автаагүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, халуун усны газар ажиллуулагч, туршлагатай нэгэн, эсвэл түүний туршлагагүй нэгэн суралцагч бээр угаалгын төмөр онгоцонд нунтаг саванг асгаж, усаар шүршиж, түүнийгээ бөмбөг хэлбэртэй болгож, нухан нухан зуурч байна гэж саная. Мөнөөх асгасан савангийн нунтаг тосонд нэвчсэн бөмбөг болж, бүхэлдээ, тэр чигээрээ, нэлэнхийдээ, гэхдээ ихдэж нялцайхгүйгээр, тос даасан байх болно.

Их хаантан минь, яг л үүний адилаар, хувраг хүн өөрийн биедээ, тэрхүү ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр аз-жаргалыг нэлэнхийд нь тарааж, нэвт шингээж, бүтэн дүүргэж, бүхэлд нь тарааж өгдөг бөгөөд ингэснээр түүний биед энэхүү хөөр-баяр, аз-жаргал автаагүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.12. Хоёрдугаар Даяан (Dutiyajhāna)

Цаашилбал хаантан минь, тэр хуврагийн зурвас-бодол, эргэцүүлсэн-бодол намжиж, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий, дотоод амар-амгалан, оюуны-нэгдэл[210] бүхий, хоёрдугаар даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байна. Тэр хувраг өөрийн биедээ, тэрхүү самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргалыг нэлэнхийд нь тарааж, нэвт шингээж, бүтэн дүүргэж, бүхэлд нь тарааж өгдөг бөгөөд ингэснээр түүний биед энэхүү хөөр-баяр аз-жаргалд автаагүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, ёроолоос нь ус ундран буй гүн нуур байна гэж бодъё. Түүний зүүн, баруун, хойд, урд, аль ч хэсгээс ус орох боломжгүй, үе үехэн орох бороны ус ч гэж үгүй аж. Гэсэн хэдий ч, нуурын ёроолоос боргилох хүйтэн усны ундарга, тэрхүү нуурыг бүхэлд нь норгож, нэвчээж, хангаж, дүүргэж өгснөөр тэр нуурын бүхий л өнцөг буланд сэрүүн ус очоогүй хэсэг нэгээхэн ч үгүй болно.

---

207 *Pītisukhaṁ*— "хөөр-баяр аз-жаргал бүхий". "Үгээр хэлэхийн аргагүй" аз жаргал гэсэн санаа буюу бясалгалаас үүсэх дээд зэргийн баяр баясал, аз жаргалантай байдал. Зарим бясалгалын уламжлалд тайлбарладгаар, бясалгагч энэ үед их хэмжээний баяр хөөрийг мэдэрснээс үүдэн асгартал уйлах нь элбэг гэж үзнэ. ("хөөр-баяр, "аз-жаргал"-ыг Лавлахад үз.)

208 Энэ хэсэгт гарах олон нэр томьёо DN 1.3.2-1.4.5-ын зүүлт тайлбарт орсон. Лавлахаас үз.

209 Мьянмар эхэд "таван-саад (*nīvaraṇa*)-ыг үгүй хийснээр үүссэн" гэжээ (MPA).

210 *Ekodibhāvaṁ*—"оюуны-нэгдэл" (анг. *one-pointedness*). Оюун санаа өөр юунд ч эс сатаарсан, юунд ч эс анхаарсан, оюун санаа дангаараа өөрөө нэгэн нэгдэл зүйл болсон (нэг зүйлд төвлөрсөн), нэн амгалан байдал. Өргөн хэрэглэдэг нэршил нь *ekaggatā* (сам. *ekāgratā*, анг. *unification of mind*). Энэ үгээс улбаалан "Төвлөрлийн Бясалгал" нэршил буруу, "Оюуны Нэгдлийн Бясалгал" нэршил зөв г.м. санаа түгээмэл бий.

Хаантан минь, яг л үүний адилаар, хувраг хүн өөрийн биедээ, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр, аз-жаргалыг нэлэнхийд нь тарааж, нэвт шингээж, бүтэн дүүргэж, бүхэлд нь тарааж өгдөг бөгөөд ингэснээр түүний биед энэхүү хөөр-баяр, аз-жаргалд автаагүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.13. Гуравдугаар Даян (Tatiyajhāna)

Цаашилбал хаантан минь, тэр хувраг, хөөр-баяраас салж-ангижирснаар, дүүрэн-анхаарал тунгалаг-оюун бүхий төв-оршихуйд байж, аз-жаргалыг бие махбодоороо[211] мэдрэх ба үүнийг Гэгээнтнүүд, “Төв-оршихуйд, дүүрэн-анхааралтай, аз-жаргалд умбав” хэмээн нэрийдэх буюу ингэж гуравдугаар даян зэрэгт хүрснээр, тэр оршин байна. Тэр хувраг өөрийн биедээ, хөөр-баяраас салсан[212] аз-жаргалыг нэлэнхийд нь тарааж, нэвт шингээж, бүтэн дүүргэж, бүхэлд нь тарааж өгдөг бөгөөд ингэснээр түүний биед, хөөр-баяраас салсан энэ аз-жаргалд автаагүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, хөх, улаан, цагаан бадамлянхуа[213] цэцэгс, цөөрмийн усанд төрж, тэр усандаа соёолж, тэр уснаас хөвж гаралгүйгээр, тэр усандаа дүрээтэйгээр дэлбээлэн цэцэглэдэг билээ. Бадамлянхуа цэцэгсийн нэгээхэн ч хэсэг сэрүүн уснаасаа ил гаралгүйгээр, үзүүрээсээ үндэс хүртлээ нэвт норсон, дэвтсэн, живсэн, дүрэгдсэн, тийм л байдалтай ургадаг билээ.

Хаантан минь, яг л үүний адилаар, хувраг өөрийн биедээ, хөөр-баяргүй аз-жаргалыг нэлэнхийд нь тарааж, нэвт шингээж, бүтэн дүүргэж, бүхэлд нь тарааж өгдөг бөгөөд ингэснээр түүний биед энэхүү аз-жаргалд автаагүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.14. Дөрөвдүгээр Даян (Catutthajhāna)

Цаашилбал хаантан минь, тэр хувраг, жаргалаас салж-ангижирснаар, зовлонгоос салж-ангижирснаар, урьдын таатай хийгээд таагүй байдал алга болсноор, жаргал зовлонгийн аль нь ч бус, төв-оршихуйгаас үүссэн дүүрэн-анхаарлын ариусал, дөрөвдүгээр даян зэрэгт хүрснээр, тэр оршин байна. Тэр хувраг

211 Мьянмар эхэд “бие болон сэтгэлээрээ” мэдэрнэ гэжээ (MPA).

212 Хөөрцөглөсөн байдал алга болж, цэвэр аз жаргалтай байдлыг мэдэрнэ гэсэн санаа.

213 Зарим монгол тайлбарт (Монгол Википедиа г.м.) зөв ботаник нэршил нь “цацаргин” цэцэг гэжээ. *Uppala*—хөх бадамлянхуа (лат. *nymphaea*); *paduma*—улаан бадамлянхуа; *puṇḍarīka*—цагаан бадамлянхуа. (лат. *nelumbo nucifera*. анг. *lotus* эсвэл *lily*)

энэхүү өөрийн биеэ, тод гэрэлтсэн, ариуссан сэтгэл оюунаар[214] бүхэлд нь бүрж суух ба, ингэснээр түүний биед, энэ тод гэрэлтсэн, ариуссан сэтгэл оюунд бүрхэгдээгүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, хэн нэгэн хүн, өөрийн биеийнхээ нэгээхэн ч хэсгийг ил гаргахгүйн тулд, цагаан даавуугаар толгойгоос доош, хөлийн үзүүр хүртэл тэр чигт нь бүтээгээд, нөмрөөд сууж байна гэж бод.

Хаантан минь, яг л үүний адилаар, тэр хувраг өөрийн биеэ, төгс ариуссан, гэрэл цацарсан сэтгэлээр бүхэлд нь бүрж суух ба, ингэснээр түүний биед, энэхүү гэрэл цацарсан, төгс ариуссан сэтгэлд бүрхэгдээгүй нэгээхэн ч хэсэг үгүй болсон байна.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.15. Илтэд Харахуйн Мэдлэг (Vipassanāñāṇa)

Ийнхүү, түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир[215] үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах[216] тэр түвшинд хүрсэн энэ үед тэрээр, илтэд танихуйн мэдлэг[217] өөд, оюунаа хандуулан бясалгана.

Тэрбээр:

“Энэ миний бие бол язгуур дөрвөн махбодоос бүрэлдсэн, эцэг эхээс улбаалан ирсэн, будаатай шөлөөр[218] тэжээгдэн тэтгэгдсэн, үрэгддэг бас элэгддэг, үхдэг бас дуусдаг жамтай. Харин энэ миний оюун-ухамсар[219] бол энэ биед суусан, энэ биед уягдсан юм.” гэж ойлгож ухаарна.

Их хаантан минь, найман талт, нарийн зүссэн, усан болор, тув тунгалаг, нэвт гэрэлтсэн, өөлөх юмгүй, өөртөө бүхий л сайн чанаруудыг агуулсан, гоёмсог эрдэнийн чулуу байлаа гэж бодъё. Мөн энэ чулууны голоор хөх, шар, улаан, цагаан, хүрэн, алтан өнгийн гоёмсог судал харвасан байх аж.

---

214 *Cetasā*—“сэтгэл оюунаар”. Сэтгэл санаа, санаа бодол, зүрх сэтгэлээр гэж ойлгож болно.

215 *Kilesā*—“сэтгэлийн-хир” (анг. *mental defilement*, сам. *Klesha*). Эртний Буддизмын тайлбар ёсоор, Мунхаг-төөрөгдөл, Дон шунал, Уур-хилэн (*avijjā, lobha, dosa*) гурваас үүдэлтэй үндсэн: 1. шунал (*lobha*); 2. уур-хилэн (*dosa*); 3. төөрөгдөл (*moha*); 4. бардамнал (*māna*); 5. элдэв үзэлд автах (*diṭṭhi*); 6. эргэлзээ-тээнэгэлзээ (*vicikicchā*); 7. залхуурал (*thīna*); 8. сэтгэл түгшил (*uddhacca*); 9. ёс-зүйн-ичгүүр үгүй байдал (*ahirika*); 10. ёс-зүйн-айдас үгүй байдал (*anottappa*) болон атаархах, гуниглах, занах, зүхэх, дооглох г.м. оюуныг булингартуулж, зовлонд хөтөлдөг тусгүй-муу сэтгэлийн байдлыг хэлнэ.

216 Сургаал бус үгэнд автахгүй байх буюу тэдгээрийн нөлөөнд итгэл сэтгэл эс ганхах.

217 *Ñāṇadassanāya*—“илтэд танихуйн мэдлэг”. Өөрөөр, “харахуй, ухаарахуйн мэдлэг”, “мэдлэг, ухаарлаар харахуй”.

218 *Odanakummāsūpacayo*—“будаатай шөл”. Эсвэл “сүүтэй будаа”, “чанасан будаа”.

219 *Viññāṇa*—“оюун-ухамсар” (анг. *consciousness*, сам. *vijñāna*). Эртний Буддизмд *viññāṇa*-г юмсыг таних сэрэмж байдал буюу танин мэдэх оюуны чадвар гэж тодорхойлдог ба нөхцөл байдлаас хамааран үүсэж, мөн үгүй болдог түр зуурын үйл явц гэж үзнэ. Энэ нь дотроо зургаа буюу: 1. нүдний-ухамсар; 2. чихний-ухамсар; 3. хамрын-ухамсар; 4. хэлний-ухамсар; 5. биеийн-ухамсар; 6. оюуны-ухааны-ухамсар. Оюун-ухамсар нь таван-цулын (*pañcakhandhā*) нэг болно. (Тайлбарт буй Таван-Цул-ыг үз.)

Хараа сайтай нэгэн бээр, гартаа чулууг атгаж бариад:

“Энэ бол, найман талт, нарийн зүссэн, усан болор, тув тунгалаг, нэвт гэрэлтсэн, өөлөх юмгүй, өөртөө бүхий л сайн чанаруудыг агуулсан, гоёмсог эрдэнийн чулуу байна. Тэгээд ч зогсохгүй, дундуур нь хөх, шар, улаан, цагаан, хүрэн, алтан өнгийн гоёмсог судал хүртэл гүйжээ.” хэмээн ойлгох болно.

Их хаантан минь, яг л үүний адилаар, хувраг хүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн энэ үед тэрээр, илтэд танихуйн мэдлэг өөд, оюунаа хандуулан бясалгана.

Тэрбээр:

“Энэ миний бие бол язгуур дөрвөн махбодоос бүрэлдсэн, эцэг эхээс улбаалан ирсэн, будаатай шөлөөр тэжээгдэн тэтгэгдсэн, үрэгддэг бас элэгддэг, ухдэг бас дуусдаг жамтай. Харин энэ миний оюун-ухамсар бол энэ биед суусан, энэ биед уягдсан юм.” хэмээн ойлгож ухаарна.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.16. Оюунаар-Бүтсэн Ид-Чадлын Мэдлэг (Manomayiddhiñāṇa)

Түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, оюунаар-бүтсэн биеийг[220] бүтээхүй өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрбээр, өөрийн биеэсээ хэлбэр дүрстэй[221], оюунаар-бүтсэн, бүх эрхтэн бүтэн, бүх чадвар бүрэн, өөр нэгэн биеийг бий болгоно.

Их хаантан минь, хэн нэгэн хүн, зэгснээс түрүүг нь суга татаж авлаа гэж бодъё.

Тэрбээр:

‘Энэ бол түрүү. Энэ бол зэгс. Түрүү бол нэг юм. Зэгс нь арай өөр юм. Гэхдээ, энэ түрүү энэ зэгснээс л сугарч гарсан.’ хэмээн бодож болно.

Эсвэл хэн нэгэн хүн, сэлмийг хуйгаас нь суга татаж авлаа гэж бодъё.

Тэрбээр:

‘Энэ бол сэлэм. Энэ бол хуй. Сэлэм бол нэг зүйл. Хуй нь арай өөр зүйл. Гэхдээ, сэлэм бол хуйгаас л сугарч гарсан.’ хэмээн бодож болно.

---

220 *Manomayaṁ kāyaṁ*—“оюунаар-бүтсэн бие” (анг. “*mind-made body*”). Гүн бясалгалаар бий болсон, бүдүүн бие махбодоос ялгаатай, нарийн түвшний, энергид суурилсан бие. Ахисан түвшний бясалгалаар эгэл хүмүүний чадвараас хальж, нарийн, далд ертөнцийг мэдрэх, өөрийн биеийг энэ биеэрээ төлөөлүүлэх, өөр бусад ил бус биетүүдтэй харилцах ид-чадал (*iddhi*) хүчний илэрхийлэл.

221 *Rūpiṁ*—“хэлбэр дүрстэй”. Энд “материаллаг” гэсэн утгаар.

Эсвэл хэн нэгэн хүн, могойг хайрснаас нь мулз татаж гаргалаа гэж бодъё.

Тэрээр:

‘Энэ бол могой. Энэ бол хайрс. Могой бол нэг зүйл. Хайрс бол арай өөр зүйл. Гэхдээ, могой хайрснаас л сугарч гарсан.’ хэмээн бодож болно.

Их хаантан минь, яг л үүнтэй адил, хувраг хүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, оюунаар-бүтсэн биеийг бүтээхүй өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрбээр, өөрийн биеэсээ хэлбэр дүрстэй, оюунаар-бүтсэн, бүх эрхтэн бүтэн, бүх чадвар бүрэн, өөр нэгэн биеийг бий болгоно.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даяанч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.17. Ид-Чадлын Олон Төрөлт Мэдлэг (Iddhividhañāṇa)

Түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, ид-чадлын[222] олон төрөл хэлбэр өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрбээр, ид-чадлын янз бүрийн хэлбэрийг хөгжүүлэхдээ, нэг байсан бол олон болж, олон болсон бол эргэж нэг болно. Тэр гарч ирнэ, алга болно. Тэрбээр цайз хэрэм, хашаа бэхлэлт, уул хад дундуур, огторгуйгаар дүүлэн нисэх мэт саадгүй нэвтрэн явна. Тэр усанд шумбаад эргэж гарч ирэх мэт, энэ дэлхийгээс гарч, энэ дэлхий рүү эргэж орно. Тэрээр, газар дээгүүр явах мэт усан дээгүүр явна. Тэрээр, завилан суух атлаа шувуу нисэх мэт тэнгэрээр аялна. Тэрээр агуу хүчийг олж, нар саранд гараараа хүрнэ, цохино. Тэрбээр, Бярман Тэнгэрийн Орон хүртэл өөрийн биеийг эзэмдэн хөгжүүлнэ.

Их хаантан минь, туршлагатай нэгэн ваарчин, эсвэл түүний туршлагагүй суралцагчид байг гэж бодъё. Тэд сайтар гэгч нь бэлтгэсэн шавраараа хүссэн төрлийн дүрс маяг, хэлбэр загвар бүхий ваар сав урлаж чаддаг.

Эсвэл, туршлагатай нэгэн сийлбэрчин, эсвэл түүний туршлагагүй суралцагчид байг гэж бодъё. Тэд сайтар гэгч нь бэлтгэсэн зааны ясаараа хүссэн төрлийн дүрс маяг, хэлбэр загвар бүхий гоёл чимэглэл урлаж чаддаг.

Эсвэл, туршлагатай нэгэн алт мөнгөний дархан, эсвэл түүний туршлагагүй суралцагчид байг гэж бодъё. Тэд сайтар гэгч нь бэлтгэсэн алтаараа хүссэн төрлийн дүрс маяг, хэлбэр загвар бүхий алтан эдлэл урлаж чаддаг.

---

[222] *Iddhi*—“ид-чадал”. Эсвэл ид, хүч. Сахил болон бясалгалын үр дүнд, оюуныг гарамгай хөгжүүлснээр олох “оюуны ид хүч”, эсвэл зарим тохиолдолд оюун билгийн “ид шид”. Эртний судрын тайлбар судраар дөрвөн ид-чадал бий: 1. хүсэл зоригийн; 2. эрч хүчний; 3. сэтгэлийн; 4. задлан шинжихүйн. Зарим хэсэгт “ид-чадал”, “ид-чадлын хүч” гэж оруулав.

Их хаантан минь, яг л үүнтэй адил, хувраг хүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, ид-чадлын олон төрөл хэлбэр өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрбээр, ид-чадлын янз бүрийн хэлбэрийг хөгжүүлэхдээ, нэг байсан бол олон болж, олон болсон бол эргэж нэг болно. Тэр гарч ирнэ, алга болно. Тэрбээр цайз хэрэм, хашаа бэхлэлт, уул хад дундуур, огторгуйгаар дүүлэн нисэх мэт саадгүй нэвтрэн явна. Тэр усанд шумбаад эргэж гарч ирэх мэт, энэ дэлхийгээс гарч, энэ дэлхий рүү эргэж орно. Тэрээр, газар дээгүүр явах мэт усан дээгүүр явна. Тэрээр, завилан суух атлаа шувуу нисэх мэт тэнгэрээр аялна. Тэрээр агуу хүчийг олж, нар саранд гараараа хүрнэ, цохино. Тэрбээр, Бярман Тэнгэрийн Орон хүртэл өөрийн биеийг эзэмдэн хөгжүүлнэ.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.18. Тэнгэрлэг Сонорын Мэдлэг (Dibbasotañāṇa)

Түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, тэнгэрлэг сонорын мэдлэг[223] өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрээр, цэвэршиж ариуссан, эгэл хүний боломжоос хальсан тэнгэрлэг сонорын тусламжтайгаар, холын, ойрын, хүмүүн хийгээд бурхдын, аль алиных нь дуу авиаг сонсдог.

Их хаантан минь, зам дагуу нэгэн хүн явж байлаа гэж бодъё. Тэрбээр, хэнгэрэг, шавар бөмбөр, эвэр бүрээ, цан, цэргийн бөмбөр зэрэг олон чимээг сонсох болно. Тэгээд тэрбээр: ‘Энэ бол хэнгэргийн чимээ байна.’, ‘энэ бол шавар бөмбөрийн чимээ байна.’, ‘энэ бол эвэр бүрээ, энэ бол цан, мөн энэ бол цэргийн бөмбөрийн чимээ байна.’ гэх зэргээр бодох болно.

Их хаантан минь, яг л үүнтэй адил, хувраг хүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, тэнгэрлэг сонорын мэдлэг өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрээр, цэвэршиж ариуссан, эгэл хүний боломжоос хальсан тэнгэрлэг сонорын тусламжтайгаар, холын, ойрын, хүмүүн хийгээд бурхдын, аль алиных нь дуу авиаг сонсдог.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

---

[223] *Dibbāya sotadhātuyā*—“тэнгэрлэг сонорын мэдлэг”. (*dibba:* “тэнгэрлэг”, “Тэнгэрийн орны”; *sota:* чих; *dhātu:* чадамж) Зарим орчуулгад “мэргэн сонор” (анг. *clairaudience*) гэжээ (BS).

4.19. Бусдын Сэтгэлийг Таних Мэдлэг (Cetopariyañāṇa)

Түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, бусдын сэтгэлийг таних мэдлэг[224] өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрбээр, өөрийн оюун бодлоороо эргэцүүлэн бясалгаснаар, аливаа бодгаль хийгээд хүмүүсийн оюун санааг таньж мэднэ.

Тэрээр, дур-хүсэлтэй сэтгэлийг ‘дур-хүсэлтэй сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн дур-хүсэлгүй сэтгэлийг ‘дур-хүсэлгүй сэтгэл’ байна гэж мэднэ.

Тэрээр, уур-хилэнтэй сэтгэлийг ‘уур-хилэнтэй сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн уур-хилэнгүй сэтгэлийг ‘уур-хилэнгүй сэтгэл’ байна гэж мэднэ.

Тэрээр, төөрөгдөлтэй[225] сэтгэлийг ‘төөрөгдөлтэй сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн төөрөгдөл үгүй сэтгэлийг ‘төөрөгдөл үгүй сэтгэл’ байна гэж мэднэ.

Тэрээр, давчуу сэтгэлийг ‘давчуу сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн үймэрсэн сэтгэлийг ‘үймэрсэн сэтгэл’ байна гэж мэднэ.

Тэрээр, агуу сэтгэлийг ‘агуу сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн өчүүхэн сэтгэлийг ‘өчүүхэн сэтгэл’ байна гэж мэднэ.

Тэрээр, төгөлдөр бус сэтгэлийг ‘төгөлдөр бус сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн төгөлдөр сэтгэлийг ‘төгөлдөр сэтгэл’ байна гэж мэднэ.

Тэрээр, төвлөрсөн сэтгэлийг ‘төвлөрсөн сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн төвлөрөл үгүй сэтгэлийг ‘төвлөрөл үгүй сэтгэл’ байна гэж мэднэ.

Тэрээр, ангижирсан сэтгэлийг ‘ангижирсан сэтгэл’ байна гэж мэднэ. Мөн ангижраагүй сэтгэлийг ‘ангижраагүй сэтгэл’ байна гэж мэднэ.

Их хаантан минь, гоёж гоодох дуртай идэр залуухан нэгэн бүсгүй, эсвэл нэгэн хархүү байлаа гэж бодъё. Тэд, цэвэр тунгалаг толинд, эсвэл тунгалаг устай аяганд зүс царайгаа шинжин байна. Тэдэнд хэрэв, сэвх толбо байх аваас, ‘Надад сэвх толбо байна.’ гэж тэр дор нь мэдэх байсан. Хэрэв тэдэнд, сэвх толбо үгүй бол, ‘Надад сэвх толбо үгүй юм.’ гэж шууд л мэдэх болно.

Их хаантан минь, яг л үүнтэй адил, хувраг хүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, бусдын сэтгэлийг таних мэдлэг өөд, оюунаа хандуулан бясалгана.

---

224 *Cetopariyañāṇāya*—“бусдын сэтгэлийг таних мэдлэг”. Эсвэл “бусдын бодлыг мэдэх”, бусдын бодлыг “унших”.

225 *Samohaṁ*—“төөрөгдөлтэй”. Өөрөөр “төөрөгдөлд автсан”. *Moha*—“төөрөгдөл”. Мунхаг-төөрөгдлийн илрэл буюу тусгүй-муу үйлийг хийхэд гол шалтгаан нөхцөл болдог, сэтгэлийн гүний төөрсөн, андуурсан, сохорсон байдал. Арван сэтгэлийн-хирийн нэг болно.

Тэрбээр, өөрийн оюун бодлоороо эргэцүүлэн бясалгаснаар, аливаа бодгаль хийгээд хүмүүсийн оюун санааг таньж мэднэ.

Тэрээр, дур-хүсэлтэй сэтгэлийг 'дур-хүсэлтэй сэтгэл' байна гэж мэднэ. Мөн дур-хүсэлгүй сэтгэлийг 'дур-хүсэлгүй сэтгэл' байна гэж мэднэ.

Тэрээр, уур-хилэнтэй сэтгэлийг 'уур-хилэнтэй сэтгэл' байна гэж мэднэ. Мөн уур-хилэнгүй сэтгэлийг 'уур-хилэнгүй сэтгэл' байна гэж мэднэ.

Тэрээр, төөрөгдөлтэй сэтгэлийг 'төөрөгдөлтэй сэтгэл' байна гэж мэднэ. Мөн төөрөгдөл үгүй сэтгэлийг 'төөрөгдөл үгүй сэтгэл' байна гэж мэднэ.

Тэрээр, давчуу сэтгэлийг 'давчуу сэтгэл' байна гэж мэднэ. Мөн үймэрсэн сэтгэлийг 'үймэрсэн сэтгэл' байна гэж мэднэ.

Тэрээр, агуу сэтгэлийг 'агуу сэтгэл' байна гэж мэднэ. Мөн өчүүхэн сэтгэлийг 'өчүүхэн сэтгэл' байна гэж мэднэ.

Тэрээр, төгөлдөр бус сэтгэлийг 'төгөлдөр бус сэтгэл' байна гэж мэднэ. Мөн төгөлдөр сэтгэлийг 'төгөлдөр сэтгэл' байна гэж мэднэ.

Тэрээр, төвлөрсөн сэтгэлийг 'төвлөрсөн сэтгэл' байна гэж мэднэ. Мөн төвлөрөл үгүй сэтгэлийг 'төвлөрөл үгүй сэтгэл' байна гэж мэднэ.

Тэрээр, ангижирсан сэтгэлийг 'ангижирсан сэтгэл' байна гэж мэднэ. Мөн ангижраагүй сэтгэлийг 'ангижраагүй сэтгэл' байна гэж мэднэ.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.20. Урд Төрлүүдээ Эргэн Санах Мэдлэг (Pubbenivāsānussatiñāṇa)

Түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, урд төрлүүдээ эргэн санах мэдлэг өөд, оюунаа хандуулан бясалгана.

Тэрээр урд олон төрлөө, өөрөөр хэлбэл, нэг, хоёр, гурав, дөрөв, тав, арав, хорь, гуч, дөч, тавь, зуу, мянга, зуун мянган төрлүүдээ, эргэн санадаг. Эсвэл бүр, энэ хорвоо ертөнцийн олон галав мөхөж, олон галав мандсан, асар эрт цагийн, өөрийн урд төрлүүдээ тэд ийн санана:

'Тэр урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг

байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би энд дахин төрсөн билээ.' хэмээн эргэн санадаг.

Ийм маягаар тэр, энэ хорвоо ертөнцийн олон галав мөхөж, олон галав мандсан, асар эрт цагийн, өөрийн урд төрлүүдээ онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санадаг.

Их хаантан минь, хэн нэг хүн, төрөлх тосгоноо орхин, өөр тосгон руу явлаа гэж бодъё. Тэр тосгоноос тэр гараад, бас өөр нэгэн тосгон руу явжээ. Тэгээд тэрхүү тосгоноос тэрбээр, эргээд төрөлх тосгон уруугаа буцлаа гэж бодъё.

Тэгээд тэрбээр:

'Би төрсөн тосгоноо орхин, өөр тосгон руу явсан билээ. Тэнд би, ингэж зогсоод, ингэж суугаад, ингэж яриад, эсвэл ингээд чимээгүй байсан. Тэр тосгоноос би, өөр бас нэгэн тосгон руу гарч явсан билээ. Тэнд ч би, мөн ингэж зогсоод, ингэж суугаад, ингэж яриад, эсвэл ингээд чимээгүй байсан. Тэгээд, тэрхүү тосгоноос эргээд би энэ төрөлх тосгондоо буцаж ирсэн.' хэмээн бодож болно.

Их хаантан минь, яг л үүнтэй адил, хувраг хүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үед тэрээр, урд төрлүүдээ эргэн санах мэдлэг өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрээр урд олон төрлөө, өөрөөр хэлбэл, нэг, хоёр, гурав, дөрөв, тав, арав, хорь, гуч, дөч, тавь, зуу, мянга, зуун мянган төрлүүдээ, эргэн санадаг. Эсвэл бүр, энэ хорвоо ертөнцийн олон галав мөхөж, олон галав мандсан, асар эрт цагийн, өөрийн урд төрлүүдээ тэд ийн санана:

'Тэр урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би энд дахин төрсөн билээ.' хэмээн эргэн санадаг.

Ийм маягаар тэр, энэ хорвоо ертөнцийн олон галав мөхөж, олон галав мандсан, асар эрт цагийн, өөрийн урд төрлүүдээ онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санадаг.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.21. Тэнгэрлэг Мэлмийн Мэдлэг (Dibbacakkhuñāṇa)

Түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үедээ тэр, бодгалиудын үхэхүй хийгээд төрөхүйн мэдлэг өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрээр, цэвэршиж

ариуссан, эгэл хүмүүний боломжоос хальсан тэнгэрлэг мэлмийгээр[226], өчүүхэн эсвэл агуу, үзэсгэлэнтэй эсвэл үзээрийн, хувьтай эсвэл хувьгүй, энэ хорвоогийн бүх л бодгалийн сайхан газарт[227], эсвэл муухай газарт[228], хийсэн үйлийнхээ дагуу үхэж буйг нь, мөн дараа төрөл авч буйг нь хараад, тэд ийн ойлгоно:

‘Хөөрхий тэдгээр бодгалиуд, биеэрээ буруу үйлд автсан, яриагаараа буруу үйлд автсан, сэтгэлээрээ буруу үйлд автсан байжээ. Тэд, Гэгээнтнүүдийг хэл амаар доромжилдог байж, буруу үзэлд автсан байж, тэр автсан буруу үзлээрээ тэдгээр муу үйлийг хийсэн байжээ. Үхсэний дараа, бие цогцос нь задрахын цагт, муу ёрын төрөлд, зовлонт төрөлд, доод төрөлд, тамд, тэд дараагийн төрлөө авчээ.

Харин эдгээр бодгалиуд, биеэрээ сайныг үйлддэг, яриагаараа сайныг үйлддэг, сэтгэлээрээ сайныг үйлддэг байжээ. Тэд, Гэгээнтнүүдийг хэзээ ч хэл амаар доромжилдоггүй байж, зөв үзэлд автсан байж, тэр автсан зөв үзлээрээ тэдгээр сайн үйлийг хийсэн байжээ. Үхлийн дараа, бие цогцос нь задрахын цагт, сайн төрөлд, тэнгэрлэг оронд, тэд дараагийн төрлөө авчээ.’

Ингэж тэрээр, цэвэршиж ариуссан, эгэл хүмүүний боломжоос хальсан тэнгэрлэг мэлмийгээр, өчүүхэн эсвэл агуу, үзэсгэлэнтэй эсвэл үзээрийн, хувьтай эсвэл хувьгүй, энэ хорвоогийн бүх л бодгалийн сайхан газарт, эсвэл муухай газарт, хийсэн үйлийнхээ дагуу үхэж буйг нь, мөн дараа төрөл авч буйг нь хардаг.

Их хаантан минь, нэгэн төв талбайн дэргэд, өндөр сайхан орд харш байж гэж бодъё. Тэр өндөр орд өргөөний дээд давхраас, хараа сайтай нэгэн бээр нааш цааш орж гарах, гудамж замаар холхих, төв талбай дээр суух хүмүүсийг ажиглаад зогсож байж гэж бодъё.

Тэгээд тэрбээр:

‘Эдгээр хүмүүс, нааш цааш орж гарч, гудамж замаар алхаж холхиж, төв талбай дээр зарим нь сууцгааж байна даа.’ хэмээн бодож болох юм.

Их хаантан минь, яг л үүнтэй адил, сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн, энэ үедээ тэр, бодгалиудын үхэхүй хийгээд төрөхүйн мэдлэг өөд, оюунаа хандуулан бясалгана. Тэрээр, цэвэршиж ариуссан, эгэл хүмүүний боломжоос хальсан тэнгэрлэг мэлмийгээр, өчүүхэн эсвэл агуу, үзэсгэлэнтэй эсвэл үзээрийн, хувьтай эсвэл хувьгүй, энэ хорвоогийн бүх л бодгалийн сайхан газарт, эсвэл муухай газарт, хийсэн үйлийнхээ дагуу үхэж буйг нь, мөн дараа төрөл авч буйг нь хараад, тэд ийн ойлгоно:

‘Хөөрхий тэдгээр бодгалиуд, биеэрээ буруу үйлд автсан, яриагаараа буруу үйлд автсан, сэтгэлээрээ буруу үйлд автсан байжээ. Тэд, Гэгээнтнүүдийг хэл амаар доромжилдог байж, буруу үзэлд автсан байж,

---

226 *Dibbena cakkhunā*—“тэнгэрлэг мэлмийгээр”. (*dibba:* “тэнгэрлэг”, “Тэнгэрийн орны”; *cakkhu:* нүд) Зарим орчуулгад “далдыг харахуй” гэжээ (анг. *clairvoyance*) (BS).

227 *Sugate*—“сайхан газарт”. Бурхны болон хүмүүний төрөл, орон.

228 *Duggate*—“муухай газарт”. Там, өлсгөлөн-сүнс болон амьтны төрөл, орон.

тэр автсан буруу үзлээрээ тэдгээр муу үйлийг хийсэн байжээ. Үхсэний дараа, бие цогцос нь задрахын цагт, муу ёрын төрөлд, зовлонт төрөлд, доод төрөлд, тамд, тэд дараагийн төрлөө авчээ.

Харин эдгээр бодгалиуд, биеэрээ сайныг үйлддэг, яриагаараа сайныг үйлддэг, сэтгэлээрээ сайныг үйлддэг байжээ. Тэд, Гэгээнтнүүдийг хэзээ ч хэл амаар доромжилдоггүй байж, зөв үзэлд автсан байж, тэр автсан зөв үзлээрээ тэдгээр сайн үйлийг хийсэн байжээ. Үхлийн дараа, бие цогцос нь задрахын цагт, сайн төрөлд, тэнгэрлэг оронд, тэд дараагийн төрлөө авчээ.'

Ингэж тэрээр, цэвэршиж ариуссан, эгэл хүмүүний боломжоос хальсан тэнгэрлэг мэлмийгээр, өчүүхэн эсвэл агуу, үзэсгэлэнтэй эсвэл үзээрийн, хувьтай эсвэл хувьгүй, энэ хорвоогийн бүх л бодгалийн сайхан газарт, эсвэл муухай газарт, хийсэн үйлийнхээ дагуу үхэж буйг нь, мөн дараа төрөл авч буйг нь хардаг.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс илүү дээр, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

4.22. Оюуны-Хорлолыг Үгүй Хийх Мэдлэг (Āsavakkhayañāṇa)

Түүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн энэ үед тэрээр, оюуны-хорлолыг[229] нэгэнт үгүй хийхүйн мэдлэг өөд оюунаа хандуулан бясалгана.

Тэрбээр:

'Энэ бол зовлон.' гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

'Энэ бол зовлонгийн шалтгаан.' гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

'Энэ бол зовлонгийн төгсгөл.' гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

'Энэ бол зовлонгийн төгсгөлд хүргэх замнал.' гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

'Энэ бол оюуны-хорлол.' гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

---

229 *Āsava*—"оюуны-хорлол" (сам. *āsrava,* анг. *taints* эсвэл *cankers*). Биднийг үхэх-төрөхийн эргэлтэд уяж, Гэгээрлээс холдуулж буй, сэтгэлийн гүний тусгүй-муу чанар болох: 1. мэдрэхүйн-таашаалд шунасан (*kāmāsava*); 2. оршихуйд шунасан (*bhavāsava*); 3. мунхаг-төөрөгдөлд автсан (*avijjāsava*); мөн нэмэгдэж 4. үзэлд автсан (*diṭṭhāsava*) оюуны-хорлолууд орно.

‘Энэ бол оюуны-хорлолын шалтгаан.’ гэж яг байгаагаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол оюуны-хорлолын төгсгөл.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол оюуны-хорлолын төгсгөлд хүргэх замнал.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Ингэж ухаарч мэдсэнээр, ингэж ойлгож харснаар, түүний мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлолд[230] автсан сэтгэл ангижралыг олж, оршихуйн оюуны-хорлолд[231] автсан сэтгэл ангижралыг олж, мунхаг-төөрөгдлийн[232] оюуны-хорлолд автсан сэтгэл нь ангижралыг олдог[233].

Ингэж тэр эрх чөлөөг олсноор түүнд, “ангижирлаа” гэсэн мэдлэг ухаан бий болдог.

Тэрбээр:

‘Дахин төрөхүй[234] үгүй болов, ариуслын-замнал өндөрлөв, хийх учиртайгаа хийв, ингээд ирээдүйн үргэлжлэл үгүй болов.’ хэмээн ухаардаг.[235]

Их хаантан минь, нэгээхэн уулын бэлд, болор тунгалаг, шил толь мэт, буртаг булингаргүй нэгэн нуур байж гэж бодъё. Нуурын эрэг дээр зогсох хараа сайтай нэгэн бээр энэ нуурын хясаа, дун, хайрга, чулуу болон сүрэг загас нааш цааш эргэлдэж, эсвэл нэг газраа хөдлөхгүй байгааг харна.

Тэрбээр:

‘Энэ нуур бол, болор тунгалаг, шил толь мэт, буртаг булингаргүй, тийм нуур юм. Энэ нуурт, хясаа, дун, хайрга, чулуу байна. Сүрэг загас нааш цааш эргэлдэж, эсвэл нэг газраа хөдлөхгүй байх ажээ.’ хэмээн харж болох юм.

Их хаантан минь, яг л үүнтэй адил, хувраг хүний сэтгэл самади-төвлөрөлд оршсон, төгс ариуссан, гэрэл цацарсан, өө сэвгүй, сэтгэлийн-хир үгүй болсон, уян зөөлөн, уян хатан болсон, тогтворжсон, эс ганхах тэр түвшинд хүрсэн энэ үед тэрээр, оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийхүйн мэдлэг өөд оюунаа хандуулан бясалгана.

Тэрбээр:

---

230 *Kāmāsava*—“мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол”. Таван мэдрэхүйн хүсэл, таашаал, мэдрэмжид шунасан оюуны-хорлол.

231 *Bhavāsava*—“оршихуйн оюуны-хорлол”. Оршихуй (*bhava*)-д шунах оюуны-хорлол. Оршихуй-г Лавлахад үз.

232 *Avijjā*—“мунхаг-төөрөгдөл”. Эртний Буддизмын тайлбараар, “Гэгээнтний Дөрвөн Үнэнийг мэдэхгүй, ойлгохгүй, ухаарахгүй байх, үүнээс болж төөрөлдөх, саруул-ухаан-аар харахгүй байгаа гэгээрээгүй хүний ухаан.” (Тайлбарт дэлгэрэнгүй үз.)

233 *Vimuccati*—“ангижралыг олдог”. “Эрх чөлөөг олох”, “салан одох” гэсэн утгаар.

234 *Jāti*—“Дахин төрөхүй” (анг. *birth* эсвэл *rebirth*). DN 1.5.3; DN 15.1 болон Тайлбар-т дэлгэрэнгүй үз.

235 “...үргэлжлэл үгүй болов” гэдгээр Төгс гэгээрлийг олж буйг хэлсэн санаа.

‘Энэ бол зовлон.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол зовлонгийн шалтгаан.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол зовлонгийн төгсгөл.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол зовлонгийн төгсгөлд хүргэх замнал.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол оюуны-хорлол.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол оюуны-хорлолын шалтгаан.’ гэж яг байгаагаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол оюуны-хорлолын төгсгөл.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол оюуны-хорлолын төгсгөлд хүргэх замнал.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Ингэж ухаарч мэдсэнээр, ингэж ойлгож харснаар, түүний мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлолд автсан сэтгэл ангижралыг олж, оршихуйн оюуны-хорлолд автсан сэтгэл ангижралыг олж, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлолд автсан сэтгэл нь ангижралыг олдог.

Ингэж тэр эрх чөлөөг олсноор түүнд, “ангижирлаа” гэсэн мэдлэг ухаан бий болдог.

Тэрбээр:

‘Дахин төрөхүй үгүй болов, ариуслын-замнал өндөрлөв, хийх учиртайгаа хийв, ингээд ирээдүйн үргэлжлэл үгүй болов.’ хэмээн ухаардаг.

Их хаантан минь, энэ бол өмнөх зүйлүүдээс гоц илүү, энэ насанд үзэгдэж харагдах, даянч замналын дээд зэргийн үр шим билээ.

Их хаантан минь, даянчийн замналаас энэ насанд гарах, үзэгдэх харагдах, үүнээс илүү сайн, үүнээс дээгүүр үр шим, өгөөж ашиг гэж огтоос үгүй билээ.”

5. Ажаатасатту Хаан Шавь Болсноо Зарлав (Ajātasattuupāsakattapaṭivedanā)

Буддаг ийн айлдаж дуусахад, Ажаатасатту хаан түүнд хэлэв:

“Төгс төгөлдөр юм, Эрхэм Багш аа! Төгс төгөлдөр юм, Эрхэм Багш аа!

Хөмөрч унасан нэгнийг эргүүлж босгох мэт, эсвэл далд нууц зүйлийг илчилж харуулах мэт, замаасаа төөрсөн нэгэнд замыг нь зааж өгөх мэт, түнэр харанхуй газар гэрэл дэнлүү асаахад, хараа сайтай нэгэн бээр тэнд байсан зүйлийг нь олж харах мэт, Будда өөрийн Сургаалаа олон аргаар тайлбарлаж, ойлгуулж өглөө надад. Би, Будда, Сургаал, Хуврагийн Чуулганы нөмөрт очиж байна.[236] Будда, намайг энэ өдрөөс эхлэн насан туршдаа, түүний нөмөрт очсон, түүний сахилтан шавь болсон гэдгийг минь санах болтугай.

Эрхэм Багш аа, би том алдаа хийсэн юм. Би тэнэглэл, мунхаглал, төөрөгдөлд автан, эрх мэдлийн төлөө шударга явдалт хүмүүн, шударга явдалт хаан, өөрийн эцгийн амийг хөнөөсөн билээ. Ерөөлтэй Нэгэн минь, би үйлдсэн гэм буруугаа гэм буруу гэж ухамсарлаж, үлдсэн амьдралдаа өөрийгөө хатамжилж байгаагаар минь ойлгон хүлээн авна уу.” гэв.

“Их хаан та, үнэнхүү том алдааг хийсэн. Тэнэглэл, мунхаглал, төөрөгдөлд автан, эрх мэдлийн төлөө шударга явдалт хүмүүн, шударга явдалт хаан эцгийн амийг хөнөөсөн билээ. Гэхдээ та гэм буруугаа ухамсарлаж, өөрийн үйлдсэн гэм бурууг үлдсэн амьдралдаа өөрийгөө хатамжилснаар, Сургаал ёсоор залруулах гэж оролдож буй тул бид үүнийг тань хүлээн авч ойлгож байна. Учир юу гэвэл, ‘Өөрийн хийсэн гэм бурууг гэм буруу гэж таньж ухаарч, Сургаал ёсоор залруулахыг оролдож, ирээдүйд хатамжлалыг олно.’ гэдэг бол Гэгээнтэн хүний сахил хатамжлалын замналын нэгээхэн хэсэг мөн билээ.”

Буддаг ийн айлдаж дуусахад Ажаатасатту хаан түүнд хэлэв:

“Одоо, Эрхэм Багш аа, бид явах ёстой. Оноосон үүрэг хариуцлага, олон хийх зүйл байгаа билээ.”

“Их хаантан минь, өөрийнхөө таалаар болгоогтун.”

Тэгээд энэ хаан, Буддагийн айлдварыг дэмжээд, суудлаасаа босож түүнд мөргөөд, баруун гар талаараа түүнийг хэдэнтээ хүндэтгэлтэйгээр тойрсны дараа гарч одов.

Хааныг ийн явсны дараа Будда хуврагуудад хандан:

[236] *Saraṇaṃ gacchāmi*—“нөмөрт очиж байна”. Буддагийн шавь болж сахил авахад хэлдэг тогтсон хэллэг. (Тайлбарт үз.)

"Хуврагууд аа, энэ хаан өөрийгөө сүйрүүлсэн байна.[237] Тэр өөрийгөө гэмтээсэн байна. Хуврагууд аа, хэрвээ энэ хаан, тэр шударга явдалт хүмүүн, шударга явдалт хаан, өөрийн эцгийн амийг, аваагүй байсан бол, энэ хааныг саяа энд сууж байхад нь, хир толбогүй, өө сэвгүй Номын-Нүд нээгдэх[238] байсан билээ."

Будда ийн айлдав.

Сэтгэл өндөр болсон хуврагууд Буддагийн айлдварт догдлон баярлав.

Даяанч Замналын Үр Өгөөж Судар энд өндөрлөв.

[237] Эцэг эхийн амийг хөнөөх нь энэ төрөлд эсвэл дараа төрөлд шууд нөлөөлдөг, дээд зэргийн муу үйлийн үр хураах үйл юм. Магадхагийн хаан, эцэг Бимбисаарагийн амийг хөнөөчхөөд, Буддатай уулзах хүртлээ энэ Ажаатасатту хаан шөнө ч унтаж чадахаа больсон байсан гэж зарим эх сурвалжид байна (DA).

[238] *Dhammacakkhuṁ uppajjissathā*—"Номын-Нүд нээгдэх". Энэ нь Гэгээрэх буюу "Урсгалд Орогч" (*Sotāpanna*) нэртэй, Гэгээрлийн дөрвөн зэргийн эхний зэргийг олохуйг нэрлэдэг тогтсон нэршил.

ПОТТХАПААДА СУДАР
DN 9. POṬṬHAPĀDASUTTA

1. Бадарчин Поттхапаада (Poṭṭhapādaparibbājakavatthu)

БИ ИЙН СОНССОН ЮМ.

Нэгэн удаа Будда, Сааваттхийгийн[239] ойролцоо, Жетагийн Төгөлд орших, Анаатхапиндикагийн[240] хийдэд сууж байжээ.

Харин тэр үед, бадарчин Поттхапаада, гурван зуун бадарчдын хамт, инжир моддын төгөлд орших, гүн ухаан, ертөнцийг үзэх үзлээр маргаан мэтгэлцээн өрнөдөг, ганц том танхимтай, Малликаа хатны[241] хийдэд[242] амьдарч байлаа. Тэр өглөө Будда орхимжоо өмсөөд, бадрын аягаа аваад, бадар гуйхаар Сааваттхий хот руу оров.

Тэгтэл тэр үед түүнд,

“Сааваттхий руу бадар гуйхаар явахад арай л эрт байна. Би яагаад Малликаагийн хийд дээр очоод, бадарчин Поттхапаадагийнд зочилж болохгүй гэж?” гэсэн бодол төрлөө. Тэгээд тэрбээр тийш зүглэв.

Харин энэ үед, бадарчин Поттхапаада цугларсан олон бадарчдын дунд суучихсан, тэнд бөөн дуу шуу болж байв. Ялгаатай нь тэд, хаад ноёд, хулгайч луйварчид, сайд түшмэлүүдийн тухай яриа; цэрэг зэвсэг, аюул занал, дайн дажны тухай яриа; хоол хүнс, идээ ундаа, гутал хувцас, ор дэр, үнэт эдлэл, үнэртэн сүрчгийн тухай яриа; хамаатан садан, тээврийн хэрэгсэл, хот хөдөө, улс орны тухай яриа, охид хүүхнүүдийн тухай яриа; эрэлхэг баатруудын тухай яриа; гудамжны яриа, дошны яриа; нас нөхцөгсдийн тухай яриа; шивэр авир, явган яриа; гадаад далай, газар орны тухай таамаг яриа; тийм сайн дараа төрлийг авсан, ийм муу дараа төрлийг олсон гэх зэрэг элдвийн дэмий яриаг ярьцгаан суух аж.

Поттхапаада, Буддаг холоос гарч ирж буйг хараад хүмүүстээ сэмхэн:

“Эрхэм нөхөд өө, чимээгээ аядаарай. Энд даянч Готама ирж байна. Энэ эрхэм багш нам гүм байдалд дуртай бөгөөд нам гүмийг сайшааж үздэг юм шүү. Хэрэв тэр манай чуулган нам гүм байгааг харвал татгалзах зүйлгүйгээр бидэн дээр хүрэлцэн ирэх байх гэж найдаж байна.” гэж хэллээ. Тэгээд тэдгээр даянчид дуугаа аядацгаав.

---

[239] *Sāvatthī*—“Сааваттхий”. Тухайн цагийн Косала (па. *Kosala*) улсын нийслэл хот.

[240] *Anāthapiṇḍikassa*—“Анаатхапиндикагийн”. Чинээлэг худалдаачин Судатта (*Sudatta*) буюу Анаатхапиндика (нэрийн утга “Ядуусыг Тэжээгч”) бол хосгүй өглөгч, тус буянт үйлээрээ алдартай, хар хүний амьдралаас “Урсгалд Орогч” болж гэгээрсэн нэгэн. Жетагийн Төгөлийн яг энэхүү газрыг тэр чигт нь алтан зоосоор хучаад, тэр үнээр худалдан авч Хуврагийн Чуулганд хандив болгож энэ хийдийг барьж өгсөн гэдэг (Vin, Cullavagga, VI.4.4-9).

[241] *Mallikā*—“Малликаа хатан”. Косалагийн хаан Пасенади (*Pasenadi*)-гийн их хатан. Хаан, хатан хоёр Буддагийн үнэнч шавь нар байв (SN 3.8; AN 4.197).

[242] *Ārāme*—“хийд”. Эсвэл “цэцэрлэгт хүрээлэн”, “парк”.

Ингээд Будда, Поттхапаада даянч дээр дөхөж очиход, тэр түүнд:

“Ерөөлтэй Нэгэн минь, тавтай морил! Та энд их л удаж байж морилон ирлээ шүү. Эрхэм та сууж болгооно уу. Танд энд олбог суудал зассан байна.” гэв. Будда зассан суудал дээр суусан бол Поттхапаада хажуу тийш доогуур суудалд суув. Будда түүнд, “Поттхапаада, та бүгд саяхан юун тухай ярилцаж байв даа? Би ямар нэг яриа хөөрөөг тань тасалдуулчхав уу?” гэлээ.

1.1. Танин-Мэдэхүй Үгүй Болохуй (Abhisaññānirodhakathā)

Түүнийг ингэж хэлэхэд бадарчин Поттхапаада, Буддад хандан,

“Эрхэм ээ, бидний сая ярилцаж байсан тэр яриаг орхиё. Та тэрийг бол хожим нэг цагт сонсож болох байх.

Тэгэхээр Эрхэм ээ, хэдхэн хоногийн өмнө янз бүрийн шашны урсгал дагадаг нэлээд олон тооны даянч болон бярман нар мэтгэлцээний танхимд сууцгааж байхад, тэдний дунд танин-мэдэхүй[243] нэгмөсөн устаж алга болох[244] тухай яриа өрнөж, улмаар ‘Танин-мэдэхүй нэгмөсөн устаж алга болно гэдэг нь яг юуг хэлэх вэ?’ гэсэн асуудлаар маргаан өрнөсөн юм.

Тэдний зарим нь:

‘Хүний танин-мэдэхүй бол ямар нэг шалтгаан нөхцөлгүйгээр, санамсаргүйгээр үүсэн бий болж, мөн ямар нэг шалтгаан нөхцөлгүйгээр, санамсаргүйгээр үгүй болдог зүйл билээ. Танин-мэдэхүй үүсэх үед, та ухаан мэдээтэй болдог. Танин-мэдэхүй үгүй болоход, та ухаан мэдээгүй болдог юм.’ гэлээ.

Тэдний зарим нь танин-мэдэхүй нэгмөсөн устаж алга болохыг ингэж тайлбарласан юм.

Тэгвэл зарим нь:

‘Тэр тийм биш ээ. Нөхөд өө, танин-мэдэхүй гэдэг бол, хүн рүү нэвтэрч ордог, хүнээс гараад явчихдаг, хүний өөрийн-оршихуй[245] нь юм. Энэ тан руу орсон байхад та ухаан мэдээтэй байдаг. Энэ танаас гарч явахад, та ухаан мэдээгүй болдог.’ гэлээ.

Тэдний зарим нь танин-мэдэхүй нэгмөсөн устаж алга болохыг ингэж тайлбарласан юм.

Тэгвэл зарим нь:

---

[243] Энэ сударт үндсэндээ “танин-мэдэхүйн” тухай ярих хэдий ч, хүн тус бүрийн ойлголт янз бүр байдаг тул өөрийн-оршихуй, оюун-ухамсар, мэдрэмж г.м. ойлголтуудтай үүнийг хольж хутган ярьж буйгаар гарахыг анхаар. (Тайлбарт буй Таван-Цул, Лавлахаас оюун-ухамсар, танин-мэдэхүйг үз.)

[244] Мьянмар орчуулгад “танин-мэдэхүй нэгмөсөн устаж алга болох” гэдэг нь “сэтгэлийг” (*citta*) нэгмөсөн устах гэсэн санааг энэ сударт хэлсэн гэжээ (MPA).

[245] Энд, “Танин мэдэхүй гэдэг бол хүний өөрийн-оршихуй (*attā*) нь юм.” буюу өөрөөр хэлбэл, “миний сүнс”, “би өөрөө”, “би” гэдэг бол угтаа танин-мэдэхүй юм гэж ярьж буй хэрэг болно.

‘Тэр тийм биш ээ. Нөхөд өө, агуу ид хүчтэй, шид чадалтай, даянч болон бярман нар гэж байдаг билээ. Тэд хүний танин-мэдэхүйг оруулж, тэд бас хүнээс гаргачхаж чаддаг юм. Тэд үүнийг танд оруулах үед та ухаан мэдээтэй болно. Тэд харин үүнийг гаргахад та ухаан мэдээгүй болно.’ гэлээ.

Тэдний зарим нь танин-мэдэхүй нэгмөсөн устаж алга болохыг ингэж тайлбарласан юм.

Тэгвэл зарим нь:

‘Тэр тийм биш ээ. Нөхөд өө, агуу ид хүчтэй, шид чадалтай, тэнгэр бурхад гэж байдаг билээ. Тэд хүний танин-мэдэхүйг оруулж, тэд бас хүнээс гаргачхаж чаддаг юм. Тэд үүнийг танд оруулах үед та ухаан мэдээтэй болно. Тэд харин үүнийг гаргахад та ухаан мэдээгүй болно.’ гэлээ.

Тэдний зарим нь танин-мэдэхүй нэгмөсөн устаж алга болохыг ингэж тайлбарласан юм.

Энэ явдлаас улбаалаад Будда л миний санаанд:

‘Гарцаагүй тэр Ерөөлтэй Нэгэн, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда л энэ бүгдийн талаар нэвтэрхий мэдэх нь дамжиггүй. Тэр л танин-мэдэхүй хэрхэн нэгмөсөн устаж алга болдог тухай, энэ сэдэв дээр ихийг мэдсэн, ихийг ойлгосон хүн.’ хэмээн буусан билээ. Тэгэхээр, би танаас асуумаар байна. Танин-мэдэхүй хэрхэн нэгмөсөн устаж алга болдог юм бэ?” гэж тэр асуув.

1.2. Танин-Мэдэхүй Учир Шалтгаанаар Үүсдэг (Sahetukasaññuppādanirodhakathā)

“Энэ тал дээр гэвэл, Поттхапаада, танин-мэдэхүй ямар нэг шалтгаан нөхцөлгүйгээр, санамсаргүйгээр үүсэн бий болж, мөн ямар нэг шалтгаан нөхцөлгүйгээр, санамсаргүйгээр үгүй болдог гэж үздэг даянч болон бярман нарын үзэл тайлбар бол үндсээрээ буруу юм.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл, танин-мэдэхүй бол учир шалтгаан, нөхцөл байдлаас улбаалж үүсэн бий болж, мөн учир шалтгаан, нөхцөл байдлаас улбаалж устаж алга болдог. Бясалгал дасгалын явцад зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, бясалгал дасгалын явцад зарим төрлийн танин-мэдэхүй устдаг.

Тэгвэл тэр нь ямар дасгал бясалгал байх бол?” ийн хэлээд Будда цаашаа ийн үргэлжлүүлэв:[246]

“Поттхапаада, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда, саруул ухаан хийгээд сахил ёсыг оршоосон, Зөвөөр Одогч, Хорвоог Ухаарагч, Эгнэшгүй Нэгэн, Ухаарах Учиртайг Ухааруулах Сургагч, Бурхад Хийгээд Хүмүүсийн Багш, Сэрсэн Нэгэн, Ерөөлтэй Нэгэн, энэхүү Тийн Одогч энэ хорвоод төржээ. Бурхан, чөтгөр[247], Тэнгэр, даянч болоод бярман, хаад ноёд хийгээд харц ард бүхий энэ цаг үеийнхний

[246] Ингээд DN 2-ын 4.4.-4.4.7-той агуулга ижил хэсэг давтагдах ба зүүлт тайлбар DN 1. болон DN 2-т бий. (Анхан, Дунд, Дээд Шатны Сахил-Ухамсар, Мэдрэхүйн Чандлал-Хатамжлал, Дүүрэн-Анхаарал Тунгалаг-Оюун, Сэтгэл Ханамж, Таван-Саадыг Арилгахуй хэсгүүд давтагдана.)

[247] *Māra*—“чөтгөр”. Өөрөөр, “Маара”, “Маара чөтгөр”. Маараг Лавлахад үз.

хамтдаа амьдран буй эл хорвоог, өөр дээрээ тэрээр шууд-билгүүнээр ухаарснаар, үүнийг олонд түгээн таниулдаг. Эхэндээ ч зөв сайн, дундаа ч зөв сайн, эцэстээ ч мөн зөв сайн, эш утга бүхий, үг хэллэг бүхий, бүрэн төгс, бүхэлдээ ариун, ариуслын-замналыг тэр илчлэн заадаг.

Энэхүү Сургаалыг, гэр оронтой хүмүүн, эсвэл гэр оронтой хүмүүний хүү, аль эсвэл хаа нэгтээ төрсөн хэн нэгэн олж сонсох болно. Энэ Сургаалыг сонссоноор тэр хүмүүн, Буддад итгэх итгэлийг өөртөө олж авна. Ийм итгэлийг олж авсан болохоор, энэ хүмүүн:

‘Хар хүмүүний амьдрал бужигнаан шуугиантай, буртаг тоостой, харин сахилтны замнал хавьгүй уужим тэнүүн юм. Гэртээ суугаад амьдрах нэгэнд, зүлгэсэн хясаа шиг төгс төгөлдөр, төгс ариунаар ариуслын-замналаар замнах нь амаргүй хэрэг юм. Тэгвэл магад би, үс сахлаа хусаад, зосон орхимж өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй сахилтан болбол дээргүй юу.’ гэж эргэцүүлж тунгаах болно.

Хэсэг хугацааны дараа, тэрбээр их бага хөрөнгөө орхиж, олон цөөн хамаатнаа орхиж, үс сахлаа хусаад, зосон орхимж өмсөөд, орон гэрээ орхиод, орон гэргүй сахилтан болдог.

Ингэж тэрээр гэрээ орхисон сахилтан даянч болсноор, хуврагийн дээд сахил, Хураангуй Дүрмийг даган мөрдөж, зөв авиртай, зөв явдалтай нэгэн болж, өчүүхэн жижиг алдаа дутагдал дунд ч аюул буйг олж харж, авсан сахил номын дагуу өөрийгөө сургаж, бие, хэл, сэтгэлийн тустай-сайн барилд өөрийгөө оршоож, амьжиргаа нь нэгэнт ариусаж, сахил-ухамсрыг дадуулж, мэдрэхүйн үүдээ үргэлжид сахин хамгаалснаар, дүүрэн-анхаарал тунгалаг-оюунтай байж, тэр сэтгэл хангалуун болдог.

Хувраг хүн, амь таслах үйлийг нэгмөсөн орхиж, амь таслахыг ямагт тэр цээрлэдэг. Тэрээр, мод шийдэм хийгээд хутга сэлмийг нэгмөсөн орхиж, энэ хорвоогийн бүхий л амьд биетэд, ухамсар ухаан, хайр энэрэл, өгөөмөр нинжин сэтгэлээр хандан амьдран сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хуврага хүн, хэн нэгний өгөөгүй зүйлийг авах аливаа үйлийг нэгмөсөн орхиж, ямарваа нэг өөрт нь өгөөгүй зүйлийг өөрийн болгохыг ямагт тэр цээрлэдэг. Тэрээр, зөвхөн бусдын өгснийг авч, өгсөн зүйлийг нь хүлээн зөвшөөрдөг. Тэрбээр, хулгайн үйлээс ангид, цэвэр ариун байдлыг оршоон сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хуврага хүн, ариун-бус явдлыг нэгмөсөн орхиж, аливаа бэлгийн харилцааны ямарваа үйлийг ямагт тэр цээрлэдэг. Тэр бол хар хүмүүний үйлддэг бэлгийн харилцааны бүхий л үйлээс татгалзсан, ариун-явдалт нэгэн бөгөөд нүглээс алс буйд амьдран сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хуврага хүн, үнэн бус, худал яриаг нэгмөсөн орхиж, үнэн бус, худал яриаг ямагт тэр цээрлэдэг. Тэр бол итгэл эвдэгч нэгэн огт биш, үнэнийг өгүүлэгч, үгэндээ эзэн, итгэл даахуйц, чин шударга нэгэн байна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, гүтгэлэг хийгээд бусдыг хагаралдуулсан яриаг нэгмөсөн орхиж, гүтгэлэг хийгээд бусдыг хагаралдуулсан яриаг ямагт тэр цээрлэдэг. Бусдыг талцуулах үрийг тарьж, энэ талаас сонссон зүйлээ тэр талд нь ярьдаггүй. Бусдын эвдрэлцүүлэх үрийг тарьж, тэр талаас сонссон зүйлээ энэ талд нь ярьдаггүй юм. Ийм болохоор тэр бол харин ч бүр эвдрэлцсэн хүмүүсийг эвлэрүүлэгч, эвтэй хүмүүсийг эс эвдрүүлэгч нэгэн юм. Тэрбээр, эв эеийг эрхэмлэн сайшааж, эв найрамдлыг бататгах яриаг ярьж, энх тайвныг оршоон сууна.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, бүдүүлэг болон дээрэнгүй яриаг нэгмөсөн орхиж, бүдүүлэг болон дээрэнгүй яриаг ямагт тэр цээрлэдэг. Тэрбээр, эелдэг дотно, яруу ялдам, мэргэн цэцэн, утга уянгатай, сонорыг мялаах, хүний сэтгэл зүрхэнд хүрэх, түмний хүлээн зөвшөөрч сонсох, тийм л үгсийг хэлнэ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, хов жив хийгээд явган яриаг нэгмөсөн орхиж, ямарваа нэг хов жив хийгээд явган яриаг, ямагт тэр цээрлэдэг. Тэрбээр, цагаа олсон үед нь, үнэн баримттай, өгөөж тустай зүйлийг, Сургаал номд нийцүүлж, Сахил номд тааруулж, учир шалтгаанд суурилж, чухамхүү нүдээ олсон цагт нь, үнэнхүү цаг нь тохирсон үед нь, учир зүйгээр баталгаажихуйц, улмаар нэгийг тунгаахуйц, хүрээ хязгаарт нь таарахуйц, хүмүүнийг сайн сайханд хөтлөхүйц, тийм л үгсийг хэлнэ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Хувраг хүн, ургамлын амьдрал хийгээд түүний үрийг гэмтээхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, өдөрт нэг удаа л хооллож, үдшийн цагаар хооллох, буруу цагаар идэхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, бүжиглэх, дуулах, хөгжимдөх, цэнгээн үзвэр үзэхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, зүүлт зүүх, сүрчиг цацах, тос түрхэх, өөрийгөө гоёх, өөрийгөө тордох ямарваа нэг үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, өндөр суудал, өргөн ор хэрэглэхийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, алт болон мөнгийг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, болгоогүй будааг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, болгоогүй махыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, эмэгтэйчүүд, охидыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, эм боол, эр боолыг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, хонь, ямааг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, тахиа, гахайг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, заан, үнээ, адуу, гүүг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, газар нутаг, тариан талбайг өргөл барьцад авахыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, бусдын өмнөөс мэдээ зөөх, тушаал даалгавар дамжуулах явдалд оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, худалдаж авах, зарж борлуулах үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, хуурамч жинлүүр, хуурамч зоос, хуурамч хэмжүүрийг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, хээл хахууль, заль мэх, хуйвалдаан луйварт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Хувраг хүн, цавчих, цаазлах, эд эрхтэн тайрах, хорих хүлэх, тонох хулгайлах, булаах дээрэмдэх, харгислах хүчирхийлэхийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Анхан Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч ургамлын амьдрал хийгээд тэдгээрийн үрийг гэмтээх явдалд гар бие оролцдог.

Эдгээр үйлдлүүд нь чухамдаа, үндэснээс ургуулах, ишнээс ургуулах, мөчрөөс ургуулах, залгаж ургуулах, үрээс ургуулах зэрэг таван үйл билээ. Харин хувраг хүн ургамлын амьдрал хийгээд тэдгээрийн үрийг гэмтээхийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч хоол хүнс, идээ ундаа, гутал хувцас, тээврийн хэрэгсэл, ор дэр, үнэртэн сүрчиг, элдэв тансаглалыг өөртөө зориулан хурааж хадгалдаг. Харин хувраг хүн, тийм эд агуурс цуглуулах, хөрөнгө зоорь хураах үйлийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч ёс суртахууны түвшин ахихад тээг саад болдог цэнгээн үзвэрт оролцдог. Тэдгээр нь:

- Бүжиг, дуу, хөгжим бүхий цэнгээн үзвэр;
- Жүжиглэл бүхий цэнгээн үзвэр;
- Уран зохиол, үлгэр, түүх бүхий цэнгээн үзвэр;
- Алга ташилт, цан, бөмбөр бүхий цэнгээн үзвэр;
- Зураг, урлаг, гоо сайхны цэнгээн үзвэр;

- Үсрэх, харайх, авирах үзүүлбэр бүхий цэнгээн үзвэр;
- Үхэгсдийн ясыг угаах цэнгээн үзвэр;
- Заан, морь, үхэр, бух, ямаа, хуц, тахиа, бөднө шувууны тэмцэлдээн, уралдаан;
- Саваан тулалдаан, нударган зодолдоон, бөхийн барилдаан, жүжиглэсэн байлдаан, цэргийн бэлтгэл, цэргийн байлдааны жагсаал, цэргийн ёслолын жагсаал;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, ийм цэнгээн үзвэрт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч хэнэггүй байдлыг бий болгодог мөрийтэй тоглоомуудаар тоглодог. Тэдгээр нь:

- Найман хөлөгт шатар даам;
- Арван хөлөгт шатар даам;
- Хийсвэр хөлөгт шатар даам;
- Газар зураад харайх тоглоом;
- Саваа сугалах тоглоом;
- Шоогоор тоглодог тоглоом;
- Савхаар цохих тоглоом;
- Будгаар тоглох тоглоом;
- Бөмбөгөөр наадах тоглоом;
- Навчаар шүгэлдэх тоглоом;
- Газар хагалах тоглоом;
- Тонгорч үсрэх тоглоом;
- Салхин сэнсний тоглоом;
- Жинлүүрт тоглоом;
- Хөсөг тэрэг тоглоом;
- Тоглоомон нум суман тоглоом;
- Үгийн таавартай тоглоом;
- Бодлын таавартай тоглоом;
- Өрөөл татанхай болж жүжиглэх тоглоом;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, хэнэггүй байдлыг бий болгодог, эдгээр мөрийтэй тоглоомд оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өндөр бөгөөд тансаг, олбог суудал, ор дэр хэрэглэдэг. Тэдгээр нь:

- Өргөн буйдан;
- Амьтны сийлбэр, хээ хуар бүхий сэнтий; үслэг бүтээлэг;
- Өнгө алаглуулан шоолж хийсэн бүтээлэг; цагаан ноос ноолууран хучлага;
- Цэцэг шигтгээ бүхий ноос ноолууран хучлага, хөвөнгөөр зузаалсан хөнжил;
- Амьтны дүрсэн хээ, шигтгээ бүхий ноос ноолууран хучлага;
- Нэг эсвэл хоёр талдаа үслэг, ноос ноолууран хучлага;
- Үнэт чулуун шигтгээ бүхий орны хучлага;
- Торгон хучлага;
- Хивс, ширдэг;
- Заан, морин сүйх тэрэгний шалавч; гөрөөсний арьсан шалавч;
- Кадали бугын арьсан шалавч, бүтээлэг;
- Улаан саравч, халхавч бүхий сэнтий;
- Улаан өнгийн, гарын тавиур, хөлийн гишгүүр бүхий, зөөлөн сэнтий, буйдан;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, өндөр бөгөөд тансаг олбог суудал, ор дэр хэрэглэхийг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өөрийгөө гоёж, биеэ торддог.

Тэдгээр зүйлүүд нь: сүрчиг цацах, тосон иллэг хийлгэх, анхилуун усанд орох, гар хөлийн иллэг хийлгэх, толь хэрэглэх, тос түрхэх, зүүлт зүүх, үнэртэн хэрэглэх, нүүрээ будах, энгэсэг түрхэх, бугуйвч зүүх, үс толгойн тууз зүүх, чамин ганган таяг тулах, эмийн бортого хөөрөг хэрэглэх, гоёлын хутга зүүж явах, нарны халхавч хэрэглэх, гоёлын шаахай өмсөх, өндөр сүрлэг малгай өмсөх, үнэт эдлэл хэрэглэх, титэм зүүх, дэвүүр сэвүүр хэрэглэх, элбэг сүрлэг цагаан дээл орхимж өмсөх, гэх зэрэг болно. Харин хувраг хүн, өөрийгөө гоёх, биеэ тордох явдлыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дэмий яриа ярьдаг.

Тэдгээр нь: хаад ноёд, хулгайч луйварчид, сайд түшмэлүүдийн тухай яриа; цэрэг зэвсэг, аюул занал, дайн дажны тухай яриа; хоол хүнс, идээ ундаа, гутал хувцас, ор дэр, үнэт эдлэл, үнэртэн сүрчгийн тухай яриа; хамаатан садан, тээврийн хэрэгсэл, хот хөдөө, улс орны тухай яриа, охид хүүхнүүдийн тухай яриа; эрэлхэг баатруудын тухай яриа; гудамжны яриа, дошны яриа; нас нөхцөгсдийн тухай яриа; шивэр авир, явган

яриа; гадаад далай, газар орны тухай таамаг яриа; тийм сайн дараа төрлийг авсан, ийм муу дараа төрлийг олсон гэх зэрэг элдвийн дэмий яриа болно. Харин хувраг хүн, эдгээр хэрэггүй дэмий яриаг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өөр хоорондоо ном хаялцан маргалдаж:

‘Чи энэ Сургаал, Сахилыг ойлгодоггүй юм байна. Би энэ Сургаал, Сахилыг ойлгодог билээ.’,

‘Чи энэ Сургаал, Сахилыг чухам яаж ойлгоод байна?’,

‘Чиний дасгал, бясалгал бол буруу. Миний дасгал, бясалгал бол зөв.’,

‘Би оройд нь гарч ойлгоод байна. Чи оройд нь гарч ойлгохгүй байна.’,

‘Чи эцэст нь хэлэх ёстойгоо эхэнд нь хэлээд, эхэнд нь хэлэх ёстойгоо эцэст нь хэлээд байна.’,

‘Чиний удаан бодож тунгаасан номлол төөрөлдсөн зүйл байна.’,

‘Чиний номлол няцаагдлаа. Чи мэтгэлцээнд ялагдлаа. Чи эндээс яв одоо. Эсвэл чаддаг юм бол яг одоо энд зангилааг нь гаргачих.’ гэх зэргээр мэтгэлцэх аж. Харин хувраг хүн, ийм ном хаялцсан, цэц булаалдсан яриаг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч ‘энд ир, тэнд оч, үүнийг ав, түүнийг хүргэ’ гэх зэргээр, хаад ноёд, сайд түшмэд, язгууртнууд, бярман болон хар хүмүүс, хүүхэд залуусын хооронд, захиа мэдээ, тушаал даалгавар дамжуулах аж. Харин хувраг хүн, ийм мэтийн захиа мэдээ, тушаал даалгавар дамжуулах үйл хэрэгт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч өргөл барьц авахын тулд, зальдаж мэхлэх, зусардаж бялдуучлах, далдуур санаа өгөх, дарамт шахалт үзүүлэх, ямар нэг эд зүйл өгөөд илүү их өргөл барьц авах, элдэв заль мэхэнд оролцдог. Харин хувраг хүн, ийм мэтийн заль мэхийн үйл хэрэгт оролцохыг ямагт цээрлэдэг билээ.’

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Дунд Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Хүний наслах нас, эсвэл үхэх цагийг, сэргэн мандах, эсвэл уруудан доройтохыг, гар хөл, биеийн мэнгээр мэргэлэх зөгнөх;
- Далдын ёр, шинж тэмдгийг тодорхойлох;
- Аянга цахилгаан, тэнгэрийн дуугаар элдэв ёр зөн хэлэх;
- Хар дарсан зүүд, зүүдний тайлал хийх;
- Биеийн шинж тэмдгээр мэргэлэх;
- Хулгана мэрсэн хувцас даавуун дээрээс мэргэ төлөг буулгах;
- Галын тахилга, өргөл хийх;
- Цацлаар өргөл хийх;
- Хивэг, гурил, тариа, өөх, шар тосоор бурхдад өргөл өргөх;
- Амаараа тургиж өргөл өргөх;
- Амьтнаар тахилга хийх;
- Хурууны өндөг, алганы хээгээр мэргэлэх;
- Баригдах байшин, газар талбай, шарилын газрын, өлзийтэй сайн эсэхийг шинжих;
- Төрийн түшмэдэд зориулан мэргэ төлөг хэлж өгөх;
- Оршуулгын газрын албин чөтгөрийг зайлуулах арга жатга хийх;
- Гүйдэл, дайрлагад дайруулсан хүний албин чөтгөрийг зайлуулах арга жатга хийх;
- Шороон байшинд суугчдын тарни шившлэг буюу арга жатгыг хэрэглэх;
- Могойн хороор эмчлэх, могойд хазуулсан хүнийг эмнэх домнох;
- Хор хийх, хороор эмчлэх, хордлого тайлах;
- Хилэнцэт хорхой, харханд хазуулсан хүнийг эмнэх домнох;
- Шувуу, хэрээний дуу чимээ, гуагалалтаар зөгнөх ёрлох;
- Хүний амьдрах насны тоог хэлэх зөгнөх;
- Сум зэвээс хамгаалах тарни шившлэг хийх;
- Амьтны хэл чимээгээр зөгнөх ёрлох;

гэх зэрэг болно.

Харин хувраг хүн, эдгээр дорой аргаар, буруу замаар амь амьжиргаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь, эд зүйлсийг өнгө, дүрс болон бусад шинж чанараар нь шинжиж, эздэдээ аз хийморь, эсвэл золгүй явдал авчрах эсэхийг хэлж өгөх дорой арга буюу: эрдэнийн чулуу, гутал хувцас, таяг, сэлэм, жад, нум, сум, өөр бусад зэр зэвсэг, хүүхнүүд, эрчүүд, хөвгүүд, охид, боол эрс, боол эмс, заан, адуу, үхэр, бух, үнээ, ямаа, хуц,

тахиа, бөднө, гүрвэл, туулай, яст мэлхий, болон бусад амьтад юм. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Тэр хаан довтлох болно;
- Тэр хаан довтлохгүй;
- Манай хаан довтолж, дайсны хаан ухрах болно;
- Дайсны хаан довтолж, манай хаан ухрах болно;
- Манай хаан ялж, дайсны хаан ялагдана;
- Дайсны хаан ялж, манай хаан ялагдана;
- Тэр тал ялж, энэ тал нь ялагдана;

гэх зэрэг юм. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр нь:

- Нар, сар, оддын хиртэлт болно;
- Нар, сар жамаараа эргэлдэнэ;
- Нар, сарны эргэлтийн гажуудал бий болно;
- Од гаригууд жам ёсоороо эргэлдэнэ;
- Од гаригийн гажуудал үүсэх болно;
- Солир унана, тэнгэрийн хаяа улайна, газар хөдөлнө;
- Газар ангайна;
- Нар, сар, од гаригууд мандана, жаргана, харанхуйлна, гэрэлтэнэ;
- Нар, сарны хиртэлтийн улмаас ийм тийм зүйл тохионо;
- Нар, сар, од гаригуудын мандах ба жаргах, харанхуйлах ба тодрох шинж байдал нь ийм тийм учралыг авчирна;

гэх мэтээр зөгнөх, ёрлох, мэргэлэх юм. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь дараах зүйлс болно:

- Хур ус элбэг байна;
- Ган гачиг болно;
- Ургац арвин байна;
- Өлсгөлөн болно;
- Энх тунх болно;
- Аюул занал бий болно;
- Өвчин зовлон ирэх болно;
- Эрүүл энх болно гэх зэргээр мэргэлэх, зөгнөх, таамаглах;
- Эсвэл тэд, нягтлан бодох, тооцоолон бодох, тоо бодох, шүлэг найраг зохиох, мөн хорвоо ертөнцийн талаар элдэв таамаглал хэлэх зэрэг юм. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь:

- Хурим хийх, бэр гуйх, охиноо хадамд гаргах өдөр сарыг шинжих;
- Сүй тавих, гэр бүл салгах өдөр сарыг шинжих;
- Орлогын үүд, эсвэл гарлагын үүдийг дуудах тарни шившлэг хийх;
- Хүний аз хийморь, эсвэл золгүйдэлт бүтэлгүйдэлд тарни шившлэг хийх;
- Үргүй эмэгтэйчүүдэд үрийн заяа дуудах;
- Хүний хэл ам, хөл гар, эрүүг нь татуулах, эсвэл дүлий болгох тарни шившлэг хийх;
- Толь, чөтгөр, шулмаас, эсвэл бурхдаас шийдэл зөвлөгөө асуух;
- Нарыг тахих, шүтэх;
- Бярман Дээд Тэнгэрийг тахих, шүтэх;
- Галаар тургих арга жатга хийх;
- Азын Тэнгэр дуудах;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Сүсэгтнүүдийн итгэлийг олсон зарим нэг лам багш, даянч бярман нар иргэдийн итгэл сүсгээр барьсан идээ ундаар амьдрах боловч дорой аргаар, буруу замаар амь амьжиргаагаа залгуулдаг. Тэдгээр дорой аргууд нь:

- Ач тусын хариуд, бурхдад өргөл амлах;
- Тэр амлалтаа биелүүлэх;
- Албин чөтгөртэй холбогдох;
- Орон байрны тарни шившлэг хийх;
- Үргүйдэл, бэлгийн сулрал засах;
- Барилга барих газрыг бэлдэх, ариусгах;
- Ам зайлах, усанд оруулах ариусгал ёслол хийх;
- Галын тахилга хийх;
- Бөөлжүүлэх, дотор цэвэрлэх, цэр ховхлох, цэр хөөх эм өгөх;
- Чих, хамраар хэрэглэх эм өгөх;
- Анагаах тосон түрхлэг өгөх;
- Нүд, чихэнд нарийн мэс засал хийх;
- Ерөнхий мэс засал хийх;
- Хүүхдийн эмчилгээ хийх;
- Эмийн ургамлын үндсээр эмчилгээ хийх;
- Эмийн ургамлаар боолт хийх;

гэх зэрэг болно. Харин хувраг хүн, тийм дорой аргаар, ийм буруу замаар амь амьжиргаагаа залгуулахыг ямагт цээрлэдэг билээ.

Энэ мөн тэдний сахил-ухамсар болдог.

Поттхапаада, ийнхүү эдгээр сахилаа ямагт дагаж мөрдсөөр, сахил-ухамсрыг нэгэнт өөртөө суулгасан хувраг хүн, сахил-ухамсрын тал дээр огтхон ч түгших, эмээх зүйлгүй болдог билээ.

Поттхапаада, энэ яг л, дайснаа нэгэнт дарсан, дархан цолыг олсон баатар хунтайж, атаатан дайсны тал дээр огтхон ч түгших, эмээх зүйл олж харахгүйн адил, эдгээр сахилаа ямагт дагаж мөрдсөөр, сахил-ухамсрыг нэгэнт өөртөө суулгасан хувраг хүн, сахил-ухамсрын тал дээр огтхон ч түгших, эмээх зүйлгүй болдог билээ.

Энэхүү Гэгээнтний сахил-ухамсрыг бүхэлд нь өөртөө суулгасан тэр хувраг хүн, буруу нь үгүй аз-жаргалыг өөрийн дотор мэдэрдэг.

Поттхапаада, хувраг хүн сахил-ухамсрыг ингэж өөртөө суулгадаг билээ.

Дээд Шатны Сахил-Ухамсар хэсэг өндөрлөв.

Поттхапаада, хувраг хүн, үзэгдэх ямар нэг дүрс нүдэнд туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, харааны үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, харааны мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр, харааны мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хувраг хүн, сонсогдох ямар нэг чимээ чихэнд туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, сонсголын мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, сонсголын мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр, сонсголын мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хувраг хүн, үнэртэх ямар нэг үнэр хамарт туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, үнэрлэх мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, үнэрлэх мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр, үнэрлэх мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хувраг хүн, амтагдах ямар нэг амт хэлэнд туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, амтлах мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, амтлах мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр, амтлах мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хувраг хүн, хүрэлцэх ямар нэг зүйл биед туссанаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, хүрэлцэх мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, хүрэлцэх мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр, хүрэлцэх мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Хувраг хүн, ямарваа нэг бодол оюун-ухаанд бууснаар, үүний хэлбэр байдал эсвэл шинж чанарыг нь огт шүүрч авдаггүй. Хэрэв тэрбээр, оюун-ухааны мэдрэхүйн үүдээ сахин хамгаалалгүй хаяж зөнд нь орхих юм бол тусгүй-муу сэтгэлийн байдал болох хүсэл-мөрөөсөл, зовнил-гуниг түүнийг эзэмдэн авдаг. Учир иймээс тэр, оюун-ухааны мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах чандлал-хатамжлалыг үргэлж дасгалжуулан үйлдсэнээр, оюун-ухааны мэдрэхүйн чандлал-хатамжлалыг өөрт суулгадаг.

Мэдрэхүйн зургаан үүдийг сахин хамгаалах энэхүү Гэгээнтний чандлал-хатамжлалыг өөртөө суулгасан тэр хувраг бохирдоогүй аз-жаргалыг өөрийн дотор мэдэрдэг.

Поттхапаада, энэ бол хувраг хүний мэдрэхүйн үүд хаалгаа сахин хамгаалахуй нь юм.

Поттхапаада, тэр хувраг хүн дүүрэн-анхаарал тунгалаг-оюуныг хэрхэн дадуулдаг бол?

Энэ тал дээр, Поттхапаада, хувраг хүн урагш явсан ч, эсвэл ухарч явсан ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг, урагш харсан ч, эсвэл эргэн тойрноо харсан ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Мөчөө нугалахдаа ч, эсвэл мөчөө тэнийлгэхдээ ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Хувцсаа өмсөхдөө ч, эсвэл бадрын аягаа барихдаа ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Хоолоо идэхдээ ч, ундаа уухдаа ч, зажлахдаа ч, эсвэл амтлахдаа ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Хөнгөн бие засахдаа ч, эсвэл хүндээр бие засахдаа ч тунгалаг-оюуныг оршоож үйлддэг.

Алхахдаа ч, зогсохдоо ч, суухдаа ч, унтахдаа ч, сэрэхдээ ч, ярихдаа ч, эсвэл чимээгүй байх үедээ ч тэрээр тунгалаг-оюуныг оршоож энэ бүгдийг үйлддэг.

Поттхапаада, ингэж хувраг хүн дүүрэн-анхаарал тунгалаг-оюуныг өөрт дадуулдаг билээ.

Поттхапаада, тэр хувраг хүн хэрхэн сэтгэл ханамжтай байдаг бол?

Энэ тал дээр, Поттхапаада, хувраг хүн, биеийг хамгаалах орхимж, ходоодыг цатгах өглөгийн хоол хоёртоо л сэтгэл ханамжтай байдаг билээ. Тэрээр хаашаа ч явсан бай, орхимж, аяга хоёроо л өөртөө авч явдаг билээ.

Шувуу гэдэг амьтан хаашаа ч одсон бай, хоёр далавчаа л өөртөө авч яван, үүгээрээ дүүлэн нисдэгтэй адил, хувраг хүн мөн ялгаагүй хаашаа ч явсан бай, орхимж, аяга хоёроо л өөртөө авч явдаг билээ.

Поттхапаада, ингэж л хувраг хүн сэтгэл ханамжтай байдаг юм.

Тэрбээр Гэгээнтний сахил-ухамсрыг бүхэлд нь дадуулснаар, зургаан мэдрэхүйн үүдийг сахин хамгаалах тэрхүү Гэгээнтний чандлал-хатамжлалыг өөртөө суулгаснаар, тэрхүү Гэгээнтний дүүрэн-анхаарал тунгалаг-оюуныг дадуулснаар, тэрхүү Гэгээнтний сэтгэл ханамжийг олсноор, энэ хувраг ой мод, модны хонгил, уулын энгэр, уулын хавцал, уулын агуй, оршуулгын газар, шигүү ширэнгэн ой, ил задгай газар, өвсөн бухал зэрэг олны хөлөөс алс буйд газар орь ганцаар оршино. Тэрээр бадар барьж ирээд, гуйлгаар олсноо идэж дуусаад, хоёр хөлөө хөндлөн зөрүүлээд, биеэ эгцлэн завилан суугаад, дүүрэн-анхаарлыг өмнөө үүсгэнэ.

1. Энэ хорвоогийн хүсэл-мөрөөслөө үгүй хийснээр, тэрээр хүсэл-мөрөөслөөс ангижирсан сэтгэлийг оршооно. Тэрээр хүсэл-мөрөөсөлтэй сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

2. Хар-санаа, уур-хилэнг үгүй хийснээр, тэрээр хорвоогийн амьтан бүгдэд хайр энэрэл, нинжин сэтгэлтэй оршино. Тэрээр хар-санаа, уур-хилэнт сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

3. Хойрго-нойрмог байдлыг үгүй хийснээр, тэрээр хойрго нойрмог байдалгүй, сэруул тунгалаг, дүүрэн-анхаарал тунгалаг-оюунтай оршино. Тэрээр хойрго-нойрмог сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

4. Түгшүүр-зовнилоо үгүй хийснээр, тэрээр сэтгэл дотроо амар тайван, аюул түгшүүргүй оршино. Тэрээр түгшүүр-зовнилтой сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

5. Эргэлзээ-тээнэгэлзээг үгүй хийснээр, тэрээр тустай-сайн Чанаруудад эргэлзэж тээнэгэлзэлгүй, эргэлзээгээ-тээнэгэлзээг нэгэнт давсан хүний ёсоор оршино. Тэрээр эргэлзээ-тээнэгэлзээтэй сэтгэлээ цэвэрлэж ариусгана.

Поттхапаада, хэн нэгэн хүн өр зээл тавьж гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, зээлийн мөнгөө ажил хэрэгтээ ашиглаад, ажил хэрэг нь ч бүтэмжтэй болж, авсан өр зээлээ, бүр хүүтэй нь хамт төлөөд, тэр ч бүү хэл, эхнэртээ гоёл чимэглэл авч өгөх хангалттай мөнгийг олсон байж. Энэ болсон явдлаа тэр: “Би өр зээл тавьсан. Би зээлийн мөнгөө ажил хэрэгтээ ашиглаад, ажил хэрэг минь ч бүтэмжтэй болж, авсан өр зээлээ бүр хүүтэй нь хамт төлөөд, тэр ч бүү хэл эхнэртээ гоёл чимэглэл авч өгөх хангалттай мөнгийг олсон шүү.” хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Поттхапаада, мөн адил нэгэн хүн, хүнд өвчин тусч гэж бодъё. Хоол ундаа ч идэх чадалгүй, тамир тэнхээ нь доройтсон байж. Хэсэг хугацааны дараа тэр, энэхүү хүнд өвчнөөсөө салаад, хоол ундаа иддэг болоод, болоогүй бүр тамир тэнхээ нь эргэн цогцолсон байж. Энэ болсон явдлаа тэр: “Би хүнд өвчин тусч билээ. Хоол ундаа ч идэх чадалгүй, тамир тэнхээ минь доройтсон байсан. Гэхдээ хэсэг хугацааны дараа энэ хүнд өвчнөөсөө салж, хоол ундаа иддэг болоод, болоогүй бүр тамир тэнхээ минь эргэн цогцолсон шүү.” хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Поттхапаада, мөн адил нэгэн хүн, шоронд орчихлоо гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, элдэв бэртэл гэмтэлгүй, эд хөрөнгөө ч алдалгүй, болоогүй бүр шоронгоосоо суллагдсан байж. Энэ болсон явдлаа тэр: “Би шоронд орчхож билээ. Хэсэг хугацааны дараа би, элдэв бэртэл гэмтэлгүй, эд хөрөнгөө ч алдалгүй, болоогүй бүр шоронгоосоо суллагдсан шүү.” хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Поттхапаада, мөн адил нэгэн хүн, өөрийн гэсэн эрх чөлөөгүй, бусдаар удирдуулж захируулдаг, хүссэн зүгтээ ч явж болдоггүй, зарц боол байжээ гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, зарцлалт боолчлолоосоо чөлөөлөгдөж, эрх чөлөөг олсон байг. Тэр цагаас хойш, бусдад нэгэнт захирагдахаа больж, болоогүй бүр хүссэн зүгтээ явж болдог эрх чөлөөт нэгэн болж гэнэ. Энэ болсон явдлаа тэр: “Би, өөрийн гэсэн эрх чөлөөгүй, бусдаар удирдуулж захируулдаг, хүссэн зүгтээ ч явж болдоггүй, зарц боол байсан билээ. Хэсэг хугацааны дараа би, зарцлалт боолчлолоосоо чөлөөлөгдөж, эрх чөлөөг олсон. Тэр цагаас хойш би, бусдад нэгэнт захирагдахаа больж, болоогүй бүр хүссэн зүгтээ явж болдог эрх чөлөөт нэгэн болсон шүү.” хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Поттхапаада, мөн адил, эд баялаг, хөрөнгө чинээтэй нэгэн баян хүн, хоол хүнс ч олдохооргүй, аюул түгшүүрээр дүүрэн, эзгүй хээрийн замаар аялж байлаа гэж бодъё. Хэсэг хугацааны дараа тэр, элсэн цөлийг гатлаад, амар амгалан, аюул түгшүүргүй нэгэн тосгонд эсэн мэнд ирсэн байг. Энэ болсон явдлаа тэр: “Би, хоол хүнс ч олдохооргүй, аюул түгшүүрээр дүүрэн, эзгүй хээрийн замаар аялж байсан билээ. Хэсэг хугацааны дараа би, тэр элсэн цөлийг гатлаад, амар амгалан, аюул түгшүүргүй нэгэн тосгонд эсэн мэнд хүрээд ирсэн шүү.” хэмээн эргэн эргэцүүлж бодоод, хөөрч баярлан, сэтгэлийн цэнгэлийг тэр эдлэх болно.

Яг үүний адилаар, Поттхапаада, хувраг хүн өөрийн дотор эдгээр таван-саадыг арилаагүй байгааг мэдэх үедээ, үүнийг өр шир, өвчин зовлон, шорон гяндан, зарцлалт боолчлол, элсэн цөл, эдгээртэй зүйрлүүлэн хардаг учиртай.

Поттхапаада, хувраг хүн өөрийн дотор эдгээр таван-саадыг арилсан байгааг мэдэх үедээ, үүнийг өр ширгүй, өвчин зовлонгүй, шоронгоос суллагдсан, эрх чөлөөтэй, аюул заналгүй болсонтой зүйрлүүлэн хардаг учиртай.

Тэр хувраг хүн, өөрийн дотор эдгээр таван-саадыг арилсан байгааг мэдэх үед, түүний дотор баярлах мэдрэмж төрдөг. Энэ баярлах мэдрэмжээс, түүний дотор хөөр-баяр төрдөг. Түүний сэтгэл хөөр-баяраар дүүрэх үед, түүний бие дотор тайвшрал үүсдэг. Түүний бие тайвшралд орсон үед, тэр аз-жаргалыг мэдэрнэ. Тийн жаргалтай болсон хүний сэтгэл самади-төвлөрөлд оршдог.

Мэдрэхүйн-таашаалаас салснаар, тусгүй-муу Зүйлээс салснаар, тэрбээр зурвас-бодол бүхий, эргэцүүлсэн-бодол бүхий, ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий нэгдүгээр даяан зэрэгт хүрснээр тэр оршин байна.

Энэ үед, түүнд өмнө нь байсан мэдрэхүйн-таашаалын танин-мэдэхүй нь устан алга болсон байдаг. Харин түүнд, ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр болон аз-жаргал талаарх, нарийн түвшний бөгөөд үнэн бодит танин-мэдэхүй үүсэн бий болдог. Бясалгал дасгалын явцад, зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, зарим төрлийн танин-мэдэхүй устдаг гэж үүнийг л хэлсэн хэрэг юм. Энэ бол мөнөөх бясалгал дасгал юм.

Цаашилбал, тэр хуврагийн зурвас-бодол, эргэцүүлсэн-бодол намжиж, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий, дотоод амар-амгалан, оюуны-нэгдэл бүхий, хоёрдугаар даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байна.

Энэ үед, түүнд өмнө нь байсан, ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр аз-жаргалын талаарх танин-мэдэхүй нь устан алга болсон байдаг. Харин түүнд, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргалын талаарх, нарийн түвшний бөгөөд үнэн бодит танин-мэдэхүй үүсэн бий болдог. Бясалгал дасгалын явцад, зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, зарим төрлийн танин-мэдэхүй устдаг гэж үүнийг л хэлсэн хэрэг юм. Энэ бол мөнөөх бясалгал дасгал юм.

Цаашилбал, тэр хувраг, хөөр-баяраас салж-ангижирснаар, дүүрэн-анхаарал тунгалаг-оюун бүхий төв-оршихуйд байж, аз-жаргалыг бие махбодоороо мэдрэх ба үүнийг Гэгээнтнүүд, “Төв-оршихуйд, дүүрэн-анхааралтай, аз-жаргалд умбав” хэмээн нэрийдэх буюу ингэж гуравдугаар даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байна.

Энэ үед, түүнд өмнө нь байсан, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргалын талаарх танин-мэдэхүй нь устан алга болсон байдаг. Харин түүнд, хөөр-баяраас салсан, төв-оршихуйн аз-жаргалын талаарх, нарийн түвшний бөгөөд үнэн бодит танин-мэдэхүй үүсэн бий болдог. Бясалгал дасгалын явцад, зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, зарим төрлийн танин-мэдэхүй устдаг гэж үүнийг л хэлсэн хэрэг юм. Энэ бол мөнөөх бясалгал дасгал юм.

Цаашилбал, тэр хувраг, жаргалаас салж-ангижирснаар, зовлонгоос салж-ангижирснаар, урьдын таатай хийгээд таагүй байдал алга болсноор, жаргал зовлонгийн аль нь ч бус, төв-оршихуйгаас үүссэн дүүрэн-анхаарлын ариусал, дөрөвдүгээр даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байна.

Энэ үед, түүнд өмнө нь байсан, төв-оршихуйн аз-жаргалын талаарх танин-мэдэхүй нь устан алга болсон байдаг. Харин түүнд, жаргал зовлонгийн аль нь ч бус мэдрэмжийн талаарх, нарийн түвшний бөгөөд үнэн бодит танин-мэдэхүй үүсэн бий болдог. Бясалгал дасгалын явцад, зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, зарим төрлийн танин-мэдэхүй устдаг гэж үүнийг л хэлсэн хэрэг юм. Энэ бол мөнөөх бясалгал дасгал юм.

Цаашилбал тэрээр, бие-дүрст юмсын танин-мэдэхүйгээс нэгэнт хальснаар, "орон зай хязгааргүй"-г оршоон бясалгаснаар, юмсын төрөл зүйлийг танин-мэдэхүйд анхаарал эс хандуулснаар, аливаад үзүүлэх хариу үйлдэл үгүй болсноор, тэр Хязгааргүй Орон Зайн Оронд[248] ордог.

Энэ үед, түүнд өмнө нь байсан, бие-дүрст юмсын танин-мэдэхүй нь устан алга болсон байдаг. Харин түүнд, Хязгааргүй Орон Зайн Орны талаарх, нарийн түвшний бөгөөд үнэн бодит танин-мэдэхүй үүсэн бий болдог. Бясалгал дасгалын явцад, зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, зарим төрлийн танин-мэдэхүй устдаг гэж үүнийг л хэлсэн хэрэг юм. Энэ бол мөнөөх бясалгал дасгал юм.

Цаашилбал тэрээр, Хязгааргүй Орон Зайн Орноос нэгэнт хальж, "ухамсар хязгааргүй"-г оршоон бясалгаснаар, Хязгааргүй Ухамсрын Оронд[249] ордог.

Энэ үед, түүнд өмнө нь байсан, Хязгааргүй Орон Зайн Орны танин-мэдэхүй нь устан алга болсон байдаг. Харин түүнд, Хязгааргүй Ухамсрын Орны талаарх, нарийн түвшний бөгөөд үнэн бодит танин-мэдэхүй үүсэн бий болдог. Бясалгал дасгалын явцад, зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, зарим төрлийн танин-мэдэхүй устдаг гэж үүнийг л хэлсэн хэрэг юм. Энэ бол мөнөөх бясалгал дасгал юм.

Цаашилбал тэрээр, Хязгааргүй Ухамсрын Орноос нэгэнт хальж, "оргүй хоосон"-ыг оршоон бясалгаснаар, Огт-Оргүйн Оронд[250] ордог.

Энэ үед, түүнд өмнө нь байсан, Хязгааргүй Ухамсрын Орны танин-мэдэхүй нь устан алга болсон байдаг. Харин түүнд, Огт-Оргүйн Орны талаарх, нарийн түвшний бөгөөд үнэн бодит танин-мэдэхүй үүсэн бий болдог. Бясалгал дасгалын явцад, зарим төрлийн танин-мэдэхүй үүсэж, зарим төрлийн танин-мэдэхүй устдаг гэж үүнийг л хэлсэн хэрэг юм. Энэ бол мөнөөх бясалгал дасгал юм.

Поттхапаада, ингэж хувраг хүн, өөрийн танин-мэдэхүйг мэдэлдээ оруулж чадсан үеэс эхлэн тэр нэг түвшнээс нөгөө түвшинд ахиж, аажмаар танин-мэдэхүйн оргилд хүрдэг. Танин-мэдэхүйн оргилд хүрсэн байхдаа тэр: 'Аливаа санаа сэдэл[251] бол надад илүү муу нөлөөтэй юм. Санаа сэдэлгүй байх нь харин тустай байдаг юм байна. Учир нь, хэрэв би аливааг санах сэдэх үйлийг хийвээс, мөнөөх ухаарсан танин-мэдэхүй

[248] Мьянмар эхэд "Хязгааргүй Орон Зайн Орны Даянд ордог." гэжээ (MPA). Бие-бусын даяаныг Лавлахад үз.

[249] Мьянмар эхэд "Хязгааргүй Ухамсрын Орны Даянд ордог." гэжээ (MPA). Бие-бусын даяаныг Лавлахад үз.

[250] Мьянмар эхэд "Огт-Оргүйн Орны Даянд ордог." гэжээ (MPA). Бие-бусын даяаныг Лавлахад үз.

[251] *Cetayamānassa*—"санаа сэдэл". Зарим орчуулгад "зорилготой байх" (анг. *intentionality*) гэжээ.

минь, надаас үгүй болж, өөр болхи танин-мэдэхүйн санаа сэдэл үүсэн бий болдог. Яахаараа би, ямар ч санаа, ямар ч сэдлийг үүсгэн бий болгохгүй байж болгохгүй гэж?' хэмээн түүний санаанд буудаг.

Ингээд тэр, юуг ч санаашрахгүй, юуг ч сэдэхгүй.

Ийнхүү, мөнөөх ухаарсан танин-мэдэхүй л түүнд байсаар байхаас бус, харин өөр болхи танин-мэдэхүй түүнд шинээр үүсэн бий болдоггүй.

Ингэж тэр төгсгөлд[252] хүрдэг.

Энэ бол, Поттхапаада, тунгалаг-оюунаар дээд танин-мэдэхүй аажмаар үгүй болдог түвшин[253] юм.

Та юу гэж бодож байна, Поттхапаада? Та өмнө нь энэ талаар сонсож байв уу?"

"Үгүй Эрхэм ээ, би сонсож байгаагүй юм байна.

Би таны хэлсэн зүйлийг ингэж ойлголоо:

'Хувраг хүн, өөрийн танин-мэдэхүйг мэдэлдээ оруулж чадсан үеэс эхлэн тэр нэг түвшнээс нөгөө түвшинд ахиж, аажмаар танин-мэдэхүйн оргилд хүрдэг. Танин-мэдэхүйн оргилд хүрсэн үедээ тэр, 'Аливаа санаа сэдэл бол надад илүү муу нөлөөтэй юм. Санаа сэдэлгүй байх нь харин тустай байдаг юм байна. Учир нь, хэрэв би аливааг санах сэдэх үйлийг хийвээс, мөнөөх ухаарсан танин-мэдэхүй минь надаас үгүй болж, өөр болхи танин-мэдэхүйн санаа сэдэл үүсэн бий болдог. Яахаараа би, ямар ч санаа, ямар ч сэдлийг үүсгэн бий болгохгүй байж болгохгүй гэж?' хэмээн түүний санаанд буудаг. Ингээд тэр, юуг ч санаашрахгүй, юуг ч сэдэхгүй. Ийнхүү, мөнөөх ухаарсан танин-мэдэхүй л түүнд байсаар байхаас бус, харин өөр болхи танин-мэдэхүй түүнд шинээр үүсэн бий болдоггүй. Ингэж тэр төгсгөлд хүрдэг. Энэ бол тунгалаг-оюунаар дээд танин-мэдэхүй аажмаар үгүй болдог түвшин юм."

"Тийм ээ. Поттхапаада."

Тэгээд Поттхапаада асуув:

"Эрхэм ээ, Будда танин-мэдэхүйн зөвхөн нэг л оргилыг тайлбарладаг уу? Эсвэл олон төрлийн оргилууд гэж байдаг уу?"

"Би танин-мэдэхүйн оргилыг нэг ч байдаг, мөн олон ч байж болдог гэж тайлбарладаг."

"Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг нэг оргилтой болон олон оргилтой гэж хэрхэн яаж тайлбарлах сан бол?"

"Би танин-мэдэхүйн оргил үеийг тухайн хүний хэрхэн төгсгөлд хүрсэн байна, тэр байр байдлаар нь авч үзэж тодорхойлдог. Тийм болохоор, би үүнийг нэг оргилтой, бас олон оргилтой гэж аль алинаар нь зааж сургадаг."

---

252 *Nirodhaṁ*—"төгсгөлд". Өөрөөр хэлбэл, зовлонг төгсгөх буюу Гэгээрэлд хүрдэг.

253 *Samāpatti*—"түвшин". Бясалгал, гэгээрлийн "түвшин", ахисан "зэрэг", "ололт амжилт" гэсэн санаа.

“Тэгвэл Эрхэм ээ, эхлээд танин-мэдэхүй, дараа нь мэдлэг ухаарал[254] үүсдэг үү? Эсвэл эхлээд мэдлэг ухаарал бий болж, дараа нь танин-мэдэхүй үүсдэг үү? Эсвэл бүр хоёулаа нэгэн зэрэг үүсдэг юм уу?”

“Эхлээд танин-мэдэхүй, дараа нь мэдлэг ухаарал үүснэ, Поттхапаада. Танин-мэдэхүй байж гэмээ нь, мэдлэг ухаарал үүсэх шалтгаан нь болдог.

Хувраг хүн:

‘Миний мэдлэг ухаарал бол нөхцөл шалтгааны улмаас үүссэн.’ гэдгийг ойлгодог.

Ингэж ойлго: Танин-мэдэхүй эхлээд үүснэ. Дараа нь мэдлэг ухаарал үүснэ. Танин-мэдэхүй үүсэх нь мэдлэг ухаарлыг үүсэхэд хүргэнэ.”

1.3. Танин-Мэдэхүй ба Өөрийн-Оршихуй (Saññāattakathā)

“Эрхэм ээ, танин-мэдэхүй чинь, хүний өөрийн-оршихуй нь юм уу, эсвэл танин-мэдэхүй болон хүний өөрийн-оршихуй хоёр маань, тусдаа салангид зүйлүүд юм уу?”

“Поттхапаада, та ямар гээч өөрийн-оршихуйд итгэчихсэн хэрэг вэ?”

“Эрхэм ээ, гал, ус, газар, агаар гэсэн язгуур дөрвөн махбодоос бүрдсэн, бие-дүрст хоол хүнс хэрэглэдэг, бие-дүрст өөрийн-оршихуй байдаг гэдэгт, би итгэж байна.”

“Поттхапаада, гал, ус, газар, агаар гэсэн язгуур дөрвөн махбодоос бүрдсэн, бие-дүрст хоол хүнс хэрэглэдэг, бие-дүрст, тийм өөрийн-оршихуй байдаг байлаа гэж бодъё. Тийм тохиолдолд, таны танин-мэдэхүй нь тусдаа, өөрийн-оршихуй чинь өөр тусдаа зүйл болж таарна.

Тэгснээс Поттхапаада, ийм аргаар танин-мэдэхүй болон өөрийн-оршихуй хоёр яагаад тусдаа зүйлүүд болохыг ойлгож болох юм. Язгуур дөрвөн махбодоос бүрдсэн, бие-дүрст хоол хүнс хэрэглэдэг, бие-дүрст, тийм өөрийн-оршихуй хүнд байсаар байгаа атал, тухайн хүнд зарим танин-мэдэхүй үүсэж байдаг, мөн зарим танин-мэдэхүй үгүй болж байдаг. Ийм байгаа болохоор танин-мэдэхүй болон өөрийн-оршихуй хоёр бол тусдаа зүйлүүд болж таарах нь байна гэж ойлгож болно.”

“Эрхэм ээ, бүх чадвар бүрэн, эд эрхтэн бүтэн, оюунаар-бүтсэн, тийм өөрийн-оршихуй байдаг гэдэгт, би итгэж байна.”

“Поттхапаада, бүх чадвар бүрэн, эд эрхтэн бүтэн, оюунаар-бүтсэн, тийм өөрийн-оршихуй байдаг байлаа гэж бодъё. Тийм тохиолдолд, мөн л адил, таны танин-мэдэхүй нь тусдаа, өөрийн-оршихуй чинь өөр тусдаа зүйл болж таарна.

Тэгснээс Поттхапаада, ийм аргаар танин-мэдэхүй болон өөрийн-оршихуй хоёр яагаад тусдаа зүйлүүд болохыг ойлгож болох юм. Бүх чадвар бүрэн, эд эрхтэн бүтэн, оюунаар-бүтсэн, тийм өөрийн-оршихуй

[254] *Ñāṇa*—“мэдлэг ухаарал”. Эсвэл “ухаарлын мэдлэг”, “ухаан мэдлэг”. Зарим тохиолдолд, бясалгалын шат ахисан түвшин эсвэл “гэгээрэл ухаарал” г.м. Гэгээрэлтэй холбоотой утгад хэрэглэнэ (VM).

хүнд байсаар байгаа атал, тухайн хүнд зарим танин-мэдэхүй үүсэж байдаг, мөн зарим танин-мэдэхүй үгүй болж байдаг. Ийм байгаа болохоор танин-мэдэхүй болон өөрийн-оршихуй хоёр бол тусдаа зүйлүүд болж таарах нь байна гэж ойлгож болно.”

“Эрхэм ээ, би танин-мэдэхүйгээс бүрдсэн, бие дүрсгүй, бие-бус өөрийн-оршихуй байдаг гэдэгт, би итгэж байна.”

“Поттхапаада, танин-мэдэхүйгээс бүрдсэн, бие дүрсгүй, бие-бус өөрийн-оршихуй байдаг байлаа гэж бодъё. Тийм тохиолдолд, мөн л адил, таны танин-мэдэхүй нь тусдаа, өөрийн-оршихуй чинь өөр тусдаа зүйл болж таарна.

Тэгснээс Поттхапаада, ийм аргаар танин-мэдэхүй болон өөрийн-оршихуй хоёр яагаад тусдаа зүйлүүд болохыг ойлгож болох юм. Танин-мэдэхүйгээс бүрдсэн, бие дүрсгүй, бие-бус өөрийн-оршихуй хүнд байсаар байгаа атал, тухайн хүнд зарим танин-мэдэхүй үүсэж байдаг, мөн зарим танин-мэдэхүй үгүй болж байдаг. Ийм байгаа болохоор танин-мэдэхүй болон өөрийн-оршихуй хоёр бол тусдаа зүйлүүд болж таарах нь байна гэж ойлгож болно.”

“Тэгвэл Эрхэм ээ, хүний танин-мэдэхүй нь тухайн хүний өөрийн-оршихуй нь юм уу, эсвэл бүр танин-мэдэхүй болон тухайн хүний өөрийн-оршихуй хоёр нь өөр тусдаа зүйлүүд юм уу гэдгийг би хэрхэн яаж мэдэх болж байна аа?

“Та бол өөр үзэл баримтлалтай, өөр номлол дасгалтай, өөр итгэл үнэмшилтэй, өөр урсгалын, өөр багштай тул, танин-мэдэхүй бол тухайн хүний өөрийн-оршихуй нь юм уу, эсвэл танин-мэдэхүй болон тухайн хүний өөрийн-оршихуй хоёр нь өөр тусдаа зүйлүүд юм уу гэдгийг ойлгоход танд бэрх байх болно.”

“За тэгвэл Эрхэм ээ, би нэгэнт өөр үзэл баримтлалтай, өөр номлол дасгалтай, өөр итгэл үнэмшилтэй, өөр урсгалын, өөр багштай болохоор, танин-мэдэхүй бол тухайн хүний өөрийн-оршихуй нь юм уу, эсвэл танин-мэдэхүй болон тухайн хүний өөрийн-оршихуй хоёр нь өөр тусдаа зүйлүүд юм уу гэдгээ ойлгоход надад бэрх байдаг байж.

Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ? ‘Хорвоо мөнх. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Хорвоо мөнх. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ? ‘Хорвоо мөнх бус. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Хорвоо мөнх бус. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Хорвоо хязгаартай. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Хорвоо хязгаартай. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Хорвоо хязгааргүй. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Хорвоо хязгааргүй. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Хүний амь, хүний бие хоёр бол нэг зүйл. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Хүний амь, хүний бие хоёр бол нэг зүйл. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Хүний амь, хүний бие хоёр бол хоёр тусдаа зүйл. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Хүний амь, хүний бие хоёр бол хоёр тусдаа зүйл. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Будда үхлийн дараа оршсоор байдаг. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Будда үхлийн дараа оршсоор байдаг. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Будда үхлийн дараа оршин байдаггүй. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Будда үхлийн дараа оршин байдаггүй. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Будда үхлийн дараа оршин байх байхгүй, аль аль төлөвт байна. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Будда үхлийн дараа, оршин байх байхгүй аль аль төлөвт байдаг. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Тэгвэл Эрхэм ээ, та үүнийг юу гэж тайлбарлах вэ?

‘Будда үхлийн дараа оршин байх байхгүй, аль ч төлөвт байдаггүй. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’”

“Поттхапаада, Би, ‘Будда үхлийн дараа, оршин байх байхгүй аль ч төлөвт байдаггүй. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж тунхаглаагүй билээ.”

“Эрхэм ээ, яагаад эдгээр зүйлсийг Будда огт тунхаглаагүй хэрэг вэ?”

“Учир юу гэвэл, Поттхапаада, эдгээр нь Сургаалтай хамааралгүй, ариуслын-замналын үндэс суурь болохгүй, алмайрал-үгүй[255] болохуйд, салж-ангижрахуйд[256], зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд[257], шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирваaныг олоход, огтхон ч ашиг тусгүй болохоор тэр билээ.[258]

Тийм болохоор би, тийн тунхаглаагүй билээ, Поттхапаада.”

“Тэгвэл, Будда юуг тунхагласан юм бэ?”

“Би:

‘Энэ бол зовлон.’ гэдгийг тунхагласан.

‘Энэ бол зовлонгийн шалтгаан.’ гэдгийг тунхагласан.

‘Энэ бол зовлонгийн төгсгөл.’ гэдгийг тунхагласан.

‘Энэ бол зовлонгийн төгсгөлд хүргэх замнал.’ гэдгийг тунхагласан билээ.”

“Эрхэм ээ, Будда яагаад эдгээр зүйлсийг зааж тунхагласан юм бэ?”

“Учир юу гэвэл, Поттхапаада, эдгээр нь Сургаалд хамааралтай, ариуслын-замналын үндэс суурь болдог, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирваaныг олоход, чухамхүү ашиг тустай болохоор тэр билээ.[259]

Тийм болохоор би, ийн зааж тунхагласан билээ, Поттхапаада.”

“Үнэхээр тийм байх нь, Ерөөлтэй Нэгэн минь! Үнэхээр тийм байх нь, Зөвөөр Одогч[260] минь! Эрхэм ээ, хэрвээ танд амжуулах ажил байгаа аваас, та өөрийнхөө таалллаар болгоогоорой.” хэмээн Поттхапаада хэллээ. Тэгээд Будда суудлаасаа босоод тэндээс гаран оджээ.

---

255 *Nibbidāya*—“алмайрал-үгүй”. Аливаа зүйлд сэтгэлд татагдах, баясах, алмайрах байдлыг үгүй хийсэн байх гэсэн санаа. Бясалгал, Гэгээрлийн түвшин ахих шатанд тогтвортойгоор алмайрал-үгүй болно гэж үздэг (VM).

256 *Virāga*—“салж-ангижрахуй”. Дур-хүслээс (1. мэдрэхүйн; 2. даяаны, Нарийн-биеийн Орны; 3. Бие-бусын Орны) салж ангижрахуй, салсан байдал. (“дур-хүсэл”-ийг Лавлахад үз.)

257 *Upasamaya*—“амгаланг-олохуй”. Гэгээрлийг олохуйтай дүйцэх утга. (Тайлбарт Нирваан хэсгийг үз.)

258 Мьянмар эхэд: “...эдгээр нь хүнд өөрт өгөөжгүй, Сургаал номтой авцалдахгүй, Гэгээрлийн Замналын бүр эхлэл нь ч биш, таван-цулын мунхаг-төөрөгдлөөс гарахад нэмэргүй, хүсэл шуналаас салахад нэмэргүй, зовлонг нэгмөсөн дуусгахад нэмэргүй, оюуны-хорлолыг нэгмөсөн төгсгөхөд нэмэргүй, “Урсгалд Ороход” нэмэргүй, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг ухаарахад нэмэргүй, Нирваaныг ухаарахад нэмэр тусгүй болохоор би заагаагүй...” гэжээ (MPA).

259 Мьянмар эхэд: “...эдгээр нь хүнд өөрт өгөөж тустай, Сургаал номтой уялдах, Гэгээрлийн Замналын эхлэл нь, таван-цулын мунхаг-төөрөгдлөөс гарахад тустай, хүсэл шуналаас салахад тустай, зовлонг нэгмөсөн дуусгахад тустай, оюуны-хорлолыг нэгмөсөн төгсгөхөд тустай, “Урсгалд Ороход” тустай, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг ухаарахад тустай, Нирваaныг ухаарахад нэмэр тустай болохоор би заасан...” гэжээ (MPA).

260 *Sugata*—“Зөвөөр Одогч”. Буддаг хүндлэн нэрлэх нэгэн нэр. Тайлбарт Буддаг үз.

Ингээд Буддаг гарч явсны дараа, тэнд байсан даянчид Поттхапаадаг тал талаас нь доог тохуу хийж, элдвээр гоочилж, ийм маягаар хэлцгээж байлаа:

“Даянч Готама юу ч хэлсэн, Поттхапаада түүнтэй, ‘Үнэхээр тийм байх нь, Ерөөлтэй Нэгэн минь! Үнэхээр тийм байх нь, Зөвөөр Одогч минь!’ гээд л, шувт санал нийлэх юм. Даянч Готамагийн хэлсэн ‘Хорвоо мөнх. Эсвэл мөнх бус. Хорвоо хязгаартай. Эсвэл хорвоо хязгааргүй. Хүний амь, хүний бие хоёр бол нэг зүйл. Эсвэл хүний амь, хүний бие хоёр бол хоёр тусдаа зүйл. Будда үхлийн дараа оршсоор байдаг. Эсвэл оршин байдаггүй. Будда үхлийн дараа оршин байх байхгүй, аль аль төлөвт байна. Эсвэл Будда үхлийн дараа оршин байх байхгүй, аль ч төлөвт байдаггүй юу…’ энэ бүгдийн талаар, бид лав юу ч ойлгосонгүй.”

Тэднийг ингэж хэлэхэд, Поттхапаада тэдэнд хандан:

“Даянч Готама, энэ хорвоо ертөнц мөнх үү мөнх бус уу, хязгаартай эсвэл хязгааргүй, амь бие хоёр нэг үү тусдаа юу, гээд олон зүйлийн талаар хэлсэн, тайлбар яриаг нь би ч бас ойлгосонгүй. Гэсэн хэдий ч, түүний заасан дасгал бясалгал нь илтэд үнэн, чухам бодитой, бас тун оновчтой байна. Тэдгээр нь, байгаль ертөнцийн тогтвортой оршдог хууль зарчимтай таарч нийцэж, байгаль ертөнцийн хувьсан өөрчлөгддөг шинж чанартай мөн нийцэж байна.

Тийм болохоор, даянч Готамагийн төгс төгөлдөр тодорхойлон заасан, чухам үнэн энэ сургаалтай ямарваа юмны учир зүйг ялгаж салгадаг хүний хувьд би, яахан санал нийлэхгүй байж болох билээ дээ?” хэмээн хэлжээ.

2. Читта Хаттхисаарипуттагийн Тухай (Cittahatthisāriputtapoṭṭhapādavatthu)

Тэгээд, үүнээс хэд хоног өнгөрсний дараа, Читта Хаттхисаарипутта[261] болон Поттхапаада нар Буддатай уулзахаар очлоо. Читта Хаттхисаарипутта, Буддад сөгдөж мөргөөд, хажуу талд нь суув. Бадарчин Поттхапаада Буддатай мэнд мэдэн, мэндчилгээ, элдэг дотно яриа дууссаны дараа мөн хажуу тал руу суув. Энэ үед Поттхапаада:

“Хэдхэн хоногийн өмнө, таныг явсны дараа тэнд байсан даянчид намайг тал талаас минь дооглож гоочилж:

‘Даянч Готама юу ч хэлсэн, Поттхапаада түүнтэй, “Үнэхээр тийм байх нь, Ерөөлтэй Нэгэн минь! Үнэхээр тийм байх нь, Зөвөөр Одогч минь!” гээд л, шувт санал нийлэх юм. Даянч Готамагийн хэлсэн “Хорвоо мөнх. Эсвэл мөнх бус. Хорвоо хязгаартай. Эсвэл хорвоо хязгааргүй. Хүний амь, хүний бие хоёр бол нэг зүйл. Эсвэл хүний амь, хүний бие хоёр бол хоёр тусдаа зүйл. Будда үхлийн дараа оршсоор байдаг.

[261] *Hatthisāriputta*—“Хаттхисаарипутта”. Үгчилбэл, “заан сургагчийн хүү”. Зарим тайлбарт түүнийг заан сургагчийн хүү байсан гэжээ (Aṭṭhakathā).

Эсвэл оршин байдаггүй. Будда үхлийн дараа оршин байх байхгүй, аль аль төлөвт байна. Эсвэл Будда үхлийн дараа оршин байх байхгүй, аль ч төлөвт байдаггүй юу...” энэ бүгдийн талаар, бид лав юу ч ойлгосонгүй гэж тэд хэлсэн ба тэднийг ингэж хэлэхэд нь би:

‘Даянч Готама, энэ хорвоо ертөнц мөнх үү мөнх бус уу, хязгаартай эсвэл хязгааргүй, амь бие хоёр нэг үү тусдаа юу, гээд олон зүйлийн талаар хэлсэн тайлбар яриаг нь би ч бас ойлгосонгүй. Гэсэн хэдий ч, түүний заасан дасгал бясалгал нь илтэд үнэн, чухам бодитой, бас тун оновчтой байна. Тэдгээр нь, байгаль ертөнцийн тогтвортой оршдог хууль зарчимтай таарч нийцэж, байгаль ертөнцийн хувьсан өөрчлөгддөг шинж чанартай мөн нийцэж байна.

Тийм болохоор, даянч Готамагийн төгс төгөлдөр тодорхойлон заасан, чухам үнэн энэ сургаалтай ямарваа юмны учир зүйг ялгаж салгадаг хүний хувьд би, яахан санал нийлэхгүй байж болох билээ дээ?’ гэж би тэдэнд хариулсан билээ.” хэмээн, тэнд болсон явдлын талаар Буддад ярив.

“Поттхапаада, тэдгээр даянчид бүгд хараагүй, сохор байна. Харин чиний хараа саруул тунгалаг байна. Миний сургаж зааж тунхагласан Зүйлүүдийн зарим нь гарцаагүй тодорхой, зарим нь бүдэг бүрхэг[262] байдаг билээ. Тэгвэл би ямар Зүйлсийг тодорхой нарийн ангилан зааж, ямар Зүйлсийг тодорхой нарийн зааж тунхаглаагүй бол?

Миний, тодорхой нарийн зааж тунхаглаагүй Зүйлс бол, ‘Энэ хорвоо ертөнц мөнх, эсвэл мөнх бус, хязгаартай, эсвэл хязгааргүй, амь бие хоёр бол нэг зүйл, эсвэл амь бие хоёр бол хоёр тусдаа зүйл, Будда үхлийн дараа оршсоор байдаг, эсвэл Будда үхлийн дараа оршин байхгүй, эсвэл Будда үхлийн дараа оршин байх байхгүй аль аль төлөвт байдаг, эсвэл Будда үхлийн дараа оршин байх байхгүй аль ч төлөвт байдаггүй.’ Эдгээр Зүйлсийг би тодорхой нарийн зааж тунхаглаагүй билээ.

Эдгээр Зүйлсийг би, ямар учир шалтгаанаар тодорхой нарийн зааж тунхаглаагүй байх вэ?

Учир юу гэвэл, Поттхапаада, эдгээр нь Сургаалтай хамааралгүй, ариуслын-замналын үндэс суурь болохгүй, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирвааныг олоход, огтхон ч нэмэр тусгүй болохоор би зааж тунхаглаагүй билээ.

Тийм болохоор би, тэдгээр Зүйлсийг бүдэг бүрхэг хэмээн тунхаглан хэлнэ.

2.1. Гарцаагүй Итгэлтэй Сургаалууд (Ekaṁsikadhammā)

Тэгвэл би ямар Сургаалыг гарцаагүй[263] итгэлтэйгээр зааж тунхагласан бол?

---

[262] *Anekaṁsikā*—“бүдэг бүрхэг”. Өөрөөр, “тодорхой хариулт өгөлгүй орхисон”. Зарим эхэд, “Нирвaанд хөтлөх эсэх нь тодорхойгүй” (MPA), өөрөөр “ангилан зарлаагүй” (анг. *not to be declared categorically*) гэжээ (BS).

[263] *Ekaṁsikā*—“гарцаагүй”. Зарим эхэд, “Нирвaанд хөтлөх нь гарцаагүй” гэдэг утгаар (MPA), өөрөөр, “ангилан заасан” (анг. *to be declared categorically*) гэжээ (BS)..

Би энэ Сургаалыг гарцаагүй итгэлтэйгээр зааж тунхагласан билээ.

Поттхапаада, ‘Энэ бол зовлон.’ гэж би зааж тунхагласан билээ.

Поттхапаада, ‘Энэ бол зовлонгийн шалтгаан.’ гэдгийг би зааж тунхагласан билээ.

Поттхапаада, ‘Энэ бол зовлонгийн төгсгөл.’ гэдгийг би зааж тунхагласан билээ.

Поттхапаада, ‘Энэ бол зовлонгийн төгсгөлд хүргэх замнал.’ гэдгийг би зааж тунхагласан билээ.

Энэ л Сургаалыг би гарцаагүй итгэлтэйгээр зааж тунхагласан билээ.

Учир юу гэвэл, Поттхапаада, эдгээр нь Сургаалд хамааралтай, ариуслын-замналын үндэс суурь болдог, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирвааныг олоход, чухамхүү ашиг тустай болохоор тэр билээ.

Тийм болохоор, Поттхапаада, би эдгээр Сургаалыг гарцаагүй итгэлтэйгээр зааж тунхагласан юм.

Зарим даянч, эсвэл бярман нар иймэрхүү сургаал үзэл номлолтой байдаг:

‘Хүний Сүнс[264] үхсэний дараа өвчин зовлонгүй, дээд зэргийн жаргалтай болдог.’

Би тэднээс ингэж асуудаг:

‘Энэ үнэхээр үнэн гэж үү? Эрхэм Багш аа, энэ таны үзэл сургаал юм уу?’ гэхэд тэд,

‘Тийм’ гэж хариулдаг.

Би тэднээс:

‘Тэгвэл та нөхөд тэр чигээрээ дээд зэргийн жаргалтай, тэр ертөнцийг мэддэг, хардаг хэрэг үү?’ гэж асуухад тэд,

‘Үгүй’ гэж хариулдаг.

Би тэднээс:

‘Тэгвэл та нөхөд, бүтэн өдөржин, эсвэл бүхэл шөнөжин, бүр эсвэл хагас өдөр, эсвэл хагас шөнө ч юм уу, тэр чигээрээ дээд зэргийн жаргалтай, тэр ертөнцийг өөр дээрээ мэдэрч байв уу?’ гэж асуухад тэд,

‘Үгүй’ гэж хариулдаг.

Би тэднээс:

‘Тэгвэл та нөхөд, дээд зэргийн жаргалыг олох, тийм арга замнал, дадал бясалгалыг мэдэх үү?’ гэж асуухад тэд,

‘Үгүй’ гэж хариулдаг.

---

[264] *Attā*—“Сүнс”. Бусад хэсэгт “өөрийн-оршихуй” (*attā*) гэж оруулсан үгийг энд “Сүнс” гэж хэрэглэв.

Би тэднээс:

‘Тэгвэл та нөхөд, дээд зэргийн жаргалтай ертөнцөд дараа төрөл авсан, тэнгэр бурхдын, “Эрхмүүд ээ, дээд зэргийн жаргалыг олж авахын тулд дасгал бясалгал хийцгээе. Учир нь бид ингэж дадуулж бясалгаж, дээд зэргийн жаргалын оронд дараа төрөл авсан билээ.” гэж хэлэх дуу хоолойг нь сонсож байсан уу?’ гэж тэднээс асуухад,

‘Үгүй’ гэж хариулдаг.

Та юу гэж бодож байна, Поттхапаада? Ийм байгаа тохиолдолд, тэдний хэлж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан гэж байхгүй хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

“Поттхапаада, хүмүүс хэн нэгэн хүнээс:

‘Ноёнтон минь, таны хүсээд байгаа эндэхийн дээд зэргийн үзэсгэлэнтэй, тэрхүү хатагтай чинь язгууртан юм уу, брамин юм уу, тариачин юм уу, эсвэл доод гарлын хүн юм уу гэдгийг нь та мэдэх үү?’ хэмээн асуухад тэрээр,

‘Мэдэхгүй ээ’ гэж хариулна.

Тэд түүнээс:

‘Ноёнтон минь, таны хүсээд байгаа, эндэхийн дээд зэргийн үзэсгэлэнтэй, тэрхүү хатагтай чинь ямар гарал угсаатай, ямар овог нэртэй вэ гэдгийг нь та мэдэх үү? Тэр өндөр үү, нам уу, эсвэл дунд зэргийн нуруутай юу? Түүний арьс нь хар уу, бор уу, эсвэл шаргал уу? Тэр ямар хот, ямар тосгон, ямар суурингаас ирсэн билээ?’ гэх зэргээр асуухад тэр хүн,

‘Мэдэхгүй ээ’ гэж хариулна.

Тэд түүнээс:

‘Ноёнтон минь, та ерөөсөө ч мэдэхгүй, хэзээ ч хараагүй, тэр хүнийг хүсээд дурлаад байгаа хэрэг үү?’ гэж асуухад тэрээр,

‘Тийм ээ’ гэж хариулна.

Та юу гэж бодож байна, Поттхапаада? Ийм байгаа тохиолдолд, тэр хүний хэлж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан гэж байхгүй хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

“Үүний нэгэн адил Поттхапаада, ‘Хүний Сүнс үхсэний дараа өвчин зовлонгүй, дээд зэргийн жаргалтай болдог.’ гэсэн үзэл номлолтой даянч болон брамин нарын хэлж сургаж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан гэж байхгүй хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

“Хэн нэгэн хүн, газраас хөндий, шувуун хөлтэй[265], ямар нэг орд өргөө өөд доороос нь авирч ордог, дүүжин шат гишгүүр барих гэж байна гэж бодъё.

Хүмүүс түүнээс:

‘Ноёнтон минь, тэр дүүжин шат гишгүүр барих гээд байгаа, газраас хөндий, шувуун хөлтэй, тэр орд өргөө чинь аль зүгт байгаа юм бэ? Хойд зүг, өмнө зүг, зүүн зүг, баруун зүг, аль зүгт байгааг та мэдэж байгаа юу?’ Эсвэл,

‘Тэр орд өргөө чинь өндөр үү, нам уу, эсвэл дунд зэргийн үү? Хэр өндөр байшин юм бэ?’ гэж асуухад тэрээр,

‘Мэдэхгүй ээ’ гэж хариулна.

Тэд түүнээс:

‘Ноёнтон минь, та ерөөсөө мэдэхгүй, хэзээ ч харж байгаагүй, тийм орд өргөөндөө шат барих гэж байгаа хэрэг үү?’ гэж асуухад тэрээр,

‘Тийм ээ’ гэж хариулна.

Та юу гэж бодож байна, Поттхапаада? Ийм байгаа тохиолдолд, түүний хэлж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан гэж байхгүй хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

“Үүний нэгэн адил Поттхапаада, ‘Хүний Сүнс үхсэний дараа өвчин зовлонгүй, дээд зэргийн жаргалтай болдог.’ гэсэн үзэл номлолтой даянч болон бярман нарын хэлж сургаж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан гэж байхгүй хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

2.2. Гурван Төрлийн Хойд Дүр (Tayoattapaṭilābha)

“Поттхапаада, ийм гурван төрлийн хойд дүр[266] гэж байдаг.

265 Халуун орны бүсэд, чийг болон хорхой шавжаас үүдэн байшинг газраас хөндий барих нь элбэг.

266 *Attapaṭilābha*—“хойд дүр” (анг. *reincarnation.* BS). Үгчилбэл, энэ үг нь, *atta+paṭilābha* (олж авах) буюу “өөрийгөө олох” “өөрийн-оршихуйгаа авах” гэсэн утгатай байна. Үүгээр Будда хойд дүрийг өөрийн-оршихуй (*atta*)-тай дүйцүүлэн тайлбарлажээ. “Хойд дүр”-ийг “дараа төрөл” гэж шууд утгаар нь энд мөн ойлгож болно.

Бие-дүрст хойд дүр[267], оюунаар-бүтсэн хойд дүр[268], бие-бус хойд дүр[269].

Тэгвэл, бие-дүрст хойд дүр гэж юу вэ? Энэ нь язгуур дөрвөн махбодоос бүтсэн, бие дүрстэй бөгөөд бие-дүрст хоол хүнс иддэг, тийм хойд дүр юм.

Оюунаар-бүтсэн хойд дүр гэж юу вэ? Энэ нь бие-дүрст, оюунаар-бүтсэн[270], ур чадвар бүрэн, эд эрхтэн бүтэн, тийм хойд дүр юм.

Харин бие-бус хойд дүр гэж юу вэ? Энэ бол бие дүрсгүй, биет биш, зөвхөн танин-мэдэхүйгээс бүтсэн, тийм хойд дүр юм.

Тэр дүрс биеэс бүтсэн хойд дүрд дахин төрөх явдлыг орхин-одуулахуйн тулд би хүмүүст Сургаалаа заадаг. Та миний заасан Сургаал ёсоор дадуулан үйлдвэл, таны сэтгэлийг хиртүүлээд байгаа тийм зан чанарууд тань алга болж, ариусган гэгээрүүлэх тийм чанарууд нь улам хөгжиж, та энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарна.

Поттхапаада, та дотроо:

‘Миний сэтгэлийг хиртүүлээд байгаа, тэдгээр зан чанаруудаа алга болгож, ариусган гэгээрүүлэх чанаруудаа улам хөгжүүлж болно. Би яг энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарч болж байна. Гэсэн хэдий ч, тийм амьдрал бол үнэхээр зовлонтой.’ гэж бодож болох юм. Гэвч та үүнийг тэгж харах учиргүй юм.

Хэрвээ миний заасан Сургаал ёсоор дадуулан үйлдвэл, хүний сэтгэлийг хиртүүлээд байгаа тийм зан чанарууд нь алга болж, ариусган гэгээрүүлэх тийм чанарууд нь улам хөгжиж, энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарна. Ингэж амьдрах нь, хөөр-баяр, амар-амгалан, дүүрэн-анхаарал тунгалаг-оюуны аз-жаргалыг тэр хүнд авчирдаг билээ. Үүнийг л харин дээд зэргийн жаргалын орон гэнэ.

Мөн, тэр сэтгэл оюунаас бүтсэн хойд дүрд дахин төрөх явдлыг орхин-одуулахуйн тулд би хүмүүст Сургаалаа заадаг. Та миний заасан Сургаал ёсоор дадуулан үйлдвэл, таны сэтгэлийг хиртүүлээд байгаа тийм зан чанарууд тань алга болж, ариусган гэгээрүүлэх тийм чанарууд нь улам хөгжиж, та энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарна.

Поттхапаада, та дотроо:

---

267 *Oḷāriko attapaṭilābhā*—“бие-дүрст хойд дүр”. Эсвэл “бүдүүн бие-дүрст хойд дүр”. *Oḷāriko* нь голдуу бүдүүн, бохир, эсвэл материаллаг гэсэн утгад хэрэглэгдэнэ.

268 *Manomayo attapaṭilābhā*—“оюунаар-бүтсэн хойд дүр”. Үүнд: *Brahmakāyika, Ābhassara, Subhakiṇṇa* Тэнгэрийн орон хамаарна. (Бүрэн жагсаалтыг Тайлбарын Будда хэсэгт үз.)

269 *Arūpo attapaṭilābhā*—“бие-бус хойд дүр”. Бие үгүй төрөл. Үүнд: *Ākāsānañcāyatana, Viññāṇañcāyatana, Ākiñcaññāyatana, Nevasaññānāsaññāyatana* орон хамаарна. (Тайлбарт Будда хэсгийг, Бие-бусын Орныг Лавлахад үз.)

270 Мьянмар орчуулгад “даяаны бясалгалын оюун-ухаанаар бүтсэн” гэжээ (MPA).

‘Миний сэтгэлийг хиртүүлээд байгаа, тэдгээр зан чанаруудаа алга болгож, ариусган гэгээрүүлэх чанаруудаа улам хөгжүүлж болно. Би яг энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарч болж байна. Гэсэн хэдий ч, тийм амьдрал бол үнэхээр зовлонтой.’ гэж бодож болох юм. Гэвч та үүнийг тэгж харах учиргүй юм.

Хэрвээ миний заасан Сургаал ёсоор дадуулан үйлдвэл, хүний сэтгэлийг хиртүүлээд байгаа тийм зан чанарууд нь алга болж, ариусган гэгээрүүлэх тийм чанарууд нь улам хөгжиж, энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарна. Ингэж амьдрах нь, хөөр-баяр, амар-амгалан, дүүрэн-анхаарал тунгалаг-оюуны аз-жаргалыг тэр хүнд авчирдаг билээ. Үүнийг л харин дээд зэргийн жаргалын орон гэнэ.

Мөн, тэр бие-бус хойд дүрд дахин төрөх явдлыг орхин-одуулахуйн тулд би хүмүүст Сургаалаа заадаг. Та миний заасан Сургаал ёсоор дадуулан үйлдвэл, таны сэтгэлийг хиртүүлээд байгаа тийм зан чанарууд тань алга болж, ариусган гэгээрүүлэх тийм чанарууд нь улам хөгжиж, та энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарна.

Поттхапаада, та дотроо:

‘Миний сэтгэлийг хиртүүлээд байгаа, тэдгээр зан чанаруудаа алга болгож, ариусган гэгээрүүлэх чанаруудаа улам хөгжүүлж болно. Би яг энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарч болж байна. Гэсэн хэдий ч, тийм амьдрал бол үнэхээр зовлонтой.’ гэж бодож болох юм. Гэвч та үүнийг тэгж харах учиргүй юм.

Хэрвээ миний заасан Сургаал ёсоор дадуулан үйлдвэл, хүний сэтгэлийг хиртүүлээд байгаа тийм зан чанарууд нь алга болж, ариусган гэгээрүүлэх тийм чанарууд нь улам хөгжиж, энэ насандаа, өөрийн бие дээр шууд-билгүүнээр ухаарснаар, тэр зэрэгт хүрч амьдарна. Ингэж амьдрах нь, хөөр-баяр, амар-амгалан, дүүрэн-анхаарал тунгалаг-оюуны аз-жаргалыг тэр хүнд авчирдаг билээ. Үүнийг л харин дээд зэргийн жаргалын орон гэнэ.

Поттхапаада, хэрэв хүмүүс биднээс:

‘Найзууд аа, та нарын, орхин-одуулахуйн тулд зааж сургадаг, тэр дүрс биеэс бүтсэн хойд дүр гэж юу юм бэ?’ гэж асуувал:

‘Энэ[271], бол дүрс биеэс бүтсэн тэр хойд дүр.’ гэж хариулна.

Поттхапаада, хэрэв хүмүүс биднээс:

‘Найзууд аа, та нарын, орхин-одуулахуйн тулд зааж сургадаг, тэр оюунаар-бүтсэн хойд дүр гэж юу юм бэ?’ гэж асуувал:

---

[271] *Ayaṁ*—“энэ”. Энд Будда өмнөх 2.1.-д хэлсэн бүх ёгтлол жишээнүүдийг дайруулан хэлж байгаагаас гадна, “энэ” гэдэг нь мөн дөнгөж сая өөрийн тайлбарласан Сургаалаа зааж хэлж байгаа санаа гэж BS үзсэн байна. MW-ийн тайлбарт “энэ” гэдэг нь Будда өөрийн биеийг заагаад хэлсэн гэжээ.

‘Энэ, бол оюунаар-бүтсэн тэр хойд дүр.’ гэж хариулна.

Поттхапаада, хэрэв хүмүүс биднээс:

‘Найзууд аа, та нарын, орхин-одуулахуйн тулд зааж сургадаг, тэр бие-бус хойд дүр гэж юу юм бэ?’ гэж асуувал:

‘Энэ, бол бие-бус тэр хойд дүр.’ гэж хариулна.

Та юу гэж бодож байна, Поттхапаада? Ийм байгаа тохиолдолд, бидний хэлж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан байж байгаа хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

“Хэн нэгэн хүн, газраас хөндий, шувуун хөлтэй, ямар нэг орд өргөө рүү, доороос нь авирч ордог, дүүжин шат гишгүүр барих гэж байна гэж бодъё.

Хүмүүс түүнээс:

‘Ноёнтон минь, дүүжин шат гишгүүр барих гээд байгаа, газраас хөндий, шувуун хөлтэй, тэр орд өргөө чинь аль зүгт байгаа юм бэ? Хойд зүг, өмнө зүг, зүүн зүг, баруун зүг, аль зүгт байгааг та мэдэж байгаа юу?’ Эсвэл,

‘Тэр орд өргөө чинь өндөр үү, нам уу, эсвэл дунд зэргийн үү, хэр өндөр байшин юм бэ?’ гэж асуухад тэр:

‘Энэ, бол тэр дүүжин шат гишгүүр барих гээд байгаа, газраас хөндий, шувуун хөлтэй, орд өргөө байна. Энэ, байшинд би шууд доороос нь дээш авирч ордог шат гишгүүр барьж байгаа юм.’ гэж хариулах болно.

Та юу гэж бодож байна, Поттхапаада? Ийм байгаа тохиолдолд, түүний хэлж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан байж байгаа хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

“Үүний нэгэн адил, Поттхапаада, хэрэв хүмүүс биднээс:

‘Найзууд аа, та нарын, орхин-одуулахуйн тулд зааж сургадаг, тэр дүрс биеэс бүтсэн хойд дүр гэж юу юм бэ?’ гэж асуувал:

‘Энэ, бол дүрс биеэс бүтсэн тэр хойд дүр.’ гэж хариулна.

Поттхапаада, хэрэв хүмүүс биднээс:

‘Найзууд аа, та нарын, орхин-одуулахуйн тулд зааж сургадаг, тэр оюунаар-бүтсэн хойд дүр гэж юу юм бэ?’ гэж асуувал:

‘Энэ, бол оюунаар-бүтсэн тэр хойд дүр.’ гэж хариулна.

Поттхапаада, хэрэв хүмүүс биднээс:

‘Найзууд аа, та нарын, орхин-одуулахуйн тулд зааж сургадаг, тэр бие-бус хойд дүр гэж юу юм бэ?’ гэж асуувал:

‘Энэ, бол бие-бус тэр хойд дүр.’ гэж хариулна.

Та юу гэж бодож байна, Поттхапаада? Ийм байгаа тохиолдолд, бидний хэлж байгаа зүйлсэд итгэх үнэмших үндэслэл, учир шалтгаан байж байгаа хэрэг биш гэж үү?”

“Үнэхээр л тийм байхаар байна. Эрхэм ээ.”

Буддаг ийн хэлэх үед, Читта Хаттхисаарипутта ийн асуув:

“Эрхэм Багш аа, бие-дүрст хойд дүрийг авсан байгаа үед оюунаар-бүтсэн хойд дүр болон бие-бус хойд дүрүүд нь төсөөллийн зүйлс санагдах бөгөөд зөвхөн бие-дүрст хойд дүр нь л жинхэнэ бодит зүйл санагдах биш үү?

Эрхэм Багш аа, оюунаар-бүтсэн хойд дүрийг авсан байгаа үед бие-дүрст хойд дүр болон бие-бус хойд дүрүүд нь төсөөллийн зүйлс санагдах бөгөөд зөвхөн оюунаар-бүтсэн хойд дүр нь л жинхэнэ бодит зүйл санагдах биш үү?

Эрхэм Багш аа, бие-бус хойд дүрийг авсан байгаа үед оюунаар-бүтсэн хойд дүр болон бие-дүрст хойд дүрүүд нь төсөөллийн зүйлс санагдах бөгөөд зөвхөн бие-бус хойд дүр нь л жинхэнэ бодит зүйл санагдах биш үү?” гэсэн асуултыг тавилаа.

Үүнд Будда:

“Читта, бие-дүрст хойд дүрд орсон үед, оюунаар-бүтсэн хойд дүр гэж, эсвэл бие-бус хойд дүр гэж ярихгүй бөгөөд зөвхөн бие-дүрст хойд дүр гэж л ярина.

Оюунаар-бүтсэн хойд дүрд орсон үед, бие-дүрст хойд дүр гэж, эсвэл бие-бус хойд дүр гэж ярихгүй бөгөөд зөвхөн оюунаар-бүтсэн хойд дүр гэж л ярина.

Бие-бус хойд дүрд орсон үед, бие-дүрст хойд дүр гэж, эсвэл оюунаар-бүтсэн хойд дүр гэж ярихгүй бөгөөд зөвхөн бие-бус хойд дүр гэж л ярина.

Читта, хүмүүс чамаас,

‘Та урьд өмнө нь оршин байсан уу?

Та ирээдүйд оршин байх уу?

Та одоо үед оршин байгаа юу?’ гэж асуулаа гэж бодъё. Та үүнд яаж хариулах сан бол?”

“Эрхэм Багш аа, хэрэв надаас тэгж асуувал,

‘Би урьд цагт оршин байсан.

Би ирээдүйд оршин байх болно.

Би одоо цагт оршин байгаа.’ гэж л хариулах болов уу”

“Тэгвэл Читта, хүмүүс чамаас,

‘Таны урьдын хойд дүр чинь таны цорын ганц жинхэнэ хойд дүр бөгөөд ирээдүйн болон одоогийн хойд дүр чинь төсөөллийн хойд дүр биш үү?’,

‘Таны ирээдүйн хойд дүр чинь цорын ганц жинхэнэ хойд дүр бөгөөд урьдын болон одоогийн хойд дүр чинь төсөөллийн хойд дүр биш үү?’,

‘Таны одоогийн хойд дүр чинь таны цорын ганц жинхэнэ хойд дүр бөгөөд урьдын болон ирээдүйн хойд дүр чинь төсөөллийн хойд дүр биш үү?’ гэж асуулаа гэж бодъё.

Та үүнд яаж хариулах бол?”

“Эрхэм ээ, хэрэв надаас ингэж асуувал би,

‘Урьдын хойд дүр маань тэр үедээ л үнэн бодит байсан бөгөөд харин ирээдүйн болон одоогийн хойд дүр бол төсөөллийн хойд дүр болно.

Ирээдүйн хойд дүр минь тэр үедээ л үнэн бодит бөгөөд харин урьдын болон одоогийн хойд дүр минь төсөөллийн хойд дүр болно.

Миний одоогийн энэ хойд дүр бол энэ цаг үедээ л үнэн бодит бөгөөд харин урьдын болон ирээдүйн хойд дүр бол төсөөллийн хойд дүр болох юм.’ гэж би хариулах болно.” гэв.

Тэгэхэд нь Будда:

“Яг түүний нэгэн адилаар, тэдгээр гурван хойд дүрийн аль нэгэнд нь оршин буй цагтаа бусад хоёр хойд дүрийг хойд дүр гэж авч үзэхгүй.

Зөвхөн өөрийн оршин буй хойд дүрийг л авч үздэг учиртай.

Яг үүний нэгэн адилаар, үнээнээс сааль, саалиас хөөрүүлсэн сүү, хөөрүүлсэн сүүнээс өрөм, өрөмнөөс хайлмаг, хайлмагаас шар тос гарч ирдэг. Тэгээд шар тосыг энэ бүгдийн хамгийн дээд нь гэж үздэг. Энд үнээний сүүгээ дөнгөж сааль байх үед нь хөөрүүлсэн сүү, эсвэл өрөм, эсвэл хайлмаг, эсвэл шар тос гэж нэрлэдэггүй билээ. Үүнийг зөвхөн үнээний сааль л гэж нэрлэдэг. Үүнийг мөн хөөрүүлсэн сүү, өрөм, хайлмаг, эсвэл шар тос болчихсон байхад нь, үүнийг өөрөөр нэрлэдэггүй. Зөвхөн тухайн үеийн байгаагаар нь л нэрлэдэг билээ.

Яг үүний нэгэн адилаар, тэдгээр гурван хойд дүрийн аль нэгэнд нь оршин буй цагтаа, бусад хоёр хойд дүрийг хойд дүр гэж авч үзэхгүй.

Дээрх зүйлүүд бол энэ дэлхий дээр хэрэглэгдэж буй нийтийн хэрэглээ, нэр томьёо, хэлний хэрэглэгдэхүүн, тодорхойлолтууд бөгөөд Будда үүнд орооцолдож автахгүйгээр, зөвхөн харилцан ярилцаж ойлголцохдоо л хэрэглэж, нэрлэж, ярьдаг ойлголт билээ.”

Түүнийг ийн ярьсны дараа бадарчин Поттхапаада Буддад хандан:

“Төгс төгөлдөр юм, Эрхэм Багш аа! Төгс төгөлдөр юм, Эрхэм Багш аа!

Хөмөрч унасан нэгнийг эргүүлж босгох мэт, эсвэл далд нууц зүйлийг илчилж харуулах мэт, замаасаа төөрсөн нэгэнд замыг нь зааж өгөх мэт, түнэр харанхуй газар гэрэл дэнлүү асаахад, хараа сайтай нэгэн бээр тэнд байсан зүйлийг нь олж харах мэт, Будда өөрийн Сургаалаа олон аргаар тайлбарлаж, ойлгуулж өглөө надад. Би бээр, Будда, Сургаал, Хуврагийн Чуулганы нөмөрт очиж байна. Будда, намайг энэ өдрөөс эхлэн насан туршдаа түүний нөмөрт очсон, түүний сахилтан шавь болсон гэдгийг минь санах болтугай.” хэмээн хэлэв.

2.3. Читта Хаттхисаарипутта Дээд Сахил Хүртэв (Cittahatthisāriputtaupasampadā)

Тэгтэл, Читта Хаттхисаарипутта Буддад хандан:

“Төгс төгөлдөр юм, Эрхэм Багш аа! Төгс төгөлдөр юм, Эрхэм Багш аа!

Хөмөрч унасан нэгнийг эргүүлж босгох мэт, эсвэл далд нууц зүйлийг илчилж харуулах мэт, замаасаа төөрсөн нэгэнд замыг нь зааж өгөх мэт, түнэр харанхуй газар гэрэл дэнлүү асаахад, хараа сайтай нэгэн бээр, тэнд байсан зүйлийг нь олж харах мэт, Будда өөрийн Сургаалаа олон аргаар тайлбарлаж, ойлгуулж өглөө надад. Би бээр, Будда, Сургаал, Хуврагийн Чуулганы нөмөрт очиж байна. Будда, намайг энэ өдрөөс эхлэн таны шавь, хувраг хүмүүний дээд сахилыг өөрөөс тань авч болох сон болов уу?” хэмээн шуудхан хэлэв.

Тийнхүү Читта Хаттхисаарипутта, Буддагаас өөрөөс нь хуврагийн дээд сахил хүртэн авчээ. Хуврагийн дээд сахил аваад удаагүй байсан Эрхэм Читта, орь ганцаараа, бүгдээс тусгаарлагдан, уйгагүй мэрийлттэй, хичээл зүтгэлтэй, өөрийгөө огоорон амьдарснаар, ёстой л, сайн айлын хөвгүүд[272], зорилгоо болгон орон гэрээ орхиж, орон гэргүй сахилтан болж хүрдэг ариуслын-замналын төгс төгөлдөр оргилд их удалгүй хүрч, энэ насандаа шууд-билгүүнийг өөрийн биеэр ухаарч, тэр зэрэгт хүрч[273] амьдарсан билээ.

Тэрбээр:

“Дахин төрөхүй үгүй болов, ариуслын-замнал өндөрлөв, хийх учиртайгаа хийв, ингээд ирээдүйн үргэлжлэл үгүй болов.” хэмээн ухаардаг.

Ийнхүү Читта Хаттхисаарипутта Төгс Гэгээрсэн Арахантуудын нэг нь болсон түүхтэй.

---

[272] *Kulaputtā*—“Сайн айлын хөвгүүд”. Үгчилбэл, “нэр хүндтэй гэр бүлийн хүү нар”, “боломжийн айлын хүү нар” эсвэл “залуу ноёнтон хөвгүүд” буюу бүр “ядгаа алдсан”, “нэр нүүрээ алдсан” айл өрхийн биш, “оргуул босуул биш”, ёс журамтай хувраг болсон залуус гэсэн ерөнхий санаа.

[273] Төгс гэгээрсэн гэсэн санаа.

Поттхапаада Судар энд өндөрлөв.

ХАМАГ УЧИР ШАЛТГААН СУДАР
DN 15. MAHĀNIDĀNASUTTA

1. Учир Хамааралтай Уг Гарал (Paṭiccasamuppāda)

БИ ИЙН СОНССОН ЮМ.

Нэгэн цагт Будда, куручуудын[274] нутагт амьдран, Каммаасадамма[275] хэмээх куру хотын ойролцоо, байрлан амьдарч байлаа. Тэр үед, Эрхэм Аананда Будда дээр ирж мөргөөд, түүний дэргэд суугаад, түүнд ийн хэлэв:

"Үнэхээр гайхалтай! Эрхэм Багш аа, үнэхээр бишрэм юм! Энэ Учир Хамааралтай Уг Гарал Сургаал[276] бол гүн гүнзгий төдийгүй, гүн гүнзгий санагдам юм. Гэсэн хэдий ч, миний бодлоор бол энэ Сургаал тун энгийн ойлголт юм шиг санагдаад байх юм."

"Тэгж бүү ярь, Аананда, бүү тэгж ярь!

Энэхүү Учир Хамааралтай Уг Гарал Сургаал нь гарцаагүй гүн гүнзгий төдийгүй, гүн гүнзгий санагдам билээ.

Энэ Сургаалыг, Аананда, гүнзгий ухаараагүй, нэвтэрхий ойлгоогүй болохоор, энэ цаг үеийнхэн эрчилж ороосон мяндас мэт, ээдэрч зангирсан утас мэт, сүвлэж сүлжсэн сүрэл адил, сүлэлдэж ширэлдэж орооцолдоод, муу ёрын газар, муухай зовлонт орон, доод тамын ертөнц бүхий энэ үхэх-төрөхийн эргэлтээс гарч чадахгүй, ээрч төөрч яваа юм.

Аананда, 'Өтлөхүй хийгээд үхэхүйд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?' гэж хүн асуувал, 'Байдаг' гэх нь зүйтэй. 'Өтлөхүй хийгээд үхэхүйн нөхцөл шалтгаан нь юу юм?' гээд тэр асуувал, 'Төрөхүй[277] нь өтлөхүй хийгээд үхэхүйн нөхцөл шалтгаан нь юм.' гэж хэлэх учиртай.

Аананда, 'Төрөхүйд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?' гэж хүн асуувал, 'Байдаг' гэх нь зүйтэй. 'Төрөхүйн нөхцөл шалтгаан нь юу юм?' гээд тэр асуувал, 'Оршихуй[278] бол төрөхүйн нөхцөл шалтгаан нь юм.' гэж хэлэх учиртай.

---

274 *Kuru*—"куручууд" (эсвэл "күрү"). Индапатта (*Indapatta*) нийслэлтэй Куру ээзнт гүрэнд хамаарах иргэд бөгөөд өнөөгийн Дели орчмын газар нутаг хавиар голдуу нутаглаж байжээ.

275 *Kammāsadamma* хот нь орчин цагийн Дели хотоос хойшоо 40 км орчимд байгаа Кумашпур.

276 *Paṭiccasamuppādo*—"Учир Хамааралтай Уг Гарал Сургаал" (сам. *Pratītyasamutpāda*).

277 *Jāti*—"Төрөхүй" (анг. *birth* эсвэл *rebirth*). Энэ хорвоод, ямар нэгэн төрөлд төрөх, мэндлэх буюу "дахин төрөх" (Энэ хорвоод төрж буй бүхэн ямар нэг төрөлд үхсэнээр, өөр нэг төрөлд дахин төрж буй тул). Мөн DN 1.5.3; DN 22.4.6; Тайлбарт нэмж үз.

278 *Bhava*—"Оршихуй". Ерөнхий утга "оршин байхуй" эсвэл "хэн нэгэн болохуй". Нэг төрөлд үхээд дахин төрөл авч амьдрал үргэлжлэхүй буюу оршин байхуй, мөн болохуй, төрөл авахуй. Энэ хорвоо Үйлийн Үрийн Хуульд захирагдаж, урд төрлүүдийн үйлийн улбаагаар бодгалиуд дараагийн төрлөө авах тул тэдгээр урд төрлүүдийн (хийсвэр утгаараа мөн энэ болон ирээдүйн төрлүүдийн) "байхуй", "оршихуйг" бүхэлд нь хамруулж "оршихуй" хэмээсэн болно.

Аананда, ‘Оршихуйд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?’ гэж хүн асуувал, ‘Байдаг’ гэх нь зүйтэй. ‘Оршихуйн нөхцөл шалтгаан нь юу юм?’ гээд тэр асуувал, ‘Дон-шунал бол оршихуйн нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлэх учиртай.

Аананда, ‘Дон-шунал үүсэхэд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?’ гэж хүн асуувал, ‘Байдаг’ гэх нь зүйтэй. ‘Дон-шунал үүсэх нөхцөл шалтгаан нь юу юм?’ гээд тэр асуувал, ‘Хүсэл-цангаа бол дон-шунал үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлэх учиртай.

Аананда, ‘Хүсэл-цангаа үүсэхэд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?’ гэж хүн асуувал, ‘Байдаг’ гэх нь зүйтэй. ‘Хүсэл-цангаа үүсэх нөхцөл шалтгаан нь юу юм?’ гээд тэр асуувал, ‘Мэдрэмж[279] бол хүсэл-цангааны нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлэх учиртай.

Аананда, ‘Мэдрэмжид ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?’ гэж хүн асуувал, ‘Байдаг’ гэх нь зүйтэй. ‘Мэдрэмжийн нөхцөл шалтгаан нь юу юм?’ гээд тэр асуувал, ‘Мэдрэхүйн-харилцаа нь мэдрэмжийн нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлэх учиртай.

Аананда, ‘Мэдрэхүйн-харилцаа үүсэхэд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?’ гэж хүн асуувал, ‘Байдаг’ гэх нь зүйтэй. ‘Мэдрэхүйн-харилцаа үүсэх нөхцөл шалтгаан нь юу юм?’ гээд тэр асуувал, ‘Бие-сэтгэл[280] бол мэдрэхүйн-харилцаа үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлэх учиртай.

Аананда, ‘Бие-сэтгэл үүсэхэд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?’ гэж хүн асуувал, ‘Байдаг’ гэх нь зүйтэй. ‘Бие-сэтгэл үүсэх нөхцөл шалтгаан нь юу юм?’ гээд тэр асуувал, ‘Оюун-ухамсар[281] бол бие-сэтгэл үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлэх учиртай.

Аананда, ‘Оюун-ухамсар үүсэхэд ямар нэг нөхцөл шалтгаан бий юу?’ гэж хүн асуувал, ‘Байдаг’ гэх нь зүйтэй. ‘Оюун-ухамсар үүсэх нөхцөл шалтгаан нь юу юм?’ гээд тэр асуувал, ‘Бие-сэтгэл бол оюун-ухамсар үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлэх учиртай.

Ийм болохоор Аананда, бие-сэтгэл нь нөхцөл шалтгаан болсноор оюун-ухамсар оршин байна. Оюун-ухамсар нь нөхцөл шалтгаан болсноор бие-сэтгэл оршсоор байна. Бие-сэтгэл нь нөхцөл шалтгаан болсноор мэдрэхүйн-харилцаа оршсоор байна. Мэдрэхүйн-харилцаа нь нөхцөл шалтгаан болсноор мэдрэмж оршсоор байна. Мэдрэмж нь нөхцөл шалтгаан болсноор хүсэл-цангаа оршсоор байна. Хүсэл-цангаа нь нөхцөл шалтгаан болсноор дон-шунал оршсоор байна. Дон-шунал нь нөхцөл шалтгаан болсноор оршихуй оршсоор байна. Оршихуй нь нөхцөл шалтгаан болсноор төрөхүй оршсоор байна.

---

279 *Vedanā*—“мэдрэмж”. Таван-цулын нэг. Мэдрэхүйн объект болох ямар нэг зүйлс оюун-ухамсарт буух төлөв. Гурван янз мэдрэмж байна: 1. таатай; 2. таагүй; 3. төв-оршихуй. (Тайлбарт буй Таван-Цул-ыг үз.)

280 *Nāmarūpa*—“бие-сэтгэл”. Өөрөөр, “нэршил ба бие-дүрс”. Оюунлаг болон материаллаг зүйл хоёрыг нэгтгэж нэг үг болгон хэрэглэсэн нэршил. Өөрөөр хэлбэл, бие-дүрст зүйл болон оюун санаа хоёрын нэгдмэл байдалд оноосон үг. Зарим орчуулгад “нэр ба дүрс” (анг. *name and form.* BS), эсвэл “сэтгэлгээ ба материаллаг байдал” (анг. *mentality-materiality.* BB) гэжээ.

281 DN 2.4.15-д тайлбар бий.

Төрөхүй нь нөхцөл шалтгаан болсноор өтлөхүй хийгээд үхэхүй, харуусал, гашуудал, зовуурь, шаналал, цөхрөл оршсоор байгаа билээ.

Энэ хамаг зовлон зүдүүр бол ийм л учир шалтгаанаар, ингэж л урган гардаг билээ.

1.1. Өтлөхүй Хийгээд Үхэхүй (Jarāmaraṇa)

‘Төрөхүй нь өтлөхүй хийгээд үхэхүйн нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Энэ яагаад ийм байна гэдгийг Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юунд ч, ямар нэг байдлаар, ерөөсөө төрдөггүй, өөрөөр хэлбэл, Тэнгэрүүд Тэнгэрүүдийн оронд, бурхад бурхдын оронд, өлсгөлөн-сүнс, асура, хүмүүн, дөрвөн хөлтөн, жигүүртэн амьтад, хэвлээр явагчид тус тусын ертөнцөд, огт төрдөггүй байлаа гэж бодъё. Ингээд, бүхий л төрөхүй огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, өтлөхүй хийгээд үхэхүй гэсэн ойлголт байх уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа төрөхүй нь өтлөхүй хийгээд үхэхүйн учир шалтгаан нь, уг суурь нь, эх сурвалж нь, эхлэл үүсэл нь болдог билээ.

1.2. Төрөхүй (Jāti)

‘Оршихуй бол төрөхүйн нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Энэ яагаад ийм байна гэдгийг Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юунд ч, ямар нэг байдлаар, ерөөсөө амьдрал, оршихуй гэж байхгүй болсон, өөрөөр хэлбэл Мэдрэхүйн-Орны оршихуй, бурхдын орны оршихуй, бие-бусын оршихуй, эдгээр оршихуйн орон, ертөнц[282] гэж огт байхгүй болж гэж бодъё. Ингээд бүхий л оршихуй огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, төрөхүй гэсэн ойлголт байх уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа оршихуй бол төрөхүйн учир шалтгаан нь, уг суурь нь, эх сурвалж нь, эхлэл үүсэл нь болдог билээ.

1.3. Оршихуй (Bhava)

‘Дон-шунал бол оршихуйн нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Энэ яагаад ийм байна гэдгийг Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юунд ч, ямар нэг байдлаар, ерөөсөө донтох, шунах явдал гэж огт байдаггүй байлаа гэж бодъё. Мэдрэхүйн-таашаалд донтох, шунах, үзэл баримтлалд донтох, шунах, ёс зан заншил, зан үйлд донтох, шунах, өөрийн-оршихуйн үзэл онолд донтох, шунах явдал энэ хорвоод байхгүй

---

[282] Энд бодгалиудын оршин байх боломжтой орнуудыг (там, өлсгөлөн-сүнс, амьтан, асура, хүн, бурхан, Тэнгэр г.м.) бүгдийг багтаан хэлжээ (Орч).

болсон гэж бодъё. Ингээд бүхий л дон-шунал огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, үргэлжлэх оршихуй[283] гэсэн ойлголт байх уу?

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа дон-шунал бол оршихуйн учир шалтгаан нь, уг суурь нь, эх сурвалж нь, эхлэл үүсэл нь болдог билээ.

1.4. Дон-Шунал (Upādāna)

‘Хүсэл-цангаа бол дон-шунал үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Энэ яагаад ийм байна гэдгийг Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө хүсэх, цангах гэж зүйл байхгүй, огт хүсэхээ больчихсон гэж бодъё. Харах хүсэл, сонсох хүсэл, үнэрлэх хүсэл, амтлах хүсэл, хүрэх хүсэл, бодох хүсэл гэж зүйл огт байхгүй болсон гэж бодъё. Ингээд бүхий л хүсэл огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, дон-шунал гэсэн ойлголт байх уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа хүсэл-цангаа бол дон-шунал үүсэх учир шалтгаан нь, уг суурь нь, эх сурвалж нь, эхлэл үүсэл нь болдог билээ.

1.5. Хүсэл-Цангаа (Taṇhā)

‘Мэдрэмж бол хүсэл-цангаа үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Энэ яагаад ийм байна гэдгийг Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө мэдрэх, мэдэх гэж зүйл байхгүй, бүх мэдрэмж тэр чигээрээ огт байхгүй болчихсон байлаа гэж бодъё. Нүдээр харах мэдрэмж, чихээр сонсох мэдрэмж, хамраар үнэрлэх мэдрэмж, биеэр хүрэлцэх мэдрэмж, оюунаар төсөөлөх мэдрэмж байхгүй болсон гэж бодъё. Ингээд бүхий л мэдрэмж, мэдрэхүй огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, хүсэл-цангаа гэсэн ойлголт байх уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа мэдрэмж бол хүсэл-цангаа үүсэх учир шалтгаан нь, уг суурь нь, эх сурвалж нь, эхлэл үүсэл нь болдог билээ.

[283] Үйлийн Үрийн Хуульд захирагдаж, үхэх-төрөхийн эргэлтийг хөдөлгөгч хүч нь угтаа сэтгэлийн үйл, донтох, шунах тул, хүсэж гэмээ нь энэ хорвоогийн бүхий л зүйл бүрэлдэн бий болох тул, “шунахуй үгүй болоход оршихуй гэж байхгүй” гэсэн санаагаар.

1.6. Хүсэл-Цангаанаас Шалтгаалахуй (Taṇhāpaccayā)

Тиймээс, Аананда, мэдрэмжээс шалтгаалж хүсэл-цангаа үүсэх болно. Хүсэл-цангаанаас шалтгаалж эрэл хайгуул үүсэх болно. Эрэл хайгуулаас шалтгаалж олж авах явдал үүсэх болно. Олж авахаас шалтгаалж үнэлэмж үүсэх болно. Үнэлэмжээс шалтгаалж хүсэл-тачаал[284] үүсэх болно. Хүсэл-тачаалаас шалтгаалж шунан-дурлахуй[285] үүсэх болно. Шунан-дурлахуйгаас шалтгаалж өмчирхөл үүсэх болно. Өмчирхлөөс шалтгаалж харам нарийн үүсэх болно. Харам нарийнаас шалтгаалж хамгаалж манах явдал үүсэх болно. Хамгаалж манах сэтгэлийн үрээр мод саваа, жад сэлэм барьж авах, хэрүүл маргаан өдөөх, тэмцэл зөрчилдөөн үүсгэх, хутган үймүүлэх, худал гүжир ярих зэрэг олон муу муухай олиггүй үйлдэл үүсэн бий болдог.

‘Хамгаалж манах сэтгэлийн үрээр мод саваа, жад сэлэм барьж авах, хэрүүл маргаан өдөөх, тэмцэл зөрчилдөөн үүсгэх, хутган үймүүлэх, худал гүжир ярих зэрэг олон муу муухай олиггүй үйлдэл үүсэн бий болдог.’ гэлээ. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө хамгаалж манадаггүй байлаа гэж бодъё. Хамгаалж манах явдал огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, олон тэр муу муухай олиггүй үйлдэл урган гарах болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Аананда, хамгаалж манах явдал бол олон тэр муу муухай олиггүй үйлийн эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Харам нарийнаас шалтгаалж хамгаалж манах явдал үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө харамлаж нарийлдаггүй байлаа гэж бодъё. Харам нарийн огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, хамгаалж манах явдал гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Аананда, харам нарийн бол хамгаалж манахын эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Өмчирхлөөс шалтгаалж харам нарийн үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө өмчилдөггүй байлаа гэж бодъё. Өмчирхөл огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, харам нарийн гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

---

[284] *Chandarāgo*—“хүсэл-тачаал”. Хүсэл-цангаа (*taṇhā*) нь аливаа зүйлийг хүсэх, түүгээр дутагдах гэсэн ерөнхий утгатай гэж үзвэл, харин энэ үг нь хүсэл-цангаанаас илүү хүчтэй тачаал гэж үзэж болно. Энэ нь *chanda* (хүсэл-эрмэлзэл) болон *rāgo* (дур-хүсэл) хоёрын нийлмэл үг тул тус бүр Лавлахаас, мөн Тайлбарт буй Ойролцоо Үг хэсгээс харьцуулан хар.

[285] *Ajjhosāna*—“шунан-дурлахуй”. Аливаад дурлаж, шунах, “өөрийн болгох хүсэлд автах” г.м. утгатай гэж үзэж болно. Энэ үг нь *taṇhā* (хүсэл-цангаа)-аас хавьгүй хүчтэй юм. Харин *upādāna* (дон-шунал)-тай ойролцоо гэж харж болох ч, арай ч тийм хүчтэй биш ч гэж үзнэ. Тайлбарт буй Ойролцоо Үг хэсгээс бусад үгтэй харьцуулан хар.

“Ийм учраас, Aананда, өмчирхөл бол харам нарийны эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Шунан-дурлахуйгаас шалтгаалж өмчирхөл үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Aананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юунд ч, ямар нэг байдлаар, ерөөсөө шунан дурладаггүй байлаа гэж бодъё. Шунан-дурлахуй огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, өмчирхөл гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Aананда, шунан-дурлахуй бол өмчирхлийн эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Хүсэл-тачаалаас шалтгаалж шунан-дурлахуй үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Aананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө хүсэн тачааддаггүй байлаа гэж бодъё. Хүсэл-тачаал огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, шунан-дурлахуй гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Aананда, хүсэл-тачаал бол шунан-дурлахуйн эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Үнэлэмжээс шалтгаалж хүсэл-тачаал үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Aананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө үнэлдэггүй байлаа гэж бодъё. Үнэлэмж огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, хүсэл-тачаал гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Aананда, үнэлэмж бол хүсэл-тачаал үүсэх эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Олж авахаас шалтгаалж үнэлэмж үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Aананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө олж авдаггүй байлаа гэж бодъё. Олж авах явдал огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, үнэлэмж гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Aананда, олж авах явдал бол үнэлэмж үүсэх эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Эрэл хайгуулаас шалтгаалж олж авах явдал үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Aананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө эрж хайдаггүй байлаа гэж бодъё. Эрэл хайгуул огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, олж авах явдал гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Аананда, эрэл хайгуул бол олж авахын эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

‘Хүсэл-цангаанаас шалтгаалан эрэл хайгуул үүсэх болно.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юуг ч, ямар нэг байдлаар, ерөөсөө хүсдэггүй, цангадаггүй байлаа гэж бодъё. Хүсэл-цангаа огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, эрэл хайгуул гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Ийм учраас, Аананда, хүсэл-цангаа бол эрэл хайгуулын эх сурвалж нь, эхлэл үүсэл нь, уг суурь нь, учир шалтгаан нь болдог юм.

Тэгэхээр, Аананда, энэ хоёр Үзэгдэл нь, хосолсон мэдрэмжээр нэг цэг дээр нийлэн нэгддэг юм.

1.7. Мэдрэмж (Vedanā)

‘Мэдрэхүйн-харилцаа нь мэдрэмж үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад ингэж хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Хаана ч, хэн ч, юутай ч, ямар нэг байдлаар, ерөөсөө, нүдээрээ харилцахуй, чихээрээ харилцахуй, амаараа харилцахуй, хамраараа харилцахуй, биеэрээ харилцахуй, оюун-ухаанаараа харилцахуй гэж огт байхгүй байлаа гэж бодъё. Ингээд мэдрэхүйн-харилцаа огт байхгүй болсон, ор мөргүй болсон байхад, мэдрэмж гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа мэдрэхүйн-харилцаа бол мэдрэмж үүсэх учир шалтгаан, уг суурь, эх сурвалж, эхлэл гарал нь болж байдаг юм.

1.8. Мэдрэхүйн-Харилцаа (Phassa)

‘Бие-сэтгэл бол мэдрэхүйн-харилцаа үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад ингэж хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Сэтгэлд буухуйц, танигдахуйц, ямар нэг онцлог чанар, төлөв байдал, шинж тэмдэг, илэрхийлэл байдал гэж огт байхгүй, ор мөргүй алга болжээ гэж бодъё. Сэтгэлд бууж болох тэр шинжүүд, тэр нэршлүүд огт байхгүй, ор мөргүй болсон байхад, бие махбодод аливааг тусгаж авах танил мэдрэхүйн-харилцаа[286] үүсэх гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

---

286 *Adhivacanasamphasso*—“танил мэдрэхүйн-харилцаа” эсвэл “нэршил холбосон харилцаа”. Аливааг танихын тулд тэр зүйлийн талаарх нэршил нь оюун ухамсарт байж гэмээ нь тэр “танил” зүйлээ мэдэрч чадна. Тэр утгаар.

“Хэрвээ, бие махбодод тусахуйц, мэдэгдэхүйц, ямар нэг онцлог чанар, төлөв байдал, шинж тэмдэг, илэрхийлэл байдал гэж огт байхгүй, ор мөргүй болсон байхад, сэтгэлд гэнэтийн цочир мэдрэхүйн-харилцаа[287] үүсэх гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Хэрвээ бие махбодын болон сэтгэл санааны байдлыг дүрсэлсэн, онцлог чанар, төлөв байдал, шинж тэмдэг, илэрхийлэл бүгд огт байхгүй, ор мөргүй болсон байхад, ямар нэг танил мэдрэхүйн-харилцаа, эсвэл гэнэтийн цочир мэдрэхүйн-харилцаа үүсэх гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Хэрэв бие-сэтгэлийг дүрсэлсэн, онцлог чанар, төлөв байдал, шинж тэмдэг, илэрхийлэл байдал бүгд огт байхгүй, ор мөргүй болсон байхад, мэдрэхүйн-харилцаа үүсэх гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа, бие-сэтгэл бол мэдрэхүйн-харилцаа үүсэх учир шалтгаан, уг суурь, эх сурвалж, эхлэл гарал нь болж байдаг юм.

1.9. Бие-сэтгэл (Nāma-rūpa)

‘Оюун-ухамсар бол бие-сэтгэл үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад ингэж хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Хэрэв оюун-ухамсар эхийн хэвлий дэх урагт огт үүсэн бий болохгүй бол, ор сураггүй байгаа бол, эхийн хэвлийд бие-сэтгэл бүрэлдэх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Хэвлийд бүрэлдсэний дараа хэрэв оюун-ухамсар нь яваад өгдөг байсан бол, бие-сэтгэл нь одоо байгаа хэв шинжээ олох болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Балчир нярай хүүхдийн оюун-ухамсрыг нь тасалбал, бие-сэтгэл нь өсөж торниж, боловсорч бойжиж, хөгжил төлөвшилд хүрэх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа оюун-ухамсар бол бие-сэтгэл үүсэх учир шалтгаан, уг суурь, эх сурвалж, эхлэл гарал нь болж байдаг юм.

---

287 *Paṭighasamphasso*—“гэнэтийн цочир мэдрэхүйн-харилцаа”, эсвэл “физик нөлөөлөл”. Нэг ёсондоо аливаа биед танигдаж болох ямар нэг шинж чанар, төлөв байдал гэж огт байхгүй болсон байхад сэтгэл нь гэнэтхэн тэр огт байхгүй шинжийг таних, мэдрэх гэсэн утгаар.

1.10. Оюун-Ухамсар (Viññāṇa)

‘Бие-сэтгэл бол оюун-ухамсар үүсэх нөхцөл шалтгаан нь юм.’ гэж хэлсэн. Үүнийг яагаад ингэж хэлэв гэдгийг, Аананда, ийм маягаар ойлгоорой. Хэрэв оюун-ухамсар нь бие-сэтгэл дээр ерөөсөө үүсэн бий болоогүй, угаасаа цогцлоогүй бол, төрөхүй, өтлөхүй, үхэхүй гээд хамаг зовлон зүдүүрийн гарал үүсэл нь болохуй гэсэн ойлголт байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм учраас, Аананда, чухамдаа бие-сэтгэл бол оюун-ухамсар үүсэх учир шалтгаан, уг суурь, эх сурвалж, эхлэл гарал нь болж байдаг юм.

Аананда, энэ хэр хэмжээгээр тэр бодгаль төрж, өтөлж, үхэж, дахин төрж, энэ хэр хэмжээгээр тэр бодгаль байр байдлаа олж, энэ хэр хэмжээгээр тэр бодгаль хэлж ярьж, энэ хэр хэмжээгээр тэр бодгаль таньж, мэдэж, энэ хэр хэмжээгээр тэр бодгаль саруул-ухааны[288] цар хүрээг олж, энэ хэр хэмжээгээр тэр бодгаль дараа төрлүүдээ ямар янзтай байлгахаа энэ төрөлдөө тодорхойлж байдаг юм. Чухамдаа гэвэл, бие-сэтгэл нь оюун-ухамсрынхаа хамтаар энэ бүгдийг тодорхойлдог билээ.

2. Өөрийн-Оршихуйг Төсөөлөхүй (Attapaññatti)

Аананда, өөрийн-оршихуйг[289] ямар нэг байдлаар төсөөлдөг хүн, үүнийгээ ямар байдлаар ярих бол?

Өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай[290] гэж төсөөлдөг хүн:

‘Миний өөрийн-оршихуй бол бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай юм.’ гэж ярьдаг.

Эсвэл өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй[291] гэж үзэж төсөөлдөг хүн:

‘Миний өөрийн-оршихуй бол бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй юм.’ гэж ярьдаг.

Эсвэл өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай гэж үзэж төсөөлдөг хүн:

---

288 *Paññā*—“саруул-ухаан” (сам. *prajñā*). Саруул ухаан, ухаарсан мэдлэг, ухаарсан ойлголт, билэг ухаан, мэргэн ухаан, зарим тохиолдолд Гэгээрлийг эсвэл Гэгээрсэн хүний ухааныг хэлнэ. Ертөнцийн Гурван Шинжээр (1. мөнхийн-бус; 2. зовлонтой; 3. өөрийн-оршихуй-бус; (*anicca, dukkha, anattā*) буюу ‘яг байгаагаар нь’ харахуйг саруул-ухаанаар харах гэж үзнэ. Сахил→Самади→Саруул-ухаан (*sīla→samādhi→paññā*) буюу өөрт сахил суулгаснаар самадиг оршоож, самадиг оршоосноор саруул-ухааныг оршоож, саруул-ухааныг оршоосноор гэгээрлийг олно гэж Эртний Буддизмд үзнэ. Энэ утгаараа зарим тохиолдолд Гэгээрлийг олсон хүнийг саруул-ухааныг олсон хүн гэнэ.

289 Энэ судварт “өөрийн-оршихуй” (*attā*)-г “Өөрийгөө”, “Өөрөө”, “би-өөрөө” г.м. хэд хэдэн өөр байдлаар хэрэглэснийг анхаарна уу.

290 *Parittaṁ*—“хэмжээ хязгаартай”. Эсвэл “хязгаарлагдмал”, “жижигхэн” гэсэн утгаар (DN 1.3.3-д дурдагдсан санаа).

291 *Anantaṁ*—“хэмжээ хязгааргүй” (анг. *limitless*). Өөрөөр “эцэс төгсгөлгүй”, “хэмжээлшгүй” г.м. (DN 1.3.3-д дурдагдсан санаа).

‘Миний өөрийн-оршихуй бол бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай юм.’ гэж ярьдаг.

Эсвэл өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үзэж төсөөлдөг хүн:

‘Миний өөрийн-оршихуй бол бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй юм.’ гэж ярьдаг.

Энэ тал дээр, Aананда, өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай гэж үзсэн хүмүүс одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж төсөөлдөг. Эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй баттай ийм болох болно гэж боддог.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө[292] тийм болгох болно.’ гэж боддог. Ийм байдлаар, өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай гэж төсөөлдөг тогтсон тэр үзэл баримтлалыг тодорхойлж болох юм.

Өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үзсэн хүмүүс одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж үздэг. Эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй баттай ийм болох болно гэж боддог.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө тийм болгох болно.’ гэж боддог. Ийм байдлаар, өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үздэг тогтсон үзэл баримтлалыг тодорхойлж болох юм.

Өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай гэж үзсэн хүмүүс одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж үздэг. Эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй баттай ийм болох болно гэж боддог.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө тийм болгох болно.’ гэж боддог. Ийм байдлаар, өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай гэж үздэг тогтсон үзэл баримтлалыг тодорхойлж болох юм.

Өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үзсэн хүмүүс одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж үздэг. Эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй баттай ийм болох болно гэж боддог.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө тийм болгох болно.’ гэж боддог. Ийм байдлаар, өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үздэг тогтсон үзэл баримтлалыг тодорхойлж болох юм.

Аананда, өөрийн-оршихуйг хүмүүс ийм байдлаар тодорхойлж төсөөлдөг.

---

[292] “Өөрийн-оршихуй” (*attā*)-г “Өөрийгөө”, “Өөрөө” гэж энэ судрын зарим хэсэгт хэрэглэв.

3. Өөрийн-Оршихуйг Эс Төсөөлөхүй (Naattapaññatti)

Аананда, өөрийн-оршихуйг ямар нэг байдлаар төсөөлдөггүй хүн, ямар байдлаар үүнийгээ ярих бол?

Өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс:

‘Миний өөрийн-оршихуй бол бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай.’ гэж ярьдаггүй.

Эсвэл өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс:

‘Миний өөрийн-оршихуй бол бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй.’ гэж ярьдаггүй.

Эсвэл өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс:

‘Миний өөрийн-оршихуй бол бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай.’ гэж ярьдаггүй.

Эсвэл өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс:

‘Миний өөрийн-оршихуй бол бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй.’ гэж ярьдаггүй.

Энэ тал дээр, Аананда, өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж, эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй, баттай ийм болох болно ч гэж боддоггүй.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө тийм болгох болно.’ ч гэж мөн боддоггүй. Ийм байдлаар өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгаартай гэж үздэг, тогтсон тийм үзэл баримтлал нь тэдэнд огт хамаагүй болдог юм.

Өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж, эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй баттай ийм болох болно ч гэж боддоггүй.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө тийм болгох болно.’ ч гэж мөн боддоггүй. Ийм байдлаар өөрийн-оршихуйг бие-дүрст бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үздэг, тогтсон тийм үзэл баримтлал нь тэдэнд огт хамаагүй болдог юм.

Өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс, одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж, эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй баттай ийм болох болно ч гэж боддоггүй.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө тийм болгох болно.’ ч гэж мөн боддоггүй. Ийм байдлаар өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгаартай гэж үздэг, тогтсон тийм үзэл баримтлал нь тэдэнд огт хамаагүй болдог юм.

Өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үзэж төсөөлдөггүй хүмүүс одоогийн оршин байгаагаа л ийм байгаа гэж, эсвэл ирээдүйд миний өөрийн-оршихуй баттай ийм болох болно ч гэж боддоггүй.

Эсвэл тэд:

‘Хэдий тийм биш байсан ч гэсэн би одоогийн Өөрийгөө тийм болгох болно.’ ч гэж мөн боддоггүй. Ийм байдлаар, өөрийн-оршихуйг бие-бус бөгөөд хэмжээ хязгааргүй гэж үздэг, тогтсон тийм үзэл баримтлал нь тэдэнд огт хамаагүй болдог юм.

Аананда, ийм маягаар, өөрийн-оршихуйг элдвээр төсөөлдөггүй хүмүүс, үүнийг ямар нэгэн байдлаар, ямар нэгэн хувилбараар тодорхойлдоггүй, ярьдаггүй билээ.

4. Өөрийгөө Эргэцүүлэн Тунгаахуй (Attasamanupassanā)

Аананда, Өөрийгөө эргэцүүлэн тунгаадаг хүн үүнийгээ ямар байдлаар тунгаан ярих бол?

Өөрийгөө эргэцүүлэн тунгаадаг хүн өөрт буусан мэдрэмжээ Өөрийгөө гэж үзэж:

‘Мэдрэмж бол би-өөрөө[293] юм.’ гэж хэлдэг.

Эсвэл тэд: ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдрэмжийг угтаа таньдаггүй, мэдэрдэггүй.’ гэдэг.

Эсвэл тэд: ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдэрдэггүй гэсэн үг биш. Харин ч би-өөрөө л юмсыг мэдэрдэг. Учир нь би-өөрөө бол мэдрэмждээ л захирагддаг юм.’ гэж хэлдэг.

Аананда, ‘Мэдрэмж бол би-өөрөө юм.’ гэж хэлдэг хүнээс асуух хэрэгтэй:

‘Найз минь, таатай мэдрэмж, таагүй мэдрэмж, мөн таатай хийгээд таагүй аль нь ч биш гэсэн гурван төрлийн мэдрэмжүүд байдаг. Эдгээр гурван төрлийн мэдрэмжийн алийг нь би-өөрөө байна гэж үзэх вэ?’

Аананда, хэн нэгэн таатай мэдрэмжийг авах ба яг энэ адилхан зүйл нь зарим хүнд таагүй мэдрэмж болж байдаг. Мөн заримд нь таагүй, эсвэл таатай хийгээд таагүй аль нь ч биш санагдаж байхад, яг энэ адилхан зүйл нь заримд нь зөвхөн таатай л мэдрэмж болж байдаг.

293 “Өөрийн-оршихуй” (*attā*)-г “би-өөрөө” гэж энд хэрэглэв. “Би өөрөө” гэсэн санаа.

Хэн нэгэн хүн таагүй мэдрэмжийг авч байхад, яг энэ адилхан зүйл заримд нь таатай мэдрэмж болж байдаг. Мөн заримд нь таатай, эсвэл таатай хийгээд таагүй аль нь ч биш санагдаж байхад, яг энэ адилхан зүйл нь заримд нь зөвхөн таагүй мэдрэмж болж байдаг.

Хэн нэгэн хүн таатай хийгээд таагүй аль нь ч биш мэдрэмжийг авч байхад, яг энэ адилхан зүйл нь зарим хүнд таатай, эсвэл таагүй мэдрэмж болж байдаг. Мөн заримд нь таатай, эсвэл таагүйгээр мэдрэгдэж байхад, яг энэ адилхан зүйл заримд нь ердөө таатай хийгээд таагүй аль нь ч биш мэдрэмж болж байдаг билээ.

Аананда, таатай сайхан мэдрэмж бол мөнхийн-бус, сэдэгдсэн-цогцолсон[294], учир шалтгаанаар үүссэн, сөнөж мөхдөг, сүйрч унадаг, бүдгэрч балардаг, бүр ор мөргүй алга болдог, тийм л шинж чанартай.

Таагүй онцгүй мэдрэмж бол, мөн л, мөнхийн-бус, сэдэгдсэн-цогцолсон, учир шалтгаанаар үүссэн, сөнөж мөхдөг, сүйрч унадаг, бүдгэрч балардаг, бүр ор мөргүй алга болдог, тийм л шинж чанартай.

Таатай хийгээд таагүй аль нь ч биш мэдрэмж бол, мөн л, мөнхийн-бус, сэдэгдсэн-цогцолсон, учир шалтгаанаар үүссэн, сөнөж мөхдөг, сүйрч унадаг, бүдгэрч балардаг, бүр ор мөргүй алга болдог, тийм л шинж чанартай.

Хэрэв хүн, таатай мэдрэмжийг мэдрэх үедээ:

‘Энэ бол би-өөрөө мэдэрч байна’ гэж боддог бол, тэрхүү таатай мэдрэмж алга болох үед: ‘Би-өөрөө алга боллоо.’ гэж бодох болж таарна.

Хэрэв хүн, таагүй мэдрэмжийг мэдрэх үедээ ‘Энэ бол би-өөрөө мэдэрч байна’ гэж боддог бол, тэрхүү таагүй мэдрэмжээ алга болох үед: ‘Би-өөрөө алга боллоо.’ гэж бодох болж таарна.

Хэрэв хүн, таатай хийгээд таагүй, аль нь ч биш мэдрэмжийг мэдрэх үедээ: ‘Энэ бол би-өөрөө мэдэрч байна.’ гэж боддог бол, тэрхүү мэдрэмж алга болсны дараа: ‘Би-өөрөө алга боллоо’ гэж бодох болж таарна.

Тиймээс, ‘Мэдрэмж бол би-өөрөө юм.’ гэж хэлдэг хүмүүс, Өөрийгөө зөвхөн энэ төрөлдөө[295] байгаагаар нь мөнхийн-бус, таатай хийгээд таагүйн холимог, үүсэн бий болдог, үгүйрч алга болдог, тийм зүйл гэж эргэцүүлэн тунгаах болж таарч байна.

Тийм болохоор Аананда, ‘Мэдрэмж бол би-өөрөө юм.’ гэж эргэцүүлэн тунгаах нь хүлээн зөвшөөрч болохгүй зүйл юм.

Аананда, ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдрэмжийг угтаа таньдаггүй, мэдэрдэггүй.’ гэж хэлдэг хүнээс асууж болох юм:

---

294 *Saṅkhatā*—“сэдэгдсэн-цогцолсон” (анг. *conditioned*). Өөрөөр, “нөхцөлдөн, бүрэлдэж бий болсон”, “аливаа сэдлээр цогцолсон”, “угсрагдсан”, “үүсмэл”, “хиймэл” г.м. (Тайлбарт буй Сэдэхүй-Цогцлохуйг дэлгэрэнгүй үз.)

295 *Diṭṭheva dhamme*—“энэ төрөлдөө”. Хойд нас биш, урд нас биш, зөвхөн энэ төрөлдөө.

‘Найз минь, мэдрэгдэх зүйлүүд огт байхгүй газарт, “Энэ Би бол...”[296] гэсэн ойлголт байж байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

Тийм болохоор, Аананда, ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдрэмжийг угтаа таньдаггүй, мэдэрдэггүй.’ гэж эргэцүүлэн тунгаах нь хүлээн зөвшөөрч болохгүй зүйл юм.

Аананда, ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдэрдэггүй гэсэн үг биш. Харин ч би-өөрөө л юмсыг мэдэрдэг. Учир нь би-өөрөө бол мэдрэмждээ л захирагддаг юм.’ гэж эргэцүүлэн тунгаах хүнээс асууж болох юм:

‘Найз минь, хэрэв мэдрэмж гэдэг зүйл ор мөргүй, юу ч үгүй болж алга болсон үед, “Энэ Би бол...”[297] гэсэн ойлголт байж байх болов уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Тийм болохоор, Аананда, ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдэрдэггүй гэсэн үг биш. Харин ч би-өөрөө л юмсыг мэдэрдэг. Учир нь би-өөрөө бол мэдрэмждээ л захирагддаг юм.’ гэж эргэцүүлэн тунгаах нь хүлээн зөвшөөрч болохгүй зүйл юм.

Аананда, хувраг хүн, ‘Мэдрэмж бол би-өөрөө юм.’ хэмээн эргэцүүлэн тунгаахгүй байснаар, мөн ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдрэмжийг угтаа таньдаггүй, мэдэрдэггүй.’ хэмээн эргэцүүлэн тунгаахгүй байснаар, мөн, ‘Мэдрэмж бол би-өөрөө биш юм. Би-өөрөө мэдэрдэггүй гэсэн үг биш. Харин ч би-өөрөө л юмсыг мэдэрдэг. Учир нь би-өөрөө бол мэдрэмждээ л захирагддаг юм.’ хэмээн эргэцүүлэн тунгаахгүй байснаар, энэ хорвоогийн юунд ч автаж, юунд ч донтохгүй оршдог билээ. Тэрээр, тийнхүү юунд ч автаж, юунд ч донтохгүй байснаар, сэтгэл түгших байдлаас ангид оршдог билээ. Тэрээр, тийнхүү сэтгэл түгшилд орохгүй байснаар, шууд-билгүүнээр, өөрөө Нирвааныг ухаардаг билээ. Тэрбээр:

‘Дахин төрөхүй үгүй болов, ариуслын-замнал өндөрлөв, хийх учиртайгаа хийв, ингээд ирээдүйн үргэлжлэл үгүй болов.’ хэмээн ухаардаг.

Аананда, ийнхүү оюун санаа нь чөлөөлөгдөн, ийнхүү төгс гэгээрсэн хуврагийг хэн нэгэн хүн,

‘Будда үхлийн дараа оршин байдаг.’ гэсэн үзэлтэй гэх аваас, энэ нь зохисгүй үйлдэл болно.

Эсвэл тэр хувраг хүн,

---

296 “*ayam aham asmi*”—“Энэ Би бол...”. Хүн өөртэйгөө холбоотой зүйлийг ярихын тулд өөрийгөө хаана, яахан байгаагаа эхлээд мэдсэн, мэдэрсэн байх хэрэгтэй болов уу (Бид Мэдрэхүйн Оронд оршин буйн хувьд). Энэ тохиолдолд тэрхүү ‘мэдрэх зүйлүүд огт үгүй болох аваас’ хэмээн өөр ертөнц (мэдрэгдэх бие-дүрст юмс гэж огт үгүй Бие-Бусын Орнууд г.м.) ч мөн байгааг давхар сануулж, Будда энэ зүйрлэлийг хэрэглэсэн болов уу (Орч).

297 “*ayam aham asmi*”—“Энэ Би бол...”. Өмнөх зүүлт тайлбар (*Paṭighasamphasso, Adhivacanasamphasso*)-ын нэгэн адил, хүн аливаа зүйлийг тодорхойлж ярихын тулд мэдэрсэн, мэдсэн байх хэрэгтэй болно. Мэдрэмж үгүй болсон бол “Би бол ийм тийм...” гэж ярих нь боломжгүй зүйл болох юм. Тэр утгаар.

'Будда үхлийн дараа оршин байхгүй.' гэсэн үзэлтэй гэх аваас, энэ нь зохисгүй үйлдэл болно.

Эсвэл тэр хувраг хүн,

'Будда үхлийн дараа оршин байх байхгүйн аль аль төлөвт байна.' гэсэн үзэлтэй гэх аваас, энэ нь зохисгүй үйлдэл болно.

Эсвэл тэр хувраг хүн,

'Будда үхлийн дараа оршин байх байхгүйн аль ч төлөвт байдаггүй.' гэсэн үзэлтэй гэх аваас, энэ нь зохисгүй үйлдэл болно.

Ямар учраас тэр билээ?

Учир юу гэвэл, Аананда:

'Ангилан үзэхүйн хэр хэмжээгээр ангилан үзэхүйн цар хүрээг, хэл ярианы хэр хэмжээгээр хэл ярианы цар хүрээг, танин-мэдэхүйн хэр хэмжээгээр танин-мэдэхүйн цар хүрээг, саруул-ухааны хэр хэмжээгээр саруул-ухааны цар хүрээг, энэ амьдралын хэр хэмжээгээр[298] амьдралын цар хүрээг шууд-билгүүнээр ухаарсан болохоор, тэр хувраг шууд-билгүүний гэгээрлийг олсон билээ.

Ийнхүү төгс гэгээрсэн хуврагийг, "тэр мэддэггүй, тэр хардаггүй" гэх үзэл байх аваас, энэ нь зохисгүй үйлдэл болох болно.

5. Оюун-Ухамсрын Долоон Орон (Sattaviññāṇaṭṭhiti)

Аананда, оюун-ухамсрын долоон өөр орон, мөн хоёр ертөнц гэж бий.

Тэгвэл тэдгээр долоон орон нь юу бол?

Аананда, бие махбод болон танин-мэдэхүйн хувьд янз бүр бодгалиуд байдаг. Тухайлбал, хорвоогийн хүмүүс, зарим бурхад, эсвэл зарим доод төрөлтөн[299] байна. Энэ бол оюун-ухамсрын эхний орон юм.

Нэгдүгээр даяанаар үүссэн, бие махбодын хувьд олон янз боловч, танин-мэдэхүйн хувьд яг ижилхэн бодгалиуд гэж байдаг. Тухайлбал, Бярман Тэнгэрийн Орны тэнгэр бурхад байна. Энэ бол оюун-ухамсрын хоёр дахь орон юм.

Биеийн махбодын хувьд яг ижилхэн боловч, танин-мэдэхүйн хувьд янз бүр бодгалиуд гэж байдаг. Тухайлбал, Урсгал Туяаны Орны[300] тэнгэр бурхад байна. Энэ бол оюун-ухамсрын гурав дахь орон юм.

---

298 *Yāvatā vaṭṭaṁ*—"энэ амьдралын хэр хэмжээгээр". Авсан төрөл, энэхэн насны цар хүрээ, энэ амьдралын байр байдлаар гэдэг утгаар.

299 *Vinipātika*—"доод төрөлтөн". Өөрөөр "доод ертөнцийнхөн". Үүнд там, өлсгөлөн-сүнс, амьтан, асурад хамаарах дөрвөн төрөл орно. Урсгалд Орогч болсноор "доод төрөлд эс төрөгч" (*avinipāta-dhammo*) болно.

Бие махбодын хувьд яг ижилхэн, танин-мэдэхүйн хувьд ч мөн яг ижилхэн бодгалиуд гэж байдаг. Тухайлбал Үзэсгэлэнт Туяаны Орны[301] тэнгэр бурхад байна. Энэ бол оюун-ухамсрын дөрөв дэх орон юм.

Бие-дүрст юмсын танин-мэдэхүйгээс нэгэнт хальснаар, “орон зай хязгааргүй”-г оршоон бясалгаснаар, юмсын төрөл зүйлийг танин-мэдэхүйд анхаарал эс хандуулснаар, аливаад үзүүлэх хариу үйлдэл үгүй болсноор, Хязгааргүй Орон Зайн Оронд хүрэгч бодгалиуд байдаг. Энэ бол оюун-ухамсрын тав дахь орон юм.

Хязгааргүй Орон Зайн Орноос нэгэнт хальж, “ухамсар хязгааргүй”-г оршоон бясалгаснаар, Хязгааргүй Ухамсрын Оронд хүрэгч бодгалиуд байдаг. Энэ бол, оюун-ухамсрын зургаа дахь орон юм.

Хязгааргүй Ухамсрын Орноос нэгэнт хальж, “оргүй хоосон”-ыг оршоон бясалгаснаар, Огт-Оргүйн Оронд хүрэгч бодгалиуд байдаг. Энэ бол оюун-ухамсрын долоо дахь орон юм.

Мөн түүнчлэн, Танихуй-Үгүйн Орон[302] болон Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орон гэж хоёр ертөнц байдаг.

Аананда, бие махбод болон танин-мэдэхүйн хувьд янз бүр бодгалиуд байдаг. Тухайлбал, хорвоогийн хүмүүс, зарим бурхад, эсвэл зарим доод төрөлтөн байна гэлээ.

Хэн нэгэн хүн, энэ оюун-ухамсрын нэгдүгээр орны учир шалтгааныг ойлгосон, мөн түүний үгүй болохуйг ойлгосон, мөн түүний таатай байдлыг ойлгосон, мөн түүний үр-дагаврыг ойлгосон, мөн түүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Аананда, нэгдүгээр даянаар үүссэн, бие махбодын хувьд олон янз боловч, танин-мэдэхүйн хувьд яг ижилхэн бодгалиуд гэж байдаг. Тухайлбал, Бярман Тэнгэрийн Орны тэнгэр бурхад байна гэлээ.

Хэн нэгэн хүн, энэ хоёрдугаар орны учир шалтгааныг ойлгосон, мөн түүний үгүй болохуйг ойлгосон, мөн түүний таатай байдлыг ойлгосон, мөн түүний үр-дагаврыг ойлгосон, мөн түүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Аананда, биеийн махбодын хувьд яг ижилхэн боловч, танин-мэдэхүйн хувьд янз бүр бодгалиуд гэж байдаг. Тухайлбал, Урсгал Туяаны Орны тэнгэр бурхад байна гэлээ.

---

300 *Devā Ābhassarā*—“Урсгал Туяаны Орны” тэнгэр бурхад. “Урсгал Туяаны Орон” буюу бясалгалын II Даяаныг оршоосноор хүрдэг гэж үздэг Бярман тэнгэрийн орны гэрэл цацруулсан тэнгэр бурхад.

301 *Devā Subhakiṇhā*—“Үзэсгэлэнт Туяаны Орны” тэнгэр бурхад. “Бясалгалын III Даяаныг оршоосноор хүрдэг гэж үздэг Бярман Тэнгэрийн Орон, тод, тогтвортой, үзэсгэлэнт гэрэл цацруулсан бурхад.

302 *Asaññasattāyatanaṁ*—“Танихуй-Үгүйн Орон”. (Тайлбарт Будда хэсгийг, мэдрэхүйн-орны даяаныг Лавлахад үз.) IV Даяаныг оршоосноор хүрэх ба энэ ертөнцөд буй бодгалиуд бие-дүрст боловч тэдэнд танин-мэдэхүй гэж үгүй юм. Тэд энэ төлөвт 500 их галав (*mahākappa*)-ын турш оршино гэж үздэг (AN 4.123).

Хэн нэгэн хүн, энэ гуравдугаар орны учир шалтгааныг ойлгосон, мөн үүний үгүй болохуйг ойлгосон, мөн үүний таатай байдлыг ойлгосон, мөн үүний үр-дагаврыг ойлгосон, мөн үүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?"

"Мэдээж үгүй. Эрхэм Багш аа."

"Аананда, бие махбодын хувьд яг ижилхэн, танин-мэдэхүйн хувьд ч мөн яг ижилхэн бодгалиуд гэж байдаг. Тухайлбал Үзэсгэлэнт Туяаны Орны тэнгэр бурхад байна гэлээ.

Хэн нэгэн хүн, энэ дөрөвдүгээр орны учир шалтгааныг ойлгосон, мөн үүний үгүй болохуйг ойлгосон, мөн үүний таатай байдлыг ойлгосон, мөн үүний үр-дагаврыг ойлгосон, мөн үүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?"

"Мэдээж үгүй. Эрхэм Багш аа."

"Аананда, бие-дүрст юмсын танин-мэдэхүйгээс нэгэнт хальснаар, "орон зай хязгааргүй"-г оршоон бясалгаснаар, юмсын төрөл зүйлийг танин-мэдэхүйд анхаарал эс хандуулснаар, аливаад үзүүлэх хариу үйлдэл үгүй болсноор, Хязгааргүй Орон Зайн Оронд хүрэгч бодгалиуд байдаг гэлээ.

Хэн нэгэн хүн, энэ тавдугаар орны учир шалтгааныг ойлгосон, мөн үүний үгүй болохуйг ойлгосон, мөн үүний таатай байдлыг ойлгосон, мөн үүний үр-дагаврыг ойлгосон, мөн үүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?"

"Мэдээж үгүй. Эрхэм Багш аа."

"Аананда, Хязгааргүй Орон Зайн Орноос нэгэнт хальж, "ухамсар хязгааргүй"-г оршоон бясалгаснаар, Хязгааргүй Ухамсрын Оронд хүрэгч бодгалиуд байдаг гэлээ.

Хэн нэгэн хүн, энэ зургаадугаар орны учир шалтгааныг ойлгосон, мөн үүний үгүй болохуйг ойлгосон, мөн үүний таатай байдлыг ойлгосон, мөн үүний үр-дагаврыг ойлгосон, мөн үүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?"

"Мэдээж үгүй. Эрхэм Багш аа."

"Аананда, Хязгааргүй Ухамсрын Орноос нэгэнт хальж, "оргүй хоосон"-ыг оршоон бясалгаснаар, Огт-Оргүйн Оронд хүрэгч бодгалиуд байдаг гэлээ.

Хэн нэгэн хүн, энэ долоодугаар орны учир шалтгааныг ойлгосон, мөн үүний үгүй болохуйг ойлгосон, мөн үүний таатай байдлыг ойлгосон, мөн үүний үр-дагаврыг ойлгосон, мөн үүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?"

"Мэдээж үгүй. Эрхэм Багш аа."

"Аананда, Танихуй-Үгүйн Орон болон Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бус Орон гэж хоёр ертөнц байдаг гэлээ.

Хэн нэгэн хүн, энэ хоёр ертөнцийн учир шалтгааныг ойлгосон, мөн үүний үгүй болохуйг ойлгосон, мөн үүний таатай байдлыг ойлгосон, мөн үүний үр-дагаврыг ойлгосон, мөн үүнээс ангижран салахуйг ойлгосон бол, тэр хүн энд дээдийн жаргал эдлээд суух нь зөв зохистой явдал болох уу?”

“Мэдээж үгүй. Эрхэм Багш аа.”

“Аананда, хэрэв хувраг хүн, оюун-ухамсрын долоон орон болон тэдгээр хоёр ертөнцийн учир шалтгааныг, мөн үүний үгүй болохуйг, мөн үүний таатай байдлыг, мөн үүний үр-дагаврыг, мөн үүнээс ангижран салахуйг чухамхүү үнэнээр нь ойлгож ухаарсан бол, эдгээрт автаж донтохгүй байснаар ангижирсан бол, тэр хуврагийг саруул-ухаанаар ангижралыг олсон хувраг гэж нэрлэдэг билээ.

6. Найман Ангижрал (Aṭṭhavimokkha)

Аананда, найман ангижрал гэж байдаг.

Энэ найм нь юу бол?

Бие-дүрстэн бие-дүрсийг харна. Энэ бол ангижралын эхний түвшин юм.

Бие-дүрсийг дотроос нь танихгүй байгаа хүн гаднаас нь бие-дүрсийг харна. Энэ бол ангижралын, хоёр дахь түвшин юм.

Зөвхөн сайханд төвлөрч ангижирдаг. Энэ бол гурав дахь ангижралын түвшин юм.

Бие-дүрст юмсын танин-мэдэхүйгээс нэгэнт хальснаар, “орон зай хязгааргүй”-г оршоон бясалгаснаар, юмсын төрөл зүйлийг танин-мэдэхүйд анхаарал эс хандуулснаар, аливаад үзүүлэх хариу үйлдэл үгүй болсноор, тэр Хязгааргүй Орон Зайн Орны зэрэгт хүрч, энд оршдог. Энэ бол дөрөв дэх ангижралын түвшин юм.

Хязгааргүй Орон Зайн Орноос нэгэнт хальж, “ухамсар хязгааргүй”-г оршоон бясалгаснаар, Хязгааргүй Ухамсрын Орны зэрэгт хүрч, энд оршдог. Энэ бол тав дахь ангижралын түвшин юм.

Хязгааргүй Ухамсрын Орноос нэгэнт хальж, “оргүй хоосон”-ыг оршоон бясалгаснаар, Огт-Оргүйн Орны зэрэгт хүрч, энд оршдог. Энэ бол зургаа дахь ангижралын түвшин юм.

Огт-Оргүйн Орныг бүрэн даван хальж, Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орны зэрэгт хүрч, энд оршдог. Энэ бол долоо дахь ангижралын түвшин юм.

Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орноос хальж гарч, танин-мэдэхүй хийгээд мэдрэмж тэр чигтээ үгүй болох зэрэгт хүрч, энд оршдог. Энэ бол найм дахь ангижралын түвшин юм.

Аананда, хувраг хүн эдгээр ангижралын найман түвшинд өгсөх дарааллаар ч, урвуу дарааллаар ч, эсвэл аль алинаар нь ч юм уу хүрсэн үедээ, тэрбээр хүссэн үедээ, хүссэн газраа, хүссэн байдлаар, хүссэн хугацаагаар, эдгээр ангижралд орж, гарч, мөн тэрээр энэ амьдралдаа оюуны-хорлолыг үгүй хийснээр,

оюуны-хорлол үгүй ангижрал, саруул-ухааны ангижралд оршиж, үүнийгээ шууд-билгүүнээр өөрөө ухааран гэгээрсэн бол, түүнийг хоёр талаараа зэрэг ангижирсан хувраг хэмээн нэрлэдэг билээ.

Аананда, ийм хоёр талаараа зэрэг ангижирсан ангижралаас илүү дээр, эсвэл илүү агуу хоёр талаараа зэрэг ангижирсан ангижрал гэж байдаггүй билээ."

Будда ийн айлдав. Сэтгэл өндөр Эрхэм Аананда, Буддагийн энэ айлдвараас баяр баяслыг олов.

Хамаг Учир Шалтгаан Судар энд өндөрлөв.

АГУУ НИРВААНД НЭГМӨСӨН ОДОХУЙ СУДАР DN 16. MAHĀPARINIBBĀNASUTTA

БИ ИЙН СОНССОН ЮМ.[303]

Нэгэн цагт Будда, Раажагахагийн ойролцоох Тас Шувуудын Оргил[304] ууланд амьдарч байв.

Тэр үед, Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту, важжий[305] нарыг довтлох хүслийг өвөрлөн байв. Тэрбээр ийн хэлэх аж: "Би тэдгээр ялагдашгүй, агуу хүчтэй важжий нарыг хүйс тэмтэрнэ. Би важжий нарыг бүгдийг нь үгүй хийнэ. Би важжий нарыг газрын хөрстэй тэгшлэх болно."

Ингээд Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту, Магадха улсын ерөнхий сайд, бярман Вассакаарад хандан:

"Бярман минь, явж Будда дээр очоод, миний нэрийн өмнөөс Буддагийн хөлд сөгдөж мөргөөд, өвчин зовлонгүй, эрүүл саруул, энх тунх, аятай таатай амьдарч байгаа эсэхийг нь асуугаад: 'Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту, Эрхэм Багш Буддагийн өлмийд, толгой бөхийн сөгдөн мөргөж, та өвчин зовлонгүй, эрүүл саруул, энх тунх, аятай таатай амьдарч байна уу? гэж асуулгав.' гэж хэл. Тэгээд мөн ингэж хэл:

'Эрхэм Багш аа, Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту, важжий нарыг довтлохыг хүсэж байна. Тэрээр хэлэхдээ: 'Би тэдгээр ялагдашгүй, агуу хүчтэй важжий нарыг хүйс тэмтэрнэ. Би важжий нарыг бүгдийг нь үгүй хийнэ. Би важжий нарыг газрын хөрстэй тэгшлэх болно.' гэж байна. Тэгээд Будда чамд юу гэж хариу хэлэхийг сайн тогтоож аваад, чи надад ирж мэдэгдэх ёстой шүү. Учир нь Гэгээрсэн хүмүүс буруу юм хэлдэггүй юм." хэмээв.

1. Бярман Вассакаара (Vassakārabrāhmaṇa)

"Сайн ойлголоо. Эрхэм дээдэс ээ." гэж хаандаа хэлээд, Магадхагийн тэргүүн сайд, бярман Вассакаара цэмцийлгэж бэлдсэн дээд зэргийн сүйх тэргэндээ суун, мөн олон тооны тийм дээд зэргийн сүйх тэрэгнүүдийн хамтаар тэндээс хөдөллөө. Раажагахагаас гарсан тэдгээр дээд зэргийн сүйх тэрэгнүүд Тас Шувуудын Оргил уул руу яваад, сүйх тэрэгний туулж чадах газар хүртэл туулж явж очоод, сүйх тэрэгнээсээ бууж Буддагийн байгаа газар руу явган явж хүрээд, ойртож ирснийхээ дараа Буддад ёслол

---

[303] *Parinibbāna*—"Нирваанд нэгмөсөн одохуй" (анг. *Final Liberation*, сам. *Parinirvāṇa*). Цаашид, "Эцсийн Нирваан" гэж хэрэглэв. Үгчилбэл, "нэгмөсөн үгүй болох". *Nibbāna*— "үгүй болох", "төгсөх" (анг. *Nirvana*, сам. *Nirvāṇa*). Тайлбарт дэлгэрэнгүй үз.

[304] *Gijjhakūṭa*—"Тас Шувуудын Оргил" уул. Өнөөгийн Энэтхэгийн Ражгир (*Rajgir* буюу Раажагаха)-т орших ариун дагшин уул.

[305] *Vajjī*—"важжий" (сам. *vriji*). Бүгд найрамдах засаглалтай гэдгээрээ алдартай Зүүн Хойд Энэтхэгийн эртний овог аймгуудын нэгдэл. Будда тэдний нэгдмэл байдал, тэсвэр хатуужил, хөгжил цэцэглэлтийг судрат олонтоо магтдаг.

мэндчилгээ дэвшүүлэв. Буддатай эелдэг яриа өрнүүлэн, мэнд ус мэдсэнийхээ дараа тэрээр нэг талд нь суув.

Магадхагийн тэргүүн сайд, бярман Вассакаара нэг талд нь суусан хойноо, Буддад ингэж хэлэв:

"Эрхэм Багш аа, Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту, 'Эрхэм Багш Будда таны өлмийд, толгой бөхийн сөгдөн мөргөж, таныг өвчин зовлонгүй, эрүүл саруул, энх тунх, аятай таатай амьдарч байна уу?' хэмээн асуулгав.

Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту, важжий нарыг эзлэн довтлохыг хүсэж байна. Тэрээр хэлэхдээ: 'Би тэдгээр ялагдашгүй, агуу хүчтэй важжий нарыг хүйс тэмтэрнэ. Би важжий нарыг бүгдийг нь үгүй хийнэ. Би важжий нарыг газрын хөрстэй тэгшлэх болно.' гэж хэлж байна." гэв.

2. Доройтлоос Сэргийлэх Долоон Зүйлс (Rājaaparihāniyadhamma)

Харин тэр үед Эрхэм Аананда, Буддагийн ард зогсоод, түүнийг дэвүүрээр сэвж байв. Тэгэхэд Будда Эрхэм Ааннандад хандан:

1. "Аананда, 'Важжий нар тогтмол байнга цуглардаг, мөн үе үе цуглан нийлдэг.' гэдгийг сонссон уу?"

"Эрхэм ээ, би: 'Важжий нар тогтмол байнга цуглардаг, мөн үе үе цуглан нийлдэг.' гэж сонссон билээ."

"Аананда, важжий нар тогтмол байнга цугларч, мөн үе үе цуглан нийлж байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу."

2. "Аананда, та 'Важжий нар санал нэгдэн цугларч, санал нэгдэн босож, важжий иргэний үүргээ санал нэгдэн биелүүлдэг гэж сонссон уу?"

"Эрхэм ээ, би: 'Важжий нар санал нэгдэн цугларч, санал нэгдэн босож, важжий иргэний үүргээ санал нэгдэн биелүүлдэг.' гэж сонссон билээ."

"Аананда, важжий нар санал нэгтэйгээр цугларч, санал нэгтэйгээр босож, важжий иргэний үүргээ санал нэгтэйгээр биелүүлж байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу."

3. "Аананда, 'Важжий нар шинээр хууль гаргадаггүй, тогтоосон хуучин хуулиа үгүй хийдэггүй, важжий эртний үндсэн хуулиудаа л дагаж мөрддөг.' гэж сонссон уу?"

"Эрхэм ээ, би: 'Важжий нар шинээр хууль гаргадаггүй, тогтоосон хуучин хуулиа үгүй хийдэггүй, важжий эртний үндсэн хуулиудаа л дагаж мөрддөг.' гэж сонссон билээ."

"Аананда, важжий нар шинээр хууль гаргадаггүй, тогтоосон хуучин хуулиа үгүй хийдэггүй, важжий эртний үндсэн хуулиудаа л дагаж мөрдөж байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу."

4. “Аананда, ‘Важжий нар өөрсдийн ахмад настнуудаа асарч, хүндэлж, дээдэлж, шүтдэг бөгөөд тэднийгээ сонсож дагахыг зүйтэй гэж үздэг.’ гэдгийг та сонссон уу?”

“Эрхэм ээ, би: ‘Важжий нар өөрсдийн ахмад настнуудаа асарч, хүндэлж, дээдэлж, шүтдэг бөгөөд тэднийгээ сонсож дагахыг зүйтэй гэж үздэг.’ гэж сонссон билээ.”

“Аананда, ‘Важжий нар өөрсдийн ахмад настнуудаа асарч, хүндэлж, дээдэлж, шүтдэг бөгөөд тэднийгээ сонсож дагахыг зүйтэй.’ гэж үзэж байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу.”

5. “Аананда, ‘Важжий нар эмэгтэйчүүд охидыг хүч хэрэглэн хулгайлдаггүй бөгөөд тэдэнтэй хүчээр нэг гэрт амьдардаггүй.’ гэдгийг та сонссон уу?”

“Эрхэм ээ, би: ‘Важжий нар эмэгтэйчүүд охидыг хүч хэрэглэн хулгайлдаггүй бөгөөд тэдэнтэй хүчээр нэг гэрт амьдардаггүй.’ гэж сонссон билээ.”

“Аананда, важжий нар эмэгтэйчүүд, охидыг хүч хэрэглэн хулгайлдаггүй, тэдэнтэй хүчээр нэг гэрт амьдардаггүй, тийм байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу.”

6. “Аананда, ‘Важжий нар хотын доторх болон хотын гаднах өөрсдийн ариун гэгээн газруудад хүндэтгэл үзүүлж, тэдгээрийг дээдэлж, сайшааж, шүтэн биширч, урьд цагт босгосон, урьд цагт үйлдэж байсан ариун гэгээн тахилуудад хайхрамжгүй хандах явдлыг огт хүлээн зөвшөөрдөггүй.’ гэдгийг та сонссон уу?”

“Эрхэм ээ, би: ‘Важжий нар хотын доторх болон хотын гаднах өөрсдийн ариун гэгээн газруудад хүндэтгэл үзүүлж, тэдгээрийг дээдэлж, сайшааж, шүтэн биширч, урьд цагт босгосон, урьд цагт үйлдэж байсан ариун гэгээн тахилуудад хайхрамжгүй хандах явдлыг огт хүлээн зөвшөөрдөггүй.’ гэж сонссон билээ.”

“Аананда, важжий нар хотын доторх болон хотын гаднах өөрсдийн ариун гэгээн газруудад хүндэтгэл үзүүлж, тэдгээрийг дээдэлж, сайшааж, шүтэн биширч, урьд цагт босгосон, урьд цагт үйлдэж байсан ариун гэгээн тахилуудад хайхрамжгүй хандах явдлыг огт хүлээн зөвшөөрдөггүй ийм байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу.”

7. “Аананда, ‘Важжий нар Төгс Гэгээрсэн Нэгэнд зориулсан тусгай хамгаалалт, байр сав, аюулгүй байдлын сайн зохицуулалт хийж өгсөн бөгөөд ингэснээр ирээдүйн олон Гэгээнтнүүд энэ хүрээ рүү орно. Мөн одоо цагийн Гэгээнтнүүд ч бас энэ хүрээнд орсноор тав тухтай амьдрах боломжтой болгосон байдаг.’ гэдгийг та сонссон уу?”

“Эрхэм ээ, би: ‘Важжий нар Төгс Гэгээрсэн Нэгэнд зориулсан тусгай хамгаалалт, байр сав, аюулгүй байдлын сайн зохицуулалт хийж өгсөн бөгөөд ингэснээр ирээдүйн олон Гэгээнтнүүд энэ хүрээ рүү орно. Мөн одоо цагийн Гэгээнтнүүд ч бас энэ хүрээнд орсноор тав тухтай амьдрах боломжтой болгосон байдаг.’ гэж сонссон билээ.”

“Аананда, важжий нар Төгс Гэгээрсэн Нэгэнд зориулсан тусгай хамгаалалт, байр сав, аюулгүй байдлын сайн зохицуулалт хийж өгөн, ингэснээр ирээдүйн олон Гэгээнтнүүд энэ хүрээ рүү орж, мөн одоо цагийн Гэгээнтнүүд ч бас энэ хүрээнд орсноор тав тухтай амьдрах боломжтой болгосон байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу.”

Үүний дараа Будда, Магадхагийн тэргүүн сайд, бярман Вассакаарад хандан:

“Бярман минь, би нэгэн цагт Саарандада бунханы[306] ойролцоо, Весаалий[307] хавьд амьдарч байсан бөгөөд тэнд би важжий нарт мөхөн доройтохоос сэргийлэх эдгээр долоон зүйлийг заасан билээ. Бярман минь, важжий нар доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг баримталж, важжий нар мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлтэй санал нийлж байгаа цагт, важжий нар мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих л болов уу.” хэмээн хэлэв.

Үүнийг хэлсний дараа Магадхагийн тэргүүн сайд, бярман Вассакаара Буддад хандан:

“Хэрвээ важжий нар Готама Багшийн доройтлоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийн ядаж нэгийг нь ч гэсэн биелүүлж байгаа бол мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих нь лавтай юм байна. Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту цэрэг хүчирхийллийн замаар важжий нарыг дийлэхгүй буюу харин авлига хахуулиар[308], эсвэл хооронд нь эвдрэлцүүлэх замаар л дийлэх юм байна. Одоо Эрхэм Багш Готама, бид явах боллоо. Бидэнд хийх ёстой зүйлс, олон үүрэгт ажил байгаа билээ.” гэхэд:

“Бярман минь, та явах ёстой болсон бол таалллаараа мордогтун.” гэхэд, Магадхагийн тэргүүн сайд, бярман Вассакаара Буддагийн энэ үгийг талархан хүлээж аваад, сэтгэл өндөр суудлаасаа босон гарч одов.

3. Хувраг Доройтохоос Сэргийлэх Долоон Зүйл (Bhikkhuaparihāniyadhamma)

Магадхагийн тэргүүн сайд, бярман Вассакаара явсны дараа их удалгүй, Будда Эрхэм Аанандад хандан: “Аананда, яваад Раажагахага хавиар амьдарч байгаа бүх хуврагуудыг хурлын танхимд одоо цуглуул.” гэж хэлэв.

“Тэгье ээ, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда Буддад хариулаад, Раажагахага хавьд амьдарч байсан бүх хуврагуудыг хурлын танхимд цуглуулаад, Будда дээр ирж түүнд мөргөсний дараа, нэг талд нь гарч зогсов.

Эрхэм Аананда нэг талд нь зогсоод, Буддад:

---

306 *Sārandada cetiya*—“Саарандада бунхан”. Весаалий хотоос холгүй орших нэн эрт цагийн ариун шүтээний газар.

307 *Vesālī*—“Весаалий”. Эртний хот буюу өнөөгийн Энэтхэгийн Бихар мужийн Патна (*Patna*) хотоос хойш орших археологийн дурсгалт газар.

308 *Upalāpana*—“авлига хахуулиар”. Зарим эхэд “суртал ухуулгаар” (анг. *propaganda*) гэжээ (MW).

"Хуврагууд цугларлаа. Эрхэм Багш аа, та болгооно уу." гэв.

Ингээд Будда суудлаасаа босоод, хурлын танхимд ирж, бэлтгэсэн олбог суудал дээр суув. Будда ийн суугаад нийт хуврагуудад хандан:

"Би та бүгдэд, хувраг доройтохоос сэргийлэх долоон зүйлийг заая. Үүнийг сонсоод ой тойндоо сайтар буулгаарай. Ингээд би ярья." гэхэд:

"За, Эрхэм Багш аа." хэмээн тэдгээр хуврагууд нэгэн дуугаар хариулахад, Будда ийн айлдав:

1. "Хуврагууд аа, хуврагууд тогтмол байнга цугларч, мөн үе үе цуглан нийлж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

2. Хуврагууд аа, хуврагууд санал нэгтэйгээр цугларч, санал нэгтэйгээр босож, хуврагийнхаа үүргээ санал нэгтэйгээр биелүүлж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

3. Хуврагууд аа, хуврагууд шинээр ёс зохиодоггүй, эсвэл хуучин ёсоо үгүй хийдэггүй, хуврагийн хуучны ёс уламжлалаар хүлээн зөвшөөрөгдсөн хувраг дүрмээ дагаж мөрдөж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

4. Хуврагууд аа, хуврагууд, сахил аваад удсан, гэрээ орхиод удсан, Чуулган[309] ахалсан хуврагууд, Чуулганы толгой хуврагууд болох тэдгээр ахмад настай хуврагуудаа асарч, хүндэлж, дээдэлж, шүтэж, тэднийгээ сонсох нь зүйтэй хэмээн бодож байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

5. Хуврагууд аа, хуврагууд дараа төрөлд хөтөлдөг дон-шунал урган бий болоход, үүнд автахгүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

6. Хуврагууд аа, хуврагууд хөдөө хээр, уул модонд, бусдаас тусгаар амьдрахыг хүсдэг байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

7. Хуврагууд аа, хувраг хүн ганцаар байж, өөртөө дүүрэн-анхаарлыг урт удаан хугацаанд дадуулан бий болгож, ингэснээр ирээдүйд, ариун-сахилтан нөхөд[310], сахил ариун ёсыг дагасан, өөр нэгэн хувраг тэнд ирж нэгддэг, ийнхүү ариун-сахилтан, сахил ариун ёсыг дагасан хувраг ирж нэгдсэнээр, тэд хамтдаа эвтэй тохитой амьдарч байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Хуврагууд аа, хувраг мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг ямагт сахиж, мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг хувраг хүн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Би та бүгдэд мөхөн доройтохоос сэргийлэх өөр бас долоон зүйлийг заая. Үүнийг сонсоод, ой тойндоо сайтар буулгаарай. Ингээд би ярья." гэхэд:

---

309 *Saṅgha*—"Чуулган". Энэ тохиолдолд тухайн хийдийн нийт хуврагууд.

310 *Sabrahmacārī*—"ариун-сахилтан нөхөд". Ариуслын-замналаар зэрэгцэн замнагч, сахилтан найз нөхөд, хамтрагчид.

“За, Эрхэм Багш аа.” хэмээн тэдгээр хуврагууд нэгэн дуугаар хариулахад, Будда ийн айлдав:

1. “Хуврагууд аа, хуврагууд ажил хөдөлмөрийн[311] таашаалд автахгүй, ажил хөдөлмөрт дурлахгүй, ажил хөдөлмөрт автаж донтоогүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

2. Хуврагууд аа, хуврагууд яриа хөөрөөний таашаалд автахгүй, яриа хөөрөөнд дурлахгүй, яриа хөөрөөнд автаж донтоогүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

3. Хуврагууд аа, хуврагууд нойрны таашаалд автахгүй, нойронд дурлахгүй, нойронд автаж донтоогүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

4. Хуврагууд аа, хуврагууд андлал нөхөрлөлд[312] автахгүй, андлал нөхөрлөлд дурлахгүй, андлал нөхөрлөлд автаж донтоогүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

5. Хуврагууд аа, хуврагууд чөтгөрт эзэмдүүлсэн хүслийг[313] үүсгэхгүй, чөтгөрт эзэмдүүлсэн хүсэлд автаагүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

6. Хуврагууд аа, хуврагууд хорлолтой[314] найз үгүй, хорлолтой анд үгүй, хорлолтой нөхөд үгүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

7. Хуврагууд аа, хувраг хүн бага доод түвшний амжилт[315] дээрээ ханаж зогсдоггүй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Хуврагууд аа, хувраг мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг сахин биелүүлж, мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг хувраг хүн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Би та бүгдэд мөхөн доройтохоос сэргийлэх өөр бас долоон зүйлийг заая. Үүнийг сонсоод, ой тойндоо сайтар буулгаарай. Ингээд би ярья.” гэхэд:

“За, Эрхэм Багш аа.” хэмээн тэдгээр хуврагууд нэгэн дуугаар хариулахад, Будда ийн айлдав:

---

311 *Kamma*—“ажил хөдөлмөр”. B. Sujato тайлбартаа гол төлөв “барилгын ажил”-ыг хэлнэ гэжээ.

312 *Saṅgaṇikā*—“андлал нөхөрлөл”. Мөн олноороо цуглан нийлсэн элдэв арга хэмжээ үүнд хамаарна.

313 *Pāpicchā*—“чөтгөрт эзэмдүүлсэн хүсэл”. Сэтгэлийн-хирэнд автаж, өөрийгөө сайн үйл хийгч мэтээр хүмүүст итгүүлэх боловч, сэтгэлийн гүндээ авлигад автсан (чөтгөрт худалдагдсан) хүсэл.

314 *Pāpa*…—”хорлолтой”… Үгчилбэл, “чөтгөрлөг”, “чөтгөрт худалдагдсан”. (*pāpamittā*—хорлолтой найз)

315 *Oramattakena visesādhigamena*—“бага доод түвшний амжилт”. Гэгээрлийн зэрэг биш бөгөөд жишээ нь зарим даяаны түвшин, зарим эгэл бусын оюуны ид-чадал, бясалгалын ямар нэг түвшин.

1. "Хуврагууд аа, хувраг хүн ямагт итгэл-үнэмшилтэй[316] байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

2. Хуврагууд аа, хувраг хүн ямагт ёс-зүйн-ичгүүртэй[317] байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

3. Хуврагууд аа, хувраг хүн ямагт ёс-зүйн-айдастай[318] байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

4. Хуврагууд аа, хувраг хүн ямагт сурч байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

5. Хуврагууд аа, хувраг хүн ямагт эрч хүчтэй байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

6. Хуврагууд аа, хувраг хүн дүүрэн-анхаарлыг өөртөө ямагт оршоосон байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

7. Хуврагууд аа, хувраг хүн саруул-ухааныг өөртөө ямагт оршоосон байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Хуврагууд аа, хувраг мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг сахин биелүүлж, мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг хувраг хүн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Би та бүгдэд, мөхөн доройтохоос сэргийлэх өөр бас долоон зүйлийг заая. Үүнийг сонсоод, ой тойндоо сайтар буулгаарай. Ингээд би ярья." гэхэд:

"За, Эрхэм Багш аа." хэмээн тэдгээр хуврагууд нэгэн дуугаар хариулахад, Будда ийн айлдав:

1. "Хувраг хүн гэгээрлийг-амирлуулагч[319] дүүрэн-анхаарлыг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

2. Хувраг хүн гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүйг[320] дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

---

[316] *Saddhā*—"итгэл-үнэмшил". Буддагийн Гэгээрэл, түүний заасан Сургаал, Төгс Гэгээрсэн хуврагууд, Үйлийн Үрийн Хууль, болон Гэгээнтний Найман Замнал зэрэгт итгэлтэй, сүсэгтэй, үнэмшилтэй байх. Цөөнгүй сударт *Saddhā*-г ариуслын-замналын хамаг эхлэл нь буюу үр нь юм гэжээ (*Kasibhāradvājasutta*).

[317] *Hirimanā, hiri*—"ёс-зүйн-ичгүүр". Сахилд харш, ариуслын-замналд харш аливаа үйлд хандах ичгүүр сонжуур.

[318] *Ottappī*—"ёс-зүйн-айдас". Сахилд харш, ариуслын-замналд харш аливаа үйлээс айх эмээх сэтгэл.

[319] *Sambojjhaṅga*—"гэгээрлийг-амирлуулагч". Гэгээрлийг нөхцөлдүүлэгч, бүрэлдүүлэгч, үндэслэгч хүчин зүйл, эд эс. (*Sattasambojjhaṅga*—Сургаал ёсоор долоон хүчин зүйл: 1. дүүрэн-анхаарал; 2. Үзэгдэл-шинжихүй; 3. эрч хүч; 4. хөөр-баяр; 5. амар-амгалан; 6. самади-төвлөрөл; 7. төв-оршихуй)

[320] *Dhammavicaya*—"Үзэгдэл-шинжихүй". Юмс үзэгдлийг (мөн хорвоогийн Жам ёсыг, Сургаалыг, туйлын Үнэнийг үүнд хамруулж болно) Сургаал номын нүдээр задлан шинжихүй, ухан харахуй.

3. Хуврагхүн гэгээрлийг-амирлуулагч эрч хүчийг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

4. Хувраг хүн гэгээрлийг-амирлуулагч хөөр-баярыг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

5. Хувраг хүн гэгээрлийг-амирлуулагч амар-амгаланг[321] өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

6. Хувраг хүн гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрлийг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

7. Хувраг хүн гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Хуврагууд аа, хувраг мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг сахин биелүүлж, мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг хувраг хүн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Би та бүгдэд мөхөн доройтохоос сэргийлэх өөр бас долоон зүйлийг заая. Үүнийг сонсоод, ой тойндоо сайтар буулгаарай. Ингээд би ярья.” гэхэд:

“За, Эрхэм Багш аа.” хэмээн тэдгээр хуврагууд нэгэн дуугаар хариулахад, Будда ийн айлдав:

1. “Хувраг хүн, мөнхийн-бусын танин-мэдэхүйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

2. Хувраг хүн, өөрийн-оршихуй-бусын[322] танин-мэдэхүйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

3. Хувраг хүн, сайхан-бусын[323] танин-мэдэхүйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

4. Хувраг хүн, үр-дагаврын[324] танин-мэдэхүйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

5. Хувраг хүн, орхин-одуулахуйн[325] танин-мэдэхүйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

---

321 *Passaddhi*—“амар-амгалан” (анг. *serenity, tranquility*). Сахил, бясалгалаас үүдэн сэтгэлийн дотор үүсэн бий болох гүнзгий түвшний нэн амар амгалан байдал.

322 *Anattā*—“өөрийн-оршихуй-бус” (сам. *anatman,* анг. *no-self, not-self*). (Тайлбарт үз.)

323 *Asubha*—“сайхан-бус”. Бие махбодын үзэсгэлэнд автах шунах сэтгэлээс ангид байхуйг илэрхийлэхэд хэрэглэдэг, голчлон хүний биеийн 32 бохир муухай чанарыг тухайлсан нэршил (DN 22-т бий).

324 *Ādīnavā*—“үр-дагавар”. Үгчилбэл, “аюул, хөнөөл”. Хийсэн буруу үйлээс “үүсэх аюул хөнөөл”, “муу үр дагавар”.

325 *Pahāna*—“орхин-одуулахуй”. Ариуслын-замналд тусгүй-муу зүйлийг орхих, одуулах, зайлуулах, татгалзах.

6. Хувраг хүн, салж-ангижрахуйн танин-мэдэхүйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

7. Хувраг хүн, төгсгөл болохуйн[326] танин-мэдэхүйг өөрт дадуулж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Хуврагууд аа, хувраг мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг сахин биелүүлж, мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр долоон зүйлийг хувраг хүн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

Би та бүгдэд, мөхөн доройтохоос сэргийлэх өөр бас зургаан зүйлийг заая. Үүнийг сонсоод, ой тойндоо сайтар буулгаарай. Ингээд би ярья.” гэхэд:

“За, Эрхэм Багш аа.” хэмээн тэдгээр хуврагууд нэгэн дуугаар хариулахад, Будда ийн айлдав:

1. “Хувраг хүн, олон нийтийн газарт ч, бусдын нүднээс далд газарт ч, бие биедээ найрсаг байдлаар, өөрийн биеэр дэмжин тусалж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

2. Хувраг хүн, олон нийтийн газарт ч, бусдын нүднээс далд газарт ч, бие биедээ найрсаг байдлаар, хэл амаараа, үг яриагаараа дэмжин тусалж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

3. Хувраг хүн, олон нийтийн газарт ч, бусдын нүднээс далд газарт ч, бие биедээ найрсаг байдлаар, оюун санаагаараа дэмжин тусалж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

4. Хувраг хүн, сахил-ухамсраас гажаагүй байдлаар олдсон юмаа, мөн түүнчлэн бадрын аягандаа олсон жоохон хоолоо ч, ёс журамт хуврагуудтайгаа хуваалцаж байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

5. Хувраг хүн, олон нийтийн газарт ч, бусдын нүднээс далд газарт ч, ёс журамт хуврагуудтайгаа, сахил номынхоо дагуу, тухайлбал, алдаа зөрчил үгүй, зай завсаргүй, өөгүй, сэвгүй, ангижран гэгээрүүлэх, мэргэдээр магтуулах, аливаад автаагүй, самади-төвлөрөл, даянд оруулах, тэрхүү амьдралаар амьдарч байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

6. Хувраг хүн, олон нийтийн газарт ч, бусдын нүднээс далд газарт ч, Гэгээнтэн хүний, Гэгээрэлд хөтлөх, үүгээр нь өөрийгөө дадуулсан хүн зовлонг нэгмөсөн устгаж чадах, тэр үзлээр замнаж буй хуврагуудын хамт, мөн өөрөө бас тэрхүү, Гэгээнтэн хүний, Гэгээрэлд хөтлөх, үүгээр нь өөрийгөө дадуулсан хүн зовлонг нэгмөсөн устгаж чадах, тэр үзлээр замнан амьдарч байгаа цагт, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

---

[326] *Nirodha*—“төгсгөл болохуй”. “Төгсгөл”, “үгүй болохуй”, Гэгээрлийг олохуйтай дүйцэх утга. (Тайлбарт Нирваан хэсгийг үз.)

Хуврагууд аа, хувраг мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр зургаан зүйлийг сахин биелүүлж, мөхөн доройтохоос сэргийлдэг эдгээр зургаан зүйлийг хувраг хүн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд, хувраг мөхөн доройтохгүй, харин ч гарцаагүй өсөн дэвжих болов уу.

(...)

Раажагахагийн ойролцоох Тас Шувуудын Оргил ууланд амьдарч байхдаа, Будда хуврагууддаа Сургаал номын талаар үе үе ийн хэлдэг байв:

“Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ.”

Будда Раажагахад удаан байсны дараа Эрхэм Аанандад хандан:

“Алив, Ааннанда, Амбалаттхикаа[327] руу явцгаая.” гэхэд,

“За Эрхэм Багш аа.” гэж Ааннанда хариулав.

Ингээд Будда олон тооны хуврагуудын хамтаар Амбалаттхикаа руу явцгаажээ.

Энд амьдарч байхдаа, Будда хуврагууддаа Сургаал номын талаар мөн үе үе ийн хэлдэг байв:

“Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ.”

---

[327] *Ambalaṭṭhikā*—“Амбалаттхикаа”. Үгийн утга: “Манго жимсний суулгац”. Раажагахагаас холгүй байрлах, төрийн дархан цаазат газар буюу даяанчид, хуврагууд амьдрах эрхтэй, хааны зөвшөөрөлтэй, тухайн цагийн цэцэрлэгт хүрээлэн.

4. Сааripуттагийн Тунхаглал (Sāriputtasīhanāda)

Дараа нь Будда, Амбалаттхикаагийн ойролцоо хангалттай удаан амьдарсны эцэст Эрхэм Аанандад хандан: "Алив, Аананда, бүгдээрээ Нааландаа[328] руу дөхье." гэж хэлэв.

"За, Эрхэм Багш аа." гэж Эрхэм Аананда Буддад хариулав. Тэгээд Будда, Хуврагийн Чуулганы хамтаар Наалaндаад хүрэлцэн иржээ. Ингээд Будда, Наалaндаагийн ойролцоох Паавaарикагийн[329] манго төгөлд ирлээ.

Тэр үед Эрхэм Саарипутта[330], Будда дээр ирээд, түүнд мөргөснийхөө дараа нэг талд нь суув. Эрхэм Саарипутта хажууд нь сууж байхдаа Буддад ийн хэлэв:

"Эрхэм Багш аа, би: 'Төгс Гэгээрлийн тал дээр Буддагаас илүү ихийг мэдсэн, илүү ихийг ухаарсан өөр хэн нэгэн даянч эсвэл брман, өнгөрсөн үед ч байгаагүй, ирээдүйд ч байхгүй, өнөө цагт ч байхгүй.' хэмээн, би Буддад ийм л итгэл дүүрэн явдаг билээ." гэв.

"Агуу бөгөөд сүр жавхлантай үгийг Саарипутта та хэллээ. Тов тодорхой, сайтар ойлгогдох, агуу тунхаглалыг[331] ийн тунхаглав: 'Би: "Төгс Гэгээрлийн тал дээр Буддагаас илүү ихийг мэдсэн, илүү ихийг ухаарсан өөр хэн нэгэн даянч эсвэл брман, өнгөрсөн үед ч байгаагүй, ирээдүйд ч байхгүй, өнөө цагт ч байхгүй." хэмээн, би Буддад ийм л итгэл дүүрэн явдаг билээ.'

Гэхдээ, Эрхэм Саарипутта та, өнгөрсөн цагт Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда болсон хүмүүсийг ухан ойлгож, тэдгээр Будда нарын оюун санааг өөрийн оюун санаагаараа таньж мэдсэн юм уу? Түүнчлэн тэр Буддад, ийм сахил-ухамсар байсан уу, тэр Буддад, ийм сайн чанар байсан уу, тэр Буддад, ийм сарууул-ухаан байсан уу, тэр Буддад, ийм бясалгал амьдрал байсан уу, тэр Будда, ийм гэгээрэл ангижралд орсон болов уу гэх мэтээр?"

"Үгүй ээ. Эрхэм Багш аа."

"Тэгвэл Эрхэм Саарипутта та, ирээдүйн тэр нэгэн цагт Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда болох хүмүүсийг ухан ойлгож, тэдгээр Будда нарын оюун санааг өөрийн оюун санаагаараа шууд таньж мэдсэн юм уу? Түүнчлэн тэр Буддад ийм сахил-ухамсар байх уу, тэр Буддад, ийм сайн чанар байх уу, тэр Буддад, ийм сарууул-ухаан байх уу, тэр Буддад, ийм бясалгал амьдрал байх уу, тэр Будда, ийм гэгээрэл ангижралд орох болов уу гэх мэтээр?"

---

[328] *Nāḷandā*—"Наалaндаа". Наалaндаа бол Магадха (өнөөгийн Энэтхэгийн Бихар) хаант улсын хөгжил дэвшилтэй, нэр алдартай эртний хот юм.

[329] *Pāvārika*—"Паавaарика". Ноос, даавууны худалдаачин хүн. Паавaарика энэ өөрийн манго төглийг Хуврагийн Чуулганд хандивласан байна (DA).

[330] *Sāriputta*—"Саарипутта". Буддагийн шадар хувраг. Хувраггуудын дотроос сарууул ухаанаараа тэргүүн зэрэгт тооцогдох, Төгс Гэгээрсэн Арахант. Хувраг сахил авахаас өмнөх нэр нь *Upatissa* (Vin; MN 150). *Sāriputta* үгийн утга: "Саариигийн хүү ". *Sāri* бол түүний ээжийн нэр.

[331] *Sīhanādo nadito*—"агуу тунхаглалыг тунхаглав". Үгчилбэл, "арслангийн архиралтаар архирав".

“Үгүй ээ. Эрхэм Багш аа.”

“Тэгвэл Эрхэм Саарипутта та, өнөө цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда болсон намайг ухан ойлгож, энэ Буддагийн оюун санааг өөрийн оюун санаагаараа шууд таньж мэдэж байгаа юм уу? Түүнчлэн энэ Буддад ийм сахил-ухамсар байна уу, энэ Буддад, ийм сайн чанар байна уу, энэ Буддад, ийм саруул-ухаан байна уу, энэ Буддад, ийм бясалгал амьдрал байна уу, энэ Будда, ийм гэгээрэл ангижралд орсон байна уу гэх мэтээр?”

“Үгүй ээ. Эрхэм Багш аа.”

“Тэгэхээр Эрхэм Саарипутта та, өнгөрсөн цагт ч, ирээдүйд ч, одоо цаг дор ч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нарыг бүрэн ухаж ойлгоогүй. Буддагийн оюун санааг өөрийн оюун санаагаараа шууд таньж мэдээгүй. Тэгсэн хэрнээ та энэхүү агуу бөгөөд сүр жавхлантай үгийг хэллээ. Тов тодорхой, сайтар ойлгогдох, агуу тунхаглалыг ийн тунхаглав: ‘Би: “Төгс Гэгээрлийн тал дээр Буддагаас илүү ихийг мэдсэн, илүү ихийг ухаарсан өөр хэн нэгэн даянч эсвэл бярман, өнгөрсөн үед ч байгаагүй, ирээдүйд ч байхгүй, өнөө цагт ч байхгүй.” хэмээн, би Буддад ийм л итгэл дүүрэн явдаг.’ гэж яахан хэлж зүрхэлж байгаа билээ?” гэхэд,

“Эрхэм Багш аа, би эдгээр өнгөрсөн, ирээдүй, одоо цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нарын оюун санааг яг өөрийнхөө оюун санаагаараа бүрэн дүүрэн бөгөөд тов тодорхой, шууд таньж мэдээгүй ч гэсэн, миний хэлсэн зүйлүүд Сургаал номтой бол нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ.

Эрхэм Багш аа, хилийн зааг дээр байрлах, үндэс суурь сайтай, үлэмж сайн хамгаалагдсан хана хэрэмтэй, өргөгддөг дүүжин гарцтай, үүд болох ганц хаалгатай, харийн хүмүүсээс хамгаалдаг, өөрийн хүмүүсээ таньдаг, чадварлаг ухаалаг харуул хамгаалалттай, эзэн хаант улсын, тийм хот цайз байсан саная. Тэр цайзын харуул нь хотын цайз ханыг нэг бүрчлэн, бүхэлд нь тойрон яваад, муур ч орох зайгүй, ан цавгүй, ангархай нүх үгүйг хараад:

‘Ямар ч балмад адгуус энэ хот руу орлоо гарлаа гэхэд, гарцаагүй энэ ганц том үүдээр л орж гарах болно.’ хэмээн бодохтой адил билээ.

Яг л үүний нэгэн адилаар, Эрхэм Багш аа, ‘Өнгөрсөн цаг үеийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар таван-саадыг даваад, саруул-ухааныг доройтуулдаг оюуны-хорлолыг үгүй хийгээд, дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг дадуулаад, цаашилбал гэгээрлийг-амирлуулагч долоон хүчин зүйлийг хангасны үндсэн дээр төгс гэгээрлийг олсон.’ гэдэг Сургаал номтой нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ.

Яг л үүний нэгэн адил Эрхэм Багш аа, ‘Ирээдүй цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар таван-саадыг даваад, саруул-ухааныг доройтуулдаг оюуны-хорлолыг үгүй хийгээд, дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг дадуулаад, цаашилбал гэгээрлийг-амирлуулагч долоон хүчин зүйлийг хангасны үндсэн дээр төгс гэгээрлийг олох болно.’ гэдэг Сургаал номтойгоо мөн нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ.

Яг л үүний нэгэн адил Эрхэм Багш аа, ‘Өнөө цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда таван-саадыг даваад, саруул-ухааныг доройтуулдаг оюуны-хорлолыг үгүй хийгээд, дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг дадуулаад, цаашилбал гэгээрлийг-амирлуулагч долоон хүчин зүйлийг хангасны үндсэн дээр төгс гэгээрлийг олсон.’ гэдэг Сургаал номтой нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ.” хэмээн хэлэв.

(…)

Мөн тэр цагт Будда, Наалантаагийн ойролцоох Паавaарикагийн манго төгөлд амьдарч байхдаа хуврагууддаа, Сургаал номын талаар мөн үе үе ийн хэлдэг байв:

“Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ.”

5. Ухамсаргүй Байхуйн Үр-Дагавар (Dussīlaādīnava)

Дараа нь Будда, Наалантаагийн ойролцоо хангалттай удаан амьдарсны эцэст Эрхэм Аанандад хандан: “Алив Аананда, бүгдээрээ Паатали тосгон[332] руу явъя.” гэж хэлэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда Буддад хариулав. Тэгээд Будда Хуврагийн Чуулганы хамт Паатали тосгонд хүрэлцэн иржээ.

Паатали тосгоны эгэл ард олон: “Будда Паатали тосгонд ирсэн бололтой.” гэж дуулав. Дараа нь тэдгээр Паатали тосгоны хүмүүс Будда дээр хүрэлцэн очоод, түүн дээр ирж сөгдөн мөргөсний дараа, тэд нэг талдаа гаран сууцгаав. Паатали тосгоны хүмүүс нэг талд сууж байхдаа Буддад хандан:

“Эрхэм Багш аа, та манай зочдын амрах байранд саатан морилж ажаамуу.” гэлээ. Будда анир чимээгүй байдлаараа энэ урилгыг зөвшөөрлөө.

Дараа нь Паатали тосгоны эгэл ард олон Будда зөвшөөрснийг ойлгоод, суудлаасаа босож, Буддад мөргөөд, түүнийг баруун талаараа хэдэнтээ тойроод, тэнд байх амралтын байранд ирээд, тэр амралтын байранд бүхэлд нь хивс ширдэг дэлгэж, олбог суудлуудаа тараан байрлуулж, устай сав тавьж, тосон

[332] *Pāṭaligāma*—“Паатали тосгон”. Хожим нь Ашока хааны эзэнт гүрэн (*Mauryan*)-ий нийслэл болж Паатали Цайз (*Pāṭaliputta*) нэрийг авсан, өнөөгийн Энэтхэгийн Бихар мужийн нийслэл Патна (*Patna*).

дэнлүүгээ асаасны дараа, Будда дээр эргэж ирээд, түүнд ойртон очиж, сөгдөн мөргөсний дараа нэг талд гаран зогсов.

Паатали тосгоны хүмүүс нэг талд гаран зогссон байхдаа тэд Буддад ийн хэлэв:

"Амралтын байранд бүхэлд нь ширдэг дэвсгэр дэлгэж заслаа. Олбог суудал бэлдэж, устай сав тавьж, тосон дэнлүү асаав. Эрхэм Багш аа, та одоо өөрийн таалллаар болгооно уу." гэв.

Тэгээд өглөө нь Будда орхимжоо өмсөөд, гадуур орхимж, бадрын аягаа аваад, Хуврагийн Чуулганы хамтаар зочдын байранд ирцгээв. Тэрбээр хөлөө угаасны дараа зочдын байранд орж, зүүн зүг харсан төв баганын дэргэд суув. Хуврагийн Чуулган мөн хөлөө угааж, зочдын байранд орцгоож, баруун зүг харсан талд, Буддагийн өөдөөс харан суунцгаав. Паатали тосгоны ард иргэд ч мөн хөлөө угааж, зочдын байранд орцгоож, баруун зүг харсан зүүн хананд налж, мөн Буддагийн өөдөөс харан суунцгаалаа.

Ингээд Будда, Паатали тосгоны эгэл хүмүүст хандан:

"Хар хүмүүс ээ, ухамсар ёс суртахуунгүй хүнд, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүнд ийм таван аюул бий болно.

Ямар таван аюул бол?

1. Хар хүмүүс минь, ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүн хэнэггүй хайхрамжгүй байдлаасаа болж үлэмж их хөрөнгөө алдаж байдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүнд тохиох эхний аюул юм.

2. Цаашилбал, ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүн нэр нүүрээ алдаж байдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүнд тохиох хоёр дахь аюул юм.

3. Цаашилбал, ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүн ямар ч цуглаан уулзалтад очсон, язгууртны чуулган ч бай, бярман нарын чуулган ч бай, хар хүмүүсийн чуулга уулзалт ч бай, даянчдын чуулга уулзалт ч бай, тэр хүнд ичгүүртэй бөгөөд айдастай байх ба ингэж өөртөө итгэх итгэлээ алдаж байдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүнд тохиох гурав дахь аюул юм.

4. Цаашилбал, ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүн, үхэхийн цагт будлиж төөрсөн, явах очих зүгээ алдсан байдаг билээ.

Энэ бол ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүнд тохиох дөрөв дэх аюул юм.

5. Цаашилбал, ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүн, өөд болж бие цогцос нь задрах цагт, доод ертөнцөд, муу тавиланд, муухай газарт, тамд төрөл авдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүнд тохиох тав дахь аюул юм.

Энэ бүгд бол ухамсар ёс суртахуунгүй, ухамсар ёс суртахуунаа гээсэн хүнд тохиох таван аюул билээ.

6. Ухамсартай Байхуйн Өгөөж (Sīlavantaānisaṁsa)

Хар хүмүүс минь, ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүнд ийм таван үр өгөөж бий болно.

Ямар таван өгөөж бол?

1. Хар хүмүүс минь, ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүн туйлбартай байдал, хичээл зүтгэлийнхээ үрээр үлэмж их хөрөнгө олж байдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүнд тохиох эхний үр өгөөж юм.

2. Цаашилбал, ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүн нэр төрийг олж байдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүнд тохиох хоёр дахь үр өгөөж юм.

3. Цаашилбал, ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүн ямар ч цуглаан уулзалтад очсон, язгууртны чуулган ч бай, бярман нарын чуулган ч бай, хар хүмүүсийн чуулга уулзалт ч бай, даянчдын чуулга уулзалт ч бай, тэр хүнд айх айдас үгүй, өөртөө итгэх итгэл дүүрэн байдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүнд тохиох гурав дахь үр өгөөж юм.

4. Цаашилбал, ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүн үхэхийн цагт будлиж төөрсөн, очих газраа мэдэхгүй байдал түүнд огт үгүй юм.

Энэ бол ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүнд тохиох дөрөв дэх үр өгөөж юм.

5. Цаашилбал, ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүн өөд болж бие цогцос нь задрахын цагт, сайн сайхан газарт, тэнгэр диваажинд төрөл авдаг.

Энэ бол ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүнд тохиох тав дахь үр өгөөж юм.

Энэ бүгд бол ухамсар ёс суртахуунтай, ухамсар ёс суртахууныг дадуулсан хүнд тохиох таван үр өгөөж билээ.

7. Паатали Цайзыг Босгосон нь (Pāṭaliputtanagaramāpana)

Харин яг тэр үед Магадхагийн ерөнхий сайд Сунийдха болон Вассакаара нар важжий нартай дайтахын тулд Паатали тосгонд цайз барьж байв. Тэр үед мянга мянгаараа, асар олон бурхад, Паатали тосгоны тэр хавийн газар нутаг дээр эзэгнэн байсан аж.

Хүчирхэг бурхдын эзэгнэж байсан газарт нь дээд зиндааны захирагчид, эсвэл хааны сайд нар байр саваа барих санаатай байв.

Дунд зиндааны бурхдын эзэгнэж байсан газарт нь дунд зиндааны захирагчид, эсвэл дунд зиндааны сайд нар байр саваа барих санаатай байв.

Доогуур зиндааны бурхдын эзэгнэж байсан газарт нь доогуур зиндааны захирагчид, эсвэл доогуур зиндааны сайд нар байр саваа барих санаатай байв.

Будда, эгэл хүний боломжоос хальсан өөрийн тэнгэрлэг мэлмийгээрээ, мянга мянгаараа, асар олон бурхад Паатали тосгоны тэр газар нутгийг эзэгнэн байгааг нь харжээ. Дараа нь үүр цайх үеэр Будда суудлаасаа босож, Эрхэм Аанандад хандан:

"Аананда, Паатали тосгонд хэн цайз барьж байгаа юм бол?" гэхэд:

"Магадхагийн тэргүүн сайд Сунийдха, Вассакаара нар, Эрхэм Багш аа, важжий нартай дайтахын тулд Паатали тосгонд цайз барьж байна" гэв.

"Аананда, тэд Гучин Гурван Тэнгэрийн Орны[333] бурхадтай зөвлөлдчихөөд барьж байгаа мэт, Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нар важжий нартай дайтахын тулд Паатали тосгонд цайз барьж байх юм.

Аананда, би эгэл хүний боломжоос хальсан өөрийн тэнгэрлэг мэлмийгээрээ, мянга мянгаараа, асар олон бурхад Паатали тосгоны тэр газрыг эзэгнэн байгааг нь харсан билээ.

Хүчирхэг бурхдын эзэгнэж байсан газарт нь дээд зиндааны захирагчид, эсвэл хааны сайд нар байр саваа барих санаатай юм.

Дунд зиндааны бурхдын эзэгнэж байсан газарт нь дунд зиндааны захирагчид, эсвэл дунд зиндааны сайд нар байр саваа барих санаатай юм.

Доогуур зиндааны бурхдын эзэгнэж байсан газарт нь доогуур зиндааны захирагчид, эсвэл доогуур зиндааны сайд нар байр саваа барих санаатай юм.

Аананда, аричуудын[334] нөлөөллийн хүрээ тэлэх хэрээр, худалдаа наймаа өргөжихийн хирээр, энэ Паатали Цайз[335] зах худалдааны гол хот болох болно. Аананда, Паатали Цайзын хувьд: гал, ус, хагарал гэсэн гурван аюул тулгарах болно."

---

333 *Tāvatiṁsehi*—"Гучин Гурван Тэнгэрийн Орны". Бурхдын зургаан орны доороосоо хоёр дахь зиндаанд хамаарах орон. (Бүрэн жагсаалтыг Тайлбарын Будда хэсэгт үз.)

334 *Ariyaṁ*—"аричуудын". Өөрөөр, "Гэгээнтнүүдийн". B. Sujato үүнийг "соёлжиж иргэншсэн" гэж орчуулжээ (анг. *civilized*).

335 *Pāṭaliputtaṁ*—"Паатали Цайз". Судар энэ хэсгээс эхлэн Паатали тосгоныг "Паатали Цайз" гэж нэрлэж эхлэв.

Удалгүй Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нар Будда дээр ирэв. Ирснийхээ дараа Буддад мэнд дэвшүүлж, эелдэг яриа хөөрөө өрнүүлснийхээ дараа нэг талд гарч зогсов. Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нар Буддад хандан:

“Эрхэм Готама, та өнөөдөр Хуврагийн Чуулганы хамтаар бидэнтэй зоог барьж болох сон болов уу?” гэв. Будда тэдний урилгыг анир чимээгүй байдлаараа зөвшөөрөв.

Дараа нь Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нар Будда зөвшөөрснийг ойлгоод, өөрсдийн гэртээ, амт шимттэй хоол ундны дээжийг тусгайлан зэхэж, шинээр чанаж болгосон идээ зоогийг засаж бэлдэв. Тэгээд тэр өглөө тэд зоогийн цаг болоход ийн сонордуулав:

“Зоогийн цаг боллоо. Готама Багш аа, идээ унд бэлэн болов.”

Будда бүрэн орхимжоо өмсөөд, гадуур орхимж, бадрын аягаа аваад, Хуврагийн Чуулганы хамтаар Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нарын өргөө гэрт морилж, тараан бэлтгэсэн суудалд сууцгаалаа.

Ингээд Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нар, Буддад болон Хуврагийн Чуулганд амт шимттэй хоол ундны дээж, шинээр чанаж болгосон идээ зоогоо өөрсдийн гараараа ёслон барьж, сэтгэлд нь хүртэл үйлчлэв.

Будда идээ зоогоо өндөрлөөд, гар болон аягаа цэвэрлэж дуусахад, Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нар доогуур суудалд түүний дэргэд очин суув.

Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нарыг ийн суухад, Будда иймталархлын үгээр тэдний сонорыг мялаав:

“Гэр байшингаа барьж буй энэ газартаа
Гэгээн ариун хуврагуудыг урин зочиллоо
Гэвч Тэнгэр бурхдыг мөн баясан цэнгүүлж
Гэгээн хүндэтгэл, өргөл буяныг үйлдээрэй.

Ингэж гэмээ нь та бүгдийг,
Эх нь үрээ хайрлах адил
Эдгээр бурхад харж ивээж,
Энэрэл хайр үзүүлэх болно.” гэв.

Ингээд Будда, Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нарыг энэхүү үгээрээ мялаасныхаа дараа суудлаасаа босон гарч явжээ.

Тэгэхэд Магадхагийн тэргүүн сайд Сунийдха болон Вассакаара нар Буддагийн араас даган гарч явах зуураа: "Даянч Готамагийн гарч одсон тэр хаалгыг Готамагийн Хаалга[336], Ганга мөрнийг гаталсан тэр гармыг Готамагийн Гарам[337] гэж нэрлэнэ." хэмээн бодон явах аж.

Тэгээд дараа нь, тэрхүү орхин гарсан хаалга нь Готамагийн Хаалга нэртэй болов.

Харин дараа нь Будда Ганга мөрнийг гатлахаар тэнд дөхөж очив. Тэр үед Ганга мөрөн эргээ дүүртэл хальж, эрэг дээр нь хэрээ суугаад ус ууж болохоор хальж үерлэсэн байв. Хүмүүс нэг эргээс нөгөө эрэг рүү гарах гэж зарим нь завь хайж, зарим нь хөвөх юм хайж, зарим нь сал хийн суух аж. Тэгэхэд Будда, гартаа хүчтэй хэн нэгэн бээр гараа угз татахын адил огцом гэгч нь Ганга мөрний наад эргээс гэнэт алга болж, тэртээ цаад эрэг дээр Хуврагийн Чуулганыхаа хамт гэнэт гарч ирэв. Тэгээд Будда тэдгээр нэг эргээс нөгөө эрэг рүү гарах гэж зарим нь завь хайж, зарим нь хөвөх юм хайж, зарим нь сал хийн суугаа хүмүүсийг харав.

Ингээд Будда, энэхүү явдлын онцгой шинжийг анзааран хараад, өөрийн сэтгэлээ ийн илэрхийлэв:

> "Замагт ус, намагт газрыг гатлах хэрэгтэй хүмүүс
> Заавал гүүр барьж гэмээ нь түүнийг гаталж чадах.
> Завь, хөвүүр, сал зэргийг хүмүүс хийсээр суух ахуйд
> Замнал ухаарлыг олсон мэргэд хэдийнээ гаталсан байх."

Нэгдүгээр уншлага хэсэг өндөрлөв.

8. Гэгээнтний Үнэний Сургаал (Ariyasaccakathā)

Дараа нэгэн өдөр Будда, Эрхэм Аанандад хандан:

"Алив, Аананда, бүгдээрээ Коти[338] тосгон руу явцгаая." гэж хэлэв.

"За, Эрхэм Багш аа." гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

Тэгээд Будда томоохон Хуврагийн Чуулганы хамтаар Коти тосгонд хүрэлцэн ирцгээжээ. Ингээд Будда Коти тосгоны ойролцоо амьдрах болов.

Тэнд Будда хуврагуудад хандан өгүүлрүүн:

"Хуврагууд аа, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг нэвтэрхий ойлгоогүй, гүнзгий ухаараагүйн улмаас та ч, би ч, энэ үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөлөө.

Тэр дөрөв нь юу вэ?

---

[336] *Gotamadvāraṁ*—"Готамагийн Хаалга".

[337] *Gotamatitthaṁ*—"Готамагийн Гарам". Өнөөдөр яг энэ газарт "*Mahatma Gandhi Setu*" нэртэй 5.7 км урт гүүр баригдсан.

[338] *Koṭigāma*—"Коти тосгон". Ганга мөрнөөс холгүй орших жижиг тосгон.

1. Хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлонг нэвтэрхий ойлгоогүй, гүнзгий ухаараагүйн улмаас та ч, би ч, энэ үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөлөө.

2. Хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлонгийн шалтгааныг нэвтэрхий ойлгоогүй, гүнзгий ухаараагүйн улмаас та ч, би ч, энэ үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөлөө.

3. Хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлонгийн төгсгөлийг нэвтэрхий ойлгоогүй, гүнзгий ухаараагүйн улмаас та ч, би ч, энэ үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөлөө.

4. Хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлонгийн төгсгөлд хүргэх замналыг нэвтэрхий ойлгоогүй, гүнзгий ухаараагүйн улмаас та ч, би ч, энэ үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөлөө.

Харин одоо бол, Гэгээнтний Үнэний зовлонг нэвтэрхий ойлгож, гүнзгий ухаарлаа. Гэгээнтний Үнэний Зовлонгийн Шалтгааныг нэвтэрхий ойлгож, гүнзгий ухаарлаа. Гэгээнтний Үнэний Зовлонгийн Төгсгөлийг нэвтэрхий ойлгож, гүнзгий ухаарлаа. Гэгээнтний Үнэний Зовлонг Төгсгөх Замналыг нэвтэрхий ойлгож, гүнзгий ухаарлаа. Дараа төрөл авах хүсэл-цангаа зогсов. Оршихуйд хөтлөхүй устав. Цаашдын оршихуй гэж үгүй болов."

Будда ийн айлдав.

Тэгээд Будда үргэлжлүүлэн ийн хэлэв:

> "Энэ Гэгээнтний Дөрвөн Үнэний утгыг
> Ихэд гүнзгийгээр олж харахгүй байгаагаас
> Энэ үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр
> Энгүй их цаг хугацааг та бид тууллаа
>
> Эдгээр дөрвөн үнэнийг одоо олж харлаа
> Тэдгээр дахин төрөхүйн үндэс тасарлаа
> Ингээд зовлон зовуурийн шалтгаан нь устлаа
> Ирээдүйн оршихуй гэж үгүй боллоо."

Мөн тэр цагт, Будда Коти тосгонд амьдарч байхдаа хуврагууддаа, Сургаал номын талаар тэр үе үе ийн хэлдэг байв:

"Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ."

9. Хойд Дүрд Төрөхгүйгээр Төгс Гэгээрэх Тавилан (Anāvattidhammasambodhiparāyaṇa)

Дараа нэгэн өдөр Будда, Эрхэм Аанандад хандан:

"Алив, Ааананда, бүгдээрээ Наатика[339] руу явцгаая." гэж хэлэв.

"За, Эрхэм Багш аа." гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

Тэгээд Будда Хуврагийн Чуулганы хамтаар Наатикад хүрэлцэн ирцгээжээ. Ингээд Будда Наатикагийн ойролцоох Тоосгон Танхимд[340] амьдрах болов.

Тэр цагт, Эрхэм Аананда Будда дээр ирээд түүнд мөргөснийхөө дараа тэрээр нэг талд нь суув. Эрхэм Аананда хажуу талд нь сууж байхдаа Буддад хандан:

"Эрхэм ээ, Саалха нэртэй хувраг Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Нандаа нэртэй эмэгтэй хувраг Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Судатта нэртэй сахилтан хар хүн[341] Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Сужаатаа нэртэй сахилтан эмэгтэй Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Какудха нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Каалингаа нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Никата нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Катиссаха нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

---

339 *Nātika*—"Наатика". Раажагаха (*Rājagaha*) болон Весаалий (*Vesālī*) хоёрын хооронд байрлах жижиг тосгон. Мөн жижиг овог аймгийн нэр.

340 *Giñjakāvasathe*—"Тоосгон Танхимд". Тоосгоор барьсан сүм хийд, эсвэл хүндэтгэлийн өргөө.

341 *Upāsako*—"сахилтан хар хүн". Өөрөөр "сахилтан эрэгтэй шавь". Гэрээ орхиогүй хар хүн хэвээр боловч, Буддагийн шавь болж, тав болон түүнээс олон сахил сахиж, Сургаал, ариун амьдралыг эрхэмлэгч, сахилтан, эрэгтэй (*upāsakā*), эмэгтэй (*upāsikā*) шавь хүмүүс.

Эрхэм ээ, Туттха нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Сантуттха нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Бхадда нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?

Эрхэм ээ, Субхадда нэртэй сахилтан хар хүн Наатикад нас баржээ. Тэр хаашаа явсан бол? Түүний дараа төрөл нь юу байх вэ?" хэмээн асуулаа.

Тэгэхэд Будда[342]:

"Аананда, Саалха нэртэй хувраг, оюуны-хорлолыг үгүй хийснээр, оюуны-хорлол үгүй сэтгэлийн ангижрал, саруул-ухааны ангижралыг олж, энэ насандаа шууд-билгүүнээр өөрийн бие дээр ухаарч, тэр зэрэгт хүрч[343] амьдарсан билээ.

Аананда, эмэгтэй хувраг Нандаа, доод таван сэтгэлийн-хүлээсийг[344] бүрэн устгаснаар, энэ дэлхийд дахин хүний төрөл авалгүйгээр[345], тэнгэр бурхдын ертөнцөд дараа төрлийг олсон бөгөөд тэндээс Эцсийн Нирваанд одох болно.

Аананда, Судатта нэртэй сахилтан хар хүн, доод гурван сэтгэлийн-хүлээсийг бүрэн устгаж, түүний дур-хүсэл, уур-хилэн, төөрөгдөл[346] намжсанаар, Нэгэнтээ Эргэн Ирэгч[347] болсон бөгөөд энэ хорвоод дахин нэг удаа эргэн төрж, зовлон зүдүүрийг нэгэнт эцэс болгох болно.

---

342 Эртний Буддизмд, гэгээрлийн үндсэн дөрвөн зэрэг байна: 1. Урсгалд Орогч (*Sotāpanna*); 2. Нэгэнтээ Эргэн Ирэгч (*Sakadāgāmī*); 3. Эс Эргэн Ирэгч (*Anāgāmī*); 4. Төгс Гэгээнтэн (*Arahant*).

343 *Upasampajja*—"тэр зэрэгт хүрч". Энд Гэгээрлийг хэлсэн болно. Өөр утга: "дээд сахил авах" буюу энэ тохиолдолд, "дээд сахилтай амьдарсан" байж болно.

344 *Saṁyojana*—"сэтгэлийн-хүлээс". 1. өөрийн-оршихуйн үзэл (*sakkāyadiṭṭhi*); 2. эргэлзээ-тээнэгэлзээ (*vicikicchā*); 3. зан үйлд автахуй (*sīlabbata-parāmāsa*); 4. мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл (*kāmacchando*); 5. хар-санаа (*vyāpādo*); 6. Нарийн-биеийн Орны дур-хүсэл (*rūparāgo*); 7. Бие-бусын Орны дур-хүсэл (*arūparāgo*); 8. бардамнал (*māna*); 9. түгшүүр (*uddhacca*); 10. мунхаг-төөрөгдөл (*avijjā*). (Лавлахад бусад тайлбар үз.)

345 Энд "Эс Эргэн Ирэгч" (*Anāgāmī*) Гэгээрлийн зэрэгт хүрсэн хүний талаар ярьж байна. Тэд үхлийн дараа зөвхөн Ариун Оронд (*Suddhāvāsa*) төрөх ба дахин төрөл авдаггүй, тэндээ өөд болж төгс гэгээрлийг олдог гэж үзнэ. Ариун Орнууд нь Тайлбарт буй Тэнгэрийн таван (*Akaniṭṭha, Sudassī, Sudassā, Atappā, Avihā*) орон.

346 *Moha*—"төөрөгдөл". Мунхаг-төөрөгдлийн илрэл буюу тусгүй-муу үйлийг хийхэд гол шалтгаан нөхцөл болдог, сэтгэлийн гүний төөрсөн, андуурсан, сохорсон байдал. Арван сэтгэлийн-хирийн нэг болно.

347 *Sakadāgāmī*—"Нэгэнтээ Эргэн Ирэгч" Гэгээнтэн. Тэд үхлийн дараа зөвхөн хүмүүний эсвэл бурхны ертөнцөд, нэг л удаа дахин төрөх ба тэр амьдрал дуусаанаар төгс гэгээрлийг олдог гэж үзнэ.

Аананда, Сужаатаа нэртэй сахилтан эмэгтэй, доод гурван сэтгэлийн-хүлээсийг бүрэн устгаж, Урсгалд Орогч[348] болсон бөгөөд энэ хорвоогийн муу төрөлд дахин хэзээ ч төрөхгүй болж, төгс гэгээрлийг ирээдүйд олох хувь төөргийг олсон билээ.

Аананда, сахилтан хар хүмүүс болох Какудха, Каалингаа, Никата, Катиссаха, Туттха, Сантуттха, Бхадда, Субхадда нар, сэтгэлийн доод таван хүлээсийг бүрэн устгаснаар бурхдын ертөнцөд дараа төрлийг олсон Эс Эргэн Ирэгчид болсон бөгөөд энэ дэлхийд дахин хүний төрөл авахгүйгээр тэндээ төгс гэгээрлийг олцгоох болно.

Аананда, Наатикад өөд болсон тавь гаруй үнэнч сүсэгтэн шавь нар, сэтгэлийн доод таван хүлээсийг бүрэн устгаснаар бурхдын ертөнцөд дараа төрлийг олсон Эс Эргэн Ирэгчид болцгоосон бөгөөд энэ дэлхийд дахин хүний төрөл авахгүйгээр тэндээ төгс гэгээрлийг олцгоох болно.

Аананда, Наатикад өөд болсон ер гаруй шавь сахилтан нар, сэтгэлийн доод гурван хүлээсийг бүрэн устгаж, тэдний дур-хүсэл, уур-хилэн, төөрөгдөл багассанаар Нэгэнтээ Эргэн Ирэгчид болцгоосон бөгөөд энэ хорвоод дахин нэг л удаа эргэн төрж, зовлон зүдүүрийг нэгэнт эцэс болгож төгс гэгээрлийг олцгоох болно.

Аананда, Наатикад өөд болсон таван зуу гаруй шавь сахилтан нар сэтгэлийн доод гурван хүлээсийг бүрэн устгаж, Урсгалд Орогчид болсон бөгөөд энэ хорвоогийн муу төрөлд дахин хэзээ ч төрөхгүй болж, төгс гэгээрлийг ирээдүйд олох хувь төөргийг олцгоосон билээ.

10. Үнэнийг Тольдох Сургаал (Dhammādāsadhammapariyāya)

Гэвч Аананда, хүний төрлийг олоод нэгэн цагт үхэх болдог нь гайхах зүйл огт биш юм. Харин энэ хорвоод үхэл тохиолдох болгонд, Будда дээр хүрч ирээд энэ тухай асуугаад байвал, Аананда, энэ нь Буддад төвөгтэй байх болно.

Ийм болохоор, Аананда, би ‘Үнэнийг Тольдох Сургаал’ хэмээх энэ сургаалыг заая. Үгээр гэгээрсэн шавь[349] нар өөрийгөө тольдон үзээд ингэж тунхаглаж болох юм:

‘Би тамын оронд, сүнсний ертөнцөд болон амьтны савmember дараа төрөл олохыг нэгэнт зогсоосон. Би төөрсөн төрөлд, муу төрөлд, муухай газарт, доод ертөнцөд дараа төрөл олохыг нэгэнт зогсоосон билээ. Би бол Урсгалд Орогч болсон бөгөөд энэ хорвоогийн муу төрөлд дахин хэзээ ч төрөхгүй болж, төгс гэгээрлийг ирээдүйд олох хувь төөргийг олсон билээ.’ гэж.

Аананда, ‘Үнэнийг Тольдох Сургаал’ хэмээх энэхүү сургаалаар:

---

[348] *Sotāpanna*—“Урсгалд Орогч” Гэгээнтэн. Гэгээрлийн дөрвөн зэргийн эхний түвшин. Тэд үхлийн дараа хүмүүний төрлөөс доош муу төрлийг дахин хэзээ ч авахгүй. Ирээдүйн долоон төрөлдөө заавал амжиж төгс гэгээрлийг олно.

[349] *Ariyasāvako*—“гэгээрсэн шавь”. Үгчилбэл, “гэгээрсэн сонсогч”. Тухайн цагт сүсэгтнүүдэд Сургаалыг амаар ярьж өгөх ганц хэлбэрээр заадаг байсан тул шавь нарыг сонсогч гэж нэрлэдэг байж (Орч).

'Би тамын оронд, сүнсний ертөнцөд болон амьтны саванд дараа төрөл олохыг нэгэнт зогсоосон. Би төөрсөн төрөлд, муу төрөлд, муухай газарт, доод ертөнцөд дараа төрөл олохыг нэгэнт зогсоосон билээ. Би бол Урсгалд Орогч болсон бөгөөд энэ хорвоогийн муу төрөлд дахин хэзээ ч төрөхгүй болж, төгс гэгээрлийг ирээдүйд олох хувь төөргийг олсон билээ.' хэмээн ямар шавь өөрийгөө ийн тунхаглан хэлж болох вэ?

Тэр гэгээрсэн шавь хүмүүн, Буддад итгэх итгэлийг өөрийн биеэр мэдэж олсон[350] байх учиртай: 'Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда, саруул ухаан хийгээд сахил ёсыг оршоосон, Зөвөөр Одогч, Хорвоог Ухаарагч, Эгнэшгүй Нэгэн, Ухаарах Учиртайг Ухааруулах Сургагч, Бурхад Хийгээд Хүмүүсийн Багш, Сэрсэн Нэгэн, Ерөөлтэй Нэгэн, энэхүү Тийн Одогч энэ хорвоод төржээ.' гэж.

Мөн Аананда,

Тэр гэгээрсэн шавь хүмүүн, Буддагийн заасан Сургаалд итгэх итгэлийг өөрийн биеэр мэдэж олсон байх учиртай:

'Будда энэхүү Сургаалыг, энэ насанд үр өгөөж нь гарахуйц, аль ч цаг үед хамаарахуйц, өөрөө нягтлан үзэхэд урин дуудсан, ухаалаг хүмүүс өөр дээрээ таньж мэдэж авах боломжтойгоор, сайтар зааж тайлбарласан сургаал юм.' гэж.

Мөн Аананда,

Тэр гэгээрсэн шавь хүмүүн, Чуулганд итгэх итгэлийг өөрийн биеэр мэдэж олсон байх учиртай:

'Буддагийн шавь нарын чуулганы[351] ном бясалгал нь зөв сайн,
Буддагийн шавь нарын чуулганы ном бясалгал нь эгц шулуун,
Буддагийн шавь нарын чуулганы ном бясалгал нь нарийн аргачлал, дараалалтай,
Буддагийн шавь нарын чуулганы ном бясалгал нь үр дүнтэй, бодитой юм байна. Эдгээр хүмүүс бол, дөрвөн хос түвшин буюу, найман түвшний гэгээрсэн хүмүүсээс[352] бүрддэг. Буддагийн эдгээр шавь нар бол өргөл барьц, зочлол хүндлэл, бэлэг сэлт, соёрхол мэндчилгээг хүртэх, авах эрхтэй бөгөөд тэдэнд хийх буян бол энэ хорвоогийн хамгийн дээд буян болдог.' гэж.

---

350 *Aveccappasādena*—"итгэлийг өөрийн биеэр мэдэж олсон". "Өөрийн биеэр" гэдэг нь *avecca* буюу үгчилбэл, "өөрт нь яг учран тохиосон" гэсэн утгатай. "Өөрийн биеэр мэдэж олсон итгэл" бол чухам яг өөрөө таньсан Гэгээрсэн хүний итгэл юм. Сургаалыг дагаснаар Гэгээрэл өөрт нь яг учран тохиосон болохоор энэ шавь хүн Буддад итгэх итгэлийг яг өөр дээрээ мэдсэн болно. Энэ нь эгэл жирийн сүсэгтэн хүний Буддад итгэх итгэлээс илтэд гүнзгий түвшин.

351 *Sāvakasaṅgho*—"шавь нарын чуулган". Хуврагийн Чуулган (*bhikkhusaṅgha*)-аас ялгаатай нь энд Буддаг дагагч, гэгээрсэн шавь нарыг хэлжээ. (Тайлбарт Хуврагийн Чуулган хэсгийг үз.)

352 *Cattāri purisayugāni aṭṭha purisapuggalā*—"дөрвөн хос түвшин буюу найман түвшний гэгээрсэн хүмүүс". Өмнөх зүүлт тайлбарт дурдсан дөрвөн Гэгээрлийн дөрвөн зэрэг нь тус бүрийн "хагас" түвшинтэй бөгөөд тэр утгаараа энд найман түвшин гэсэн болно. Жишээлбэл, Урсгалд Орогч (*Sotāpanna*) зэрэг нь Бага Урсгалд Орогч (*Cūḷa Sotāpanna*) хагас түвшинтэй гэж тайлбарлах юм уу эсвэл арай өөрөөр үүнийг замналд орох (*magga*) болон гэгээрэх (*phala*) гэсэн хоёр түвшин болгож салгаснаар Гэгээрлийн дөрвөн зэрэг нь Гэгээрлийн найман түвшин болж тоологдох аргачлал бий.

Тэр гэгээрсэн шавь хүмүүний сахил-ухамсар нь алдаа зөрчил үгүй, зай завсарлага үгүй, хир үгүй, сэв толбо үгүй, ангижран гэгээрүүлэх, мэргэдээр магтуулах, аливаад автаагүй, самади-төвлөрөл, даянд оруулахуйц байх учиртай.

Үүгээр, Аананда, гэгээрсэн шавь өөрийгөө тольдон үзээд:

‘Би тамын оронд, сүнсний ертөнцөд болон амьтны саванд дараа төрөл олохыг нэгэнт зогсоосон. Би төөрсөн төрөлд, муу төрөлд, муухай газарт, доод ертөнцөд дараа төрөл олохыг нэгэнт зогсоосон билээ. Би бол Урсгалд Орогч болсон бөгөөд энэ хорвоогийн муу төрөлд дахин хэзээ ч төрөхгүй болж, төгс гэгээрлийг ирээдүйд олох хувь төөргийг олсон билээ.’ гэж тунхаглан хэлж болох тэрхүү ‘Үнэнийг Тольдох Сургаал’ нь энэ билээ.” хэмээн Будда хэлэв.

Мөн тэр цагт, Будда Наатикад, Тоосгон Танхимд амьдарч байхдаа хуврагууддаа, Сургаал номын талаар мөн үе үе ийн хэлдэг байв:

“Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ.”

(...)

Дараа нэгэн өдөр Будда, Наатикад хангалттай амьдарсны эцэст, Эрхэм Аанандад хандан: “Алив, Аананда, бүгдээрээ Весаалий руу явцгаая” гэж хэлэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

Ингээд Будда томоохон Хуврагийн Чуулганы хамтаар Весаалийд хүрэлцэн ирцгээжээ. Тэгээд Будда Весаалийгийн ойролцоо Амбапаалийгийн[353] манго төгөлд амьдрах болов.

Тэр үед Будда хуврагуудад хандан[354]:

“‘Хувраг хүн, дүүрэн-анхаарал тунгалаг-оюунтай амьдрах учиртай билээ.’ гэж би та нарт зөвлөн хэлдэг билээ. Хуврагууд аа, хувраг хүн хэрхэн дүүрэн-анхаарлыг суулгадаг бол?

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, бие дээр биеийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

---

[353] *Ambapālī*—“Амбапаалий”. Весаалийгийн иргэн, чинээлэг, эелдэг, өглөгчөөрөө алдартай энэ эмэгтэй Буддагийн шавь болсон ба хожим нь төгс гэгээрлийг олж Арахант болсон Гэгээнтэн.

[354] Энэ хэсэгт гарах нэр томьёоны тайлбар DN 2, DN 22-т бий.

Хуврaг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хуврaг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хуврaг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, Үзэгдэл дээр, Үзэгдлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Ингэж, хуврагууд аа, хуврaг хүн дүүрэн-анхаарлыг суулгадаг билээ.

Тэгвэл хуврагууд аа, хуврaг хүн хэрхэн тунгалаг-оюуныг суулгадаг бол?

Энэ тал дээр хуврагууд аа, хуврaг хүн урагш алхсан ч, ухарч явсан ч тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Урагшаа харсан ч, хойшоо харсан ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Үе мөчөө нугалсан ч, тэнийлгэсэн ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Орхимжоо өмссөн ч, бадрын аягаа барин алхаж явсан ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Идэхдээ ч, уухдаа ч, зажлахдаа ч, амтлахдаа ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Хүндээр бие засахдаа ч, хөнгөнөөр бие засахдаа ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Явахдаа ч, зогсохдоо ч, суухдаа ч, унтахдаа ч, сэрүүн байхдаа ч, ярихдаа ч, яриагүй байхдаа ч, тэрбээр энэ бүгдийг тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ.

Ингэж, хуврагууд аа, хуврaг хүн тунгалаг-оюуныг суулгадаг билээ.

Хуврaг хүн, дүүрэн-анхаарал тунгалаг-оюунтай оршино гэж, үүнийг би та бүгдэд зааж хэлэх болно.

11. Эелдэг Эмэгтэй Амбапаалий (Ambapālīgaṇikā)

Тэр цагт, эелдэг эмэгтэй Амбапаалий, ‘Будда, Весаалийд хүрэлцэн ирээд, Весаалийгийн ойролцоох, түүний эзэмшил газар болох манго төгөлд нь амьдарч байгаа бололтой.’ хэмээн дуулав.

Тэгээд тэрхүү эелдэг Амбапаалий, олон тооны чамин тансаг сүйх тэргийг бэлтгүүлж, тэдгээр чамин тансаг сүйх тэргэндээ суугаад Весаалийгаас хөдөлж, сүйх тэрэг туулж хүрч чадах газарт хүрээд, сүйх тэрэгнээсээ бууж явган явсаар Буддагийн байгаа газар явж хүрэв. Буддад дөхөж очоод, түүнд мөргөснийхөө дараа тэрээр түүний нэг талд гаран суулаа. Эелдэг Амбапаалий түүний нэг талд сууж байхад, Будда түүнд Сургаал номыг тайлбарлан ярьж өгч, түүнд зааж сурган, сэнхрүүлэн ухааруулж, урам зориг өгч, ухаарал хайрлав.

Эелдэг Амбапаалий Буддагаас Сургаал Номын тухай сонсож, түүнээс суран, сэнхрэн ухаарч, урам зориг орон, ухаарлыг олсны дараа, Буддад хандан: “Эрхэм ээ, маргааш өглөө та, Хуврагийн Чуулганы хамтаар миний өргөн барих унд зоогт хүрэлцэн ирнэ үү.” гэв.

Будда анир чимээгүй байдлаараа урилгыг зөвшөөрөв. Дараа нь эелдэг Амбапаалий Будда зөвшөөрснийг ойлгоод, суудлаасаа босож, түүнд мөргөөд, түүнийг баруун талаараа хүндэтгэлтэйгээр хэдэнтээ тойрсны дараа гарч явав.

Весаалийгийн личчхавийчууд[355], 'Будда, Весаалийд хүрэлцэн ирж, Весаалийгийн ойролцоох, Амбапаалийгийн манго төгөлд амьдарч байгаа бололтой.' гэж сонсов.

Тэгээд тэдгээр личчхавийчууд олон тооны чамин тансаг сүйх тэргийг бэлтгэж, тэдгээр чамин тансаг сүйх тэргэндээ сууцгаагаад Весаалийгаас хөдөлцгөөв. Личчхавийчуудын зарим нь хөх өнгөтэй, ерөнхийдөө хөх өнгөнөөс бүрдсэн, хөх өнгийн чимэглэлтэй, хөх өнгийн хувцас өмссөн байх аж. Харин личчхавийчуудын зарим нь шар өнгөтэй, ерөнхийдөө шар өнгөнөөс бүрдсэн, шар өнгийн чимэглэлтэй, шар өнгийн хувцас өмссөн байх аж. Мөн зарим личчхавийчууд улаан өнгөтэй, ерөнхийдөө улаан өнгөнөөс бүрдсэн, улаан өнгийн чимэглэлтэй, улаан өнгийн хувцас өмссөн байх аж. Түүнчлэн зарим личчхавийчууд нь цагаан өнгөтэй, ерөнхийдөө цагаан өнгөнөөс бүрдсэн, цагаан өнгийн чимэглэлтэй, цагаан өнгийн хувцас өмссөн байх аж.

Тэгтэл тэр үед, эелдэг Амбапаалийгийн сүйх тэрэг личчхавийгийн залуусын сүйх тэрэгтэй, тэнхлэг нь тэнхлэгээрээ, дугуй нь дугуйгаараа, буулга нь буулгаараа тулж зогсов. Тэгэхэд тэдгээр личчхавий нар эелдэг Амбапаалийд ингэж хэлэв:

"Амбапаалий хүүхэн[356] минь, чи яахаараа личчхавийгийн залуучуудтай, тэнхлэг нь тэнхлэгээрээ, дугуй нь дугуйгаараа, буулга нь буулгаараа, ингэж тулж мөргөлддөг билээ?" гэхэд:

"Учир юу гэвэл, эрхэм ноёд оо, би Буддаг Хуврагийн Чуулганы хамтаар маргааш зоогт уриад, яарч яваа юм." гэхэд,

"Амбапаалий, энэ хоол хүнсээ бидэнд зуун мянган зоосоор өгчих." гэв.

"Эрхэм ноёд оо, та бүгд Весаалийг, Весаалийгийн бүх татвар орлоготой нь надад өгсөн ч, би та бүгдэд энэ хоол ундаа өгөхгүй ээ." гэв.

Тэгэхэд личчхавийчууд гараа савчих зуураа, 'Бид нэг муу эгчид[357] ялагдсан болж таарлаа. Бид нэг муу эгчид ялагдчихлаа шив.' гэж хэлэх аж.

Тэгээд личчхавийчууд Амбапаалийгийн манго төгөл рүү явж орцгоов. Будда тэдгээр личчхавий нарыг холоос ирж буйг хараад, хуврагуудад хандан:

"Гучин Гурван Тэнгэрийн Орны бурхдыг харж байгаагүй хуврагууд аа, личчхавийгийн цувааг харна уу! Хуврагууд аа, личчхавийгийн цувааг Гучин Гурван Тэнгэрийн Орны бурхадтай яг адилхан байгааг нь харна уу!" гэв.

---

355 *Licchavī*—"личчхавий". Эртний Весаалий хотод амьдарч байсан язгууртан (па. *Khattiya*) ангийн дайчин омгийнхон.

356 *Je ambapāli*—"Амбапаалий хүүхэн". Доромж байдлаар эмэгтэй хүнийг дуудсан үгийг ингэж оруулав.

357 *Ambakāyā*—"нэг муу эгч". Эсвэл "авгай". Мөн нас зүсээр нь доромж байдлаар дуудсан үгийг ингэж оруулав.

Ингээд личчхавийчууд сүйх тэрэг явж туулж чадах газрыг явж туулж бараад, сүйх тэрэгнээсээ буусны дараа явган явсаар Будда дээр ойртож очоод, түүнд мөргөснийхөө дараа тэд нэг талд гаран суув. Личчхавий нарыг түүний нэг талд сууж байхад, Будда тэдэнд Сургаал номын тухай ярьж, тэдэнд зааж сурган, сэргээн бадрааж, урам зориг өгч, тэдэнд ухаарал хайрлав.

Личчхавий нар Буддагаас Сургаал номын тухай сонсож, түүнээс суран, сэргэн бадарч, урам зориг орон, ухаарал аваад, Буддад хандан:

“Эрхэм ээ, маргааш өглөө та Хуврагийн Чуулганыхаа хамтаар бидний өргөн барих унд зоогт хүрэлцэн ирнэ үү.” хэмээхэд:

“Маргааш элдэг Амбапаалийгийн хоолны урилгыг би аль хэдийн зөвшөөрчихсөн билээ.” гэв.

Тэгэхэд, личчхавийчууд гараа савчих зуураа, ‘Бид нэг муу эгчид ялагдсан болж таарлаа. Бид нэг муу эгчид ялагдчихлаа шив.’ гэж хэлэх аж.

Дараа нь личчхавийчууд Буддагийн зааж сургасан ном Сургаалд талархан, баяртай хүлээн авсны дараа суудлаасаа босоцгоож, Буддад мөргөж, түүнийг баруун талаараа хүндэтгэлтэйгээр хэдэнтээ тойроод гарч одов.

Элдэг Амбапаалий тэр шөнө өнгөрсний дараа, өөрийн цэцэрлэгт хүрээлэндээ амт шимттэй хоол ундны дээжийг тусгайлан зэхэж, шинээр чанаж болгосон идээ зоогийг засаж бэлдэв. Тэгээд тэр өглөө тэд зоогийн цаг болоход ийн сонордуулав:

“Зоогийн цаг боллоо. Готама Багш аа, идээ унд бэлэн болов.” гэв.

Будда орхимжоо өмсөн, бадрын аягаа аваад Хуврагийн Чуулганы хамтаар элдэг Амбапаалийгийн өргөө гэрт морилж, тараан бэлтгэсэн суудалд сууцгаалаа.

Дараа нь элдэг Амбапаалий, Буддад болон Хуврагийн чуулганд амт шимттэй хоол ундны дээж, шинээр чанаж болгосон идээ зоогоо өөрийн гараараа ёслон барьж, сэтгэлд нь хүртэл үйлчлэв.

Будда идээ зоогоо өндөрлөөд, гар болон аягаа цэвэрлэж дуусахад, элдэг Амбапаалий доогуур суудалд түүний дэргэд очин суув. Нэг талд сууж байхдаа элдэг Амбапаалий Буддад ингэж хэлэв:

“Эрхэм Багш аа, би энэ төглөө[358] Хуврагийн Чуулганд өргөн хандивлаж байна.” гэж хэллээ.

Будда түүний энэ төглийг хүлээн зөвшөөрөв. Дараа нь Элдэг Амбапаалий Буддагаас Сургаал ном сонсож, түүнээс сурч, сэргэн бадарч, урам зориг орон, ухаарал авсны дараа тэндээс явлаа.

Мөн тэр цагт, Будда энэ Весаалийгийн ойролцоо амьдарч байхдаа хуврагуудаа, Сургаал номын талаар үе үе ийн хэлдэг байв:

---

[358] *Ārāmaṁ*—“төглөө”. Будда болон хуврагуудын байрлаж байгаа Амбапаалийгийн манго төгөл.

"Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ."

12. Велува Дахь Борооны Улирлын Бясалгал (Veḷuvagāmavassūpagamana)

Дараа нэгэн өдөр Будда, Амбапаалийгийн төгөлд хангалттай амьдарсны эцэст, Эрхэм Аанандад хандан:

"Алив, Ааананда, бүгдээрээ Велува[359] тосгон руу явцгаая." гэж хэлэв.

"За, Эрхэм Багш аа." гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

Тэгээд Будда Хуврагийн Чуулганы хамт Велува гэх бяцхан тосгонд хүрэлцэн ирцгээжээ. Ингээд Будда Велува гэх бяцхан тосгоны ойролцоо амьдрах болов.

Тэр үед Будда хуврагуудад хандан:

"Хуврагууд аа, та бүгд яваад Весаалийгийн ойр хавьд очоод, тэдэнтэй яг л найз нөхөд шиг нь, хамтран зүтгэгчид шиг нь, анд найзууд шиг нь, тэнд амьдарч борооны улирлын бясалгал[360] номдоо хамрагдаарай. Би борооны улирлын бясалгалыг яг энд, Велува бяцхан тосгонд өнгөрүүлэх болно." гэж хэлэв.

"Тэгье ээ, Эрхэм Багш аа." гэж тэдгээр хуврагууд Буддад хариулсны дараа Весаалийгийн ойр хавьд очоод, тэдэнтэй яг л найз нөхөд шиг нь, хамтран зүтгэгчид шиг нь, анд найзууд шиг нь, амьдран сууж, борооны улирлын бясалгал номдоо хамрагдав. Харин Будда борооны улирлын бясалгалаа яг тэнд, Велува хэмээх бяцхан тосгонд өнгөрөөлөө.

Гэтэл борооны улирлын бясалгалаа үйлдэн амьдрах зуур Будда хүнд өвчин тусч, айхавтар өвдөлтийг мэдэрч, үхлийн ирмэгт очив. Гэвч Будда санаа зовнилгүйгээр, дүүрэн-анхаарал тунгалаг-оюунаар үүнийг давж туулав.

---

[359] *Veḷuvagāmako*—"Велува" тосгон. Эсвэл "Белува". Весаалийгийн ойр байрлах жижиг тосгон.

[360] *Vassaṁ*—"борооны улирлын бясалгал". Буддагийн шавь болсон хувраг хүн, жил бүр 3 сарын турш нэг хийдэд, элдэв шилжилт хөдөлгөөн хийлгүй тогтвортой амьдарч, бясалгал хийн суудаг эртний уламжлалтай. Борооны улирлын бясалгал буюу *vassa* нь ойролцоогоор 7-10 сарын хооронд тохионо. Тиймээс *vassa* нь хувраг сахил сахисан нийт хугацаагаа (жилээ) тоолох нэршил болдог. (жишээлбэл, 10 жилийн өмнө хувраг сахил авсан хүн өнөөдөр 10 *vassa*-тай болно.) Иймээс *vassa* нь мөн цол эрэмбийн хэрэглүүр болно.

Тэгээд Будда:

‘Би намайг дэмжигч, намайг дагагч шавь нартаа мэдэгдэлгүйгээр, Хуврагийн Чуулгандаа мэдэгдэлгүйгээр, эцсийн замдаа Нирваанд одвол, энэ нь тун зохимжгүй хэрэг болох юм. Энэ зовлон зүдүүрийг эрч хүчтэйгээр даван туулаад, биеийн байдлаа тогтворжуулаад, лавтайяа үргэлжлүүлэн амьдарч болох биш үү?’ гэсэн бодол орж иржээ.

Ингээд Будда тэр зовлон зүдүүрийг эрч хүчтэйгээр давж гараад, биеийн байдлаа тогтворжуулаад, үргэлжлүүлэн амьдрав.

Буддагийн өвчин зовлон дарагдав. Тэр өвчнөөсөө эдгээд боссоныхоо дараа, суудаг байрнаасаа гарч ирэн, өөрт нь дэлгэн бэлдсэн суудалд суулаа.

Тэгэхэд нь, Эрхэм Аананда Буддад ойртож очоод, түүнд мөргөснийхөө дараа тэрээр нэг талд нь суув. Эрхэм Аананда нэг талд нь сууж байхдаа Буддад хандан:

“Буддаг энх тунх байгааг харах юутай сайхан юм. Буддаг эдгэсэн байгааг харах юутай сайхан юм. Учир нь Будда таныг өвдсөн байхад, миний бие ч мөн адил согтож хордсон мэт болж тун хэцүү байлаа. Эрхэм ээ, би зүг чигээ ч мэдэхгүй болж, Сургаалыг ч тунгалаг нүдээр харж чадахгүй болж байлаа. Гагцхүү надад Будда арай Хуврагийн Чуулгандаа хэлэлгүйгээр эцсийн замдаа, Нирваанд одчихгүй байх гэсэн итгэл минь л намайг бага зэрэг тайвшруулж байлаа.” гэхэд:

“Тэгвэл Аананда, Хуврагийн Чуулган надаас юу хүсэж хүлээж байгаа юм бол? Аананда, Би ямар нэг нууц Сургаал[361] болон олон нийтэд зориулсан Сургаал гэсэн ялгаатай байдалгүйгээр Сургаалыг заасан билээ. Тийн Одогч[362] нэгэнд, Сургаал номыг зангидсан гартаа нууж атгахтай адил арга барил гэж үгүй билээ.

Аананда, хэрэв хэн нэгэн:

‘Би Хуврагийн Чуулганыг удирдах учиртай.’ эсвэл ‘Хуврагийн Чуулган бол миний удирдлагад байх учиртай.’ гэж бодон Хуврагийн Чуулганы талаар ярьж болох юм.

Гэвч Будда миний хувьд,

‘Хэн нэгэн Хуврагийн Чуулганыг удирдах учиртай.’ эсвэл ‘Хуврагийн Чуулган бол хэн нэгний удирдлагад байх учиртай.’ гэж үзэхгүй байна.[363] Хуврагийн Чуулганы тухайд яагаад ямар нэг зүйлийг сөхөх учиртай гэж?

---

361 *Dhammo anantaraṁ*—“нууц Сургаал”. B. Sujato тайлбартаа, “Нууц сургаал заадаг орчин үеийн зарим буддын урсгалын ном энэ зарчимтай нийцэхгүй байна.” гэсэн бол M. Walshe, “Энэ бол, Буддын номыг үүсгэгч нь өөрөө, ямар нэг ‘нууцлаг’ (анг. *esoteric*) сургаал байхгүй гэдгийг онцгойлон хэлсэн алдартай үг нь юм.” гэжээ. Энэ утгаараа элдэв “нууц” судар, сургаалууд бол Буддагийн заасан Сургаал мөн эсэх нь тун эргэлзээтэй болох юм.

362 Энэ судартＩ, Будда *Tathāgata*-г III бие дээр ярих хэсгүүдийг бүгдийг “Тийн Одогч” нэршлээр нь хэрэглэв.

363 Энэ утгаараа Буддагийн үүсгэсэн буддын ёсонд, энэ уламжлалыг удирдагч хэн нэг хүн, толгойлогч лам хуврag, эсвэл шашны тэргүүн гэсэн ойлголт байх үндэслэлгүй болох юм.

Би, Аананда, өнөөдөр, их насыг элээсэн, өндөр насыг зооглосон, нас сүүдэр талийж, наян настай болсон байна. Аананда, хулсаар бэхлэн байж л хөдөлдөг, хуучин тэрэгтэй адилхан, Будда миний бие ч мөн адил, хулсаар бэхэлж л байж хөдөлдөг болж гэж харж байна.

Аананда, Би юмсын ямарваа шинж чанарт огтоос анхаарал тавихгүй байх үед л, бүх мэдрэмжүүд алга болсон тэр үед л, огт шинж чанаргүй оюуны самади-төвлөрөлд орох ба, тэр үедээ л Аананда, Буддагийн бие арай тохь тухтай болдог билээ.

Тийм болохоор Аананда, өөрөө өөрийнхөө аврал[364] болж, өөрөө арал[365] шиг оршиж, өөр авралгүйгээр, Сургаалыг арлаа болгож, Сургаалыг авралаа болгож, өөр авралгүй оршоорой.

Аананда, хувраг хүн хэрхэн өөрөө өөрийнхөө аврал болж, өөрөө арал шиг оршиж, өөр авралгүйгээр, Сургаалыг арлаа болгож, Сургаалыг авралаа болгож, өөр авралгүй орших вэ?

Үүн дээр Аананда, хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, бие дээр биеийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Ингэж Аананда, хувраг хүн өөрөө өөрийнхөө аврал болж, өөрөө арал шиг оршиж, өөр авралгүйгээр, Сургаалыг арлаа болгож, Сургаалыг авралаа болгож, өөр авралгүй оршино.

Аананда, одоо цагт ч бай, намайг өнгөрсний дараа ч бай хамаагүй, өөрөө өөрийнхөө аврал болж, өөрөө арал шиг оршиж, өөр авралгүйгээр, Сургаалыг арлаа болгож, Сургаалыг авралаа болгож, өөр авралгүй оршдог, сахил дадалдаа дуртай тэдгээр миний хуврагууд, шилдгийн шилдэг нь болох болно.”

Хоёрдугаар уншлага хэсэг өндөрлөв.

---

364 *Saraṇā*—“аврал”. Эсвэл “хоргодох газар”, “аврагдах газар”.

365 *Dīpa*—“арал”. Энэ паали үг нь “арал, эх газар” болон “гэрэл, гэгээ” гэх хоёр утгатай авч судартʻаралʼ гэсэн утгаар орсон гэж Эртний Буддизмд үзнэ. Энэ зовлонт хорвоог далайтай зүйрлэж, харин арлыг аврагдах газар гэсэн утгаар хэрэглэсэн гэж тайлбарладаг. Дуудлага ижил энэ хоёр үгийг самгарди хувилбарыг барин “гэрэл, дэнлүү” гэж орчуулах тал байна. (сам. *dīpa*—гэрэл; *dvīpa*—арал) Хоёр хувилбарын аль ч утгаар нь авч үзсэн Сургаалын үндсэн утгаас гажихгүй юм.

13. Илт Санаа Өгсөн нь (Nimittobhāsakathā)

Дараа нь тэр өглөө, Будда орхимжоо өмсөөд, бадрын аягаа аваад, Весаалий руу бадар барихаар гарав. Весаалийд бадар барин явж, түүгээр олдсон хоолоо идээд өглөгийн газраас буцаж ирээд, Эрхэм Аанандад хандан:

“Суух олбог дэвсгэрээ ав, Аананда, бид Каапаала[366] шүтээний газар очиж, энэ өдрийг тэнд өнгөрөөх болно.” гэж хэлэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда Буддад хариулаад, суух дэвсгэрээ аваад Буддагийн араас даган явав.

Ингээд Будда Каапаала дээр очоод, ойртож ирснийхээ дараа бэлтгэсэн суудалд сууж, мөн Эрхэм Аананда Буддад мөргөснийхөө дараа түүний нэг талд гаран суув. Будда, Эрхэм Аанандад ингэж хэлэв:

“Аананда, бишрэм сайхан газар бол Весаалий, бишрэм сайхан газар бол Удена, бишрэм сайхан газар бол Готамака, бишрэм сайхан газар бол Саттамба, бишрэм сайхан газар бол Бахупутта, бишрэм сайхан газар бол Саарандада, бишрэм сайхан газар бол Каапаала юм.

Аананда, ид-чадлын дөрвөн үндсийг[367] дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн хүн, хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг[368] дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой байдаг.

Аананда, Тийн Одогч бээр, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн билээ. Хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой юм.” гэв.

Харин Эрхэм Аананда, Буддаг иим давхар санааг дэвшүүлж, тийм илтэд санааг өгсөөр атал түүнийг нь ухаж ойлгож чадаагүй бөгөөд Буддагаас ингэж гуйж болох байв:

“Эрхэм Багш минь, Будда та эндээ оршин байх болтугай. Амьдралын нэгэн мөчлөгөө дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдарч, олон хүний тусын тулд, олон хүний аз жаргалын төлөө, ертөнцийг энэрэн нигүүлсэж, бурхад болон хүмүүсийн сайн сайхан хийгээд ашиг тус, аз жаргалын төлөө үлдэх болтугай.” Гэвч Аананда тэрхэн мөчид тэгээгүй бөгөөд Маара чөтгөр түүний оюун санааг эзэмдсэн байв уу гэхээр[369] байжээ.

---

[366] *Cāpāla Cetiya*—“Каапаала” шүтээний газар. Эртний хот Весаалийгаас холгүй орших ариун дагшин шүтээний газар.

[367] *Iddhipādā*—“ид-чадлын дөрвөн үндэс”. Эсвэл “ер бусын ид чадал”, “оюуны ид хүч”, “ид шид”. (“ид-чадал”-ын тайлбар үз.)

[368] *Kappaṁ*—“амьдралын нэгэн мөчлөгийг”. *Kappa*-гийн утга бол “галав” болович маш олон тайлбар бичигт дурдсанаар энэ тохиолдолд “амьдралын бүтэн мөчлөг” (анг. *lifespan*) гэжээ. (*Kathāvatthu* 11.5; *Milindapañha* 5.1.10) Зарим орчуулгад “нэг зуун жил”, “нэг зуун” гэжээ.

[369] Өөр сударт (Vin, Kd 1:1.10.17) Эрхэм Аананда өөрөө: “...Би тэр үед Маара чөтгөрт эзэмдүүлсэн байлаа...” гэжээ.

Ингээд Будда, хоёр дахь удаагаа Эрхэм Аанандад ингэж хэлэв:

“Аананда, бишрэм сайхан газар бол Весаалий, бишрэм сайхан газар бол Удена, бишрэм сайхан газар бол Готамака, бишрэм сайхан газар бол Саттамба, бишрэм сайхан газар бол Бахупутта, бишрэм сайхан газар бол Саарандада, бишрэм сайхан газар бол Каапаала юм.

Аананда, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн хүн, хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой байдаг. Аананда, Тийн Одогч бээр, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн билээ. Хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой юм.” гэв.

Даанч Эрхэм Аананда, Буддаг ийм давхар санааг дэвшүүлж, тийм илтэд санааг өгсөөр атал түүнийг нь ухаж ойлгож чадаагүй бөгөөд Буддагаас ингэж гуйж болох байв:

“Эрхэм Багш минь, Будда та эндээ оршин байх болтугай. Амьдралын нэгэн мөчлөгөө дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдарч, олон хүний тусын тулд, олон хүний аз жаргалын төлөө, ертөнцийг энэрэн нигүүлсэж, бурхад болон хүмүүсийн сайн сайхан хийгээд ашиг тус, аз жаргалын төлөө үлдэх болтугай.” Гэвч Аананда тэрхэн мөчид тэгээгүй бөгөөд Маара чөтгөр түүний оюун санааг эзэмдсэн байв уу гэхээр байжээ.

Тэгээд Будда, гурав дахь удаагаа Эрхэм Аанандад ингэж хэлэв:

“Аананда, бишрэм сайхан газар бол Весаалий, бишрэм сайхан газар бол Удена, бишрэм сайхан газар бол Готамака, бишрэм сайхан газар бол Саттамба, бишрэм сайхан газар бол Бахупутта, бишрэм сайхан газар бол Саарандада, бишрэм сайхан газар бол Каапаала юм.

Аананда, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн хүн, хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой байдаг. Аананда, Тийн Одогч бээр, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн билээ. Хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой юм.” гэв.

Даанч, Эрхэм Аананда, Буддаг ийм давхар санааг дэвшүүлж, тийм илтэд санааг өгсөөр атал түүнийг нь ухаж ойлгож чадаагүй бөгөөд Буддагаас ингэж гуйж болох байв:

“Эрхэм Багш минь, Будда та эндээ оршин байх болтугай. Амьдралын нэгэн мөчлөгөө дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдарч, олон хүний тусын тулд, олон хүний аз жаргалын төлөө, ертөнцийг энэрэн нигүүлсэж, бурхад болон хүмүүсийн сайн сайхан хийгээд ашиг тус, аз жаргалын төлөө үлдэх болтугай.” Гэвч Аананда тэрхэн мөчид тэгээгүй бөгөөд Маара чөтгөр түүний оюун санааг эзэмдсэн байв уу гэхээр байжээ.

Дараа нь Будда Эрхэм Аанандад хандан:

“Яв, Аананда, явах хэрэгтэй бол одоо яв.” гэж хэлэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда Буддад хэлээд, суудлаасаа өндийж, Буддад мөргөж, түүнийг хүндэтгэлтэйгээр хэдэнтээ тойроод, холгүйхэн нэгэн модны ёроолд очиж суув.

14. Маарагийн Хүсэлт (Mārayācanakathā)

Дараа нь Маара чөтгөр, Эрхэм Аанандаг холдон явсны дараа, удалгүй Будда дээр дөхөж ирээд, ойртон ирснийхээ дараа нэг талд нь зогсов. Маара чөтгөр нэг талд нь зогсож байхдаа Буддад ингэж хэлэв:

“Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох[370] болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

‘Чөтгөр[371] минь, миний хуврагууд хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах өөр бусад үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.’ гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Буддагийн хуврагууд бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

‘Чөтгөр минь, миний эмэгтэй хуврагууд хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал

---

370 *Parinibbātu*—“нэгмөсөн үгүй болтугай”. Тогтсон хүндэтгэлтэй хэллэг нь “Эцсийн Нирваанд одох” боловч үгчилбэл, “нэгмөсөн үгүй болох” юм (*Parinibbāna*—“Эцсийн Нирваан” нэгмөсөн үгүй болох, *Nibbāna*—“үгүй болох”, “төгсөх”).

371 *Pāpima*—“чөтгөр”. (*Māro pāpimā*—Маара чөтгөр)

номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолготойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Буддагийн эмэгтэй хуврагууд бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолготойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

'Чөтгөр минь, сахилтан эрэгтэй шавь нар[372] хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолготойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Буддаг дагагч эрэгтэй шавь нар бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолготойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

---

372 *Upāsakā*—"сахилтан эрэгтэй шавь нар". Өөрөөр "сахилтан хар хүн". Гэрээ орхиогүй хар хүн хэвээр боловч, Буддагийн шавь болж, тав болон түүнээс олон сахил сахиж, Сургаал, ариун амьдралыг эрхэмлэгч, эрэгтэй (*upāsakā, upāsako*), эмэгтэй (*upāsikā*) шавь хүмүүс.

‘Чөтгөр минь, сахилтан эмэгтэй шавь нар хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирвааанд одохгүй.’ гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Будда таныг дагагч эмэгтэй шавь нар бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

‘Чөтгөр минь, миний ариуслын-замнал амжилтад хүрээгүй, хөгжин дэвжээгүй, даян дэлхийгээр тараагүй, ард олны хүртээл болоогүй, сүр хүчийг олоогүй, бурхад хийгээд хүмүүсийн дунд сайтар танигдаагүй байгаа цагт, би Эцсийн Нирвааанд одохгүй.’ гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Будда таны ариуслын-замнал амжилтад хүрсэн, хөгжин дэвжсэн, даян дэлхийгээр тарсан, ард олны хүртээл болсон, сүр хүчийг олсон, бурхад хийгээд хүмүүсийн дунд сайтар танигдсан билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Ийнхүү хэлэхэд, Будда, Маара чөтгөрт:

“Тайвширч үз, чөтгөр минь, удаан хүлээнэ гэж санаа зовох хэрэггүй. Яг өнөөдрөөс гурван сарын дараа, Будда Эцсийн Нирвааанд нэгмөсөн одох болно.” хэмээн хэлэв.

15. Амьдралын Үргэлжлэлээс Татгалзахуй (Āyusaṅkhāraossajjana)

Тэгээд Каапаала бунхан дээр, ийнхүү Будда дүүрэн-анхаарал тунгалаг-оюунаар үргэлжлэх амьдралаас[373] татгалзав. Буддаг үргэлжлэх амьдралаас татгалзсаны дараа, асар хүчтэй газар хөдлөлт, сэртхийн цочирдом, аймшигт нүжгэнээн, тэнгэр бурхдын харангын нүргээн хадан цуурайтав. Тэгэхэд Будда үүний нарийн шинж байдлыг ойлгоод, яг тэр мөчид ийн хэлэв:

“Хэмжээтэй, хэмжээгүй энэ үргэлжлэлээс
Хэзээ нэг цагт мэргэн нэгэн татгалздаг
Сэрэмж анхаарал, саруул тунгалаг оюунаар
Сэлэм хуягаа тайлж хаях мэт тэр үүнийг орхив.

16. Агуу Газар Хөдлөлтийн Найман Шалтгаан (Mahābhūmicālahetu)

Тэгэхэд Эрхэм Аананда, “Энэ ёстой гайхамшигтай, үнэхээр гайхамшигтай, энэ асар хүчтэй газар хөдлөлт, сэртхийн цочирдом, аймшигт нүжгэнээн, тэнгэр бурхдын харангын нүргээн хадаан үнэхээр гайхалтай байна. Энэ асар хүчтэй газар хөдлөлт болсон шалтгаан нь юу байсан юм бол?” хэмээн бодов.

Тэгээд Эрхэм Аананда Будда дээр очоод, түүнд ойртон очиж, сөгдөн мөргөснийхөө дараа нэг талд нь суув. Эрхэм Аананда Буддад хандан ингэж хэлэв: “Энэ ёстой гайхамшигтай, үнэхээр гайхамшигтай, энэ асар хүчтэй газар хөдлөлт, сэртхийн цочирдом, аймшигт нүжгэнээн тэнгэр бурхдын харангын нүргээн хадаан, үнэхээр гайхалтай байлаа. Энэ асар хүчтэй газар хөдлөлт болсон шалтгаан нь юу байсан юм бол?” гэхэд:

“Аананда, агуу газар хөдлөлт болоход ийм найман шалтгаан, найман учир бий. Ямар найман шалтгаан байх бол?

1. Аананда, энэ газар дэлхий усан дээр, ус нь агаар дээр, агаар нь огторгуй дээр тогтож байдаг. Аананда аа, агуу салхи салхилах үед энэ нь усанд нөлөөлж, ус долгилж, ус хөдлөх үед газар дэлхий мөн хөдөлдөг. Энэ бол агуу газар хөдлөлтийн эхний шалтгаан нь, эхний нөхцөл нь юм.

2. Цаашилбал, Аананда, бясалгалын хүчээр дамжуулан оюун билгийн өндөр чадамжийг олсон даянч, бярман нар, эсвэл агуу хүчийг эрхшээсэн, сүр жавхланг олсон бурхад байдаг. Тэд газрын танин-мэдэхүйг бага хэмжээгээр олж, харин усны танин-мэдэхүйг их хэмжээгээр олсон үедээ, газар дэлхийг хөдөлгөж, шилгээж, сэгсчиж, чичрүүлдэг юм. Энэ бол агуу газар хөдлөлтийн хоёр дахь шалтгаан нь, хоёр дахь нөхцөл нь юм.

[373] *Āyusaṅkhāraṁ*—“үргэлжлэх амьдрал”. Эсвэл “амьдралын үргэлжлэл”.

3. Цаашилбал, Аананда, Ирээдүйн-Будда[374] Тусита диваажингаас[375] бууж, дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтай эхийнхээ хэвлийд бүрэлдэх тэр үед газар дэлхий хөдөлж, ганхаж, сэгсчиж, чичирдэг. Энэ бол агуу газар хөдлөлтийн гурав дахь шалтгаан нь, гурав дахь нөхцөл нь юм.

4. Цаашилбал, Аананда, Ирээдүйн-Будда эхийнхээ хэвлийгээс дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтай мэндлэн төрөх тэр үед газар дэлхий хөдөлж, ганхаж, сэгсчиж, чичирдэг. Энэ бол агуу газар хөдлөлтийн дөрөв дэх шалтгаан нь, дөрөв дэх нөхцөл нь юм.

5. Цаашилбал, Аананда, Ерөөлтэй Нэгэн Будда, төгс гэгээрлийг олох, Нойрноос Нэгэнт Сэрэх тэр үед газар дэлхий хөдөлж, ганхаж, сэгсчиж, чичирдэг. Энэ бол агуу газар хөдлөлтийн тав дахь шалтгаан нь, тав дахь нөхцөл нь юм.

6. Цаашилбал, Аананда, Ерөөлтэй Нэгэн Будда, төгс төгөлдөр Номын-хүрдийг[376] эргүүлж эхлэх тэр үед газар дэлхий хөдөлж, ганхаж, сэгсчиж, чичирдэг. Энэ бол агуу газар хөдлөлтийн зургаа дахь шалтгаан нь, зургаа дахь нөхцөл нь юм.

7. Цаашилбал, Аананда, Ерөөлтэй Нэгэн Будда, өөрийн амьдралын үргэлжлэлийг, дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтайгаар татгалзах тэр үед газар дэлхий хөдөлж, ганхаж, сэгсчиж, чичирдэг. Энэ бол агуу газар хөдлөлтийн долоо дахь шалтгаан нь, долоо дахь нөхцөл нь юм.

8. Цаашилбал, Аананда, Ерөөлтэй Нэгэн Будда, ор мөргүйгээр Нирваанд нэгмөсөн одох тэр үед газар дэлхий хөдөлж, ганхаж, сэгсчиж, чичирдэг. Энэ бол агуу газар хөдлөлтийн найм дахь шалтгаан нь, найм дахь нөхцөл нь юм.

Эдгээр нь, Аананда, агуу газар хөдлөлтийн найман шалтгаан, найман нөхцөл нь билээ.” гэв.

17. Найман Чуулган (Aṭṭhaparisā)

Аананда, найман чуулган байдаг билээ.

Ямар найман чуулган гэж үү?

---

374 *Bodhisatta*—“Ирээдүйн-Будда”. Хэн нэгэн хүн, ‘Би ирээдүйд Будда болно’ гээд өөрийн хүслээр болчихдоггүй. Тэр хүнтэй амьд сэрүүн Буддатай уулзаад, энэ хүн Ирээдүйн-Будда (*Bodhisatta*) байна гэж Будда түүнийг таниад, түүнд ерөөл зөгнөлийг (*niyata vivaraṇa*) хэлдэг (Bv). Готама Будда бол *Dīpaṅkara* Буддагаас ерөөл авч *Bodhisatta* болжээ (Bv I.1–58). Зарим шашны урсгалын “бодисадва” эсвэл “бодисадын сахил” гэх мэт ойлголт нь Эртний Буддизм болон паали эх сурвалжийн *Bodhisatta* ойлголтоос нэлээд ялгаатай болохыг анхаар.

375 *Tusitakāyā*—“Тусита диваажингаас”. Бурхдын зургаан орны доороосоо дөрөв дэх нь Тусита (үгчилбэл, “жаргалтай бурхад”) юм. Буддын уламжлалаар Ирээдүйн-Будда нь хүмүүний төрөл авахаас өмнө Тусита диваажинд эхлээд төрөл авдаг учиртай (DN 14).

376 *Dhammacakkaṁ*—“Номын-хүрдийг”. *Dhammacakka* буюу үгчилбэл, “Сургаалын дугуй (хүрд)” гэсэн утгатай энэ хэллэг нь Будда өөрийн Сургаалаа хүмүүст анхлан заасан тэр үйл явдлыг ‘хөсөг тэргийг анхлан хөдөлгөхөд тэр тэрэгний дугуй нь өнхөрч эргэлдэж эхэлдэг’ тэр үзэгдлээр зүйрлэн хэлсэн үг.

Язгууртнуудын чуулган, бярман нарын чуулган, хар хүмүүсийн чуулган, даяанчдын чуулган, Агуу Дөрвөн Хаадын Орны[377] бурхдын чуулган, Гучин Гурван Тэнгэрийн Орны[378] бурхдын чуулган, Маара чөтгөрүүдийн чуулган, Бярман Тэнгэрүүдийн чуулган гэж байна.

1. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун язгууртнууд цугласан чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: ‘Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?’ гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд ‘Саяалга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?’ гэж асуудаг байв.

2. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун бярман цугласан чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: ‘Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?’ гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд ‘Сая алга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?’ гэж асуудаг байв.

3. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун хар хүмүүс цугласан чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: ‘Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?’ гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд ‘Сая алга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?’ гэж асуудаг байв.

---

377 *Cātummahārājā*—“Агуу Дөрвөн Хаадын Орны”. Бурхдын 6 орны доод зиндаа ба энэ дөрвөн хаад: 1. *Dhataraṭṭha* (Дорнын) буюу диваажингийн хөгжимчид (*gandhabba*)-ийн хаан; 2. *Virūḷhaka* (Өмнийн) буюу савдгууд (*kumbhaṇḍa*)-ын хаан; 3. *Virūpakkha* (Баруун) буюу лус (*nāga*)-ын хаан; 4. *Vessavaṇa* (Умардын. өөр нэр: *Kuvera*) буюу ягчис нар (*yakkha*)-ын хаан. Тэдний удирдагч нь Сакка (*Sakka*) Бурхан буюу өөр нэршил нь Индра Бурхан. Буддын номыг хамгаалагч гэж үздэг (DN 21; SN 11; MN 35).

378 *Tāvatiṃsa*—“Гучин Гурван Тэнгэрийн Орон”. Бурхдын зургаан орны нэг. (Бүрэн жагсаалтыг Тайлбарын Будда хэсэгт үз.)

4. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун даянчид цугласан чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: ‘Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?’ гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд ‘Сая алга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?’ гэж асуудаг байв.

5. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун Агуу Дөрвөн Хаадын Орны бурхдын чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: ‘Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?’ гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд ‘Сая алга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?’ гэж асуудаг байв.

6. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун Гучин Гурван Тэнгэрийн Орны бурхдын цугласан чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: ‘Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?’ гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд ‘Сая алга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?’ гэж асуудаг байв.

7. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун Маара чөтгөрүүдийн чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: ‘Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?’ гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд ‘Сая алга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?’ гэж асуудаг байв.

8. Аананда, би, тоолшгүй олон, хэдэн зуун Бярман Тэнгэрүүдийн чуулганд явж очсоноо эргэн санаж байна. Тэнд би, суухаасаа өмнө, ярилцахаасаа өмнө, хэлэлцэхээсээ өмнө, тэдний царай төрх нь ямар байсан, би царай төрхөө мөн тийм ижилхэн, тэдний дуу хоолой ямар байсан, би дуу хоолойгоо мөн тийм адилхан болгож хувилаад, би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байсан бөгөөд намайг ярьж байхад тэд намайг танихгүй байсан бөгөөд: 'Энэ хэн ярьж байна вэ, бурхан юм уу, хүн юм уу?' гэж асууж байлаа. Би тэдэнд Сургаал номын тухай ярьж, сургаж, тэднийг сэрээж, урам зориг өгч, сэтгэлийг нь сэргээж байгаад гэнэт тэндээс алга болсон юм. Тэгээд намайг алга болоход тэд намайг таниагүй бөгөөд 'Саяалга болсон хэн байв аа, бурхан байв уу, эсвэл хүн байв уу?' гэж асуудаг байв.

Аананда, эдгээр нь тэрхүү найман чуулган билээ.

18. Төгөлдөр Найман Орон (Aṭṭhaabhibhāyatana)

Аананда, төгөлдөр оюуны[379] найман орон байдаг билээ.

Тэр найм юу вэ?

1. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлан, гадаад байдлаар нь хязгаарлагдмал байдлаар, сайхан эсвэл муухай хэлбэр дүрсийг харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

Энэ бол төгөлдөр оюуны эхний орон юм.

2. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлан, гадаад байдлаар нь хязгааргүйгээр, сайхан эсвэл муухай хэлбэр дүрсийг харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

Энэ бол төгөлдөр оюуны хоёр дахь орон юм.

3. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гадаад байдлаар нь хязгаарлагдмал байдлаар, сайхан эсвэл муухай хэлбэр дүрсийг харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

Энэ бол төгөлдөр оюуны гурав дахь орон юм.

4. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гадаад байдлаар нь хязгааргүйгээр, сайхан эсвэл муухай хэлбэр дүрсийг харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

[379] *Abhibhāyatanāni*—"төгөлдөр оюуны орон". Бясалгалын эсвэл даяаны хувьд төгөлдөржих байдлыг, үүнд хамаарах мэдрэмжийн орныг, мөн үүнд хамаарах мэдлэг.

Энэ бол төгөлдөр оюуны дөрөв дэх орон юм.

5. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гадаад байдлаараа цэнхэр, цэнхэр өнгөтэй, цэнхэрдүү өнгийн, цэнхэр өнгөөр гэрэлтсэн мэтээр харна. Маалинга[380] цэцэг шиг цэнхэр, цэнхэр өнгөтэй, цэнхэрдүү өнгийн, цэнхэр өнгөөр гэрэлтсэнээр, эсвэл Варанасигийн[381] цэнхэр хоргой шиг цэнхэр, цэнхэр өнгөтэй, цэнхэрдүү өнгийн, цэнхэр өнгөөр гэрэлтсэн мэтээр хардаг. Яг үүн шиг аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гаднах байдлаараа цэнхэр, цэнхэр өнгөтэй, цэнхэрдүү өнгийн, цэнхэр өнгөөр гэрэлтсэн мэтээр харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

Энэ бол төгөлдөр оюуны тав дахь орон юм.

6. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гадаад байдлаараа шар, шар өнгөтэй, шаргалдуу өнгийн, шар өнгөөр гэрэлтсэн мэтээр харна. Каникаарагийн[382] цэцэг шар байдаг шиг шар, шар өнгөтэй, шаргалдуу өнгийн, шар өнгөөр гэрэлтсэн мэтээр, эсвэл Варанасигийн шар хоргой шиг шар, шар өнгөтэй, шаргалдуу өнгийн, шар өнгөөр гэрэлтсэн мэтээр хардаг. Яг үүн шиг аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гаднах байдлаараа шар, шар өнгөтэй, шаргалдуу өнгийн, шар өнгөөр гэрэлтсэн мэтээр харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

Энэ бол төгөлдөр оюуны зургаа дахь орон юм.

7. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гадаад байдлаараа улаан, улаан өнгөтэй, улаавтар өнгийн, улаан өнгөөр гэрэлтсэн мэтээр харна. Хамба[383] цэцэг улаан байдаг шиг улаан, улаан өнгөтэй, улаавтар өнгийн, улаан өнгөөр гэрэлтсэн мэтээр, эсвэл Варанасигийн улаан хоргой шиг улаан, улаан өнгөтэй, улаавтар өнгийн, улаан өнгөөр гэрэлтсэн мэтээр хардаг. Яг үүн шиг аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гаднах байдлаараа улаан, улаан өнгөтэй, улаавтар өнгийн, улаан өнгөөр гэрэлтсэн мэтээр харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

Энэ бол төгөлдөр оюуны долоо дахь орон юм.

8. Аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гадаад байдлаараа цагаан, цагаан өнгөтэй, цагаавтар өнгийн, цагаан өнгөөр гэрэлтсэн мэтээр харна. Сараана[384] цэцэг цагаан байдаг шиг цагаан, цагаан

[380] *Umāpuppha*—"Маалинга" (лат. *linum usitatissimum*, ор. *лён*, анг. *flax flower*). (Өөр монгол нэршил байж болохыг анхаар.)

[381] *Varanasi*—"Варанаси". Эсвэл *Banarasi, Benares, Banaras* г.м. нэршил байна.

[382] *Kaṇikāra*—"Каникаара" (лат. *pterospermum acerifolium*, ор. *птероспермум кленолистный*, анг. *bayur tree*). Багваахай шиг хурц шар өнгийн цэцэг бүхий халуун орны нэгэн төрлийн мод.

[383] *Bandhujīvaka*—"Хамба" (лат. *pentapetes phoenicea*, ор. *пентапетес фиолетовый*, анг. *scarlet mallow*). Халуун оронд голдуу ургадаг гал улаан өнгийн цэцэг бүхий ургамал. (Өөр монгол нэршил байж болохыг анхаар.)

[384] *Osadhitārakā*—"Сараана" (лат. *zephyranthes*, ор. *зефирантес*, анг. *white fairy lily*). Зарим англи орчуулгад "*morning star*" (лат. *lilium concolor*) гэсэн байна (BS, MW).

өнгөтэй, цагаавтар өнгийн, цагаан өнгөөр гэрэлтсэн мэтээр, эсвэл Варанасигийн цагаан хоргой шиг цагаан, цагаан өнгөтэй, цагаавтар өнгийн, цагаан өнгөөр гэрэлтсэн мэтээр хардаг. Яг үүн шиг аливаа дүрс юмыг дотроо ухамсарлахгүйгээр, гаднах байдлаараа цагаан, цагаан өнгөтэй, цагаавтар өнгийн, цагаан өнгөөр гэрэлтсэн мэтээр харах бөгөөд эдгээрийг өөртөө дээд зэргээр дадуулснаар, 'Би мэдэж байна, би харж байна.' гэж ойлгоно.

Энэ бол төгөлдөр оюуны найм дахь орон юм.

Аананда, эдгээр нь төгөлдөр оюуны найман орон[385] билээ.

19. Найман Ангижрал (Aṭṭhavimokkha)

Аананда, найман ангижрал гэж бий.

Энэ найм нь юу бол?

1. Бие-дүрстэн бие-дүрсийг харна. Энэ бол ангижралын эхний түвшин юм.

2. Бие-дүрсийг дотроос нь танихгүй байгаа хүн гаднаас нь бие-дүрсийг харна. Энэ бол ангижралын, хоёр дахь түвшин юм.

3. Зөвхөн сайханд төвлөрч ангижирдаг. Энэ бол гурав дахь ангижралын түвшин юм.

4. Бие-дүрст юмсын танин-мэдэхүйгээс нэгэнт хальснаар, "орон зай хязгааргүй"-г оршоон бясалгаснаар, юмсын төрөл зүйлийг танин-мэдэхүйд анхаарал эс хандуулснаар, аливаад үзүүлэх хариу үйлдэл үгүй болсноор, тэр Хязгааргүй Орон Зайн Орны зэрэгт хүрч энд оршдог. Энэ бол дөрөв дэх ангижралын түвшин юм.

5. Хязгааргүй Орон Зайн Орноос нэгэнт хальж, "ухамсар хязгааргүй"-г оршоон бясалгаснаар, Хязгааргүй Ухамсрын Орны зэрэгт хүрч энд оршдог. Энэ бол тав дахь ангижралын түвшин юм.

6. Хязгааргүй Ухамсрын Орноос нэгэнт хальж, "оргүй хоосон"-ыг оршоон бясалгаснаар, Огт-Оргүйн Орны зэрэгт хүрч энд оршдог. Энэ бол зургаа дахь ангижралын түвшин юм.

7. Огт-Оргүйн Орныг бүрэн даван хальж, Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орны зэрэгт хүрч энд оршдог. Энэ бол долоо дахь ангижралын түвшин юм.

8. Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орноос хальж гарч, танин-мэдэхүй хийгээд мэдрэмж тэр чигтээ үгүй болох зэрэгт хүрч энд оршдог. Энэ бол найм дахь ангижралын түвшин юм.

Аананда, эдгээр найман ангижрал билээ.

---

[385] Хувраг Аанандажоти (B. Ānandajoti)-гийн орчуулгад эдгээрийг "Оюуныг Төгөлдөржүүлэх Найман Арга" гэжээ. MPA орчуулгад эдгээр наймыг "Даяаны Найман Арга" гэж үзэн үүнийг *Kasiṇa* (өнгөнд төвлөрөх) Бясалгалын техник гэж тайлбарласан байна.

(...)

Аананда, нэгэн цагт би, Урувелаа[386] гэдэг газар, Неранжараа[387] голын эрэг дээр, ямаачдын инжир модны ёроолд, Гэгээрэлд хүрснийхээ дараа хэсэг амьдарч байлаа. Аананда, тэгэхэд, Маара чөтгөр над дээр дөхөж ирээд, миний нэг талд гарч зогслоо. Аананда, тэр миний хажууд зогсож байхдаа Маара чөтгөр надад ингэж хэллээ:

“Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.”

Аананда, үүнийг хэлсний дараа, би Маара чөтгөрт ийн хэлсэн юм:

‘Чөтгөр минь, миний хуврагууд хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах өөр бусад үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.’

‘Чөтгөр минь, миний эмэгтэй хуврагууд хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.’

‘Чөтгөр минь, сахилтан эрэгтэй шавь нар хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.’ гэж хэлсэн билээ.

‘Чөтгөр минь, сахилтан эмэгтэй шавь нар хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал

[386] *Uruvelā*—“Урувелаа”. Будда гэгээрэхээсээ өмнө, өөрийгөө зовоох аргаар (*attakilamatha*) замнах үедээ Неранжараа голын эрэг болох энэ орчмын газраар амьдарч байсан гэж үздэг.

[387] *Nerañjarā*—“Неранжараа”. Өнөө цагт *Līlajan* нэртэй энэ гол нь сүсэгтнүүдийн очиж мөргөдөг алдарт Бодхгаяа (*Bodhgaya*) орчимд байна.

номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

'Чөтгөр минь, миний ариуслын-замнал амжилтад хүрээгүй, хөгжин дэвжээгүй, даян дэлхийгээр тараагүй, ард олны хүртээл болоогүй, сүр хүчийг олоогүй, бурхад хийгээд хүмүүсийн дунд сайтар танигдаагүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.'

Аананда, харин өнөөдөр, Каапаала бунхан дээр Маара чөтгөр над дээр ирээд, ойртож ирснийхээ дараа миний хажууд зогслоо. Миний хажууд зогсож байхдаа Маара чөтгөр надад ингэж хэллээ:

"Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

'Чөтгөр минь, миний хуврагууд хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах өөр бусад үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Буддагийн хуврагууд бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

'Чөтгөр минь, миний эмэгтэй хуврагууд хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн,

оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Буддагийн эмэгтэй хуврагууд бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаас сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

'Чөтгөр минь, сахилтан эрэгтэй шавь нар хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Буддаг дагагч эрэгтэй шавь нар бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

'Чөтгөр минь, сахилтан эмэгтэй шавь нар хараахан жинхэнэ шавь болоогүй, Сургаал номыг өөрт бүрэн дадуулаагүй, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгаагүй, бүрэн итгэлийг олоогүй, номоо сураагүй, Сургаал номыг төгс оршоогоогүй, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажаагүй, Сургаал номын дагуух амьдралыг бий болгоогүй, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахааргүй байгаа цагт, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн,

оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахааргүй, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахааргүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Будда таныг дагагч эмэгтэй шавь нар бол жинхэнэ шавь болсон, Сургаал номоо өөрт бүрэн дадуулсан, өөрт сахил-ухамсрыг гүйцэд суулгасан, бүрэн итгэлийг олсон, номоо сурсан, Сургаал номоо төгс оршоосон, Сургаал номын дагуу зөвөөр дадлагажсан, Сургаал номын дагуух амьдралыг бий болгосон, багшаасаа сурсан зүйлээ бусдад тайлбарлаж, сургаж, нотолж, ойлгуулж, ил болгож, дүгнэж, тодорхой болгож өгч чадахаар байгаа, түүнчлэн урган гарах бусдын үзэл онолыг бүрэн, оновчтойгоор үгүйсгэж няцааж чадахаар, үндэслэл нотолгоотойгоор тэдэнд Сургаал номыг зааж чадахаар болсон билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Будда та нэгэн цагт:

'Чөтгөр минь, миний ариуслын-замнал амжилтад хүрээгүй, хөгжин дэвжээгүй, даян дэлхийгээр тараагүй, ард олны хүртээл болоогүй, сүр хүчийг олоогүй, бурхад хийгээд хүмүүсийн дунд сайтар танигдаагүй байгаа цагт, би Эцсийн Нирваанд одохгүй.' гэж хэлсэн билээ.

Харин одоо бол, Эрхэм Багш аа, Будда таны ариуслын-замнал амжилтад хүрсэн, хөгжин дэвжсэн, даян дэлхийгээр тарсан, ард олны хүртээл болсон, сүр хүчийг олсон, бурхад хийгээд хүмүүсийн дунд сайтар танигдсан билээ.

Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Төгс Одогч Нэгэн одоо нэгмөсөн үгүй болох болтугай! Эрхэм ээ, Ерөөлтэй Нэгний нэгмөсөн үгүй болох цаг нь одоо болсон.

Ийнхүү хэлэхэд нь, би Маара чөтгөрт ингэж хэллээ:

"Тайвширч үз, чөтгөр минь, удаан хүлээнэ гэж санаа зовох хэрэггүй. Яг өнөөдрөөс гурван сарын дараа, Будда Эцсийн Нирваанд нэгмөсөн одох болно."

Тэгээд Каапаала бунхан дээр, би дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтайгаар амьдралын үргэлжлэлээс татгалзсан билээ."

20. Аанандагийн Хүсэлт (Ānandayācanakathā)

Үүнийг хэлэхэд, Эрхэм Аананда, Буддад ийн хэлэв:

"Буддаг үүрд үлдээгээч, Эрхэм Багш аа. Бурхад хийгээд хүмүүсийн сайн сайхан, тусын тулд, энэ хорвоо дэлхийн хүмүүсийг энэрэн хайрлаж, энэ олон хүмүүсийн аз жаргал, эрүүл энхийн төлөө Буддаг үргэлжлүүлэн амьдруулаач."

"Одоо хангалттай, Аананда. Буддагаас одоо гуйх хэрэггүй. Аананда, одоо Буддагаас гуйх цаг нь биш."

Эрхэм Аананда хоёр дахь удаагаа Буддад ийн хэлэв:

“Буддаг үүрд үлдээгээч, Эрхэм Багш аа. Бурхад хийгээд хүмүүсийн сайн сайхан, тусын тулд, энэ хорвоо дэлхийн хүмүүсийг энэрэн хайрлаж, энэ олон хүмүүсийн аз жаргал, эрүүл энхийн төлөө Буддаг үргэлжлүүлэн амьдруулаач.”

“Одоо хангалттай, Аананда. Буддагаас одоо гуйх хэрэггүй. Аананда, одоо Буддагаас гуйх цаг нь биш.”

Эрхэм Аананда гурав дахь удаагаа Буддад ийн хэлэв:

“Буддаг үүрд үлдээгээч, Эрхэм Багш аа. Бурхад хийгээд хүмүүсийн сайн сайхан, тусын тулд, энэ хорвоо дэлхийн хүмүүсийг энэрэн хайрлаж, энэ олон хүмүүсийн аз жаргал, эрүүл энхийн төлөө Буддаг үргэлжлүүлэн амьдруулаач.”

“Аананда, чи Буддагийн Төгс Гэгээрэлд итгэдэг үү?”

“Тийм ээ. Эрхэм ээ.”

“Тэгвэл Аананда, чи яагаад гурван удаа гуйх хүртэл Буддаг зовоогоод байгаа билээ?”

“Та над руу харж байгаад:

‘Аананда, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн хүн, хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой байдаг. Аананда, Тийн Одогч бээр, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн билээ. Хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой юм.’ гэж хэлсэн шүү дээ.”

“Чамд итгэл-үнэмшил бий юу Аананда?”

“Тийм ээ. Эрхэм Багш аа.”

“Тэгвэл, Аананда, чамд хийсэн алдаа байна, чи ийм алдаа хийсэн байна, учир нь Буддаг ийн давхар санаа дэвшүүлж, тийн илтэд санаа өгөх атал түүнийг ухаж ойлгож чадаагүй бөгөөд Будда надаас ингэж гуйж болох байсан билээ:

‘Эрхэм ээ, Будда та эндээ оршин байх болтугай. Амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдарч, олон хүний тусын тулд, олон хүний аз жаргалын төлөө, ертөнцийг энэрэн нигүүлсэж, бурхад болон хүмүүсийн сайн сайхан хийгээд ашиг тус, аз жаргалын төлөө үлдэх болтугай.’

Хэрвээ, Аананда чи, Буддагаас хоёр дахь удаагаа гуйхад чинь Будда энэ гуйлтыг чинь үгүйсгэж болох байсан ч, гурав дахь удаагаа гуйсан бол хүлээж авах байсан билээ. Тэгэхээр, Аананда, чамд хийсэн ийм алдаа байна. Энэ чиний алдаа боллоо.

Аананда, нэг удаа би, Раажагахагийн ойролцоох Тас Шувуудын Оргил ууланд амьдарч байлаа. Тэнд байхдаа би чамд:

‘Аананда, Раажагаха бол бахдам сайхан газар юм. Тас Шувуудын Оргил ч бас бахдам сайхан газар юм.

Аананда, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн хүн, хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой байдаг. Аананда, Тийн Одогч бээр, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн билээ. Хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой юм.’ гэж хэлсэн билээ.

Даанч, Аананда, Будда намайг ийн давхар санаа дэвшүүлж, тийн илтэд санаа өгөх атал түүнийг чи ухаж ойлгож чадаагүй бөгөөд надаас:

‘Эрхэм Багш минь, Будда та эндээ оршин байх болтугай. Амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдарч, олон хүний тусын тулд, олон хүний аз жаргалын төлөө, ертөнцийг энэрэн нигүүлсэж, бурхад болон хүмүүсийн сайн сайхан хийгээд ашиг тус, аз жаргалын төлөө үлдэх болтугай.’ гэж гуйж болох байв.

Хэрвээ, Аананда чи, Буддагаас хоёр дахь удаагаа гуйхад чинь Будда энэ гуйлтыг чинь үгүйсгэж болох байсан ч, гурав дахь удаагаа гуйсан бол хүлээж авах байсан билээ. Тэгэхээр, Аананда, чамд хийсэн ийм алдаа байна. Энэ чиний алдаа боллоо.

Би Раажагахагийн ойролцоох Готама инжир модны амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох Хулгайчдын Хаданд амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох Вебхаара уулын энгэр дэх Саттапаннид амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох Исигили уулын Хар Хаданд амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох Могойн Ангалын доор Сэрүүн Төгөлд амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох Халуун Рашаан хийдэд амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох хэрэм тэжээдэг Хулсан Төгөлд амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох Жийвакагийн манго төгөлд амьдардаг байсан… Би Раажагахагийн ойролцоох Маддакуччхи бугат хүрээлэнд амьдардаг байсан…

Тэдгээр газарт амьдарч байхдаа, Аананда, би чамд ингэж хэлж байсан билээ:

‘Аананда, Раажагахагийн ойролцоох Готама инжир мод бол бахдам сайхан газар юм. Раажагахагийн ойролцоох Хулгайчдын Хад бол бахдам сайхан газар юм. Раажагахагийн ойролцоох Вебхаара уулын энгэр дэх Саттапанни бол бахдам сайхан газар юм. Раажагахагийн ойролцоох Исигили уулын Хар Хад бол бахдам сайхан газар юм. Раажагахагийн ойролцоох Могойн Ангалын доор Сэрүүн Төгөл бол бахдам сайхан газар юм. Раажагахагийн ойролцоох Халуун Рашаан хийд бол бахдам сайхан газар юм. Раажагахагийн ойролцоох, хэрэм тэжээдэг Хулсан Төгөл бол бахдам сайхан газар юм.

Аананда, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн хүн, хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой байдаг. Аананда, Тийн Одогч бээр, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн билээ. Хэрвээ

тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой юм.' гэж хэлсэн билээ.

Даанч, Аананда, Будда намайг ийн давхар санаа дэвшүүлж, тийн илтэд санаа өгөх атал түүнийг чи ухаж ойлгож чадаагүй бөгөөд надаас:

'Эрхэм Багш минь, Будда та эндээ оршин байх болтугай. Амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдарч, олон хүний тусын тулд, олон хүний аз жаргалын төлөө, ертөнцийг энэрэн нигүүлсэж, бурхад болон хүмүүсийн сайн сайхан хийгээд ашиг тус, аз жаргалын төлөө үлдэх болтугай.' гэж гуйж болох байв.

Хэрвээ, Аананда чи, Буддагаас хоёр дахь удаагаа гуйхад чинь Будда энэ гуйлтыг чинь үгүйсгэж болох байсан ч, гурав дахь удаагаа гуйсан бол хүлээж авах байсан билээ. Тэгэхээр, Аананда, чамд хийсэн ийм алдаа байна. Энэ чиний алдаа боллоо.

Аананда, нэгэн цагт би, Весаалийгийн ойролцоох Удена мөргөлийн газарт амьдарч байлаа... Би Весаалийгийн ойролцоох Готамака мөргөлийн газарт амьдарч байлаа... Би Весаалийгийн ойролцоох Долоон Шивэгчин мөргөлийн газарт амьдарч байлаа... Би Весаалийгийн ойролцоох Олон Хүүдийн мөргөлийн газарт амьдарч байлаа... Би Весаалийгийн ойролцоох Саарандада мөргөлийн газарт амьдарч байлаа... Өнөөдөр энд, Аананда, Каапаала мөргөлийн газарт би чамд:

'Аананда, Весаалийгийн ойролцоох Удена мөргөлийн газар бол бахдам сайхан газар юм... Весаалийгийн ойролцоох Готамака мөргөлийн газар бол бахдам сайхан газар юм... Весаалийгийн ойролцоох Долоон Шивэгчин мөргөлийн газар бол бахдам сайхан газар юм... Весаалийгийн ойролцоох Олон Хүүдийн мөргөлийн газар бол бахдам сайхан газар юм... Весаалийгийн ойролцоох Саарандада мөргөлийн газар бол бахдам сайхан газар юм... Каапаала мөргөлийн газар бол бахдам сайхан газар юм...

Аананда, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн хүн, хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой байдаг. Аананда, Тийн Одогч бээр, ид-чадлын дөрвөн үндсийг дадуулж, хөгжүүлж, түүнийг сайжруулж, хадгалж, цогцлоож, зохих ёсоор нь биелүүлсэн билээ. Хэрвээ тэр хүсвэл, Аананда, амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдрах боломжтой юм.' гэж хэлсэн билээ.

Даанч, Аананда, Будда намайг ийн давхар санаа дэвшүүлж, тийн илтэд санаа өгөх атал түүнийг чи ухаж ойлгож чадаагүй бөгөөд надаас:

'Эрхэм Багш минь, Будда та эндээ оршин байх болтугай. Амьдралын нэгэн мөчлөгийг дуусах хүртэл үргэлжлүүлэн амьдарч, олон хүний тусын тулд, олон хүний аз жаргалын төлөө, ертөнцийг энэрэн нигүүлсэж, бурхад болон хүмүүсийн сайн сайхан хийгээд ашиг тус, аз жаргалын төлөө үлдэх болтугай.' гэж гуйж болох байв.

Хэрвээ, Аананда чи, Буддагаас хоёр дахь удаагаа гуйхад чинь Будда энэ гуйлтыг чинь үгүйсгэж болох байсан ч, гурав дахь удаагаа гуйсан бол хүлээж авах байсан билээ. Тэгэхээр, Аананда, чамд хийсэн ийм алдаа байна. Энэ чиний алдаа боллоо.

‘Хайр татсан, сэтгэл булаасан бүх юм өөрчлөгдөн хувьсаж, салан холдож, ондоошин хувирдаг биш үү? Төрсөн, бий болсон, сэдэгдсэн-цогцолсон[388] бол эвдрэх Жамтай байхаас бус өөрөөр яана гэж? Аананда. Өөрөөр байх боломжгүй.’ гэж би, өмнө нь чамд заагаагүй гэж үү?

Гэвч Будда энэ амьдралын үргэлжлэл, үйл явцыг нэгэнтээ орхиж, явуулж, гээж, суллаж, хаяж байгаа билээ.

Будда:

‘Удахгүй Будда Эцсийн Нирваанд нэгэнт одох болно, яг гурван сарын дараа Будда Эцсийн Нирваанд нэгэнт одох болно.’ хэмээн, энэ үгийг итгэлтэйгээр хэлж байна. Аананда, Будда амьдрахын тулд хэлсэн үгнээсээ буцах учир байдаггүй юм. Энэ нь боломжгүй юм.

Алив, Аананда, одоо Их Модон дахь Шовх Дээвэрт Танхим руу явцгаая.” хэмээн хэллээ.

“За, Эрхэм Багш аа.” хэмээн Эрхэм Аананда Буддад хариулав.

Дараа нь Будда, Эрхэм Ааанандагийн хамт Их Модон дахь Шовх Дээвэрт танхим руу хөдлөөд, тэнд дөхөж ирснийхээ дараа Эрхэм Ааанандад хандаж хэлэв:

“Яв, Аананда, Весаалий хавиар амьдарч байгаа хуврагуудыг бүгдийг нь хурлын танхимд цуглуул.”

“За, Эрхэм Багш аа.” хэмээн Эрхэм Аананда Буддад хариулав.

Весаалий хавиар амьдарч байгаа хуврагуудыг бүгдийг нь, хурлын танхимд цуглуулаад Будда дээр эргэж ирээд, түүнд ойртон мөргөсний дараа тэрээр түүний хажууд нь зогсов. Эрхэм Аананда нэг талд нь зогсож байхдаа Буддад:

“Эрхэм Багш аа, Хуврагийн Чуулган цугларлаа. Будда, та болгооно уу.” гэж хэлэв.

Гэгээрлийн Гучин Долоон Зүйл (Bodhipakkhiyādhammā)

Ингээд Будда хурлын танхимд хүрч ирэв. Орж ирснийхээ дараа бэлдсэн суудалд суулаа.[389] Будда тэнд сууж байхдаа нийт хуврагуудад хандан:

388 *Saṅkhatāṁ*—“сэдэгдсэн-цогцолсон” (анг. *conditioned*). Өөрөөр, “нөхцөлдөн бүрэлдэж бий болсон”, “аливаа сэдлээр цогцолсон”, “угсрагдсан”, “үүсмэл” “хиймэл” г.м. (Тайлбарт буй Сэдэхүй-Цогцлохуйг дэлгэрэнгүй үз.)

389 Энэ бүлэг хэсэг зарим орчуулгад дугаарлагдаж, заримд дугаарлагдаагүй байдаг. Ач холбогдлын зэрэг өндөр тул гарчиг өгч, дугаарлалгүйгээр нэгэн бүлэг болгож оруулсан болно.

“Тэгэхээр, хуврагууд аа, би шууд-билгүүнээр ухаарсан, та бүгдэд заасан Сургаалыг эхлээд сайтар ойлгож, ой тойндоо буулгасныхаа дараа, та бүгд үүнийг бясалгаж, дадуулж, нандигнан авч явах учиртай юм. Ингэж гэмээ нь, энэ ариуслын-замнал өнө удаан үргэлжлэх болно. Тэгж гэмээ нь, энэ нь олон хүмүүсийн ашиг тусын төлөө, олон хүмүүсийн аз жаргалын төлөө, энэ хорвоог энэрэн нигүүлссэн сэтгэлийн үүднээс, бурхад хийгээд хүмүүсийн сайн сайхан, ашиг тус, аз жаргалын төлөө болох юм.

Олон хүмүүсийн ашиг тусын төлөө, олон хүмүүсийн аз жаргалын төлөө, энэ хорвоог энэрэн нигүүлссэн сэтгэлийн үүднээс, бурхад хийгээд хүмүүсийн сайн сайхан, ашиг тус, аз жаргалын төлөө болох, эхлээд сайтар ойлгож, ой тойндоо буулгасныхаа дараа, та бүгд бясалгаж, дадуулж, нандигнан авч явах учиртай, миний шууд-билгүүнээр ухаарсан, та бүгдэд заасан тэр Сургаал юу билээ?

Тэдгээр сургаал бол:

Дүүрэн-Анхаарал Суулгах Дөрвөн Бясалгал[390],

Дөрвөн Зөв Чармайлт[391],

Дөрвөн Ид-Чадал[392],

Таван Чадвар[393],

Таван Хүч[394],

Долоон Гэгээрлийг-Амирлуулагч[395],

Гэгээнтний Найман Замнал[396] билээ.[397]

Эдгээр нь хуврагууд аа, би шууд-билгүүнээр ухаарсан, та бүгдэд заасан Сургаалыг эхлээд сайтар ойлгож, ой тойндоо буулгасныхаа дараа, та бүгд үүнийг бясалгаж, дадуулж, нандигнан авч явах учиртай юм. Ингэж гэмээ нь, энэ ариуслын-замнал өнө удаан үргэлжлэх болно. Тэгж гэмээ нь, энэ нь олон хүмүүсийн

---

390 *Cattāro satipaṭṭhānā*—“Дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгал” (1. биеийг ажихуй; 2. мэдрэмжийг ажихуй; 3. сэтгэлийг ажихуй; 4. үзэгдлийг ажихуй). (DN 22-г үз.)

391 *Cattāro sammappadhānā*—“Дөрвөн Зөв Чармайлт”. Үүнд: 1. сахил хатамжлалын (*saṃvara*); 2. орхин-одуулахуйн (*pahāna*); 3. дадуулахуйн (*bhāvana*); 4. хамгаалахуйн (*anurakkhana*).

392 *Cattāro iddhipādā*—“Дөрвөн Ид-Чадал”. (DN 2.4.17-г үз.)

393 *Pañcindriyāni*—“Таван Чадвар” (1. итгэл-үнэмшлийн; 2. эрч хүчний; 3. дүүрэн-анхаарлын; 4. самади-төвлөрлийн; 5. саруул-ухааны).

394 *Pañca balāni*—“Таван Хүч” (1. итгэл-үнэмшлийн; 2. эрч хүчний; 3. дүүрэн-анхаарлын; 4. самади-төвлөрлийн; 5. саруул-ухааны).

395 *Satta bojjhaṅgā*—“Долоон гэгээрлийг-амирлуулагч”. (1. дүүрэн-анхаарал; 2. Үзэгдэл-шинжихүй; 3. эрч хүч; 4. хөөр-баяр; 5. амар-амгалан; 6. самади-төвлөрөл; 7. төв-оршихуй)

396 *Ariyo aṭṭhaṅgiko maggo*—“Гэгээнтний Найман Замнал” (1. зөв үзэл; 2. зөв сэдэл; 3. зөв яриа; 4. зөв үйлдэл; 5. зөв амьжиргаа; 6. зөв зүтгэл; 7. зөв дүүрэн-анхаарал; 8. зөв самади-төвлөрөл).

397 Гэгээрлийн 37 зүйл (Дөрвөн бясалгал, Дөрвөн Чармайлт, Дөрвөн Чадал, Таван Чанар, Таван Чадамж, Долоон Нөхцөл, Найман Замнал).

ашиг тусын төлөө, олон хүмүүсийн аз жаргалын төлөө, энэ хорвоог энэрэн нигүүлссэн сэтгэлийн үүднээс, бурхад хийгээд хүмүүсийн сайн сайхан, ашиг тус, аз жаргалын төлөө болох юм.

Дараа нь Будда хуврагуудад хандан:

“Одоо хуврагууд аа, анхаараад сонсоно уу! Би та бүгдэд,

‘Сэдэхүй-цогцлохуй бүхэн[398] сүйрч унадаг жамтай. Хичээнгүйлэн зүтгээрэй хуврагууд аа!’ гэдгийг хэлье.

Удахгүй Будда Нирваанд нэгмөсөн одох болно. Гурван сарын дараа, Будда Эцсийн Нирваанд одох болно.” хэмээн хэллээ.

Ингээд Зөвөөр Одогч[399], Будда ийн хэлэв:

“Хөгшин хийгээд залуу, мунхаг хийгээд ухаант хүмүүс
Хөрөнгөтэй хийгээд хөрөнгөгүй бүгд үхлээр дуусдаг жамтай
Том, жижиг, шатаасан, шатаагаагүй, ваарчны хийсэн бүх ваар сав
Тоост энэ орчлонд хагарч бутарч, эвдэрч хаягдаж дуусдагийн адил
Хүмүүний амьдрал ч ялгаагүй үхлээр л дуусдаг жамтай
Өтөлсөн, хөгширсөн миний амьдралд өчүүхэн бага хугацаа үлдсэн
Өөрийгөө хоргодох газар болгоод, өөр төрлийг дахин олохгүйгээр явлаа
Анхаарал дүүрэн, ухаан саруул, тустай буянтай байж хуврагууд аа
Аюулт хөнөөлт сэдлээс оюун санаагаа ямагт хамгаалж яваарай
Үнэн Сургаал, бясалгал хийгээд Сахилыг дадуулж чадаж гэмээ нь
Үхэх-төрөхийн эргэлтээс ангижирч гэмээ нь хамаг зовлон нэгэнт эцэслэнэ.”

Гуравдугаар уншлага хэсэг өндөрлөв.

21. Зааны Адил Ширтэхүй (Nāgāpalokita)

Ингээд удаах өглөө нь Будда, орхимжоо өмсөөд, бадрын аягаа аваад, Весаалийг бадар барихаар зорив. Весаалийд тэр өглөө бадар барьж олсон хоолоо идчихээд, өглөгийн газраас буцаж ирэхдээ, Весаалий уруу, заан адил бүх л биеэрээ эргэн хараад, тийш ширтэн зогсох зуур, Эрхэм Аанандад хандан:

398 *Saṅkhārā*—“Сэдэхүй-цогцлохуй бүхэн”. Судрын энэ хэсэгт *saṅkhāra*-г олон тоон дээр бичсэн байгаа, мөн “нөхцөлдсөн бүх юмс үзэгдэл” (анг. *conditioned things*) гэсэн түгээмэл орчуулгын хувилбар байдгийг харгалзан үзэж “сэдэхүй-цогцлохуй бүхэн” гэж оруулав. Өөрөөр “сэдэхүй-цогцлохуйнууд”. Зарим англи орчуулгад, “сэдлийн үүсмэлүүд” (анг. *volitional formations*, BB), эсвэл “нөхцөлүүд” (анг. “*conditions*”, BS) гэсэн байна. (Тайлбарт Сэдэхүй-Цогцлохуйг үз.)

399 *Sugato*—“Зөвөөр Одогч”. Буддаг нэрлэх өөр нэгэн нэр.

"Аананда, Би Весаалий руу сүүлчийн удаа харж байгаа нь энэ билээ. Алив, Аананда, Бханда[400] тосгон руу явцгаая." гэхэд:

"За, Эрхэм Багш аа." гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

Тэгээд дараа нь Будда Хуврагийн Чуулганы хамтаар Бханда тосгонд ирэв. Ингээд Будда Бханда тосгоны ойролцоо буусан байлаа.

Тэнд Будда нийт хуврагуудад хандан:

"Хуврагууд аа, та нар ч, би ч, энэ дөрвөн зүйлийг ойлгоогүй, нэвт ухамсарлаж чадаагүйн улмаас үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөсөн байна.

Тэгвэл энэ дөрөв юу вэ?

1. Гэгээнтний сахил-ухамсрыг гүнзгий ойлгоогүй, нэвтэрхий ухаараагүйн улмаас та нар ч, би ч, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөсөн байна.

2. Гэгээнтний самади-төвлөрлийг гүнзгий ойлгоогүй, нэвтэрхий ухаараагүйн улмаас та нар ч, би ч, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөсөн байна.

3. Гэгээнтний саруул-ухааныг гүнзгий ойлгоогүй, нэвтэрхий ухаараагүйн улмаас та нар ч, би ч, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөсөн байна.

4. Гэгээнтний ангижралыг гүнзгий ойлгоогүй, нэвтэрхий ухаараагүйн улмаас та нар ч, би ч, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчилсээр, удаан хугацааг өнгөрөөсөн байна.

Харин одоо Гэгээнтний сахил-ухамсрыг ойлгож ухаарав. Гэгээнтний самади-төвлөрлийг ойлгож ухаарав. Гэгээнтний саруул-ухааныг ойлгож ухаарав. Гэгээнтний ангижралыг ойлгож ухаарав. Дараа төрөл авах хүсэл-цангаа зогсов. Оршихуйд хөтлөхүй устав. Цаашдын оршихуй гэх зүйл үгүй болов."

Будда ийн айлдав.

Ингээд Зөвөөр Одогч, Будда ийн хэлэв:

> "Сахил-ухамсар, самади-төвлөрөл, саруул-ухаан, ангижралыг
> Сакя омгоос гаралтай, сайн нэрийг олсон Готама ухаараад
> Сайтар нягталсан Сургаал номоо төгс гэгээрсэн Будда
> Сахилтан хуврагууд та бүгдэд заан сургасан билээ."

Мөн тэр цагт, Будда Бханда тосгонд амьдарч байхдаа хуврагууддаа, Сургаал номын талаар мөн үе үе ийн хэлдэг байв:

---

400 *Bhaṇḍagāma*—"Бханда" тосгон. Важжий нарын газар нутаг, Весаалий болон Хаттхи тосгоны хооронд байрлах жижиг тосгон.

"Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ."

22. Эрхэм Дөрвөн Шалгуур (Catumahāpadesakathā)

Дараа нь Будда, Бханда тосгоны ойролцоо хангалттай амьдарсны эцэст Эрхэм Аанандад хандан:

"Алив, Аананда, Заан тосгон[401] руу явцгаая…", "Алив, Аананда, Манго тосгон[402] руу явцгаая…", "Алив, Аананда, Хар Чавга тосгон[403] руу явцгаая…", "Алив, Аананда, Бхога хот[404] руу явцгаая…"

"За, Эрхэм Багш аа." хэмээн Эрхэм Аананда Буддад хариулав.

Дараа нь Будда, Хуврагийн Чуулганы хамтаар Бхога хотод ирэв. Тэнд Будда Бхога хотын ойролцоох Баясгалант Шүтээн[405] орчимд амьдарч байв.

Тэнд Будда нийт хуврагуудад хандан:

"Хуврагууд аа, би та бүгдэд эрхэм дөрвөн шалгуурыг зааж өгье. Анхааралтай сонсоод, оюундаа тунгаагаарай, би үүнийг хэлье." гэв.

"За, Эрхэм Багш аа." хэмээн хуврагууд хариулав.

Будда ингэж айлдав:

1. "Хуврагууд аа, хэн нэг хувраг ингэж хэлж болох юм:

'Найзууд аа, би үүнийг Буддагийн амнаас сонссон. Би үүнийг яг түүнээс ингэж сурсан:

"Энэ бол Сургаал нь. Энэ бол Сахил[406] нь. Энэ бол Багшийн заавар нь."

---

401 *Hatthigāmo*—"Заан тосгон". Тосгодын нэрс голдуу тэдний эрхэлдэг ажил үйлдвэртэй холбоотой нэрлэгдсэн байна (Орч).

402 *Ambagāmo*—"Манго тосгон".

403 *Jambugāmo*—"Хар Чавга тосгон".

404 *Bhoganagaraṁ*—"Бхога хот".

405 *Ānande cetiye*—"Баясгалант Шүтээн".

406 *Vinaya*—"Сахил". Өөрөөр, "сахил ёс". Эртний уламжлал ёсоор Анхдугаар Чуулган дээр хувраг Упаалигийн амаар айлдсан Винайн судрууд (Vinaya Piṭaka) буюу хувраг, сахилтан нарын дагаж мөрдөх дэг ёс.

Хуврагууд аа, тэр хуврагийн хэлсэн үгийг шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл шууд үгүйсгэн няцаах хэрэггүй юм. Үүнийг шууд хүлээн зөвшөөрөлгүйгээр, эсвэл үгүйсгэн няцаалгүйгээр, түүний хэлсэн үг, өгүүлбэрийг сайтар тогтоож аваад, тэдгээрийг Сударт[407] байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзэх хэрэгтэй билээ.

Хэрэв тэдгээр нь Судартбайхгүй, Сахилтай нийцэхгүй бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг биш байна. Энэ хувраг номыг буруу ойлгосон байна.’

Тэгээд та бүгд үүнийг хаях учиртай.

Хэрэв тэдгээрийг Сударт байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзээд, тэдгээр нь Сударт байгаа, Сахилтай нийцэж байгаа бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг байна. Энэ хувраг номыг зөв сурсан байна.’

Энэ бол хуврагууд аа, та бүхний санаж явах ёстой эхний эрхэм шалгуур юм.

2. Хуврагууд аа, хэн нэг хувраг ингэж хэлж болох юм:

‘Ахмад настай, эрдэм номтой, хуврагууд болон шашны тэргүүнүүд цугласан, тийм нэгэн газар, ийм нэгэн хуврагийн чуулал байдаг. Би үүнийг тэр хуврагийн чууллын амнаас сонссон. Би яг тэндээс ингэж сурсан:

“Энэ бол Сургаал нь. Энэ бол Сахил нь. Энэ бол Багшийн заавар нь.”

Хуврагууд аа, тэр хуврагийн чууллын хэлсэн үгийг шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл шууд үгүйсгэн няцаах хэрэггүй юм. Үүнийг шууд хүлээн зөвшөөрөлгүйгээр, эсвэл үгүйсгэн няцаалгүйгээр, түүний хэлсэн үг, өгүүлбэрийг сайтар тогтоож аваад, тэдгээрийг Сударт байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзэх хэрэгтэй билээ.

Хэрэв тэдгээр нь Судартбайхгүй, Сахилтай нийцэхгүй бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг биш байна. Энэ хувраг номыг буруу ойлгосон байна.’

Тэгээд та бүгд үүнийг хаях учиртай.

Хэрэв тэдгээрийг Сударт байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзээд, тэдгээр нь Сударт байгаа, Сахилтай нийцэж байгаа бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг байна. Энэ хувраг номыг зөв сурсан байна.’

Энэ бол хуврагууд аа, та бүхний санаж явах ёстой хоёр дахь эрхэм шалгуур юм.

---

[407] *Sutte*—“Сударт”. *Sutta*—яриа, заавар, хичээл (сам. *Sutra*). Цаас Буддагийн цагт үүсээгүй байсан ба *sutta* гэдэг нь зөвхөн аман яриа, заавар хичээл байж. Уламжлал ёсоор Аанандагийн амаар айлдсан Судрын Сав Аймгийн судруудыг “Судар” (*sutta*) гэнэ.

3. Хуврагууд аа, хэн нэг хувраг ингэж хэлж болох юм:

‘Ёс уламжлалыг сайтар сурсан, Сургаал номыг гаргуун мэдсэн, Сахил ёсыг өөртөө суулгасан, хуврагийн ёсыг дээдэлсэн, тийм нэгэн газар, ийм эрдэм номтой, нэлээд хэдэн ахмад настай хуврагууд байдаг. Би үүнийг тэдгээр хуврагуудын яг амнаас нь сонссон. Би үүнийг тэднээс ингэж сурсан:

“Энэ бол Сургаал нь. Энэ бол Сахил нь. Энэ бол Багшийн заавар нь.”

Хуврагууд аа, тэр хуврагийн хэлсэн үгийг шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл шууд үгүйсгэн няцаах хэрэггүй юм. Үүнийг шууд хүлээн зөвшөөрөлгүйгээр, эсвэл үгүйсгэн няцаалгүйгээр, түүний хэлсэн үг, өгүүлбэрийг сайтар тогтоож аваад, тэдгээрийг Судрт байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзэх хэрэгтэй билээ.

Хэрэв тэдгээр нь Судрт байхгүй, Сахилтай нийцэхгүй бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг биш байна. Энэ хувраг номыг буруу ойлгосон байна.’

Тэгээд та бүгд үүнийг хаях учиртай.

Хэрэв тэдгээрийг Судрт байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзээд, тэдгээр нь Судрт байгаа, Сахилтай нийцэж байгаа бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг байна. Энэ хувраг номыг зөв сурсан байна.’

Энэ бол хуврагууд аа, та бүхний санаж явах ёстой гурав дахь эрхэм шалгуур юм.

4. Хуврагууд аа, хэн нэг хувраг ингэж хэлж болох юм:

‘Ёс уламжлалыг сайтар сурсан, Сургаал номыг гаргуун мэдсэн, Сахил ёсыг өөртөө суулгасан, хуврагийн ёсыг дээдэлсэн, тийм нэгэн газар, ийм эрдэм номтой, ахмад настай нэгэн хувраг байдаг. Би үүнийг тэр хуврагийн яг амнаас нь сонссон. Би үүнийг түүнээс ингэж сурсан:

“Энэ бол Сургаал нь. Энэ бол Сахил нь. Энэ бол Багшийн заавар нь.”

Хуврагууд аа, тэр хуврагийн хэлсэн үгийг шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл шууд үгүйсгэн няцаах хэрэггүй юм. Үүнийг шууд хүлээн зөвшөөрөлгүйгээр, эсвэл үгүйсгэн няцаалгүйгээр, түүний хэлсэн үг, өгүүлбэрийг сайтар тогтоож аваад, тэдгээрийг Судрт байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзэх хэрэгтэй билээ.

Хэрэв тэдгээр нь Судрт байхгүй, Сахилтай нийцэхгүй бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг биш байна. Энэ хувраг номыг буруу ойлгосон байна.’

Тэгээд та бүгд үүнийг хаях учиртай.

Хэрэв тэдгээрийг Судрт байгаа эсэхийг, Сахилтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзээд, тэдгээр нь Судрт байгаа, Сахилтай нийцэж байгаа бол та эндээс дараах дүгнэлтэд хүрч болно:

‘Мэдээж хэрэг, энэ бол Буддагийн үг байна. Энэ хувраг номыг зөв сурсан байна.’

Энэ бол хуврагууд аа, та бүхний санаж явах ёстой дөрөв дэх эрхэм шалгуур юм.

Эдгээр нь хуврагууд аа, та бүхний санаж явах ёстой эрхэм дөрвөн шалгууруud билээ.

Мөн тэр цагт, Будда Бхога хотын ойролцоох Баясгалант Шүтээний газарт амьдарч байхдаа хуврагууддаа, Сургаал номын талаар мөн үе үе ийн хэлдэг байв:

“Сахил-ухамсрыг өөрт суулгаснаар, энэ нь самади-төвлөрлийг үүсгэн бий болгодог асар их үр өгөөж, асар их үр дүнг авчирдаг билээ. Самади-төвлөрлийг өөрт суулгаснаар, энэ нь үр шимээ өгч, саруул-ухааныг үүсгэн бий болгодог их үр өгөөж, их үр дүнг авчирдаг билээ. Саруул-ухааныг олсноор, энэ нь оюун санааг оюуны-хорлолоос нэгмөсөн ангижруулан гэгээрүүлдэг билээ. Тэр оюуны-хорлол гэдэг нь мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол, оршихуйн оюуны-хорлол, мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол, эдгээрийг хэлж буй хэрэг юм.

Үүнийг л сахил-ухамсар, үүнийг л самади-төвлөрөл, үүнийг л саруул-ухаан гэж хэлнэ.”

23. Дархны Хүү Чундагийн Түүх (Kammāraputtacundavatthu)

Ингээд Будда Бхога хотод хангалттай удаан байсны эцэст, Эрхэм Аанандад хандан:

“Алив, Ааната, Пааваа[408] руу явцгаая.” гэхэд:

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Ааната Буддад хариулав. Ингээд дараа нь Будда Хуврагийн Чуулганы хамтаар Паавад ирэв. Тэгээд Будда Паавагийн ойролцоо Чунда[409] гэх дархны эзэмшил манго төгөлд буусан байлаа.

Чунда дархан:

“Будда Хуврагийн Чуулганы хамтаар Паавад хүрэлцэн ирээд, Паавагийн ойролцоох миний эзэмшил манго төгөлд буусан байлаа бололтой.” гэж сонсов. Дараа нь Чунда дархан Будда дээр ирээд, түүнд ойртож мөргөснийхөө дараа нэг талд нь суув. Чундаг нэг талд нь сууж байхад Будда түүнд Сургаал номын тухай ярьж өгч, зааж зөвлөж, түүнийг сэргээж, урам зориг өгч, түүнд ухаарал хайрлав. Дархан Чунда Буддагаар заалгуулаад, сэргээд, урам зориг, ухаарал аваад, Сургаал номын тухай тэрхүү яриаг сонссоныхоо дараа Буддад хандан:

“Эрхэм дээдэс ээ, маргааш, та болон танай Хуврагийн Чуулган миний өргөн барих унд зоогийг минь хүлээн авч болох сон болов уу?” гэхэд Будда анир чимээгүй байдлаараа түүнийг хүлээн зөвшөөрөв.

[408] *Pāvā*—“Пааваа”. Малла нарын нутагт байсан эртний хот. Жайн шашны төв байсан гэж үздэг (BS).

[409] *Cunda*—“Чунда”. Зарим эхэд Кунда гэж галигласан байна. Төмрийн дархны хүү, дархан хүн.

Дараа нь Буддаг зөвшөөрснийг ойлгосон Чунда дархан суудлаасаа босож бөхийгөөд, Буддаг баруун гар талаараа хүндэтгэлтэйгээр хэдэнтээ тойроод гарч одов.

Тэр шөнө өнгөрч, Чунда дархан өөрийн гэртээ, амт шимттэй хоол ундны дээжийг тусгайлан зэхэж, шинээр чанаж болгосон идээ зоогийг засаж бэлдэв. Тэгээд тэр өглөө тэд зоогийн цаг болоход ийн сонордуулав:

“Зоогийн цаг боллоо. Готама Багш аа, идээ унд бэлэн болов.”

Будда бүрэн орхимжоо өмсөн, бадрын аягаа аваад, Хуврагийн Чуулганы хамтаар Чундагийн өргөө гэрт морилж, тараан бэлтгэсэн суудалд сууцгаалаа.

Ийнхүү бэлдсэн суудалд суусныхаа дараа Чунда дарханд хандан Будда:

“Чунда дархан минь, зөөлрүүлж чанасан гахайн махаараа[410] намайг дайлна уу. Харин Хуврагийн Чуулганыг бусад бэлдсэн хоолоороо дайлна уу.” гэв.

“Тэгье ээ, Эрхэм Багш аа.” гэж Чунда дархан хариулав. Ингээд Чунда дархан Буддад зөөлрүүлж чанасан гахайн махыг барин, харин Хуврагийн Чуулганд бусад шинэхэн чанаж болгосон амтат идээ зоогоор үйлчлэв.

Будда идээ зоогоо өндөрлөөд, гар болон аягаа цэвэрлэж дуусахад, Чунда доогуур суудалд түүний дэргэд очин суув.

Тэгээд дараа нь Чунда дарханд хандан Будда:

“Чунда, зөөлрүүлж чанасан гахайн махны үлдэгдлийг миний олж харж чадахааргүй нүхэнд аваачиж хаяад булаарай. Бурхад, Чөтгөр, Тэнгэр, даянч, бярман хийгээд хар хүмүүсийн амьдран буй энэ хорвоо дэлхий дээр үүнийг зохистой шингээж чадах хүн, Буддагаас өөр байгааг би лав олж харахгүй байна.” хэмээн хэлэв.

“Тэгье ээ, Эрхэм Багш аа.” гэж Чунда дархан хариулаад зөөлрүүлж чанасан гахайн махны үлдэгдлийг хол нүхэнд хаяж булаад, Будда дээр ирэн түүнд мөргөөд, түүний хажууд суув. Чундаг нэг талд нь сууж байхад Будда түүнд Сургаал номын тухай ярьж, зааж, түүнийг сэрээж, урам зориг өгч, түүнд ухаарал хайрлав. Дархан Чунда Буддагаар заалгуулаад, сэргээд, урам зориг, ухаарал аваад, Сургаал номын тухай тэрхүү яриаг сонссоныхоо дараа суудлаасаа босон явж одлоо.

(...)

---

410 *Sūkaramaddava*—“зөөлрүүлж чанасан гахайн мах”. (*sūkara*—гахай; *maddava*—махан хоолыг гал дээр удаан хугацаагаар зөөлрүүлж чанах)

Тэгээд Чунда дархны барьсан хоолыг идсэний дараа Буддагийн биед хүнд зовуурь үүсэж, хүчтэй цусан суулга, үхэхийн наагуур болж буй мэт айхавтар өвдөлт бий болов.[411] Тэгэхэд Будда дүүрэн-анхаарал тунгалаг-оюунаар энэ өвдөлт зовууриййг их хүндээр хүлээж авалгүйгээр давав.

Дараа нь Будда Эрхэм Аанандад хандан:

“Алив, Аананда, Кусинаараа[412] руу дөхье.” гэж хэлэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

> Дархан Чундагийн идээ зоогийг идээд
> Даанч хүндээр өвдсөн гэж би дуулсан.
> Гахайн махан тэрхүү зоогийг идээд
> Газрын холыг туулалгүй Багш өвдсөн.
> Биеийн байдал ийм хүнд байсан ч Будда,
> “Бид Кусинаараа руу явна.” гэсэн гэдэг.

24. Ундны Ус Авчрав (Pānīyāharaṇa)

Ингээд аялан явах зуур Будда замаас гарч, нэгэн модны ёроолд явж очоод, тэнд дөхөж очсоныхоо дараа Эрхэм Аанандад хандан:

“Аананда, нааш ирээд, гадуур орхимжийг дөрөв нугалаад надад бэлдээд өгөөч. Би их ядарсан байна. Аананда, би энд хэсэг суую.” гэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда хариулав. Буддад ийн хариулсны дараа гадуур орхимжийг дөрөв нугалан бэлдэв. Тэгээд Будда тэр бэлдсэн суудалд суув. Будда тэнд сууж байхдаа Эрхэм Аанандад хандан:

“Алив, Аананда, ундны ус авчраач. Би их цангаж байна. Аананда, би ус ууя.” гэв.

Үүнийг хэлсний дараа Эрхэм Аананда Буддад ингэж хэлэв:

“Дөнгөж сая, эрхэм ээ, бидний хажуугаар таван зуу орчим хөсөг тэрэг бүхий цуваа өнгөрч, тэдний тэрэгний хүрд дугуйд, энэ урсаж буй жижиг горхи бужигнаж, нэлээн булингартсан байна. Какуттхаа гол тун холгүй, тунгалаг устай, сайхан устай, сэрүүн устай, цэвэр устай, голын эрэг нь үзэсгэлэнтэй, үнэхээр сайхан. Будда та тэнд ундны ус ууж, гар хөлөө сэрүүцүүлж болно шүү дээ.” гэхэд:

---

411 Орчин цагийн зарим судлаачид гахайн махан хоолноос үүдсэн гэж ойлгож болох Буддагийн эл өвчин эмгэгийг (эсвэл хордлого) судрын үйл явдалд дүгнэлт хийснээр, Гэдэсний үхжилт үрэвсэл (анг. *necrotizing enteritis*) эсвэл Гэдэсний цочмог ишеми (анг. *acute mesenteric ischemia*) хэмээн таамаглан оношилдог байна.

412 *Kusinārā*—“Кусинаараа” (сам. *Kuśinagara*). Маллачуудын нийслэл, эртний хот. Өнөөгийн Энэтхэгийн *Kushinagar* дүүргийн *Kushinagar* хот буюу Будда Нирваанд одсон газар.

Будда хоёр дахь удаагаа Эрхэм Аанандад хандан:

“Алив, Аананда, ундны ус авчраач. Би их цангаж байна. Аананда, би ус ууя.” гэж хэлэв.

Эрхэм Аананда хоёр дахь удаагаа Буддад ингэж хэлэв:

“Дөнгөж саяа, эрхэм ээ, бидний хажуугаар таван зуу орчим хөсөг тэрэг бүхий цуваа өнгөрч, тэдний тэрэгний хүрд дугуйд, энэ урсаж буй жижиг горхи бужигнаж, нэлээн булингартсан байна. Какуттхаа гол тун холгүй, тунгалаг устай, сайхан устай, сэрүүн устай, цэвэр устай, голын эрэг нь үзэсгэлэнтэй, үнэхээр сайхан. Будда та тэнд ундны ус ууж, гар хөлөө сэрүүцүүлж болно шүү дээ.” гэхэд:

Будда гурав дахь удаагаа Эрхэм Аанандад хандан:

“Алив, Аананда, ундны ус авчраач. Би их цангаж байна. Аананда, би ус ууя.” гэж хэлэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда хариуллаа.

Буддад ийн хариулсны дараа аяга аваад, тэр жижиг горхи руу явав. Тэгэхэд хөсөг тэрэгний хүрд дугуйд бужигнаж, нэлээн булингартсан байсан тэр жижигхэн горхины ус Эрхэм Аанандаг очиход, тув тунгалаг, огтоос булингаргүй болсон урсаж байлаа.

Тэгэхэд Эрхэм Аанандад:

“Үнэн гайхамшигтай, үнэхээр гайхамшигтай юм. Буддагийн оюун билгийн хүч, агуу чадлаар, тэдгээр хөсөг тэрэгний хүрд дугуйд бужигнаж, нэлээн булингартсан байсан тэр жижигхэн горхины ус намайг очиход тув тунгалаг, огтоос булингаргүй болон урслаа.” гэсэн бодол орж ирэв.

Нэг аяга ус уусны дараа, тэрбээр Буддад дээр дөхөж очоод, түүнд хэлэв:

“Үнэн гайхамшигтай, үнэхээр гайхамшигтай юм, Буддагийн оюун билгийн хүч, агуу чадлаар, тэдгээр хөсөг тэрэгний хүрд дугуйд бужигнаж, нэлээн булингартсан байсан тэр жижигхэн горхины ус намайг очиход тув тунгалаг, огтоос булингаргүй болон урслаа. Ундны усаа уугаарай, Ерөөлтэй Нэгэн минь! Ундны ус уугаарай Ариун Багш минь!”

Ингээд Будда горхины усыг уув.

25. Малла Пуккусагийн Түүх (Pukkusamallaputtavatthu)

Харин яг тэр үед Аалаара Каалаамагийн[413] шавь, малла[414] хүн болох Пуккуса гэгч Пааваагаас Кусинаараа хүрэх төв замаар явж байв. Тэгээд Пуккуса Буддаг нэгэн модны ёроолд сууж байхыг харав.

---

413 *Āḷāra Kālāma*—“Аалаара Каалаама” (сам. *Arāḍa Kālāma*). Даянч, бясалгалын багш тэр ‘даянч бадарчин’ (па. *samaṇa*; сам. *śramaṇa*) урсгалын төлөөлөл ба даянч болж гэрээ орхисон Сиддхаттха Готамагийн анхны багш нь байлаа.

414 *Mallaputto*—“Малла” хүн. Маллачууд бол дайчин *Khattiya* омгийн, бүгд найрамдах засаглалтай, тухайн цагийн хүчирхэг 16 хаант улсын (*Mahajanapadas*) нэг нь.

Түүнийг хараад Будда дээр ирээд, түүнд ойртож ирээд, түүнд мөргөснийхөө дараа нэг талд нь суув. Нэг талд нь сууж байхдаа Пуккуса Буддад ингэж хэлэв:

“Эрхэм ээ, гайхамшигтай юм. Эрхэм ээ, сахилтан, даянч хүмүүс, Эрхэм Багш аа, ийм амар амгалан амьдарч байгаа нь юутай сайхан хэрэг вэ. Эрт дээр нэгэн цагт, Аалаара Каалаама өөрийн явж байсан төв замаас гарч, холгүйхэн нэг модны ёроолд суугаад өдрийг өнгөрөөсөн юм. Дараа нь, Эрхэм ээ, Аалаара Каалаамагийн дэргэдүүр таван зуу орчим хөсөг тэрэг өнгөрлөө. Эрхэм ээ, тэгэхэд тэдгээр хөсөг тэрэгний ард явж байсан нэгэн хүн, Аалаара Каалаама дээр ойртож ирээд, Аалаара Каалаамад ингэж хэллээ:

‘Эрхэм ээ, таван зуу орчим хөсөг өнгөрч байгааг та харсангүй гэж үү?’

‘Би харсангүй ээ, найз минь.’

‘Гэхдээ эрхэм ноёнтон минь, та чимээг нь сонсоогүй юм уу?’

‘Би чимээг нь сонссонгүй, найз минь.’

‘Тэгвэл эрхэм ноёнтон, та унтаж байсан хэрэг үү?’

‘Би унтаагүй байлаа, найз минь.’

‘Тэгвэл эрхэм ноёнтон, та сэрүүн байсан юм уу?’

‘Тийм ээ, найз минь.’

‘Тэгээд, эрхэм ноёнтон та, ухаантай, сэрүүн байсан ч гэсэн таван зуун хөсөг тэрэг маш ойрхон зөрж өнгөрөхөд тэднийг харсангүй, чимээг нь ч сонссонгүй! Эрхэм ноёнтон минь, давхар орхимж чинь хүртэл тоос шороонд дарагдсан байна шүү дээ!’

‘Тийм ээ, найз минь.’ гэсэн юм.

Тэгэхэд тэр хүнд:

‘Сахилтан даянч хүмүүс үнэхээр ийм амар амгалан амьдарч байгаа нь гайхалтай, энэ үнэхээр гайхалтай хэрэг юм. Учир нь ухаантай, сэрүүн байсан ч гэсэн таван зуун хөсөг тэрэг маш ойрхон зөрж өнгөрөхөд тэднийг харсангүй, чимээг нь ч сонссонгүй!’ гэсэн бодол буусан байдаг.

Тэгээд тэр хүн Аалаара Каалаамад итгэх гүнзгий итгэлийг олоод, тэрбээр цаашлан одсон билээ.” гэхэд Будда:

“Тэгвэл одоо та юу гэж бодож байна, Пуккуса, аль нь хэцүү бол:

Хэн нэгэн ухаантай, сэрүүн байсан ч гэсэн таван зуун хөсөг тэрэг маш ойрхон зөрж өнгөрөхөд тэднийг харахгүй, чимээг нь ч сонсохгүй байхуу, эсвэл ухаантай, сэрүүн байсан ч гэсэн, тэнгэр бурхад бороо оруулж, тэнгэр бурхад аадар буулгаж, цахилгаан цахиулж, аянгаар ниргэсэн ч үүнийг харахгүй, чимээг нь сонсохгүй байж чадах тэр түвшинд очих, хоёрын аль нь хэцүү бол?”

“Яаж тэр билээ, эрхэм ээ? Таван зуун хөсөг, зургаан зуун хөсөг, долоон зуун хөсөг, найман зуун хөсөг, есөн зуун хөсөг, мянган хөсөг тэрэгний ялгаа гэж юу байх билээ дээ? Ухаантай, сэрүүн байсан ч гэсэн, тэнгэр бурхад бороо оруулж, тэнгэр бурхад аадар буулгаж, цахилгаан цахиулж, аянгаар ниргэсэн ч үүнийг харахгүй, чимээг нь сонсохгүй байж чадах хийгээд тэр түвшинд очих бол мэдээж хамаагүй илүү хэцүү нь шүү дээ.” гэхэд Будда:

“Нэгэн удаа, Пуккуса, би Аатумаагийн[415] ойролцоо Чимэгт Өргөөнд[416] амьдарч байлаа. Харин яг тэр үед тэнгэр бурхад бороо оруулж, тэнгэр бурхад аадар буулгаж, цахилгаан цахиулж, аянгаар ниргэж, Чимэгт Өргөөнөөс холгүйхэн байсан тариачин ах дүү хоёр, дөрвөн үхрийнхээ хамт өөд болсон юм. Дараа нь Пуккуса, Аатумаагаас маш олон хүн ирж, тариачин ах дүү хоёр, дөрвөн үхрийн хамт өнгөрсөн тэр газар руу очицгоов.

Тэгээд Пуккуса, тэр үед би, Чимэгт Өргөөний төв хаалганы дэргэд задгай агаарт алхаж байлаа. Тэгтэл тэр олны дундаас нэг хүн над дээр дөхөж ирээд мөргөсний дараа нэг талд минь зогсов. Пуккуса, тэнд зогсож байхдаа би тэр хүнээс ингэж асуулаа:

‘Найз минь, яагаад ийм олон хүмүүс энд цугларсан юм бэ?’

‘Дөнгөж сая, Эрхэм ээ, тэнгэр бурхад бороо оруулж, тэнгэр бурхад аадар буулгаж, цахилгаан цахиулж, аянгаар ниргэж, тариачин ах дүү хоёр, дөрвөн үхрийнхээ хамт өөд болжээ, тэгээд энд энэ олон хүн цугларсан билээ. Харин та хаана байсан юм бэ? Эрхэм ээ.’

‘Би яг энд байсан, найз минь.’

‘Тэгвэл Эрхэм ээ, та энэ явдлыг харсан уу?’

‘Би хараагүй ээ, найз минь.’

‘Тэхдээ Эрхэм ээ, та энэ чимээг сонссон уу?’

‘Би чимээ сонссонгүй, найз минь.’

‘Тэгвэл Эрхэм ээ, та унтаж байсан юм уу?’

‘Би унтаагүй байсан, найз минь.’

‘Тэгвэл Эрхэм ээ, та сэрүүн байсан юм уу?’

‘Тийм ээ, найз минь.’

‘Тэгвэл, Эрхэм ээ, хэдийгээр тэнгэр бурхад бороо оруулж, тэнгэр бурхад аадар буулгаж, цахилгаан цахиулж, аянгаар ниргэж байхад, ухаантай, сэрүүн байсан та үүнийг хараагүй, чимээг нь сонсоогүй байж!’

‘Тийм ээ, найз минь.’

---

[415] *Ātumā*—“Аатумаа”. Тосгон эсвэл газрын нэр.

[416] *Bhusāgāre*—“Чимэгт Өргөө” (MPA).

Тэгэхэд тэр хүнд:

‘Сахилтан даянч хүмүүс үнэхээр ийм амар амгалан амьдарч байгаа нь гайхалтай, энэ үнэхээр гайхалтай хэрэг юм. Учир нь ухаантай, сэрүүн байсан ч гэсэн Тэнгэр Бурхад бороо оруулж, Тэнгэр Бурхад аадар буулгаж, цахилгаан цахиулж, аянгаар ниргэж байхад ч тэднийг харсангүй, чимээг нь ч сонссонгүй!’ гэсэн бодол буусан байдаг.

Тэгээд тэр хүмүүн, надад итгэх гүн итгэлийг олоод, намайг хүндэтгэн хэдэнтээ тойроод, цаашлан одсон билээ.”

Үүнийг хэлсний дараа Пуккуса Буддад ингэж хэлэв:

“Эрхэм ээ, Аалаара Каалаамад өгсөн өөрийн итгэлээ би, хуй салхи адил үлдэн хөөж, хурдан урсах голын адил угаан арчиж байна.

Гайхалтай, Готама Багш аа! Үнэхээр гайхалтай! Хөмөрснийг эргүүлж, нуугдсаныг илчилж, төөрснийг замчлах мэт, тас харанхуйд дэнлүү асааж, хараа сайтай хүн тэнд юу буйг олж харахын адил, Готама багш надад олон янз аргаар сургаал номоо ойлгомжтой болгож өглөө.

Миний бие, Готама багш, түүний Сургаал, Хуврагийн Чуулган гурвын нөмөрт очмуй. Энэ өдрөөс эхлэн, Готама багш та намайг насан туршдаа, хар хүний сахилтан, өөрийн тань үнэнч шавь болсон гэдгийг санан дурсах болтугай.” гэв.

Ингээд Пуккуса өөрийн нэг хүндээ хандан:

“Алив чи, надад өмсөхөд бэлэн, алтлаг өнгийн орхимжийг аваад ирээч.” гэв.

“Тэгье ээ, эрхэм ноёнтон.” гэж тэр хүн Пуккуса хэлээд, өмсөхөд бэлэн, алтлаг өнгийн хос орхимжийг авчирлаа. Тэгээд Пуккуса тэрхүү өмсөж хэрэглэхэд бэлэн, алтлаг өнгийн хос орхимжийг Буддад бариад:

“Эрхэм Багш минь, намайг энэрч хайрлан, өмсөж хэрэглэхэд бэлэн, алтлаг өнгийн энэ хос орхимжийг минь хүлээн авна уу.” гэхэд:

“Тэгвэл Пуккуса, намайг нэгээр нь, Аанандаг нөгөөгөөр нөмрүүлнэ үү.” хэмээн хэлэхэд,

“Тэгье ээ. Эрхэм Багш аа.” гэж Пуккуса хэлээд Буддаг нэгээр нь, Эрхэм Аанандаг нөгөөгөөр нөмөргөв. Дараа нь Будда Пуккусад Сургаал номын тухай ярьж, түүнийг сэрээж, түүнд урам зориг өгч, түүний сэтгэлийг сэргээв. Үүний дараа нь Пуккуса Буддатай Сургаал номын тухай яриагаа дуусгаад, суудлаасаа босож, түүнд мөргөж, түүнийг хүндэтгэлтэйгээр хэдэнтээ тойрсны дараа явж одов.

Энэ явдлын дараа, Пуккусаг явсан хойно, Эрхэм Аананда өмсөж хэрэглэхэд бэлэн, алтлаг өнгийн тэр хос орхимжийг Буддад барьсан бөгөөд Буддагийн бие дээр тавихад, тэрхүү орхимжийн гялбаа туяа нь үгүй болов уу гэмээр болов.

Ингээд Эрхэм Аананда Буддад:

“Гайхалтай юм, Эрхэм Багш аа, гайхалтай юм, Буддагийн арьс цэвэр тунгалаг өнгөтэй ажгуу. Эрхэм Багш аа, өмсөж хэрэглэхэд бэлэн болсон өнгөлөг алтлаг тэр хос орхимжийг Буддагийн бие дээр тавихад, тэрхүү орхимжийн гялбаа туяа нь үгүй болов уу гэмээр харагдах аж.” гэв.

“Аананда аа, яг чиний ажигласан шиг, Будда нарын биеийн арьс хоёр тохиолдолд цэвэр тунгалаг өнгөөр харагддаг билээ. Ямар хоёр тохиолдол байх бол?

Аананда, төгс гэгээрлийг олж, нойрноос нэгэнт сэрсэн тэр шөнө болон Эцсийн Нирваанд, ор мөргүй нэгмөсөн одохын өмнөх шөнө хоёрт билээ. Энэ хоёр тохиолдолд Буддагийн арьс цэвэр тунгалаг өнгөөр харагддаг билээ. Өнөөдөр, Аананда, энэ шөнийн төгсгөл болоход Кусинаараагийн ойролцоо, Упаваттана[417] дахь маллачуудын төгөлд, Ихэр Сал[418] Моддын дунд Будда Эцсийн Нирваанд одох болно.

Алив, Аананда, Какуттхаа гол руу дөхье.” гэхэд:

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

(...)

Дараа нь Будда, асар олон хувраг нэгдсэн Хуврагийн Чуулганы хамтаар Какуттхаа голын эрэг дээр очиж, Какуттхаа гол руу орж, голын усанд орж, голын уснаас ууж, буцаж гарсны дараа манго төгөлд ирээд, дөхөж ирснийхээ дараа хувраг Чундакад хандан:

“Алив, Эрхэм Чундака, надад гадуур орхимжийг дөрөв нугалаад бэлдээч. Би их ядарсан байна. Чундака, би хэвтье.” гэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж хувраг Чундака Буддад хэлсний дараа, гадуур орхимжийг тэрээр дөрөв нугалан бэлдэв. Дараа нь Будда арслан байрлалд, баруун гар тал дээрээ хажуулдан хэвтээд, нэг хөлөө нөгөө хөл дээрээ тавиад, дүүрэн-анхааралтайгаар, тунгалаг-оюунтайгаар, оюун бодолдоо сэрэх босох тухайгаа санан бэлдэв. Хувраг Чундака яг тэнд Буддагийн өмнө суув.

Тунгалаг, цэнгэг, рашаан усыг
Какуттхаа голоос очиж уув
Туйлдаж ядарсан Багш
Тамир тэнхээг олов.
Горхи уснаас гарч ирээд
Голд нь нэгдэв хуврагууддаа
Манай үеийн номын-хүрд эргүүлэгч
Манго төглийг зорин хөдлөв.
Орхимж дэлгээч, би түр хэвтье гэж
Ойрын хувраг Чундакагаас хүсэв.
Төгс Гэгээнтэн ийн хүсэхэд

---

417 *Upavattana*—“Упаваттана”. Кусинаараагийн ойролцоох сал моддын төгөлд оноосон нэр.

418 *Sāla*—“Сал” (лат. *shorea robusta*). Халуун орны бүсийн, жимсэлдэг, 5 метрээс өндөр ургадаг (саала эсвэл сала) мод.

Түргэхэн үүнийг гүйцэлдүүлэв.
Чухам алжаасан Багш тэнд амарч
Чундака өмнө нь нам гүмхэн суув.

Дараа нь Будда Эрхэм Аанандад хандан:

“Аананда, магадгүй хэн нэгэн, Чунда дарханд ийм үгсийг хэлж болох юм:

‘Чи өөдлөхгүй, найз минь. Чамд их л нүгэл болох болно. Будда чамаас авсан сүүлчийн өглөгийн хоолоо идсэний дараа Эцсийн Нирваанд одсон.’ Гэх мэтээр түүнд гэмших харамсах сэтгэлийг бий болгож болох юм. Хэрэв Чунда дарханд гэмших харамсах сэтгэл төрвөл Аананда түүний тэр бодлыг ингэж хэлж болиулаарай:

‘Найз Чунда минь, чиний хувьд бол энэ буян юм. Будда сүүлчийн өглөгийн хоолоо чамаас авч идсэний дараа Эцсийн Нирваанд одсон нь чамд буян болох билээ. Би Буддагийн яг амнаас нь үүнийг сонссон. Найз Чунда минь, би үүнийг яг түүнээс сонсоод, ийн мэдэж авсан:

“Үр жимс, өгөөж буян нь ижилхэн бөгөөд бусад өргөлийн хоолноос илүү үр дүн, өгөөж буянтай хоёр өргөлийн хоол гэж байдаг.

Ямар хоёр өргөлийн хоол байх вэ?

Идсэний дараа төгс гэгээрлийг олж, нойрноос нэгэнт сэрэх тэр өглөгийн хоол[419] болон мөн идсэнийхээ дараа Будда ор мөргүйгээр Эцсийн Нирваанд оддог тэр өглөгийн хоолнууд билээ.

Эдгээр нь үр дүн, өгөөж буян нь ижилхэн бөгөөд бусад өргөлийн хоолноос илүү үр дүн, өгөөж буянтай хоёр өргөлийн хоол билээ.”

Чунда дархан урт наслах буян хураалаа. Чунда дархан үзэсгэлэн болох буян хураалаа. Чунда дархан аз жаргалд умбах буян хураалаа. Алдар нэрийг олох буян хураалаа. Диваажингийн орны буян хураалаа. Дээд зиндааны буян хураалаа.’

Хэрэв Чунда дархан харамсаж гэмших юм бол, Аананда, ингэж түүний тийм бодлыг үргээх учиртай юм шүү!” гэв.

Мөн энэ мөчид Будда ийм нэгэн үгийг хэлэв:

“Өглөг хоол өгсөн хүний буяны хэмжээ өсдөг бол
Өөрийгөө хатамжилсан хүний өс хонзон өсдөггүй.
Билэг ухаантай хүмүүн муу муухайгаас ангижран салахдаа
Биеийн жаргал, хорсол, төөрөгдлийг устгаж тэр ангижирдаг.”

Дөрөвдүгээр уншлага хэсэг өндөрлөв.

419 Буддаг Гэгээрэхийн өмнөхөн Сужаатаа (*Sujātā*) бүсгүйн өгсөн сүүтэй будааг (*khīra*) хэлсэн бололтой (Орч).

26. Ихэр Сал Модод (Yamakasālā)

Дараа нь Будда Эрхэм Аанандад хандан:

“Алив Аананда, Алтан голын цаад эрэг, Кусинаараа, Упаваттана дахь маллачуудын Ихэр Сал Модод руу дөхье.” гэж хэлэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда хариулав.

Ингээд Будда бүх Хуврагийн Чуулганы хамтаар Алтан голын[420] цаад эрэг, Кусинаараа, Упаваттана дахь маллачуудын Ихэр Сал Модод руу хөдлөөд, хэсэг явсны дараа Эрхэм Аанандад хандан:

“Алив, Аананда, нааш ир. Надад хойд зүг, Ихэр Сал Моддын тийшээ хараад хэвтэж болох дэвсгэр бэлдээч. Би их ядарсан байна. Аананда, би хэвтье.” гэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда хэлээд Буддад хойд зүг, Ихэр Сал Моддын тийшээ хараад хэвтэж болох дэвсгэр бэлдэв. Тэгээд Будда нэг хөлөө нөгөө хөл дээрээ тавиад, арслан байрлалд баруун талаа дараад, дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтай хэвтэв.

Харин яг тэр үед Ихэр Сал Модод цаг улирал нь болоогүй байхад ид цэцэглэж дэлбээлж байх бөгөөд тэр цэцэгс Буддагийн бие дээр бутран унаж, Буддагийн бие дээрээс бороо мэт асгарч, түүнд сөгдөн мөргөх мэт түүний өмнө ханаран унах аж. Ариун Мандарваа[421] цэцэгс, агаар тэнгэрээс бужигнан бууж, Буддагийн бие дээр бутран унаж, Буддагийн бие дээрээс бороо мэт асгарч, түүнд сөгдөн мөргөх мэт түүний өмнө ханаран унах аж. Ариун Зандан[422] модны анхилуун нунтаг агаар тэнгэрээс бужигнан бууж, Буддагийн бие дээр бутран унаж, Буддагийн бие дээрээс бороо мэт асгарч, түүнд сөгдөн мөргөх мэт түүний өмнө ханаран унах аж. Тэнгэр диваажингийн хөгжим аялгуу, түүнийг магтан дуулж тэртээх тэнгэрт эгшиглэх аж. Тэнгэр диваажингийн дуу хуур, түүнийг магтан дуулж тэртээх тэнгэрт эгшиглэх аж.

Тэгэхэд Будда Эрхэм Аанандад хандан:

“Ихэр Сал Модод улирал нь болоогүй байхад, ид цэцэглэн дэлбээлж, Буддагийн бие дээр бутран унаж, Буддагийн бие дээрээс бороо мэт асгарч, сөгдөн мөргөх мэт түүний өмнө ханаран унаж байна. Ариун Мандарваа цэцэгс, агаар тэнгэрээс бужигнан бууж, Буддагийн бие дээр бутран унаж, Буддагийн бие дээрээс бороо мэт асгарч, түүнд сөгдөн мөргөх мэт түүний өмнө ханаран унаж байна. Ариун Зандан модны анхилуун нунтаг агаар тэнгэрээс бужигнан бууж, Буддагийн бие дээр бутран унаж, Буддагийн бие дээрээс бороо мэт асгарч, түүнд сөгдөн мөргөх мэт түүний өмнө ханаран унаж байна. Тэнгэр диваажингийн хөгжим аялгуу, түүнийг магтан дуулж тэртээх тэнгэрт эгшиглэж байна. Тэнгэр диваажингийн дуу хуур, түүнийг магтан дуулж тэртээх тэнгэрт эгшиглэж байна.

---

420 *Hiraññavatiyā*—“Алтан гол”. Үгийн утга “алттай гол”. Өнөөгийн *Kushinagar* орчмоор дайрч өнгөрдөг гол.

421 *Mandāravapupphāni*—“Мандарваа” цэцэгс (анг. *coral tree*).

422 *Candanacuṇṇāni*—“Зандан” (лат. *santalum album.* анг. *sandalwood*).

Гэхдээ Аананда, ийм маягаар Буддаг ингэж хүндэлж, ингэж мөргөж, ингэж биширч, ингэж өргөмжилж, ингэж дээдлэн шүтэх учиргүй юм. Аананда, тэгвэл харин тэр хувраг, эмэгтэй хувраг, шавь сахилтан эрэгтэй, шавь сахилтан эмэгтэй хүмүүс, Сургаал номыг ёсчлон дагаж, Сургаал номыг чухамхүү үнэн зөвөөр бясалгаж дадуулж, Сургаал номд нийцүүлэн тааруулж амьдардаг бол, тэр л харин Буддаг үнэнхүү хүндэлж, мөргөж, биширч, өргөмжилж, дээдлэн шүтэж байгаа хамгийн дээд хүндлэл болох билээ.

Тиймээс, Аананда, Сургаал номыг ёсчлон дагаж, Сургаал номыг чухамхүү үнэн зөвөөр бясалгаж, Сургаал номд нийцүүлэн амьдарч, өөрийгөө дадуулах хэрэгтэй юм.

27. Ахмад Хувраг Упаваана (Upavāṇatthera)

Харин яг тэр үед ахмад хувраг[423] Упаваана Буддагийн өмнө зогсож, Буддаг дэвүүрээр сэрүүцүүлж байв. Дараа нь Будда Эрхэм Упаваанаг зогсоогоод:

"Алив, хувраг минь яв, миний өмнө зогсох хэрэггүй" гэв.

Тэгэхэд Эрхэм Аананда,

"Эрхэм Упаваана Буддагийн туслахаар удаан хугацаанд ойр байж, ойрхон амьдарч ирсэн. Тэгээд эцсийн мөчид Будда, Эрхэм Упаваанаг явуулж, 'Алив, хувраг минь яв, миний өмнө зогсох хэрэггүй.' гэж хэлэх нь ямар учиртай юм бол? Ямар шалтгаанаар Будда Эрхэм Упаваанаг явуулж: 'Алив, хувраг минь яв, миний өмнө зогсох хэрэггүй.' гэж хөөх маягтай байгаа хэрэг юм бол?" хэмээн бодлоо.

Дараа нь Эрхэм Аананда Буддад хандан:

"Эрхэм Упаваана Буддагийн туслахаар удаан хугацаанд ойр байж, ойрхон амьдарч ирсэн. Тэгээд эцсийн мөчид та, эрхэм Упаваанаг явуулж: 'Алив, хувраг минь яв, миний өмнө зогсох хэрэггүй.' гэж хэлэх нь ямар учиртай юм билээ?" гэхэд:

"Аананда, энэ хорвоо ертөнцийн арван нарны аймгийн[424] бараг бүх бурхад, Буддаг харахаар бууж ирэн, Кусинаараа болон Упаваттана дахь маллачуудын Ихэр Сал Моддын эргэн тойронд хаа сайгүй, зуун бээр[425] хүртэлх газарт завсар зайгүй, тэр ч байтугай үсний үзүүр ч багтах зайгүй, хүчирхэг бурхад цугларчээ. Аананда тэдгээр бурхад:

---

[423] *Thera*—"ахмад хувраг". Арваас олон жил сахил сахисан ахмад хуврагийг дуудах нэр. *Upavāṇatthera*—Ахмад хувраг Упаваана. Ааннандагаас гадна, ахмад хувраг Упаваана нь мөн Буддагийн ойрын туслах нь байсан аж.

[424] *Dasasu lokadhātūsu*—"арван нарны аймгийн". Үгчилбэл, "арван дэлхий-тогтолцоо". Зарим англи орчуулгад "*ten solar systems*" гэжээ (BS).

[425] *Dvādasa yojanāni*—"зуун бээр" (үгчилбэл, "12 *yojanā*"). Нэг *yojanā* нь ойролцоогоор 7-10 бээр (анг. *mile*), буюу 11-16 км орчим зай.

‘Бид Буддаг харахаар алс холоос ирсэн. Чухамхүү тун ховор тохиолдлоор, үнэнхүү маш цөөн тоогоор энэ дэлхийд төрдөг, Ерөөлтэй Нэгэн, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Буддаг энэ шөнийн төгсгөлөөр Эцсийн Нирваанд одох гэж буй энэ цагт, харин энэ сүрхий хувраг Буддагийн урд зогсож халхлаад, бидэнд Буддагийн Эцсийн Нирваанд одох мөчийг харуулахгүй нь’ хэмээн гомдол мэдүүлж байна.

“Будда та ямар төрлийн бурхдыг ярина вэ?”

“Аананда, энэ дэлхийн талаарх танин-мэдэхүйтэй[426], тэнгэрийн мандалд орших бурхад байх ба тэд үсээ зулгаан уйлж, гараа савчин савж унаж, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн:

‘Будда арай эрт Эцсийн Нирваанд одох нь. Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одох нь. Энэ ертөнцийн Мэлмий[427] болсон тэр, Эцсийн Нирваанд ингээд эрт одох нь!’ гэцгээж байна.

Аананда, энэ дэлхийн талаарх танин-мэдэхүйтэй, газар дэлхий дээр орших бурхад[428] байх ба тэд үсээ зулгаан уйлж, гараа савчин савж унаж, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн:

‘Будда арай эрт Эцсийн Нирваанд одох нь. Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одох нь, энэ ертөнцийн Мэлмий болсон тэр Эцсийн Нирваанд ингээд эрт одох нь!’ гэцгээж байна.

Гэвч дур-хүслээс салж чадсан зарим бурхад, дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтай оршиж, энэ бүгдэд тайван хандаж:

‘Сэдэхүй-цогцлохуй бүхэн мөнхийн-бус. Үүнээс өөрөөр яах байсан гэж?[429]’ хэмээн бодож байна.” гэж хэлэв.

28. Сүсэг Бадраах Дөрвөн Газар (Catusaṁvejanīyaṭhāna)

“Урьд нь, Эрхэм Багш аа, хуврагууд борооны улирлын бясалгалд суусан хойноо, Буддатай уулзахаар ирээд, бид тэдгээр бясалгагч хуврагуудыг хүлээн авч, зохион байгуулж, Буддатай уулзуулдаг байсан. Харин Буддаг өөд болсны дараа, Эрхэм Багш аа, бид тэдгээр бясалгагч хуврагуудыг хүлээн авч, зохион байгуулж, Буддатай уулзуулж чадахгүй нь дээ.” гэхэд,

“Аананда, сайн явдалтай, итгэл-үнэмшилтэй хүмүүн, тэрхүү газрыг үзэхэд, итгэл сүсэг, урам зориг төрөх дөрвөн газар байдаг билээ.

---

426 *Pathavīsaññiniyo*—“дэлхийн талаарх танин-мэдэхүйтэй”. Энэ дэлхий дээр болж буй үйл явдлыг таньж мэдэж байдаг, Бурхдын олон зиндааны арай доогуур түвшний бодгалиуд энд хамаарна.

427 *Cakkhuṁ loke*—“Мэлмий”. Эсвэл “энэ ертөнцийн Мэлмий”. Энэ үг нь Готама Буддаг нэрлэсэн үг тул томоор бичдэг уламжлалтай (анг. *The Eye*).

428 *Devatā pathaviyaṁ*—“газар дэлхий дээр орших бурхад”. Эсвэл “лус”. Тэнгэрийн мандалд орших бурхдаас арай доогуур зиндаа буюу бурхдын хамгийн доод зиндаа. Эдгээр нь дотроо: модны бурхад, хадны бурхад, усны бурхад г.м. ялгаатай. Энэ үгийг зарим тохиолдолд “лус” гэж оруулсан болно.

429 *Taṁ kutettha labbhā*—“Үүнээс өөрөөр яах байсан гэж?”. Утгачилбал, “мөнхийн юм энэ хорвоод олдоно гэж үү?”

Ямар дөрвөн газар бол?

1. Аананда, ‘Будда энэ газар[430] мэндэлсэн билээ.’ гэж бодоод, тэр газрыг нүдээр үзэхэд, сайн явдалтай, итгэл-үнэмшилтэй хүмүүний итгэл сүсэг, урам зоригийг төрүүлэх юм.

2. Аананда, ‘Будда энэ газар[431] төгс гэгээрлийг олсон билээ.’ гэж бодоод, тэр газрыг нүдээр үзэхэд, сайн явдалтай, итгэл-үнэмшилтэй хүмүүний итгэл сүсэг, урам зоригийг төрүүлэх юм.

3. Аананда, ‘Будда энэ газар[432] ариун Номын-хүрдийг анхлан эргүүлсэн билээ.’ гэж бодоод, тэр газрыг нүдээр үзэхэд, сайн явдалтай, итгэл-үнэмшилтэй хүмүүний итгэл сүсэг, урам зоригийг төрүүлэх юм.

4. Аананда, ‘Будда энэ газар[433] үлдэх ул мөргүйгээр Эцсийн Нирваанд одсон билээ.’ гэж бодоод, тэр газрыг нүдээр үзэхэд, сайн явдалтай, итгэл-үнэмшилтэй хүмүүний сүсэг, урам зоригийг төрүүлэх юм.

Эдгээр нь, сайн явдалтай, итгэл-үнэмшилтэй хүмүүн, тэрхүү газрыг үзээд, итгэл сүсэг, урам зориг нь төрөх дөрвөн газар билээ.

Итгэл үнэмшилтэй хувраг, эмэгтэй хувраг, сахилтан шавь эрчүүд, сахилтан шавь эмэгтэйчүүд ирээд: ‘Будда энэ газар мэндэлсэн билээ.’, ‘Будда энэ газар төгс гэгээрлийг олсон билээ.’, ‘Будда энэ газар ариун Номын-хүрдийг анхлан эргүүлсэн билээ.’, ‘Будда, энэ газар үлдэх ул мөргүйгээр Эцсийн Нирваанд одсон билээ.’ гэж бодох ба, Аананда, эдгээр ариун газруудад, итгэл бишрэлээр мөргөл үйлдэх аян замдаа өөд болсон хэн ч бай, нас барсны дараа, тэдний бие цогцос нь задрахын цагт, хувьтай сайн дараа төрлийг олж, тэнгэр диваажинд төрөх болно.”

29. Ааналдагийн Асуултууд (Ānandapucchākathā)

“Эрхэм Багш аа, эмэгтэйчүүдийн тал дээр, бид яаж хандах ёстой вэ?”

“Аананда, харахгүй байвал болох юм.”

“Эрхэм Багш аа, тэгвэл тэдэнтэй харц тулгарчихвал, бид яаж хандах ёстой вэ?”

“Аананда, ярихгүй байвал болох юм.”

“Эрхэм Багш аа, тэгвэл тэдэнтэй ярилцах тохиолдол гарвал, бид яаж хандах ёстой вэ?”

“Аананда, дүүрэн-анхаарлыг оршоох хэрэгтэй.”

“Эрхэм Багш аа, бид Буддагийн шарилын тал дээр, бид яаж хандах ёстой вэ?”

---

430 Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба (*Nepal*) Улсын нийслэл Катманду.

431 Энэтхэгийн Бихар мужийн Гаяа дүүрэгт байрлах Бодхгаяа (*Bodhgaya*).

432 Эртний *Isipatana* буюу өнөөгийн Энэтхэгийн *Varanasi*-аас зүүн хойд зүгт, Ганга мөрний эрэг дээрх *Sarnath*.

433 Кушинагар (*Kushinagar*). Өнөөгийн Энэтхэгийн Уттар Прадеш (*Uttar Pradesh*) мужийн Кушинагар дүүргийн хот.

“Аананда, Буддагийн шарилын зан үйлийн ажилд оролцох хэрэггүй. Аананда, чи өөрийнхөө эрхэм дээд зорилгынхоо төлөө л тэмүүл, эрхэм дээд зорилгынхоо төлөө өөрийгөө зориулж, оюун санаагаа огт шантралгүй үүндээ зориулж, эрхэм дээд зорилгын төлөө хичээнгүйлэн зүтгэж амьдрах хэрэгтэй. Буддаг дээдлэн хүндэлдэг, ухаалаг язгууртнууд, ухаалаг брамман нар, ухаалаг хар хүмүүс байна. Тэд Буддагийн шарилыг ёслол хүндэтгэлтэйгээр оршуулах ажлыг хариуцах болно.”

“Эрхэм Багш аа, тэгсэн ч гэсэн бид Буддагийн шарилын тал дээр, бид яаж хандах ёстой юм бэ?”

“Аананда үүн дээр, хүрд-эргүүлэгч хааны[434] шарилтай ижил байдлаар хандана уу.”

“Эрхэм Багш аа, хүрд-эргүүлэгч хааны шарилтай яаж харьцдаг ёстой вэ?”

“Аананда, хүмүүс хүрд-эргүүлэгч хааны шарилыг шинэ маалинган даавуунд ороосны дараа эсгийгээр давхарлан ороогоод, мөн дахин шинэ даавуугаар үүний гадуур ороодог. Үүнийг тус бүр таван зуун удаа давтан хийх ба хааны тэр шарилыг өөр төмөр онгоцтой тосонд дүрж хийнэ. Дараа нь тэд үүнийгээ төрөл бүрийн үнэртэн бүхий өөр нэг онгоцонд хийж битүүмжлээд, хааны шарилыг чандарлаж, олон замын уулзвар дээр суварга босгодог билээ.

Үүнийг тэд хүрд-эргүүлэгч хааныхаа биеийг нь гэж үздэг. Тэд хүрд-эргүүлэгч хааныхаа биеийг хэмээн үздэгтэй адил, Буддагийн биеийг мөн энэ байна гэж үзэж болох юм. Буддад зориулсан суварга олон замын уулзвар дээр байж болно. Тэнд чин сүсгээр, чимэглэл, хүж, үнэртэн өргөх, эсвэл өөрийн сэтгэл дотроо итгэл бишрэлийг бясалган залбирч болох бөгөөд ингэснээр тэдний өөрсдийн алс хэтийн сайн сайхан, аз жаргалын төлөөх үйл нь болох билээ.

30. Суварга Босгох Дөрвөн Хүмүүн (Thūpārahapuggala)

Аананда, үнэ цэнтэй дөрвөн суварга байдаг.

Ямар дөрөв бол?

1. Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда[435],
2. Өөрөө Сэрсэн Будда[436],
3. Төгс Сэрсэн Буддагийн гэгээрсэн шавь хуврагууд,
4. Хүрд-Эргүүлэгч Хаан.

---

434 *Rañño cakkavattissa*—“хүрд-эргүүлэгч хааны”. Энэ хаан бол хүчээр биш, харин ёс суртахуун, Сургаалаар дэлхийг захирдаг нинжин сэтгэлтэй, зөв шударга хаан юм. Түүний засаглал нь түүний хаант улсад амар амгалан, хөгжил цэцэглэлт, ёс суртахууны дэг журмыг авчирна.

435 *Sammāsambuddha*—“Төгс Сэрсэн Будда”. (Дэлгэрэнгүйг Тайлбарт буй Будда-д үз.)

436 *Paccekabuddha*—“Өөрөө Сэрсэн Будда”. (Дэлгэрэнгүйг Тайлбарт буй Будда-д үз.)

Эдгээр хүмүүсийн суварга бол үнэ цэнтэй суварга юм.

Ямар учир шалтгаанаар Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Буддагийн суварга үнэ цэнтэй суварга болдог бол?

Аананда, 'Энэ бол Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Буддагийн суварга юм!' хэмээн бодож, олон хүн сэтгэл санаагаа ариусгаж, зүрх сэтгэлдээ, итгэл бишрэлийг олж, үхсэний дараа бие нь задрахад тэд хувьтай ерөөлтэй газар, тэнгэр диваажинд дараа төрлийг олдог.

Ийм болохоор, Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Буддагийн суварга нь үнэ цэнтэй суварга болдог.

Ямар учир шалтгаанаар Өөрөө Сэрсэн Буддагийн суварга үнэ цэнтэй суварга болдог бол?

Аананда, 'Энэ бол Өөрөө Сэрсэн Буддагийн суварга юм!' хэмээн бодож, олон хүн сэтгэл санаагаа ариусгаж, зүрх сэтгэлдээ, итгэл бишрэлийг олж, үхсэний дараа бие нь задрахад тэд хувьтай ерөөлтэй газар, тэнгэр диваажинд дараа төрлийг олдог.

Ийм болохоор, Өөрөө Сэрсэн Буддагийн суварга нь үнэ цэнтэй суварга болдог.

Ямар учир шалтгаанаар Төгс Сэрсэн Буддагийн гэгээрсэн шавь хуврагуудын суварга үнэ цэнтэй суварга болдог бол?

Аананда, 'Энэ бол Төгс Сэрсэн Буддагийн гэгээрсэн шавь хуврагуудын суварга юм!' хэмээн бодож, олон хүн сэтгэл санаагаа ариусгаж, зүрх сэтгэлдээ, итгэл бишрэлийг олж, үхсэний дараа бие нь задрахад тэд хувьтай ерөөлтэй газар, тэнгэр диваажинд дараа төрлийг олдог.

Ийм болохоор, Төгс Сэрсэн Буддагийн гэгээрсэн шавь хуврагуудын суварга нь үнэ цэнтэй суварга болдог.

Ямар учир шалтгаанаар хүрд-эргүүлэгч хааны суварга үнэ цэнтэй суварга болдог бол?

Аананда, 'Энэ бол хүрд-эргүүлэгч хааны суварга юм!' хэмээн бодож, олон хүн сэтгэл санаагаа ариусгаж, зүрх сэтгэлдээ, итгэл бишрэлийг олж, үхсэний дараа бие нь задрахад тэд хувьтай ерөөлтэй газар, тэнгэр диваажинд дараа төрлийг олдог.

Ийм болохоор, хүрд-эргүүлэгч хааны суварга нь үнэ цэнтэй суварга болдог.

Эдгээр төрлийн дөрвөн хүн, Аананда, суваргатай байх нь үнэ цэнтэй болдог билээ.

31. Ааналдагийн Бишрэм Чанарууд (Ānandaacchariyadhamma)

Эрхэм Аананда зочдын танхимд орж ирээд хаалганы хөндлөвч налаад:

“Намайг мэдэх сурах хэрэгтэй номоо мэдэж сурч дуусаагүй, суралцагч хэвээрээ байхад минь, намайг энэрэн хайрладаг Багш маань, намайг орхиод Эцсийн Нирваанд одох болчихлоо!” хэмээн уйлж суулаа.

Харин тэр үед Будда хуврагуудад хандан:

“Хуврагууд аа, Аананда хаана байна?” гэж асуув.

“Эрхэм Аананда зочдын танхимд орж ирээд хаалганы хөндлөвчийг налан, ‘Намайг мэдэх сурах хэрэгтэй номоо мэдэж сурч дуусаагүй, суралцагч хэвээрээ байхад минь, намайг энэрэн хайрладаг Багш маань, намайг орхиод Эцсийн Нирваанд одох болчихлоо!’ гээд уйлаад сууж байна.” гэв.

Тэгэхэд нь Будда нэг хуврагт хандан:

“Алив яв, хувраг минь. Миний өмнөөс Аананда дээр очоод, ‘Багш, Аананда таныг дуудаж байна.’ гээд хэл.” гэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж тэр хувраг хариулаад, Эрхэм Аананда дээр очоод, тэрээр, ‘Багш, Аананда таныг дуудаж байна.’ гэж хэлэв.

“Тэгье ээ.” гэж Эрхэм Аананда тэр хувpагт хариулаад Будда дээр очоод, түүнд мөргөөд нэг талд нь суув. Нэг талд нь сууж байхад нь Будда Эрхэм Ааннандад хандан:

“Хангалттай. Аананда, бүү харамс, бүү гашууд. ‘Хайр татсан, сэтгэл булаасан бүх юм өөрчлөгдөн хувьсаж, салан холдож, ондоошин хувирдаг биш үү? Төрсөн, бий болсон, сэдэгдсэн-цогцолсон бол эвдрэх Жамтай байхаас бус өөрөөр яана гэж? Аананда. Өөрөөр байх боломжгүй.’ гэж би, өмнө нь чамд заагаагүй гэж үү?

Аананда, чи удаан хугацааны туршид, тус дэмтэйгээр, эелдэг нийцтэйгээр, үнэнч итгэлтэйгээр Буддагийн ойр амьдарч, итгэлтэй, нийцтэй, тустай, эс цуцах, найрсаг бие махбодын үйл, итгэлтэй, нийцтэй, тустай, эс цуцах, найрсаг хэл ярианы үйл, итгэлтэй, нийцтэй, тустай, эс цуцах, найрсаг оюун санааны үйлээрээ, асар их буяныг хийсэн болохоор, Аананда, үтэр түргэн, оюуны-хорлолыг үгүй хийсэн Төгс Гэгээрсэн Нэгэн болохын төлөө өөрийгөө шамдан зориулаарай!” гэв.

Дараа нь Будда хуврагуудад хандан:

“Хуврагууд аа, урьд цагт байсан бүх л Төгс Сэрсэн Будда нарын хэнд нь ч, надад Аананда байсан шиг, гарын туслах эрхэм дээд түшээ нар байсан билээ. Хуврагууд аа, ирээдүй цагт ч мөн адил, бүх Төгс Сэрсэн Будда нарын хэнд нь ч, надад Аананда байсан шиг, гарын туслах эрхэм дээд түшээ нар байх болно. Аананда бол мэргэн ухаантай. Хуврагууд аа, Аананда бол цэцэн ухаантай. Тэрээр, ‘Энэ бол хуврагуудын цаг, энэ бол эмэгтэй хуврагуудын цаг, энэ бол сахилтан шавь эрчүүдийн цаг, энэ бол сахилтан шавь эмэгтэйчүүдийн цаг, энэ бол хаад ноёд, тэдний сайд, өөр шашны багш нар, өөр шашны багш нарын шавь нарын цаг юм.’ гэх зэргээр, Буддатай уулзахад зохистой цаг ийг тэр л сайн мэддэг.

Хуврагууд аа, Аанандагийн хувьд гайхалтай бөгөөд бишрэм дөрвөн чанар байдаг.

Ямар дөрвөн чанар бол?

1. Хуврагууд аа, хэрэв хэсэг хуврag Аанандатай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв Аананда Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл хөөр-баяраар дүүрдэг. Хэрэв Аананда чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

2. Хуврагууд аа, хэрэв хэсэг эмэгтэй хуврag Аанандатай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв Аананда Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл хөөр-баяраар дүүрдэг. Хэрэв Аананда чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

3. Хуврагууд аа, хэрэв хэсэг сахилтан шавь эрчүүд Аанандатай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв Аананда Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл хөөр-баяраар дүүрдэг. Хэрэв Аананда чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

4. Хуврагууд аа, хэрэв хэсэг сахилтан шавь эмэгтэйчүүд Аанандатай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв Аананда Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл хөөр-баяраар дүүрдэг. Хэрэв Аананда чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

Эдгээр нь Аанандагийн дөрвөн гайхалтай бөгөөд бишрэм чанар билээ.

Хуврагууд аа, хүрд-эргүүлэгч хааны хувьд дөрвөн гайхалтай бөгөөд бишрэм чанарууд байдаг билээ. Ямар дөрвөн чанар бол?

1. Хуврагууд аа, хэрэв хэсэг язгууртан, хүрд-эргүүлэгч хаантай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв хаан Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл санаа баясдаг. Хэрэв тэр чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

2. Хуврагууд аа, хэрэв хэсэг бярман, хүрд-эргүүлэгч хаантай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв хаан Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл санаа баясаж, хэрэв тэр чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

3. Хуврагууд аа, хэрэв хэсэг ард иргэд, хүрд-эргүүлэгч хаантай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв хаан Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл санаа баясаж, хэрэв тэр чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

4. Хуврагууд аа, хэрэв хэсэг даяанч, хүрд-эргүүлэгч хаантай уулзахаар очвол, түүнийг хараад тэдний сэтгэл нь сэргэж, хэрэв хаан Сургаал ном хэлбэл тэдний сэтгэл санаа баясаж, хэрэв тэр чимээ аниргүй байвал тэдний сэтгэл хангалуун бус болдог.

Эдгээр нь, хүрд-эргүүлэгч хааны дөрвөн гайхалтай бөгөөд бишрэм чанарууд нь юм.

Яг л үүний адил, Аанандагийн хувьд дөрвөн гайхалтай бөгөөд бишрэм чанарууд байдаг билээ.

32. Махаасудассанагийн Түүх (Mahāsudassanasuttadesanā)

Үүнийг хэлсний дараа, Эрхэм Аананда Буддад хандан:

“Эрхэм Багш аа, Будда ийм жижигхэн, ийм бөглүү, ийм алс хөдөөгийн тосгонд Эцсийн Нирваанд бүү одооч. Эрхэм Багш аа, Чампаа, Раажагаха, Сааваттхий, Саакета, Косамбий, Варанаси гэх мэт бусад сүрлэг хотууд[437] байдаг. Будда, Эцсийн Нирваанд тэнд одоосой. Тэнд Буддад чин үнэнч, Буддаг шүтэн биширдэг олон чинээлэг язгууртан, чинээлэг бярман, чинээлэг айлын эзэд байдаг шүү дээ.”

“Бүү тэгж ярь, Аананда, ‘Ийм жижигхэн, ийм бөглүү, ийм алс хөдөөгийн тосгон.’ гэж бүү ярь, Аананда. Урьд цагт Аананда, Махаасудассана[438] хэмээх хаан байсан бөгөөд тэр бол дөрвөн зовхисыг эзэлсэн, улс орноо тогтворжуулсан, долоон эрдэнийг оршоосон, зөв явдалт, агуу буянт хаан билээ.

Энэ Кусинаараа бол тэр цагт, Кусааватий[439] нэртэй байсан бөгөөд Махаасудассана хааны нийслэл хот байсан юм. Аананда, зүүнээс баруун зуун бээр, хойноос урагш далан бээр газар орших, нийслэл хот Кусааватий нь хөрөнгө баялагтай, хөгжил дэвшилтэй, хүн зон ихтэй, хүний хөл холхисон, хүнс хоол элбэг газар байлаа. Яг л, хөрөнгө баялагтай, хөгжил дэвшилтэй, хүн зон ихтэй, хүний хөл холхисон, хүнс хоол элбэг, бурхдын хот Аалакамандаатай[440] адилхан, нийслэл Кусааватий нь хөрөнгө баялагтай, хөгжил дэвшилтэй, хүн зон ихтэй, хүний хөл холхисон, хүнс хоол элбэг газар байсан юм Аананда.

Нийслэл Кусааватий хот нь сүрлэг зааны, адуу малын, сүйх тэрэгний чимээ, бөмбөр, хэнгэрэг, хуур, ятга, аялгуу дууны чимээ, жингэнэх хонхны чимээнээс гадна, ‘Алив, ид, уу, зоогло!’ гэх арваад зүйлийн чимээ шуугианаас өдөр ч, шөнө ч салдаггүй байлаа.

“Алив, Аананда, Кусинаараад орсон хойноо, маллачуудад: ‘Өнөөдөр, ваасеттхачууд[441] аа, энэ шөнө шувтрах цагаар, Будда Эцсийн Нирваанд одох болно. Ваасеттхачууд аа, хүрэлцэн ирээрэй, ваасеттхачууд аа. Дараа нэгэн цагт, ‘Манай тосгоны нутаг дээр, Будда Эцсийн Нирваанд одсон бөгөөд бид тэр шөнө шувтрах цагаар Буддатай очиж уулзах минь яалаа даа.’ хэмээн харамсах хэрэг гарахгүй болно.’ гээд зарлаарай.” гэв.

“За, Эрхэм Багш аа.” гэж Эрхэм Аананда хэлээд, орхимжоо өмсөөд, бадрын аягаа аваад, тэрээр нэгэн хамтрагчийн хамт Кусинаараа руу явав.

---

437 Эдгээр нь бүгд *Aṅga*, *Magadha*, *Kāsi, Kosala*, *Vaccha* нарын нийслэл, баян чинээлэг хотууд юм.

438 *Mahāsudassana*—“Махаасудассана”. Эсвэл “Агуу Судассана”.

439 *Kusāvatī*—“Кусааватий”. Домогт гарах эртний хот (DN 17).

440 *Āḷakamandā*—“Аалакамандаа”. Энэ бол Агуу Дөрвөн Хаадын Орны бурхдын нэг Вессавана (*Vessavaṇa*)-ын нийслэл. Бярман Тэнгэрийн орноос зиндаа доогуур, газар дэлхий дээрх лусын орноос дээгүүр, Гучин Гурван Тэнгэрийн Орны яг дор орших бурхдын орны нэг хэсэг гэж үздэг.

441 *Vāseṭṭha*—“Ваасеттхачууд”. Ваасеттха нар бол Ведийн шашны санваартнуудын ургийн овог. Маллачууд энэ санваартан удам угсааныхаа нэрийг *Khattiya* заншил ёсоор өөрсдөдөө өвлөн авчээ.

33. Маллачуудын Мөргөл (Mallānaṁvandanā)

Харин яг тэр үед, Кусинаараагийн маллачууд Хотын Зөвлөлийн танхимд ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулж байлаа. Тэгээд Эрхэм Аананда Кусинаараагийн маллачууд Хотын Зөвлөлийн танхимд цугларсан байхад нь очжээ. Маллачууд дээр дөхөж ирээд:

“Өнөөдөр, ваасеттхачууд аа, энэ шөнө шувтрах цагаар, Будда Эцсийн Нирваанд одох болно. Ваасеттхачууд аа, хүрэлцэн ирээрэй, ваасеттхачууд аа. Дараа нэгэн цагт: ‘Манай тосгоны нутаг дээр, Төгс Гэгээрсэн, Будда Эцсийн Нирваанд одсон бөгөөд бид тэр шөнө шувтрах цагаар Буддатай очиж уулзах минь яалаа даа.’ хэмээн харамсах хэрэг гарахгүй болно шүү.” гэж зарлав.

Эрхэм Аанандагаас үүнийг сонссон маллачууд, маллачуудын хөвгүүд, маллачуудын бэрүүд, маллачуудын эхнэрүүд сэтгэлийн зовлонд унан, ихэд өрөвдөж, ихэд гашуудалд автав. Зарим нь үсээ зулгаан уйлж, гараа савчин савж унан, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн,

‘Будда арай эрт Эцсийн Нирваанд одох нь, Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одох нь, энэ дэлхийн Мэлмий болсон тэр Эцсийн Нирваанд ингээд эрт одох нь!’ гэцгээж байв.

Ингээд тэрхүү сэтгэлийн зовлонд унасан, ихэд өрөвдсөн, ихэд гашуудсан, маллачууд, маллачуудын хөвгүүд, маллачуудын бэрүүд, маллачуудын эхнэрүүд, Упаваттана дахь маллачуудын Ихэр Сал Модод руу явсаар, Эрхэм Аананда дээр хүрч ирэв.

Тэгэхэд Эрхэм Ааннандад:

“Хэрвээ би Буддаг шүтдэг Кусинаараагийн маллачуудыг Буддад нэг нэгээр нь мөргүүлбэл энэ шөнөдөө дуусахгүй юм байна. Харин би тэдгээр маллачуудыг гэр бүл, гэр бүлээр нь бүлэг болгон салгаж зогсоогоод, ‘Тийм, тийм нэртэй малла иргэн, эхнэр, хүүхдүүд, зөвлөхүүд болоод бусад хамааралтай хүмүүсийнхээ хамтаар Буддад одоо хүндэтгэл үзүүлнэ үү.’ гэж зарлах маягаар Буддад мөргүүлбэл яасан юм бэ?” гэсэн бодол буув.

Ингээд Эрхэм Аананда маллачуудыг, гэр бүл гэр бүлээр нь бүлэг болгон салгаж зогсоогоод, ‘Тийм тийм нэртэй, малла иргэн, эхнэр, хүүхдүүд, зөвлөхүүд болоод бусад хамааралтай хүмүүсийнхээ хамтаар Буддад одоо сөгдөж мөргөнө үү.’ хэмээн зарлаж, Буддад хүндэтгэл үзүүлэн сөгдөн мөргөв.

Эрхэм Аананда ийнхүү тэр шөнийн дөнгөж эхэн гэхэд, Кусинаараагийн маллачуудыг бүгдийг нь Буддад хүндэтгэл үзүүлж амжив.

34. Бадарчин Субхадда (Subhaddaparibbājakavatthu)

Харин яг тэр үед, Субхадда[442] хэмээх нэгэн бадарчин, Кусинаараад хүрч ирэв. Бадарчин Субхадда, "Өнөө шөнө шувтрах цагаар, даянч Готама Эцсийн Нирваанд одох болно." гэж дуулав.

Тэгээд тэр бадарчин Субхаддад:

"Би багш нарын багш нар болох өндөр настай, их амьдралыг үзсэн, туулсан даянч бадарчдаас, 'Энэ дэлхий дээр тун ховорхон, маш цөөхөн тохиолдлоор Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар бууж ирдэг.' гэж хэлж байхыг би сонссон билээ. Өнөө шөнө шувтрах цагаар, даянч Готама Эцсийн Нирваанд одох болно. Миний хувьд номын талаар үл мэдэх зүйлүүд их боловч, би ойлгож чадах хэмжээнд даянч Готама надад Сургаал номоо зааж тараа гэж би даянч Готамад итгэж найдаж байна." хэмээн тэр бодлоо.

Ингээд бадарчин Субхадда, Упаваттана дахь маллачуудын Ихэр Сал Модод руу явж, Эрхэм Аанандад хүрч ирснийхээ дараа Эрхэм Аанандад хандан:

"Би багш нарын багш нар болох өндөр настай, их амьдралыг үзсэн, туулсан даянч бадарчдаас, 'Энэ дэлхий дээр тун ховорхон, маш цөөхөн тохиолдлоор Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар бууж ирдэг.' гэж хэлж байхыг би сонссон билээ. Өнөө шөнө шувтрах цагаар, даянч Готама Эцсийн Нирваанд одох болно. Миний хувьд номын талаар үл мэдэх зүйлүүд их боловч, би ойлгож чадах хэмжээнд даянч Готама надад Сургаал номоо зааж тараа гэж би даянч Готамад итгэж найдаж байна. Эрхэм Аананда минь, хэрэв намайг даянч Готаматай уулзахыг зөвшөөрвөл ихэд талархах байна." гэж хэллээ.

Үүнийг хэлсний дараа Эрхэм Аананда бадарчин Субхаддад ингэж хэлэв:

"Хэрэггүй ээ, Субхадда анд минь, Буддад төвөг учруулах хэрэггүй. Будда маш их ядарч туйлдсан байгаа."

Тэгэхэд нь бадарчин Субхадда хоёр дахь удаагаа, Эрхэм Аанандад хандан:

"Би багш нарын багш нар болох өндөр настай, их амьдралыг үзсэн, туулсан даянч бадарчдаас, 'Энэ дэлхий дээр тун ховорхон, маш цөөхөн тохиолдлоор Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар бууж ирдэг.' гэж хэлж байхыг би сонссон билээ. Өнөө шөнө шувтрах цагаар, даянч Готама Эцсийн Нирваанд одох болно. Миний хувьд номын талаар үл мэдэх зүйлүүд их боловч, би ойлгож чадах хэмжээнд даянч Готама надад Сургаал номоо зааж тараа гэж би даянч Готамад итгэж найдаж байна. Эрхэм Аананда минь, хэрэв намайг даянч Готаматай уулзахыг зөвшөөрвөл ихэд талархах байна." гэж хэллээ.

---

442 *Subhadda*—"Субхадда". Энэ сударт дурдагдаж буй хоёр дахь Субхадда (өөр хэсэгт ижил нэртэй нэг хар хүн Наатикад өөд болсон ба дараа хэсэгт дахин ийм нэртэй, ухамсаргүй, ахимаг насны нэг хувраг гарахыг энэ Субхаддатай бүү андуур.)

Эрхэм Ааналда бадарчин Субхаддад хоёр дахь удаагаа: “Хангалттай, Субхадда анд минь, Буддад төвөг учруулах хэрэггүй. Будда маш их ядарч туйлдсан байгаа.” гэж хэлэв.

Харин бадарчин Субхадда гурав дахь удаагаа, Эрхэм Аанандад хандан:

“Би багш нарын багш нар болох өндөр настай, их амьдралыг үзсэн, туулсан даянч бадарчдаас, ‘Энэ дэлхий дээр тун ховорхон, маш цөөхөн тохиолдлоор Тийн Одогч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар бууж ирдэг.’ гэж хэлж байхыг би сонссон билээ. Өнөө шөнө шувтрах цагаар, даянч Готама Эцсийн Нирваанд одох болно. Миний хувьд номын талаар үл мэдэх зүйлүүд их боловч, би ойлгож чадах хэмжээнд даянч Готама надад Сургаал номоо зааж таараа гэж би даянч Готамад итгэж найдаж байна. Эрхэм Ааналда минь, хэрэв намайг даянч Готаматай уулзахыг зөвшөөрвөл ихэд талархах байна.” гэж хэлэв.

Эрхэм Ааналда бадарчин Субхаддад гурав дахь удаагаа:

“Одоо болно оо, Субхадда анд минь, Буддад төвөг учруулах хэрэггүй. Будда маш их ядарч туйлдсан байгаа.” гэж хэлэв.

Эрхэм Ааналда, бадарчин Субхаддатай иймхүү ярилцаж байхыг Будда сонсов. Тэгээд Эрхэм Аанандад ингэж хэлэв:

“Одоо хангалттай. Ааналда, Субхаддад Буддатай уулзахад нь хориг тавих хэрэггүй. Субхадда надаас гүнзгий мэдлэгийг эрэлхийлж, төвөг болохгүйгээр юу ч асуух гэсэн бай, би түүний бүх асуултад хариулах болно. Ямар ч асуулт асуух бай, би хариулъя. Тэр үүнийг түргэн ухаарч ойлгох болно.” гэв.

Тэгэхэд нь Эрхэм Ааналда бадарчин Субхаддад:

“Алив, Субхадда анд минь, Будда чамд зөвшөөрөл өгчихлөө.” гэж хэлэв.

Тэгээд бадарчин Субхадда Будда дээр явж очоод, түүнд дөхөж ирснийхээ дараа Буддад мэнд дэвшүүлж, эелдэг яриа өрнүүлсний дараа нэг талд нь суулаа.

Бадарчин Субхадда нэг талд нь сууж байхдаа Буддад ингэж хэлэв:

“Хүндэт Готама, шашны урсгал үндэслэгч, энэ урсгалынхаа тэргүүн нь, энэ урсгалынхаа удирдагч нь, энэ урсгалынхаа багш нь, алдар нэртэй, тахин шүтэгдсэн, нийтээрээ түүнийг гэгээнтэн гэж үздэг, ихийг үзэж туулсан, насаараа лам байсан, туршлага хураасан, одоо өтөл насандаа очсон даянч болон бярман лам нар байдаг. Тухайлбал, Пуурана Кассапа, Маккхали Госаала, Ажита Кесакамбала, Пакудха Каччааяана, Санжаяа Белаттхипутта, Нигантха Наатапутта нар юм. Эдгээр хүмүүсийн хувьд тэд бүгд өөрсдийн шууд-билгүүнээр гэгээрлийг олсон уу? Эсвэл тэдний хэн нь ч гэгээрлийг олоогүй юу? Эсвэл зарим нь гэгээрлийг олсон уу?”

“Болно оо. Субхадда. Тэд бүгд өөрсдийн шууд-билгүүнээр гэгээрлийг олсон уу? Эсвэл тэдний хэн нь ч гэгээрлийг олоогүй юу? Эсвэл зарим нь гэгээрлийг олсон уу?” гэх мэтээр асууж шалгаах хэрэггүй. Би чамд

Сургаал номыг зааж өгье. Субхадда, үүнийг анхааралтай сонсоод, ой тойндоо сайтар буулгаарай. Ингээд би чамд хэлье.”

“Тэгье ээ, Эрхэм Багш минь.” гэж бадарчин Субхадда Буддад хариулахад Будда:

“Субхадда, хэрэв сургаал номлол болон сахил санваарт нь, Гэгээнтний Найман Замнал байхгүй л тохиолдолд, тэндээс нэгдүгээр түвшний жинхэнэ даянч[443] олдохгүй, хоёрдугаар түвшний жинхэнэ даянч[444] олдохгүй, гуравдугаар түвшний жинхэнэ даянч[445] олдохгүй, дөрөвдүгээр түвшний жинхэнэ даянч[446] олдохгүй билээ.

Харин, Субхадда, хэрэв сургаал номлол болон сахил санваарт нь, Гэгээнтний Найман Замнал байгаа тохиолдолд, тэндээс нэгдүгээр түвшний жинхэнэ даянч олдоно, хоёрдугаар түвшний жинхэнэ даянч олдоно, гуравдугаар түвшний жинхэнэ даянч олдоно, дөрөвдүгээр түвшний жинхэнэ даянч олдох болно.

Энд Субхадда, энэ Сургаал болон Сахилд, Гэгээнтний Найман Замнал байгаа билээ. Зөвхөн энд, нэгдүгээр түвшний жинхэнэ даянч байна, хоёрдугаар түвшний жинхэнэ даянч байна, гуравдугаар түвшний жинхэнэ даянч байна, дөрөвдүгээр түвшний жинхэнэ даянч нар байна. Бусад урсгалууд дотор тийм даянчид байхгүй байна.

Хуврагууд нь л зөв явдалтай бол энэ дэлхий Төгс Гэгээнтэнгүй болох учиргүй билээ.

> Хорин естэй идэр насандаа би, Субхадда,
> Хорвоогоос үнэнийг эрэн гарч явсан.
> Одоогоос тавь гаруй жилийн өмнө би, Субхадда,
> Орон гэрээ орхиод даянч хуврага болсон.
> Өөгүй сайн Сургаал, Сахилд тооцогдож чадах
> Өөр нэгдүгээр түвшний жинхэнэ даянч олдохгүй
> Хоёрдугаар түвшний жинхэнэ даянч олдохгүй
> Гуравдугаар түвшний жинхэнэ даянч олдохгүй
> Дөрөвдүгээр түвшний жинхэнэ даянч олдохгүй.
> Өөр тэдгээр номлол урсгалд үнэн даянч олдохгүй.

Субхадда, хуврага хүмүүс нь л зөв сайн явдалтай бол хорвоо дэлхий Төгс Гэгээнтэнгүй болох учиргүй юм.

Үүнийг хэлсний дараа бадарчин Субхадда Буддад ингэж хэлэв:

---

443 Нэгдүгээр түвшний жинхэнэ даянч: Сэтгэлийн доод гурван хүлээсийг устгасан Урсгалд Орогч (AN 4.241:2.2).

444 Хоёрдугаар түвшний жинхэнэ даянч: Сэтгэлийн доод гурван хүлээсийг устгасан, дур-хүсэл, уур-хилэн, төөрөгдөл намжсан Нэгэнтээ Эргэн Ирэгч (AN 4.241:3.2).

445 Гуравдугаар түвшний жинхэнэ даянч: Сэтгэлийн доод таван хүлээсийг устгасан Эс Эргэн Ирэгч (AN 4.241:4.2).

446 Дөрөвдүгээр түвшний жинхэнэ даянч: Сэтгэлийн бүх хүлээсийг устгасан Арахант (AN 4.241:5.2).

“Үнэхээр гайхалтай. Эрхэм Багш аа! Төгс төгөлдөр юм. Эрхэм Багш аа! Хөмөрч унасан нэгнийг эргүүлж босгох мэт, эсвэл далд нууц зүйлийг илчилж харуулах мэт, замаасаа төөрсөн нэгэнд замыг нь зааж өгөх мэт, түнэр харанхуй газар гэрэл дэнлүү асаахад, хараа сайтай нэгэн бээр, тэнд байсан зүйлийг нь олж харах мэт, Будда өөрийн Сургаалаа олон аргаар тайлбарлаж, ойлгуулж өглөө надад. Би, Будда, Сургаал, Хуврагийн Чуулганы нөмөрт очиж байна. Эрхэм Багш аа, Будда өөрийн биеэр надад хуврагийн дээд сахилаа хайрлаж болох сон болов уу?” гэхэд,

“Өмнө нь өөр шашны сургаал ном, сахил санваартай байсан хүмүүс, манай уламжлалд орж хуврагийн дээд сахил авахыг хүсэж буй тохиолдолд, дөрвөн сарын турш туршилтын хугацаанд хийдэд амьдардаг бөгөөд дөрвөн сарын эцэст бусад хуврагууд сэтгэл ханамжтай байгаа тохиолдолд, хувраг болгох, хуврагийн дээд сахил хүртэх эсэхийг нь шийддэг. Гэвч хүмүүсийн хооронд нэлээд ялгаа байдаг гэдэг нь, энэхүү тохиолдол дээр харагдаж байна. Би үүнийг ойлгож байна.”

“Эрхэм Багш аа, хэрэв урьд нь өөр шашны сургаал ном, сахил санваартай байсан хүмүүс, манай уламжлалд орж хуврагийн дээд сахил авахыг хүсэж буй тохиолдолд, дөрвөн сарын турш туршилтын хугацаанд хийдэд амьдардаг, дөрвөн сарын эцэст бусад хуврагууд нь сэтгэл ханамжтай байгаа тохиолдолд, хувраг болгох, хуврагийн дээд сахил хүртээх эсэхийг нь шийддэг юм бол би дөрвөн жилийн турш ч хамаагүй, туршилтын хугацаанд хамрагдаж, эцэст нь бусад хуврагууд сэтгэл ханамжтай байгаа тохиолдолд намайг хувраг болгох, хуврагийн дээд сахилыг надад хүртээх эсэхээ шийдэг.”

Тэгэхэд нь Будда, Эрхэм Аанандад хандан:

“За тэгвэл, Аананда, Субхаддад хуврагийн сахил өг.” хэмээв.

“Тэгье ээ, Эрхэм Багш минь.” гэж Эрхэм Аананда Буддад хариулав.

Тэр үед бадарчин Субхадда Эрхэм Аанандад хандан:

“Аананда, найз аа, чамд буян хурдаг нь гарцаагүй. Аананда, найз аа, энд Буддатай байнга нүүр тулан гарын туслахаар нь байсан хүнд мэдээжийн хэрэг хишиг буян очдог нь дамжиггүй юм.” гэж хэллээ.

Ингээд бадарчин Субхадда, Буддагаас өөрөөс нь, хуврагийн дээд сахил авч, Буддагийн шавь хувраг болов.

Сахил авсан тэр цагаас хэсэг хугацааны дараа эрхэм Субхадда, орь ганцаар амьдарч, бусдаас тусгаарлагдаж, хичээнгүй, шамдангүй, шийдэмгий байснаар их удалгүй энэ насандаа амжиж, төгс гэгээрлийг олсон билээ. Тэрээр хар хүний амьдралаас орон гэргүй даянч болоод, өөрийн ухаарлаар төгс гэгээрэл өөд зорьсон зорилгодоо хүрч амьдарсан бөлгөө.

Тэрээр:

“Дахин төрөхүй үгүй болов, ариуслын-замнал өндөрлөв, хийх учиртайгаа хийв, ингээд ирээдүйн үргэлжлэл үгүй болов.” хэмээн ухаардаг.

Ийнхүү Эрхэм Субхадда, Төгс Гэгээрсэн Арахантуудын нэг болсон билээ.

Тавдугаар уншлага хэсэг өндөрлөв.

35. Буддагийн Сүүлчийн Үгс (Tathāgatapacchimavācā)

Ингээд дараа нь Будда, Эрхэм Аанандад хандан хэлэв:

“Аананда, та нарт, ‘Сургалт багшаа алдлаа. Бид Багшгүй боллоо.’ гэж бодож болох юм. Гэхдээ ингэж харж, бодож болохгүй юм.

Аананда, ямар Сургаал ном болон Сахил ёсыг би зааж хэлсэн, захиж үлдээсэн билээ, намайг үгүй болсны дараа тэдгээр нь та нарын Багш байх болно.

Аананда, одоо үед хуврагууд, нэг нэгнээ ‘Анд аа’[447] гэж дууддаг ч, намайг үгүй болсны дараа, тэд нэгнээ ингэж дуудаж болохгүй. Ахмад хувраг л шинэ хуврагийг нэрээр нь, эсвэл овгийнх нь нэрээр, эсвэл ‘Анд’ гэсэн үгээр дуудаж болно. Харин шинэ залуу хувраг бол ахмад хуврагийг ‘Эрхэм Багш’[448] эсвэл ‘Хүндэт Багш’[449] гэж дуудвал зохих юм.

Аананда, намайг нас барсны дараа Хуврагийн Чуулган, бага болон туслах чанартай сургалтын дүрмийг цуцалж болно.

Аананда, намайг нас барсны дараа, дээд зэмийг[450] хувраг Чаннад[451] өгөх ёстой”

“Тэгвэл хамгийн дээд зэм нь, юу байх вэ, Эрхэм Багш аа?”

“Аананда, энэ шийтгэл бол: Хувраг Чанна хүссэн бүхнээ хэлж ярьж болно. Гэхдээ бусад хуврагууд түүнтэй ярилцах, түүнд зөвлөх, түүнд зааварлах ёсгүй юм.”

Дараа нь Будда, бусад хуврагуудад хандан өгүүлрүүн:

“Хуврагууд аа, хуврагуудын хэн нэгэнд, Буддагийн талаар, эсвэл Сургаалын талаар, эсвэл Хуврагийн Чуулганы талаар, эсвэл Гэгээрлийн Замналын[452] талаар, эсвэл бясалгал дасгалын талаар тодорхойгүй

---

447 *Āvuso*—“Анд”. Эсвэл “найз”, “журмын нөхөр”.

448 *Bhante*—“Эрхэм Багш” (анг. *Venerable Sir*, сам. *Bhadanta*). Өөрөөр “Хүндтэй Нэгэн”, “Эрхэм Та” г.м.

449 *Āyasmā*—“Хүндэт Багш” (сам. *Āyuṣmant*). Үгчилбэл, “өнө удаан амьдрагч”.

450 *Brahmadaṇḍa*—“дээд зэм”. Үгчилбэл, “тэнгэрлэг шийтгэл”. Хийдийн хуврагууд түүнтэй огт харьцахаа больдог шийтгэл. Хийдийн дотор аливаа зөрчилд хүч хэрэглэсэн шийтгэл гэж байдаггүй. Тиймээс хийдийн амар амгалан орчинд *brahmadaṇḍa* шийтгэл нь хамгийн хүнд шийтгэл болдог. Үүнээс гадна, энэ насандаа дахиж хувраг болох эрхээ алддаг *Pārājika* (1. хүн алах; 2. хурьцал хийх; 3. хулгай дээрэм хийх; 4. гэгээрээгүй атлаа гэгээрсэн гэж зарлах)-г үйлдсэн хуврагтай мөн бусад бүх хувраг харилцахаа больж тэр хуврагийг өөрөө явахыг хүсдэг. Хэрэв энэ хувраг энэ үйлдлээ хэлэлгүй нуух, орхимжоо тайлахгүй хувраг дүрийг эсгэн явах аваас тэр хүн “хулхи” хувраг болсон гэсэн үг (Vin).

451 *Channa*—“Чанна”. Урьд нь Сиддхаттхагийн сүйх тэрэгч байсан, дараа нь хувраг болоод олон удаа сахилын зөрчил гаргах авч огт зөрчлөө арилгадаггүй, арилгах, ойлгохыг хүсдэггүй байж Хожим тэр алдаагаа засаад зогсохгүй Арахант болон гэгээрдэг (Vin; SN 22.90).

452 *Maggo*— “Тэгээрлийн Замнал”. Гэгээнтний Найман Замналыг хэлсэн санаа. Лавлахад үз.

бүрхэг, ойлгомжгүй зүйл байж болох юм. Ийм зүйл байвал асуугтун. Хуврагууд аа, 'Будда бидэнтэй нүүр тулан уулзаж байхад Багшаас сургалт бясалгалын талаараа шуудхан асуултууд асуух минь яалаа даа.' гэж дараа нь бодож харамсах шаардлага гарахгүй болно."

Үүнийг хэлсний дараа тэдгээр хуврагууд чимээ аниргүй л байв.

Тэгэхэд Будда, хоёр дахь удаагаа, хуврагуудад хандан хэлэв:

"Хуврагууд аа, хуврагуудын хэн нэгэнд, Буддагийн талаар, эсвэл Сургаалын талаар, эсвэл Хуврагийн Чуулганы талаар, эсвэл Гэгээрлийн Замналын талаар, эсвэл бясалгал дасгалын талаар тодорхойгүй бүрхэг, ойлгомжгүй зүйл байж болох юм. Ийм зүйл байвал асуугтун. Хуврагууд аа, 'Будда бидэнтэй нүүр тулан уулзаж байхад Багшаас сургалт бясалгалын талаараа шуудхан асуултууд асуух минь яалаа даа.' гэж дараа нь бодож харамсах шаардлага гарахгүй болно."

Үүнийг хэлсний дараа ч тэдгээр хуврагууд хоёр дахь удаагаа мөн л чимээ аниргүй байв.

Ингээд Будда, гурав дахь удаагаа, хуврагуудад хандан хэллээ:

"Хуврагууд аа, хуврагуудын хэн нэгэнд, Буддагийн талаар, эсвэл Сургаалын талаар, эсвэл Хуврагийн Чуулганы талаар, эсвэл Гэгээрлийн Замналын талаар, эсвэл бясалгал дасгалын талаар тодорхойгүй бүрхэг, ойлгомжгүй зүйл байж болох юм. Ийм зүйл байвал асуугтун. Хуврагууд аа, 'Будда бидэнтэй нүүр тулан уулзаж байхад Багшаас сургалт бясалгалын талаараа шуудхан асуултууд асуух минь яалаа даа.' гэж дараа нь бодож харамсах шаардлага гарахгүй болно."

Үүнийг хэлсний дараа ч мөн адил тэдгээр хуврагууд гурав дахь удаагаа чимээ аниргүй л байлаа.

Тэгэхэд нь, Будда, хуврагуудад хандан:

"Хуврагууд аа, та нар Багшаа ихэд хүндэлсэндээ асуулт асуухгүй байж болох юм. Тэгвэл хуврагууд аа, нэг найз нь нөгөө найздаа, өөрийн эргэлзээгээ хэлнэ үү." гэв. Үүнийг хэлсний дараа тэдгээр хуврагууд чимээ аниргүй л байв.

Тэр үед Эрхэм Аананда, Буддад ийн хэлэв:

"Гайхалтай юм, Эрхэм Багш аа, гайхамшигтай юм. Эрхэм ээ, энд чуулсан хуврагуудын дунд Будда, түүний Сургаал, Хуврагийн Чуулган, Гэгээрлийн Замнал, эсвэл дасгал бясалгалын талаар эргэлзэж, тээнэгэлзэж байгаа нэг ч хувраг байхгүй гэдэгт би итгэл төгс байна." гэхэд:

"Аананда, чи ердөө итгэл дээрээ л үндэслэж ярьж байна. Тэгвэл Будда өөрөө энд чуулсан хуврагуудын дунд, Будда, Сургаал, Хуврагийн Чуулган, Гэгээрлийн Замнал эсвэл дасгал бясалгалын талаар эргэлзэж, тээнэгэлзэж байгаа нэг ч хувраг байхгүй гэдгийг нь мэдэж байгаа болохоороо хэлж байгаа билээ. Энд буй

таван зуун хуврагуудын хамгийн доод түвшин нь гэхэд л доод төрөл дахин авахгүй, төгс гэгээрлийг ирээдүйд олох нь баталгаажсан Урсгалд Орогч юм.”[453]

Дараа нь Будда хуврагуудад хандан:

“Алив хуврагууд аа, би та бүгдэд,

‘Сэдэхүй-цогцлохуй бүхэн сүйрч унадаг жамтай. Хичээнгүйлэн зүтгээрэй хуврагууд аа!’ гэдгийг хэлье.” хэмээв.

36. Эцсийн Нирваан (Parinibbutakathā)

Үүний дараа, Будда, нэгдүгээр даянд ороод, нэгдүгээр даянаас гарсны дараа тэрбээр хоёрдугаар даянд орж, хоёрдугаар даянаас гарсны дараа тэрбээр гуравдугаар даянд орж, гуравдугаар даянаас гарсны дараа тэрээр дөрөвдүгээр даянд орж, дөрөвдүгээр даянаас гарсны дараа тэрээр Хязгааргүй Орон Зайн Оронд орж, Хязгааргүй Орон Зайн Орноос гарсны дараа тэрээр Хязгааргүй Ухамсрын Оронд орж, Хязгааргүй Ухамсрын Орноос гарсны дараа тэрээр Огт-Оргүйн Оронд орж, Огт-Оргүй Орноос гарсны дараа тэрээр Танихуй-Бухий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Оронд орж, Танихуй-Бухий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орноос гарсны дараа тэрээр танин-мэдэхүй хийгээд мэдрэмжийн төгсгөлд хүрэв.

Тэгэхэд Эрхэм Аананда, Эрхэм Анурудлхад[454] хандан:

“Будда Эцсийн Нирваанд одчихсон уу?” гэхэд,

“Эрхэм Аананда, Будда Эцсийн Нирваанд хараахан одоогүй байна. Харин тэрээр танин-мэдэхүй, мэдрэмжийн төгсгөл зэрэгт хүрлээ.” гэв.

Дараа нь Будда, танин-мэдэхүй, мэдрэмжийн төгсгөлөөс гарсны дараа, Танихуй-Бухий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Оронд орж, Танихуй-Бухий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орноос гарсны дараа тэрээр Огт-Оргүйн Оронд орж, Огт-Оргүй Орноос гарсны дараа тэрээр Хязгааргүй Ухамсрын Оронд орж, Хязгааргүй Ухамсрын Орноос гарсны дараа тэрээр Хязгааргүй Орон Зайн Оронд орж, Хязгааргүй Орон Зайн Орноос гарсны дараа тэрээр дөрөвдүгээр даянд орж, дөрөвдүгээр даянаас гарсны дараа тэрээр гуравдугаар даянд орж, гуравдугаар даянаас гарсны дараа тэрээр хоёрдугаар даянд орж, хоёрдугаар даянаас гарсны дараа нэгдүгээр даянд ороод, нэгдүгээр даянаас гарсны дараа тэрбээр хоёрдугаар даянд орж, хоёрдугаар даянаас гарсны дараа тэрбээр гуравдугаар даянд орж, гуравдугаар даянаас

[453] Энд хурсан 500 орчим хуврагууд бүгд гэгээрсэн хуврагууд байсан бөгөөд зөвхөн Аананда л хамгийн доод түвшин буюу Урсгалд Орогч байсан гэх ба энд Будда Ааванадаг дайруулж хэлэх маягаар буюу түүнийг Төгс Гэгээрэлд шамдаарай гэсэн санаагаар энд гарах үгсийг хэлсэн гэж тайлбар судpт байна (*Aṭṭhakathā*).

[454] *Anuruddha*—“Анурудха”. Сакя овгийн хунтайж асан, Буддагийн үеэл, нэр хүндтэй Төгс Гэгээнтэн хуврag. Бясалгалын өндөр түвшинд хүрсэн тэрээр хараагүй болсон байсан гэх ба билгийн нүдээрээ энэ хорвоогийн бүх орныг (там, өлсгөлөн-сүнс, диваажин, Тэнгэрийн орон г.м.) хардаг байж (AN 3.131; SN 52.12).

гарсны дараа тэрээр дөрөвдүгээр даянд орж, дөрөвдүгээр даянаас гарсны дараа Будда тэр дороо Эцсийн Нирваанд одов.

Будда Эцсийн Нирваанд одох үед асар хүчтэй газар хөдлөлт болж, Тэнгэр бурхдын айдас төрөм, айхавтар дуун, аймшигт чимээ, аянга цахилгааны нүргээн хадав.

Будда Эцсийн Нирваанд одох үед Бярман Тэнгэр Сахампати[455] эдгээр мөртүүдийг хэлэв:

> “Энэ хорвоогийн амьтай бүхэн энэ биеэ орхих нь гарцаагүй
> Эгнэгт Гэгээрсэн, Нэгэнт Нойрноос Сэрсэн, ялагдашгүй
> Энгүй ийм Багшид, энэ дэлхийд өрсөлдөгч үгүй
> Эцсийн Нирваанд Төгс Сэрсэн Будда биднийг орхин одмуй.”

Будда Эцсийн Нирваанд одох үед Бурхдын Хаан Сакка[456] эдгээр мөртүүдийг хэлэв:

> “Мөнх бус хорвоогийн нөхцөлдсөн юмс
> Мөхөж сөнөж дуусдаг жамтай
> Ирсэн юм бүгд буцдаг болохоор
> Ийм ангижрал л жаргал завшаантай.”

Будда Эцсийн Нирваанд одох үед эрхэмсэг Ануруддха, эдгээр мөртүүдийг хэлэв:

> “Төв сэтгэлийг тийн тогтоосон ийм нэгэнд дахин авах амьсгал тасрав
> Төвшин амгаланг-олсон гэгээнтэн Эцсийн Нирваанд нэгэнт одов
> Зовуурь өвчнийг зогсолт үгүй амар амгалан сэтгэлээр давж
> Зоргоор салхинд зул унтрах шиг зохист нэгэн Нирваанд одов.”

Будда Эцсийн Нирваанд одох үед Эрхэм Аананда, эдгээр мөртүүдийг хэлэв:

> “Айдас хүрэхийн хамт, түгшүүр төрөхийн хамт
> Ариуссан, Төгс Багш, ангижрал Нирваанд одлоо.”

Будда Эцсийн Нирваанд одох үед, дур-хүслээс хараахан ангижраагүй зарим хуврагууд гараа савчин савж унаж, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн уйлж:

‘Будда арай эрт Эцсийн Нирваанд одлоо. Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одлоо, энэ дэлхийн Мэлмий болсон тэр Эцсийн Нирваанд ингээд эрт одлоо!’ гэцгээж байв.

Харин дур-хүслээс ангид болсон хуврагууд дүүрэн-анхаарал тунгалаг-оюунаар энэ бүгдийг давах зуураа:

“Сэдэхүй-цогцлохуй бүхэн мөнхийн-бус. Үүнээс өөрөөр яах байсан гэж?” хэмээн бодно.

---

455 *Brahmāsahampati*—“Бярман Тэнгэр Сахампати”. Будда гэгээрснийхээ дараа, бусдад Сургаалаа заахгүй гэсэн санааг нь, энэ Бярман Тэнгэр бээр болиулан ятгаж, улмаар Будда Сургаалаа заахаар болсон гэдэг (SN 6.1).

456 *Sakko devānamindo*— “Бурхдын Хаан Сакка”. Гучин Гурван Тэнгэрийн Орны удирдагч, Буддад шавь орсон, түүний Сургаал номыг дээдлэгч, Урсгалд Орогч нэгэн (DN 21; SN 11).

Тэгэхэд Эрхэм Ануруддха хуврагуудад хандан:

“Хангалттай, андууд аа, бүү харамсаж, бүү уйл. ‘Хайр татсан, сэтгэл булаасан бүх юм өөрчлөгдөн хувьсаж, салан холдож, ондоошин хувирдаг биш үү? Төрсөн, бий болсон, сэдэгдсэн-цогцолсон бол эвдрэх Жамтай байхаас бус өөрөөр яана гэж? Өөрөөр байх боломжгүй.’ гэж Будда нарт заагаагүй гэж үү?

Андууд аа, бурхад шүүмж хэлж байна шүү.” гэж хэлэв.

“Эрхэм Ануруддха, ямар бодгалиуд хийгээд бурхдын тухай ярина вэ?”

“Aананда, найз минь, энэ дэлхийн талаарх танин-мэдэхүйтэй, тэнгэрийн мандалд орших бурхад байх ба тэд үсээ зулгаан уйлж, гараа савчин савж унаж, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн: ‘Будда арай эрт Эцсийн Нирваанд одлоо. Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одлоо. Энэ дэлхийн Мэлмий болсон тэр Эцсийн Нирваанд ингээд эрт одлоо!’ гэцгээж байна.

Аананда, найз минь, энэ дэлхийн талаарх танин-мэдэхүйтэй, газар дэлхий дээр орших бурхад байх ба тэд үсээ зулгаан уйлж, гараа савчин савж унаж, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн: ‘Будда арай эрт Эцсийн Нирваанд одлоо. Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одлоо. Энэ дэлхийн Мэлмий болсон тэр Эцсийн Нирваанд ингээд эрт одлоо!’ гэцгээж байна.

Гэвч, дур-хүслээс салж чадсан зарим бурхад дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтай, энэ бүгдийг тэвчин: ‘Сэдэхүй-цогцлохуй бүхэн мөнхийн-бус. Үүнээс өөрөөр яах байсан гэж?’ хэмээн бодоцгоож байна.” гэв.

Дараа нь Эрхэм Ануруддха, Эрхэм Аананда нар үлдсэн шөнийг Сургаал номын тухай ярилцан өнгөрөөв. Тэгээд эрхэм Ануруддха Эрхэм Ааннандад хандан:

“Алив, Аананда, Кусинаараад очоод, Кусинаараагийн маллачуудад: ‘Будда Эцсийн Нирваанд одлоо. Ваасеттхачуудаа, та бүгд таавараа ирж болно.’ гээд хэлнэ үү.” гэв.

“Тэгье ээ. Эрхэм ээ.” гэж Аананда, Эрхэм Ануруддхад хариулаад, үүрээр эрт орхимжоо өмсөөд, бадрын аягаа аваад, нэгэн хүний хамтаар Кусинаараа руу явав. Харин яг тэр үед, Кусинаараагийн маллачууд Хотын Зөвлөлийн танхимдаа ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулж байлаа. Тэгээд Эрхэм Аананда Кусинаараагийн маллачууд Хотын Зөвлөлийн танхимд цугларсан байхад нь очиж, маллачууд дээр дөхөж ирээд:

“Будда Эцсийн Нирваанд одлоо. Ваасеттхачуудаа, та бүгд таавараа ирж болно.” гэж зарлав.

Эрхэм Ааннандагаас үүнийг сонссон маллачууд, маллачуудын хөвгүүд, маллачуудын бэр хүүхнүүд, маллачуудын эхнэрүүд сэтгэлийн зовлонд унан, ихэд өрөвдөж, ихэд гашуудалд автав. Зарим нь үсээ зулгаан уйлж, гараа савчин савж унан, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн: ‘Будда арай эрт Эцсийн Нирваанд одлоо. Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одлоо, энэ дэлхийн Мэлмий болсон тэр Эцсийн Нирваанд ингээд эрт одлоо!’ гэцгээж байв.

37. Буддагийн Шарилыг Дээдлэн Хүндлэхүй (Buddhasarīrapūjā)

Тэгээд Кусинаараагийн маллачууд эрчүүддээ: “Нөхөд өө, одоо үнэртэн танартан, чимэглэл цэцэгсийг, мөн Кусинаараа дахь бүх хөгжимчдийг цуглуулцгаа!” хэмээн хэллээ.

Дараа нь Кусинаараагийн маллачууд үнэртэн танартан, чимэглэл цэцэгс, тэндхийн бүх хөгжимчид болоод таван зуун хос, шарил ороох даавуу сэлтийг аван Упаваттана дахь маллачуудын Ихэр Сал Модонд ирээд, Буддагийн биед ойртож, хүндэтгэл үзүүлэн, бүжиг, дуу, хөгжим, чимэглэл цэцэгс, үнэртэн танартан зэргээр түүний шарилд хүндэтгэл үзүүлэн, шүтэн мөргөж, даавуугаар халхавч хийж, дугуй асар зэргийг бэлтгэсээр, тэр өдрийг өнгөрөөв.

Тэгээд Кусинаараагийн маллачууд:

“Өнөөдөр Буддагийн шарилыг чандарлахад хэтэрхий оройтсон байна. Маргааш бид Буддагийн шарилыг чандарлах болно.” гэцгээв.

Тэгээд Кусинаараагийн маллачууд Буддагийн биед хүндэтгэл үзүүлэн, бүжиг, дуу, хөгжим, чимэглэл цэцэгс, үнэртэн танартан зэргээр түүний шарилд хүндэтгэл үзүүлэн, шүтэн мөргөж, даавуугаар халхавч хийж, дугуй асар зэргийг бэлтгэсээр, хоёр дахь өдрийг өнгөрөөв. Ингээд тэд бүр гурван өдөр, дөрвөн өдөр, таван өдөр, зургаан өдрийг өнгөрөөв.

Харин долоо дахь өдөр нь Кусинаараагийн маллачуудад ийм бодол орж ирэв:

“Буддагийн шарилыг өмнө зүгт, хотоос үдэн гаргаж, түүний шарилд хүндэтгэл үзүүлэн бүжиг, дуу, хөгжим, чимэглэл цэцэгс, үнэртэн танартан зэргээр түүний шарилд хүндэтгэл ёслол үйлдэж, хотын өмнө зүгт бид Буддагийн шарилыг чандарлах болно.”

Харин яг тэр үед, маллачуудын удирдагч найман хүн толгой юугаа угааж, цэвэрхэн хувцас өмсөөд:

“Буддагийн шарилыг өргөцгөөе.” гэж хэлээд өргөх гэсэн боловч тэд өргөж эс дийлэв. Тэгээд Кусинаараагийн маллачууд Эрхэм Ануруддхад хандан ингэж хэлэв:

“Ямар учиртай юм бол оо? Эрхэм Ануруддха, маллачуудын найман удирдагч толгой юугаа угааж, цэвэрхэн хувцас өмсөөд, ‘Буддагийн шарилыг өргөцгөөе.’ гэж хэлээд өргөх гэсэн боловч тэд өргөж дийлсэнгүй.” гэхэд:

“Ваасеттхачууд та нарт нэг бодол байдаг. Харин бурхдад өөр бодол байна даа.”

“Тэгвэл бурхдын өөр бодол нь юу юм бэ, Эрхэм ээ?”

“Ваасеттхачууд та бүгдийн бодол бол:

‘Буддагийн шарилыг өмнө зүгт, хотоос үдэн гаргаж, түүний шарилд хүндэтгэл үзүүлэн, бүжиг, дуу, хөгжим, чимэглэл цэцэгс, үнэртэн танартан зэргээр түүний шарилд хүндэтгэл ёслол үйлдэн, хотын өмнө зүгт бид Буддагийн шарилыг чандарлах.’

Харин бурхдын өөр бодол нь:

‘Буддагийн шарилыг хойд зүгт, хотоос үдэн гаргаж, түүний шарилд хүндэтгэл үзүүлэн, бурхдын бүжиг, дуу, хөгжим, чимэглэл цэцэгс, үнэртэн танартан зэргээр түүний шарилд хүндэтгэл ёслол үйлдэн, хотын хойд зүгт аваачаад, хойд хаалгаар дахин хот руу орж, дунд нь хотын төвд аваачиж, мөн зүүн хаалгаар гарч, хотын зүүн талд, шүтээн мөргөлийн Макутабандхана[457] хэмээх газарт Буддагийн шарилыг чандарлах юм.’ гэхэд:

“Бурхдын таалллаар болцгооё, Эрхэм ээ.” гэв.

Харин яг энэ үед, Кусинаараа тэр аяараа, бүр хогийн жалга нь хүртэл Ариун Мандарваа цэцэгсээр, өвдөг хүрэхээр өндөр, битүү бүрхэгдэн хучигдсан байлаа. Дараа нь Кусинаараагийн маллачууд хийгээд Бурхад, Буддагийн шарилыг хойд зүгт, хотоос үдэн гаргаж, түүний шарилд хүндэтгэл үзүүлэн, Бурхдын хийгээд хүмүүний, бүжиг, дуу, хөгжим, чимэглэл цэцэгс, үнэртэн танартан зэргээр түүний шарилд хүндэтгэл ёслол үйлдэн, хотын хойд зүгт аваачаад, хойд хаалгаар дахин хот руу эргэн орж, дунд нь хотын төвд аваачиж, мөн зүүн хаалгаар гарч, хотын зүүн талд, маллачуудын шүтээн мөргөлийн Макутабандхана нэртэй газарт, Буддагийн шарилыг чандарлахаар байрлуулав.

Дараа нь Кусинаараагийн маллачууд Эрхэм Аанандад ингэж хэлэв:

“Хүндэт Аананда, Буддагийн шарилтай бид хэрхэн хандах ёстой байдаг вэ?”

“Ваасеттхачуудаа, хүрд-эргүүлэгч хааны шарилтай адил, Буддагийн шарилтай харьцах ёстой.”

“Эрхэм Багш аа, хүрд-эргүүлэгч хааны шарилтай яаж харьцдаг ёстой байдаг юм бэ?”

“Ваасеттхачуудаа, хүрд-эргүүлэгч хааны шарилыг шинэ маалинган даавуунд ороосны дараа эсгийгээр давхарлан ороогоод, мөн дахин шинэ даавуугаар үүний гадуур ороодог. Үүнийг тус бүр таван зуун удаа давтан хийх ба хааны тэр шарилыг өөр төмөр онгоцтой тосонд дүрж хийнэ. Дараа нь тэд үүнийгээ төрөл бүрийн үнэртэн бүхий өөр нэг онгоцонд хийж битүүмжлээд, хааны шарилыг чандарлаж, олон замын уулзвар дээр суварга босгодог билээ.

Үүнийг тэд хүрд-эргүүлэгч хааныхаа биеийг нь гэж үздэг. Тэд хүрд-эргүүлэгч хааныхаа биеийг гэж үздэгтэй адил, Буддагийн биеийг мөн энэ байна гэж үзэж болох юм. Буддад зориулсан суварга олон замын уулзвар дээр байж болно. Тэнд чин сүсгээр чимэглэл, хүж, үнэртэн өргөх, эсвэл өөрийн сэтгэл дотроо итгэл бишрэлийг бясалган залбирч болох бөгөөд ингэснээр тэдний өөрсдийн алс хэтийн сайн сайхан, аз жаргалын төлөө үйл болдог билээ.”

Дараа нь Кусинаараагийн маллачууд эрчүүддээ:

“За тэгвэл, маллачуудынхаа бэлдсэн даавуунуудаараа Буддагийн шарилыг ороож эхэлье, нөхөд өө.” хэмээн уриалав.

---

457 *Makuṭabandhana*—“Макутабандхана”. Тухайн цагийн шүтээн мөргөлийн нэгэн газар.

Ингээд Кусинаараагийн маллачууд Буддагийн шарилыг шинэ маалинган даавуунд ороосны дараа, эсгийгээр давхарлан боогоод, мөн дахин шинэ даавуугаар үүний гадуур ороов. Үүнийг тус бүр таван зуун удаа давтан хийсний дараа төмөр онгоцтой тосонд дүрж хийгээд, дараа нь төрөл бүрийн үнэртэн бүхий, өөр нэг онгоцонд хийж битүүмжлээд, оршуулгын шатаах тавцан дээр тавив.

38. Ахмад Хувраг Махаакассапагийн Тухай (Mahākassapattheravatthu)

Тэр үед ахмад хувраг, Эрхэм Махаакассапа[458] таван зуу орчим хуврагуудын хамт Пааваагаас Кусинаараа хүрэх төв замаар явж байв. Эрхэм Махаакассапа замаас гарч, нэгэн модны ёроолд суув. Харин тэр үед, Аажийвака[459] шашны нэгэн даянч Мандарваа цэцэг барин Кусинаараагаас Паавaa руу мөн тэр төв замаар явж байлаа.

Эрхэм Махаакассапа аажийвака даянчийг алсаас ойртон ирэхийг хараад, түүнийг ойртон ирсний дараа тэр аажийвака даянчид ингэж хэлэв:

“Найз минь, чи манай Багшийг таньдаг уу?”

“Тэгэлгүй яах вэ. Найз аа, би мэднэ. Өнөөдөр даянч Готама Эцсийн Нирваанд одсоноос хойш долоо хоног болж буй тул би Мандарваа цэцэг барих гэж байгаа билээ.” гэв.

Тэгтэл тэнд байсан дур-хүслээс хараахан ангижраагүй зарим хуврагууд, гараа савчин савж унаж, хөлөө тайруулсан мэт урагш хойш өнхрөн уйлж:

“Будда арай эрт Эцсийн Нирваанд одлоо. Будда дэндүү эрт Эцсийн Нирваанд одлоо, энэ дэлхийн Мэлмий болсон тэр Эцсийн Нирваанд ингээд эрт одлоо!” гэцгээж байв.

Харин дур-хүслээс ангид болсон хуврагууд дүүрэн-анхаарал тунгалаг-оюунаар энэ бүгдийг давах зуур: “Сэдэхүй-цогцлохуй бүхэн мөнхийн-бус. Үүнээс өөрөөр яах байсан гэж?” хэмээн бодох аж.

Харин яг тэр үед, Субхадда хэмээх өтөл насандаа сахил авсан нэгэн хувраг тэр хэсэг хуврагууд дунд сууж байв. Тэгээд тэрээр тэдгээр хуврагуудад ийн өгүүлрүүн:

“Хангалттай, андууд аа. Бүү харамс. Бүү гашууд. Бид, ‘Үүнийг чамд зөвшөөрнө. Үүнийг бол зөвшөөрөхгүй.’ гээд байх Агуу Даянчаас одоо ангижирлаа. Одоо бид харин ч хүссэн бүхнээ хийж, хүсээгүй зүйлээ хийхгүй байж болохоор боллоо.” гэж хэлэв.

Тэгэхэд нь эрхэм Махаакассапа хуврагуудад хандан:

---

458 Судaрт *Mahākassapa* нэртэй цөөнгүй хүн гардаг ч энэ хувраг бол Буддагийн ахмад хувраг Махаакассапа (*Mahākassapatthera*) юм. Буддагийн бусад ахмад хуврагууд болох Саарипутта, Моггаллаана нар энэ үед өөд болсон байсан ба Махаакассапа нь хамгийн ахмад хувраг нь бөгөөд тэр ганцаар даянчлан амьдрагч нэгэн байж.

459 *Ājīvaka*—“Аажийвака” (анг. *fatalism* эсвэл *determinism*). Тухайн цагийн, “хувь төөрөгт захирагдах” (па. *niyativāda*) номлолыг заадаг шашны урсгал. DN 2.1 болон DN 2.3.2.-т гарсан даянч багш Маккхали Госаала энэ урсгалыг үүсгэгч, удирдагч юм.

“Одоо болно оо. Эрхэм нөхөд өө, бүү харамс. Бүү гашууд. ‘Хайр татсан, сэтгэл булаасан бүх юм өөрчлөгдөн хувьсаж, салан холдож, ондоошин хувирдаг биш үү? Төрсөн, бий болсон, сэдэгдсэн-цогцолсон бол эвдрэх Жамтай байхаас бус өөрөөр яана гэж? Өөрөөр байх боломжгүй.’ гэж Будда та нарт заагаагүй гэж үү?” хэмээн хэлэв.

Тэр үед маллачуудын дөрвөн удирдагч нь толгойгоо угааж, цэвэрхэн хувцас өмсөөд: “Буддаг чандарлах галыг асаая” гэж хэлсэн боловч тэд галаа асааж чадсангүй. Дараа нь Кусинаараагийн маллачууд Эрхэм Ануруддхад ингэж хэлэв:

“Учир юунд байна вэ? Эрхэм Ануруддха, ямар учиртай юм бэ? Яагаад маллачуудын дөрвөн удирдагч нь толгойгоо угааж, цэвэрхэн хувцас өмсөөд, ‘Буддагийн шарилыг чандарлах галыг асаая!’ гэх боловч тэр гал яагаад ассангүй вэ?”

“Ваасеттхачууд аа, бурхдад өөр бодол байна.”

“Тэгвэл бурхдын өөр бодол нь юу юм бэ, эрхэм ээ?”

“Бурхдын бодол нь, ваасеттхачуудаа, ‘Эрхэм Махаакассапа Паавaагаас Кусинаараа хүрэх төв замаар, таван зуу орчим хуврагуудын хамтаар ирж байгаа бөгөөд Эрхэм Махаакассапа байхгүй байхад, тэр Буддагийн өлмийд толгой сөгдөн мөргөөгүй байгаа цагт, Буддагийн оршуулгын гал асахгүй.’ юм.”

“Тэгвэл, бурхдын таалллаар болцгооё! Эрхэм ээ.” гэв.

Дараа нь Эрхэм Махаакассапа Кусинаараад ирж, маллачуудын шүтээн мөргөлийн Макутабандхана нэртэй, Буддагийн оршуулгын галыг асаах гэж байгаа мөнөөх газар дээр хүрч ирэв. Мөрөн дээрх гадуур орхимжоо засаад, хүндэтгэлтэйгээр алга хавсран залбирч, оршуулгын галыг гурван удаа тойрч, мөн Буддагийн өлмийг ил гаргаад, түүний өлмийд толгойгоо хүргэн сөгдөн мөргөв.

Түүнчлэн таван зуун хувраг, мөрөн дээрх гадуур орхимжоо засаж, хүндэтгэлтэйгээр алга хавсран залбирч, оршуулгын галыг гурвантаа тойроод, мөн Буддагийн өлмийд толгойгоо хүргэн сөгдөн мөргөцгөөв.

Ингээд Эрхэм Махаакассапа болон таван зуун хувраг Буддагийн шарилд мөргөн, ийн хүндэтгэл үзүүлсний дараа оршуулгын гал өөрөө асав.

Буддагийн бие шатаж байх тэр үед, түүний гадна арьс, дотор арьс, мах, шөрмөс, үе мөчний шингэн зэргээс хөө тортог ч гарсангүй төдийгүй, биеэс нь үнс ч үлдсэнгүй. Зөвхөн гэгээнтний чандар[460] үлдэв. Тос юм уу, эсвэл шар тос шатаж байхад хөө тортог гардаггүйтэй адил Буддагийн бие шатаж байх тэр үед түүний гадна арьс, дотор арьс, мах, шөрмөс, үе мөчний шингэн зэргээс хөө тортог ч гарсангүй төдийгүй, биеэс нь үнс ч үлдсэнгүй. Зөвхөн гэгээнтний чандар л үлдсэн байв.

[460] *Sarīrāni*—“чандар”. Үгчилбэл, “цогцос, шарил, бие”. Энэ паали эх үг олон тоон дээр бичигдсэн байгаа нь гүн хүндэтгэлтэй холбоотой бололтой. DN 16.29-д энэ үг Аананда Буддагаас түүний *sarīra*-г хэрхэх талаар асуун, анх дурдагдахдаа нэг тоон дээр байсныг “шарил” гэж, энэ удаад “чандар” гэж оруулав. (Паали хэлэнд гүн хүндэтгэлд, нэр үгийг олон тоон дээр хэрэглэх нь түгээмэл.)

Тэдгээр шарил ороосон, таван зуун хос даавуунаас зөвхөн хамгийн дотор талын болон хамгийн гадна талын хэсэг шаталгүй үлдсэн байлаа.

Мөн Буддагийн шарилыг шатаж дуусахад, тэнгэрээс их бороо асгарч, Буддагийн оршуулгын галыг унтраажээ. Мөн Ихэр Сал Моддоос ус оргилж, Буддагийн оршуулгын галыг унтраажээ. Мөн Кусинаараагийн маллачууд анхилуун усаар цацаж Буддагийн оршуулгын галыг унтраажээ.

Дараа нь Кусинаараагийн маллачууд хотын зөвлөлийн танхим дотор, жадаар хашлага хамгаалалт хийж, Буддагийн шарилаас үлдсэн гэгээнтний чандрыг нумаар хүрээлэн, дээдлэн шүтэж, сөгдөн мөргөж, хүндэтгэлийн бүжиг, дуу, хөгжим эгшиг, цэцэг чимэглэл, анхилуун үнэрт ус зэргээр ёслол хүндэтгэл үзүүлцгээж байв.

39. Гэгээнтний Чандрыг Хуваарилсан нь (Sarīradhātuvibhajana)

Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту:

“Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой.” гэж дуулав. Дараа нь Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

“Будда бол язгууртан байсан. Би ч бас язгууртан юм. Би Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Би суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ.” хэмээн мэдэгдэв.

Харин дараа нь Весаалийгийн личчхавий нар:

“Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой.” гэж дуулав. Тэгээд Весаалийгийн личчхавий нар Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

“Будда бол язгууртан байсан. Бид ч мөн язгууртнууд бөлгөө. Бид Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Бид суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ.” хэмээн мэдэгдэв.

Мөн дараа нь Капилаваттхугийн[461] Сакячууд:

“Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой.” гэж дуулав. Тэгээд Капилаваттхугийн Сакячууд Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

“Будда бол яах аргагүй бидний нэг. Бидний үр удам. Бид Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Бид суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ.” хэмээн мэдэгдэв.

---

[461] *Kapilavatthu*—“Капилаваттху” (сам. *Kapilavastu*). Готама Буддагийн удам угсааны Сакя овгийнхны нийслэл хот бөгөөд түүний өссөн газар.

Мөн түүнчлэн, Аллакаппагийн була нар[462]:

“Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой.” гэж дуулав. Тэгээд Аллакаппагийн була нар, Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

“Будда бол язгууртан байсан. Бид ч мөн язгууртнууд бөлгөө. Бид Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Бид суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ.” хэмээн мэдэгдэв.

Дараа нь Раама тосгоны колиячууд[463]:

“Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой.” гэж дуулав. Тэгээд Раама тосгоны колиячууд, Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

“Будда бол язгууртан байсан. Бид ч мөн язгууртнууд бөлгөө. Бид Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Бид суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ.” хэмээн мэдэгдэв.

Дараа нь бярман Веттхадийпака[464]:

“Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой.” гэж дуулав. Тэгээд бярман Веттхадийпака, Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

“Будда бол язгууртан байсан. Би бол бярман хүн. Би мөн Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Би суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ.” хэмээн мэдэгдэв.

Тэр үед мөн, Пааваагийн маллачууд:

“Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой.” гэж дуулав. Тэгээд Пааваагийн маллачууд, Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

“Будда бол язгууртан байсан. Бид ч мөн язгууртнууд бөлгөө. Бид Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Бид суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ.” хэмээн мэдэгдэв.

Энэ бүгдийн дараа, Кусинаараагийн маллачууд өөрсдийн зөвлөл болон хүмүүстээ хандан:

---

[462] *Allakappakā bulayo*—“Аллакаппагийн була нар”. Судрын өөр хаана ч огт дурдагдаагүй, тайлбар хийх эх сурвалжгүй, хот ба омгийн нэр.

[463] *Rāmagāmakā koḷiyā*—“Раама тосгоны колиячууд”. Колиячууд нь Сакя нарын зүүн өмнөд хөрш байсан бөгөөд тэдний хот, хүмүүсийн тухай эртний өөр бусад судрат дурдагдсан байна (BS).

[464] *Veṭṭhadīpako brāhmaṇo*—“бярман Веттхадийпака”. Өөр судрат огт дурдагдаагүй нэр (BS).

"Будда манай тосгоны нутаг дэвсгэр дээр Эцсийн Нирваанд одсон. Бид Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандрыг ингээд тараачхаж болохгүй." гэж хэлэв. Үүнийг хэлсний дараа бярман Дона[465] өөрсдийн зөвлөл болон хүмүүстээ хандан ингэж хэлэв:

'Энд цугласан нөхөд өө, миний хэлэхийг сонсоорой
Эрхэм Будда бол тэвчээрийг дээдэлдэг хүн байсан
Энэ агуу хүнээс үлдсэн эрдэнийн чулуун дээр
Эсэргүүцэл тэмцэл хийх нь сайн хэрэг лав биш
Эрхэм нөхөд өө, эв нэгдэлтэй байцгаая бүгдээрээ
Энгүй амгалан сэтгэлээр, эрдэнийн чулууг найм хуваая,
Энэ дэлхийн найман зүг зовхист бунхан суварга босгоё
Ингэснээр олон хүн зон Буддад улам сүсэглэх учиртай."

"Тэгвэл бярман та, Буддагийн биеэс үлдсэн, гэгээнтний чандрыг найман тэнцүү хэсэгт хуваах ёстой болж байна." гэхэд:

"Тэгье ээ, эрхэм ноёд оо." гэж бярман Дона тэдгээр хүмүүст хариулаад, Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандрыг найман тэнцүү хэсэгт хувааж, тэдгээр өөрсдийн зөвлөл болон хүмүүстээ хандан ийн хэлэв:

"Эрхэм ноёд оо. Надад энэ бумбыг өгөөч. Би ч мөн суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ." гэж хэлэхэд нь, тэд бумбыг бярман Донад өгөв.

Дараа нь Пиппаливанагийн морияа нар[466]:

"Будда Кусинаараад, Эцсийн Нирваанд одсон бололтой." гэж дуулав. Тэгээд Пиппаливанагийн морияа нар Кусинаараагийн маллачууд руу илчээ илгээж:

"Будда бол язгууртан байсан. Бид ч мөн язгууртнууд бөлгөө. Бид Буддагийн биеэс үлдсэн гэгээнтний чандраас мөн хувь хүртэх учиртай. Бид суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийнэ." хэмээн мэдэгдэв.

"Буддагийн биеэс гарсан гэгээнтний чандраас үлдсэнгүй. Оронд нь энэ үлдсэн хэсэг үнсийг ав." гэхэд тэд үнснээс аваад явцгаав.

40. Гэгээнтний Чандрыг Дээдлэхүй (Dhātuthūpapūjā)

Дараа нь Видехаа хатны хүү, Магадхагийн хаан Ажаатасатту Раажагахад, гэгээнтний чандар агуулсан суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

465 *Doṇo brāhmaṇo*—"бярман Дона". Өөр хэд хэдэн судард дурдагдсан бярман (AN 4.36; AN 5.192).

466 *Pippalivaniyā moriyā*—"Пиппаливанагийн морияа нар". Тухайн цагийн жижиг овог аймаг.

Весаалийгийн личчхавий нар Весаалийд, гэгээнтний чандар агуулсан суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

Капилаваттхугийн Сакя нар Капилаваттхуд, гэгээнтний чандар агуулсан суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

Аллакаппагийн була нар Аллакаппа хотод, гэгээнтний чандар агуулсан суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

Раама тосгоны колияа нар Раама тосгонд, гэгээнтний чандар агуулсан суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

Веттхадийпака бярман, гэгээнтний чандар агуулсан суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

Пааваагийн малла нар, Паавaад суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

Кусинаараагийн малла нар Кусинаараа хотод суварга бунхан босгож, оршуулгын дурсгалд зориулж баяр наадам хийв.

Бярман Дона гэгээнтний чандар агуулсан бумбандаа зориулсан суварга бунхан хийж, наадам зохион байгуулав.

Пиппаливанагийн морияа нар Пиппаливанад чандрын үнс агуулсан суварга бунхан хийж, наадам зохион байгуулав.

Ийнхүү шарилын дурсгалд зориулсан найман суварга бунхан байсан бол бумбат дуган ес дэх нь, үнс агуулсан суварга арав дахь нь болжээ.

Чандрын найман хэсэг түүнээс үлдэж
Чавганы оронд үүний долоо нь тахигдав.
Хүмүүний дээд түүний чандрын нэг хувь
Хүчит луугийн хааны Раамагаамад шүтэгдэв.

Нэг шүд Гучин Гурван Тэнгэрт дээдлэгдэж
Нөгөө нь Гандхаара хотноо тахигдав.
Өөр нэг нь Калингагийн хааны нутагт
Өшөө нэг нь луугийн хаанд шүтээн болов.

Тэдний сүр жавхаагаар энэ баян дэлхий
Тэнгэрлэг өргөлөөр чимэглэгдэн байна.
Тунгалаг Мэлмий түүний шарил
Тусгай хүндлэлийг олсон байна.

Хүчит лус бурхад тэнгэрүүдэд хүндлэгдэж
Хүн төрөлхтний удирдагчдад ч шүтэгдэв.
Зуун галавт нэг л тохиодгийг нь санаад
Зуур ч болов алга хавсран залбирна уу.

Тэргүүн болоод биеийн үс
Тэгш дөчин шүд бүтнээрээ
Тэнгэр бурхдад гардагдан
Тэртээ алсад халин оджээ.

Агуу Нирваанд Нэгмөсөн Одохуй Судар энд өндөрлөв.

АГУУ ДҮҮРЭН-АНХААРАЛ СУУЛГАХУЙ СУДАР DN 22. MAHĀSATIPAṬṬHĀNASUTTA

БИ ИЙН СОНССОН ЮМ.

Нэгэн цагт Будда, куручуудын нутаг болох Каммаасадамма гэх худалдаа наймааны хотын ойролцоо, куру иргэдийн дунд амьдарч байлаа. Тэнд Будда хуврагуудад хандан:

“Хуврагууд аа.” хэмээн дуудахад, хуврагууд:

“За, Багш аа.” хэмээн хариулж, анхаарлаа хандуулцгаав.

Будда өгүүлрүүн:

“Хуврагууд аа, энэ бол, хэнийг ч ариусалд оруулах, харуусал, уй гашууг даван туулах, зовлон шаналлыг арилгах, ухаарлыг олох, Нирваанд одуулах, нэг чигийн[467] зам бөгөөд өөрөөр хэлбэл энэ бол дүүрэн-анхаарал суулгах[468] дөрвөн бясалгал юм.

Тэр дөрөв нь юу бол?

Хуврагууд аа,

1. Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, бие дээр[469] биеийн ажиглалттайгаар[470], хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна[471].

2. Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, мэдрэмж[472] дээр мэдрэмжийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

---

467 *Ekāyano*—“нэг чигийн” (анг. *leading in one direction*, BA). Энэ үгийг, BB, BN: “шулуун зам (анг. *the direct path*)”, R. Gethin: “нэг зорилгод хөтлөх нэгэн зам (анг. *a path that leads to one goal*)”, BT: “нэг урсгалтай зам (анг. *the one-way course*)” гэж орчуулжээ. Хувраг Махааси (Mahasi Sayadaw) болон цөөнгүй уламжлалд “цорын ганц арга зам” гэж орчуулах нь байдаг ч, энэ хувилбар нь зарим паали судартай харшилж болно гэж үздэг. Мөн “оюуны-нэгдэл (па. *ekaggatā*, анг. *one-pointedness*)-д хүргэх” бясалгал гэсэн өөр нэг тайлбар бий (DA).

468 *Satipaṭṭhānā*—“дүүрэн-анхаарал суулгах”. *Sati*—“дүүрэн-анхаарал”. Ариуслын-замналын үндсэн хэсэг болох сахил-ухамсар, самади-төвлөрөл, саруул-ухаанаар анхаарлаа дүүрэн байлгахуй, эдгээрийг ямагт санаж байхуй, эс умартахуй. *Paṭṭhāna*—“суулгах” буюу “үүсгэн бий болгох” (анг. *establishment*, BA). *Satipaṭṭhānā*-г орчин үед *Vipassana* бясалгал зэргээр нэрлэж байж болох ч, Паали Судартбуй *vipassanā* ойлголт, тухайн цагийн хэрэглээг дөрвөн даяаныг оршоосны дараа дурдагдах DN 2.4.15 хэсгээс харж болно.

469 *Kāye*—“бие дээр”. Бие махбод дээр.

470 *Kāyānupassī*—“биеийн ажиглалттай”. Эсвэл “биеийн эргэцүүлэлтэй”, “бие махбодын байдлыг ажиглан” гэсэн утгаар. “Бие дээр биеийн ажиглалт…” гэдгийг зарим тайлбарт “биеийг биеэр нь ажиглах” буюу “биеийг зүгээр л нэгэн бие махбод” гэсэн байдлаар ажиглах гэжээ (BA). Мөн адил “мэдрэмжийг ердөө л мэдрэмж гэдгээр нь…” г.м.

471 *Viharati*—“оршин байна”. Эсвэл “амьдарна”, “байна”, “бясалгана”.

472 Паали эх дээр, энэ судартгарах хоёр “мэдрэмж” олон тоон дээр байгааг анхаарна уу (“мэдрэмжүүд дээр мэдрэмжүүдийн…”). Судрын үлдсэн хэсэгт анхаар.

3. Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

4. Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, Үзэгдэл[473] дээр Үзэгдлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Оршил өндөрлөв.

1. Биеийг Ажихуй (Kāyānupassanā)

1.1. Биеийг Ажихуйн Орох Гарах Амьсгалын Тухай (Kāyānupassanāānāpānapabba)

Хуврагууд аа, хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар, хэрхэн оршин байх билээ?

Хувраг хүмүүн, алс зэлүүд газар, аль эсвэл модны ёроолд, аль эсвэл хоосон оромжид, хоёр хөлөө зөрүүлэн завилан суугаад, биеэ эгц болгон, ам хамар орчимдоо[474] дүүрэн-анхаарлыг бий болгоно. Ийн дүүрэн-анхааралтайгаар амьсгал авч, ийн дүүрэн-анхааралтайгаар амьсгалаа гаргана.

Гүн[475] амьсгал ороход:

“Гүн амьсгал орлоо.” гэж мэдэж ойлгоно. Гүн амьсгал гарахад:

“Гүн амьсгал гарлаа.” гэж мэдэж ойлгоно. Гүехэн амьсгал ороход:

“Гүехэн[476] амьсгал орлоо.” гэж мэдэж ойлгоно. Гүехэн амьсгал гарахад:

“Гүехэн амьсгал гарлаа.” гэж мэдэж ойлгоно. Түүнчлэн тэрээр:

“Би бүхий л биеэ мэдэрч, амьсгал авна.” хэмээн дадуулна. Түүнчлэн тэрээр:

“Би бүхий л биеэ мэдэрч, амьсгалаа гаргана.” хэмээн дадуулна. Түүнчлэн тэрээр:

“Би биеийн үйл хөдөлгөөнийг тайвшруулж, амьсгал авна.” хэмээн дадуулна. Түүнчлэн тэрээр:

“Би биеийн үйл хөдөлгөөнийг тайвшруулж, амьсгалаа гаргана.” хэмээн дадуулна.

---

473 *Dhammesu*—“Үзэгдэл дээр”. (*Dhamma*—Сургаал, Жам ёс, Юмс Үзэгдэл, Үнэн, Чанар г.м.) Энэ судартˮ “Үзэгдэл” эсвэл “Төсөөлөл” гэж оруулав (Тайлбарт Сургаал хэсгийг хар). Паали эх дээр, энэ сударт гарах хоёр “*Dhamma*” олон тоон дээр байгааг анхаарна уу (“Үзэгдлүүд дээр Үзэгдлүүдийн…”). Судрын үлдсэн хэсэгт анхаар.

474 *Parimukhaṁ*—“ам хамар орчимдоо” (*pari*—“орчимд”, *mukha*—“ам, нүүр”). Зарим орчуулгад “өмнөө”, “урдаа” гэжээ (BB).

475 Гүнзгий, урт, уужим г.м.

476 Богино, охор, мөчид г.м.

Туршлагатай нэгэн мужаан, эсвэл түүний туршлагагүй нэгэн суралцагчийн үйлдэлтэй яг л адилхан үйлдэл юм.

Гүн зүсэлт хийдээ тэд:

“Би гүн зүсэлт хийж байна.” гэж, харин гүехэн зүсэлт хийхдээ:

“Би гүехэн зүсэлт хийж байна.” гэж мэдэж ойлгож байдаг.

Яг л үүний адилаар, гүн амьсгал ороход:

“Гүн амьсгал орлоо.” гэж мэдэж ойлгоно. Гүн амьсгал гарахад:

“Гүн амьсгал гарлаа.” гэж мэдэж ойлгоно. Гүехэн амьсгал ороход:

“Гүехэн амьсгал орлоо.” гэж мэдэж ойлгоно. Гүехэн амьсгал гарахад:

“Гүехэн амьсгал гарлаа.” гэж мэдэж ойлгоно. Түүнчлэн тэрээр:

“Би бүхий л биеэ мэдэрч, амьсгал авна.” хэмээн дадуулна. Түүнчлэн тэрээр:

“Би бүхий л биеэ мэдэрч, амьсгалаа гаргана.” хэмээн дадуулна. Түүнчлэн тэрээр:

“Би биеийн үйл хөдөлгөөнийг тайвшруулж, амьсгал авна.” хэмээн дадуулна. Түүнчлэн тэрээр:

“Би биеийн үйл хөдөлгөөнийг тайвшруулж, амьсгалаа гаргана.” хэмээн дадуулна.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь[477], бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь[478], бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь[479], нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд[480], энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд[481] хангалттай байдлаар “Бие байна”[482] гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

---

477 *Ajjhattaṁ*—“дотоод талаас нь”. Зарим орчуулгад “өөрийн биеийг”, “өөрийн бие гэдэг талаас нь” гэжээ (BS).

478 *Bahiddhā*—“гадаад талаас нь”. Зарим орчуулгад “өрөөлийн биеийг” гэжээ (BS).

479 *Ajjhattabahiddhā*—“дотор гадар аль аль талаас нь”. Зарим орчуулгад “өөрийн болон өрөөлийн биеийг” гэж тайлбарласан байна (BS).

480 *Ñāṇamattāya*—“энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд”. Өөрөөр: “ердөө л мэдэж байх үүднээс”.

481 *Paṭissatimattāya*—“энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд”. Өөрөөр, “ердөө санаж, анхаарч байх үүднээс”.

482 *‘Atthi kāyo’*—“Бие байна”. Өөрөөр: “Энд бие махбод байна”, “ Энэ бол бие махбод”. Бясалгагч оюунд бууж байгаа зүйлээ энэ бол “бие”, “мэдрэмж”, “сэтгэл”, “Үзэгдэл” байна гэх мэтээр танихыг энд хэлсэн санаа болно. Үүнийг дараа хэсгүүдэд мөн яг ийм хэлбэрээр гарах Мэдрэмж, Сэтгэл, Үзэгдэл дээр ижил байдлаар тусгаж ойлгоно уу.

Орох Гарах Амьсгал хэсэг өндөрлөв.

1.2. Биеийг Ажихуйн Байрлалын Тухай (Kāyānupassanāiriyāpathapabba)

Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн алхаж явахдаа,

“Би алхаж байна.” гэж мэдэж ойлгоно. Зогсож байхдаа,

“Би зогсож байна.” гэж мэдэж ойлгоно. Сууж байхдаа,

“Би сууж байна.” гэж мэдэж ойлгоно. Хэвтэж байхдаа,

“Би хэвтэж байна.” гэж мэднэ.

Түүний бие ямар ч байдалд байсан, тэр үүнийг яг байгаагаар нь мэдэж ойлгоно.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

Байрлал хэсэг өндөрлөв.

1.3. Биеийг Ажихуйн Тунгалаг-Оюуны Тухай (Kāyānupassanāsampajānapabba)

Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн урагш явсан ч, ухарч явсан ч тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Урагшаа харсан ч, хойшоо харсан ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ.

Үе мөчөө нугалсан ч, тэнийлгэсэн ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ.

Орхимжоо өмссөн ч, бадрын аягаа барин алхаж явсан ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ.

Идэхдээ ч, уухдаа ч, зажлахдаа ч, амтлахдаа ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ. Хүндээр бие засахдаа ч, хөнгөнөөр бие засахдаа ч, тэрбээр тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ.

Явахдаа ч, зогсохдоо ч, суухдаа ч, унтахдаа ч, сэрүүн байхдаа ч, ярихдаа ч, яриагүй байхдаа ч, тэрбээр энэ бүгдийг тунгалаг-оюуныг оршоон үйлдэнэ.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь, бие дээрээ, биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь, бие дээрээ, биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

Тунгалаг-Оюуны хэсэг өндөрлөв.

1.4. Биеийг Ажихуйн Бохирыг Эргэцүүлэх Тухай (Kāyānupassanāpaṭikūlamanasikārapabba)

Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, хөлийн улнаас дээшээ, толгойн үсний үзүүр хүртэл бүхэлдээ арьсаар хучигдсан элдэв төрлийн бохироос бүрдсэн энэ биеийг ийн эргэцүүлэн тунгаана:

“Энэ бие дотор: толгойн үс, биеийн үс, хумс, шүд, арьс, мах, шөрмөс, яс, чөмөг, бөөр, зүрх, элэг, гялтан, дэлүү, уушги, гэдэс, сэмж, шингээгүй хоол, ялгадас, цөс, цэр, идээ, цус, хөлс, өөх, нулимс, тос, шүлс, нус, үений шингэн, шээс зэрэг байна.”

Цагаан будаа, улаан буудай, ногоон буурцаг, вандуй, шош, шар будаа зэрэг янз бүрийн үр тариагаар дүүргэсэн, хоёр үзүүртээ нүхтэй уут байлаа гэж бодъё. Үүнийг нээн харж буй, хараа сайтай хүмүүн, доторх зүйлсийг:

“Энэ будаа бол цагаан будаа байна. Эдгээр нь улаан буудай байна. Тэдгээр нь харин буурцаг байна. Энэ нь вандуй. Тэр нь шош. Энэ бол шар будаа.” гэх зэргээр ялгаж салган, шинжиж харах болно.

Яг л үүний нэгэн адилаар, хувраг хүн, хөлийн улнаас дээшээ, толгойн үсний үзүүр хүртэл бүхэлдээ арьсаар хучигдсан элдэв төрлийн бохироос бүрдсэн энэ биеийг ийн эргэцүүлэн тунгаана:

“Энэ бие дотор: толгойн үс, биеийн үс, хумс, шүд, арьс, мах, шөрмөс, яс, чөмөг, бөөр, зүрх, элэг, гялтан, дэлүү, уушги, гэдэс, сэмж, шингээгүй хоол, ялгадас, цөс, цэр, идээ, цус, хөлс, өөх, нулимс, тос, шүлс, нус, үений шингэн, шээс зэрэг байна.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

Бохирыг Эргэцүүлэх хэсэг өндөрлөв.

1.5. Биеийг Ажихуйн Язгуур Махбодыг Эргэцүүлэх Тухай (Kāyānupassanādhātumanasikārapabba)

Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн энэ биеийг ямар ч байрлалтай, ямар ч байдалтай байсан бай, язгуур махбодынх нь хувьд шинжин эргэцүүлэхдээ:

“Энэ бие бол: газар махбод, ус махбод, гал махбод, агаар махбод, гэсэн дөрвөн махбодоос бүрддэг.” гэж язгуур дөрвөн махбодоор нь харж бодно.

Туршлагатай нэгэн мал нядлагч, эсвэл түүний туршлагагүй нэгэн суралцагч, үнээ нядалж, эд эрхтнээр нь жиргэсний дараа, олон хөлийн газарт дэлгэж тавиад суудаг үйлдэлтэй яг адилхан үйлдэл юм.

Яг л үүний адилаар, хувраг хүн, энэ биеийг ямар ч байрлалтай, ямар ч байдалтай байсан бай, язгуур дөрвөн махбодынх нь хувьд шинжин эргэцүүлэхдээ:

“Энэ бие бол: газар махбод, ус махбод, гал махбод, агаар махбод, гэсэн дөрвөн махбодоос бүрддэг.” гэж язгуур дөрвөн махбодоор нь харж бодно.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

Язгуур Махбодыг Эргэцүүлэх хэсэг өндөрлөв.

1.6. Биеийг Ажихуйн Есөн Шарилын Газрын Тухай (Kāyānupassanānavasivathikapabba)

1. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцос нэг хоносон, хоёр хоносон, гурван хоносон эсвэл бүр олон өдөр болсон, хөөж хавдсан, зэвхий даасан, илжирч ялзарсан байдалтай байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

“Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

2. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцсыг хэрээ идэж байгааг, шонхор идэж байгааг, тас идэж байгааг, дэглий идэж байгааг, нохой идэж байгааг, бар идэж байгааг, ирвэс идэж байгааг, зэрэг элдэв амьтад идэж байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

“Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

3. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцсын араг яс нь мах цустайгаа, шөрмөсөөр хоорондоо хэлхээтэй байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

“Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

4. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцсын араг яс нь махгүй болж, цусан судал үлдсэн, шөрмөсөөр хоорондоо хэлхээтэй байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

“Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

5. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцсын араг яс нь мах ч үгүй, цус ч үгүй болсон, шөрмөсөөр хоорондоо хэлхээтэйгээ байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

“Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

6. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцсын араг яс нь салж үүгээр түүгээр тарсан, тэнд шууны яс, энд хөлийн яс, тэнд өсгийн яс, энд шилбэний яс, тэнд гуяны яс, энд ташааны яс, тэнд хавирганы яс, энд далны яс, тэнд нурууны яс, энд хүзүүний яс, тэнд эрүүний яс, энд араа шүднүүд, тэнд гавлын яс байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

“Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Бие байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

7. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцсын араг яс нь хувхай цайж, хясаа шиг болсон байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

“Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ.”

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар "Бие байна" гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

8. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцос олон жил болж, араг яс нь хааш яаш хөглөрч, хөсөр идсэн байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

"Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ."

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар "Бие байна" гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

9. Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, шарилын газарт хаягдсан цогцсын өгөр идсэн араг яс нь, үйрч бутарсан байгааг харж буйн адил энэ өөрийн биеийг ийн эргэцүүлэн бодно:

"Миний бие махбод ч мөн адил ийм л шинж чанартай. Ийм болох жамтай. Энэ явдлаас зугтах аргагүй байдаг билээ."

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь бие дээр биеийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, биед үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл биеэс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн биед үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар "Бие байна" гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, бие дээр биеийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

Есөн Шарилын Газрын хэсэг өндөрлөв.

Биеийг Ажихуйн арван дөрвөн хэсэг өндөрлөв.

2. Мэдрэмжүүдийг Ажихуй (Vedanānupassanā)

Хуврагууд аа, мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттай хэрхэн орших вэ?

Хуврага хүн жаргалыг мэдрэх үедээ,

“Би, жаргалыг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Зовлонг мэдрэх үедээ,

“Би, зовлонг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Жаргалтай ч биш, зовлонтой ч биш мэдрэмжийг мэдрэх үедээ тэр,

“Би, жаргалтай ч биш, зовлонтой ч биш мэдрэмжийг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Бие махбодын жаргалыг мэдрэх үедээ,

“Би, бие махбодын жаргалыг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Бие махбодын бус жаргалыг мэдрэх үедээ,

“Би, бие махбодын бус жаргалыг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Бие махбодын зовлонг мэдрэх үедээ,

“Би, бие махбодын зовлонг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Бие махбодын бус зовлонг мэдрэх үедээ,

“Би, бие махбодын бус зовлонг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Бие махбодын жаргалтай ч биш, зовлонтой ч биш мэдрэмжийг мэдрэх үедээ, “Би, бие махбодын жаргалтай ч биш, зовлонтой ч биш мэдрэмжийг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгоно.

Бие махбодын бус, жаргалтай ч биш, зовлонтой ч биш мэдрэмжийг мэдрэх үедээ, “Би, бие махбодын бус, жаргалтай ч биш, зовлонтой ч биш мэдрэмжийг мэдэрч байна.” гэж мэдэж ойлгож байдаг.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, мэдрэмжид үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан оршиж, эсвэл мэдрэмжээс үгүй болох Үзэгдлийг ажиглан оршиж, мөн мэдрэмжид үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Мэдрэмжүүд байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

Мэдрэмжүүдийг Ажихуй хэсэг өндөрлөв.

3. Сэтгэлийг Ажихуй (Cittānupassanā)

Хуврагууд аа, хувраг хүн, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай хэрхэн орших вэ?

Хувраг хүн:

Дур-хүсэлтэй сэтгэлийг,

“Дур-хүсэлтэй сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл дур-хүсэлгүй сэтгэлийг,

“Дур-хүсэлгүй сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл уур-хилэнтэй сэтгэлийг,

“Уур-хилэнтэй сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл уур-хилэнгүй сэтгэлийг,

“Уур-хилэнгүй сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл төөрөгдөлтэй сэтгэлийг,

“Төөрөгдөлтэй сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл төөрөгдөл үгүй сэтгэлийг,

“Төөрөгдөл үгүй сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл давчуу сэтгэлийг,

“Давчуу сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл үймэрсэн сэтгэлийг,

“Үймэрсэн сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл агуу сэтгэлийг,

“Агуу сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл өчүүхэн сэтгэлийг,

“Өчүүхэн сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл төгөлдөр бус сэтгэлийг,

“Төгөлдөр бус сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл төгөлдөр сэтгэлийг,

“Төгөлдөр сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл төвлөрсөн сэтгэлийг,

“Төвлөрсөн сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл төвлөрөл үгүй сэтгэлийг,

“Төвлөрөл үгүй сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл ангижирсан сэтгэлийг,

“Ангижирсан сэтгэл байна.” гэж мэдэж ойлгоно.

Эсвэл ангижрал үгүй сэтгэлийг,

“Ангижрал үгүй сэтгэл байна.” хэмээн мэдэж ойлгож байдаг.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Ийнхүү, сэтгэлд үүсэн бий болох Үзэгдлийг ажиглан орший, эсвэл сэтгэлээс үгүй болох Үзэгдлийг ажиглан орший, мөн сэтгэлд үүсэх хийгээд үгүй болох Үзэгдлийг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Сэтгэл байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттайгаар оршин байдаг билээ.

Сэтгэлийг Ажихуй хэсэг өндөрлөв.

4. Үзэгдлүүдийг Ажихуй (Dhammānupassanā)

4.1. Үзэгдлүүдийг Ажихуйн Саадын Тухай (Dhammānupassanānīvaraṇapabba)

Хуврагууд аа, хуврагхүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар таван-саадыг ямагт санан хэрхэн орших вэ?

Хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар оршихдоо таван-саадыг ямагт санаж байх учиртай билээ. Тэгвэл хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо таван-саадыг ямагт санан, хэрхэн орших вэ?

1. Хувраг хүний дотор, мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл[483] илрэх үед:

"Миний дотор, мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл байна." гэж мэдэж ойлгоно.

Мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл байхгүй үед:

"Миний дотор, мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл байхгүй байна." гэж мэдэж ойлгоно.

Ийнхүү үүсээгүй байсан мэдрэхүйн хүсэл-эрмэлзлийг хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Ийнхүү үүссэн байсан мэдрэхүйн хүсэл-эрмэлзлийг хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Тийнхүү, үүсээгүй байгаа мэдрэхүйн хүсэл-эрмэлзлээс ирээдүйд хэрхэн ангид хол байхыг ойлгож мэднэ.

2. Хувраг хүний дотор, хар-санаа илрэх үед:

"Миний дотор, хар-санаа байна." гэж мэдэж ойлгоно.

Хар-санаа байхгүй үед:

"Миний дотор, хар-санаа байхгүй байна." гэж мэдэж ойлгоно.

Ийнхүү үүсээгүй байсан хар-санаа хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Ийнхүү үүссэн байсан хар-санаа хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Тийнхүү, үүсээгүй байгаа хар-санаанаас ирээдүйд хэрхэн ангид хол байхыг ойлгож мэднэ.

3. Хувраг хүний дотор, хойрго-нойрмог байгаа үед:

"Миний дотор, хойрго-нойрмог байна." гэж мэдэж ойлгоно.

---

[483] *Kāmacchando*—"мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл". Таван мэдрэхүйгээрээ мэдрэх аливаа зүйлийг хүсэх, түүнд тэмүүлэхүй. Таван-саад болон Арван сэтгэлийн-хүлээсний нэг болно. DN 2-ын Таван-саадад "мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл" (*kāmacchando*) биш харин хүсэл-мөрөөсөл (*abhijjhā*) гэж хэрэглэсэн байдаг тул энэ хоёр үгийг утга зүйн хувьд тун ойролцоо гэж үзэж болно.

Хойрго-нойрмог байхгүй үед:

“Миний дотор, хойрго-нойрмог байхгүй байна.” гэж мэдэж ойлгоно.

Ийнхүү үүсээгүй байсан хойрго-нойрмог, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Ийнхүү үүссэн байсан хойрго-нойрмог, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Тийнхүү, үүсээгүй байгаа хойрго-нойрмогоос ирээдүйд хэрхэн ангид хол байхыг ойлгож мэднэ.

4. Хувраг хүний дотор, түгшүүр-зовнил илрэх үед:

“Миний дотор, түгшүүр-зовнил байна.” гэж мэдэж ойлгоно.

Түгшүүр-зовнил байхгүй үед:

“Миний дотор, түгшүүр-зовнил байхгүй байна.” гэж мэдэж ойлгоно.

Ийнхүү үүсээгүй байсан түгшүүр-зовнил хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Ийнхүү үүссэн байсан түгшүүр-зовнил хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Тийнхүү, үүсээгүй байгаа түгшүүр-зовнилоос ирээдүйд хэрхэн ангид хол байхыг ойлгож мэднэ.

5. Хувраг хүний дотор, эргэлзээ-тээнэгэлзээ илрэх үед:

“Миний дотор, эргэлзээ-тээнэгэлзээ байна.” гэж мэдэж ойлгоно.

Эргэлзээ-тээнэгэлзээ байхгүй үед:

“Миний дотор, эргэлзээ-тээнэгэлзээ байхгүй байна.” гэж мэдэж ойлгоно.

Ийнхүү үүсээгүй байсан эргэлзээ-тээнэгэлзээ хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Ийнхүү үүссэн байсан эргэлзээ-тээнэгэлзээ хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Тийнхүү, үүсээгүй байгаа эргэлзээ-тээнэгэлзээнээс ирээдүйд хэрхэн ангид хол байхыг ойлгож мэднэ.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Тийнхүү, Үзэгдлийн үүсэн бий болохыг ажиглан оршиж, эсвэл Үзэгдлийн үгүй болохыг ажиглан оршиж, мөн Үзэгдэл үүсэх хийгээд үгүй болохыг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Үзэгдлүүд байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар таван-саадыг ямагт санан оршдог.

Саадын Тухай хэсэг өндөрлөв.

4.2. Үзэгдлүүдийг Ажихуйн Цулуудын Тухай (Dhammānupassanākhandhapabba)

Цаашилбал, хуврагууд аа, хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар оршихдоо, дон-шуналын таван-цулыг[484] ямагт санаж байх учиртай билээ. Тэгвэл хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо, дон-шуналын таван-цулыг ямагт санан, хэрхэн орших вэ?

Энэ тав бол Хуврагууд аа, хувраг хүн:

1. “Энэ бол бие-дүрст юм. Энэ бол бие-дүрст юмсын үүсэн бий болохуй. Энэ бол бие-дүрст юмсын үгүй болохуй.

2. Энэ бол мэдрэмж. Энэ бол мэдрэмжийн үүсэн бий болохуй. Энэ бол мэдрэмжийн үгүй болохуй.

3. Энэ бол танин-мэдэхүй. Энэ бол танин-мэдэхүйн үүсэн бий болохуй. Энэ бол танин-мэдэхүйн үгүй болохуй.

4. Энэ бол сэдэхүй-цогцлохуй[485]. Энэ бол сэдэхүй-цогцлохуйн үүсэн бий болохуй. Энэ бол сэдэхүй-цогцлохуй үгүй болохуй.

5. Энэ бол оюун-ухамсар. Энэ бол оюун-ухамсрын үүсэн бий болохуй. Энэ бол оюун-ухамсрын үгүй болохуй.” гэж таньж мэднэ.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Тийнхүү, Үзэгдлийн үүсэн бий болохыг ажиглан оршиж, эсвэл Үзэгдлийн үгүй болохыг ажиглан оршиж, мөн Үзэгдэл үүсэх хийгээд үгүй болохыг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Үзэгдлүүд байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар, дон-шуналын таван-цулыг ямагт санан орщдог.

Цулуудын Тухай хэсэг өндөрлөв.

---

484 *Pañcasu upādānakkhandhesu*—“дон-шуналын таван-цул”. Тайлбар хэсэгт дэлгэрэнгүй үз.

485 *Saṅkhārā*. (Тайлбарт үз.)

4.3. Үзэгдлүүдийг Ажихуйн Мэдрэхүйн-Хүрээний Тухай (Dhammānupassanāāyatanapabba)

Түүнчлэн, хуврагууд аа, хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо, дотоод болон гадаад, зургаан мэдрэхүйн-хүрээг[486] ямагт санаж байх учиртай билээ.

Тэгвэл хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо, дотоод гадаад зургаан мэдрэхүйн-хүрээг ямагт санаж хэрхэн орших вэ?

Үүн дээр хуврагууд аа, хувраг хүн,

1. Тэрээр нүдийг ойлгосноор, тэрээр бие-дүрсийг ойлгосноор, энэ хоёроос үүдэн, үүсэн бий болдог сэтгэлийн-хүлээсийг ойлгож мэддэг.

Тийнхүү үүсэн бий болоогүй байсан сэтгэлийн-хүлээс хэрхэн үүсэн бий болсон байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүсэн бий болсон сэтгэлийн-хүлээс хэрхэн үгүй болсныг ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсэн бий болоогүй байгаа сэтгэлийн-хүлээсийг, цаашдаа хэрхэн үүсэн бий болгохгүй байхыг ойлгож мэддэг.

2. Тэрээр чихийг ойлгосноор, тэрээр дуу чимээг ойлгосноор, энэ хоёроос үүдэн, үүсэн бий болдог сэтгэлийн-хүлээсийг ойлгож мэддэг.

Тийнхүү үүсэн бий болоогүй байсан сэтгэлийн-хүлээс хэрхэн үүсэн бий болсон байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүсэн бий болсон сэтгэлийн-хүлээс хэрхэн үгүй болсныг ойлгож мэддэг.

Ийнхүү, үүсэн бий болоогүй сэтгэлийн-хүлээсийг, цаашдаа хэрхэн үүсэн бий болгохгүй байхыг ойлгож мэддэг.

3. Тэрээр хамрыг ойлгосноор, тэрээр үнэрийг ойлгосноор, энэ хоёроос үүдэн, үүсэн бий болдог сэтгэлийн-хүлээсийг ойлгож мэддэг.

Тийнхүү үүсэн бий болоогүй байсан сэтгэлийн-хүлээс хэрхэн үүсэн бий болсон байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүсэн бий болсон сэтгэлийн-хүлээс хэрхэн үгүй болсныг ойлгож мэддэг.

Ийнхүү, үүсэн бий болоогүй сэтгэлийн-хүлээсийг, цаашдаа хэрхэн үүсэн бий болгохгүй байхыг ойлгож мэддэг.

---

486 *Āyatana*—“мэдрэхүйн-хүрээ”. Ертөнцийг танин мэдэх зургаан суваг буюу мэдрэхүйн суурь, талбар, орон. Нийт 12 мэдрэхүйн-хүрээ байгаа нь: дотоод: 1. нүдний 2. чихний 3. хамрын 4. хэлний 5. биеийн 6. оюун-ухааны, гадаад: 1. үзэгдлийн 2. чимээний 3. үнэрийн 4. амтны 5. хүрэлцлийн 6. төсөөллийн. Зарим тохиолдолд судартмэдрэхүйн-хүрээг, мэдрэхүйн-харилцаа үүсэх нөхцөл болох талаас нь мэдрэхүйн-харилцааны хүрээ хэмээн нэрлэх нь бий.

4. Тэрээр хэлийг ойлгосноор, тэрээр амтыг ойлгосноор, энэ хоёроос үүдэн, үүсэн бий болдог сэтгэлийн-хүлээсийг ойлгож мэддэг.

Тийнхүү үүсэн бий болоогүй байсан сэтгэлийн-хүлээс хэрхэн үүсэн бий болсон байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүсэн бий болсон сэтгэлийн-хүлээс хэрхэн үгүй болсныг ойлгож мэддэг.

Ийнхүү, үүсэн бий болоогүй сэтгэлийн-хүлээсийг, цаашдаа хэрхэн үүсэн бий болгохгүй байхыг ойлгож мэддэг.

5. Тэрээр бие махбодыг ойлгосноор, тэрээр хүрэлцэхүйг ойлгосноор, энэ хоёроос үүдэн, үүсэн бий болдог сэтгэлийн-хүлээсийг ойлгож мэддэг.

Тийнхүү үүсэн бий болоогүй байсан сэтгэлийн-хүлээс хэрхэн үүсэн бий болсон байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүсэн бий болсон сэтгэлийн-хүлээс хэрхэн үгүй болсныг ойлгож мэддэг.

Ийнхүү, үүсэн бий болоогүй сэтгэлийн-хүлээсийг, цаашдаа хэрхэн үүсэн бий болгохгүй байхыг ойлгож мэддэг.

6. Тэрээр оюун-ухааныг ойлгосноор, тэрээр Төсөөллийг[487] ойлгосноор, энэ хоёроос үүдэн, үүсэн бий болдог сэтгэлийн-хүлээсийг ойлгож мэддэг.

Тийнхүү үүсэн бий болоогүй байсан сэтгэлийн-хүлээс хэрхэн үүсэн бий болсон байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүсэн бий болсон сэтгэлийн-хүлээс хэрхэн үгүй болсныг ойлгож мэддэг.

Ийнхүү, үүсэн бий болоогүй сэтгэлийн-хүлээсийг, цаашдаа хэрхэн үүсэн бий болгохгүй байхыг ойлгож мэддэг.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Тийнхүү, Үзэгдлийн үүсэн бий болохыг ажиглан оршиж, эсвэл Үзэгдлийн үгүй болохыг ажиглан оршиж, мөн Үзэгдэл үүсэх хийгээд үгүй болохыг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Үзэгдлүүд байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хуврага хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар, дотоод гадаад зургаан мэдрэхүйн-хүрээг ямагт санан оршдог.

---

[487] *Dhamma*-г цаашид “Төсөөлөл” гэж энэ судрын олон хэсэгт оруулав. Бодол, “Төсөөлөл” бол хүний оюун-ухаан доторх “Үзэгдэл” тул тэр санааг илүү гаргах үүднээс, мөн дүрс болон нүдтэй холбоотой бусад ухагдахуунтай андууруулахгүй гэсэн санаа.

Мэдрэхүйн-Хүрээний Тухай хэсэг өндөрлөв.

4.4. Үзэгдлүүдийг Ажихуйн Гэгээрлийг-Амирлуулагчийн Тухай (Dhammānupassanābojjhaṅgapabba)

Түүнчлэн, хуврагууд аа, хуврag хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо, гэгээрлийг-амирлуулагч долоон нөхцлийг ямагт санаж байх учиртай билээ. Тэгвэл хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо, гэгээрлийг-амирлуулагч долоон нөхцлийг ямагт санан, хэрхэн орших вэ?

Үүн дээр хуврагууд аа, хувраг хүн,

1. Хувраг хүн, өөрийн дотор, гэгээрлийг-амирлуулагч дүүрэн-анхаарал байгаа үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч дүүрэн-анхаарал байна.” гэж ойлгож мэднэ.

Гэгээрлийг-амирлуулагч дүүрэн-анхаарлыг байхгүй үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч дүүрэн-анхаарал байхгүй байна.” гэж ойлгож мэднэ.

Тийнхүү үүсээгүй байсан, гэгээрлийг-амирлуулагч дүүрэн-анхаарлыг, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүссэн байсан, гэгээрлийг-амирлуулагч дүүрэн-анхаарлыг, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсээгүй байгаа гэгээрлийг-амирлуулагч дүүрэн-анхаарлыг, ирээдүйд хэрхэн төгс болгон дадуулахыг ойлгож мэддэг.

2. Хувраг хүн, өөрийн дотор, гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүйг байгаа үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүй байна.” гэж ойлгож мэднэ.

Гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүйг байхгүй үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүй байхгүй байна.” гэж ойлгож мэднэ.

Тийнхүү үүсээгүй байсан гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүйг, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүссэн байсан гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүйг, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсээгүй байгаа гэгээрлийг-амирлуулагч Үзэгдэл-шинжихүйг, ирээдүйд хэрхэн төгс болгон дадуулахыг ойлгож мэддэг.

3. Хувраг хүн, өөрийн дотор, гэгээрлийг-амирлуулагч эрч хүч байгаа үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч эрч хүч байна.” гэж ойлгож мэднэ.

Гэгээрлийг-амирлуулагч эрч хүч байхгүй үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч эрч хүч байхгүй байна.” гэж ойлгож мэднэ.

Тийнхүү үүсээгүй байсан гэгээрлийг-амирлуулагч эрч хүч, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүссэн байсан гэгээрлийг-амирлуулагч эрч хүч, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсээгүй байгаа гэгээрлийг-амирлуулагч эрч хүчийг, ирээдүйд хэрхэн төгс болгон дадуулахыг ойлгож мэддэг.

4. Хувраг хүн, өөрийн дотор, гэгээрлийг-амирлуулагч хөөр-баяр байгаа үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч хөөр-баяр байна.” гэж ойлгож мэднэ.

Гэгээрлийг-амирлуулагч хөөр-баяр байхгүй үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч хөөр-баяр байхгүй байна.” гэж ойлгож мэднэ.

Тийнхүү үүсээгүй байсан гэгээрлийг-амирлуулагч хөөр-баярыг, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүссэн байсан гэгээрлийг-амирлуулагч хөөр-баярыг, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсээгүй байгаа гэгээрлийг-амирлуулагч хөөр-баярыг, ирээдүйд хэрхэн төгс болгон дадуулахыг ойлгож мэддэг.

5. Хувраг хүн, өөрийн дотор, гэгээрлийг-амирлуулагч амар-амгаланг байгаа үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч амар-амгалан байна.” гэж ойлгож мэднэ.

Гэгээрлийг-амирлуулагч амар-амгаланг байхгүй үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч амар-амгалан байхгүй байна.” гэж ойлгож мэднэ.

Тийнхүү үүсээгүй байсан гэгээрлийг-амирлуулагч амар-амгаланг, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүссэн байсан гэгээрлийг-амирлуулагч амар-амгаланг, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсээгүй байгаа гэгээрлийг-амирлуулагч амар-амгаланг, ирээдүйд хэрхэн төгс болгон дадуулахыг ойлгож мэддэг.

6. Хувраг хүн, өөрийн дотор, гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрлийг байгаа үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрөл байна.” гэж ойлгож мэднэ.

Гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрлийг байхгүй үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрөл байхгүй байна.” гэж ойлгож мэднэ.

Тийнхүү үүсээгүй байсан гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрлийг, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүссэн байсан гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрлийг, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсээгүй байгаа гэгээрлийг-амирлуулагч самади-төвлөрлийг, ирээдүйд хэрхэн төгс болгон дадуулахыг ойлгож мэддэг.

7. Хувраг хүн, өөрийн дотор, гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуйг байгаа үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуй байна.” гэж ойлгож мэднэ.

Гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуйг байхгүй үед:

“Миний дотор, гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуй байхгүй байна.” гэж ойлгож мэднэ.

Тийнхүү үүсээгүй байсан гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуйг, хэрхэн үүссэн байгааг ойлгож мэднэ.

Тийнхүү үүссэн байсан гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуйг, хэрхэн үгүй болсныг бас ойлгож мэднэ.

Ийнхүү, үүсээгүй байгаа гэгээрлийг-амирлуулагч төв-оршихуйг, ирээдүйд хэрхэн төгс болгон дадуулахыг ойлгож мэддэг.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Тийнхүү, Үзэгдлийн үүсэн бий болохыг ажиглан оршиж, эсвэл Үзэгдлийн үгүй болохыг ажиглан оршиж, мөн Үзэгдэл үүсэх хийгээд үгүй болохыг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Үзэгдлүүд байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар, гэгээрлийг-амирлуулагч энэ долоон нөхцлийг ямагт санан орщдог.

Гэгээрлийг-Амирлуулагчийн Тухай хэсэг өндөрлөв.

4.5. Үзэгдлүүдийг Ажихуйн Үнэний Тухай (Dhammānupassanāsaccapabba)

Түүнчлэн, хуврагууд аа, хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг[488] ямагт санаж байх учиртай билээ. Тэгвэл хувраг хүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршихдоо, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг ямагт санан хэрхэн орших вэ?

Үүн дээр хуврагууд аа, хувраг хүн:

‘Энэ бол зовлон.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол зовлонгийн шалтгаан.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол зовлонгийн төгсгөл.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Тэрээр:

‘Энэ бол зовлонгийн төгсгөлд хүргэх замнал.’ гэж чухам бодит байдлаар нь ухаарч мэднэ.

Нэгдүгээр Уншлага хэсэг өндөрлөв.

4.6. Зовлон Үнэний Тайлбар (Dukkhasaccaniddesa)

Тэгвэл хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлон гэдэг нь юу вэ?

Төрөхүй[489] зовлон, өтлөхүй хийгээд үхэхүй мөн зовлон, харуусал, гашуудал, зовуурь, шаналал, цөхрөл мөн зовлон, таагүйтэй учрах мөн зовлон, таатайгаас хагацах мөн зовлон, хүссэнээ эс олох мөн зовлон. Товчхондоо, дон-шуналын таван-цул[490] бол зовлон юм.

Тэгвэл хуврагууд аа, төрөхүй гэдэг нь юу вэ?

Хуврагууд аа, энэ бол, олон янзын бодгалиудын, олон янзын төрөлд, төрөх, мэндлэх, бүрэлдэх, ирэх, бий болох, таван-цулын илрэл[491], мэдрэхүйн чадварыг эзэмшихүй юм. Үүнийг, хуврагууд аа, төрөхүй гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, өтлөхүй гэдэг нь юу вэ?

---

488 *Cattāri Ariyasaccāni*—“Гэгээнтний Дөрвөн Үнэн” (анг. *The Four Noble Truths*). (Тайлбарт Ариуссан хэсгийг үз.)

489 *Jāti*—“Төрөхүй”. DN 1.5.3; DN 15.1; Тайлбарт нэмж үз.

490 *Pañcupādānakkhandhā*—“дон-шуналын таван-цул”. (Тайлбарт буй Таван-Цулыг үз.)

491 *Khandhānaṁ pātubhāvo*—“таван-цулын илрэл”. Таван-цулууд байгаа нь мэдэгдэх, илрэх, илхэн байх гэсэн утгаар.

Хуврагууд аа, олон янзын бодгалиудын, олон янзын төрөлд, өтлөх, муудах, шүд унах, үс бууралтах, арьс үрчийх, нас богиносох, мэдрэхүйн-чадвар доройтох, үүнийг хуврагууд аа, өтлөхүй гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, үхэл гэдэг нь юу вэ?

Олон янзын бодгалиудын, олон янзын төрөлд, үхэх, мөхөх, үгүй болох, явах, дуусах, нас барагдах, биеэ орхих, үүнийг хуврагууд аа, үхэл гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, харуусал гэдэг нь юу вэ?

Хуврагууд аа, хэн нэгэн, ямар нэгэн золгүй байдалд ороод, ямар нэгэн таагүй үйл явдал учраад, харамсах, харуусах, шаналах, зүдрэх болон тарчлах, үүнийг хуврагууд аа, харуусал гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, гашуудал гэдэг нь юу вэ?

Хуврагууд аа, хэн нэгэн, ямар нэгэн золгүй байдалд ороод, ямар нэгэн таагүй үйл явдал учраад, гашуудах, эмгэнэх, мэлмэрэн шаналах, мэгшин гашуудах болон цөхрөн шаналах, үүнийг хуврагууд аа, гашуудал гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, зовуурь гэдэг нь юу вэ?

Хуврагууд аа, энэ бол бие махбодын зовуурь, бие махбодын таагүй байдал, биед хүрэлцэх зовуурь болон таагүй байдал, үүнийг хуврагууд аа, зовуурь гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, шаналал гэдэг нь юу вэ?

Хуврагууд аа, энэ бол сэтгэлийн зовуурь, сэтгэлийн таагүй байдал, оюун санаанд буусан зовуурь болон таагүй байдал, үүнийг хуврагууд аа, шаналал гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, цөхрөл гэдэг нь юу вэ?

Хуврагууд аа, хэн нэгэн ямар нэгэн золгүй байдалд ороод, ямар нэгэн таагүй үйл явдал учраад, гутрах, цөхрөх, мухардах, цөхрөнгөө барах, үүнийг хуврагууд аа, цөхрөл гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, таагүйтэй учрах зовлон гэдэг нь юу вэ?

Үүнд, таагүй, таарамжгүй, тааламжгүй, бие-дүрс, дуу чимээ, амт, үнэр, биед хүрэлцэх байдал, сэтгэл санааны байдал; мөн хүнийг дордуулахыг хүсдэг, хүнийг хохироохыг хүсдэг, хүнийг эвгүй байдалд оруулахыг хүсдэг, хүнийг донтолт хамааралтай байлгахыг хүсдэг, тэдгээр хүмүүстэй уулзах, холбогдох, ханилах, дайралдах, үүнийг, хуврагууд аа, таагүйтэй учрах зовлон гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, таатайгаас хагацах зовлон гэдэг нь юу вэ?

Үүнд, таатай, таарамжтай, тааламжтай, бие-дүрс, дуу чимээ, амт, үнэр, биед хүрэлцэх байдал, сэтгэл санааны байдал; мөн хүнд сайн сайхныг хүсдэг, хүнд ашигтай тустайг хүсдэг, хүнд тохь тухтайг хүсдэг, хүнд гэгээрэл ухаарлыг хүсдэг хүмүүс, ээж, аав, ах, эгч, найз, нөхөд, хамаатан садан хүмүүстэй эс уулзах эс холбогдох, хол байх, хагацах, эдгээрийг, хуврагууд аа, таатайгаас хагацах зовлон гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, хүссэнээ эс олох зовлон гэдэг нь юу вэ?

Хуврагууд аа, энэ хорвоод төрөх жамтай бодгалиудад, “Ерөөсөө төрөөгүй байсан ч болоосой. Ерөөсөө дахиж төрөхгүй юм сан.” гэх хүсэл төрдөг. Гэвч энэ нь хүссэнээр болдоггүй, үүнийг хуврагууд аа, хүссэнээ эс олох зовлон гэж нэрлэдэг билээ.

Хуврагууд аа, энэ хорвоогийн хөгшрөх жамтай бодгалиудад, “Ерөөсөө хөгширдөггүй байсан ч болоосой. Ерөөсөө хөгшрөхгүй юм сан.” гэх хүсэл төрдөг. Гэвч энэ нь хүссэнээр болдоггүй, үүнийг хуврагууд аа, хүссэнээ эс олох зовлон гэж нэрлэдэг билээ.

Хуврагууд аа, энэ хорвоогийн өвдөх жамтай бодгалиудад, “Ерөөсөө өвддөггүй байсан ч болоосой. Ерөөсөө өвдөхгүй юм сан.” гэх хүсэл төрдөг. Гэвч энэ нь хүссэнээр болдоггүй, үүнийг хуврагууд аа, хүссэнээ эс олох зовлон гэж нэрлэдэг билээ.

Хуврагууд аа, энэ хорвоогийн үхэх жамтай бодгалиудад, “Ерөөсөө үхдэггүй байсан ч болоосой. Ерөөсөө үхэхгүй юм сан.” гэх хүсэл төрдөг. Гэвч энэ нь хүссэнээр болдоггүй, үүнийг хуврагууд аа, хүссэнээ эс олох зовлон гэж нэрлэдэг билээ.

Хуврагууд аа, энэ хорвоогийн харуусах, гашуудах, өвдөх, шаналах, цөхрөх жамтай бодгалиудад, “Ерөөсөө, харамсдаггүй, гашуудлаггүй, өвддөггүй, шаналдаггүй, цөхөрдөггүй ч болоосой. Ерөөсөө харамсахгүй, гашуудахгүй, өвдөхгүй, шаналахгүй, цөхрөхгүй юм сан.” гэх хүсэл төрдөг. Гэвч эдгээр нь хүссэнээр болдоггүй, үүнийг хуврагууд аа, хүссэнээ эс олох зовлон гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл хуврагууд аа, “Товчхондоо, дон-шуналын таван-цул бол зовлон юм.” гэдэг нь юу байх вэ?

Тэр бол:

1. Бие-дүрсийн дон-шуналын цул.

2. Мэдрэмжийн дон-шуналын цул.

3. Танин-мэдэхүйн дон-шуналын цул.

4. Сэдэхүй-цогцлохуйн дон-шуналын цул.

5. Оюун-ухамсрын дон-шуналын цул.

Эдгээрийг, хуврагууд аа, товчхондоо, дон-шуналын таван-цул гэж нэрлэдэг билээ.

Үүнийг хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлон гэж хэлдэг билээ.

4.7. Учир Шалтгаан Үнэний Тайлбар (Samudayasaccaniddesa)

Тэгвэл хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлонгийн шалтгаан гэдэг нь юу вэ?

Энэ бол дахин төрөл авах явдалд хүргэж буй, дур-хүсэлд автахтай холбоотой, энэ тэрийг таалах таашаах буюу, өөрөөр хэлбэл: мэдрэхүйн хүсэл-цангаа[492], оршихуйн хүсэл-цангаа[493], эс оршихуйн хүсэл-цангаа[494] юм.

Тэгэхээр, хуврагууд аа, тэр хүсэл-цангаа төрвөл хаана төрж, оршвол хаана оршдог бол?

Энэ хорвоогийн хаана тааламжтай юм, нийцэмжтэй юм байна, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн юу нь тааламжтай юм, нийцэмжтэй юм байх вэ?

Энэ хорвоогийн нүдэнд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн чихэнд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хамарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хэлэнд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн бие махбодод тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн оюун-ухаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн бие-дүрс бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн дуу чимээ бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн үнэр бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн амт бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

---

[492] *Kāmataṇhā*—“мэдрэхүйн хүсэл-цангаа”. Таван мэдрэхүйгээрээ мэдэрч болох зүйлийн хүсэл.

[493] *Bhavataṇhā*—“оршихуйн хүсэл-цангаа”. Ямар нэг дараа төрөл авах, эсвэл хорвоод оршин байхуй, мөн хэн нэгэн болохуйн хүсэл.

[494] *Vibhavataṇhā*—“эс оршихуйн хүсэл-цангаа”. Ямар нэг дараа төрөл дахин эс авах, эсвэл хорвоод эс оршин байх, мөн оршихгүй байх хүсэл. Өөрөөр, “оршихуйн хүсэл-цангаа”-ны эсрэг утга.

Энэ хорвоогийн хүрэлцэл[495] бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн Төсөөлөл бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн нүдний-ухамсарт[496] тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн чихний-ухамсарт[497] тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хамрын-ухамсарт[498] тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хэлний-ухамсарт[499] тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн биеийн-ухамсарт[500] тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн оюун-ухааны-ухамсарт[501] тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн нүдтэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн чихтэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хамартай мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

---

495 Биед мэдрэгдэх, хүрэлцэх.

496 *Cakkhuviññāṇaṁ*—"нүдний-ухамсарт". Нүд (па. *cakkhu*) ба харагдах зүйлийн харилцах нөлөөллөөр үүсэх ухамсар. Зургаан ухамсрын нэг (SN 35).

497 *Sotaviññāṇaṁ*—"чихний-ухамсарт". Чих (па. *sota*) ба сонсогдох зүйлийн харилцах нөлөөллөөр үүсэх ухамсар. Зургаан ухамсрын нэг (SN 35).

498 *Ghānaviññāṇaṁ*—"хамрын-ухамсарт". Хамар (па. *ghāna*) ба үнэртэх зүйлийн харилцах нөлөөллөөр үүсэх ухамсар. Зургаан ухамсрын нэг (SN 35).

499 *Jivhāviññāṇaṁ*—"хэлний-ухамсарт". Хэл (па. *jivhā*) ба амтагдах зүйлийн харилцах нөлөөллөөр үүсэх ухамсар. Зургаан ухамсрын нэг (SN 35).

500 *Kāyaviññāṇaṁ*—"биеийн-ухамсарт". Бие (па. *kāya*) ба хүрэлцэх зүйлийн харилцах нөлөөллөөр үүсэх ухамсар. Зургаан ухамсрын нэг (SN 35).

501 *Manoviññāṇaṁ*—"оюун-ухааны-ухамсарт". Оюун-ухаан (па. *mano*) ба оюун санаанд тусч буй объект хоёрын харилцах нөлөөллөөр үүсэх ухамсар. Зургаан ухамсрын нэг (SN 35).

Энэ хорвоогийн хэлтэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн биетэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн оюун-ухаантай мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн нүдний мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн чихний мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хамрын мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хэлний мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн биеийн мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн оюун-ухааны мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн бие-дүрсний танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн дуу чимээний танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн үнэрийн танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн амтны танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн Төсөөллийн танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн бие-дүрсний сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн дуу чимээний сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн үнэрийн сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн амтны сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн Төсөөллийн сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн харах хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн сонсох хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн үнэрлэх хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн амтлах хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хүрэлцэх хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн Төсөөлөх хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн бие-дүрсний зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн дуу чимээний зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн үнэрийн зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн амтны зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн Төсөөллийн зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн бие-дүрсний эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн дуу чимээний эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн үнэрийн эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн амтны эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Энэ хорвоогийн Төсөөллийн эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа төрвөл үүнд төрж, оршвол үүнд оршин байна.

Үүнийг хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлонгийн шалтгаан гэж хэлдэг билээ.

4.8. Төгсгөл Үнэний Тайлбар (Nirodhasaccaniddesa)

Тэгвэл хуврагууд аа, Гэгээнтний Үнэний төгсгөл үнэн гэдэг нь юу вэ?

Энэ бол мөнөөх хүсэл-цангаа замхрах хийгээд нэгэнт төгсөх, түүнээс салах, үгүй хийх, хаях, хараат бус болох билээ. Тэгвэл хуврагууд аа, энэ хүсэл-цангаа үгүй болбол хаана үгүй болж, уствал хаана устдаг вэ?

Энэ хорвоогийн тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн нүдэнд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн чихэнд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хамарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хэлэнд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн бие махбодод тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн оюун-ухаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн бие-дүрс бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн дуу чимээ бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн үнэр бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн амт бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хүрэлцэл бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн Төсөөлөл бүхий тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн нүдний-ухамсарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн чихний-ухамсарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хамрын-ухамсарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хэлний-ухамсарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн биеийн-ухамсарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн оюун-ухааны-ухамсарт тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн нүдтэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн чихтэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хамартай мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хэлтэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн биетэй мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн оюун-ухаантай мэдрэхүйн-харилцаа үүсэхэд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн нүдний мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн чихний мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хамрын мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хэлний мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн биеийн мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн оюун-ухааны мэдрэхүйн-харилцаанаас үүссэн мэдрэмжид тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн бие-дүрсний танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн дуу чимээний танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн үнэрийн танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн амтны танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн Төсөөллийн танин-мэдэхүйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн бие-дүрсний сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн дуу чимээний сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн үнэрийн сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн амтны сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн Төсөөллийн сэдэхүй-цогцлохуйд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн харах хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн сонсох хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн үнэрлэх хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн амтлах хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хүрэлцэх хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн Төсөөлөх хүсэл-цангаанд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн бие-дүрсний зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн дуу чимээний зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн үнэрийн зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн амтны зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн Төсөөллийн зурвас-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн бие-дүрсний эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн дуу чимээний эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн үнэрийн эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн амтны эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн хүрэлцэхүйн эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Энэ хорвоогийн Төсөөллийн эргэцүүлсэн-бодолд тааламжтай юманд, нийцэмжтэй юманд, хүсэл-цангаа үгүй болбол тэнд үгүй болж, уствал тэнд устах болно.

Үүнийг хуврагууд аа, Гэгээнтний Үнэний төгсгөл үнэн гэж хэлдэг билээ.

4.9. Замнал Үнэний Тайлбар (Maggasaccaniddesa)

Тэгвэл хуврагууд аа, Гэгээнтний Үнэний зовлонг төгсгөх замнал гэдэг нь юу вэ?

Энэ нь:

1. Зөв үзэл,
2. Зөв сэдэл[502],
3. Зөв яриа,
4. Зөв үйлдэл,
5. Зөв амьжиргаа,
6. Зөв зүтгэл,
7. Зөв дүүрэн-анхаарал,
8. Зөв самади-төвлөрөл

гэсэн Гэгээнтний найман хураангуй замналыг хэлнэ.

---

[502] *Saṅkappo*—“сэдэл” (анг. *intention*, сам. *saṃkalpa*). Санаа, зорилго, шийдэл, тэмүүлэл г.м. утга санаа (Мөн ойролцоо утгатай үгсийг Тайлбарт Сэдэхүй-Цогцлохуйд үз.)

Тэгвэл хуврагууд аа, зөв үзэл гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

1. Зовлонгийн тухай мэдлэг,
2. Зовлонгийн шалтгааны тухай мэдлэг,
3. Зовлонг төгсгөх тухай мэдлэг,
4. Зовлонг төгсгөх замналын тухай мэдлэг билээ.

Үүнийг хуврагууд аа, зөв үзэл гэж хэлнэ.

Тэгвэл хуврагууд аа, зөв сэдэл гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

1. Хорвоогийн явдлыг орхих[503] сэдэл,
2. Хар-санаа үгүй[504] сэдэл,
3. Харгис-санаа үгүй[505] сэдэл.

Үүнийг хуврагууд аа, зөв сэдэл гэж хэлнэ.

Тэгвэл хуврагууд аа, зөв яриа гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

1. Худал үг, яриаг цээрлэх,
2. Хагалан бутаргах, эе эвдүүлэх яриаг цээрлэх,
3. Хатуу ширүүн хэллэг, яриаг цээрлэх,
4. Хов живийн яриа, хэрэггүй дэмий яриаг цээрлэх билээ.

Үүнийг хуврагууд аа, зөв яриа гэж хэлнэ.

Тэгвэл хуврагууд аа, зөв үйлдэл гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

1. Аливаа бодгалийг хөнөөхийг цээрлэх,
2. Аливаа өгөөгүйг авахыг цээрлэх,

---

503 *Nekkhamma*—“Хорвоогийн явдлыг орхих”. Гэрээ орхиж сахилтан хувраг болохуй, хар хүмүүний явдлыг орхихуй буюу амар амгалан, гэгээрэлд хүрэхийн тулд авталт донтолт, хүсэл тачаал, энэ хорвоогийн аливаа хүсэл шуналаас татгалзах, огоорох үйлдлийг хэлнэ. Эртний Буддизмд, дор хаяж даяаны нэгдүгээр зэрэгт хүрэхийн тулд юун түрүүн хорвоогийн явдлыг орхисон байх учиртай гэж үзэх хандлага түгээмэл байна.

504 *Abyāpāda*—Бусдад огт мууг хүсээгүй, хор хүргэх санаа өвөрлөөгүй, ивээсэн сэтгэлийн төлөв байдал. “Хар-санаа”-г Лавлахад, ойролцоо утгатай үгийг Тайлбарт үз.

505 *Avihiṃsā*—“харгис-санаа үгүй”. Бусдад хүч хэрэглэх, хохироох огтхон ч санаа сэдэлгүй, нигүүлсэнгүй сэтгэлийн төлөв байдал. “Харгис-санаа”-г Лавлахад, ойролцоо утгатай үгийг Тайлбарт үз.

3. Садар самуун үйлийг цээрлэх[506] орно.

Үүнийг хуврагууд аа, зөв үйлдэл гэж хэлнэ.

Тэгвэл хуврагууд аа, зөв амьжиргаа гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

- Гэгээрсэн шавь хүмүүн буруу амьжиргааны замналыг орхисноор, өөрийн амьдралыг зөв амьжиргаагаар[507] залгуулахуй юм.

Үүнийг хуврагууд аа, зөв амьжиргаа гэж хэлнэ.

Тэгвэл хуврагууд аа, зөв зүтгэл гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

1. Хувраг хүн, хараахан үүсээгүй байгаа адын муу, тусгүй-муу зүйлсийг, төрүүлэхгүй байх тэмүүллийг үүсгэх, шамдан чармайх, эрч хүчээ гаргах, оюун бодлыг дайчлах, зүтгэлийг хэлдэг.

2. Хэдийнээ үүссэн адын муу, тусгүй-муу зүйлсийг үгүй хийх тэмүүллийг үүсгэх, шамдан чармайх, эрч хүчээ гаргах, оюун бодлыг дайчлах, зүтгэлийг хэлдэг.

3. Хараахан үүсээгүй байгаа тустай-сайн зүйлсийг, төрүүлэх тэмүүллийг үүсгэх, шамдан чармайх, эрч хүчээ гаргах, оюун бодлыг дайчлах, зүтгэлийг хэлдэг.

4. Хэдийнээ үүссэн тустай-сайн зүйлсийг, оршоох, тогтоох, үржүүлэх, өргөжүүлэх, хөгжүүлэх, төгсрүүлэх, тэр тэмүүллийг үүсгэх, шамдан чармайх, эрч хүчээ гаргах, оюун бодлыг дайчлах, зүтгэлийг хэлдэг.

Үүнийг хуврагууд аа, зөв зүтгэл гэж хэлнэ.

Тэгвэл хуврагууд аа, зөв дүүрэн-анхаарал гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

1. Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, бие дээр биеийн ажиглалттайгаар, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байх,

---

[506] *Kāmesumicchācārā veramaṇī*—"Садар самуун үйлдлийг цээрлэх". *Kāmesumicchācārā*— "садар самуун" буюу үгчилбэл, "таван мэдрэхүйг буруугаар ашиглах". Энэ нь хар хүний таван сахил (*pañcasīla*)-ын нэг болж, "араар тавих, хүчиндэх", хуримлаагүй хэн нэгэн, насанд хүрээгүй хүнтэй харилцаанд орох, мөн садар завхай сэдэлд автсан бие болон хэл ярианы үйлдэл зэрэг өргөн утгыг хамааруулан ойлгоно.

[507] Үүнд DN 1.2.3-т тодорхой зааж хэлсэн, түүнтэй эс харшилдах амьжиргаа, мөн зэр зэвсэг, хүн амьтан, мах, согтууруулах мансууруулах бодис, бусад хортой холбоотой арилжаа наймаа (AN 5.177), бялдуучлах, зусардах, далд санаагаар ярих, басамжлан доромжлох, мөн эдээр эдийг арвижуулах амьжиргаа (MN 117) орно.

2. Цаашилбал хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттайгаар, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байх,

3. Цаашилбал хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттайгаар, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байх,

4. Цаашилбал хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байх юм.

Үүнийг хуврагууд аа, зөв дүүрэн-анхаарал гэж хэлнэ.

Тэгвэл хуврагууд аа, зөв самади-төвлөрөл гэж юу вэ?

Хуврагууд аа, энэ бол:

1. Хувраг хүн мэдрэхүйн-таашаалаас салснаар, тусгүй-муу Зүйлээс салснаар, тэрбээр зурвас-бодол бүхий, эргэцүүлсэн-бодол бүхий, ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий нэгдүгээр даяан зэрэгт хүрснээр тэр оршин байх,

2. Хувраг хүний зурвас-бодол, эргэцүүлсэн-бодол намжиж, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий, дотоод амар-амгалан, оюуны-нэгдэл бүхий, хоёрдугаар даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байх,

3. Хувраг хүн хөөр-баяраас салж-ангижирснаар, дүүрэн-анхаарал тунгалаг-оюун бүхий төв-оршихуйд байж, аз-жаргалыг бие махбодоороо мэдрэх ба үүнийг Гэгээнтнүүд, “Төв-оршихуйд, дүүрэн-анхааралтай, аз-жаргалд умбав” хэмээн нэрийдэх буюу ингэж гуравдугаар даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байх,

4. Хувраг хүн жаргалаас салж-ангижирснаар, зовлонгоос салж-ангижирснаар, урьдын таатай хийгээд таагүй байдал алга болсноор, жаргал зовлонгийн аль нь ч бус, төв-оршихуйгаас үүссэн дүүрэн-анхаарлын ариусал, дөрөвдүгээр даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байх юм.

Үүнийг хуврагууд аа, зөв самади-төвлөрөл гэж хэлнэ.

Эдгээр бүгдийг хуврагууд аа, Гэгээнтний үнэний зовлонг төгсгөх замнал гэж хэлнэ.

Ийнхүү тэрээр, дотоод талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн гадаад талаас нь, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай оршин байж, мөн дотор гадар аль аль талаас нь нэгэн зэрэг ажиглалттай оршин байна.

Тийнхүү, Үзэгдлийн үүсэн бий болохыг ажиглан оршиж, эсвэл Үзэгдлийн үгүй болохыг ажиглан оршиж, мөн Үзэгдэл үүсэх хийгээд үгүй болохыг нэгэн зэрэг ажиглан оршино.

Энгийн мэдлэг ухааны хэр хэмжээнд, энгийн сэрэмж анхаарлын хэр хэмжээнд хангалттай байдлаар “Үзэгдлүүд байна” гэсэн дүүрэн-анхаарал түүнд бий болж, ангижран салсан байдалд оршин, энэ хорвоогийн юухныг ч эс шунана.

Ийнхүү хуврагхүн, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттайгаар, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг ямагт санаж, оршин байдаг билээ.

Үнэний хэсэг өндөрлөв.

Үзэгдлийг Ажихуйн хэсэг өндөрлөв.

5. Дүүрэн-Анхаарал Суулгах Бясалгалын Үр Шим (Satipaṭṭhānabhāvanānisaṃsa)

Хуврагууд аа, Дүүрэн-анхаарал Суулгах Дөрвөн Бясалгалыг долоон жилийн турш ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг[508] усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Долоон жилийг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, зургаан жилийн турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Зургаан жилийг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, таван жилийн турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Таван жилийг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, дөрвөн жилийн турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Дөрвөн жилийг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, гурван жилийн турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Гурван жилийг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, хоёр жилийн турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай.

[508] *Upādisese*—"буртаг". Үгчилбэл, "дон-шуналын үлдэгдэл, шавхруу".

Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Хоёр жилийг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, нэг жилийн турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Нэг жилийг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, долоон сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Долоон сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, зургаан сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Зургаан сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, таван сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Таван сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, дөрвөн сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Дөрвөн сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, гурван сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Гурван сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, хоёр сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Хоёр сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, нэг сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Нэг сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, хагас сарын турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

Хагас сарыг болъё, хуврагууд аа. Дүүрэн-анхаарал суулгах эдгээр дөрвөн бясалгалыг, долоо хоногийн турш, ийм маягаар бясалгасан хэн ч бай, дараах хоёр үр шимийн аль нэгийг нь олно гэж найдаарай. Эхнийх нь бол, энэ насандаа гэгээрэл ухаарлыг олох, эсвэл багахан буртаг усталгүй үлдсэн бол Эс Эргэн Ирэгчийн гэгээрлийг олох гэсэн хоёр үр шим боловсрох учиртай.

‘Хуврагууд аа, энэ бол, хэнийг ч ариусалд оруулах, харуусал, уй гашууг даван туулах, зовлон шаналлыг арилгах, ухаарлыг олох, Нирваанд одуулах, нэг чигийн зам бөгөөд өөрөөр хэлбэл, энэ бол дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгал юм.’ хэмээн хэлсэн нь энэ бүгд дээр үндэслэн хэлсэн учиртай билээ.”

Будда ийн айлдав.

Буддагийн энэхүү айлдварыг хөөр баяртай хуврагууд сэтгэл хангалуун хүлээн авлаа.

Агуу Дүүрэн-Анхаарал Суулгахуй Судар энд өндөрлөв.

ХҮРД-ЭРГҮҮЛЭГЧ СУДАР
DN 26. CAKKAVATTISUTTA

1. Өөртөө Авралын Арал Болохуй (Attadīpasaraṇatā)

БИ ИЙН СОНССОН ЮМ.

Нэгэн цагт Будда Магадхагийн газар нутагт, Маатулаад[509] амьдарч байжээ. Тэгээд нэгэн удаа, Будда хуврагууддаа хандан,

“Хуврагууд аа!” хэмээн дуудахад:

“За, Багш аа.” хэмээн тэд хариулав. Ингээд Будда тэдэнд хандан:

“Хуврагууд аа, өөр аврал үгүй болохоор, өөрөө өөртөө арал болж, өөрөө өөртөө аврал болж, өөр аврал үгүй болохоор, Сургаалыг арлаа болгож, Сургаалыг авралаа болгож амьдар.

Хуврагууд аа, хувраг хүн, өөр аврал үгүй болохоор, өөрөө өөртөө арал болж, өөрөө өөртөө аврал болж, өөр аврал үгүй болохоор, Сургаалыг арлаа болгож, Сургаалыг авралаа болгож, хэрхэн амьдрах вэ?

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийгээд, бие дээр биеийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршино.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийгээд, мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршино.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийгээд, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршино.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийгээд, Үзэгдэл дээр Үзэгдлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршино.

Ингэж л, хувраг хүн, өөр аврал үгүй болохоор, өөрөө өөртөө арал болж, өөрөө өөртөө аврал болж, өөр аврал үгүй болохоор, Сургаалыг арлаа болгож, Сургаалыг авралаа болгож амьдарна.

Хуврагууд аа, та бүгд өөрийн бэлчээр газар буюу эцэг өвгөдөөс өвлөн авсан газар нутаг[510] дотор бадарчлан яваарай. Хэрэв та өөрийн бэлчээр газар буюу эцэг өвгөдөөс өвлөн авсан газар нутаг дотор бадарчлан яваа бол, Маара чөтгөр таныг оролдохгүй, таныг хорлохгүй. Учир юу гэвэл, буяныг арвижуулдаг зөв сайн чанарыг цогцлоож буй болохоор тэр билээ.

---

[509] *Mātulā*—“Маатулаа”. Магадха улсын нэгэн жижиг тосгон.

[510] *Gocare sake pettike visaye*—“эцэг өвгөдөөс өвлөн авсан газар нутаг”. Зарим эх сурвалжид, Буддагийн Сургаалыг өвлөн авч яваа ахмад хуврагууд буй нутаг орон буюу Буддын уламжлал өвлөгдсөн газар нутаг гэдэг утгаар хэлсэн гэжээ (DA).

2. Хүрд-Эргүүлэгч Далханеми Хаан (Daḷhanemicakkavattirājā)

Эрт урьд цагт, хүрд-эргүүлэгч[511], шударга, зарчимч, Далханеми[512] хэмээх нэгэн хаан байжээ. Тэрбээр, хаанчлал нь дөрвөн зовхист хүрсэн, улс орон нь амар амгалан болсон, өөртөө долоон эрдэнийг[513] оршоосон нэгэн байв.

Түүний долоон эрдэнэ болбоос, хүрд-эрдэнэ, заан-эрдэнэ, ажнай-эрдэнэ, баялаг-эрдэнэ, бүсгүй-эрдэнэ, хамжлагат ард-эрдэнэ, сайд түшээ-эрдэнэ, эдгээр долоон эрдэнэ юм. Түүнд, атаатан дайсны их цэргийг бут ниргэх, айдас үгүй эрэлхэг баатарлаг, мянга гаруй хөвгүүд бий. Тэнгис далайгаар тойрон хүрээлэгдсэн, тив газрыг эзэлсэн хойноо, тэрбээр, мод шийдэм, илд сэлэмгүй зарчмаар, улс орноо захиран сууж байлаа.

Тэгээд, олон жил, олон зуун жил, олон мянган жил өнгөрсний дараа, Далханеми хаан өөрийн хүмүүсийн нэгэнд хандан:

"Сайхан сэтгэлт хүн минь, тэнгэрлэг хүрд-эрдэнэ хэрэв байрнаасаа ухарч хөдлөх юм бол надад заавал мэдэгдээч." хэмээн хэлэв.

"За тэгье ээ, эрхэм дээдэс ээ." гэж тэр хүн хариуллаа. Олон мянган жил өнгөрсний дараа мөнөөх хүн, тэнгэрлэг хүрд-эрдэнэ байрнаасаа ухран хөдөлж байгааг нь олж харав. Тэгээд тэрээр, Далханеми хаандаа очоод,

"Эрхэм ээ, таны тэнгэрлэг хүрд-эрдэнэ, байрнаасаа ухран хөдөлж байгааг би танд мэдэгдэн дуулгаж байна." гэв.

Тэгээд хаан угсаа залгамжлагч хунтайжаа дуудаад,

"Эрхэм хунтайж аа, миний тэнгэрлэг хүрд-эрдэнэ байрнаасаа ухарлаа. Хүрд-эргүүлэгч хаанд хэрэв ийм зүйл тохиолдох аваас, тэр удаан насалдаггүй гэж би сонссон билээ. Би энэ насныхаа жаргалыг хангалттай эдэлсэн. Одоо миний хувьд тэнгэрлэг аз жаргалыг эрэлхийлэх цаг минь болжээ. Алив, дотнын ханхүү минь, тэнгис далайгаар хүрээлэгдсэн энэ их нутгийг захиргтун! Би, үс сахлаа хусаж, зосон орхимж өмсөөд, эгэл хүний амьдралаа орхин, гэр оронгүй замналаар явах боллоо." хэмээн хэлжээ.

---

511 *Cakkavatti*—"хүрд-эргүүлэгч". Үгчилбэл, "дугуйг эргүүлэгч" боловч дугуй нь эзэнт гүрэн ба зөв шударга ёсны бэлгэдэл юм. Хүрд-эргүүлэгч нь хүчээр бус, ёс суртахуун болон Сургаал номын дагуу дэлхийг энх тайвны аргаар байлдан дагуулж, захирдаг их хаан бөгөөд ард олноо арван буяны үйлийг дагахыг уриална. Улс орон нь амгалан болно.

512 *Daḷhanemi*—"Далханеми". Үгчилбэл, "Хүчит Дугуй" (хүрдний тойрог дугуй). Эртний Буддизмын үлгэр домогт, зөв явдалт, билгүүн ухаант хаан байдлаар гарах нэгэн дүр.

513 *Satta ratana*—"долоон эрдэнэ". Эртний домог ёсоор хүрд-эргүүлэгч хаад долоон эрдэнэтэй байх учиртай юм. 1. Хүрд-эрдэнэ: шударга засаглалыг тогтоох бэлгэдэл, тэнгэрлэг хүрд; 2. Заан-эрдэнэ: Сүр хүчний бэлгэдэл, нисдэг цагаан заан; 3. Ажнай-эрдэнэ: Хурдны бэлгэдэл, нисдэг морь; 4. Баялаг-эрдэнэ: Элбэг байдлын бэлгэдэл, шөнийг ч гэрэлтүүлэх үнэт чулуу; 5. Бүсгүй-эрдэнэ: Нигүүлсэл ба үнэнч байдлын бэлгэдэл, үзэсгэлэнт, буянт хатан; 6. Хамжлагат ард-эрдэнэ: Нууц эрдэнэсийг олж өгөх шидтэй хар хүмүүн; 7. Сайд түшээ-эрдэнэ: Хаанд үнэн зөвийг хэлэх мэргэн ухаант зөвлөх.

Ийнхүү хаан Далханеми хаан угсаа залгамжлагч хунтайжид хаан ширээг хэрхэн удирдахыг сайтар зааж өгснийхөө дараа, үс сахлаа хусаж, зосон орхимж өмсөөд, эгэл хүний амьдралаа орхин, гэр оронгүй амьдралыг замнав.

Долоо хоногийн дараа тэнгэрлэг хүрд-эрдэнэ алга болов.

Тэгээд нэгэн хүн, тэрхүү шинээр соёрхогдсон хаан дээр хүрч ирээд:

“Эрхэм ээ, таны тэнгэрлэг хүрд-эрдэнэ алга болсныг танд мэдэгдэж байна.” гэж хэлэхэд, хааны баяр баясгалан үгүй болж, аз жаргал нь замхран одов.

Тэрбээр, хаант улсынхаа их түшмэл дээрээ очоод,

“Эрхэм ээ, та тэнгэрлэг хүрд-эрдэнэ алга болсныг та болгооно уу.” хэмээн хэллээ.

Түүнийг ингэж хэлэхэд, хааны их түшмэл түүнд:

“Тэнгэрлэг хүрд-эрдэнэ алга болсон явдалд, сэтгэл гундах хэрэггүй юм. Идэр залуу хүү минь, энэ тэнгэрлэг хүрд-эрдэнэ бол эцэг өвгөдөөс тань өвлөгдөн ирсэн зүйл биш билээ. Залуу хүү минь, за тэгэхээр одоо, тэнгэрлэг хүрд-эргүүлэгч хааны, тэрхүү эрхэм ариун үүргийг биелүүлэх цаг тань болжээ.

Хэрэв тэргүүн юугаа угаагаад, тэргэл сартай мацаг өдөр, их өргөөнийхөө дээд тагтан дээрээ гараад, энэ мацаг өдрийг ёс журмын дагуу ёслон өнгөрүүлэх аваас, голтой, бултай, хэдэн мянган хигээстэй, эд анги бүгд бүрэн, ариун хүрд-эрдэнэ өмнө тань гарч ирэх болно.” хэмээн хэлэв.

2.1. Хүрд-Эргүүлэгчийн Ариун Үүрэг (Cakkavattiariyavatta)

“Гэхдээ эрхэм ээ, хүрд-эргүүлэгч хааны эрхэм тэр үүрэг нь юу байх сан билээ?”

“За тэгэхээр хүү минь, чи Сургаал номд ямагт тулгуурлаж, түүнийгээ хүндэлж, дээдэлж, тахиж, шүтэж, Сургаал номыг өөрийн туг, сүлд болгон мандуулж, Сургаал номыг өөрийн эзэн хэмээн хүлээн зөвшөөрч, өөрийн цайз хороо, цэрэг эрс, язгууртан хийгээд хамжлагат ард, брахман болоод хар хүмүүс, хот хөдөөгийн ард иргэд, даянч хийгээд брахман лам нар, ан амьтад, жигүүртэн шувуудад зориулж, Сургаал номын дагуу, харуул манаа, аюулгүй байдлыг бий болгож өгөх учиртай билээ. Гэмт хэргийг бүү гаргуулагтун. Үгээгүй хоосныг мөнгөөр тэтгэгтүн.

Мөн, согтуурал мансуурал хийгээд замбараагүй явдлаас нэгэнт татгалзсан, тэвчээр хатамжлал болоод амгалан дөлгөөнийг өөртөө бий болгосон, тогтсон, томоожсон, өөрийгөө нэгмөсөн огоорсон даянч болон брахман нар байдаг. Тэдэн дээр үе үе зочлон очиж зөвлөлдөж, тэднээс:

‘Эрхэм ээ, юуг зөв сайн гэж үзэх вэ? Юуг буруу муу гэж үзэх вэ? Юуг үйлдвэл буруудах вэ? Юуг үйлдвэл буруудахгүй вэ? Юуг өөрт дадуулах учиртай вэ? Юуг өөрт дадуулж учиргүй вэ? Юуг үйлдэх нь миний алс хэтэд хор хөнөөл, гай зовлонг авчрах вэ? Юуг үйлдэх нь миний алс хэтэд өгөөж буян, аз жаргалыг авчрах

вэ?' гэх мэтээр асууж, тэднээс суралцаж байгаарай. Тэднийг сонссоныхоо дараагаар, буруу муугаас татгалзаж, зөв сайныг даган мөрдөх учиртай юм.

Энэ бол хүрд-эргүүлэгч хааны ариун үүрэг нь билээ."

2.2. Тэнгэрлэг Хүрд Гарч Ирэв (Cakkaratanapātubhāva)

"За, эрхэм дээдэс минь." хэмээн шинэхэн хаан, их төлөгчид хариуллаа. Тэгээд тэрээр хүрд-эргүүлэгч хааны ариун үүргийг даган биелүүлэв.

Тэрбээр, тэргүүн юугаа угаагаад, тэргэл сартай мацаг өдөр, их өргөөнийхөө дээд тагтан дээрээ гараад, энэ мацаг өдрийг ёс журмын дагуу өнгөрүүлэв. Тэгтэл голтой, бултай, хэдэн мянган хигээстэй, эд анги бүгд бүрэн, тэнгэрлэг хүрд-эрдэнэ хааны өмнө гарч ирэв. Үүнийг хараад хаан:

"Тэнгэрлэг хүрд-эрдэнэ бээр, хаан хүмүүнд тэргэл сартай мацаг өдөр ийнхүү үзэгдвэл, тэр хаан ариун хүрд-эргүүлэгч хаан болдог гэж би сонссон билээ. Тэгэхээр би хүрд-эргүүлэгч хаан болж буй хэрэг үү?" хэмээн бодлоо.

Тэгээд хаан суудлаасаа босоод, мөрөн дээрх орхимжоо засаад, зүүн гартаа шүтээний домбоо бариад, баруун гараараа хүрд-эрдэнэ рүү цацах зуур:

"Урагшаа эргэ, хүрд-эрдэнэ минь! Алив хүрд-эрдэнэ минь, хурай хурай!" хэмээн ерөөв.

Тэгэхэд нь хүрд-эрдэнэ зүүн зүг рүү өнхрөв. Тэгээд хаан, дөрвөн их цэргийн хамт түүнийг даган явлаа. Хүрд-эрдэнэ хаана л зогсохоор байна тэр хүртэл нь, хаан их цэргийн хамтаар харгалзан дагахаар явцгаав.

Тэгтэл, зүүн зүгийн дайсагнагч талын удирдагчид түүн дээр ирээд:

"Саатан морил, агуу хаантан минь! Тавтай морил, агуу хаан минь! Бид таны мэдэлд ирэв, агуу хаан минь! Биднийг удирдан жолоодож хайрла." гэв.

Хаан тэгэхэд нь:

"Амьтныг бүү хороо. Хулгайг бүү хий. Садар самуун[514] бүү яв. Худал яриаг бүү ярь. Архи дарсыг бүү уу. Идэш хоолоо бүү ихдүүл." хэмээн хэллээ.

Ийнхүү зүүн зүгийн дайсагнагч талын удирдагчид түүнд дагаар оржээ.

Дараа нь хүрд-эрдэнэ зүүн далайд умбаж, дахин гарч ирээд, өмнө зүг рүү өнхрөн эргэлдэв. Тэгээд хаан, дөрвөн их цэргийн хамт түүнийг даган явав. Хүрд-эрдэнэ хаана л зогсохоор байна тэр хүртэл нь, хаан их цэргийн хамтаар харгалзан дагахаар явцгаав.

[514] *Kāmesumicchācārā*— "садар самуун" буюу үгчилбэл, "таван мэдрэхүйг буруугаар ашиглах". Хар хүний таван сахил (*pañcasīla*)-ын нэг буюу "араар тавих, хүчиндэх", хуримлаагүй хэн нэгэн, насанд хүрээгүй хүнтэй харилцаанд орох, мөн садар завхай сэдэлд автсан бие болон хэл ярианы үйлдэл зэрэг өргөн утга хамаарна.

Тэгтэл өмнө зүгийн дайсагнагч талын удирдагчид түүн дээр ирээд:

“Саатан морил, агуу хаантан минь! Тавтай морил, агуу хаан минь! Бид таны мэдэлд ирэв, агуу хаан минь! Биднийг удирдан жолоодож хайрла.” гэв.

Хаан тэгэхэд нь:

“Амьтныг бүү хороо. Хулгайг бүү хий. Садар самуун бүү яв. Худал яриаг бүү ярь. Архи дарсыг бүү уу. Идэш хоолоо бүү ихдүүл.” хэмээн хэллээ.

Ийнхүү өмнө зүгийн дайсагнагч талын удирдагчид түүнд дагаар оржээ.

Хүрд-эрдэнэ өмнөд далайд шумбаж, дахин гарч ирснээ баруун зүг рүү өнхрөн эргэлдэв. Тэгээд хаан, дөрвөн их цэргийн хамт түүнийг даган явав. Хүрд-эрдэнэ хаана л зогсохоор байна тэр хүртэл нь, хаан их цэргийн хамтаар харгалзан дагахаар явцгаав.

Тэгтэл баруун зүгийн дайсагнагч талын удирдагчид түүн дээр ирээд:

“Саатан морил, агуу хаантан минь! Тавтай морил, агуу хаан минь! Бид таны мэдэлд ирэв, агуу хаан минь! Биднийг удирдан жолоодож хайрла.” гэв.

Хаан тэгэхэд нь:

“Амьтныг бүү хороо. Хулгайг бүү хий. Садар самуун бүү яв. Худал яриаг бүү ярь. Архи дарсыг бүү уу. Идэш хоолоо бүү ихдүүл.” хэмээн хэллээ.

Ийнхүү баруун зүгийн дайсагнагч талын удирдагчид түүнд дагаар оржээ.

Хүрд-эрдэнэ баруун далайд шумбаж, дахин гарч ирснээ хойд зүг рүү өнхрөн эргэлдэв. Тэгээд хаан, дөрвөн их цэргийн хамт түүнийг даган явав. Хүрд-эрдэнэ хаана л зогсохоор байна тэр хүртэл нь, хаан их цэргийн хамтаар харгалзан дагахаар явцгаав.

Тэгтэл хойд зүгийн дайсагнагч талын удирдагчид түүн дээр ирээд:

“Саатан морил, агуу хаантан минь! Тавтай морил, агуу хаан минь! Бид таны мэдэлд ирэв, агуу хаан минь! Биднийг удирдан жолоодож хайрла.” гэв.

Хаан тэгэхэд нь:

“Амьтныг бүү хороо. Хулгайг бүү хий. Садар самуун бүү яв. Худал яриаг бүү ярь. Архи дарсыг бүү уу. Идэш хоолоо бүү ихдүүл.” хэмээн хэллээ.

Ийнхүү хойд зүгийн дайсагнагч талын удирдагчид түүнд дагаар оржээ.

Ингээд хүрд-эрдэнэ нэг далайгаас нөгөө далай хүртэлх тэдгээр газруудыг байлдан дагуулж явсаар, их хааны нийслэл өргөөнд эргэн ирлээ. Тэгээд, хааны Дээд Шүүхийн гаднах их хаалганы дэргэд, бул тэнхлэгт бэхлэгдсэн мэт, бат бөх гэгч нь байрлаад, хааны ордныг чимэглэн гэрэлтүүлэх болжээ.

3. Хүрд-Эргүүлэгчдийн Залгамжлал (Dutiyādicakkavattikathā)

Ийнхүү, хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх, тав, зургаа, долоо дахь удаагийн хүрд-эргүүлэгчдийн хаант төр, яг л ийм байдлаар төвхнөн тогтнов. Олон жилийн дараа, долоо дахь хүрд-эргүүлэгч хаан гарч ирэн, хаант улсаа угсаа залгамжлагч хунтайжид шилжүүллээ.

Харин долоо хоногийн дараа тэнгэрлэг хүрд-эрдэнэ алга болов.

Тэгтэл нэгэн хүн, шинээр соёрхогдсон тэр хаанд хүрч ирээд:

“Эрхэм ээ, таны тэнгэрлэг хүрд-эрдэнэ алга болсныг танд мэдэгдэж байна.” гэж хэлэхэд, тэр хааны баяр баясгалан үгүй болж, аз жаргал нь замхран одов. Гэвч тэрбээр, их төлөгч дээрээ ч очсонгүй, хүрд-эргүүлэгч хааны ариун үүрэг юу болохыг ч асуусангүй. Тэрбээр, ердөө л өөрийнхөө үзэл бодлоороо улс орноо удирдаж байлаа.

Ийнхүү удирдаж байсан тус улсын ард иргэд, урьд өмнөх хаадын хүрд-эргүүлэгчийн эрхэм үүргийг гүйцэтгэж байсан тэдгээр цаг үе шиг дэвжин дээшилсэнгүй.

Тэгээд төрийн сайд, зөвлөх, нярав, даамал, цэргийн жанжин, удирдагч, мэргэжлийн зөвлөхүүд цуглаад, хаандаа хандан:

“Эрхэм дээдэс минь, хэрвээ өөрийнхөө үзэл бодлоороо улс орныг засаглавал ард иргэд, урьд өмнөх хаад хүрд-эргүүлэгчийнхээ ариун үүргийг гүйцэтгэж байсан тэр цаг үе шиг дэвжин дээшилж чадахгүй билээ. Хүрд-эргүүлэгч хааны эрхэм үүргийг санах төрийн сайд, зөвлөх, нярав, даамал, цэргийн жанжин, удирдагч, мэргэжлийн зөвлөхүүд, энэ улсад бий. Бид ч мөн тэдний нэг хэсэг нь билээ. Эрхэм дээдэс ээ, тэнгэрлэг хүрд-эргүүлэгч хааны эрхэм ариун үүргийн талаар асуугтун. Бид бүгд танд үүнийг хэлж өгөх болно.” гэж хэллээ.

4. Доройтлын Үе (Āyuvaṇṇādiparihānikathā)

Ингээд тэр соёрхогдсон хаан, цугларсан төрийн сайд, зөвлөх, нярав, даамал, цэргийн жанжин, удирдагч, мэргэжлийн зөвлөхүүдээс тэнгэрлэг хүрд-эргүүлэгч хааны эрхэм ариун үүргийн талаар асуув. Тэгээд тэд, түүнд бүгдийг хэлж өгөв. Үүнийг сонссоныхоо дараа тэрбээр, ердөө харуул хамгаалалт, аюулгүй байдлыг л хангав. Харин тэр улсынхаа үгээгүй хоосон ядуустаа мөнгө тусламж тараасангүй. Ингээд ядуурал гаарав.

Ядуурал гаарсан энэ үед, нэгэн хүн санаатайгаар хүний эд зүйлсийг хулгайлсан байж гэнэ. Тэд түүнийг баривчилж, хаан дээрээ авчраад,

“Эрхэм дээдэс ээ, энэ хүн, санаатайгаар, бусдын юмыг хулгайлсан байна.” хэмээн мэдэгдэв.

Хаан тэр хүнээс,

“Энэ үнэхээр үнэн гэж үү? Эрхэм ээ та, санаатайгаар энэ хулгайг үйлдсэн гэж үү?” гэхэд,

“Энэ бол үнэн, эрхэм дээдэс ээ.” гэлээ.

“Ямар шалтгааны улмаас үүнийг үйлдэв?”

“Эрхэм дээдэс ээ, би ердөө үмх хоолны төлөө л үүнийг үйлдсэн билээ.” гэж хариулав.

Тэгэхэд нь, хаан тэр хүнд мөнгөн тусламж үзүүлээд,

“Эрхэм ээ, энэ мөнгөөр амин зуулгаа хийж, эцэг эх, хань ижил, үр хүүхдүүдээ тэжээ. Цаашдаа ажил төрөл эрхэлж, тэнгэр диваажинд хөтөлдөг, ариуслын аз жаргалыг цогцлоодог, сайн төрлийг олдог, ариун өглөг буяныг, даянч болон бярман нарт дандаа өгч яваарай.” гэв.

“За, эрхэм дээдэс ээ.” хэмээн тэр хүн хариуллаа.

Хүмүүс энэ явдлын тухай: ‘Хаан бусдаас хулгай хийсэн хэнд ч бай, мөнгө тусламж өгч байгаа бололтой шүү!’ гэж сонсоод, ‘Бид яахаараа бас бусдаас хулгай хийж болохгүй гэж?’ гэсэн бодол тэдэнд төржээ. Ингээд өөр бас нэгэн хүн бусдаас эд зүйлс хулгайлсан хэрэгт холбогдов. Тэд түүнийг баривчилж, хаан дээр авчраад,

“Эрхэм дээдэс ээ, энэ хүн, санаатайгаар, бусдын юмыг хулгайлсан байна.” гэж мэдэгдэв.

Хаан тэр хүнээс,

“Энэ үнэхээр үнэн гэж үү? Эрхэм ээ та, санаатайгаар энэ хулгайг үйлдсэн гэж үү?”

“Энэ бол үнэн, эрхэм дээдэс ээ.”

“Ямар шалтгааны улмаас үүнийг үйлдэв?”

“Эрхэм дээдэс ээ, би ердөө үмх хоолны төлөө л үүнийг үйлдсэн билээ.”

Ингээд хаан бодлоо, ‘Хэрэв би бусдаас хулгай хийсэн бүх хүмүүст мөнгө тусламж өгөөд байвал, ердөө хулгай тонуулыг л гааруулах нь байна. Тиймээс би, түүнийг алж, түүний толгойг авч, энэ хүнээр энэ явдлыг эцэс болгох нь зүйтэй.’

Тэгээд тэрбээр өөрийн хүмүүстээ:

“За нөхөд өө, энэ хүний гарыг ард нь олсоор чанга гэгч нь хүл. Түүний үсийг хусаж, аюулын харанга дэлдэж, хотын гудамж талбайгаар авч яв. Тэгээд түүнийг урд дааман хаалгаар гаргаад, түүнийг алж, түүний толгойг ав.” хэмээн тушаав.

“Тэгье ээ, эрхэм дээдэс ээ.” гэж тэд хариулаад, түүний тушаалыг ёсоор болгов.

Хүмүүс энэ явдлын тухай: ‘Хаан бусдаас хулгай хийсэн хэний ч бай, толгойг нь авч байгаа бололтой шүү!’ гэж сонсоод, ‘Бид тэгвэл, хурц жад сэлэмтэй болцгоосон нь дээр юм. Тэгээд, бид хүмүүсээс хулгай хийсэн үедээ, хөрөнгийн эздийг алж, толгойг нь авч байх хэрэгтэй юм байна.’ хэмээн боджээ. Тэд хурц

жад сэлэм хийцгээв. Ингээд тэд хот тосгон, суурь гацаа руу дайрч, төв замууд дээр дээрэм тонуул хийж эхлэв. Тэгээд тэд, юмыг нь авсан хүмүүсийнхээ толгойг нь ч авдаг болов.

Хуврагууд аа, ийнхүү үгээгүй ядуу хүмүүст мөнгө тусламж өгөхгүй байснаар, өлсгөлөн ядуурал газар авсан юм. Ядуурал газар авах хирээр, хулгай дээрэм хааяагүй болов. Хулгай дээрэм гаарах хирээр, хутга сэлэм хааяагүй болов. Хутга сэлэм хааяагүй болох хирээр, аллага хядлага гаарав. Ингээд, аллага хядлага гаарснаар, тэдгээр хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундав. Тэдгээр хүмүүс 80 000 жил амьдарсан ч, үр хүүхдүүд нь 40 000 жил амьдрав.

Тэдгээр 40 000 жил амьдрах хүмүүсийн нэг нь хүний эд юм хулгайлсан байлаа. Тэд түүнийг баривчилж, хаан дээрээ авчраад,

“Эрхэм дээдэс ээ, энэ хүн, санаатайгаар, бусдын эд юмыг хулгайлсан байна.” гэж мэдэгдэв.

Хаан тэр хүнээс,

“Энэ үнэхээр үнэн гэж үү? Эрхэм ээ та, санаатайгаар энэ хулгайг үйлдсэн гэж үү?” гэхэд,

“Үгүй ээ, эрхэм дээдэс ээ.” хэмээн тэр түүнд санаатай худал хэлэв.

Хуврагууд аа, ийнхүү үгээгүй ядуу хүмүүст мөнгө тусламж өгөхгүй байснаар өлсгөлөн ядуурал газар авсан юм. Ядуурал газар авах хирээр хулгай дээрэм ч хааяагүй болов. Хулгай дээрэм гаарах хирээр хутга сэлэм ч хааяагүй болов. Хутга сэлэм хааяагүй болох хирээр аллага хядлага ч гаарав. Ингээд, аллага хядлага гаарснаар худлаа ярих явдал дэндэв. Тэдгээр худал ярих хүмүүсийн нас богиносож, гоо үзэсгэлэн нь гундлаа. Тэдгээр хүмүүс 40 000 жил амьдарсан ч, үр хүүхдүүд нь 20 000 жил амьдрав.

Тэдгээр 20 000 жил амьдрах хүмүүсийн нэг нь хүний юм хулгайлсан байлаа. Тэгэхэд нэгэн хүн хаандаа очиж,

“Эрхэм дээдэс ээ, тэр хүн санаатайгаар бусдын юмыг хулгайлсан байна.” гэж түүнийг сэм матав.

Хуврагууд аа, ийнхүү үгээгүй ядуу хүмүүст мөнгө тусламж өгөхгүй байснаар өлсгөлөн ядуурал газар авсан юм. Ядуурал газар авах хирээр хулгай дээрэм хааяагүй болов. Хулгай дээрэм гаарах хирээр хутга сэлэм хааяагүй болов. Хутга сэлэм хааяагүй болох хирээр аллага хядлага гаарав. Ингээд, аллага хядлага гаарснаар худлаа ярих явдал дэндэв. Худал ярихын хирээр далдуур матах, гүтгэх явдал дэндлээ. Тэдгээр далдуур матах, гүтгэх үйлийг хийгч хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундлаа. Тэдгээр хүмүүс 20 000 жил амьдарсан ч, үр хүүхдүүд нь 10 000 жил амьдрав.

10 000 жил амьдрах хүмүүсийн зарим нь үзэмж сайн, зарим нь үзэмж дорой байлаа. Үзэмж дорой нь үзэмж сайндаа шунасаар, бусдын эхнэртэй холбогдох болов.

Хуврагууд аа, ийнхүү үгээгүй ядуу хүмүүст мөнгө тусламж өгөхгүй байснаар өлсгөлөн ядуурал газар авсан юм. Ядуурал газар авах хирээр хулгай зэлгий, хутга сэлэм, аллага хядлага, худал яриа, гүтгэлэг матаас, самуурах завхайрах явдал дэндсэн юм. Тэдгээр гэр бүлээс гадуурх явдалтай хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундлаа. Тэдгээр хүмүүс 10 000 насалсан ч, үр хүүхдүүд нь 5000 насаллаа.

Тэдгээр 5000 наслах хүмүүсийн дунд ширүүн дориун ярих болон дэмий хэрэггүй юм ярих гэсэн хоёр үйл өргөн дэлгэр болов. Эдгээр хоёр үйл өргөн тархсан хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундлаа. 5000 жил амьдарсан тэдгээр хүмүүсийн үр хүүхдүүдийн зарим нь 2500 жил, зарим нь 2000 жил амьдрав.

Тэдгээр 2500 наслах хүмүүсийн дунд хүсэл-мөрөөсөл, хар-санаа өргөн дэлгэр болов. Хүсэл-мөрөөсөл, хар-санаат хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундав. Тэдгээр 2500 наслах хүмүүсийн үр хүүхдүүд нь 1000 жил амьдрав.

Тэдгээр 1000 наслах хүмүүсийн дунд буруу үзэл газар авав.

Буруу үзэл бодолтой хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундав. Тэдгээр 1000 жил амьдарсан хүмүүсийн үр хүүхдүүд нь 500 насалжээ.

Тэдгээр 500 жил амьдарсан хүмүүсийн дунд, ёс бус дур-хүсэл, тамтаггүй их шунал болон гаж буруу зуршил[515] гэсэн гурван үйл, өргөн дэлгэр болов.

Эдгээр гурван үйлд автсан хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундав. Тэдгээр 500 наслах хүмүүсийн үр хүүхдүүдийн зарим нь 250 жил, зарим нь 200 жил амьдрав.

Тэдгээр 250 наслах хүмүүсийн дунд эцэг эхээ, даянч болон бярман нарыг, мөн ахмад настнаа эс хүндлэх байдал дэндэв.

Хуврагууд аа, ийнхүү үгээгүй ядуу хүмүүст мөнгө тусламж өгөхгүй байснаар өлсгөлөн ядуурал, хулгай зэлгий, хутга сэлэм, аллага хядлага, худал яриа, гүтгэлэг матаас, гэр бүлээс гадуурх явдал, ширүүн дориун яриа, дэмий буруу яриа, хүсэл-мөрөөсөл, хар-санаа, буруу үзэл бодол, ёс бус дур-хүсэл, тамтаггүй их шунал, гаж буруу зуршил болоод, эцэг эх, даянч, бярман, ахмад настнуудаа эс хүндлэх байдал, бүгд өргөн тархав. Эдгээр явдалд автсан хүмүүсийн нас нь богиносож, гоо үзэсгэлэн нь гундсан билээ. Ингээд 250 насалсан тэдгээр хүмүүс 100 насалдаг үр хүүхдүүдтэй болсон билээ.

5. Хүний Нас Арав Болох Цаг (Dasavassāyukasamaya)

Хуврагууд аа, эдгээр хүмүүсийн үр хүүхэд арван жил насалдаг цаг үе ирэх болно. Арван жил амьдрах хүмүүсийн охин хүүхэд нь таван настайдаа хуримладаг болно.

Шар тос, зөөхий, цөцгийн тос, зөгийн бал, чихэр бурам, давсны амт гэж үгүй болох болно.

Өнөө цагт, махтай цагаан будаа тансаг зоог байдаг шиг, шар будаа[516] тэр цагт хамгийн тансаг хоол болно.

---

515 *Micchādhamma*—“гаж буруу зуршил”, эсвэл “буруу ном”. Зарим тайлбарт, “ижил хүйстний харилцаа” (анг. *homosexuality*) гэжээ (DA).

516 *Kudrūsaka*—“шар будаа” (лат. *eleusine coracana*, анг. *finger millet*). Дээд зэргийн (сортын) цагаан будааг халуун орны бүсэд хамгийн үнэ цэнтэй, дээд зиндааны хүнсэнд тооцох бөгөөд, харин шар будааг цагаан будаа ургуулах боломжгүй

Арван цагаан буян хийх гэсэн ойлголт бүрмөсөн үгүй болж, арван хар нүгэл хийх нь галт уул тэсрэх мэт газар аван түгнэ. Тэдгээр хүмүүсийн хэлэн ярианд, “зөв сайн” гэдэг үг ч байхгүй болсноор, зөв сайныг үйлддэг хүн гэж үгүй болно.

Тэгээд өнөө цагаас тэс эсрэгээрээ, эцэг эх, даянч болон бярман нар, ахмад настнаа үл хүндэлж, эс ойшоосон аливаа хүн, харин ч бүр хүндлэгдэж, харин ч улам бишрэгдэх болно.

Ээж, эгч, эхнэр эсвэл хүндтэй нэгний гэргий гэсэн ойлголт огт хамаагүй хэрэг болж, хонь ямаа, тахиа гахай, чоно нохой мэт заваарна.

Тэд, бие биедээ дайсагнах, муу санах, хорлох чадах, алах хядах, санаа бодлоор дүүрэн болно. Эх нь үрээ, үр нь мөн эхээ, эцэг нь хүүгээ, хүү нь эцгээ, ах нь эгчээ, эгч нь ахаа, хорлох егүүтгэх талаар боддог болно. Бугын анчин буга олж харсан мэт, дайсагнах, муу санах, хорлох чадах, алах хядах санаа бодлоор дүүрэн болно.

Арван жил амьдрах эдгээр хүмүүсийн хооронд, хутга сэлэм агссан тэмцэл долоо хоног үргэлжлэх болно. Тэр үед тэд, бие биеэ адгуус араатан мэт үзнэ. Гартаа хурц жад сэлэм агсаад, тэд бие биеийнхээ амийг авч, ‘Энэ адгуус! Энэ адгуус!’ гэж орилж бархирна.

Харин тэдгээр хүмүүсийн заримд нь, ‘Бүгдээрээ огт алдаггүй, огт алуулдаггүй болцгооё! Бид яагаад өндөр өвс, ширэнгэн ой, ой мод, хүн очихын аргагүй голын бэлчир, хад асагт нуугдаж, ойгоос үр үндэс, жимс ногоо идээд амьдарч болохгүй гэж?’ гэсэн бодол төрөх ажээ. Ингээд тэд, тэр ёсоор амьдарна.

Тэрхүү тэмцэлт долоон хоног өнгөрсний дараа, нуугдаж байсан газраасаа тэд гарч ирцгээгээд, бие биеэ тэврээд, “Ямар сайхан учрал вэ? Хөөрхий минь, чи минь амьд байна шүү дээ! Ямар гайхалтай учрал вэ? Хөөрхий минь, та минь амьд байна шүү дээ!” гэцгээж, зэрэг зэрэг уйлалдах болно.

6. Хөгжлийн Эрин (Āyuvaṇṇādivaḍḍhanakathā)

Ингээд тэд:

“Бид буруу муу үйлд автсанаас болж, элгэн саднаа алдлаа. Бид зөв сайныг үйлдэж байх нь зүйтэй юм. Бид ямар зөв сайн зүйлсийг үйлдэж байсан нь зүйтэй вэ? Тэгвэл бид яагаад аливаа бодгалийг алж хороохоос татгалзаж болохгүй гэж? Ийм зөв сайныг үйлийг дадуулж, бид ийм зөв номоор амьдрах болно.” гэх зэргээр бодно.

Ийнхүү зөв сайн замналаар явснаар тэдний амьдрах нас, гоо үзэсгэлэн нэмэгдэх болно. Арван жил амьдрах тэдгээр хүмүүсийн үр сад нь хорин жил наслах болно.

Тэгээд тэдгээр хүмүүс,

газар л тариалах ба зэрэг доогуур хүнс гэж үзнэ (Орч).

"Энэхүү зөв сайн үйлийг дадуулснаар бидний амьдрах нас, гоо үзэсгэлэн нэмэгдэж байна. Бид яагаад илүү ихээр зөв сайн зүйлийг үйлдэж болохгүй гэж? Бид ямар зөв сайн зүйлсийг үйлдэж байсан нь зүйтэй вэ? Бусдын өгөөгүйг авах явдал, гэр бүлээс гадуурх явдал, худал хуурмаг, хов гүтгэлэг, ширүүн дориун, дэмий буруу ярианаас бид яагаад татгалзаж болохгүй гэж. Бид яагаад хүсэл-мөрөөсөл, хар-санаа, буруу үзэл бодол, ёс бус дур-хүсэл, тамтаггүй их шунал, гаж буруу зуршлаас салж татгалзаж болохгүй гэж? Бид яагаад эцэг эх, даяанч болон бярман нар, ахмад настнуудаа дээдэлж хүндэлж болохгүй гэж? Ийм зөв сайныг дадуулж, бид ийм зөв номоор амьдрах болно." гэх зэргээр бодно.

Ингээд тэд энэ ёсоор амьдрах болно.

Энэхүү зөв сайн замналаар явснаар тэдний амьдрах нас, гоо үзэсгэлэн нэмэгдэх болно. Хорин жил амьдрах тэдгээр хүмүүсийн үр сад, дөч наслах болно. Дөчин жил амьдрах тэдгээр хүмүүсийн үр сад, ная наслах болно. Ная насалсан хүмүүсийн үр сад 160 жил, 320 жил, 640 жил, 2000 жил, 4000 жил, 8000 жил, 20 000 жил, 40 000 жил, бүр сүүлдээ 80 000 наслах болно. Тэдгээр 80 000 наслах хүмүүсийн охид хүүхдүүд нь таван зуун настайдаа гэрлэдэг болно.

7. Санкха Хааны Үе (Saṅkharājauppatti)

Наян мянган жил амьдрах хүмүүсийн хувьд, хүсэл, өлсгөлөн, хөгшрөлт гэсэн гурван зовлон л байх болно. Энэ замбуу тив[517] дэвжин дээшилж, цэцэглэн хөгжиж, тосгон суурин, хот нийслэлүүд, хоорондоо тахиа нисээд хүрэхээр, ойр зэргэлдээ болно.

Замбуу тив зэгс бургас адил, зай завсаргүй хүмүүсээр дүүрч, тамын амьтас шиг чигжүү болно. Варанаси хотоор тэд нийслэлээ хийгээд, Кетуматий[518] хэмээн нэрийдээд, хөрөнгө баялагтай, хөгжил дэвшилтэй, хүн зон ихтэй, хүний хөл холхисон, хүнс хоол элбэг, тийм газар болно. Энэ замбуу тивд 84 000 хот байх бөгөөд их нийслэл нь Кетуматий болно.

Тэгээд их нийслэл Кетуматийд, Санкха[519] хэмээх хаан тодрон гарч ирэх ба тэрбээр хүрд-эргүүлэгч, шударга бөгөөд зарчимч нэгэн хаан болно. Түүний хаанчлал дөрвөн зовхист хүрч, улс орныг тогтвортой амгалан болгож, долоон эрдэнийг оршоосон нэгэн болно.

Түүний долоон эрдэнэ болбоос: хүрд-эрдэнэ, заан-эрдэнэ, ажнай-эрдэнэ, баялаг-эрдэнэ, бүсгүй-эрдэнэ, хамжлагат ард-эрдэнэ, сайд түшээ-эрдэнэ, эдгээр долоон эрдэнэ юм. Түүнд, атаатан дайсны их цэргийг бут ниргэх, айдас үгүй эрэлхэг баатарлаг, мянга гаруй хөвгүүд бий. Тэнгис далайгаар тойрон хүрээлэгдсэн, тив газрыг эзэлсэн хойноо, тэрбээр, мод шийдэм, илд сэлэмгүй зарчмаар, улс орноо захиран суух болно.

---

517 *Jambudīpo*—"замбуу тив" (сам. *jambudvīpa*). Үгчилбэл: *jambu*—замбуу (хар чавга); *dīpo*—тив, арал. Энэтхэгийн хойгийг тэр чигт нь хамруулан нэрлэсэн үг. Паали, самгарди хэлнээс монгол хэлэнд орж ирсэн байж болох цөөнгүй үгсийн нэг.

518 *Ketumatī*—"Кетуматий". Үгчилбэл, "тугаар гоёсон". Эртний хот *Bārāṇasī* буюу өнөөгийн Энэтхэгийн *Uttar Pradesh*.

519 *Saṅkha*—"Санкха". Үгчилбэл, "дун, хясаа" ("зүлгэсэн хясаа шиг" өөгүй гэсэн ёгт санаа).

8. Меттейяа Будда Төрөхүй (Metteyyabuddhuppāda)

Тэгээд тэр цагт, яг л өнөө цагт би тодрон гарч ирсний адил, Меттейяа[520] нэртэй, Ерөөлтэй Нэгэн, энэ дэлхий дээр тодрон гарч ирнэ. Тэрхүү, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда, саруул ухаан хийгээд сахил ёсыг оршоосон, Зөвөөр Одогч, Хорвоог Ухаарагч, Эгнэшгүй Нэгэн, Ухаарах Учиртайг Ухааруулах Сургагч, Бурхад Хийгээд Хүмүүсийн Багш, Сэрсэн Нэгэн, Ерөөлтэй Нэгэн, энэхүү Тийн Одогч энэ хорвоод төрнө.

Тэрбээр, яг л өнөө цагт миний үйлдэж буйн адил, бурхан, чөтгөр, Тэнгэр, даянч болоод бярман, хаад ноёд хийгээд харц ард бүхий тэр цаг үеийнхний хамтдаа амьдран байх тэр хорвоог, өөр дээрээ тэрээр шууд-билгүүнээр ухаарснаар, үүнийг олонд түгээн таниулах болно. Эхэндээ ч зөв сайн, дундаа ч зөв сайн, эцэстээ ч мөн зөв сайн, эш утга бүхий, үг хэллэг бүхий, бүрэн төгс, бүхэлдээ ариун, ариуслын-замналыг тэр илчлэн заах болно.

Өнөө цагт би олон зуун хувраг бүхий Хуврагийн Чуулганыг удирдах адил, тэрээр олон мянган хувраг бүхий Хуврагийн Чуулганыг удирдах болно.

Тэгээд Санкха хаан, нэгэн цагт Махаапанаада[521] хааны босгож байсан, тахилгын баганыг сэргээн босгоно. Хаан ширээнд заларсныхаа дараа, тэрбээр тэр хаан ширээнээсээ татгалзаж, даянч, бярман, ядуус, тэнүүлчид, нүүдэлчид, гуйлгачдад, өргөл буяныг үйлддэг болно. Дараа нь тэрээр, үс сахлаа хусаад, зосон орхимж нөмрөөд, эгэл хүмүүний амьдралаа орхиод, гэр оронгүй замыг сонгоод, Меттейяа Буддагаас сахил авна. Ийнхүү хуврагийн дээд сахил аваад удаагүй тэр, орь ганцаараа, бүгдээс тусгаарлагдан, уйгагүй мэрийлттэй, хичээл зүтгэлтэй, өөрийгөө огоорон амьдарснаар, ёстой л, сайн айлын хөвгүүд, зорилгоо болгон орон гэрээ орхиж, орон гэргүй сахилтан болж хүрдэг ариуслын-замналын төгс төгөлдөр оргилд их удалгүй хүрч, энэ насандаа шууд-билгүүнийг өөрийн биеэр ухаарч, тэр зэрэгт хүрч амьдрах болно.

Хуврагууд аа, өөр аврал үгүй мэт, өөрөө өөрийнхөө арал болж, өөрөө өөрийнхөө аврал болж явах учиртай. Өөр аврал үгүй мэт, Сургаалыг өөрийн арлаа болгож, Сургаалыг өөрийн авралаа болгож амьдрах учиртай.[522]

Хуврагууд аа, хувраг хүн, өөр аврал үгүй мэт, өөрөө өөрийнхөө арал болж, өөрөө өөрийнхөө аврал болж, өөр аврал үгүй мэт, Сургаалыг өөрийн арлаа болгож, Сургаалыг өөрийн авралаа болгож, хэрхэн амьдрах вэ?

---

520 *Metteyya*—“Меттейяа” (сам. *Maitreya*). Монголчууд “Майдар Будда” (эсвэл Майдар Бурхан) гэж нэрлэдэг. Будда болох учиртай бодгалиуд хүний төрөл авахаас урьд *Tusita* диваажинд бурхны төрөл авдаг гэж үздэг. Ирээдүйн-Будда (*Bodhisatta*) Меттейяа одоо тэнд заларч байгаа гэж буддын уламжлалд үздэг. (“Ирээдүйн-Будда”-гийн тайлбар үз.)

521 *Mahāpanāda*—“Махаапанаада”. Голдуу агуу их эд баялаг, буянтай сайн хааны дүрээр паали домог үлгэрт гарах ба үйлийн үр ба бардамнал, сүр хүчний түр зуурын шинжийг харуулах хэсэгт дурдагджээ. (Ja)

522 Өмнөх судраат (DN 16) гарсан энэ хосгүй үгийг энэ тохиолдолд байж болох арай өөр орчуулгын хувилбараар оруулав.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, бие дээр биеийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, мэдрэмж дээр мэдрэмжийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, сэтгэл дээр сэтгэлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Хувраг хүн, энэ хорвоогийн хүсэл-мөрөөсөл, зовнил-гунигаа үгүй хийж, Үзэгдэл дээр, Үзэгдлийн ажиглалттай, хичээл зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтай оршин байна.

Ингэж л, хувраг хүн, өөр аврал үгүйн адил, өөрөө өөрийнхөө арал болж, өөрөө өөрийнхөө аврал болж, өөр аврал үгүйн адил, Сургаалыг өөрийн арлаа болгож, Сургаалыг өөрийн авралаа болгож амьдарна.

9. Хувраг Хүний Урт Нас Хийгээд Гоо Үзэмж (Bhikkhunoāyuvaṇṇādivaḍḍhanakathā)

Хувраргууд аа, та нар өөрийн бэлчээр газар буюу эцэг өвгөдөөс өвлөн авсан газар нутаг дотор бадарчлан яваарай. Ийм байгаа цагт, наслах нас уртсаж, гоо үзэмж нэмэгдэж, аз жаргал, эд баялаг, хүч чадлыг олох болно.

Хувраг хүний хувьд урт нас гэж юу байх вэ?

Хувраргууд аа, энэ нь, урам зориг хийгээд уйгагүй хичээл зүтгэлийн үр дүнд, төвлөрөл даянд орж, улмаар ид-чадлын үндэс суурийг үүсгэх үед үүсэн бий болно.

Тэд эрч хүч хийгээд идэвхтэй хүчин чармайлтын үр дүнд, төвлөрөл даянд орж, улмаар ид-чадлын үндэс суурийг үүсгэх үед үүсэн бий болно.

Тэд оюун санааны хөгжил хийгээд уйгагүй чармайлтын үр дүнд, төвлөрөл даянд орж, улмаар ид-чадлын үндэс суурийг үүсгэх үед үүсэн бий болно.

Тэд ухан шинжихүй хийгээд уйгагүй чармайлтын үр дүнд, төвлөрөл даянд орж, улмаар ид-чадлын үндэс суурийг үүсгэх үед үүсэн бий болно.

Ид-чадлын, эдгээр дөрвөн үндсийг хөгжүүлж, төлөвшүүлсний дараа, хэрэв тэд хүсвэл, таарамжтай насыг наслан эсвэл наслах учиртай насыг наслан амьдрах боломжтой.

Хувраг хүний урт нас гэж үүнийг хэлэх билээ.

Хувраг хүний хувьд гоо үзэмж гэж юу байх вэ?

Хувраг хүн, сахил-ухамсартай, сахил санваартаа үнэнч, явдал суудал нь зөв, зохистой газраар бадраа барьдаг байх учиртай юм. Тэрээр, өчүүхэн ч гэсэн, алдаан дундаас ирэх аюулыг, алдалгүй олж хараад, сахил номоо даган мөрддөг.

Хувраг хүний гоо үзэмж гэж үүнийг хэлэх билээ.

Хувраг хүний хувьд аз жаргал гэж юу байх вэ?

Хувраг хүн мэдрэхүйн-таашаалаас салснаар, тусгүй-муу Зүйлээс салснаар, тэрбээр зурвас-бодол бүхий, эргэцүүлсэн-бодол бүхий, ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий нэгдүгээр даян зэрэгт хүрснээр тэр оршин байна.

Цаашилбал хувраг хүний зурвас-бодол, эргэцүүлсэн-бодол намжиж, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий, дотоод амар-амгалан, оюуны-нэгдэл бүхий, хоёрдугаар даян зэрэгт хүрснээр, тэр оршин байна.

Цаашилбал хувраг хүн хөөр-баяраас салж-ангижирснаар, дүүрэн-анхаарал тунгалаг-оюун бүхий төв-оршихуйд байж, аз-жаргалыг бие махбодоороо мэдрэх ба үүнийг Гэгээнтнүүд, "Төв-оршихуйд, дүүрэн-анхааралтай, аз-жаргалд умбав" хэмээн нэрийдэх буюу ингэж гуравдугаар даян зэрэгт хүрснээр, тэр оршин байна.

Цаашилбал хувраг хүн жаргалаас салж-ангижирснаар, зовлонгоос салж-ангижирснаар, урьдын таатай хийгээд таагүй байдал алга болсноор, жаргал зовлонгийн аль нь ч бус, төв-оршихуйгаас үүссэн дүүрэн-анхаарлын ариусал, дөрөвдүгээр даян зэрэгт хүрснээр, тэр оршин байна.

Хувраг хүний аз жаргал гэж үүнийг хэлэх билээ.

Хувраг хүний хувьд эд баялаг гэж юу байх вэ?[523]

1. Хувраг хүн, ивээл хайр[524] дагалдсан зүрх сэтгэлийг[525], нэгэн зүг, хоёр зүг, гурван зүг, дөрвөн зүг, зүг бүр, цацруулан илгээж бясалгана. Үүний нэгэн адил, тэрбээр, элбэг дэлбэг, энгүй өргөн, хаяа хязгаар үгүй, зүхэл хорсол үгүй, хар-санаа, хорлол үгүй, ивээл хайр дагалдсан зүрх сэтгэлийг, дээшээ, доошоо, эргэн тойрондоо, хаа сайгүй, зүг бүхэнд, энэ хорвоо даяар цацруулан илгээж оршино.

---

523 Энэ бол "Тэнгэрлэг Оршихуйн Дөрвөн Бясалгал" (па. *cattāri brahmavihārā,* анг. *four divine abodes meditation*)-ын эртний унаган хувилбар. Шашны олон урсгалд янз бүрээр нэрлэн, янз бүрээр өөрчлөн хийдэг алдартай бясалгал. Эртний Буддизмд энэ бясалгал нь ангижрах замналын сайн суурь болж өгдөг, сэтгэл санааг ариусгах, сэтгэлийн-хирийг арилгах, төвлөрөл дадуулах дасгал болдог. Уур-хилэн, зөрчил-хорсол, хар-санаа, сэтгэлийн муу муухай байдалгүй болгох ач холбогдолтой бясалгал.

524 *Mettā*—"ивээл хайр". Эсвэл "элбэрэл асрал", "дотно сэтгэл", "нөхөрсөг байдал".

525 *Cetasā*—"зүрх сэтгэлийг". "Сэтгэл" (*citta*)-г үз. *Citta*-г зүрхтэй холбож ярих, тайлбарлах хандлага түгээмэл тул энэ тохиолдолд "зүрх сэтгэл" гэж оруулав.

2. Хувраг хүн, энэрэл нигүүлсэл[526] дагалдсан зүрх сэтгэлийг, нэгэн зүг, хоёр зүг, гурван зүг, дөрвөн зүг, зүг бүр, цацруулан илгээж бясалгана. Үүний нэгэн адил, тэрбээр, элбэг дэлбэг, энгүй өргөн, хаяа хязгаар үгүй, зүхэл хорсол үгүй, хар-санаа, хорлол үгүй, энэрэл нигүүлсэл дагалдсан зүрх сэтгэлийг, дээшээ, доошоо, эргэн тойрондоо, хаа сайгүй, зүг бүхэнд, энэ хорвоо даяар цацруулан илгээж оршино.

3. Хувраг хүн, өрөөлийн жаргалд баярласан[527] зүрх сэтгэлийг, нэгэн зүг, хоёр зүг, гурван зүг, дөрвөн зүг, зүг бүр, цацруулан илгээж бясалгана. Үүний нэгэн адил, тэрбээр, элбэг дэлбэг, энгүй өргөн, хаяа хязгаар үгүй, зүхэл хорсол үгүй, хар-санаа, хорлол үгүй, өрөөлийн жаргалд баярласан зүрх сэтгэлийг, дээшээ, доошоо, эргэн тойрондоо, хаа сайгүй, зүг бүхэнд, энэ хорвоо даяар цацруулан илгээж оршино.

4. Хувраг хүн, төв-оршихуй дагалдсан зүрх сэтгэлийг, нэгэн зүг, хоёр зүг, гурван зүг, дөрвөн зүг, зүг бүр, цацруулан илгээж бясалгана. Үүний нэгэн адил, тэрбээр, элбэг дэлбэг, энгүй өргөн, хаяа хязгаар үгүй, зүхэл хорсол үгүй, хар-санаа, хорлол үгүй, төв-оршихуй дагалдсан зүрх сэтгэлийг, дээшээ, доошоо, эргэн тойрондоо, хаа сайгүй, зүг бүхэнд, энэ хорвоо даяар цацруулан илгээж оршино.

Хувраг хүний эд баялаг гэж үүнийг хэлэх билээ.

Хувраг хүний хувьд хүч чадал гэж юу байх вэ?

Хувраг хүний оюуны-хорлол үгүй болж, оюуны-хорлол үгүй сэтгэлийн ангижрал, саруул-ухааны ангижралаар энэ насандаа амжин өөрийн шууд-билгүүнээр гэгээрлийг олж, тэр зэрэгт хүрч амьдрах болно. Хувраг хүний хүч чадал гэж үүнийг хэлэх билээ.

Хуврагууд аа, би Маара чөтгөрийн хүч чадлаас өөр, ялж дийлэхэд хэцүү бэрх, тийм өөр нэгээхэн ч хүч чадлыг олж харахгүй байна.

Сайн чанараа улам дадуулан хөгжүүлж гэмээ нь, буян заяа чинь өсөн нэмэгдэх болно.”

Будда ийн айлдав.

Хөөр баяртай хуврагууд, Буддагийн айлдсан сургаалд сэтгэл өндөр болов.

Хүрд-Эргүүлэгч Судар энд өндөрлөв.

---

526 *Karuṇā*—“энэрэл нигүүлсэл”. Эсвэл “бусдыг бүү зовоосой гэсэн сэтгэл”, “бусдыг өрөвдөж хайрласан сэтгэл”, “өршөөнгүй, энэрэнгүй сэтгэл”.

527 *Muditā*—“өрөөлийн жаргалд баярласан”. Эсвэл “бусдыг баяртай байгаад баярлах сэтгэл”, “өрөөлийг жаргалтай байгаад нь таатай хандах сэтгэл”. Монголчуудын “буянд даган баясах” гэх мэтээр хэлдэг үгийн унаган санаа.

ИТГЭЛ ТӨРҮҮЛЭХ СУДАР
DN 28. SAMPASĀDANĪYASUTTA

1. Саарипуттагийн Тунхаглал (Sāriputtasīhanāda)

БИ ИЙН СОНССОН ЮМ.

Нэгэн цагт Будда, Наалагдаагийн ойролцоо Паавaарикагийн манго төгөлд байрлаж байлаа.

Тэр үед Эрхэм Саарипутта, Будда дээр ирээд, түүнд мөргөснийхөө дараа нэг талд нь суув. Эрхэм Саарипутта хажууд нь сууж байхдаа Буддад ийн хэлэв:

“Эрхэм Багш аа, би: ‘Төгс Гэгээрлийн тал дээр Буддагаас илүү ихийг мэдсэн, илүү ихийг ухаарсан өөр хэн нэгэн даянч эсвэл бярман, өнгөрсөн үед ч байгаагүй, ирээдүйд ч байхгүй, өнөө цагт ч байхгүй.’ хэмээн, би Буддад ийм л итгэл дүүрэн явдаг билээ.” гэв.

“Агуу бөгөөд сүр жавхлантай үгийг Эрхэм Саарипутта та хэллээ. Тов тодорхой, сайтар ойлгогдох, агуу тунхаглалыг ийн тунхаглав: ‘Би: “Төгс Гэгээрлийн тал дээр Буддагаас илүү ихийг мэдсэн, илүү ихийг ухаарсан өөр хэн нэгэн даянч эсвэл бярман, өнгөрсөн үед ч байгаагүй, ирээдүйд ч байхгүй, өнөө цагт ч байхгүй.” хэмээн, би Буддад ийм л итгэл дүүрэн явдаг билээ.’

Гэхдээ, Эрхэм Саарипутта та, өнгөрсөн цагт Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нарыг ухан ойлгож, тэдгээр Будда нарын оюун санааг өөрийн оюун санаагаараа таньж мэдсэн юм уу? Түүнчлэн тэр Буддад, ийм сахил-ухамсар байсан уу, тэр Буддад, ийм сайн чанар байсан уу, тэр Буддад, ийм саруул-ухаан байсан уу, тэр Буддад, ийм бясалгал амьдрал байсан уу, тэр Будда, ийм гэгээрэл ангижралд орсон болов уу гэх мэтээр?”

“Үгүй ээ. Эрхэм Багш аа.”

“Тэгвэл Эрхэм Саарипутта та, ирээдүйн тэр нэгэн цагт Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нарыг ухан ойлгож, тэдгээр Будда нарын оюун санааг өөрийн оюун санаагаараа шууд таньж мэдсэн юм уу? Түүнчлэн тэр Буддад ийм сахил-ухамсар байх уу, тэр Буддад, ийм сайн чанар байх уу, тэр Буддад, ийм саруул-ухаан байх уу, тэр Буддад, ийм бясалгал амьдрал байх уу, тэр Будда, ийм гэгээрэл ангижралд орох болов уу гэх мэтээр?”

“Үгүй ээ. Эрхэм Багш аа.”

“Тэгвэл Эрхэм Саарипутта та, өнөө цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Буддаг ухан ойлгож, энэ Буддагийн оюун санааг өөрийн оюун санаагаараа шууд таньж мэдэж байгаа юм уу? Түүнчлэн энэ Буддад ийм сахил-ухамсар байна уу, энэ Буддад, ийм сайн чанар байна уу, энэ Буддад, ийм саруул-ухаан байна уу, энэ Буддад, ийм бясалгал амьдрал байна уу, энэ Будда, ийм гэгээрэл ангижралд орсон байна уу гэх мэтээр?”

“Үгүй ээ. Эрхэм Багш аа.”

"Тэгэхээр Эрхэм Саарипутта та, өнгөрсөн цагт ч, ирээдүйд ч, одоо цаг дор ч, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нарыг бүрэн ухаж ойлгоогүй. Буддагийн оюун санааг өөрийн оюун санаагаараа шууд таньж мэдээгүй. Тэгсэн хэрнээ та энэхүү агуу бөгөөд сүр жавхлантай үгийг хэллээ. Тов тодорхой, сайтар ойлгогдох, агуу тунхаглалыг ийн тунхаглав: 'Би: "Төгс Гэгээрлийн тал дээр Буддагаас илүү ихийг мэдсэн, илүү ихийг ухаарсан өөр хэн нэгэн даянч эсвэл брямaн, өнгөрсөн үед ч байгаагүй, ирээдүйд ч байхгүй, өнөө цагт ч байхгүй." хэмээн, би Буддад ийм л итгэл дүүрэн явдаг билээ.' гэж яахан хэлж зүрхэлж байгаа билээ?" гэхэд,

"Эрхэм Багш аа, би эдгээр өнгөрсөн, ирээдүй, одоо цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нарын оюун санааг яг өөрийнхөө оюун санаагаараа бүрэн дүүрэн бөгөөд тов тодорхой, шууд таньж мэдээгүй ч гэсэн, миний хэлсэн зүйлүүд Сургаал номтой бол нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ.

Эрхэм Багш аа, хилийн зааг дээр байрлах, үндэс суурь сайтай, үлэмж сайн хамгаалагдсан хана хэрэмтэй, өргөгддөг дүүжин гарцтай, үүд болох ганц хаалгатай, харийн хүмүүсээс хамгаалдаг, өөрийн хүмүүсээ таньдаг, чадварлаг ухаалаг харуул хамгаалалттай, эзэн хаант улсын, тийм хот цайз байсан саная. Тэр цайзын харуул нь хотын цайз ханыг нэг бүрчлэн, бүхэлд нь тойрон яваад, муур ч орох зайгүй, ан цавгүй, ангархай нүх үгүйг хараад:

'Ямар ч балмад адгуус энэ хот руу орлоо гарлаа гэхэд, гарцаагүй энэ ганц том үүдээр л орж гарах болно.' хэмээн бодохтой адил билээ.

Яг л үүний нэгэн адилаар, Эрхэм Багш аа, 'Өнгөрсөн цаг үеийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар таван-саадыг даваад, саруул-ухааныг доройтуулдаг оюуны-хорлолыг үгүй хийгээд, дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг дадуулаад, цаашилбал гэгээрлийг-амирлуулагч долоон хүчин зүйлийг хангасны үндсэн дээр төгс гэгээрлийг олсон.' гэдэг Сургаал номтой нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ.

Яг л үүний нэгэн адил Эрхэм Багш аа, 'Ирээдүй цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар таван-саадыг даваад, саруул-ухааныг доройтуулдаг оюуны-хорлолыг үгүй хийгээд, дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг дадуулаад, цаашилбал гэгээрлийг-амирлуулагч долоон хүчин зүйлийг хангасны үндсэн дээр төгс гэгээрлийг олох болно.' гэдэг Сургаал номтойгоо мөн нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ.

Яг л үүний нэгэн адил Эрхэм Багш аа, 'Өнөө цагийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда таван-саадыг даваад, саруул-ухааныг доройтуулдаг оюуны-хорлолыг үгүй хийгээд, дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг дадуулаад, цаашилбал гэгээрлийг-амирлуулагч долоон хүчин зүйлийг хангасны үндсэн дээр төгс гэгээрлийг олсон.' гэдэг Сургаал номтой нийцэж байгаа гэдгийг би ухаарч ойлгож байгаа билээ." хэмээн хэлэв.

"Эрхэм Багш аа, нэгэн удаа би, Будда дээр, Сургаал сонсохоор явж очсон юм.

Тэрээр Сургаалыг улам илүү өндөр түвшинд, улам илүү сайн шатанд, хар бараан хийгээд гэрэл гэгээтэй талуудтай нь, гэх зэргээр надад зааж сургасан билээ. Түүнийг номоо айлдаж байх үед, би тэр Сургаал дотор, шууд-билгүүнээр, надаа зааж байсан сургаалуудын тал дээр ийм эцсийн дүгнэлтэд очсон юм. Би Багшдаа: 'Энэ Ерөөлтэй Нэгэн бол Төгс Сэрсэн Будда ажээ. Түүний Сургаал бол маш сайн тайлбарлагдсан ажээ. Хуврагийн Чуулган бол маш зөвөөр бясалган дасгалыг хийдэг ажээ.' гэсэн итгэл-үнэмшлийг олсон билээ.[528]

1.1. Тустай-Сайн Чанарыг Сургахуй (Kusaladhammadesanā)

Цаашилбал, Эрхэм Багш аа, Будда тустай-сайн чанаруудыг хэрхэн зааж сургадаг нь, юутай ч зүйрлэшгүй юм. Эдгээр нь болбоос: Дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгал, Дөрвөн зөв чармайлт, Дөрвөн ид-чадал, Таван чадвар, Таван хүч, Долоон гэгээрлийг-амирлуулагч, Гэгээнтний найман замналаас бүрдэх юм.

Энэ бүгдээр хувраг хүн, оюуны-хорлол үгүй болж, оюуны-хорлол үгүй сэтгэлийн ангижрал, саруул-ухааны ангижралаар энэ насандаа амжин өөрийн шууд-билгүүнээр гэгээрлийг олж, үүгээрээ оршин амьдрах болно.

Дээдийн дээд, тустай-сайн зүйлийн тал дээр гэвэл, үүнээс илүү гарах зүйл гэж үгүй билээ.

Будда үүнийг бүрэн ойлгож ухаарсан бөгөөд үүнээс цааш нэвтрэн ухаарах зүйл гэж үгүй юм.

Дээдийн дээд, тустай-сайн зүйлийн тал дээр гэвэл, Буддагийн шууд-билгүүнээс илүү гарах, эсвэл түүний Гэгээрлээс илүү давж гарах өөр даянч, эсвэл бярман гэж үгүй билээ.

1.2. Мэдрэхүйн-Хүрээг Тайлбарлахуй (Āyatanapaṇṇattidesanā)

Цаашилбал, Эрхэм Багш аа. Будда, мэдрэхүйн-хүрээний талаар хэрхэн тайлбарлаж заадаг нь юутай ч зүйрлэшгүй билээ. Үүнд гадаад зургаан мэдрэхүйн-хүрээ, дотоод зургаан мэдрэхүйн-хүрээ орно.

Эдгээр нь болбоос: нүд хийгээд бие-дүрс, чих хийгээд чимээ, хамар хийгээд үнэр, хэл хийгээд амт, бие хийгээд хүрэлцэл, оюун-ухаан хийгээд Төсөөлөл юм.

Мэдрэхүйн-хүрээг тайлбарласан сургаалын хувьд гэвэл үүнээс илүү гарсан Сургаал гэж үгүй билээ.

Будда үүнийг төгс бүрэн ойлгож ухаарсан бөгөөд үүнээс хальж, давж ухаарах зүйл гэж үгүй юм. Мэдрэхүйн-хүрээг тайлбарлан заах тал дээр, Буддагийн шууд-билгүүнээс илүү гарах өөр даянч, эсвэл бярман байхгүй билээ.

---

[528] Энд Саарипутта хэрхэн Гэгээрлийг олсон тухайгаа ярьж байгаа болж таарах юм. шууд-билгүүн (*abhiññā*) гэдэг нь зөвхөн Гэгээрлийн мөчид тохиох зүйл юм. Арван сэтгэлийн-хүлээсийн нэг, эргэлзээ-тээнэгэлзээ энд устсан тухай ярьж байна.

1.3. Ураг Бүрэлдэхүйн Тухай (Gabbhāvakkantidesanā)

Цаашилбал, Эрхэм Багш аа. Будда, ураг бүрэлдэхүйн талаар хэрхэн тайлбарлаж заадаг нь юутай ч зүйрлэшгүй билээ. Үүнд дөрвөн ойлголт хамаарна.

Нэгдүгээрт, хүн эхийн хэвлийд, өөрийн мэдээгүй бүрэлдэн тогтож, тэнд өөрийн мэдээгүй бойжиж, энэ хорвоод өөрийн мэдээгүй мэндэлдэг. Энэ бол эхний ойлголт юм.

Цаашилбал, хүн эхийн хэвлийд, өөрийн мэдээтэй бүрэлдэн тогтож, харин тэнд өөрийн мэдээгүй бойжиж, энэ хорвоод өөрийн мэдээгүй мэндэлдэг. Энэ бол хоёр дахь ойлголт юм.

Цаашилбал, хүн эхийн хэвлийд, өөрийн мэдээтэй бүрэлдэн тогтож, тэнд өөрийн мэдээтэй бойжиж, харин энэ хорвоод өөрийн мэдээгүй мэндэлдэг. Энэ бол гурав дахь ойлголт юм.

Цаашилбал, хүн эхийн хэвлийд, өөрийн мэдээтэй бүрэлдэн тогтож, тэнд өөрийн мэдээтэй бойжиж, энэ хорвоод өөрийн мэдээтэй мэндэлдэг. Энэ бол дөрөв дэх ойлголт юм.

Ураг бүрэлдэхүйн талаарх энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.4. Илрүүлэн Мэдэхүйн Тухай (Ādesanavidhādesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, дөрвөн арга замаар бусдын бодлыг мэдэхүйг, Будда хэрхэн тайлбарлаж заадаг нь өөр бусадтай зүйрлэшгүй юм. Бодлыг мэдэх дөрвөн арга зам байдаг нь:

Нэгдүгээрт, үзэгдэх харагдах шинж байдлаар нь, 'Та ингэж бодож байна. Таны бодол тийм байна. Таны сэтгэл санааны байдал бол ийм байна.' гэж мэднэ. Хэдийгээр тэд, олон тохиолдлоор ийн илчлэх ч, тэд огт ташаарахгүйгээр, энэ нь дандаа үнэн болж таардаг. Энэ бол бодол илчлэх эхний арга зам юм.

Цаашилбал, үзэгдэх харагдах шинж байдлаар нь биш, харин хүнээс, хүн бусаас[529], эсвэл бурхдаас сонсож дуулаад, 'Та ингэж бодож байна. Таны бодол тийм байна. Таны сэтгэл санааны байдал бол ийм байна.' хэмээн мэднэ. Хэдийгээр тэд, олон тохиолдлоор ийн илчлэх ч, тэд огт ташаарахгүйгээр, энэ нь дандаа үнэн болж таардаг. Энэ бол бодол илчлэх хоёр дахь арга зам юм.

Цаашилбал, үзэгдэх харагдах шинж байдлаар нь ч биш, хүнээс, хүн бусаас, бурхдаас сонсож дуулах замаар ч биш, харин оюун санаагаа төвлөрүүлэн тухайн хүний бодох санах үед түүнээс цацрах бодлын чимээг мэдрэн, 'Та ингэж бодож байна. Таны бодол тийм байна. Таны сэтгэл санааны байдал бол ийм байна.' хэмээн мэднэ. Хэдийгээр тэд, олон тохиолдлоор ийн илчлэх ч, тэд огт ташаарахгүйгээр, энэ нь дандаа үнэн болж таардаг. Энэ бол бодол илчлэх гурав дахь арга зам юм.

Цаашилбал, үзэгдэх харагдах шинж байдлаар нь ч биш, хүнээс, хүн бусаас, бурхдаас сонсож дуулах замаар ч биш, оюун санаагаа төвлөрүүлэн тухайн хүний бодох санах үед түүнээс цацрах бодлын чимээг

[529] *Amanussānaṁ*—"хүн бусаас". Энд лус савдгийг хэлсэн гэж зарим эхэд тайлбарласан байна (MPA).

мэдрэх замаар ч биш, харин зурвас-бодол, эргэцүүлсэн-бодлоос салсан тогтвортой самади-төвлөрөлд орон оршсоноор[530], бусдын бодлыг танин мэднэ. Тэд, 'Энэ хүний санаа зориг нь яг одоо ийшээ чиглэж байгаагаас үзвэл, энэхүү бодол нь удахгүй тийш хөтлөх болно.' хэмээн ойлгож мэддэг. Хэдийгээр тэд, олон тохиолдлоор ийн илчлэх ч, тэд огт ташаарахгүйгээр, энэ нь дандаа үнэн болж таардаг. Энэ бол бодол илчлэх дөрөв дэх арга зам юм.

Бусдын бодлыг мэдэх дөрвөн аргын энэ тайлбар нь, өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.5. Билгийн Мэлмийг Олохуйн Тухай (Dassanasamāpattidesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, мэлмийг олохуйг[531], Будда хэрхэн тайлбарлаж заадаг нь, өөр бусадтай зүйрлэшгүй юм. Мэлмийг олох дөрвөн түвшин байдаг.

Эхнийх нь, зарим даянч эсвэл бярман нар, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, оюуны зөв тусгал зэргээр самади-төвлөрөлд[532] ордог. Ийн төвлөрөлд орсон, оюун санаа нь нэгдмэл болсон үедээ, бүхэлдээ арьсаар хучигдсан, элдэв төрлийн бохироос бүрдсэн өөрийн биеийг хөлийн улнаас дээш толгойн үсний үзүүр хүртэл шинжин хараад:

'Энэ бие дотор: толгойн үс, биеийн үс, хумс, шүд, арьс, мах, шөрмөс, яс, чөмөг, бөөр, зүрх, элэг, гялтан, дэлүү, уушги, гэдэс, сэмж, шингээгүй хоол, ялгадас, цөс, цэр, идээ, цус, хөлс, өөх, нулимс, тос, шүлс, нус, үений шингэн, шээс зэрэг байна.' гэж эргэцүүлнэ.

Энэ бол мэлмийг олох эхний түвшин юм.

Цаашилбал, зарим даянч эсвэл бярман нар, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, оюуны зөв тусгал зэргээр самади-төвлөрөлд ордог. Ийн төвлөрөлд орсон, оюун санаа нь нэгдмэл болсон үедээ, бүхэлдээ арьсаар хучигдсан, элдэв төрлийн бохироос бүрдсэн өөрийн биеийг хөлийн улнаас дээш толгойн үсний үзүүр хүртэл шинжин хараад:

'Энэ бие дотор: толгойн үс, биеийн үс, хумс, шүд, арьс, мах, шөрмөс, яс, чөмөг, бөөр, зүрх, элэг, гялтан, дэлүү, уушги, гэдэс, сэмж, шингээгүй хоол, ялгадас, цөс, цэр, идээ, цус, хөлс, өөх, нулимс, тос, шүлс, нус, үений шингэн, шээс зэрэг байна.' гэж эргэцүүлнэ.

Тэд энэ шатанд хүрээд, түүнээс цаашлан өгсдөг. Тэд, хүний ясыг арьс, мах, цусаар хучигдсан байгаагаар нь шинжин хардаг.

Энэ бол мэлмийг олох дараагийн түвшин юм.

---

530 Энд II Даянд орохыг тайлбарласан болно (Орч).

531 *Dassanasamāpattīsu*—"мэлмийг олохуйг". Үгчилбэл, "харааг олохуй". MN-д гарах өөр шашны даянч нарын бясалгалтай тун ойролцоо бясалгалыг энд ярив (MN 136:9.1).

532 Мьянмар орчуулгад I Даянд ордог гэжээ (MPA).

Цаашилбал, зарим даянч эсвэл бярман нар, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, оюуны зөв тусгал зэргээр самади-төвлөрөлд ордог. Ийн төвлөрөлд орсон, оюун санаа нь нэгдмэл болсон үедээ, бүхэлдээ арьсаар хучигдсан, элдэв төрлийн бохироос бүрдсэн өөрийн биеийг хөлийн улнаас дээш толгойн үсний үзүүр хүртэл шинжин хараад:

‘Энэ бие дотор: толгойн үс, биеийн үс, хумс, шүд, арьс, мах, шөрмөс, яс, чөмөг, бөөр, зүрх, элэг, гялтан, дэлүү, уушги, гэдэс, сэмж, шингээгүй хоол, ялгадас, цөс, цэр, идээ, цус, хөлс, өөх, нулимс, тос, шүлс, нус, үений шингэн, шээс зэрэг байна.’ гэж эргэцүүлнэ.

Тэд энэ шатанд хүрээд, түүнээс цаашлан өгсдөг. Тэд, хүний ясыг арьс, мах, цусаар хучигдсан байгаагаар нь шинжин хардаг.

Тэд энэ шатанд хүрээд, түүнээс цаашлан өгсдөг. Тэд, хүний ясыг арьс, мах, цусаар хучигдсан байгаагаар нь шинжин харахгүйгээр цаашлан эргэцүүлэн бясалгаснаар, хүмүүний нэг мөчөөс нөгөө мөч рүү дамжин буй оюун-ухамсрын урсгалыг[533] тасралтгүй үргэлжлэхийг хардаг. Энэ хүний[534] оюун-ухамсрын урсгал нь энэ насанд хийгээд дараа төрөлд, аль алинд нь оршин байгааг нь харж ойлгодог.

Энэ бол мэлмийг олох гурав дахь түвшин юм.

Цаашилбал, зарим даянч эсвэл бярман нар, хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, оюуны зөв тусгал зэргээр самади-төвлөрөлд ордог. Ийн төвлөрөлд орсон, оюун санаа нь нэгдмэл болсон үедээ, бүхэлдээ арьсаар хучигдсан, элдэв төрлийн бохироос бүрдсэн өөрийн биеийг хөлийн улнаас дээш толгойн үсний үзүүр хүртэл шинжин хараад:

‘Энэ бие дотор: толгойн үс, биеийн үс, хумс, шүд, арьс, мах, шөрмөс, яс, чөмөг, бөөр, зүрх, элэг, гялтан, дэлүү, уушги, гэдэс, сэмж, шингээгүй хоол, ялгадас, цөс, цэр, идээ, цус, хөлс, өөх, нулимс, тос, шүлс, нус, үений шингэн, шээс зэрэг байна.’ гэж эргэцүүлнэ.

Тэд энэ шатанд хүрээд, түүнээс цаашлан өгсдөг. Тэд, хүний ясыг арьс, мах, цусаар хучигдсан байгаагаар нь шинжин хардаг.

Тэд энэ шатанд хүрээд, түүнээс цаашлан өгсдөг. Тэд, хүний ясыг арьс, мах, цусаар хучигдсан байгаагаар нь шинжин харахгүйгээр цаашлан эргэцүүлэн бясалгаснаар, хүмүүний нэг мөчөөс нөгөө мөч рүү дамжин буй оюун-ухамсрын урсгалыг тасралтгүй үргэлжлэхийг хардаг. Тэд, энэ хүний[535] оюун-ухамсрын урсгал нь энэ насанд хийгээд дараа төрөлд, аль алинд нь үгүй болсныг нь харж ойлгодог.

Энэ бол мэлмийг олох дөрөв дэх түвшин юм.

Мэлмийг олохуйн энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

---

533 *Viññāṇasotaṁ*—“оюун-ухамсрын урсгал” (*viññāṇa*—“оюун-ухамсар”; *sotaṁ*—“урсгал”).

534 Мьянмар орчуулгад “Хүслээс хараахан салаагүй энэ хүний…” гэжээ (MPA).

535 Мьянмар орчуулгад “Хүслээс салж, үйлийн үрийн хамааралгүй болсон энэ хүний…” гэжээ (MPA).

1.6. Хүмүүсийг Ангилсан Тухай (Puggalapaṇṇattidesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, Будда хүмүүсийг хэрхэн өөрөөр ангилсан тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй юм. Эдгээр долоон төрлийн хүмүүс үүнд хамаарна.

1. Аль алинаар нь Гэгээрсэн[536],
2. Саруул-ухаанаар Гэгээрсэн[537],
3. Биеэрээ ойлгож Гэгээрсэн[538],
4. Зөв Үзлийг Ологч[539],
5. Итгэл-Үнэмшлээр Гэгээрсэн[540],
6. Сургаалыг Дагагч[541],
7. Итгэл-Үнэмшлээр Дагагч[542] энэ долоо юм.

Хүмүүний төрөл янзын талаарх энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.7. Чармайлтын Тухай (Padhānadesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, хүчин чармайлтын тухай, Будда хэрхэн тайлбарлаж заадаг нь, өөр бусадтай зүйрлэшгүй юм.

Гэгээрлийг-амирлуулагч долоон хүчин зүйлс бол: дүүрэн-анхаарал, Үзэгдэл-шинжихүй, эрч хүч, хөөр-баяр, амар-амгалан, самади-төвлөрөл, төв-оршихуй билээ.

Хүчин чармайлтын тухай энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.8. Замналын Тухай (Paṭipadādesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, замналын талаар Будда хэрхэн тайлбарлаж заадаг нь, өөр бусадтай зүйрлэшгүй юм. Эдгээр нь:

1. Гэгээрэлд, удаж хүргэх зовуурьтай замнал,

---

536 *Ubhatobhāgavimutto.* Энэ бол *Arūpa Samāpatti* болон *Arahatta Phala* хоёр замаар Гэгээрсэн Арахант (MPA).

537 *Paññāvimutto.* Саруул-Ухаанаар буюу *Arahatta Phala* -аар Гэгээрсэн Арахант (MPA).

538 *Kāyasakkhi.* Урсгалд Орогчийн ухаарлаас *Arahatta Magga* хүртэл бясалгалаар Гэгээрч буй нэгэн (MPA).

539 *Diṭṭhippatto.* Урсгалд Орогчийн ухаарлаас *Arahatta Magga* хүртэл мэдлэгээр Гэгээрч буй нэгэн (MPA).

540 *Saddhāvimutto.* Урсгалд Орогчийн ухаарлаас *Arahatta Magga* хүртэл итгэл-үнэмшлээр Гэгээрч буй нэгэн (MPA).

541 *Dhammānusārī.* Сургаалын мэдлэг болон чармайлтаар Урсгалд Орогч болж буй нэгэн (MPA).

542 *Saddhānusārī.* Дөрвөн Үнэний мэдлэгт итгэх итгэл-үнэмшил болон чармайлтаар Урсгалд Орогч болж буй нэгэн (MPA).

2. Гэгээрэлд, удалгүй хүргэх зовуурьтай замнал,

3. Гэгээрэлд, удаж хүргэх таатай замнал,

4. Гэгээрэлд, удалгүй хүргэх таатай замнал юм.

Эдгээрийн дотроос Гэгээрэлд удаж хүргэх зовуурьтай замнал нь хүнд бэрх бөгөөд нэн уддаг тул, аль ч талаараа сул дорой замналд тооцогддог.

Гэгээрэлд удалгүй хүргэх, хүнд замнал нь зовуурьтай бэрх байдаг тул сул дорой замналд тооцогддог.

Гэгээрэлд удаж хүргэх таатай замнал нь нэн уддаг тул сул дорой замналд тооцогддог.

Харин Гэгээрэлд удалгүй хүргэх таатай замнал бол уддаггүй бөгөөд таатай тул, аль ч талаараа бүхнээс тэргүүн замналд тооцогддог билээ.

Дөрвөн янз замналын талаарх энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.9. Ярианы Төлөвшлийн Тухай (Bhassasamācārādidesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, хэл ярианы төлөвшлийн талаар, Будда хэрхэн тайлбарлаж заадаг нь өөр бусадтай зүйрлэшгүй юм.

Эдгээр нь: худал хэлэх, бусдыг хагалан бутаргах, гүтгэх, хэл үгээр ялж дийлэхийг хэл яриандаа хэрэглэхгүй байх явдал юм. Түүгээр ч зогсохгүй, зөвхөн онч мэргэн, үнэ цэнтэй, цагаа олсон үг яриаг хэрэглэх явдал билээ.

Хэл ярианы төлөвшлийн талаарх энэ Сургаал нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

Түүгээр ч зогсохгүй Эрхэм Багш аа, хүний зан байдлын талаар Будда хэрхэн сургадаг нь юутай ч зүйрлэшгүй юм. Энэ бол хүн үнэнч шударга байх тухай билээ. Тэд хууран мэхлэх, зусардан бялдуучлах, ёжлон ёгтлох, гутаан доромжлох үг яриаг ашигладаггүй бөгөөд хөрөнгөөр хөрөнгө өсгөх ашиг хонжоонд автахгүй. Тэд мэдрэхүйн үүд хаалгаа ямагт сахин хамгаалж, уйгагүй, мятаршгүй, эрч хүчтэй, сэргэг соргог, дүүрэн-анхааралтай бясалган оршино. Тэд, ой тогтоолттой, яруу илэрхийлэлтэй, зорилготой, тууштай, ухаантай оршино. Тэд мэдрэхүйн-таашаалд автахгүй бөгөөд анхаарал дүүрэн, оюун тунгалаг оршино.

Хүний зан байдлын талаарх энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.10. Ном Зааврыг Дагахуйн Тухай (Anusāsanavidhādesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, ном зааврыг дагах, хүмүүсийн өөр өөр түвшний талаар, Будда хэрхэн тайлбарлаж заасан нь өрөөл бусадтай зүйрлэшгүй юм.

Эдгээрт нь, ном зааврыг өөртөө тусгах дөрвөн түвшин ордог.

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн ном зааврыг ёсчлон дагаснаар, сэтгэлийн доод гурван хүлээсийг устгаж, муу төрөлд ерөөс дахин төрөхгүй бөгөөд Төгс Гэгээрэх зам нь нэгэнт шулуудсан Урсгалд Орогч болох болно.’

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн ном зааврыг ёсчлон дагаснаар, сэтгэлийн доод гурван хүлээсийг устгаад, дур-хүсэл, уур-хилэн, төөрөгдөл намжсанаар, Нэгэнтээ Эргэн Ирэгч болж, энэ хорвоод дахин нэг л удаа төрөл авах бөгөөд улмаар хамаг зовлон зүдүүрийг нэгэнт төгсгөл болгох болно.’

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн ном зааврыг ёсчлон дагаж, сэтгэлийн доод таван хүлээсийг устгаснаар, энэ дэлхийд эргэж төрөлгүйгээр, зөвхөн бурхдын төрөлд дахин төрж, тэндээс Эцсийн Нирваанд одох болно.’

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн ном зааврыг ёсчлон дагаж, оюуны-хорлолыг үгүй хийснээр, оюуны-хорлол үгүй сэтгэлийн ангижрал, саруул-ухааны ангижралыг олж, энэ насандаа шууд-билгүүнээр өөрийн бие дээр ухаарч, тэр зэрэгт хүрч амьдрах болно.’

Аливаа хүний ном зааврыг дагахуйн өөр түвшний талаарх энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.11. Хүмүүсийн Ангижралын Тухай (Parapuggalavimuttiñāṇadesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, хүмүүсийн ангижралын талаар Будда хэрхэн тайлбарлаж заасан нь өрөөл бусадтай зүйрлэшгүй юм.

Эдгээрт нь, хүмүүсийн ангижралын дөрвөн түвшин орно.

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн, доод гурван сэтгэлийн-хүлээсийг устгаснаар, Урсгалд Орогч нэгэн болж, муу төрөлд ерөөс дахин төрөхгүй бөгөөд төгс гэгээрэх зам нь нэгэнт шулуудах болно.’

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн, доод гурван сэтгэлийн-хүлээсийг устгаад, дур-хүсэл, уур-хилэн, төөрөгдөл намжсанаар, Нэгэнтээ Эргэн Ирэгч болж, энэ хорвоод дахин нэг л удаа төрөл авах бөгөөд улмаар хамаг зовлон зүдүүрийг нэгэнт төгсгөл болгох болно.’

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн, ном зааврыг ёсчлон дагаж, доод таван сэтгэлийн-хүлээсийг устгаснаар, энэ дэлхийд эргэж төрөлгүйгээр, зөвхөн бурхдын төрөлд дахин төрж, тэндээс Эцсийн Нирваанд одох болно.’

Будда, өөрийн оюун бодолдоо, оновчтой, үндэслэлтэйгээр ухан эргэцүүлээд, хэн нэг хүнийг ийн таньдаг:

‘Энэ хүн, ном зааврыг ёсчлон дагаж, бүх оюуны-хорлолыг үгүй хийснээр, оюуны-хорлол үгүй сэтгэлийн ангижрал, саруул-ухааны ангижралыг олж, энэ насандаа шууд-билгүүнээр өөрийн бие дээр ухаарч, тэр зэрэгт хүрч амьдрах болно.’

Хүмүүсийн ангижралын талаарх энэ тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.12. Мөнх Үзэл (Sassatavādadesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, мөнх үзлийн талаар Будда хэрхэн тайлбарлаж заасан нь өрөөл бусадтай зүйрлэшгүй юм.

Үүнд гурван янз мөнх үзлийн сургаал орно.

Нэгдүгээрт, зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санадаг.

Тэрбээр, урдах төрлөө, урьдын хоёр, гурав, дөрөв, эсвэл таван төрлөө, арав, хорь, гуч, дөч, эсвэл тавин төрлөө, зуу, мянга, эсвэл зуун мянган төрлөө, эсвэл бүр, хэдэн зуун мянган төрлөө, олон зуун мянган төрлөө эргэн санахдаа: ‘Тэр урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн билээ.’ гэх зэргээр эргэн санадаг. Ийм маягаар, тэрбээр, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санана.

Тэрээр:

‘Урьд цагт хорвоо ертөнц мөхсөн, сэхсэн гэдгийг би мэдэж байна. Ирээдүйд хорвоо ертөнц мөхөх, сэхэхийг би мэдэхгүй юм.

Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно.’ гэдэг.

Энэ бол эхний мөнх үзэл юм.

Хоёрдугаарт, зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санана.

Тэрбээр, нэгэн галавын мөхөл хийгээд сэхэл, эсвэл хоёр галавын, эсвэл гурван галавын, эсвэл дөрвөн галавын, эсвэл таван галавын, бүр эсвэл арван галавын, мөхөл сэхлийн эргэлтүүдийг, эргэн санахдаа:

‘Тэр урд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн билээ.’ гэх зэргээр эргэн санадаг. Ийм маягаар, тэрбээр, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь, эргэн санана.

Тэрээр:

‘Урьд цагт хорвоо ертөнц мөхсөн, сэхсэн гэдгийг би мэдэж байна. Ирээдүйд хорвоо ертөнц мөхөх, сэхэхийг би мэдэхгүй юм.

Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно.’ гэдэг.

Энэ бол хоёр дахь мөнх үзэл юм.

Гуравдугаарт, зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санана.

Тэрбээр, арван галавын мөхөл хийгээд сэхэл, эсвэл хорин галавын, эсвэл гучин галавын, бүр эсвэл дөчин галавын, мөхөл сэхлийн эргэлтүүдийг, эргэн санахдаа:

‘Тэр урд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би,

тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн билээ.' гэх зэргээр эргэн санадаг. Ийм маягаар, тэрбээр, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь, эргэн санана.

Тэрээр:

'Урьд цагт хорвоо ертөнц мөхсөн, сэхсэн гэдгийг би мэдэж байна. Ирээдүйд хорвоо ертөнц мөхөх, сэхэхийг би мэдэхгүй юм.

Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнц бол нүцгэн тал мэт, уулын оргил мэт, лужир багана мэт бат бөх, мөнхөд оршино. Тэдгээр бодгалиуд хэрэн хэсэж, үхэх-төрөхийн эргэлтээр тэнүүчлэн, нас барсаар, дахин төрсөөр, тэгсэн хэдий ч, мөнхөд оршсоор байх болно.' гэдэг.

Энэ бол гурав дахь мөнх үзэл юм.

Энэхүү мөнх үзлийн талаарх тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.13. Урьд Төрлүүдийг Санахуй (Pubbenivāsānussatiñāṇadesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, урьд төрлүүдийг эргэн санахуйн тал дээр, Будда хэрхэн тайлбарлаж заасан нь, өрөөл бусадтай зүйрлэшгүй юм.

Энэ нь болбоос, зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, ухааны зөв тусгал зэргээр төвлөрөл бясалгалын өндөр түвшинд хүрч, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь эргэн санадаг.

Тэрбээр, урдах төрлөө, урьдын хоёр, гурав, дөрөв, эсвэл таван төрлөө, арав, хорь, гуч, дөч, эсвэл тавин төрлөө, зуу, мянга, эсвэл зуун мянган төрлөө, эсвэл бүр, хэдэн зуун мянган төрлөө, олон зуун мянган төрлөө эргэн санахдаа:

'Тэр урьд төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, өөр төрөлд дахин төрсөн. Тэр төрөлдөө би, тийм нэр устай байсан. Би тийм гэр бүлд төрсөн байсан. Би тийм дүр төрхтэй байсан. Би тийм хоол унд иддэг байсан. Би тэгж жаргадаг байсан. Би тэгж зовдог байсан. Би тийм насыг насалсан. Тэгээд би, тэр төрлөө орхиж үхсэн. Ингээд би, энд дахин төрсөн билээ.' гэх зэргээр эргэн санадаг. Ийм маягаар, тэрбээр, олон тооны урьд төрлөө онцлог шинж чанар, холбогдох зүйлсийн хамтаар нь, эргэн санана.

Эрхэм Багш аа, амьдрах хугацааг нь тоолж барамгүй тийм бурхад байдаг. Гэсэн хэдий ч, тэд, бие-дүрст, эсвэл бие-бус, танихуй-бүхий, эсвэл танихуй-үгүй, эсвэл танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус гэх мэт, өмнө нь ямар ч төрөлд төрсөн бай, тэд урд төрлүүдээ олон янзын онцлог шинж, нарийн ширийн зүйлстэй нь эргэн санадаг.

Энэхүү урьд төрлүүдийг эргэн санахуйн тал дээрх тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.14. Үхэхүй Хийгээд Төрөл Авахуй (Cutūpapātañāṇadesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, үхэхүй хийгээд төрөл авахуйн тухайд, Будда хэрхэн тайлбарлаж заасан нь өрөөл бусадтай зүйрлэшгүй юм.

Зарим даянч хийгээд бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлтээр бясалган, самади-төвлөрөлд орон, цэвэршиж ариуссан, эгэл хүмүүний боломжоос хальсан тэнгэрлэг мэлмийгээр, өчүүхэн эсвэл агуу, үзэсгэлэнтэй эсвэл үзээрийн, хувьтай эсвэл хувьгүй, энэ хорвоогийн бүх л бодгалийн сайхан газарт, эсвэл муухай газарт, хийсэн үйлийнхээ дагуу үхэж буйг нь, мөн дараа төрөл авч буйг нь хараад, тэд ийн ойлгоно:

'Хөөрхий тэдгээр бодгалиуд, биеэрээ буруу үйлд автсан, яриагаараа буруу үйлд автсан, сэтгэлээрээ буруу үйлд автсан байжээ. Тэд, Гэгээнтнүүдийг хэл яриагаар доромжилдог, буруу үзэлд автсан, тэр автсан буруу үзлээрээ тэдгээр муу үйлийг хийсэн байжээ. Үхсэний дараа, бие цогцос нь задрахын цагт, муу ёрын төрөлд, зовлонт төрөлд, доод төрөлд, тамд, тэд дараагийн төрлөө авчээ.

Харин эдгээр бодгалиуд, биеэрээ сайныг үйлддэг, хэл яриагаараа сайныг үйлддэг, сэтгэлээрээ сайныг үйлддэг байжээ. Тэд, Гэгээнтнүүдийг хэзээ ч хэл яриагаар доромжилдоггүй, зөв үзэлд автсан, тэр автсан зөв үзлээрээ тэдгээр сайн үйлийг хийсэн байжээ. Үхлийн дараа, бие цогцос нь задрахын цагт, сайн төрөлд, тэнгэрлэг оронд, тэд дараагийн төрлөө авчээ.'

Ийнхүү тэд цэвэршиж ариуссан, эгэл хүмүүний боломжоос хальсан тэнгэрлэг мэлмийгээр, өчүүхэн эсвэл агуу, үзэсгэлэнтэй эсвэл үзээрийн, хувьтай эсвэл хувьгүй, энэ хорвоогийн бүх л бодгалийн сайхан газарт, эсвэл муухай газарт, хийсэн үйлийнхээ дагуу үхэж буйг нь, мөн дараа төрөл авч буйг нь ойлгодог.

Үхэхүй хийгээд төрөл авахуйн тухай энэхүү тайлбар нь өөр бусадтай зүйрлэшгүй билээ.

1.15. Ид-Чадлын Тухай (Iddhividhadesanā)

Түүнчлэн Эрхэм Багш аа, ид-чадлын тухай, Будда хэрхэн тайлбарлаж заасан нь өрөөл бусадтай зүйрлэшгүй юм.

Үүнд хоёр төрлийн ид-чадал хамаарна.

Оюуны-хорлол болон дон-шуналыг араасаа дагуулдаг ид-чадал гэж байдаг бөгөөд үүнийг 'Гэгээнтний бус'[543] гэж үздэг.

---

543 '*No ariyā*'—'Гэгээнтний бус'. Өөрөөр, "Гэгээнтэн хүнийх биш", "Гэгээрээгүй хүний".

Оюуны-хорлол болон дон-шуналаас хол хөндий ид-чадал гэж байдаг бөгөөд үүнийг ‘Тэгээнтний’[544] гэж үздэг.

Оюуны-хорлол болон дон-шуналыг араасаа дагуулдаг, ‘Тэгээнтний бус’ ид-чадал гэж юуг хэлэх бол?

Зарим даянч эсвэл бярман нар хүчин чармайлт, хичээл зүтгэл, чин эрмэлзэл, уйгагүй мэрийлт, зөв төвлөрөл зэргээр бясалгалын өндөр түвшинд хүрч, олон янз оюун билгийн хүч чадлыг эзэмшиж, өөрийгөө дүрд хувилгах, эсвэл эргэн нэг биедээ хувилах, ил гарч ирэх эсвэл далд орон замхрах, цайз хэрэм, хашаа бэхлэлт, уул хад дундуур огторгуйгаар дүүлэн нисэх мэт нэвт саадгүй явах, ус руу шумбах мэт газар руу орох, эргэж гарч ирэх, газар дээгүүр явах адил усан дээгүүр явах, жигүүртэн шувуу адил тэнгэрт завилан нисэх, нар саранд гараараа хүрэх, цохих асар их хүч чадлыг олох, бие махбодоо Бярман Тэнгэрийн Орон хүрэхээр алс холд удирдах зэрэг өндөр түвшний шидийг олдог.

Эдгээр нь, ‘Тэгээнтний бус’ гэж тооцдог, оюуны-хорлол болон дон-шуналыг араасаа дагуулдаг ид-чадал юм.

Тэгвэл ‘Тэгээнтний’ гэж үздэг, оюуны-хорлол болон дон-шуналаас хол хөндий ид-чадал гэж юу бол?

Хэрэв хувраг хүн, ‘Бохир бусыг, бохир[545] хэмээн бясалгая.’ гэж хүсвэл, тэд бохир бусыг бохир гэж бясалган орших болно.

Хэрэв тэд, ‘Бохирыг, бохир бус хэмээн бясалгая.’ гэж хүсвэл, тэд бохирыг бохир бус гэж бясалган орших болно.

Хэрэв тэд, ‘Бохир болон бохир бусыг, бохир бус хэмээн бясалгая.’ гэж хүсвэл, тэд бохир болон бохир бусыг, бохир бус гэж бясалган орших болно.

Хэрэв тэд, ‘Бохир болон бохир бусыг, бохир хэмээн бясалгая.’ гэж хүсвэл, тэд бохир болон бохир бусыг, бохир гэж бясалган орших болно.

Хэрэв тэд, ‘Төв-оршихуйтай, дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтай бясалгая.’ гэж хүсвэл тэд, бохир ч бай, бохир бус бай, эдгээрийг эс ойшоон, төв-оршихуйтай, дүүрэн-анхааралтай, тунгалаг-оюунтай бясалган орших болно.

Эдгээр нь ‘Тэгээнтний’ гэж тооцдог, оюуны-хорлол болон дон-шуналаас хол хөндий ид-чадал юм.

Энэхүү ид-чадлын тал дээр Буддаг өөр бусадтай зүйрлэшгүй юм.

Ид-чадлын тухай үүнээс цаашлан ойлгох сургаалтай, Буддагийн шууд-билгүүнээс давж гарах ухааралтай өөр даянч эсвэл бярман гэж үгүй юм.

---

544 *‘Ariyā’*—‘Тэгээнтний’. Өөрөөр, “Тэгээнтэн хүний”, “Тэгээрсэн хүмүүний”.

545 *Paṭikūla*—“бохир”. Энэ бол DN 22.1.4-т гарах “бохир” юм.

1.16. Багшийн Хосгүй Чанарыг Харахуй (Aññathāsatthuguṇadassana)

Итгэл үнэмшилтэй, эрхэм шударга хүмүүн л, эрч хүчтэй, хичээнгүй тууштай, эрэлхэг чадалтай, идэвх чармайлттай, чин зүтгэлтэй байдлаар л хүрдэг зүйлд Будда хүрсэн билээ.

Ядмаг доорой, болхи бүдүүлэг, нийтлэг түгээмэл, ариун бус, ашиг тусгүй мэдрэхүйн-таашаалд, Будда автаж донтоогүй. Мөн Будда, зовлон шаналалтай, ариун бус, ашиг тусгүй өөрийгөө зовоох арга[546] замналд автаж донтоогүй.

Тэрээр, хүссэн үедээ, хүндрэл бэрхшээлгүйгээр, тэнгэрлэг оронд хамаарах, энэ насанд хөөр-баяр, аз-жаргалыг авчрах дөрвөн даяаныг оршоосон билээ.

1.17. Асуултад Хариулахуй (Anuyogadānappakāra)

Эрхэм Багш аа, хэрэв тэд надаас,

‘Хүндэт Саарипутта, өнгөрсөн цаг үед, Гэгээрэл ухаарлын тал дээр Буддагаас илүү гарсан даянч эсвэл бярман байсан уу?’ гэж асуувал, би тэдэнд,

‘Үгүй ээ, байгаагүй.’ гэж хариулна.

Эрхэм Багш аа, хэрэв тэд надаас,

‘Хүндэт Саарипутта, ирээдүй цаг үед, Гэгээрэл ухаарлын тал дээр Буддагаас илүү гарах даянч эсвэл бярман байх болов уу?’ гэж асуувал би тэдэнд,

‘Үгүй ээ, байхгүй.’ гэж хариулна.

Эрхэм Багш аа, хэрэв тэд надаас,

‘Хүндэт Саарипутта, өнөө цаг үед, Гэгээрэл ухаарлын тал дээр Буддагаас илүү гарахаар даянч эсвэл бярман байгаа болов уу?’ гэж асуувал би тэдэнд,

‘Үгүй ээ, байхгүй.’ гэж хариулна.

Эрхэм Багш аа, хэрэв тэд надаас,

‘Хүндэт Саарипутта, өнгөрсөн цаг үед, Гэгээрэл ухаарлын тал дээр Буддатай эн тэнцэхүйц даянч эсвэл бярман байсан уу?’ гэж асуувал би тэдэнд,

‘Тиймээ, байсан.’ гэж хариулах болно.

Эрхэм Багш аа, хэрэв тэд надаас,

---

546 *Attakilamatha*—“өөрийгөө зовоох арга”. Тухайн цаг үед Энэтхэгт байсан гэгээрэл ариуслын төлөө өөрийгөө зовоох сургаал номлол, дасгал. Готама Будда Төгс Гэгээрэлд хүрэхээсээ өмнөх цаг үедээ энэ аргыг замнаж үзсэн байдаг.

‘Хүндэт Саарипутта, ирээдүй цаг үед, Гэгээрэл ухаарлын тал дээр Буддатай эн тэнцэхүйц даянч эсвэл бярман байх болов уу?’ гэж асуувал би тэдэнд,

‘Тийм ээ, байх болно.’ гэж хариулна.

Эрхэм Багш аа, хэрэв тэд надаас,

‘Хүндэт Саарипутта, өнөө цаг үед, Гэгээрэл ухаарлын тал дээр Буддатай эн тэнцэхүйц даянч эсвэл бярман байгаа болов уу?’ гэж асуувал би тэдэнд,

‘Үгүй ээ, байхгүй.’ гэж хариулах болно.

Эрхэм Багш аа, хэрэв тэд надаас,

‘Хүндэт Саарипутта, та яагаад бусдыг нь биш, нэгийг нь ингэж их үнэлж үзэж байгаа юм бэ?’ гэж асуувал би,

‘Эрхмүүд ээ, би Буддагаас өөрөөс нь,

‘Өнгөрсөн цаг үеийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар Гэгээрэл ухаарлын хувьд бүгд надтай адил эн тэнцэхүйц байсан.’ гэж хэлэхийг нь сонсож мэдсэн билээ. Мөн би Буддагаас өөрөөс нь,

‘Ирээдүй цаг үеийн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда нар, Гэгээрэл ухаарлын хувьд бүгд надтай адил эн тэнцэхүйц байх болно.’ гэж хэлэхийг нь сонсож мэдсэн билээ. Мөн би Буддагаас өөрөөс нь,

‘Нэгэн гариг эрхсийн тогтолцоонд, нэгэн зэрэг хоёр Будда төрөх боломжгүй байдаг.’ гэж хэлэхийг нь сонсож мэдсэн билээ.’ гэж хэлэх болно.

Ингэж хариулснаараа би, Буддагийн хэлсэн үгийг тэр хэвээр нь дамжуулан хэлээд, худал ташаа зүйлээр төөрөгдүүлээгүй болж таарах болов уу? Миний эдгээр тайлбар нь, Сургаалаас гажихгүй нийцэж, няцаагдах эсвэл шүүмжлэгдэх зүй ёсны үндэслэл болохгүй гэдэгт би найдаж болох уу?” хэмээн Эрхэм Саарипутта асуулаа.

“Үнэхээр тийм. Эрхэм Саарипутта, ингэж хариулснаараа та, миний хэлсэн үгийг тэр хэвээр нь дамжуулан хэлээд, худал ташаа зүйлээр төөрөгдүүлээгүй болно. Таны эдгээр тайлбар бол Сургаалаас гажихгүй нийцэж, няцаагдах эсвэл шүүмжлэгдэх зүй ёсны үндэслэл болохгүй гэдэгт та итгэж болно.” хэмээн Будда хариулав.

2. Хосгүй Гайхамшигтай (Acchariyaabbhuta)

Түүнийг ийн ярьсны дараа, Эрхэм Удааеий[547] Буддад хандан,

---

[547] *Udāyī*—“Удааеий”. Удааеий нэртэй цөөнгүй хувраг байдгийн чухам яг хэн нь энд гарч байгаа нь тодорхойгүй байна.

“Гайхамшигтай! Эрхэм Багш аа, Будда хүсэл шунал гэх зүйл үгүй, ийн сэтгэл хангалуун орших нь үнэхээр гайхалтай!

Хэдий тэр Төгс Гэгээрсэн, тийм суу ухаантай, тийм агуу хүчтэй ч, ийм даруу, ийм төлөв ажгуу. Хэрэв бусад шашин үзлийг дагагч бадарчин даянчид, эдгээр хосгүй чанаруудын нэгийг нь ч атугай өөрсдөөсөө олж харвал, хоолой мэдэн зарлаж, хот тосгоноор яван, туг дарцаг намируулах байх.

Гайхамшигтай! Эрхэм Багш аа, Будда хүсэл шунал гэх зүйл үгүй, ийн сэтгэл хангалуун орших нь үнэхээр гайхалтай! Хэдий тэр Төгс Гэгээрсэн, тийм суу ухаантай, тийм агуу хүчтэй ч, ийм даруу, ийм төлөв ажгуу.” хэмээн хэлэв.

“Удааеий, Будда хүсэл шунал гэх зүйл үгүй, ийн сэтгэл хангалуун оршихыг нь харна уу! Хэдий тэр Төгс Гэгээрсэн, тийм суу ухаантай, тийм агуу хүчтэй ч, ийм даруу, ийм төлөв байгааг нь харна уу! Хэрэв бусад шашин үзлийг дагагч бадарчин даянчид, эдгээр хосгүй чанаруудын нэгийг нь ч атугай өөрсдөөсөө олж харвал, хоолой мэдэн зарлаж, хот тосгоноор яван, туг дарцаг намируулах байх.

Удааеий, Будда хүсэл шунал гэх зүйл үгүй, ийн сэтгэл хангалуун оршихыг нь харна уу! Хэдий тэр Төгс Гэгээрсэн, тийм суу ухаантай, тийм агуу хүчтэй ч, ийм даруу, ийм төлөв байгааг нь харна уу!”

Тэгэхэд, Будда Эрхэм Саарипуттад хандан:

“Тэгэхээр Эрхэм Саарипутта, та энэ Сургаалын тайлбарыг эрэгтэй эмэгтэй хуврагууд, шавь эрчүүд, шавь эмэгтэйчүүдэд үргэлж давтан ярьж өгч байвал зохилтой болов уу.

Буддад эс итгэдэг, эсвэл эргэлздэг, зарим ахицгүй хүмүүс байж болох хэдий ч, Сургаал номын энэхүү тайлбарыг сонсоод тэдгээр хүмүүс бээр эс итгэдэг, эсвэл эргэлздэг тэрхүү байдлаасаа салж болох юм.”

Ийнхүү Эрхэм Саарипутта, Буддад өөрт нь, өөрийн итгэл үнэмшлээ ийн зарлан тунхаглав.

Иймээс, энэхүү хүүрнэлийн нэр бол “Итгэл Төрүүлэх” билээ.

Итгэл Төрүүлэх Судар энд өндөрлөв.

ТААЛАМЖИТ СУДАР
DN 29. PĀSĀDIKASUTTA

БИ ИЙН СОНССОН ЮМ.

Нэгэн цагт Будда, Сакячуудын нутагт, Ведханньягийн манго төгөлд байрлах, газраас хөндий уужим өргөөнд[548] байрлаж байжээ.

Харин тэр үед, Нигантха Наатапутта[549] бээр Пааваа хотод дөнгөж нас барсан байлаа. Түүнийг өнгөрсний дараа Наатапуттагийн нүцгэн даянчид хоёр талцан маргалдаж, ном хаялцаж, мэтгэлцэн хэрэлдэж, бие биеэ:

‘Чи энэ ном дасгалыг ойлгодоггүй юм байна. Би энэ ном дасгалыг ойлгодог билээ.’

‘Чи энэ ном дасгалыг чухам яаж ойлгоод байна?’

‘Чиний дасгал, бясалгал бол буруу. Миний дасгал, бясалгал бол зөв.’

‘Би оройд нь гарч ойлгоод байна. Чи оройд нь гарч ойлгохгүй байна.’

‘Чи эцэст нь хэлэх ёстойгоо эхэнд нь хэлээд, эхэнд нь хэлэх ёстойгоо эцэст нь хэлээд байна.’

‘Чиний удаан бодож тунгаасан номлол төөрөлдсөн зүйл байна.’

‘Чиний номлол няцаагдлаа. Чи мэтгэлцээнд ялагдлаа. Чи эндээс яв одоо. Эсвэл чаддаг юм бол, яг одоо энд зангилааг нь гаргачих.’ гэх зэргээр хорон үгээр чичлэх аж.

Наатапуттагийн нүцгэн даянчид ёстой л, нэг нэгнээ алж хядаж байна уу даа гэж бодохоос өөр аргагүй байдалтай байлаа.

Сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй[550], Төгс Гэгээрээгүй нэгний номлосон, нурсан суваргатай[551], нөмөр нөөлөггүй тийм ном сургаалаас, хэний ч дээдлэл хүндлэл нь гутаж, ядарч залхахаар байсан төдийгүй, Наатапуттагийн нүцгэн даянч нартаа, Наатапуттагийн цагаан хувцаст, шавь хар хүмүүс нь хүртэл дургүй нь хүрч, ой нь гутав. Тэдэнд тэд огт үнэ хүндгүй болов.

---

548 *Pāsāda*—“газраас хөндий уужим өргөө” (эсвэл “урт байшин”). Шувуун хөл хийж, газраас хөндий барьдаг, тэгш өнцөгт хэлбэртэй, урт модон байшин. Халуун орны бүсэд ийм уламжлалт загварын сууц түгээмэл байж.

549 *Nigaṇṭha Nāṭaputta*—“Нигантха Наатапутта”. Үгчилбэл, “Наатикагийн хүү, нүцгэн даянч”. (DN 2.1 болон DN 2.3.5-г үз.)

550 Мьянмар эхэд энэ хэсгийг “...нарийвчлан заагаагүй, Гэгээрлийн Замналд эсвэл Гэгээрэлд хөтөлдөггүй, оюуны-хорлолыг арилгадаггүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлосон...” гэжээ (MPA).

551 *Bhinnathūpe*—“нурсан суваргатай”. Багш нь өөд болж, сүсэгтнүүдийг нэгтгэх зүйл үгүй болохыг ёжлон хэлсэн хэлц үг.

Энэ явдлын дараа, сурагч[552] Чунда, Пааваагийн ойролцоо, уламжлалт борооны улирлын бясалгалаа дуусгаад, Эрхэм Аанандатай уулзахаар Саама тосгонд очив. Тэрээр түүнд сөгдөж мөргөөд, нэг талд нь суугаад:

“Эрхэм Аананда, Нигантха Наатапутта бээр Паавaa хотод саяхан нас баржээ. Түүнийг өнгөрсний дараа Наатапуттагийн нүцгэн даянчид хоёр талцан маргалдаж, ном хаялцаж, мэтгэлцэн хэрэлдэж, бие биеэ:

‘Чи энэ ном дасгалыг ойлгодоггүй юм байна. Би энэ ном дасгалыг ойлгодог билээ.’, ‘Чи энэ ном дасгалыг чухам яаж ойлгоод байна?’, ‘Чиний дасгал, бясалгал бол буруу. Миний дасгал, бясалгал бол зөв.’, ‘Би оройд нь гарч ойлгоод байна. Чи оройд нь гарч ойлгохгүй байна.’, ‘Чи эцэст нь хэлэх ёстойгоо эхэнд нь хэлээд, эхэнд нь хэлэх ёстойгоо эцэст нь хэлээд байна.’, ‘Чиний удаан бодож тунгаасан номлол төөрөлдсөн зүйл байна.’, ‘Чиний номлол няцаагдлаа. Чи мэтгэлцээнд ялагдлаа. Чи эндээс яв одоо. Эсвэл чаддаг юм бол, яг одоо энд зангилааг нь гаргачих.’ гэх зэргээр хорон үгээр чичилж байна.

Наатапуттагийн нүцгэн даянчид ёстой л, нэг нэгнээ алж хядаж байна уу даа гэж бодохоос өөр аргагүй байдалтай байна. Сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлосон, нурсан суваргатай, нөмөр нөөлөггүй тийм ном сургаалаас, хэний ч дээдлэл хүндлэл нь гутаж, ядарч залхахаар байсан төдийгүй, Наатапуттагийн нүцгэн даянч нартаа, Наатапуттагийн цагаан хувцаст, шавь хар хүмүүс нь хүртэл дургүй нь хүрч, ой нь гутав. Тэдэнд тэд огт үнэ хүндгүй болсон байна.” хэмээн болсон явдлын тухай ярив.

Аананда түүнд хандан:

“Сурагч Чунда, бид энэ асуудлын хувьд Буддатай уулзах нь дээр болов уу. Алив, Буддад очиж энэ тухай хэлье.” гэхэд,

“Тэгье ээ, Эрхэм Багш аа.” гэж сурагч Чунда хариуллаа.

Тэгээд Аананда, Чунда хоёр Будда дээр очиж мөргөөд, нэг талд нь суугаад, Буддад сурагч Чундагийн ярьсан зүйлсийг хэллээ.

“Эрхэм Багш аа, Нигантха Наатапутта бээр Паавaa хотод саяхан нас баржээ. Түүнийг өнгөрсний дараа Наатапуттагийн нүцгэн даянчид хоёр талцан маргалдаж, ном хаялцаж, мэтгэлцэн хэрэлдэж, бие биеэ:

‘Чи энэ ном дасгалыг ойлгодоггүй юм байна. Би энэ ном дасгалыг ойлгодог билээ.’, ‘Чи энэ ном дасгалыг чухам яаж ойлгоод байна?’, ‘Чиний дасгал, бясалгал бол буруу. Миний дасгал, бясалгал бол зөв.’, ‘Би оройд нь гарч ойлгоод байна. Чи оройд нь гарч ойлгохгүй байна.’, ‘Чи эцэст нь хэлэх ёстойгоо эхэнд нь хэлээд, эхэнд нь хэлэх ёстойгоо эцэст нь хэлээд байна.’, ‘Чиний удаан бодож тунгаасан номлол төөрөлдсөн зүйл байна.’, ‘Чиний номлол няцаагдлаа. Чи мэтгэлцээнд ялагдлаа. Чи эндээс яв одоо. Эсвэл чаддаг юм бол, яг одоо энд зангилааг нь гаргачих.’ гэх зэргээр хорон үгээр чичилж байна.

[552] *Samaṇuddeso*—“сурагч”. Хувраг болохоор суралцаж буй 10 сахилтай шавь.

Наатапуттагийн нүцгэн даянчид ёстой л, нэг нэгнээ алж хядаж байна уу даа гэж бодохоос өөр аргагүй байдалтай байна. Сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлосон, нурсан суваргатай, нөмөр нөөлөггүй тийм ном сургаалаас, хэний ч дээдлэл хүндлэл нь гутаж, ядарч залхахаар байсан төдийгүй, Наатапуттагийн нүцгэн даянч нартаа, Наатапуттагийн цагаан хувцаст, шавь хар хүмүүс нь хүртэл дургүй нь хүрч, ой нь гутав. Тэдэнд тэд огт үнэ хүндгүй болсон байна."

1. Төгс Гэгээрээгүй Нэгний Сургаал (Asammāsambuddhappaveditadhammavinaya)

"Чунда, сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлосон сургаал номтой ийм зүйл тохиолдох нь байх үзэгдэл билээ.

Чунда, багш нь гэгээрээгүй, сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлолыг заадаг, тийм нэгэн тохиолдол байг гэж бодъё.

Тэр номлолын шавь, ном сургаалынхаа дагуу дасгалаа хийдэггүй, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэж, дасгалаа хийдэггүй, багшийнхаа номлосон зааснаар нь дасгалаа хийдэггүй байж. Ингээд тэр, тэр сургаал номлолоосоо холддог.

Тэдэнд,

'Найз минь, чи азтай юм. Чамд үнэхээр аз таарлаа! Учир юу гэвэл, чиний багш бол Төгс Гэгээрсэн Нэгэн биш. Тэдний сургаал ном нь сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлолыг заадаг сургаал. Тэгвэл чи, ном сургаалынхаа дагуу дасгалаа хийдэггүй, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэж дасгалаа хийдэггүй, багшийнхаа номлосон зааснаар нь дасгалаа хийдэггүй. Ингээд чи, тэр сургаал номлолоос холдож байна.' гэж хэлэх учиртай болов уу.

Ийм тохиолдолд, Чунда, миний түрүүн хэлсэнчлэн, тэр багш буруудах учиртай. Тэр сургаал буруудах учиртай. Харин тэр шавь сайшаагдах учиртай.

Тэр багш тэр шавьдаа[553],

'Алив, шавь минь, чи ном сургаалынхаа дагуу, багшийнхаа сургаж зааснаар дасгалаа хий.' гэж хэлдэг гэж бодъё. Ийм байдлаар, багш нь шавиа ухуулж ятгаж, шавь нь багшийнхаа ухуулга ятгалгад орж, ингэж

[553] Энэ харилцан яриа нь өөр эхэд, "хэн нэгэн" болон шавь хоёрын хооронд өрнөх яриа мэтээр дүрсэлсэн байх ба энд Мьянмар эхийг дагаж багш болон шавь хоёрын хооронд өрнөх яриа байдлаар нь оруулав.

багшийн ухуулга ятгалгад орсон шавь нь түүний заасан номлосноор нь замнадаг. Ийм багш, ийм шавь, хамтдаа их нүглийг хураадаг.

Яагаад тийм байх вэ?

Яагаад гэвэл, Чунда, тэр номлол сургаал бол сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний заадаг номлол сургаал болохоор тэр юм.

Чунда, багш нь Гэгээрээгүй, сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлолыг заадаг, тийм нэгэн тохиолдол байг гэж бодъё.

Тэр номлолын шавь, ном сургаалынхаа дагуу дасгалаа хийж, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэж дасгалаа хийж, багшийнхаа номлосон зааснаар нь дасгалаа хийдэг байж.

Тэдэнд,

‘Найз минь, чи азгүй юм. Чамд үнэхээр азгүйдэл тохиож! Учир юу гэвэл, чиний багш бол Төгс Гэгээрсэн Нэгэн биш. Тэрхүү сургаал ном бол сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний номлолыг заадаг сургаал. Гэхдээ чи, тэр ном сургаалын дагуу дасгал хийж, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэн энэ дасгалыг хийж, багшийнхаа номлосон зааснаар нь тэр дасгалыг хийдэг юм байна.’ гэж хэлэх учиртай болов уу.

Ийм тохиолдолд, Чунда, миний түрүүн хэлсэнчлэн, тэр багш буруудах учиртай. Тэр сургаал буруудах учиртай. Тэр шавь ч мөн буруудах учиртай.

Тэр багш тэр шавьдаа,

‘Шавь минь, чи зөв замналаар явж байна. Чи гэгээрэлд хүрэх нь дамжиггүй болсон.’ гэж хэлдэг гэж бодъё. Ийм байдлаар, багш нь шавиа сайшаан магтаж, шавь нь багшийнхаа сайшаал магтаалд орж, ингэж багшийн сайшаал магтаалд орсон тэр шавь нь асар их эрч хүч, хичээл зүтгэлээр замнадаг. Ийм багш, ийм шавь, хамтдаа их нүглийг хураадаг.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл, Чунда, тэр номлол сургаал бол сайтар тайлбарлаагүй, нарийвчлан заагаагүй, гэгээрлийн эрх чөлөөг авчрахгүй, амгаланг-олохуйд хүргэхгүй, Төгс Гэгээрээгүй нэгний заадаг номлол сургаал болохоор тэр юм.

2. Төгс Гэгээрсэн Нэгний Сургаал (Sammāsambuddhappaveditadhammavinaya)

Чунда, багш нь Төгс Сэрсэн Будда, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг[554], Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заадаг, тийм нэгэн тохиолдол байг гэж бодъё.

Тэр номлолын шавь, ном сургаалынхаа дагуу дасгалаа хийдэггүй, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэж, дасгалаа хийдэггүй, багшийнхаа номлосон зааснаар нь дасгалаа хийдэггүй байж. Ингээд тэд, тэр Сургаалаас холддог.

Түүнд,

‘Найз минь, чи азгүй юм. Чамд үнэхээр азгүйдэл тохиож! Учир юу гэвэл, чиний багш бол Төгс Сэрсэн Будда, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заадаг номлол. Гэхдээ чи, Сургаалынхаа дагуу дасгалаа хийдэггүй, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэдэггүй, багшийнхаа номлосон зааснаар нь хийдэггүй. Ингээд чи, тэр Сургаалаас холдож байна.’ гэж хэлэх учиртай болов уу.

Ийм тохиолдолд, Чунда, миний түрүүн хэлсэнчлэн, тэр багш сайшаагдах учиртай. Тэр Сургаал сайшаагдах учиртай. Харин шавь буруудах учиртай.

Түүнд,

‘Алив, шавь минь, чи Сургаалын дагуу, багшийнхаа сургасан зааснаар, дасгалаа хий.’ хэмээн хэллээ гэж бодъё. Ийм байдлаар, багш нь шавиа ухуулж ятгаж, шавь нь багшийнхаа ухуулга ятгалгад орж, ингэж багшийн ухуулга ятгалгад орсон шавь, заасан номлосноор нь замнадаг. Ийм багш, ийм шавь, хамтдаа их буяныг хураадаг.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл, Чунда, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заадаг болохоор тэр билээ.

Чунда, багш нь Төгс Сэрсэн Будда, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн номлолыг заадаг, тийм нэгэн тохиолдол байг гэж бодъё.

Тэгээд номлолын шавь, Сургаалын дагуу дасгалаа хийдэг, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэдэг, багшийнхаа номлосон зааснаар нь дасгалаа хийдэг байж.

---

[554] Мьянмар эхэд энэ хэсгийг “... нарийвчлан заасан, Гэгээрлийн Замналд эсвэл Гэгээрэлд хөтөлдөг, оюуны-хорлолыг үгүй хийдэг, Төгс Гэгээрсэн Нэгний...” гэжээ (MPA).

Түүнд,

‘Найз минь, чи азтай юм. Чамд үнэхээр аз таарлаа! Учир юу гэвэл, чиний багш бол Төгс Сэрсэн Будда, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заадаг. Тэгээд чи, Сургаалын дагуу дасгалаа хийдэг, чин сэтгэлээсээ итгэж сүсэглэдэг, багшийнхаа номлосон зааснаар нь дасгалаа хийдэг болохоор тэр билээ.’ гэж хэлэх учиртай болов уу.

Ийм тохиолдолд, Чунда, миний түрүүн хэлсэнчлэн, тэр багш сайшаагдах учиртай. Тэр Сургаал сайшаагдах учиртай. Мөн тэр шавь сайшаагдах учиртай.

Түүнд,

‘Шавь минь, чи үнэн зөв замналаар явж байна. Чи гэгээрэлд хүрэх нь дамжиггүй.’ гэж хэлдэг гэж бодъё. Ийм байдлаар, багш нь шавиа хөөргөж магтаж, шавь нь багшийнхаа сайшаал магтаалд орж, ингэж багшийн сайшаал магтаалд орсон шавь, асар их эрч хүч, хичээл зүтгэлээр замнадаг. Ийм багш, ийм шавь, хамтдаа их буяныг хураадаг.

Яагаад тэр билээ?

Яагаад гэвэл, Чунда, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заадаг болохоор тэр билээ.

3. Шавь Нар Шаналахуй (Sāvakānutappasatthu)

Чунда, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда энэ хорвоод төржээ. Түүний Сургаал нь, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заасан номлол байна.

Гэвч түүний шавь нар нь, үнэн-номын[555] учир зүйг тайлбарлуулаагүй байдаг. Ариуслын-замналыг бүрэн бүтнээр нь, гүйцэд тодорхой заалгаагүй байдаг. Номлолын олон төрлийн хэсгүүд болон Сургаалын дасгал бясалгал хоёрыг нэгтгэн нийлүүлж, эдгээрийг хослуулсан нэгдмэл цогц болгоогүй байдаг. Үхэх төрөхийн эргүүлгээс ангижрах тухай Сургаал болж хараахан томьёологдоогүй байдаг. Энэ нь бурхад хийгээд хүмүүний ертөнцөд хараахан сайн танигдаагүй байдаг.

Ийм багшийг өөд болоход шавь нар нь, түүний үхэлд харууссан сэтгэлдээ ихэд шаналдаг.

Яагаад тэр билээ?

Тэдгээр шавь нар ийн бодож болох юм:

---

[555] *Saddhamma*—“үнэн-ном”. Өөрөөр “сайны ном”. Будда чухам өөрөө зааж сургасан, элдэв хольц ороогүй, үнэн зөв, өгөөжтэй сайн тэр Сургаал.

‘Манай багш, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда байсан. Түүний Сургаал нь, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заасан номлол байсан. Гэвч бид, үнэн-номын учир зүйг тайлбарлуулаагүй байдаг. Ариуслын-замналыг бүрэн бүтнээр нь, гүйцэд тодорхой заалгаагүй байдаг. Номлолын олон төрлийн хэсгүүд болон Сургаалын дасгал бясалгал хоёрыг нэгтгэн нийлүүлж, эдгээрийг хослуулсан нэгдмэл цогц болгоогүй байдаг. Үхэх төрөхийн эргүүлгээс ангижрах тухай Сургаал болж хараахан томьёологдоогүй байдаг. Энэ нь бурхад хийгээд хүмүүний ертөнцөд хараахан сайн танигдаагүй. Ингээд одоо багш маань өөд болчихлоо.’

Чунда, ийм багшийг өөд болоход шавь нар нь түүний үхэлд харууссан шаналалд автдаг.

4. Шавь Нар Эс Шаналахуй (Sāvakānanutappasatthu)

Чунда, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда энэ хорвоод төржээ. Түүний Сургаал нь, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заасан номлол байна.

Түүний шавь нар нь, үнэн-номын учир зүйг тайлбарлуулсан байдаг. Ариуслын-замналыг бүрэн бүтнээр нь, гүйцэд тодорхой заалгасан байдаг. Номлолын олон төрлийн хэсгүүд болон Сургаалын дасгал бясалгал хоёрыг нэгтгэн нийлүүлж, эдгээрийг хослуулсан нэгдмэл цогц болгосон байдаг. Үхэх төрөхийн эргүүлгээс ангижрах тухай Сургаал болж томьёологдсон байдаг. Энэ нь бурхад хийгээд хүмүүний ертөнцөд сайн танигдсан байдаг.

Ийм багшийг өөд болоход шавь нар нь, түүний үхэлд харууссан шаналалд автдаггүй.

Яагаад тэр билээ?

Тэдгээр шавь нар ийн бодож болох юм:

‘Манай багш, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда байсан. Түүний Сургаал нь, сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн Сургаалыг заасан номлол байсан. Тэгээд бид, үнэн-номын учир зүйг тайлбарлуулсан билээ. Ариуслын-замналыг бүрэн бүтнээр нь, гүйцэд тодорхой заалгасан билээ. Номлолын олон төрлийн хэсгүүд болон Сургаалын дасгал бясалгал хоёрыг нэгтгэн нийлүүлж, эдгээрийг хослуулсан нэгдмэл цогц болгосон билээ. Үхэх төрөхийн эргүүлгээс ангижрах тухай Сургаал болж томьёологдсон билээ. Энэ нь бурхад хийгээд хүмүүний ертөнцөд сайн танигдсан билээ. Ингээд одоо багш маань өөд боллоо.’

Чунда, ийм багшийг өөд болоход шавь нар нь, түүний удирдамж заавар, тусламж дэмжлэг нь хэрэг болдог тэрхүү түвшинд хүрчихсэн болохоор, харуусал шаналлаас ангижирсан байдаг.

5. Төгс Бус Ариуслын-Замналын Сургаал (Brahmacariyaaparipūrādikathā)

Тэгвэл, Чунда, түрүүн дурдсан бүх л сайн чанаруудыг шингээсэн ариуслын-замнал байлаа гэж бодъё. Гэтэл багш нь, ахлах хувраг болоогүй, туршлага хуримтлуулаагүй, сахилтан замналд удаагүй, номдоо ахиагүй, өндөр насыг зооглоогүй аж.

Тэгвэл, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Гэтэл, Чунда, түрүүн дурдсан бүх л сайн чанаруудыг шингээсэн ариуслын-замнал байлаа гэж бодъё. Тэгээд багш нь, ахлах хувраг болсон, туршлага хуримтлуулсан, сахилтан замналд удсан, номдоо ахисан, өндөр насыг зооглосон аж.

Тэгвэл, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс юм.

Тэгвэл, Чунда, түрүүн дурдсан бүх л сайн чанаруудыг шингээсэн ариуслын-замнал байлаа гэж бодъё. Тэгээд багш нь ахлах хувраг болсон, туршлага хуримтлуулсан, сахилтан замналд удсан, номдоо ахисан, өндөр насыг зооглосон аж. Гэтэл түүний шавь болох ахлах түвшний хуврагууд нь номоо сураагүй, сахилаа дадуулаагүй, номын итгэл олоогүй, гэгээрлийн замд ороогүй, үнэн-номыг түгээн дэлгэрүүлэх өндөр түвшинд очоогүй, сөрөн гарч ирэх өөр ном сургаалыг няцаах чадамжгүй, ул үндэстэйгээр Сургаалыг заах чадваргүй байж.

Тэгвэл, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Тэгвэл, Чунда, түрүүн дурдсан бүх л сайн чанаруудыг шингээсэн ариуслын-замнал байлаа гэж бодъё. Тэгээд багш нь ахлах хувраг болсон, туршлага хуримтлуулсан, сахилтан замналд удсан, номдоо ахисан, өндөр насыг зооглосон аж. Түүнчлэн түүний шавь болох ахлах түвшний хуврагууд нь номоо сурсан, сахилаа дадуулсан, номын итгэл олсон, гэгээрлийн замд орсон, үнэн-номыг түгээн дэлгэрүүлэх өндөр түвшинд очсон, сөрөн гарч ирэх өөр ном сургаалыг няцаах чадамжтай, ул үндэстэйгээр Сургаал номыг заах чадвартай байж.

Тэгвэл, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс юм.

Тэгвэл, Чунда, түрүүн дурдсан бүх л сайн чанаруудыг шингээсэн ариуслын-замнал байлаа гэж бодъё. Тэгээд багш нь ахлах хувраг болсон, туршлага хуримтлуулсан, сахилтан замналд удсан, номдоо ахисан, өндөр насыг зооглосон аж. Түүнчлэн түүний шавь болох ахлах түвшний хуврагууд нь номоо сурсан, сахилаа дадуулсан, номын итгэл олсон, гэгээрлийн замд орсон, үнэн-номыг түгээн дэлгэрүүлэх өндөр түвшинд очсон, сөрөн гарч ирэх өөр ном сургаалыг няцаах чадамжтай, ул үндэстэйгээр Сургаал номыг заах чадвартай байж.

Гэтэл түүний шавь болох дунд түвшний хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олоогүй байж.

Тэгвэл, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Тэгвэл, Чунда, түүний шавь болох дунд түвшний хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон байтал анхан шатны хуврагууд нь, энэ мэдлэгийг олоогүй бол тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.[556]

Тэгвэл, Чунда, түүний шавь болох анхан шатны хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон байтал түүний шавь болох ахлах түвшний эмэгтэй хуврагууд, дунд түвшний эмэгтэй хуврагууд, анхан шатны эмэгтэй хуврагууд нь энэ мэдлэгийг олоогүй бол тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Тэгвэл, Чунда, түүний шавь болох анхан шатны эмэгтэй хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон байтал тэр багшийн шавь болох, ариун-сахилтан[557], цагаан өмсгөлтэй эрчүүд нь энэ мэдлэгийг олоогүй бол тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Тэгвэл, Чунда, тэр багшийн шавь болох, ариун-сахилтан, цагаан өмсгөлтэй эрчүүд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон байтал, тэр багшийн шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй эгэл харчуул нь энэ мэдлэгийг олоогүй бол, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Тэгвэл, Чунда, тэр багшийн шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй эгэл харчуул нь ариуслын-замналын мэдлэгийг олсон байтал, тэр багшийн шавь болох, ариун-сахилтан, цагаан өмсгөлтэй эмэгтэйчүүд нь энэ мэдлэгийг олоогүй бол, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Тэгвэл, Чунда, тэр багшийн шавь болох, ариун-сахилтан, цагаан өмсгөлтэй эмэгтэйчүүд, ариуслын-замналын мэдлэгийг олсон байтал, тэр багшийн шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй хүүхнүүд нь энэ мэдлэгийг олоогүй бол, тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Тэгвэл, Чунда, тэр багшийн шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй хүүхнүүд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон боловч тэр ариуслын-замнал хөгжөөгүй, дэвжээгүй, нийтийн хүртээл болоогүй, нэр алдрыг олоогүй, бурхад хийгээд хүмүүсийн дунд, хаана ч тэр сайтар танигдаагүй бол тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус юм.

Хэдий тэр багшийн, ариуслын-замнал хөгжингүй, дэвжингүй, нийтийн хүртээл болсон, нэр алдрыг олсон, бурхад хийгээд хүмүүсийн дунд, хаана ч тэр сайтар танигдсан боловч энэ нь нэр хүнд, биет юмсын үнэмлэхүй оргилд хүрээгүй бол тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс бус билээ.

Гэвч Чунда, урьд дурдсан бүх л сайн чанаруудыг шингээсэн ариуслын-замнал байлаа гэж бодъё. Тэгээд багш нь ахлах хувраг болсон, туршлага хуримтлуулсан, сахилтан замналд удсан, номдоо ахисан, өндөр насыг зооглосон, түүний шавь болох ахлах түвшний хуврагууд нь номоо сурсан, сахилаа дадуулсан, номын итгэл олсон, гэгээрлийн замд орсон, үнэн-номыг түгээн дэлгэрүүлэх өндөр түвшинд очсон, сөрөн гарч ирэх өөр ном сургаалыг няцаах чадамжтай, ул үндэстэйгээр Сургаал номыг заах чадвартай, түүний шавь болох дунд түвшний хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, түүний шавь болох анхан шатны хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, түүний шавь болох ахлах түвшний эмэгтэй

556 Энд гарах олон давталт бүхий хэсгүүд паали эхүүд дээр товчлолт хийсэн байх тул түүнийг дагасан болно.

557 *Brahmacārino*—“ариун-сахилтан”. (“ариун-явдалт нэгэн”, “ариун-явдал”, “ариуслын-замнал”-ыг Лавлахад үз.)

хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, түүний шавь болох дунд түвшний эмэгтэй хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, түүний шавь болох анхан шатны эмэгтэй хуврагууд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, тэр багшийн шавь болох, ариун-сахилтан, цагаан өмсгөлтэй эрчүүд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, тэр багшийн шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй эгэл харчуул нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, тэр багшийн шавь болох, ариун-сахилтан, цагаан өмсгөлтэй эмэгтэйчүүд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, тэр багшийн шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй хүүхнүүд нь ариуслын-замналын мэдлэгийг олсон, мөн тэр ариуслын-замнал хөгжингүй, дэвжингүй, нийтийн хүртээл болсон, нэр алдрыг олсон, бурхад хийгээд хүмүүсийн дунд, хаана ч тэр сайтар танигдсан бөгөөд энэ нь нэр хүнд, биед юмсын үнэмлэхүй оргилд хүрсэн бол тэр ариуслын-замнал тэр талаасаа төгс юм.

Чунда, би одоо энэ ертөнцөд төрсөн Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда билээ. Миний Сургаал бол сайтар тайлбарласан, нарийвчлан заасан, гэгээрлийн эрх чөлөөнд хүргэдэг, амгаланг-олохуйг авчирдаг, Төгс Сэрсэн Буддагийн тунхагласан Сургаал бүхий ариуслын-замнал билээ.

Энэ шашин номын шавь нар нь, үнэн-номын учир зүйг тайлбарлуулсан билээ. Ариуслын-замналыг бүрэн бүтнээр нь, гүйцэд тодорхой заалгуулсан билээ. Номлолын олон төрлийн хэсгүүд болон Сургаалын дасгал бясалгал хоёрыг нэгтгэн нийлүүлж, эдгээрийг хослуулсан нэгдмэл цогц болгосон. Үхэх төрөхийн эргүүлгээс ангижрах тухай Сургаал болж томьёологдсон. Энэ нь бурхад хийгээд хүмүүний ертөнцөд сайн танигдсан билээ.

Чунда, багш би, ахлах хувраг болсон, туршлага хуримтлуулсан, сахилтан замналд удсан, номдоо ахисан, өндөр насыг зооглосон билээ.

Чунда, одоо миний шавь болох ахлах түвшний хуврагууд маань номоо сурсан, сахилаа дадуулсан, номын итгэл олсон, гэгээрлийн замд орсон, үнэн-номыг түгээн дэлгэрүүлэх өндөр түвшинд очсон, сөрөн гарч ирэх өөр ном сургаалыг няцаах чадамжтай, ул үндэстэйгээр Сургаал номыг заах чадвартай, шавь болох дунд түвшний хуврагууд маань, ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох анхан шатны хуврагууд маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох ахлах түвшний эмэгтэй хуврагууд маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох дунд түвшний эмэгтэй хуврагууд маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох анхан шатны эмэгтэй хуврагууд маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох, ариун-сахилтан, цагаан өмсгөлтэй эрчүүд маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй эгэл харчуул маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох, ариун-сахилтан, цагаан өмсгөлтэй эмэгтэйчүүд маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, шавь болох, таван мэдрэхүйн жаргалд автагч, цагаан өмсгөлтэй хүүхнүүд маань ариуслын-замналын мэдлэгийг олсон, мөн энэ шашин номлол маань хөгжингүй, дэвжингүй, нийтийн хүртээл болсон, нэр алдрыг олсон, бурхад хийгээд хүмүүсийн дунд, хаана ч тэр сайтар танигдсан билээ.

Чунда, янз бүрийн багш нар өнөө цагт энэ дэлхийд тодрон гарч ирсэн байна. Гэхдээ Чунда, би тэдний дунд, багш миний адил амжилт, нэр хүнд, биет юмсын үнэмлэхүй оргилд хүрсэн нэгээхэн ч хүнийг олж харахгүй байна.

Чунда, янз бүрийн шашин өнөө цагт энэ дэлхийд тодрон гарч ирсэн байна. Гэхдээ Чунда, миний хуврагууд шиг амжилт, нэр хүнд, биет юмсын үнэмлэхүй оргилд хүрсэн нэгээхэн ч хүнийг олж харахгүй байна.

Чунда, хэрэв хэн нэгэн хүн ямарваа нэг Сургаал номыг бүх л талаараа төгс төгөлдөр, нарийн ширийн бүх зүйлс нь цөм бүрэн, нэмэх эсвэл хасах зүйлгүй, дээд зэргээр зааж, сайтар гэгч нь ойлгуулсан ном хэмээн тодорхойлно гэвэл, энэ л Сургаалыг зааж хэлэх болно.

Чунда, Уддака Раамапутта[558] нэгэнтээ: ‘Харах мөртөө, хардаггүй. Харах мөртөө, юуг хардаггүй юм бол? Хүн сайтар ирлэсэн сахлын хутгыг харахдаа, хутгыг харах боловч ирийг нь хардаггүй юм.’ гэж хэлсэн байдаг.

Уддака Раамапутта, сайтар ирлэсэн сахлын хутгыг л ‘Харах мөртөө, хардаггүй.’ гэж хэлсэн байна.

Чунда, гэхдээ Уддака Раамапуттагийн эдгээр үгс нь ядмаг, болхи, нийтийн, ариун бус, өгөөж тусгүй үгс юм.

Чунда, ‘Харах мөртөө, хардаггүй.’ гэж чухам үнэнээр нь тодорхойлохыг хүсвэл, энэ манай Сургаалыг хэлэх учиртай билээ.

Харах мөртөө, юуг хардаггүй юм бол?

Түрүүн дурдсан, бүх л талаараа төгс төгөлдөр, нарийн ширийн бүх л зүйлс нь бүрэн бүтэн, нэмэх эсвэл хасах зүйлгүй, дээд зэргээр зааж, сайтар гэгч нь ойлгуулсан энэ Сургаал ном юм. Энэ Сургаал бол харах зүйл нь юм.

Түүнчлэн энэ Сургаал дотор, хасчихвал илүү цэвэр ариун болох гээд байгаа ямар нэг шинж чанар үгүй. Тиймээс энэ Сургаалаас хасах шаардлагатай ямар нэг шинж чанарыг олж харахгүй.

Түүнчлэн энэ Сургаал дээр нэмчихвэл илүү бүрэн төгс болох гээд байгаа ямар нэг шинж чанар үгүй. Тиймээс Сургаал дээр нэмэх шаардлагатай ямар нэг шинж чанарыг олж харахгүй.

Тийм болохоор, энд “харах” гэдэг нь Сургаалыг харахыг хэлж байгаа бөгөөд “харахгүй” гэдэг нь Сургаалаас аливааг хасах эсвэл нэмэх шаардлагыг харахгүйг хэлсэн билээ.

Чунда, хэрэв хэн нэгэн хүн ямарваа нэг Сургаал номыг, бүх л талаараа төгс төгөлдөр, нарийн ширийн бүх л зүйлс нь бүрэн бүтэн, нэмэх эсвэл хасах зүйлгүй, дээд зэргээр зааж, сайтар гэгч нь ойлгуулсан сургаал

---

558 *Uddaka Rāmaputta*—“Уддака Раамапутта”. Үгчилбэл, “Раамагийн хүү Уддака”. Бярман Шашны энэ даянч багшаас Ирээдүйн-Будда буюу Сиддхаттха Готама гэрээ орхисны дараахан бясалгал сурч байв.

ном хэмээн тодорхойлно гэвэл, энэ Сургаалыг л бүх л талаараа төгс төгөлдөр, нарийн ширийн бүх л зүйлс нь бүрэн бүтэн, нэмэх эсвэл хасах зүйл үгүй Сургаал юм хэмээн хэлж болох билээ.

6. Чуулан Дуудах Сургаал (Saṅgāyitabbadhamma)

Иймээс Чунда, би шууд-билгүүнээр ухаарсан, улмаар та бүгдэд зааж өгсөн, тэдгээр Сургаалыг та бүгд, нийлж цуглаад, хотол болж чуулаад, тэдгээрийг нэгэн жигдээр, мэтгэлцэж маргахгүйгээр, утга санааг утга санаатай нь, үг хэллэгийг үг хэллэгтэй нь тааруулан, дуудан уншиж, таниулан түгээгээрэй. Ингэснээр, энэхүү Сургаал нь олон түмний сайн сайхан, аз жаргалын төлөө, даян дэлхийн амар амгалангийн төлөө, бурхад хийгээд хүмүүсийн ашиг тус, аз жаргал, сайн сайхны тусын тулд амьдран үргэлжлэх бөгөөд өнө удаан орших болно.

Чунда, ‘Би шууд-билгүүнээр ухаарсан, улмаар та бүгдэд зааж өгсөн, тэдгээр Сургаалыг та бүгд, нийлж цуглаад, хотол болж чуулаад, тэдгээрийг нэгэн жигдээр, мэтгэлцэж маргахгүйгээр, утга санааг утга санаатай нь, үг хэллэгийг үг хэллэгтэй нь тааруулан, дуудан уншиж, таниулан түгээгээрэй. Ингэснээр, энэхүү Сургаал нь олон түмний сайн сайхан, аз жаргалын төлөө, даян дэлхийн амар амгалангийн төлөө, бурхад хийгээд хүмүүсийн ашиг тус, аз жаргал, сайн сайхны тусын тулд амьдран үргэлжлэх бөгөөд өнө удаан орших болно.’ гэж хэлж буй тэдгээр Сургаалууд нь юу билээ?

Тэдгээр Сургаалууд нь:

- Дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгал,
- Дөрвөн зөв чармайлт,
- Дөрвөн ид-чадал,
- Таван чадвар,
- Таван хүч,
- Долоон гэгээрлийг-амирлуулагч,
- Гэгээнтний найман замнал билээ.

Чунда, эдгээр нь, ‘Би шууд-билгүүнээр ухаарсан, улмаар та бүгдэд зааж өгсөн, тэдгээр Сургаалыг та бүгд, нийлж цуглаад, хотол болж чуулаад, тэдгээрийг нэгэн жигдээр, мэтгэлцэж маргахгүйгээр, утга санааг утга санаатай нь, үг хэллэгийг үг хэллэгтэй нь тааруулан, дуудан уншиж, таниулан түгээгээрэй. Ингэснээр, энэхүү Сургаал нь олон түмний сайн сайхан, аз жаргалын төлөө, даян дэлхийн амар амгалангийн төлөө, бурхад хийгээд хүмүүсийн ашиг тус, аз жаргал, сайн сайхны тусын тулд амьдран үргэлжлэх бөгөөд өнө удаан орших болно.’ гэж хэлсэн тэдгээр Сургаалууд билээ.

7. Гажсан Ойлголтыг Засахуй (Saññāpetabbavidhi)

Чунда, эв түнжинтэй, энх найрамдалтай, зөрүү маргаангүй, ариуслын-замналаар хамт амьдран буй та нарын дунд, хэрэв хэн нэг хувраг бусдадаа, Сургаал номын талаар ярих үед, хүндлэл хүлээсэн тэр хувраг, буруу утгад баригдаж, буруу үгсийг хэрэглэсэн мэт санагдах аваас, түүний хэлсэн зүйлийг шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл үгүйсгэн няцаах хэрэггүй юм. Шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл үгүйсгэн няцаахгүйгээр, ердөө л,

‘Найз аа, энэ утгыг илэрхийлэх үг хэллэгийн тал дээр, эдгээр үгс нь зохимжтой юу, тэдгээр үгс нь зохимжтой юу? Энэ утгатай аль нь илүү зохимжтой вэ? Эсвэл найз аа, энэ илэрхийлэл санааны утгад, үүнийг ийм байдлаар авч үзэх үү, тийм байдлаар авч үзэх үү? Энэ илэрхийлэл санаатай, аль нь илүү тохиромжтой бол?’ гэж хэлэх учиртай.

Энэ үед, тэр хүндлэл хүлээсэн хувраг:

‘Найзууд аа, энэ утга санааг илэрхийлэх, янз бүрийн үг хэллэгүүдээс зөвхөн энэ л үг хамгийн сайн тохирох болно. Тийм болохоор би, энэхүү үгийг сонгож байна. Мөн энэ илэрхийллийн янз бүрийн утга санаан дотроос, зөвхөн энэ утга санаа нь л үг хэллэгтэйгээ хамгийн сайн тохироод байх шиг санагдаж байна. Ийм болохоор би, энэхүү утгыг сонгож байна.’ гэж хэлж болох юм.

Ийм тохиолдолд, та түүнийг магтан сайшаах эсвэл зэмлэн буруушаах учиргүй юм. Түүнийг магтан сайшаах эсвэл зэмлэн буруушаахгүйгээр, тэр хувраг зохих байдлаар утга санаа, үг хэллэгийг ойлгуулан сануулах учиртай юм.

Чунда, хэрэв өөр хэн нэгэн хувраг бусдадаа, Сургаалын талаар ярих үед, тэр хүндлэл хүлээсэн хувраг, буруу утгад баригдах боловч, зөв үгсийг хэрэглэсэн мэт санагдах аваас, түүний хэлсэн зүйлийг шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл үгүйсгэн няцаах хэрэггүй юм. Шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл үгүйсгэн няцаахгүйгээр, ердөө л,

‘Найз аа, энэ илэрхийлэл санааны утгад, үүнийг ийм байдлаар авч үзэх үү, тийм байдлаар авч үзэх үү? Энэ илэрхийлэл санаатай, аль нь илүү тохиромжтой бол?’ гэж хэлэх учиртай.

Энэ үед, тэр хувраг:

‘Найзууд аа, энэ илэрхийллийн янз бүрийн утга санаан дотроос, зөвхөн энэ утга санаа нь л үг хэллэгтэйгээ хамгийн сайн тохироод байх шиг санагдаж байна.’ гэж хэлж болох юм.

Ийм тохиолдолд, та түүнийг магтан сайшаах эсвэл зэмлэн буруушаах учиргүй юм. Түүнийг магтан сайшаах эсвэл зэмлэн буруушаахгүйгээр, тэр хувраг зохих байдлаар, утга санааг ойлгуулан сануулах учиртай юм.

Түүнчлэн Чунда, хэрэв өөр хэн нэг хувраг бусдадаа, Сургаалын талаар ярих үед, хүндлэл хүлээсэн тэр хувраг, зөв утгыг барих боловч, буруу үгсийг хэрэглэсэн мэт санагдах аваас, түүний хэлсэн зүйлийг шууд

хүлээн зөвшөөрөх, эсвэл үгүйсгэн няцаах хэрэггүй юм. Шууд хүлээн зөвшөөрөх, эсвэл үгүйсгэн няцаахгүйгээр, ердөө л,

‘Найз аа, энэ утгыг гаргах үг хэллэгийн тал дээр, эдгээр үгс нь зохимжтой юу, тэдгээр үгс нь зохимжтой юу? Энэ утгатай аль нь илүү зохимжтой бол?’ гэж хэлэх учиртай.

Энэ үед, тэр хувраг:

‘Найзууд аа, энэ утга санааг илэрхийлэх, янз бүрийн үг хэллэгүүдээс зөвхөн энэ л үг хамгийн сайн тохирох болно.’ гэж хэлж болох юм.

Ийм тохиолдолд, та түүнийг магтан сайшаах эсвэл зэмлэн буруушаах учиргүй юм. Түүнийг магтан сайшаах эсвэл зэмлэн буруушаахгүйгээр, тэр хувраг зохих байдлаар, утга санаа, үг хэллэгийг ойлгуулан сануулах учиртай юм.

Түүнчлэн Чунда, хэрэв өөр хэн нэг хувраг бусдадаа, Сургаалын талаар ярих үед, хүндлэл хүлээсэн тэр хувраг, зөв утгыг барин, зөв үгсийг хэрэглэсэн мэт санагдаж болох юм. Энэ тохиолдолд та, түүний хэлсэн үгийг,

‘Оновчтой хэллээ!’[559] хэмээн баяртайгаар дэмжвэл зохилтой билээ.

Түүний хэлсэн үгийг ‘Оновчтой хэллээ!’ хэмээн баяртайгаар дэмжсэнийхээ дараа түүнд,

‘Аяа, анд минь, энэ бидний хувьд азтай хэрэг юм. Сургаалын утга санаа болон үг хэллэг хоёрын аль алинд нь, сурамгай гарамгай мэргэшсэн ийм хүндтэй хуврагийг харах нь, хувраг бидний хувьд хувьтай явдал билээ.’ гэж хэлбэл зохилтой.

8. Хэрэгтэйг нь Олгохуй (Paccayānuññātakāraṇa)

Чунда, би Сургаалыг зөвхөн энэ насанд өгөөжөө өгөх оюуны-хорлолын чандлал-хатамжлалыг заадаг хэрэг биш билээ.

Чунда, би Сургаалыг зөвхөн дараа төрөлд өгөөжөө өгөх оюуны-хорлолын чандлал-хатамжлалыг ч заадаг хэрэг бас биш билээ.

Чунда, би Сургаалыг энэ төрөл төдийгүй ирэх төрлүүд, аль алинд нь өгөөжөө өгөх оюуны-хорлолын чандлал-хатамжлалыг заадаг билээ.

Тийм болохоор Чунда, би чамд хувраг орхимжийг зөвшөөрсөн билээ. Энэ нь чамайг хүйтнээс хамгаалж чадна. Энэ нь чамайг халуунаас хамгаалж чадна. Энэ нь чамайг ялаанаас, шумуулаас, салхинаас, нар шарахаас, хэвлээр явагчаас хамгаалж чадна. Энэ нь тохитой томоотой байдлын үүднээс биеийн нууц хэсгийг чинь далдалж, хаалж чадна.

[559] ‘*Sādhū*’—“Оновчтой хэллээ!”. Одоо цагт үүнийг энэ хэвээр нь буюу “Саадуу, саадуу, саадуу!” хэмээн хэлдэг.

Би чамд бадрын хоолыг зөвшөөрсөн билээ. Энэ нь бие махбодыг тэтгэж, амь голыг зогоож чадна. Энэ нь өлсөх зовлонг үгүй хийж чадна. Мөн энэ нь цэвэр ариун замналын дадлага бясалгалд тусалж чадна. 'Энэхүү өглөгийн хоолоор би өлсөх зовлонг үгүй хийх учиртай. Би их шунаж идсэнээс үүдэх таагүй явдлаас сэргийлэх учиртай. Би эрүүл саруулаар, уруудаж буруудахгүйгээр амьдрах учиртай.' хэмээн бодно.

Би чамд амьдрах байр сууцыг зөвшөөрсөн билээ. Энэ нь чамайг хүйтнээс хамгаалж чадна. Энэ нь чамайг халуунаас хамгаалж чадна. Энэ нь чамайг ялаанаас, шумуулаас, салхинаас, нар шарахаас, хэвлээр явагчаас хамгаалж чадна. Энэ нь байгаль цаг агаарын хатуу ширүүн байдлаас сэргийлж, ганцаар орчинд, таатай бясалгах боломжийг олгох болно.

Би чамд өвчнийг анагаах, амийг аврах эм танг зөвшөөрсөн билээ. Энэ нь биеийн эд эрхтнүүдийн хүндрэлээс үүссэн зовлон зүдүүрийг арилгаж, өвчин эмгэг, зовуурь шаналлаас ангижрах эрх чөлөөг олгодог билээ.

9. Жаргал Эдлэхүй (Sukhallikānuyoga)

Чунда, бусад шашны бадарч даянчид 'Сакя омгийн даянч хуврагууд жаргал эдэлдэг.' гэж ярьж болох юм.

Чунда, ийм үг хэлдэг бусад шашны бадарч даянч нарт, 'Найзууд аа, жаргал гэж юуг хэлэх вэ? Жаргал эдлэх олон хэлбэр, олон төрөл байдаг шүү дээ.' гэж хариулах учиртай юм.

Чунда, жаргал эдлэх ядруу дорой, болхи бүдүүлэг, нийтийн түгээмэл, ариун бус, ашиг тусгүй, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирвааныг олоход[560], огтхон ч ашиг тусгүй дөрвөн янзын хэлбэр байдаг.

Тэгвэл тэдгээр дөрвөн хэлбэр нь юу бол?

Энэ хорвоогийн зарим нэг мунхаг хүмүүн, алах буюу аливаа бодгалийн амийг нь авахдаа жаргаж, зугаацдаг. Энэ бол жаргал эдлэх эхний хэлбэр юм.

Түүнчлэн, энэ хорвоо дэлхий дээр, зарим нэг мунхаг хүмүүн, хулгай хийх буюу бусдын өгөөгүй зүйлийг авахдаа жаргаж, зугаацдаг. Энэ бол жаргал эдлэх хоёр дахь хэлбэр юм.

Түүнчлэн, энэ хорвоогийн зарим нэг мунхаг хүмүүн, үнэн бусыг хэлэх буюу худал ярихдаа жаргаж, зугаацдаг. Энэ бол жаргал эдлэх гурав дахь хэлбэр юм.

[560] Энэ хэсгийг Мьянмар эхэд: "...дон-шуналын таван-цулд итгэсэн зүүднээс сэрэхэд ч, авталт донтолтыг орхин одуулахад ч, зовлонг төгсгөхөд ч, оюуны-хорлолыг төгсгөл болгоход ч, Гэгээрлийн Урсгалд ороход ч, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг ухаарахад ч, Нирвааныг ухаарахад ч ашиг тусгүй..." гэжээ (MPA).

Түүнчлэн, энэ хорвоогийн зарим нэг мунхаг хүмүүн, таван мэдрэхүйн таашаал эдлэхдээ жаргаж, зугаацдаг. Энэ бол жаргал эдлэх дөрөв дэх хэлбэр юм.

Чунда, эдгээр дөрвөн төрлийн жаргал бол ядруу дорой, болхи бүдүүлэг, нийтийн түгээмэл, ариун бус, ашиг тусгүй, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирвааныг олоход, огтхон ч нэмэр тус болдоггүй билээ.

Чунда, бусад шашны бадарч даянчид,

'Сакя омгийн даянч хуврагууд эдгээр дөрвөн төрлийн жаргалыг эдэлдэг.' гэж ярьж болох юм.

Тэдгээр бадарч даянч нарт,

'Тэгж бүү ярь.' гэж хэлэх учиртай.

Тэдгээр бадарч даянч нар, та нарын талаар үнэн бусыг ярих учиргүй.

Чунда, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирвааныг олоход[561], чухамхүү ашиг тус болдог дөрвөн хэлбэрийн жаргал гэж байдаг.

Тэгвэл эдгээр дөрвөн хэлбэр нь юу билээ?

Чунда, хувраг хүн мэдрэхүйн-таашаалаас салснаар, тусгүй-муу Зүйлээс салснаар, тэрбээр зурвас-бодол бүхий, эргэцүүлсэн-бодол бүхий, ганцаар-ахуйгаас үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий нэгдүгээр даян зэрэгт хүрснээр тэр оршин байх.

Энэ бол жаргал эдлэх эхний хэлбэр юм.

Хувраг хүний зурвас-бодол, эргэцүүлсэн-бодол намжиж, самади-төвлөрлөөс үүссэн хөөр-баяр аз-жаргал бүхий, дотоод амар-амгалан, оюуны-нэгдэл бүхий, хоёрдугаар даян зэрэгт хүрснээр, тэр оршин байх.

Энэ бол жаргал эдлэх хоёр дахь хэлбэр юм.

Хувраг хүн, хөөр-баяраас салж-ангижирснаар, дүүрэн-анхаарал тунгалаг-оюун бүхий төв-оршихуйд байж, аз-жаргалыг бие махбодоороо мэдрэх ба үүнийг Гэгээнтнүүд, 'Төв-оршихуйд, дүүрэн-анхааралтай, аз-жаргалд умбав' хэмээн нэрийдэх буюу ингэж гуравдугаар даян зэрэгт хүрснээр, тэр оршин байх.

Энэ бол жаргал эдлэх гурав дахь хэлбэр юм.

---

[561] Энэ хэсгийг Мьянмар эхэд: "...дон-шуналын таван-цулд итгэсэн зүүднээс сэрэхэд ч, авталт донтолтыг орхин одуулахад ч, зовлонг төгсгөхөд ч, оюуны-хорлолыг төгсгөл болгоход ч, Гэгээрлийн Урсгалд ороход ч, Гэгээнтний Дөрвөн Үнэнийг ухаарахад ч, Нирвааныг ухаарахад ч ашиг тустай..." гэжээ (MPA).

Хувраг хүн, жаргалаас салж-ангижирснаар, зовлонгоос салж-ангижирснаар, урьдын таатай хийгээд таагүй байдал алга болсноор, жаргал зовлонгийн аль нь ч бус, төв-оршихуйгаас үүссэн дүүрэн-анхаарлын ариусал, дөрөвдүгээр даяан зэрэгт хүрснээр, тэр оршин байх.

Энэ бол жаргал эдлэх дөрөв дэх хэлбэр юм.

Эдгээр нь Чунда, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирваaныг олоход, чухамхүү ашиг тус болдог дөрвөн хэлбэрийн жаргалууд юм.

Чунда, бусад шашны бадарч даянчид,

‘Сакя омгийн даянч хувраггууд ийм дөрвөн төрлийн жаргалыг эдэлдэг.’ гэж ярьж болох юм.

Тэдгээр бадарч даянч нарт,

‘Тэр бол үнэн.’ гэж хэлэх учиртай.

Тэдгээр бадарч даянч нар, та нарын талаар үнэнийг ярих учиртай.

10. Жаргал Эдлэхүйн Ач Тус (Sukhallikānuyogānisaṁsa)

Чунда, бусад шашны бадарч даянч нар, ийм дөрвөн төрлийн жаргалыг эдэлдэг хүмүүст, энэ нь ямар ашиг тустай, ямар давуу талыг өгдөг тухай асууж болох юм.

Тэгвэл Чунда, бусад шашны эдгээр бадарч даянч нарт ингэж хариулах хэрэгтэй:

‘Найзууд аа, энэ дөрвөн төрлийн жаргалыг эдэлдэг хүмүүс, дөрвөн ашиг тус, давуу талыг эндээс горилох учиртай.

Тэгээд эдгээр дөрвөн ашиг тус нь юу бол?

Найзууд аа, энэ номын хувраг хүн, доод гурван сэтгэлийн-хүлээсийг бүрмөсөн устгасны дараа Урсгалд Орогч нэгэн болж, зовлонт төрлийг авах, доод ертөнцөд дахин хэзээ ч төрөл авах учиргүй бөгөөд Төгс Гэгээрэлд гарцаагүй хүрдэг билээ.

Энэ бол эхний ашиг тус, эхний давуу тал юм.

Мөн хувраг хүн, доод гурван сэтгэлийн-хүлээсийг бүрмөсөн устгаж, дур-хүсэл, уур-хилэн, төөрөгдөл намжсанаар, Нэгэнтээ Эргэн Ирэгч болдог бөгөөд тэрээр зөвхөн нэг л удаа, энэ хүмүүний ертөнцөд дахин төрөл авч эргэн ирэх ба, зовлон зүдүүрийг нэгэнт төгсгөх болно.

Энэ бол хоёр дахь ашиг тус, хоёр дахь давуу тал юм.

Мөн хувраг хүн, доод төрөлд төрөл авахад хүргэдэг, доод таван сэтгэлийн-хүлээсийг бүгдийг бүрэн устгаснаар, энэ дэлхийд дахин хүний төрөл авалгүйгээр, тэнгэр бурхдын ертөнцөд дараа төрлийг олж Эс Эргэн Ирэгч болох буюу, тэндээс Эцсийн Нирваанд одох болно.

Энэ бол гурав дахь ашиг тус, гурав дахь давуу тал юм.

Мөн хувраг хүн, оюуны-хорлолыг үгүй хийснээр, оюуны-хорлол үгүй сэтгэлийн ангижрал, саруул-ухааны ангижралыг олж, энэ насандаа шууд-билгүүнээр өөрийн бие дээр ухаарч, тэр зэрэгт хүрч амьдардаг билээ.

Энэ бол дөрөв дэх ашиг тус, дөрөв дэх давуу тал билээ.’

Чунда, эдгээр нь, тэдгээр дөрвөн төрлийн жаргалыг эдэлдэг хүмүүст олддог, дөрвөн ашиг тус, дөрвөн давуу тал юм.

11. Төгсөрсөн Нэгний Хэрхэвч Үйлдэхгүй Үйл (Khīṇāsavaabhabbaṭhāna)

Чунда, бусад шашны бадарч даянчид,

‘Сакя омгийн даянч хуврагууд, ном сургаалдаа бат зогсдоггүй.’ гэж ярьж болох юм.

Чунда, бусад шашны эдгээр бадарч даянч нарт ингэж хариулах хэрэгтэй:

‘Нөхөд өө, Ерөөлтэй Нэгэн, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда, шавь нарынхаа энэ амьдралынхаа туршид, өнөд зөрчих учиргүй, үндсэн сахил ёсыг зааж сургаж, зарлигдаж өгсөн байдаг.

Яг л, ганхашгүй хөдөлшгүй болгож, газар гүн суулгасан гантиг чулуун, эсвэл төмөр хүдэр багана адил, Ерөөлтэй Нэгэн, Төгс Гэгээрсэн Нэгэн, Төгс Сэрсэн Будда, шавь нарынхаа энэ амьдралынхаа туршид өнөд зөрчих учиргүй, үндсэн сахил ёсыг зааж сургаж, зарлигдаж өгсөн байдаг билээ.

Нөхөд өө, оюуны-хорлолыг үгүй хийсэн, ариуслын-замнал нь өндөрлөсөн, хийх учиртайгаа хийсэн, туулах ёстойгоо туулсан, өөрийн зорилгодоо хүрсэн, дахин төрөл авахад хүргэдэг бүх сэтгэлийн-хүлээсийг тасалсан, төгс ухаарлаар бүрэн ангижралд орсон, Төгс Гэгээрсэн Нэгэн, тэр хувраг хүмүүн дараах есөн үйлийг хэзээ ч үйлдэхгүй:

1. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, санаатайгаар аливаа бодгалийн амийг таслахгүй.

2. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, хулгайд тооцогддог, бусдын өгөөгүй зүйлийг авахгүй.

3. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, бэлгийн харилцааны шинжтэй үйлд оролцохгүй.

4. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, санаатай худал хэлэхгүй.

5. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, эгэл хар хүн байсан шигээ, эд юмсыг хожим ашиглах, эдлэх хэрэглэх гэж цуглуулах юм уу, дарж хураахгүй.

6. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, хүсэл-эрмэлзэлд автаж буруу шийдвэр гаргахгүй.

7. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, уур-хилэнд автаж буруу шийдвэр гаргахгүй.

8. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, төөрөгдөлд автаж буруу шийдвэр гаргахгүй.

9. Оюуны-хорлолыг нэгэнт үгүй хийсэн хувраг хүн, айдаст автаж буруу шийдвэр гаргахгүй.

Эдгээр есөн зүйлс бол, нөхөд өө, оюуны-хорлолыг үгүй хийсэн, ариуслын-замнал нь өндөрлөсөн, хийх учиртайгаа хийсэн, туулах ёстойгоо туулсан, өөрийн зорилгодоо хүрсэн, дахин төрөл авахад хүргэдэг бүх сэтгэлийн-хүлээсийг тасалсан, төгс ухаарлаар бүрэн ангижралд орсон, Төгс Гэгээрсэн Нэгэн, тэр хувраг хүмүүний, хэзээ ч үйлдэхгүй зүйлс нь билээ.’

12. Асуултад Хариулахуй (Pañhābyākaraṇa)

Чунда, бусад шашны бадарч даянчид ингэж хэлж болох юм:

‘Даянч Готама өнгөрсөн цаг үеийн тал дээр, цаглашгүй мэдлэг болон ухаарлаа нотлон үзүүлдэг ч, даанч ирээдүй цаг үеийн тал дээр тэр, энэ мэдлэг болон ухаарлаа нотлон үзүүлээгүй. Яагаад ийм байдаг билээ? Үүний шалтгаан нь юу байх вэ?’

Мунхаг хүмүүний нэгэн адил, бусад шашны бадарч даянчид, тодорхой нэг цогц зүйл дээрх мэдлэг болон ухаарал нь өөр нэг цогц зүйл дээр мөн ялгалгүй адилхан хэрэгждэг гэсэн ойлголттой явдаг.

Чунда, өнгөрсөн цаг үеийн тал дээр, Будда урд төрлөө мэдэх ой санамжтай байдаг. Тэрбээр оюундаа ухраан, аль ч урд төрлөө эргэн санах чадвартай юм.

Чунда, ирээдүй цаг үеийн тал дээр, Будда, Бодь модны ёроолд суугаад, ‘Энэ бол эцсийн, сүүлчийн төрөл минь. Үүнээс цааш, төрөл авахуй гэж үгүй болов.’ гэсэн Гэгээрлээс үүссэн, ухаарал мэдлэгтэй юм.

Чунда, өнгөрсөн цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь худлаа, ташаа, үр ашиггүй зүйл байх аваас, Будда энэ асуултад хариулдаггүй.

Чунда, өнгөрсөн цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь үнэн, зөв боловч үр ашиггүй зүйл байх аваас, Будда энэ асуултад хариулдаггүй.

Чунда, өнгөрсөн цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь үнэн, зөв, мөн үр ашигтай зүйл байх аваас, Будда энэ асуултад зөв цагт нь хариулах болно.

Чунда, ирээдүй цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь худлаа, ташаа, үр ашиггүй зүйл байх аваас, Будда энэ асуултад хариулдаггүй.

Чунда, ирээдүй цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь үнэн, зөв боловч үр ашиггүй зүйл байх аваас, Будда энэ асуултад хариулдаггүй.

Чунда, ирээдүй цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь үнэн, зөв, мөн үр ашигтай зүйл байх аваас, Будда энэ асуултад зөв цагт нь хариулах болно.

Чунда, өнөө цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь худлаа, ташаа, үр ашиггүй зүйл байх аваас, Будда энэ асуултад хариулдаггүй.

Чунда, өнөө цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь үнэн, зөв боловч үр ашиггүй зүйл байх аваас, Будда энэ асуултад хариулдаггүй.

Чунда, өнөө цаг үеийн тал дээр, хэрэв энэ нь үнэн, зөв, мөн үр ашигтай зүйл байх аваас, Будда энэ асуултад зөв цагт нь хариулах болно.

Чунда, энэхүү зарчмаар Будда, өнгөрсөн, ирээдүй хийгээд өнөө цаг үеийн тал дээрх асуудалд, тохирох цаг нь эсэх, үнэн эсэх, зөв эсэх, ашиг тустай эсэхээс хамаарч, зөвхөн Сургаал ном болон Сахил ёсонд тааруулж хариулдаг билээ.

Тийм ч болохоор тэр, 'Тийн Одогч' гэж нэрлэгдсэн билээ.

Чунда, бурхан, чөтгөр, Тэнгэр, даяанч болоод бярман, хаад ноёд хийгээд харц ард бүхий энэ цаг үеийнхний хамтдаа амьдран буй эл хорвоод, харагдах, сонсогдох, мэдрэгдэх, мэдэгдэх, олж авах, эрэлхийлэх, бодон төсөөлөх боломжтой, тэдгээр бүх л юмсыг Будда нэвт ухааран таньсан билээ.

Тийм ч болохоор тэр, 'Тийн Одогч' гэж нэрлэгдсэн билээ.

Чунда, Будда Төгс Гэгээрэлд хүрсэн тэр шөнөөс эхлээд, бүгд юу ч үгүй болж сөнөж төгсөх тэр Эцсийн Нирваны шөнө хүртэлх, энэ бүх хугацаанд, Будда, өөр юуг ч биш, зөвхөн бодит үнэнийг л зааж, сургаж, зааварчилсан юм.

Тийм ч болохоор тэр, 'Тийн Одогч' гэж нэрлэгдсэн билээ.

Чунда, Будда тийн номлосон зүйлээ өөрөө хэрэгжүүлдэг бөгөөд зөвхөн өөрөө хэрэгжүүлсэн зүйлээ л тэр тийн номлодог юм.

Тийм ч болохоор тэр, 'Тийн Одогч' гэж нэрлэгдсэн билээ.

Чунда, бурхан, чөтгөр, Тэнгэр, даяанч болоод бярман, хаад ноёд хийгээд харц ард бүхий энэ цаг үеийнхний хамтдаа амьдран буй эл хорвоод, Будда бүгдийг ялан дийлэгч, эс ялагдагч бөгөөд тэрээр хорвоог илтэд харагч, хүч чадлыг оршоогч нэгэн юм.

Тийм ч болохоор тэр, 'Тийн Одогч' гэж нэрлэгдсэн билээ.

13. Тунхаглаагүй Зүйлс (Abyākataṭṭhāna)

Чунда, өөр шашны бадарч даянчид ингэж ярьж болох юм:

‘Нөхөд өө, Будда үхлийн дараа оршсоор байдаг. Чухам энэ л үнэн. Бусад нь худал. Та ингэж бодож байна уу?’

Чунда, тэгж ярьж буй өөр шашны тэдгээр бадарч даянч нарт ингэж хэлэх учиртай:

‘Нөхөд өө, Будда, “Будда үхлийн дараа оршсоор байдаг. Чухам энэ л үнэн. Бусад нь худал.” гэж тунхаглаагүй билээ.’

Чунда, өөр шашны бадарч даянчид ингэж ярьж болох юм:

‘Нөхөд өө, Будда үхлийн дараа үгүй болдог. Чухам энэ л үнэн. Бусад нь худал. Та ингэж бодож байна уу?’

Чунда, тэгж ярьж буй өөр шашны тэдгээр бадарч даянч нарт ингэж хэлэх учиртай:

‘Нөхөд өө, Будда, “Үхсэний дараа Будда үгүй болдог. Чухам энэ л үнэн. Бусад нь худал.” гэж тунхаглаагүй билээ.’

Чунда, өөр шашны бадарч даянчид ингэж ярьж болох юм:

‘Нөхөд өө, Будда үхлийн дараа орших, эс орших, аль аль төлөвт байдаг. Чухам энэ л үнэн. Бусад нь худал. Та ингэж бодож байна уу?’

Чунда, тэгж ярьж буй өөр шашны тэдгээр бадарч даянч нарт ингэж хэлэх учиртай:

‘Нөхөд өө, Будда, “Үхсэний дараа Будда орших, эс орших, аль аль төлөвт байдаг. Чухам энэ л үнэн. Бусад нь худал.” гэж тунхаглаагүй билээ.’

Чунда, өөр шашны бадарч даянчид ингэж ярьж болох юм:

‘Нөхөд өө, Будда үхлийн дараа орших, эс орших, аль аль төлөвт байдаггүй. Энэ бол цор үнэн. Бусад нь худал. Та ингэж бодож байна уу?’

Чунда, тэгж ярьж буй өөр шашны тэдгээр бадарч даянч нарт ингэж хэлэх учиртай:

‘Нөхөд өө, Будда, “Үхсэний дараа Будда орших, эс орших, аль аль төлөвт байдаггүй. Чухам энэ л үнэн. Бусад нь худал.” гэж тунхаглаагүй билээ.’

Чунда, өөр шашны бадарч даянчид ингэж асууж болох юм:

‘Нөхөд өө, яагаад даянч Готама эдгээр асуултад хариулдаггүй юм бэ?’

Чунда, тэгж ярьж буй өөр шашны тэдгээр бадарч даянч нарт ингэж хэлэх учиртай:

‘Нөхөд өө, Будда эдгээр асуултад хариулдаггүй учир нь, эдгээр нь Сургаалтай хамааралгүй, ариуслын-замналын үндэс суурь болохгүй, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирваансыг олоход, огтхон ч ашиг тусгүй зүйлүүд юм.

Ийм учраас Будда эдгээр асуултад хариулдаггүй билээ.’

14. Тунхагласан Зүйлс (Byākataṭṭhāna)

Чунда, өөр шашны бадарч даянчид ингэж асууж болох юм:

‘Нөхөд өө, тэгвэл даянч Готама юуг зааж хэлсэн юм бэ?’

Чунда, тэгж асууж буй өөр шашны тэдгээр бадарч даянч нарт ингэж хэлэх учиртай:

‘Нөхөд өө, Будда, “Энэ бол зовлон.” гэж заасан.

Нөхөд өө, Будда, “Энэ бол зовлонгийн шалтгаан.” гэж заасан.

Нөхөд өө, Будда, “Энэ бол зовлонгийн төгсгөл.” гэж заасан.

Нөхөд өө, Будда, “Энэ бол зовлонгийн төгсгөлд хүргэх замнал.” хэмээн заасан билээ.’

Чунда, өөр шашны бадарч даянчид ингэж асууж болох юм:

‘Нөхөд өө, даянч Готама яагаад үүнийг заасан юм бэ?’

Чунда, тэгж ярьж буй өөр шашны тэдгээр бадарч даянч нарт ингэж хэлэх учиртай:

‘Нөхөд өө, Будда үүнийг тайлбарласан учир нь эдгээр нь Сургаалд хамааралтай, ариуслын-замналын үндэс суурь болдог, алмайрал-үгүй болохуйд, салж-ангижрахуйд, зовлонгийн төгсгөлд, амгаланг-олохуйд, шууд-билгүүнийг ухаарахуйд, Төгс Гэгээрэлд, Нирваансыг олоход, чухамхүү ашиг тустай болохоор тэр юм.

Ийм учраас Будда, эдгээр номыг заасан билээ.’

15. Өнгөрсний Таамаглалаас Үүдсэн Үзэл (Pubbantasahagatadiṭṭhinissaya)

Чунда, өнгөрсний талаарх таамаглал дээр үндэслэсэн, зарим нэг үзэл баримтлал[562] байдаг. Тэдгээр үзэл баримтлалыг харгалзан үзээд би та бүгдэд чухам тайлбарлан заах учиртай зүйлсийг зааж хэлсэн билээ.

Та бүгдэд хэлэх учиргүй зүйлсийг яах ч гэж би та бүхэнд, тийн заах учиртай билээ?

Чунда, ирээдүйн талаарх таамаглал дээр үндэслэсэн, зарим нэг үзэл баримтлал байдаг. Тэдгээр үзэл баримтлалыг харгалзан үзээд би та бүгдэд чухам тайлбарлан заах учиртай зүйлсийг зааж хэлсэн билээ.

Та бүгдэд хэлэх учиргүй зүйлсийг яах ч гэж би та бүхэнд, тийн заах учиртай билээ?

Чунда, тэдгээр үзэл бодлыг харгалзан үзээд, би та бүгдэд чухамхүү тайлбарлан заах учиртай зүйлсийг зааж хэлсэн билээ.

Та бүгдэд хэлэх учиргүй зүйлсийг яах ч гэж би та бүхэнд, тийн заах учиртай билээ?

Тэгвэл өнгөрсний талаарх таамаглал дээр үндэслэсэн тэдгээр үзэл баримтлал нь юу юм бол?

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх бус. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх бөгөөд мөнх бус. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх, мөнх бус, аль нь ч биш. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо өөрөө бүтсэн. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоог өөр хэн нэгэн бүтээсэн. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо өөрөө бүтсэн ба өөр хэн нэгэн бүтээсэн. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

---

[562] Мьянмар орчуулгад энэ хэсэгт гарах эдгээр даянч болон бярман нарын бүх үзэл баримтлалыг “буруу үзэл баримтлал” гэжээ. Эдгээр нь DN 1-ийн 62 үзлийн зарим нь юм (MPA).

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо өөрөө ч бүтээгүй бас өөр хэн нэгэн ч бүтээгээгүй бөгөөд учир шалтгаангүйгээр үүсэн бий болсон. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлон бол мөнх. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлон бол мөнх бус. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлон бол мөнх бөгөөд мөнх бус. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлон бол мөнх, мөнх бусын аль нь ч биш. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлон өөрөө бий болсон. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлонг өөр хэн нэгэн бий болгосон. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлон өөрөө бий болсон ба өөр хэн нэгэн мөн бий болгосон. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Жаргал хийгээд зовлон өөрөө ч бий болоогүй, өөр хэн нэгэн ч бий болгоогүй бөгөөд учир шалтгаангүйгээр үүсэн бий болсон. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар байдаг.

Чунда, ‘Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автсан, тийн айлддаг даянч хийгээд бярман нар дээр очоод би,

‘Нөхөд өө, та нар, өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх гэсэн үзлийг баримталж байна. Үнэхээр тийм гэж үү, нөхөд өө?’ гэж асуудаг.

Тэгэхэд тэд,

‘Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж хариулдаг.

Би тэдний энэ санааг хүлээн зөвшөөрдөггүй.

Яагаад гээч?

Яагаад гэвэл, Чунда, энэ тал дээр өөр танин-мэдэхүйтэй бодгалиуд ч мөн байгаа болохоор тэр юм.[563]

Чунда, тэдгээр олон янзын үзэл баримтлалаа зааж тайлбарлаж байгааг нь харгалзан үзэхэд, миний тайлбараас давж гарах нь бүү хэл, ижил хэмжээнд буйг ч би олж харахгүй байна. Чухамдаа, туйлын номлолын тал дээр[564], би үнэмлэхүй дээд түвшинд байгаа хэрэг юм.

Чунда, 'Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх бус. Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх бөгөөд мөнх бус. Өөрийн-оршихуй болон хорвоо бол мөнх, мөнх бус, аль нь ч биш. Өөрийн-оршихуй болон хорвоо өөрөө бүтсэн. Өөрийн-оршихуй болон хорвоог өөр хэн нэгэн бүтээсэн. Өөрийн-оршихуй болон хорвоо өөрөө бүтсэн ба өөр хэн нэгэн бүтээсэн. Өөрийн-оршихуй болон хорвоо өөрөө ч бүтээгүй бас өөр хэн нэгэн ч бүтээгээгүй бөгөөд учир шалтгаангүйгээр үүсэн бий болсон. Жаргал хийгээд зовлон бол мөнх. Жаргал хийгээд зовлон бол мөнх бус. Жаргал хийгээд зовлон бол мөнх бөгөөд мөнх бус. Жаргал хийгээд зовлон бол мөнх, мөнх бусын аль нь ч биш. Жаргал хийгээд зовлон өөрөө бий болсон. Жаргал хийгээд зовлонг өөр хэн нэгэн бий болгосон. Жаргал хийгээд зовлон өөрөө ч бий болсон ба өөр хэн нэгэн ч бий болгосон. Жаргал хийгээд зовлон өөрөө ч бий болоогүй, өөр хэн нэгэн ч бий болгоогүй бөгөөд учир шалтгаангүйгээр үүсэн бий болсон.' гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон бярман нар дээр очоод би,

'Нөхөд өө, та нар үнэхээр тэгж ярьж, заадаг гэж үү?' гэж асуудаг.

Тэгэхэд тэд,

'Энэ бол цор үнэн. Бусад нь худал.' гэж хариулдаг.

Би тэдний энэ санааг хүлээн зөвшөөрдөггүй.

Яагаад гээч?

Яагаад гэвэл, Чунда, энэ тал дээр өөр танин-мэдэхүйтэй бодгалиуд ч мөн байгаа болохоор тэр юм.

Чунда, тэдгээр олон янзын үзэл баримтлалаа зааж тайлбарлаж байгааг нь харгалзан үзэхэд, миний тайлбараас давж гарах нь бүү хэл, ижил хэмжээнд буйг ч би олж харахгүй байна. Чухамдаа, туйлын номлолын тал дээр, би үнэмлэхүй дээд түвшинд байгаа хэрэг юм.

Чунда, эдгээр нь өнгөрсний талаарх таамаглал дээр үндэслэсэн, тэдгээр үзэл баримтлал юм. Эдгээр үзэл баримтлалыг харгалзан үзээд би та бүгдэд чухам тайлбарлан заах учиртай зүйлсийг л зааж хэлсэн билээ.

Та бүгдэд хэлэх учиргүй зүйлсийг яах ч гэж би та бүхэнд, тийн заах учиртай билээ?

---

563 Энэ хэсгийг Мьянмар орчуулгад "Яагаад гэвэл, Чунда, энэ тал дээр өөр төрлийн 'оршихуйн үргэлжлэлийн ухамсар' (*paṭisandhi-citta*) бүхий бодгалиуд ч мөн байгаа болохоор тэр юм." гэжээ (MPA).

564 "туйлын номлолын тал дээр" гэдгийг Мьянмар эхэд, "Туйлын Үнэнүүдийн тал дээр" гэжээ (MPA).

16. Ирээдүйн Тухай Таамаглалаас Үүдсэн Үзэл (Aparantasahagatadiṭṭhinissaya)

Чунда, тэдгээр ирээдүйн талаарх таамаглал дээр үндэслэсэн үзэл баримтлалыг харгалзан үзээд би та бүгдэд чухам тайлбарлан заах учиртай зүйлсийг л зааж хэлсэн билээ.

Та бүгдэд хэлэх учиргүй зүйлсийг яах ч гэж би та бүхэнд, тийн заах учиртай билээ?

Тэгвэл, ирээдүйн талаарх таамаглал дээр үндэслэсэн тэдгээр үзэл баримтлал нь юу юм бол?

Чунда,

‘Өөрийн-оршихуй бол бие-дүрст. Энэ нь үхсэний дараа мөнхөд оршино. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэлд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон брман нар байдаг.

Тэгвэл Чунда,

‘Өөрийн-оршихуй бол бие-бус. Өөрийн-оршихуй бол бие-дүрст бие-бус хавсарсан. Өөрийн-оршихуй бол бие-дүрст, бие-бус аль нь ч биш. Өөрийн-оршихуй бол танихуй-бүхий. Өөрийн-оршихуй бол танихуй-үгүй. Өөрийн-оршихуй бол танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус юм. Өөрийн-оршихуй нь үхэхийн цагт нэгмөсөн устдаг. Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэсэн үзэл баримтлалд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон брман нар байдаг.

Чунда,

‘Өөрийн-оршихуй бол бие-дүрст. Энэ нь үхсэний дараа мөнхөд оршино.’ гэсэн үзэлд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон брман нар дээр очоод би,

‘Нөхөд өө, та нар, өөрийн-оршихуй бол бие-дүрст. Энэ нь үхсэний дараа мөнхөд оршино гэсэн үзлийг баримталж байна. Үнэхээр тийм гэж үү, нөхөд өө?’ гэж асуудаг.

Тэгэхэд тэд,

‘Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж хариулдаг.

Би тэдний энэ санааг хүлээн зөвшөөрдөггүй.

Яагаад гээч?

Яагаад гэвэл, Чунда, энэ тал дээр өөр танин-мэдэхүйтэй бодгалиуд ч мөн байгаа болохоор тэр юм.

Чунда, тэдгээр олон янзын үзэл баримтлалаа зааж тайлбарлаж байгааг нь харгалзан үзэхэд, миний тайлбараас давж гарах нь бүү хэл, ижил хэмжээнд буйг ч би олж харахгүй байна. Чухамдаа, туйлын номлолын тал дээр, би үнэмлэхүй дээд түвшинд байгаа хэрэг юм.

Чунда, ‘Өөрийн-оршихуй бол бие-бус. Өөрийн-оршихуй бол бие-дүрст бие-бус хавсарсан. Өөрийн-оршихуй бол бие-дүрст, бие-бус аль нь ч биш. Өөрийн-оршихуй бол танихуй-бүхий. Өөрийн-оршихуй бол танихуй-үгүй. Өөрийн-оршихуй бол танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус юм. Өөрийн-оршихуй нь үхэхийн цагт нэгмөсөн устдаг.’ гэсэн үзэлд автаж, тэгж заадаг зарим нэг даянч болон брамин нар дээр очоод би,

‘Нөхөд өө, та нар үнэхээр тэгж ярьж, заадаг гэж үү?’ гэж асуудаг.

Тэгэхэд тэд,

‘Энэ бол цор үнэн. Бусад нь худал.’ гэж хариулдаг.

Би тэдний энэ санааг хүлээн зөвшөөрдөггүй.

Яагаад гээч?

Яагаад гэвэл, Чунда, энэ тал дээр өөр танин-мэдэхүйтэй бодгалиуд ч мөн байгаа болохоор тэр юм.

Чунда, тэдгээр олон янзын үзэл баримтлалаа зааж тайлбарлаж байгааг нь харгалзан үзэхэд, миний тайлбараас давж гарах нь бүү хэл, ижил хэмжээнд буйг ч би олж харахгүй байна. Чухамдаа, туйлын номлолын тал дээр, би үнэмлэхүй дээд түвшинд байгаа хэрэг юм.

Чунда, эдгээр нь ирээдүйн талаарх таамаглал дээр үндэслэсэн, тэдгээр үзэл баримтлал юм. Эдгээр үзэл баримтлалыг харгалзан үзээд би та бүгдэд чухам тайлбарлан заах учиртай зүйлсийг л зааж хэлсэн билээ.

Та бүгдэд хэлэх учиргүй зүйлсийг яах ч гэж би та бүхэнд, тийн заах учиртай билээ?

Чунда, өнгөрсний талаарх таамаглал хийгээд ирээдүйн талаарх таамаглал дээр үндэслэсэн тэдгээр үзлийг хаях, орхих, мөн хальж давахын тулд би, тэдгээр дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг сургаж заасан билээ.

Тэгвэл тэр дөрөв нь юу билээ?

Чунда, миний сургаалыг дагадаг хувраг хүн хичээнгүй зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтайгаар, оюун санаагаа бие махбод дээрээ тогтвортой оршоож (түүнчлэн үүний мөнх бус, баталгаагүй, өөрийн гэсэн сүнсгүй шинжийг нь танин мэдэж), ингэснээр, (таван-цулд дүүрэн-анхааралтай хандаагүйгээс үүдэн гарах ирээдүйн) хүсэл-мөрөөсөл, зовлон зүдүүрийг холуур байлгадаг.[565]

Тэр хувраг, хичээнгүй зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтайгаар, оюун санаагаа мэдрэмж дээрээ тогтвортой оршоож (түүнчлэн үүний мөнх бус, баталгаагүй, өөрийн гэсэн сүнсгүй шинжийг нь танин мэдэж), ингэснээр, (таван-цулд дүүрэн-анхааралтай хандаагүйгээс үүдэн гарах ирээдүйн) хүсэл-мөрөөсөл, зовлон зүдүүрийг холуур байлгадаг.

[565] Дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг энэ судрын Мьянмар орчуулгад арай өөр байдлаар тайлбарласан байгаа хувилбарыг энд зориуд оруулав (MPA).

Тэр хувраг, хичээнгүй зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтайгаар, оюун санаагаа, оюун бодол дээрээ тогтвортой оршоож (түүнчлэн үүний мөнх бус, баталгаагүй, өөрийн гэсэн сүнсгүй шинжийг нь танин мэдэж), ингэснээр, (таван-цулд дүүрэн-анхааралтай хандаагүйгээс үүдэн гарах ирээдүйн) хүсэл-мөрөөсөл, зовлон зүдүүрийг холуур байлгадаг.

Тэр хувраг, хичээнгүй зүтгэлтэй, тунгалаг-оюунтай, дүүрэн-анхааралтайгаар, оюун санаагаа, юмс Үзэгдэл дээр тогтвортой оршоож (түүнчлэн үүний мөнх бус, баталгаагүй, өөрийн гэсэн сүнсгүй шинжийг нь танин мэдэж), ингэснээр, (таван-цулд дүүрэн-анхааралтай хандаагүйгээс үүдэн гарах ирээдүйн) хүсэл-мөрөөсөл, зовлон зүдүүрийг холуур байлгадаг.

Чунда, ийм маягаар, өнгөрсний талаарх таамаглал хийгээд ирээдүйн талаарх таамаглал дээр үндэслэсэн тэдгээр үзлийг хаях, орхих, мөн хальж давахын тулд би, эдгээр дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгалыг сургаж заасан билээ.”

Энэ үед Хүндэт Упаваана, Буддагийн ард зогсоод түүнийг дэвүүрээр сэвж байлаа. Тэгээд тэрээр Буддад хандан:

“Гайхамшигтай, Эрхэм Багш аа! Гайхалтай юм. Эрхэм Багш аа, энэ айлдвар үнэхээр тааламжтай байна. Энэ айлдвар үнэхээр дээд зэргээр таалагдаж байна. Эрхэм Багш аа, энэхүү айлдвар яриаг юу гэж нэрийдэх учиртай бол?” гэхэд,

“Упаваана, энэ яриа нь ингэж итгэх, бишрэх, татагдах, таалах сэтгэлийг төрүүлсэн болохоор, та үүнийг ‘Тааламжит Яриа’ гэсэн нэрээр хожим санах байх.”

Будда ийн айлдав.

Эрхэм Упаваана сэтгэл зүрхнээсээ Буддагийн энэ айлдварт хөөрөн баярлав.

Тааламжит Судар энд өндөрлөв.

СИГААЛАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ СУДАР
DN 31. SIGĀLOVĀDASUTTA

БИ ИЙН СОНССОН ЮМ.[566]

Нэгэн цагт Будда, Раажагахагийн ойролцоох, хар хэрэм хооллодог[567] Хулсан Төгөл хэмээх газар байрлаж байв. Харин тэр үед, нэгэн хар хүмүүний хүү Сигаала өглөө эртлэн босож, Раажагахаг орхин одох бөгөөд нойтон хувцастай, нойтон үстэй чигтээ, алгаа хавсран, дорнын хаяа, өмнийн хаяа, баруун хаяа, умардын хаяа, доод хаяа[568], дээд хаяа[569] зовхис буюу бүх зүг зовхист[570] залбиран мөргөж байлаа.

Тэр үед Будда, орхимжоо өмсөөд, бадрын аяга болон дээд орхимжоо аваад, бадар гуйхаар Раажагахаг зорив. Өглөө эртлэн босож, Раажагахагаас нойтон хувцастай, нойтон үстэй гарч ирсэн, хар хүмүүний хүү Сигаалаг дорнын хаяа, өмнийн хаяа, баруун хаяа, умардын хаяа, доод хаяа, дээд хаяа зовхис буюу бүх зүг зовхист алга хавсран залбиран мөргөж байгааг хараад, Будда түүнд ингэж хэлэв:

“Хар хүмүүний хүү минь, өглөө эртлэн босож, Раажагахагаас нойтон хувцастай, нойтон үстэй гарч ирээд, дорнын хаяа, өмнийн хаяа, баруун хаяа, умардын хаяа, доод хаяа, дээд хаяа зовхис гээд, бүх зүг зовхист алга хавсран залбиран мөргөх учир юу билээ?”

“Эрхэм ноёнтон минь, аав минь өөд болохдоо надад, ‘Хонгор үр минь, тэнгэрийн бүх хаяа зовхист залбирч мөргөж бай.’ гэсэн юм. Эрхэм ээ, би аавынхаа үгийг дээдэлж, хүндэлж, нандигнаж, сүсэглэж, би өглөө эртлэн босож, Раажагахаг орхин одох бөгөөд нойтон хувцастайгаа, нойтон үстэйгээ чигтээ, алгаа хавсран, дорнын хаяа, өмнийн хаяа, баруун хаяа, умардын хаяа, доод хаяа, дээд хаяа зовхис буюу бүх зүг зовхист залбиран мөргөдөг билээ.”

1. Зургаан Зүг (Cha disā)

“Хар хүмүүний хүү минь, Гэгээнтний Сахилд тэнгэрийн зургаан хаяа зовхисыг ийм маягаар дээдлэн шүтдэггүй билээ.”

---

566 Энэ судар нь зарим газар “*Siṅgālasutta* эсвэл *Sigālasutta*” нэрээр явдаг.

567 Тэр эрт цагт зарим цэцэрлэгт хүрээлэн, төрийн дархан цаазат газрууд нь тодорхой нэг амьтныг хамгаалах, асрах, тэжээхэд зориулагдсан байдаг байж.

568 *Heṭṭhimaṁ disaṁ*—“доод хаяа”. (анг. *Nadir*) Зарим эхэд энэ нь лус, савдаг, гүйдэл, өлсгөлөн-сүнс г.м. доогуур зүг зовхис буюу доош чиглүүлэн гэсэн санаа гэжээ.

569 *Uparimaṁ disaṁ*—“дээд хаяа”. (анг. *Zenith)* Зарим эхэд энэ нь Тэнгэр, бурхан, диваажин г.м. дээгүүр зүг зовхис буюу дээш чиглүүлэн гэсэн санаа гэжээ.

570 Зарим Буддын бус (*Śatapatha Brāhmaṇa, Bṛhadāraṇyaka Upaniṣad, Atharva Veda* г.м. эртний Вед, Упанишад) судрыг авч үзвэл, эдгээр зүг зовхис шүтэх явдал нь тухайн үеийн шашны зан үйлийн нэг хэсэг байсан бололтой. Үүнд: Дорнын хаяа—“Агни” галын бурхан; Өмнийн хаяа—“Индра, Сома” бурхан; Баруун хаяа—олон бурхад; Умардын хаяа—“Митра, Варуна” бурхад г.м. зарим тохиолдолд хоорондоо бага зэрэг ялгаатай байдлаар тахигдан шүтэгддэг байсан бололтой. Паали Судартbайгаагаар дөрвөн зүг зовхисыг Агуу Дөрвөн Хаадын (*Cātumahārājika*) зүг гэж DN 32-д дурдсан байна (BS).

“Тэгвэл Эрхэм ээ, Гэгээнтний Сахилд, тэнгэрийн зургаан хаяа зовхисыг хэрхэн дээдлэн шүтдэг юм бэ? Будда, та надад Гэгээнтний Сахил дагуу тэнгэрийн зургаан хаяа зовхисыг хэрхэн дээдлэн шүтэх Сургаалыг зааж өгч болох уу.”

“Хэрэв тийм бол, хар хүмүүний хүү минь, үүнийг анхааран сонсоод, оюун санаандаа сайтар буулгаж авна уу. Би зааж өгье.”

“За, Эрхэм ээ.” хэмээн хар хүмүүний хүү Сигаала хариулав. Тэгээд Будда ийн хэлэв:

“Хар хүмүүний хүү минь, гэгээрсэн шавь[571] хүмүүн, сэтгэлийн-хирийн дөрвөн үйлийг цээрлэдэг. Тэрээр мөн дөрвөн хүчин зүйлээр үүсдэг адын мууг[572] үйлддэггүй. Мөн тэрээр гарлагын үүдийг нээгч зургаан үйлд автдаггүй. Ийнхүү эдгээр арван дөрвөн адын муу зүйлээс зайлсхийснээр, зургаан хаяа зовхист санаа зоволтгүй болж, хоёр төрөлдөө, амжилтад хүрэх замналыг дагаж буй хэрэг билээ. Тэрээр энэ төрөлдөө хийвэл зохилтой зүйлээ хийгээд зогсохгүй дараа төрлийнхийгөө ч биелүүлж байгаа болно.

Нас барсны дараа, бие барагдах цагт, тэрээр жаргалтай бурхдын оронд, дахин төрөл авдаг билээ.

2. Сэтгэлийн-Хирийн Дөрвөн Үйл (Cattāro kammakilesā)

Мөн, гэгээрсэн шавь хүмүүний, цээрлэдэг дөрвөн бузартах бохирдох үйлдэл гэдэг нь юуг хэлэх бол?

Хар хүмүүний хүү минь,

> Амийг таслах нь сэтгэлийн-хирийн үйл юм.
> Хулгай хийх нь сэтгэлийн-хирийн үйл юм.
> Садар самуун явдал нь сэтгэлийн-хирийн үйл юм.
> Худал хэлэх нь сэтгэлийн-хирийн үйл юм.

Энэхүү сэтгэлийн-хирийн дөрвөн үйлдэл нь, гэгээрсэн шавь хүмүүний цээрлэдэг, тэрхүү адын муу үйлүүд юм.”

Будда энэ үгийг хэлснийхээ дараа, дараах мөртийг хэлэв:

> “Бусдын амийг таслахыг
> Бусдын юмыг хулгайлахыг
> Худал үгийг ярихыг
> Хуумгай завхай явахыг
> Мэргэд хэзээ ч сайшаадаггүйг
> Мэдэж авагтун! хүү минь.

---

[571] *Ariyasāvaka*—“гэгээрсэн шавь”. Гэгээрлийн аль нэг түвшинд хүрсэн Буддагийн шавь хэн нэгэн.

[572] *Pāpakammaṁ*—“адын муу”. Үгчилбэл, “чөтгөрийн үйлдэл”.

3. Дөрвөн Хүчин Зүйлс (Catuṭhānaṁ)

Гэгээрсэн шавь хүмүүний төөрөлдөж автдаггүй, адын мууг үйлдэхэд хүргэдэг, дөрвөн хүчин зүйл гэдэг нь юуг хэлэх бол?

Хүсэл-эрмэлзэлд хөтлөгдөж, адын мууг үйлддэг.
Уур-хилэнд хөтлөгдөж, адын мууг үйлддэг.
Төөрөгдөлд хөтлөгдөж, адын мууг үйлддэг.
Айдаст хөтлөгдөж, адын мууг үйлддэг.

Гэвч хар хүмүүний хүү минь, гэгээрсэн шавь хүмүүн, эдгээр дөрвөн хүчин зүйлд автахгүй байснаар, чухамдаа хүсэл-эрмэлзэл, уур-хилэн, төөрөгдөл, мөн айдаст автахгүй байснаар, адын муу үйлд хөтлөгддөггүй.”

Будда энэ үгийг хэлснийхээ дараа, дараах мөртийг хэлэв:

“Хар хүмүүний хүү минь,
Ааг омог хийгээд дур хүсэл
Айдас болоод мунхаглалд автсанаар
Алиман сар хавирган сар болдог шиг
Алга болох болно хүмүүний нэр хүнд
Хар хилэн болоод хүсэл шунал
Харам болоод айдаст автахгүй байснаар
Хавирган сар бүтэн сар болдог шиг
Хайрлал хүндлэл нь өсөх болно.

4. Гарлагын Үүдийг Нээгч Зургаан Үйл (Cha apāyamukhāni)

Мөн, гэгээрсэн шавь хүмүүний автаж зугаацдаггүй, гарлагын үүдийг нээгч зургаан үйл гэдэг нь юуг хэлэх бол?

- Хар хүмүүний хүү минь, халамцуу согтуу болоод хайхрамж сэрэмжгүй байдлыг үүсгэгч согтууруулах ундаанд автаж зугаацах нь гарлагын үүдийг нээдэг.
- Зохисгүй цагаар гадуур гудамжаар тэнэж зугаалах нь гарлагын үүдийг нээдэг.
- Үзвэр зугаа цэнгээнд үргэлж автах нь гарлагын үүдийг нээдэг.
- Хайхрамжгүй сэрэмжгүй байдлыг үүсгэдэг мөрийтэй тоглоомд донтох нь гарлагын үүдийг нээдэг.
- Муу хань нөхөдтэй нийлэх нь гарлагын үүдийг нээдэг.
- Залхуу хойрго зан байдал нь гарлагын үүдийг нээдэг билээ.

5. Согтууруулах Ундаанаас Үүсэх Зургаан Үр-Дагавар (Surāmerayassa cha ādīnavā)

Хар хүмүүний хүү минь, халамцуу согтуу болоод хайхрамж сэрэмжгүй байдлыг үүсгэгч, согтууруулах ундаанаас үүсэх зургаан үр-дагавар бол:

- энэ насныхаа эд хөрөнгөөсөө салдаг;
- хэрүүл тэмцэлд оролцож хариуцлага алддаг;
- өвчин эмгэг тусах эрстэлд ордог;
- сайн нэр, алдар хүндээ алддаг;
- шалдан нүцгэн явдаг;
- оюун ухаан нь муудаж доройтдог.

Хар хүмүүний хүү минь, энэ бол халамцуу согтуу болоод хайхрамжгүй байдлыг үүсгэгч, архи согтууруулах ундаанаас үүсдэг зургаан үр-дагавар юм.

6. Зохисгүй Цагаар Гадуур Зугаалахын Зургаан Үр-Дагавар (Vikālacariyāya cha ādīnavā)

Хар хүмүүний хүү минь, хүн зохисгүй цагаар гадуур гудамжаар тэнэж зугаалахад дараах зургаан үр-дагавар авчирдаг:

- тэрээр өөрийгөө өмгөөлөл хамгаалалтгүй, аюултай осолтой байдалд оруулдаг;
- тэрээр өөрийнхөө эхнэр хүүхдээ өмгөөлөл хамгаалалтгүй, осолтой аюултай байдалд оруулдаг;
- тэрээр өөрийн өмчөө, өмгөөлөл хамгаалалтгүй, осолтой аюултай байдалд оруулдаг;
- тэрээр гэмт хэрэг болон адын муу үйлд сэжиглэгддэг;
- тэрээр ялт хэрэгт гүтгэгддэг;
- тэрээр элдэв төвөгтэй байдалд ордог.

Хар хүмүүний хүү минь, эдгээр нь хүн зохисгүй цагаар гудамжаар тэнэж зугаалахад учирдаг зургаан үр-дагавар юм.

7. Үзвэр Цэнгээнд Үргэлж Автахын Зургаан Үр-Дагавар (Samajjābhicaraṇassa cha ādīnavā)

Хар хүмүүний хүү минь, үзвэр зугаа цэнгээнд үргэлж автахад, дараах зургаан үр-дагавартай байдаг:

- ‘Хаана бүжиглэж байна?

- Хаана дуулж байна?
- Хаана хөгжимдөж байна?
- Хаана уран уншлага, сонирхолтой түүх яриа болж байна?
- Хаана цан цохиж байна?
- Хаана бөмбөр нүдэж байна?’

гэсэн эрэл сурал болж, чухам тийшээ л явж очиж, үүргээ умартаж, сэрэмжээ алддаг.

Хар хүмүүний хүү минь, эдгээр нь үзвэр зугаа цэнгээнд үргэлж автахын зургаан үр-дагавар юм.

8. Мөрийтэй Тоглоомын Зургаан Үр-Дагавар (Jūtappamādassa cha ādīnavā)

Хар хүмүүний хүү минь, сэрэмж хайхрамжгүй байдлыг үүсгэгч, мөрийтэй тоглоомд донтсон хүнд, эдгээр зургаан үр-дагавар ирдэг:

- ялсан бол өрөөлд өширхөл дайсагнал үүсгэдэг;
- ялагдсан бол өөрт гутрал харуусал үүсдэг;
- энэ насныхаа эд хөрөнгөөсөө салдаг;
- түүний үг нь хууль шүүх дээр үнэ цэнгүй болдог;
- түүнийг найз нөхөд, хань ижил нь жигшдэг;
- ‘Энэ мөрийтэй тоглоомчин эхнэр тэжээж чадахгүй.’ гэж хэлэгдэх тул, түүнтэй гэрлэх хүн олдохгүй.

Хар хүмүүний хүү минь, эдгээр нь сэрэмж хайхрамжгүй байдлыг үүсгэгч, мөрийтэй тоглоомд донтсон хүнд ирэх зургаан үр-дагавар юм.

9. Муу Нөхдийн Зургаан Үр-Дагавар (Pāpamittatāya cha ādīnavā)

Хар хүмүүний хүү минь, муу хань нөхөдтэй нийлэхийн эдгээр зургаан үр-дагавар байдаг:

- мөрийтэй тоглоомчид;
- наадамч наргианчид;
- архичид донтогчид;
- хулгайч луйварчид;
- хууран мэхлэгчид;
- догшин түрэмгий хүмүүстэй

тэр учирдаг.

Зөвхөн ийм л хүмүүс түүний найз нөхөд, хань хамсаатны хүрээлэл болдог.

Хар хүмүүний хүү минь, эдгээр нь муу хань нөхөдтэй нийлэхийн зургаан үр-дагавар юм.

10. Залхуугийн Зургаан Үр-Дагавар (Ālasyassa cha ādīnavā)

Хар хүмүүний хүү минь, залхуу хойрго зан байдалд автагч хүнд, эдгээр зургаан үр-дагавар ирдэг:

- хэт хүйтэн байна гээд ажлаа хийдэггүй;
- хэт халуун байна гээд ажлаа хийдэггүй;
- хэтэрхий орой болсон байна гээд ажлаа хийдэггүй;
- хэтэрхий эрт байна гээд ажлаа хийдэггүй;
- хэт их өлссөн байна гээд ажлаа хийдэггүй;
- хэт их идсэн байна гээд ажлаа хийдэггүй.

Ийнхүү тэрээр шалихгүй шалтаг тоочиж, олон үүрэг хариуцлагаа орхиж, эд хөрөнгөө арвижуулахгүй ба, харин хураасан хөрөнгөө бардаг.

Хар хүмүүний хүү минь, эдгээр нь залхуу хойрго зан байдалд автагч хүнд учрах зургаан үр-дагавар юм."

Будда энэ үгийг хэлсний дараа, дараах мөртүүдийг хэлэв:

"Алиалж согтох үед л ирдэг
Архины найз гэж байдаг.
Үйлээ үзэхийн цагт ирдэг
Үнэнч найз гэж байдаг билээ.
Үд болтол унтах, өрөөлийн хүүхэнтэй холбогдох
Өштөн дайсан үүсгэх, өгөөжгүй явдалтай зууралдах
Адын хүмүүстэй нөхцөх, харам нарийн загнах нь
Алив хүнийг сүйрүүлдэг, зургаан шалтгаан билээ.
Муу найз нөхөд, муу хань хамсаатантай хүн
Буруу замд орж, буруу хүрээлэлд нэгдсэн хүн
Энэ насандаа ч, ирэх төрөлдөө ч, сүйрлийг чиглэнэ.
Хөзөр шоо тоглох, хүүхэн шуухан эргүүлэх,
Хөгжимдөх, бүжиглэх, дуулах
Өдөр унтах шөнө тэнэх нь
Өөрийгөө сүйрүүлэх эрийн зургаан үйл юм.
Мөрий тавин тоглодог, хундага тавихгүй уудаг
Хэн нэгний, нандин хайр нь болсон эмэгтэйтэй
Хэт олон эрчүүдийг, араасаа дагуулсан бүсгүйтэй
Саруул ухаант хүмүүний зайгаа барьдаг хүүхэнтэй

Самбаганан аальгүйтэгч эрчүүдийн хувьд
Сар тэргэл байснаа хавирган болдгийн адил
Сайхан нэр алдар нь үгүй болдог учиртай.
Архи дарс уудаг, архиар ангаж цангадаг
Архины мухлагт тогтмол харагдах хүмүүн
Хад чулуу усанд живэхийн адил
Хамаатан садандаа адлагдаж
Өөлөгдөж адлагдахын хэрээр
Өр ширэндээ баригддаг.
Өдрийн цагаар унтдаг хүмүүн
Шөнийн цагаар сэргэг байхгүй.
Өлөн завхай, үргэлж согтуу хүмүүн
Өрх толгойлох чадвар байхгүй.
Хэт халуун, хэт хүйтэн байна
Хэт орой эрт байна гэх хүний
Хэрэг явдал нь бүтдэггүй
Хэтийн боломж нь тойрч явдаг.
Харин халуун хүйтнийг
Хамхуулын чинээ тоодоггүй
Үүрэг ажилдаа хандагч хүний
Үйл хэрэг нь ямагт дэвждэг.

11. Хуурамч Найз (Mittapatirūpaka)

Хар хүмүүний хүү минь, энэ дөрвийг жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, хуурамч найз гэж үзэх учиртай:

- бусдаас зөвхөн юмыг нь авдаг хүн;
- хоосон амлалт өгч, зөвхөн амаараа тусалдаг хүн;
- зусар бялдууч хүн;
- эд хөрөнгөөсөө салах хэрэгт чинь хамтралцдаг хүн.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, бусдаас юмыг нь зөвхөн авдаг хүнийг хуурамч найз гэдгийг нь дараах дөрвөн шинжээр нь таниуштай:

- тэрээр хүнээс зөвхөн л авдаг;
- тэрээр бага зэрэг өгснийхөө хариуд ихийг хүсдэг;
- тэрээр зөвхөн өөрөө асуудалд орох үедээ л бусдад тусалдаг;
- тэрээр чухам ганцхан өөрийнхөө л ашиг сонирхлын үүднээс бусдад тусалдаг.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр нь жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, бусдаас зөвхөн юмыг нь авдаг хүнийг хуурамч найз байна хэмээн таних учиртай юм.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, хоосон амлалт өгч, зөвхөн амаараа тусалдаг хүнийг хуурамч найз гэдгийг нь дараах дөрвөн шинжээр нь таниуштай:

- тэрээр бусдын төлөө юу хийж чадах байснаа л ярьдаг;
- тэрээр ирээдүйд бусдын төлөө юу хийж чадахаа л ярьдаг;
- тэрээр хоосон амлалтаар бусдыг уяраахыг оролддог;
- тэгээд үнэндээ яг цаг нь болоход, боломжгүй байгаагаа илэрхийлдэг.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр нь жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, хоосон амлалт өгч, зөвхөн амаараа тусалдаг хүнийг хуурамч найз байна хэмээн таних учиртай юм.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, зусар бялдууч хүнийг хуурамч найз гэдгийг нь дараах дөрвөн шинжээр нь таниуштай:

- тэрээр найзынхаа адын муу үйлдлийг хүлээн зөвшөөрдөг;
- тэрээр найзынхаа сайн үйлийг болиулдаг;
- тэрээр найзыгаа дэргэд нь магтдаг;
- тэрээр түүнийг эзгүйд нь муугаар ярьдаг.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр нь жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, зусарч бялдууч хүнийг хуурамч найз байна хэмээн таних учиртай юм.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, эд хөрөнгөөсөө салах хэрэгт чинь хамтралцдаг хүнийг, хуурамч найз гэдгийг нь дараах дөрвөн шинжээр нь таниуштай:

- тэрээр халамцуу согтуу болоод хайхрамж сэрэмжгүй байдлыг үүсгэн бий болгодог согтууруулах ундаагаар зугаацах үед чинь хамтрагч болдог;
- тэрээр зохисгүй цагаар, гадуур гудамжаар тэнэж зугаалахад чинь хамтрагч болдог;
- тэрээр үзвэр зугаа цэнгээнд үргэлж автахад чинь хамтрагч болдог;
- тэрээр хайхрамж сэрэмжгүй байдлыг үүсгэдэг мөрийтэй тоглоомоор тоглоход чинь хамтрагч болдог.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр нь, жинхэнэ найзын дүрийг эсгэсэн, эд хөрөнгөөсөө салах хэрэгт хамтралцдаг хүнийг хуурамч найз байна хэмээн таних учиртай юм.”

Будда энэ үгийг хэлснийхээ дараа, дараах мөртийг хэлэв:

> “Зөвхөн чамаас л авдаг, ганцхан амаараа л тусалдаг
> Зусар бялдууч найз, цуглуулсан хөрөнгийг үрэлцдэг найз
> Андын хуурамч дөрвөн шинжийг ухаант хүн таних нь зүйтэй
> Алсаас холдон зайгаа авч, аюулаас өөрийгөө салгах учиртай.

12. Жинхэнэ Найз (Suhadamitta)

Хар хүмүүний хүү минь, энэ дөрөв бол жинхэнэ найзад тооцогдох учиртай:

- тэрээр тусархуу нэгэн;
- тэрээр сайн муу явах аль ч цагт чинь, нэг л зангаараа хандах нэгэн;
- тэрээр зөв сайн зөвлөгөөг өгдөг нэгэн;
- тэрээр чамайг ойлгодог, энэрдэг нэгэн.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзад тооцогдох учиртай, тусархуу тэр хүнийг дараах дөрвөн шинжээр нь таних нь зүйтэй:

- тэрээр халамцуу согтуу найзаа хамгаалдаг;
- тэрээр халамцуу согтуу найзынхаа өмч хөрөнгийг хамгаалдаг;
- тэрээр аюулд орсон найзынхаа аврал нь байдаг;
- тэрээр, гэнэтийн тус хэрэг гарсан найздаа, гуйснаас нь нэг дахин ихийг өгдөг.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр, жинхэнэ найзад тооцогдох учиртай, тусч тэр хүнийг таних нь зүйтэй.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзад тооцогдох учиртай, сайн муу явах аль ч цагт чинь нэг л зангаараа ханддаг тэр хүнийг дараах дөрвөн шинжээр нь таних нь зүйтэй:

- тэрээр найздаа нууцаа хэлнэ;
- тэрээр найзынхаа нууцыг хадгална;
- тэрээр хүнд хэцүү цагт, найзыгаа орхихгүй;
- тэрээр тэр найзын төлөө амиа хайрлахгүй.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр жинхэнэ найзад тооцогдох учиртай, сайн муу явах аль ч цагт чинь нэг л зангаараа ханддаг тэр хүнийг таних нь зүйтэй.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзад тооцогдох учиртай, зөв сайн зөвлөгөөг өгдөг тэр хүнийг дараах дөрвөн шинжээр нь таних нь зүйтэй:

- тэрээр найзыгаа адын муу зүйл хийхээс татгалзуулна;
- тэрээр найзыгаа зөв сайн үйлсэд уриална;
- тэрээр найзынхаа урьд өмнө нь сонсож байгаагүй гүн гүнзгий утга санаа бүхий зүйлсийн талаар хэлж өгнө;
- тэрээр найздаа тэнгэр диваажингийн оронд очих замыг зааж өгнө.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр, жинхэнэ найзад тооцогдох учиртай, зөв сайн зөвлөгөөг өгдөг тэр хүнийг таних нь зүйтэй.

Хар хүмүүний хүү минь, жинхэнэ найзад тооцогдох учиртай, чамайг ойлгодог, энэрдэг тэр хүнийг дараах дөрвөн шинжээр нь таних нь зүйтэй:

- тэрээр найзынхаа золгүй явдалд баярлахгүй;
- тэрээр найзыгаа сайн явахад баярлана;
- тэрээр бусдыг найзынх нь талаар муугаар ярихыг үл зөвшөөрнө;
- тэрээр найзынх нь талаар сайнаар ярих хүмүүсийг сайшаан үзнэ.

Хар хүмүүний хүү минь, эдгээр дөрвөн шинжээр жинхэнэ найзад тооцогдох учиртай, чамайг ойлгодог, энэрдэг тэр хүнийг таних нь зүйтэй билээ."

Будда энэ үгийг хэлснийхээ дараа, дараах мөртийг хэлэв:

"Ивээлтэй тустай найз, нэг л зангаараа найз
Иттэлт сайн зөвлөгч найз, энэрэн ойлгодог найз
Энэ дөрвөн найзыг ухаант хүмүүн таних нь зүйтэй юм.
Эх нь үрээ хайрлахын адил, эрхэмлэн нандигнах учиртай юм.
Ухаантай, ёс суртахуунтай, мэргэн хүмүүн
Улам бадамлах гал мэт тодрон гэрэлтэнэ.
Цэцэгсийг гэмтээлгүй балаа цуглуулдаг зөгийн адил
Цэвэр ариунаар хөрөнгөө өсгөх хүмүүний баялаг
Улаан шоргоолжны үүр овойж өндөрсдөгийн адил
Улам их болон алгуураар нэмэгддэг билээ.
Өмч хөрөнгөө ингэж олсны дараа залуу хүмүүн
Өрх гэрээ барьж босгож гэмээ нь
Өөрийн хөрөнгөө дөрвөн хэсэгт хуваавал зохилтой.
Өөртөө найзуудыг олох боломжтой.
Анхны нэг хэсгийг нь хэрэглэх, эдлэх учиртай.
Амьжиргаагаа залгуулахын тулд талыг нь зарцуулах ёстой.
Ард нь үлдсэн дөрөвний нэгийг тусгайлан авч үлдээж
Аюултай гэнэтийн тохиолд хадгалж байвал зохилтой.

13. Тэнгэрийн Зургаан Хаяа Зовхист Аврал Одуулахуй (Chaddisāpaṭicchādanakaṇḍa)

Хар хүмүүний хүү минь, гэгээрсэн шавь хүмүүн, тэнгэрийн зургаан хаяа зовхист хэрхэн аврал одуулдаг[573] бол?

[573] *Paṭicchādana*—"аврал одуулах". Өөрөөр "аргалах", "хамгаалах", "аврах". Тухай цаг үед байсан, Бярман болон бусад шашны зан үйлийн нэршлийг нь Будда энд "ёжлох" байдлаар сургаалдаа хэрэглэж байгаа болно.

Хар хүмүүний хүү минь, тэнгэрийн зургаан хаяа зовхисыг ийн үздэг байх нь зүйтэй:

- эцэг эхийг дорнын хаяа;
- багш нарыг өмнийн хаяа;
- хань ижлээ баруун хаяа;
- хамтрагчид найзуудаа умардын хаяа;
- ажилчид туслагчдаа доод хаяа;
- даянч хувраг, бярман нарыг дээд хаяа

хэмээн харах учиртай юм.

Хар хүмүүний хүү минь, дараах таван байдлаар үр хүүхэд нь эцэг эхээ дорнын хаяа адил хүндлэн асрах ёстой:

- эцэг эх минь намайг асран тэтгэсэн, би тэднийг мөн асран тэтгэх болно;
- би тэднийхээ өмнөөс ажил хэргийг нь зохион явуулах болно;
- би гэр бүлийнхээ нэр төр, ёс уламжлалыг хадгалах болно;
- би өв хөрөнгөнд эзэн байх, үнэ хүндтэй хүн байх болно;
- би өөд болсон эцэг эхийнхээ өмнөөс өглөг буяныг хийх болно.

Хар хүмүүний хүү минь, дараах таван байдлаар эцэг эх нь үрсээ, дорнын хаяа адил харж хандах ёстой:

- тэднийг адын муугаас холдуулах;
- зөв сайн үйл хэрэгт хөхүүлэн дэмжих;
- мэдлэг боловсрол, мэргэжил чадвар олгох;
- таарах тохирох ханьтай гэрлүүлж хуримлуулах;
- оновчтой зүйтэй цагт нь өв хөрөнгөө үлдээх явдал юм.

Хар хүмүүний хүү минь, тийм таван байдлаар үр хүүхэд нь эцэг эхээ хүндлэн асарч, ийм таван байдлаар эцэг эх нь үрсээ харж хандах учиртай. Дорнын хаяа зовхист аврал одуулна гэж энэ бөгөөд ингэж аюулгүй хийгээд амгалан болно.

Хар хүмүүний хүү минь, дараах таван байдлаар сурагч нь багшаа өмнийн хаяа зовхис адил хүндлэн хандах учиртай:

- суудлаасаа босож багштайгаа ёслох, мэндлэх;
- багшид ойр зуур үйлчлэх туслах;
- багшийн хэлсэн үгийг дагах;
- багшид хувиасаа нэмэр тусаа санал болгох;
- багшийн зааврыг анхаарал тавин хүндэтгэн, хүлээн авах, сурах болно.

Хар хүмүүний хүү минь, эдгээр таван байдлаар багш нь сурагчдаа, өмнийн хаяа адил хүндлэгдэх ба дараах таван байдлаар сурагчаа асран хандах учиртай:

- тэрээр дадуулах ёстой зүйлийг сайтар дадуулж өгнө;
- тэрээр юуг зааж өгөх ёстойг сайтар зааж өгнө;
- тэрээр сурагчийг бүх л төрлийн урлаг, ухаанд сургана;
- тэрээр сурагчаа, найз нөхөд, хамтрагч хүмүүстээ итгэн танилцуулна;
- тэрээр сурагчаа зүг бүрээс учрах аюулаас өмгөөлж хамгаалах болно.

Хар хүмүүний хүү минь, тийм таван байдлаар сурагч нь багшаа өмнийн хаяа адил хүндлэн хандаж, ийм таван байдлаар багш нь сурагчаа өмнийн хаяа адил асран хандах учиртай. Өмнийн хаяа зовхист аврал одуулна гэж энэ бөгөөд ингэж аюулгүй хийгээд амгалан болно.

Хар хүмүүний хүү минь, дараах таван байдлаар нөхөр нь гэргийгээ баруун хаяа зовхис адил хүндлэн хандах учиртай:

- тэрээр түүнтэй эелдэг харьцаж, түүнийг зохистойгоор дууддаг байх;
- түүнтэй хүндэтгэлтэй байж, доромжлол үгүй хандана;
- тэрээр түүнд үнэнч байх болно;
- тэрээр түүнд гэрийн дотоодын асуудлыг бүрэн хариуцуулна;
- тэрээр түүнийг хувцас хунар, гоёл чимэглэлээр хангана.

Хар хүмүүний хүү минь, эдгээр таван байдлаар гэргий нь нөхөртөө, баруун хаяа адил хүндлэгдэх ба дараах таван байдлаар нөхрөө асран хандах учиртай:

- тэрээр өөрийн хариуцсан олон үүргээ сайтар биелүүлнэ;
- тэрээр худын болон хадмын талд эн тэнцүүгээр, зочломтгой бөгөөд өгөөмөр хандана;
- тэрээр нөхөртөө үнэнч байна;
- тэрээр нөхрийн гэртээ авч ирснийг харж хамгаална;
- тэрээр даасан үүрэг ажлаа авхаалжтай бөгөөд үр бүтээлтэйгээр гүйцэтгэнэ.

Хар хүмүүний хүү минь, тийм таван байдлаар нөхөр нь гэргийгээ баруун хаяа адил хүндлэн хандаж, ийм таван байдлаар гэргий нь нөхрөө баруун хаяа адил асран хандах учиртай. Баруун хаяа зовхист аврал одуулна гэж энэ бөгөөд ингэж аюулгүй хийгээд амгалан болно.

Хар хүмүүний хүү минь, дараах таван байдлаар, буянтай сайн айл гэрийн эзэн хар хүн бээр, найз нөхөд, хамтрагч нараа умардын хаяа адил хүндлэн хандах учиртай:

- тэрээр хармын сэтгэлгүй өгөөмөр сэтгэлээр хандана;
- тэрээр таатай, эелдэг үг яриагаар харьцана;
- тэрээр нэмэртэй тустай байна;
- тэрээр өөртөө ханддаг шигээ тэдэндээ хандана;
- тэрээр хэлсэн үг, амласан амлалтдаа эзэн байна.

Хар хүмүүний хүү минь, эдгээр таван байдлаар найз нөхөд, хамтрагч нар нь, буянтай сайн айл гэрийн эзэн хар хүнээр, умардын хаяа адил хүндлэгдэх ба дараах таван байдлаар мөн түүнийг асран хандах учиртай:

- тэд халамцуу согтуу найзаа хамгаалдаг;
- тэд халамцуу согтуу найзынхаа өмч хөрөнгийг хамгаалдаг;
- тэд аюулд орсон найзынхаа аврал нь байна;
- тэд түүнийг зовлонд унахад орхин явахгүй;
- тэд түүний үр удмыг хүртэл асран тэтгэнэ.

Хар хүмүүний хүү минь, тийм таван байдлаар буянтай сайн айл гэрийн эзэн хар хүн бээр, найз нөхөд, хамтрагч нараа умардын хаяа адил хүндлэн хандаж, ийм таван байдлаар найз нөхөд, хамтрагч нар нь, мөн түүнийг умардын хаяа адил харж хандах учиртай. Умардын хаяа зовхист аврал одуулна гэж энэ бөгөөд ингэж аюулгүй хийгээд амгалан болно.

Хар хүмүүний хүү минь, дараах таван байдлаар, дарга эзэн хүн бээр, ажилчид туслах нараа доод хаяа зовхис адил хүндлэн хандах учиртай:

- тэрээр тэднийг боломж хийгээд хүч чадалд нь тохирсон ажил үүрэгт хуваарилна;
- тэрээр тэдэнд цай унд болоод цалин хөлсийг нь олгоно;
- тэрээр тэднийг өвдөх цагт нь асарч тэтгэнэ;
- тэрээр тэднийг элбэг дэлбэг хоолоор цайлж дайлна;
- тэдэнд үе үе, чөлөө амралт олгож байна.

Хар хүмүүний хүү минь, эдгээр таван байдлаар ажилчид туслах нар нь, дарга эзэндээ хүндлэгдэх ба дараах таван байдлаар мөн түүнд туслах учиртай:

- тэд түүнээс эрт босно;
- тэд түүний дараа унтана;
- тэд түүний зөвхөн өгсөн юмыг л авна;
- тэд өөрсдийн үүргээ сайтар биелүүлнэ;
- тэд түүний сайн нэр төр, алдар хүндийг хамгаална.

Хар хүмүүний хүү минь, тийм таван байдлаар ажилчид туслах нар нь, дарга эзнээ доод хаяа зовхис адил хүндлэн хандаж, мөн ийм таван байдлаар дарга эзэд, ажилчид туслах нараа харж хандах учиртай. Доод хаяа зовхист аврал одуулна гэж энэ бөгөөд ингэж аюулгүй хийгээд амгалан болно.

Хар хүмүүний хүү минь, дараах таван байдлаар, буянтай сайн айл гэрийн эзэн хар хүн бээр, даянч хувраг, бярман нарыг дээд хаяа зовхис адил хүндлэн хандах учиртай:

- энэрэл хайрын үйлээрээ хандана;
- энэрэл хайрын үгээрээ хандана;
- энэрэл хайрын сэтгэлээрээ хандана;

- тэдэнд үүд хаалгаа нээлттэй байлгана;
- тэдэнд өглөг буяныг хайрлана.

Хар хүмүүний хүү минь, эдгээр таван байдлаар даянч хувраг, бярман нар нь, буянтай сайн айл гэрийн эзэн хар хүнээр, дээд хаяа зовхис адил хүндлүүлэх ба дараах зургаан байдлаар мөн түүнд өгөөж тусаа үзүүлэх учиртай:

- тэд түүнийг адын муу үйлсээс холдуулна;
- тэд түүнийг буянтай тустай үйлд уриална;
- тэд түүнийг энэрэл хайраар хамгаална;
- тэд түүнд урьд өмнө нь сонсож байгаагүй гүн гүнзгий утга санаа бүхий сургаалыг зааж өгнө;
- тэд түүнд урьд өмнө нь сонсож байсан гүн гүнзгий утга санаа бүхий сургаалыг тайлбарлаж ойлгуулж өгнө;
- тэд түүнд тэнгэр диваажингийн оронд очих замыг зааж өгнө.

Хар хүмүүний хүү минь, тийм таван байдлаар буянтай сайн айл гэрийн эзэн хар хүн бээр, даянч хувраг, бярман нарыг дээд хаяа зовхис адил хүндлэн хандаж, ийм зургаан байдлаар мөн тэд түүнд өгөөж тусыг үзүүлэх учиртай. Дээд хаяа зовхист аврал одуулна гэж энэ бөгөөд ингэж аюулгүй хийгээд амгалан болно.”

Будда энэ үгийг хэлснийхээ дараа, дараах мөртийг хэлэв:

“Эцэг эх дорнын хаяа зовхис
Эрдэмт багш өмнийн хаяа зовхис
Эхнэр хүүхэд баруун хаяа зовхис
Эрхэм анд нөхөд умардын хаяа зовхис
Ажилчид туслахууд доод хаяа зовхис
Ариун хуврагууд дээд хаяа зовхис.
Айлын эзэн энэ зургааг шүтэж
Арвин буяныг хураадаг учиртай.
Ухаантай бөгөөд чадвартай
Ухамсартай бөгөөд хүндлэлтэй
Ачлалтай бөгөөд энэрэлтэй тэд
Алдар сууг ямагт олно.
Авхаалжтай бөгөөд цуцашгүй
Аядуу бөгөөд мятаршгүй
Ачлах хүндлэлийг сурсан тэд
Алдар сууг ямагт олно.
Өөртөө найз нөхдийг татсан
Өгөөмөр сэтгэлээр харамгүй загнах
Аргадаж, сургаж, удирдаж чаддаг тэд
Алдар сууг ямагт олно.

Өглөг буян, эелдэг уян
Өрөөлийг өөр шигээ үзэх
Өгөөмөр баян эдгээр зан
Өртөөлөх хүрдний цүү адил юм.
Энэрэл хайрын ийм сэтгэл гэж
Энэ хорвоод үгүй сэн бол
Ээжүүд үрээсээ асрал авахгүй
Аавууд хүүгээсээ хүндлэл үзэхгүй.
Ухаант хүмүүн эдгээрийг
Улам арвижуулан үйлддэг болохоор
Улсын хайрыг булаадаг
Түмний хүндлэлийг хүлээдэг билээ.”

Буддаг ийн ярьж дуусахад, хар хүмүүний хүү Сигаала ийн хэлэв:

“Эрхэм Багш аа, Үлэмж төгс! Үнэхээр үлэмж төгс юм, Багш аа! Хөмөрч унасан нэгнийг босгоод ирэх мэт, далд нуугдсан юмыг ил болгох мэт, замаасаа гарч төөрсөн нэгэнд замыг нь заагаад өгөх мэт, түнэр харанхуй газар гэрэл гэгээ гаргахад, нүдтэй л хүн юм бол, юу тэнд байгааг нь олоод харчих мэт, Будда энгийн олон аргаар, нартын чухам үнэнийг надад дэлгэж харууллаа.

Эрхэм Багш аа, би Буддагийн нөмөрт очмуй. Сургаалын нөмөрт очмуй. Хуврагийн Чуулганы нөмөрт очмуй.

Энэ өдрөөс эхлэн, энэ амьдрал дуусах хүртэл, Будда та намайг өөрийн сахилтан шавь хар хүн болсныг минь хүлээн авч соёрхоно уу.”

Сигаалад Өгсөн Зөвлөмж Судар энд өндөрлөв.

НЭР ТОМЬЁОНЫ ЛАВЛАХ

Энэ Лавлах толь нь бүрэн хэмжээний Паали-Монгол толь бичиг, эсвэл Паали Судрын бүх паали нэр томьёог хамруулан авч үзсэн тайлбар биш бөгөөд зөвхөн Арван Судартт гарах үгийн тухайн тохиолдолд илэрхийлэгдсэн утгыг тайлбарласан товч лавлах болно. Мөн энд буй паали үгс, нэр томьёоны зарим нь судрын хэсгээс шууд тастаж авсан байдалтай, Паали хэлний нэрийн тийн ялгал, үйлийн өнгөрсөн цагийн олон төлөвт хувирсан хэвээр байж болохыг анхаарна уу. Тайлбар хийгдсэн үг бүрийг тод хар болгож оруулсан тул энэ лавлах дотроо тэдгээр үгээ дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Энэ хэсгийг "Лавлах" гэж товчлон зүүлт тайлбарт хэрэглэснийг анхаарна уу.

аз-жаргал—*sukha*. I-III **даян**-д үүсэх, нэн жаргалантай байдал. Бясалгалын **хөөр-баяр**-аас хавьгүй хүчтэй тусах аз жаргал. Сахилыг дээд зэргээр оршоох, **таван-саад**-ыг давах, **самади-төвлөрөл**-д орох үед мэдрэгдэх хосгүй аз жаргал. (DN 2-г үз.)

алмайрал-үгүй—*nibbida.* Аливаа зүйлд сэтгэлд татагдах, баясах, алмайрах байдлыг үгүй хийсэн байх гэсэн санаа; зарим тохиолдолд сахил, бясалгалын түвшин.

амар-амгалан—*passaddhi* (анг. *serenity, tranquility*). Сахил, бясалгалаас үүдэн сэтгэлийн дотор үүсэн бий болох гүнзгий түвшний нэн амар амгалан байдал. Энэ нь **таван-саад**-ын **түгшүүр-зовнил**-ыг дарах эм болох ба **таван-саад**-ыг давах үед, "биеийн амар-амгалан", **аз-жаргал**-ыг мэдэрнэ.

амгаланг-олохуй—*upasama*. Гэгээрлийг олохуйтай дүйцэх утга. (Тайлбарт Нирваан хэсгийг үз.)

амьд биетийн амийг таслах—*pāṇātipāta.* Ямар нэг амьд зүйлийг хөнөөх, амийг нь авах. Амьтан, эсвэл ургамал эсэхийг тухайлан зааж хэлээгүй байна.

амьжиргаа—*ājīvo*. Ахуй амьжиргаа, орлогын хэлбэр. **Гэгээнтний Найман Замнал**-ын түвшин ахиснаар энэ нь бадар гуйлгаар, зөвхөн бусдын өгсөн зүйлээр амьжиргаа хийх ойлголт. (амьжиргаа ариусах—*parisuddhājīvo*)

Арахант—*arahant*. **Төгс Гэгээрсэн Нэгэн**-ийг үз.

ариун бус—*anariya* (анг. *ignoble*). Гэгээнтний бус, гэгээрсэн хүн эс үйлдэх, ариун биш, гэгээрлийн бус, **ариуслын-замнал**-д **тусгүй-муу**, ариун бус хүмүүний г.м. Дийлэнх тохиолдолд, гэгээрэлд эс хөтлөх, гэгээрэлд харш гэсэн санаа.

ариун-бус явдал—*abrahmacariya* (анг. *unchastity*). **ариуслын-замнал**-д эс нийцэх "ариун-бус үйл", "нүгэл", "садар самуун" буюу аливаа бэлгийн харилцааны үйл (санаатайгаар үрийн шингэн гаргах), ялангуяа хурьцлыг хэлнэ. Хувраг хүний хувьд засагдахгүй алдаа бөгөөд сахилаа тэр дороо алдаж, энэ насандаа дахин сахил авах эрхгүй болно (Vin; DA).

ариун-явдал—*brahmacāriya* (анг. *celibacy*). Аливаа бэлгийн харилцааны үйлээс нэгэнт татгалзсан, гэгээрэл өөд чиглэсэн, ариун ёсны амьдрал, үйл. Ерөнхий утгаараа ариун сахил, **ариуслын-замнал**.

ариун-явдалт нэгэн—*brahmacārī*. Аливаа бэлгийн харилцааны үйлээс нэгэнт татгалзсан нэгэн; гэгээрэл өөд чиглэсэн, ариун ёсны амьдрал, **ариуслын-замнал**-аар замнагч; ариун-сахилтан.

ариуслын-замнал—*brahmacāriya* (анг. *holy life*). Ариун-сахилтан, **ариун-явдалт нэгэн**-ий дагах, чандлал-хатамжлал бүхий, гэгээрэл өөд чиглэсэн замнал. Буддагийн Сургаалын дагуу гэгээрэлд хүрэх замналыг ерөнхий утгаар хэрэглэсэн нэр томьёо. Уг замналд "ариун-явдал" нь салшгүй хэсэг болж багтах боловч, үүнээс гадна дүүрэн-анхаарал, тунгалаг-оюун, даяан бясалгал болон саруул-ухаан, бүгдийг нь хамруулан авч үзнэ.

бадар барих—*piṇḍapāta*. Хувраг хүн хоолоо олж идэх үндсэн хэлбэр буюу ойролцоох тосгон суурինд очиж, бадрын аягаа барин, хоол горилж явах.

бадрын аяга—*patta*. Хувраг хүн бадар барин (хоол гуйж) явахдаа, идэхдээ хэрэглэдэг ваарan, төмөр сав. Эртний ёсоор, хувраг өмчилж болох хоёр л зүйлийн нэг. Нөгөө нь орхимж.

бие-бус—*arūpa*. **бие-дүрст** биш, бие дүрс байхгүй, биегүй, хэлбэргүй, дүрсгүй, материаллаг биш; **бие-бусын даяан**; Бярман Тэнгэрийн хамгийн дээд дөрвөн орон г.м.

бие-бусын даяан—*arūpa jhāna, samāpatti*. Бие-бусын 4 даяан байгаа нь, Бярман Тэнгэрийн Орны, хамгийн дээд дөрвөн: 1. Хязгааргүй Орон Зайн Орон (*ākāsānañcāyatana*), 2. Хязгааргүй Ухамсрын Орон (*viññāṇañcāyatana*), 3. Огт-Оргүйн Орон (*ākiñcaññāyatana*), 4. Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орны (*nevasaññānāsaññāyatana*) даяанууд хамаарна. Нарийндаа, бясалгагч бясалгал хийх үедээ эдгээр оронд орох, мэдрэх, оршоох тохиолууд байх бөгөөд, харин тэр орны даяанаа өөртөө баттай суулгасан бол үхэхийн цагт тэр Тэнгэрийн орон уруу явна гэж үздэг (Abh; DA). (Ойролцоо ойлголтыг Тайлбарт үз.)

бие-бусын дур-хүсэл—*arūpa-rāga*. Эртний Буддизмд, **бие-бусын даяан**-д автах болон Бярман тэнгэрийн орны хамгийн дээд дөрвөн оронд төрөл авах хүсэл.

Бие-бусын Орон—*arūpa-loka*. Бярман Тэнгэрийн Орны, хамгийн дээд дөрвөн: 1. Хязгааргүй Орон Зайн Орон (*ākāsānañcāyatana*), 2. Хязгааргүй Ухамсрын Орон (*viññāṇañcāyatana*), 3. Огт-Оргүйн Орон (*ākiñcaññāyatana*), 4. Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орон (*nevasaññānāsaññāyatana*), зарим тохиолдолд **бие-бусын даяан** орно.

бие-дүрст, бие-дүрс—*rūpī (rūpa)*. 1. бие, дүрс, хэлбэр бүхий; ямар нэг материалаас бүтсэн; хүний мэдрэхүйд ямар нэг байдлаар танигдахуйц (үүнд өнгө, үнэр, гэрэл г.м. орно); 2. I-IV **даяан** буюу **нарийн-биеийн даяан**; 3. Бярман Тэнгэрийн **Нарийн-биеийн Орон** (*rūpa-loka*) г.м.

бие-дүрсийн дур-хүсэл—*rūpa-rāga*. Эртний Буддизмд, I-IV **даяан**-ны буюу **нарийн-биеийн даяан**-д хамаарах **хөөр-баяр** (*pīti*), **аз-жаргал** (*sukha*)-д автах болон Бярман Тэнгэрийн доод 16 **Нарийн-биеийн Орон** (*rūpa-loka*)-д төрөл авах хүсэл. (Тайлбарт Будда хэсгийг үз.)

бие-сэтгэл—*nāmarūpa*. Өөрөөр, "нэршил ба бие-дүрс". Оюунлаг болон материаллаг зүйл хоёрыг нэгтгэж нэг үг болгон хэрэглэсэн нэршил. Өөрөөр хэлбэл, бие-дүрст зүйл болон оюун санаа хоёрын нэгдмэл байдалд оноосон үг. Зарим орчуулгад "нэр ба дүрс" (анг. *name and form*. BS), эсвэл "сэтгэлгээ ба материаллаг байдал" (анг. *mentality-materiality*. BB) гэжээ.

бие—*kāya*. "бие махбод", "махан бие".

биеийн-ухамсар—*kāyaviññāṇa*. (**мэдрэхүйн-харилцаа**-г үз.)

бодгаль—*sattā*. Ямар нэг амьд биет (өлсгөлөн-сүнс, адгуус, хүмүүн, лус, бурхан, Тэнгэр); бидний дараа төрөлдөө, урд төрөлдөө байсан байж болох, энэ хорвоогийн бүхий л амьтан бодгалийг хамруулан хэлсэн нэршил.

бохирдоогүй аз-жаргал—*abyāsekasukha*. Зугаа цэнгэлээс бус, цэвэр ариун үйлээс үүсэх цэвэр ариуны аз жаргал.

буян—*puñña* (сам. *puṇya*). Гол төлөв таатай төрөл авахад тустай, таатай **үйлийн үр**-ийг бий болгох, бие хэл, сэтгэлийн аливаа эерэг **үйлдэл**.

буруу нь үгүй аз-жаргал—*anavajjasukha*. Өөрөөр “буруудахгүй аз-жаргал”. “Буруу нь үгүй” гэдэг нь нүгэлтэйд, тусгүй-муud эс тооцогдох гэсэн санаа.

Бярман Дээд Тэнгэр—*Mahābrahmā*. Бярман тэнгэрийн орны доороосоо гурав дахь орон буюу захирагч хаан, Бярман Тэнгэр (Тайлбарт Будда болон Бярман хэсгийг үз.)

ганцаар-ахуй—*viveka* (анг. *seclusion* эсвэл *solitude*). Орь ганцаар; бүхнээс тусгаарлагдсан байдал; бүгдээс салж ангижирсан байдал. Сахил сахих, **самади-төвлөрөл**д орох, **даян**д орох, ариусал бясалгалын түвшин ахих, **саруул-ухаан**, гэгээрлийг олох гол суурь. (DN 2-г үз.)

гэгээрлийг-амирлуулагч—*sambojjhaṅga*. Гэгээрлийг нөхцөлдүүлэгч, бүрэлдүүлэгч, үндэслэгч, хүчин зүйл, эд эс. **Долоон Гэгээрлийг-Амирлуулагч**-ийг үз.

Гэгээнтний Дөрвөн Үнэн—*Cattāri Ariyasaccāni*. Гэгээрсэн хүмүүний дөрвөн үнэн. (Тайлбарт Ариуссан хэсгийг үз.)

Гэгээнтний Найман Замнал—*Ariyo Aṭṭhaṅgiko Maggo*. (1. зөв **үзэл**; 2. зөв сэдэл; 3. зөв яриа; 4. зөв **үйлдэл**; 5. зөв **амьжиргаа**; 6. зөв зүтгэл; 7. зөв **дүүрэн-анхаарал**; 8. зөв **самади-төвлөрөл**.)

Гэгээнтэн, Гэгээнтний—*ariyā*. Гэгээрсэн хүний, ариун, Гэгээрэлд хөтлөх, ариуссан хүмүүний; Гэгээрлийг олсон, ариуссан хүмүүс г.м. Зарим тохиолдолд Ари угсаа буюу Буддагийн угсаа гарал (B. Sujato үүнийг: “соёлжиж иргэншсэн”, анг. *civilized*). (Тайлбарт Будда, Нирваан, Ариуссан хэсгээс дэлгэрэнгүй үз.)

Гэгээрлийн Замнал—*maggo*. **Гэгээнтний Найман Замнал**-ыг үз.

Гэгээрэл—олон. Тайлбарт Ариуссан хэсгийг үз. 10 **сэттэлийн-хүлээс**-ний доод гурав ба түүнээс олон хүлээснээс салсан, **Гэгээнтний Дөрвөн Үнэн**-ийг бүхэлд нь мэдсэн нэгний ухаарал мэдлэг. **Гэгээнтний Найман Замнал**-ын ядаж эхний шатыг ойлгосон бодит үнэн мэдлэг.

гэр оронтой хүмүүн—*gahapati*. **хар хүн**, сахилтан бус, гэр оронтой, гэр бүлтэй, ахуй амьдралтай, ажил төрөлтэй хүмүүс.

даян—*jhāna* (сам. *dhyāna*). **сахил-ухамсар** суусан, **таван-саад**-ыг давсан үедээ *samādhi* бясалгалыг зөв хийснээр хүрэх, бясалгалын ахисан түвшин. (DN 2.4.11-14-г үз.)

Долоон Гэгээрлийг-Амирлуулагч—*sattasambojjhaṅga*. **гэгээрлийг-амирлуулагч**. (1. **дүүрэн-анхаарал**; 2. **Үзэгдлийг-шинжихүй**; 3. эрч хүч; 4. **хөөр-баяр**; 5. **амар-амгалан**; 6. **самади-төвлөрөл**; 7. **төв-оршихуй**)

дон-шунал—*upādāna*. Хүсэл-цангаа (*taṇhā*)-наас үүдэн бий болж улам хүчтэй автаж зууралдсан, гүн гүнзгий шунал, дон. Энэ хорвоод дахин дахин төрөх, хамаг зовлонд унагах үндсэн шалтгаан. (DN 15-г үз.)

дотоод амар-амгалан—*sampasādana* (анг. *luminous confidence* эсвэл *internal clarity*). Бясалгалаас (II даяанаас) үүсэх, гэрэл гэгээтэй, итгэл үнэмшил бүхий нэн амар амгалан байдал. (DN 2. 4.12 үз.)

дөрвөн ид-чадал—*cattāro iddhipādā*. (1. хичээл зүтгэл; 2. эрч хүч; 3. **сэтгэл**; 4. шинжин үзэхүй) **ид-чадал**-ыг үз.

дөрвөн язгуур махбод—*cātumahābhūtiko*. Язгуур махбод (*mahābhūta*); үндсэн бодис, үндсэн элемент, үндсэн төлөв, суурь эд эс (1. гал; 2. ус; 3. газар; 4. агаар). (DN 2.4.15-г үз.)

дур-хүсэл—*rāga*. Үүнд: 1. мэдрэхүйн **дур-хүсэл** (*kāma-rāga*); 2. даяаны, **Нарийн-биеийн Орон**, энэ төлөвт оршихуйн дур-хүсэл (*rūpa-rāga*); 3. **Бие-бусын Орон**, энэ төлөвт оршихуйн дур-хүсэл (*arūpa-rāga*) хамаарах буюу ихэд татагдах, наалдах шинжийн шунал.

дүүрэн-анхаарал—*sati* (анг. *mindfulness*). Ариуслын-замналын үндсэн хэсэг болох сахил-ухамсар, самади-төвлөрөл, саруул-ухаанаар анхаарлаа дүүрэн байлгахуй, эдгээрийг ямагт санаж байхуй, эс умартахуй. Судрат гол төлөв “тунгалаг-оюун”-тай хоршуулан хэрэглэнэ. Дэлгэрэнгүйг DN 2.4.8; DN 22.4.9; Лавлахад үз. Эртний Буддизмын тайлбараар, **Гэгээнтний Найман Замнал** болон **долоон гэгээрлийг-амирлуулагч**-ийг ямагт санах, анхаарах буюу анхаарлаа үүнд байлгах, сэрэмж анхаарлаа ямагт үүнд байлгахуй. (DN 22.4.9 үз.)

дүүрэн-анхаарал суулгах—*satipaṭṭhānā*. (DN 2; DN 22; **дүүрэн-анхаарал**-ыг үз.)

дүүрэн-анхаарал тунгалаг-оюун—*satisampajañña*. **дүүрэн-анхаарал** болон **тунгалаг-оюун**-ыг хамтад нь хэлсэн ойлголт.

дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгал (үндэс, суурь)—*cattāro satipaṭṭhānā*. (1. биеийг ажихуй; 2. **мэдрэмж**-ийг ажихуй; 3. **сэтгэл**-ийг ажихуй; 4. **Үзэгдэл**-ийг ажихуй). (DN 22-г үз.)

Ерөөлтэй Нэгэн—*Bhagavā* (сам. *Bhagavān*). Буддаг нэрлэсэн өөр нэршил. (Тайлбарт Будда хэсгийг үз.)

ёс-зүйн-айдас—*ottappī, ottappa*. Сахилд, **ариуслын-замнал**-д харш аливаа үйлээс айх эмээх сэтгэл.

ёс-зүйн-ичгүүр—*hirimanā, hiri*. Сахилд, **ариуслын-замнал**-д харш алив үйлд хандах ичгүүр сонжуур.

зовлон, зовлонтой—*dukkhā* (сам. *duḥkha*). Таагүй байдал, зовлонтой байдал, төвөгтэй байдал, зовуурь; зовлонгийн шинжтэй, сэтгэлд нийцэхгүй, таалагдахгүй байх.

зовнил-гуниг—*domanassa*. Аливаад дургүй, таагүй байх, бухимдах, зовуурилах, мөн уйтгар гуниг, уй гашуу зэрэг сэтгэлийн эс нийцэх, зовуурь бүхий таагүй байдлыг нийтэд нь хамруулан хэлсэн үг.

зосон—*kāsāyāni* (анг. *saffron, ochre*). Боровтор, улаавтар, шаравтар, шороон будгийн өнгө.

Зөвөөр Одогч—*Sugata*. Буддаг нэрлэсэн өөр нэршил. (Тайлбарт үз.)

зөрчил-хорсол—*paṭigho*. Эсэргүүцсэн, тэрсэлдсэн, зөрчилдсөн, мөргөлдөөнт сэтгэлийн байдал. (Тайлбарт Ойролцоо Үг хэсгийг үз.)

зурвас-бодол бүхий—*savitakkaṁ*. **зурвас-бодол**-ыг үз.

зурвас-бодол—*vitakka* (анг. *applied thought* эсвэл *initial application*). Ямар нэг бодол, санаа, мэдрэмж зурсхийн орох; ямар нэгэн зурвасхан ч атугай бодол, санаа, мэдрэмж оюун санаанд байхуй, харвахуй; тухайн бодол дээр оюун тогтвортой удаан оршихгүй. (DN 2.4.11-12 үз.)

ид-чадал—*iddhi*. **ид-чадал**, ид, хүч. Сахил болон бясалгалаар, оюуныг гарамгай хөгжүүлснээр олох оюуны ид хүч; зарим тохиолдолд оюун билгийн ид шид.

ид-чадлын дөрвөн үндэс—*iddhipādā*. **Дөрвөн Ид-Чадал**-ыг үз.

Ирээдүйн-Будда—*Bodhisatta*. Амьд Буддагаас *niyata vivaraṇa* буюу ерөөл зөгнөл авсан, ирээдүйд Будда болох нь гарцаагүй нэгэн.

итгэл-үнэмшил—*saddhā*. Чин сэтгэлээсээ итгэх, үнэмших; сүсэглэн найдах; Буддагийн Гэгээрэл, түүний Сургаал, Төгс Гэгээрсэн хуврагууд, Үйлийн Үрийн Хууль, Гэгээрлийн Замналд итгэлтэй, сүсэгтэй, үнэмшилтэй байх; ариуслын-замналын хамаг эхлэл, үр нь болж чадах итгэл үнэмшил.

Маара, Маара чөтгөр—*Māra, Māro pāpimā*. Үгчилбэл, ‘алуурчин’, ‘үхэл’. **Гэгээрэл**-д саад бологч чөтгөр; *Paranimmitavasavattī* диваажингийн захирагч бурхан; ямар нэг бодгаль биш, бодгаль нь солигддог ‘албан тушаал’.

Мөнх Үзэл—*sassatavādā* (анг. *eternalism*). Өөрөөр “мөнх үзэлтэн” (анг. *eternalists*). Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг мөнх оршино гэж үзэх үзэл. *Ekaccasassatavāda*—“Заримдаг Мөнх Үзэл”. Өөрийн-оршихуй болон хорвоо ертөнцийг зарим талаараа мөнх, зарим талаараа мөнх бус гэж үзэх үзэл.

мөнхийн-бус—*aniccā* (анг. *impermanent* эсвэл *unstable*). Тогтворгүй, мөнхийн биш, нэг янзаараа бус, найдваргүй, байнга өөрчлөгддөг, хувирамтгай. Зөвхөн цаг хугацааны талаарх ойлголт бус, “тогтворгүй” г.м. нөхцөл байдлын утгууд бүгд хамаарахыг анхаар.

Мөхлийн Үзэл—*ucchedavādā* (анг. *annihilationism*). Өөрөөр, “Мөхлийн Онол”. Үхлийн дараа, одоо байгаа амьд биетүүд, өөрийн- мөхөж, сөнөж, алга болдог гэж үзэх үзэл.

мунхаг-төөрөгдлийн оюуны-хорлол—*avijjāsava*. **мунхаг-төөрөгдөл**-д автсан, эс мэдэхүйн **оюуны-хорлол**. **мунхаг-төөрөгдөл**-ийг үз.

мунхаг-төөрөгдөл—*avijjā*. Эртний Буддизмын тайлбараар, **Гэгээнтний Дөрвөн Үнэн**-ийг мэдэхгүй, ойлгохгүй, ухаарахгүй байх, үүнээс болж төөрөлдөх, **саруул-ухаан**-аар харахгүй байгаа гэгээрээгүй хүний ухаан. (Тайлбарт дэлгэрэнгүй үз.)

муухай газарт—*duggate*. Доод муу төрөлд; там, өлсгөлөн-сүнс болон амьтны төрөлд; хүнээс доошоо төрөлд.

мэдлэг ухаарал—*ñāṇa*. Ухаарлын мэдлэг, ухаан мэдлэг; **Гэгээрэл**-ийн зарим нэг түвшин.

мэдрэмж—*vedanā*. Мэдрэхүйн объект болох ямар нэг зүйл **оюун-ухамсар**-т буух байдал. Гурван янз мэдрэмж байна: 1. таатай; 2. таагүй; 3. таатай таагүй аль нь ч биш. (Тайлбарт буй Таван-Цул; DN 15; DN 22; **мэдрэхүйн-харилцаа**-г үз.)

мэдрэхүйн-чадвар—*indriya* (1. нүдний; 2. чихний; 3. хамрын; 4. хэлний; 5. биеийн; 6. оюун-ухааны). (**мэдрэхүйн-хүрээ**-г үз.)

мэдрэхүйн-таашаалын оюуны-хорлол—*kāmāsava*. Таван мэдрэхүйн хүсэл, таашаал, мэдрэмжид шунасан **оюуны-хорлол**.

мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл—*kāmacchando*. Таван мэдрэхүйгээрээ мэдрэх аливаа зүйлийг хүсэх, түүнд тэмүүлэхүй; **таван-саад** болон 10 **сэтгэлийн-хүлээс**-ний нэг болно.

мэдрэхүйн-таашаал—*kāma*. Өөрөөр, "таван мэдрэхүйн хүсэл таашаал". Таван мэдрэхүйд (1. харах; 2. сонсох; 3. үнэрлэх; 4. амтлах; 5. хүрэлцэх) мэдрэгдэх зүйлсэд татагдах хүсэл таашаал. Судрын зарим хэсэгт "таван мэдрэхүйн таашаал" гэж оруулав.

мэдрэхүйн үүдээ сахин хамгаалах—*indriyesu guttadvāro*. Зургаан мэдрэхүйгээр орж ирэх зүйлийг манах, цагдах; мэдрэхүйгээ харж хамгаалах.

Мэдрэхүйн Орон—*kāmāvacaro*. Сайн муу **үйлийн үр**, **мэдрэхүйн-таашаал**-ын улмаас төрдөг 11 орон (1. там; 2. өлсгөлөн-сүнс; 3. амьтан; 4. асура; 5. хүн; 6-11. бурхдын зургаан орон). (Бурхдын 6 орныг Тайлбарын Будда хэсэгт үз.)

мэдрэхүйн-харилцаа—*phassa*. Мэдрэхүйн үйл явц гэж хэлж болох **мэдрэхүйн-харилцаа** гэдэг нь: нэгд, мэдрэхүйд тусах зүйл (1. үзэгдэл; 2. чимээ; 3. үнэр; 4. амт; 5. хүрэлцэл; 6. төсөөлөл), хоёрт **оюун-ухамсар** (1. **нүдний-ухамсар**; 2. **чихний-ухамсар**; 3. **хамрын-ухамсар**; 4. **хэлний-ухамсар**; 5. **биеийн-ухамсар**; 6. **оюуны-ухааны-ухамсар**), гуравт **мэдрэхүйн-хүрээ**, энэ гурав уулзах агшин юм.

мэдрэхүйн-харилцааны хүрээ—*phassāyatana*. **мэдрэхүйн-харилцаа** явагдах хүрээ, талбар, суурь, орон; **Үүнд:** 1. нүдний 2. чихний 3. хамрын 4. хэлний 5. биеийн 6. **оюун-ухаан**-ы 6 хүрээ хамаарна. Зарим тохиолдолд сударт *āyatana* (**мэдрэхүйн-хүрээ**)-г, **мэдрэхүйн-харилцаа** (*phassa*) үүсэх нөхцөл болох талаас нь авч үзэхдээ *phassāyatana* (**мэдрэхүйн-харилцааны хүрээ**) хэмээн нэрлэх нь бий.

мэдрэхүйн-хүрээ—*āyatana*. Ертөнцийг танин мэдэх зургаан суваг буюу мэдрэхүйн суурь, талбар, орон; 12 **мэдрэхүйн-хүрээ** байгаа нь: дотоод (*ajjhattikāni āyatanāni*): 1. нүдний 2. чихний 3. хамрын 4. хэлний 5. биеийн 6. **оюун-ухаан**-ы, гадаад (*bāhirāni āyatanāni*): 1. үзэгдлийн 2. чимээний 3. үнэрийн 4. амтны 5. хүрэлцлийн 6. төсөөллийн. Зарим тохиолдолд сударт *āyatana* (**мэдрэхүйн-хүрээ**)-г, **мэдрэхүйн-харилцаа** (*phassa*) үүсэх нөхцөл болох талаас нь авч үзэхдээ *phassāyatana* (**мэдрэхүйн-харилцааны хүрээ**) хэмээн нэрлэх нь бий.

Нарийн-биеийн Орон—*rūpa-loka*. Брахман Тэнгэрийн доод 16 орон (Тайлбарт Будда хэсгийг үз.); мөн зарим тохиолдолд **нарийн-биеийн даяан** хамаарна.

нарийн-биеийн даяан—*rūpa-jhāna*. I-IV **даяан**, мөн Брахман Тэнгэрийн доод 16 орон. (Тайлбарт Будда хэсгийг үз.) Нарийндаа, бясалгагч бясалгал хийх үедээ I-IV **даяан**-д орох, мэдрэх, оршоох тохиолууд байх бөгөөд, харин тэр даянаа өөртөө баттай суулгасан бол үхэхийн цагт тэрхүү Брахман Тэнгэрийн доод 16 орны аль нэг рүү явна гэж үздэг (Abh; DA).

Номын-Нүд нээгдэх—*Dhammacakkhuṁ uppajjissathā*. Гэгээрэлд орох, **Урсгалд Орогч** болохуй.

Номын-хүрд—*Dhammacakka*. Үгчилбэл, 'Сургаалын дугуй (хүрд)'. Будда сургаалаа хүмүүст анхлан заасан үйл явдлыг хөсөг тэргийг хөдөлгөхөд тэр тэрэгний дугуй нь эргэлдэж эхэлдэг үзэгдлээр зүйрлэн хэлсэн үг.

нүдний-ухамсар—*cakkhuviññāṇa*. **оюун-ухамсар**-ыг үз.

нэгдүгээр даяан—*paṭhamaṁ jhānaṁ*. **даяан**-ыг үз. (DN 2.4.11-14-д дэлгэрэнгүй бий.)

Нэгэнтээ Эргэн Ирэгч—*Sakadāgāmī*. Хоёрдугаар түвшний Гэгээрэлд хүрсэн хүн; үхлийн дараа зөвхөн нэг удаа дахиж төрөөд, улмаар зовлонг нэгэнт төгсгөх болно.

огт-оргүй—*ākiñcañña*. Огт оргүй хоосон, хов хоосон, юу ч байхгүй, хоосон чанар.

Огт-Оргүйн Орон—*ākiñcaññāyatana*. **Бие-бусын Орон**-ы нэг, хорвоогийн 31 төрлийн дээрээсээ хоёр дахь зиндааны Тэнгэрийн орон; бясалгалын Огт-Оргүйн Орны **даяан**. (**бие-бусын даяан**-ыг үз.)

'Оргүй хоосон.'—*'natthi kiñcī'*. 'Оргүй хоосон, юу ч үгүй.' гэх байдлыг оюундаа оршоон бясалгах.

орон гэргүй, орон гэргүй нэгэн (болох)—*anagāriyaṁ*. Гэр оронгүй гуйлгачин бадарч; ариуслын зорилгоор гэрээ орхигч (*anagāriya*) болох; гэр бүл, хамаатан садан, эд хөрөнгөө нэгэнт орхих.

'орон зай хязгааргүй'—*'ananto ākāso'*. 'Орон зай бол хязгааргүй юм.' хэмээн оюундаа оршоон бясалгах.

орхин-одуулахуй—*pahāna*. **ариуслын-замнал**-д **тусгүй-муу** зүйлийг нэгмөсөн орхих, одуулах, зайлуулах, татгалзах.

оршин байна—*viharati*. Амьдарна; байна; бясалгана; оршино.

оршихуй—*bhava*. Ерөнхий утга "оршин байхуй" эсвэл "хэн нэгэн болохуй". Нэг төрөлд үхээд дахин төрөл авч амьдрал үргэлжлэхүй буюу оршин байхуй, мөн болохуй, төрөл авахуй. Энэ хорвоо Үйлийн Үрийн Хуульд захирагдаж, урд төрлүүдийн үйлийн улбаагаар бодгалиуд дараагийн төрлөө авах тул тэдгээр урд төрлүүдийн (хийсвэр утгаараа мөн энэ болон ирээдүйн төрлүүдийн) "байхуй", "оршихуйг" бүхэлд нь хамруулж "оршихуй" гэнэ.

оршихуйн оюуны-хорлол—*bhavāsava*. **оршихуй** (*bhava*)-д шунах оюуны-хорлол. **оршихуй**-г үз.

оюун-ухаан—*mano* (сам. *mano*). Оюун ухаан, оюун санаа буюу тархины үйл ажиллагаатай холбосон, эрхтэн талаас нь онцлон нэрлэсэн үг; зургаан мэдрэхүйн нэг; зарим тохиолдолд **сэтгэл** болон **оюун-ухамсар**-тай ойролцоо утгаар хэрэглэгдэх нь бий.

оюун-ухааны-ухамсар—*manoviññāṇa*. **оюун-ухамсар**-ыг үз. (мөн DN 22; DN 2.4.7-г үз.)

оюун-ухамсар—*viññāṇa* (анг. *consciousness*, сам. *vijñāna*). Юмсыг ялган таних сэрэмж байдал; танин мэдэх оюуны чадвар; (энэ нь нөхцөл байдлаас хамааран үүсэж, үгүй болдог түр зуурын үйл явц) Зургаан ухамсар байна: 1. **нүдний-ухамсар**; 2. **чихний-ухамсар**; 3. **хамрын-ухамсар**; 4. **хэлний-ухамсар**; 5. **биеийн-ухамсар**; 6. **оюун-ухааны-ухамсар**; (Тайлбарт буй Таван-Цул, DN 15.1-д үз.)

оюунаар-бүтсэн—*manomayā*. **оюун-ухаан**-аар бүтээсэн, бий болгосон; **оюун-ухаан** бүтээсэн;

оюунаар-бүтсэн бие—*manomaya kāya* (анг. *mind-made body*). Ахисан түвшний бясалгалаар бүтээх, бүдүүн бие махбодоос ялгаатай, нарийн түвшний, энергид суурилсан бие; эгэл хүмүүний чадвараас хальж, нарийн эсвэл далд ертөнцийг мэдрэх; өөрийн биеийг энэ биеэрээ төлөөлүүлэх, өөр бусад ил бус биетүүдтэй харилцах; ер бусын **ид-чадал**-аар бий болгосон бие.

оюуны-нэгдэл—*ekodibhāvaṁ, ekaggatā* (сам. *ekāgratā*, анг. *one-pointedness* эсвэл *unification of mind)*. Оюун санаа өөр юунд ч эс сатаарсан, юунд ч эс анхаарсан, оюун санаа дангаараа өөрөө нэгэн нэгдэл болсон (нэг зүйлд төвлөрсөн), нэн амгалан байдал. (DN 2. 4.13 үз.)

оюуны-хорлол—*āsava* (анг. *taints* эсвэл *cankers*, сам. *āsrava*). Биднийг **үхэх-төрөхийн эргэлт**-д уяж, Гэгээрлээс холдуулж буй, сэтгэлийн гүний **тусгүй-муу** чанар: 1. **мэдрэхүйн-таашаал**-д автсан (*kāmāsava*); 2. **оршихуй**-д шунасан (*bhavāsava*); 3. **мунхаг-төөрөгдөл**-д автсан (*avijjāsava*); мөн нэмэгдэж 4. үзэлд автсан (*diṭṭhāsava*) оюуныг хорлогчид орно.

өөрийн-оршихуй—*attā*. (Тайлбарт, Өөрийн-оршихуйг дэлгэрэнгүй үз.)

өөрийн-оршихуй-бус—*anattā* (сам. *anatman*, анг. *no-self, not-self*). (Тайлбарт, Өөрийн-оршихуй-бусыг дэлгэрэнгүй үз.)

Өөрөө Сэрсэн Будда—*Paccekabuddha* (сам. *Pratyekabuddha*). Өөрөөрөө гэгээрээд өрөөл бусдад Гэгээрлийн Замналыг заагаагүй Будда. (Дэлгэрэнгүйг Тайлбарт буй Будда-д үз.)

садар самуун—*kāmesumicchācārā*. Үгчилбэл, "таван мэдрэхүйг буруугаар ашиглах". Хар хүний таван сахил (*pañcasīla*)-ын нэг буюу, "араар тавих, хүчиндэх", хуримлаагүй хэн нэгэн, насанд хүрээгүй хүнтэй харилцаанд орох, садар завхай сэдэлд автсан бие болон хэл ярианы үйлдэл г.м. орно.

сайхан-бус—*asubha*. Бие махбодын үзэсгэлэнд автах, шунах сэтгэлээс ангид байх, голчлон хүний биеийн 32 бохир муухай чанарыг тухайлсан нэршил. (DN 22.1.4-г үз.)

сайхан газарт—*sugate*. Тэнгэр бурхны болон хүмүүний төрөлд.

салж-ангижрахуй—*virāga*. **дур-хүсэл** (*rāga*)-ээс салж ангижрахуй, **дур-хүсэл**-ээс салсан байдал.

самади-төвлөрөл—*samādhi* (анг. *concentration, immersion*). Өөрөөр **даяан**, **ариуслын-замнал**, төвлөрлийн бясалгалаас үүдэн, мөн **таван-саад**-ыг давах үед оюун санаа нь бясалгалын гүн төвлөрөлд орох, сатааралтгүй болохуй; **оюуны-нэгдэл**-д орохуй; сэтгэл санаа нэн тогтох байдал; бясалгалын ахисан төлөв.

санаа сэдэл—*cetayamāno* (анг. *intentionality*). Аливааг санасан, сэдсэн байх; зорилготой байх;

саруул-ухаан—*paññā* (сам. *prajñā*). Саруул ухаан, ухаарсан мэдлэг, ухаарсан ойлголт, билэг ухаан, мэргэн ухаан, зарим тохиолдолд Гэгээрэл, Гэгээрсэн хүний ухаан; Ертөнцийн Гурван Шинжээр (1. мөнхийн-бус; 2. зовлонтой; 3. өөрийн-оршихуй-бус) харахуйг саруул-ухаанаар харах гэнэ. (Сахил→ Самади→ Саруул-Ухааныг DN 16-д үз.)

сахил-ухамсар—*sīla*. Үндсэн утга: "сахил", "сахилга", "дээд ухамсар", "өндөр ёс суртахуун", "дэг" г.м. Аливаа хүмүүний бусдад харагдах гаднах байдал гэхээс илүү сэтгэлийн дотоод төлөв байдал, мөн чанар, итгэл үнэмшил бүхий өндөр дээд ухамсар, өөрөө өөртөө үнэнчээр даган биелүүлэх, сэтгэлийн, дотоод ухамсрын зөв төлөвшил. (DN 1.2; DN 2.4; DN 9.1.2-г үз.)

Сахил, сахил ёс—*vinaya*. Эртний уламжлал ёсоор Анхдугаар Чуулган дээр хувраг Упаалигийн амаар айлдсан Винайн судрууд (Vinaya Piṭaka) буюу хувраг, сахилтан нарын дагаж мөрдөх дэг ёс.

сахилтан хар хүн, шавь нар—*upāsakā*. Өөрөөр, **сахилтан хар хүмүүс**, **сахилтан эрэгтэй шавь** (*upāsakā, upāsako*), **сахилтан эмэгтэй шавь нар**, **сахилтан эмэгтэй** (*upāsikā*). Гэрээ орхиогүй хар хүн

хэвээр боловч, Буддагийн шавь болж, тав болон түүнээс олон сахил сахиж, Сургаал, ариун амьдралыг эрхэмлэгч, шавь хүмүүс.

сэдэл—*saṅkappo.* (анг. *intention*, сам. *saṃkalpa*). Санаа, зорилго, шийдэл, тэмүүлэл г.м. утга санаа (Мөн ойролцоо утгатай үгсийг Тайлбарт Сэдэхүй-Цогцлохуйд үз.)

сэдэхүй-цогцлохуй—*saṅkhāra* (анг. *volitional formation*, сам. *saṃskāra*). "Сэдэхүй-цогцлохуй бүхэн"-г сэдэхүй-цогцлохуйг судрт олон тоон дээр оруулсан тохиолдлуудад хэрэглэв. Дэлгэрэнгүйгээр Тайлбарт буй Сэдэхүй-Цогцлохуйд үз.

сэтгэл—*citta (ceto). Citta*—Оюун санаа, зүрх сэтгэл болон бодол санааны төлөв байдлыг илэрхийлнэ. Эртний Буддизмд сэтгэл гэдэг нь бие даасан тогтвортой зүйл биш, харин агшин зуур төрж, устдаг сэтгэхүйн нэгж төлөвүүдийн (*cittas*) тасралтгүй урсгал (*citta-santāna*) юм. *Ceto*—Голдуу нөлөөлөлд орсон сэтгэлийн байдал, сэдэл агуулсан (зүрх сэтгэл, хүсэл зориг, санаа зориг г.м.) сэтгэлийн төлөвийг илэрхийлэх хандлагатай.

сэтгэлийн-хир—*kilesā* (анг. *mental defilement*, сам. *Klesha*). Эртний Буддизмын тайлбар ёсоор, Мунхаг-төөрөгдөл, Дон шунал, Уур-хилэн (*avijjā, lobha, dosa*) гурваас үүдэлтэй үндсэн: 1. **шунал** (*lobha*); 2. **уур-хилэн** (*dosa*); 3. **төөрөгдөл** (*moha*); 4. бардамнал (*māna*); 5. элдэв үзэлд автах (*diṭṭhi*); 6. **эргэлзээ-тээнэгэлзээ** (*vicikicchā*); 7. залхуурал (*thīna*); 8. сэтгэл түгшил (*uddhacca*); 9. **ёс-зүйн-ичгүүр** үгүй байдал (*ahirika*); 10. **ёс-зүйн-айдас** үгүй байдал (*anottappa*) болон атаархах, гуниглах, занах, зүхэх, дооглох г.м. оюуныг булингартуулж, зовлонд хөтөлдөг **тусгүй-муу** сэтгэлийн байдлыг хэлнэ.

сэтгэлийн-хүлээс—*saṁyojana* (анг. *fetters*, сам. *saṁyojana*). Эртний Буддизмд, биднийг **үхэх-төрөхийн эргэлт**-ээс гаргахгүй уяж хүлсэн **тусгүй-муу** сэтгэлийн 10 хүлээс байна. Доод тав: 1. **өөрийн-оршихуй**-н үзэл (*sakkāyadiṭṭhi*); 2. **эргэлзээ-тээнэгэлзээ** (*vicikicchā*); 3. ёс заншил, зан үйлд автахуй (*sīlabbata-parāmāsa*); 4. **мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл** (*kāmacchando*); 5. **хар-санаа** (*vyāpādo*); Дээд тав: 6. **Нарийн-биеийн Орон**-ы **дур-хүсэл** (*rūparāgo*); 7. **Бие-бусын Орон**-ы **дур-хүсэл** (*arūparāgo*); 8. бардамнал, өөрийгөө бусдаас ялгахуй (*māna*); 9. сэтгэлийн түгшүүр (*uddhacca*); 10. **мунхаг-төөрөгдөл** (*avijjā*). Гэгээрлийн дөрвөн зэргийг хэмжих хэмжүүр болно.

Таван Хүч—*pañca balāni*. (1. **итгэл-үнэмшил**; 2. эрч хүч; 3. **дүүрэн-анхаарал**; 4. **самади-төвлөрөл**; 5. **саруул-ухаан**)

Таван Чадвар—*pañcindriyāni*. (1. **итгэл-үнэмшил**; 2. эрч хүч; 3. **дүүрэн-анхаарал**; 4. **самади-төвлөрөл**; 5. **саруул-ухаан**)

таван-саад—*nīvaraṇa*. Үгчилбэл, "саад тотгор". Таван-саад: 1. **хүсэл-мөрөөсөл**; 2. **хар-санаа**, **уур-хилэн**; 3. **хойрго-нойрмог**; 4. **түгшүүр-зовнил**; 5. **эргэлзээ-тээнэгэлзээ**. (DN 2.4.10-г үз.)

таван-цул—*pañcakhandhā.* (цул: па. *khandhā*, сам. *skandhas*). Тайлбарт үз.

танин-мэдэхүй—*saññā* (сам. *saṃjñā*). Ухаан мэдээ, ой санамж, ухаан мэдлэг, танихуй, ойлгохуй г.м. утга. Танин-мэдэхүй нь **таван-цул**-ын нэг. Мөн ялгамжаатай орон ертөнц (дараа төрөл авах), зарим бясалгалын түвшин болон аргачлалын нэр томьёонд хэрэглэгдэнэ. Жиш: 1. "танихуй-бүхий" (*saññī*); 2. "танихуй-үгүй" (*asaññī*); 3. "танихуй-бүхий танихуй-үгүй хавсарсан" (*saññī ca asaññī ca*); 4. "танихуй-

бүхий танихуй-үгүй аль нь ч бус” (*nevasaññī nāsaññī*). Зарим хэсэгт “ой санамж” гэж оруулав. (Тайлбарт буй Таван-Цул; DN 1.4; DN 9; DN 15.5/6-г үз.)

танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус—*nevasaññīnāsaññī*. **Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орон**-ыг үз.

Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орон—*nevasaññānāsaññāyatana*. **Бие-бусын Орон**-уудын хамгийн дээд орон (**танихуй-бүхий** эсвэл **танихуй-үгүй** аль нь ч биш төлөв байдалтай орших бодгалиудын). Хамгийн дээд даяан буюу **бие-бусын даяан**-ыг *(arūpa jhāna* эсвэл *samāpatti*) нэгэнт оршоосноор хүрнэ. Энэ бодгалиуд бие-дүрсгүй, танин-мэдэхүй гэх зүйлгүй, ухаан мэдээгүй шахам төлөвт 84 000 их галавын турш оршино (Abh; DA).

танихуй-бүхий—*saññī*. **танин-мэдэхүй**-тэй; ой санамжтай, ухаан мэдээтэй, мэдлэг ухаантай, танихуйтай, ойлгохуйтай; (DN 1.4; DN 9; DN 15.5/6-г үз.)

Танихуй-Үгүйн Орон—*asaññasattāyatana*. IV **даяан**-ыг оршоосноор хүрэх ба энэ ертөнцөд буй бодгалиуд **бие-дүрст** боловч тэдэнд **танин-мэдэхүй** гэж үгүй юм. Тэд энэ төлөвт 500 их галав (*mahākappa*)-ын турш оршино гэж үздэг (AN 4.123). Энэ нь мөн бясалгалын төлөв болно (DN 1.4; DN 9; DN 15.5/6-г үз.)

танихуй-үгүй—*asaññī*. **танин-мэдэхүй** үгүй; санамжгүй, ухаан мэдээгүй, мэдлэг ухаангүй, танихуй байхгүй, ойлгохуй байхгүй; (DN 1.4; DN 9; DN 15.5/6-г үз.)

төв-оршихуй—*upekkha* (анг. *equanimity, neutrality*). Таатай ч биш, таагүй ч биш мэдрэмж, байдал; төлөвгүй төлөв; “төв сэтгэл”; (DN 2.4.13 үз.)

төгс гэгээрлийг олох—**Төгс Гэгээрсэн Нэгэн** болох гэсэн санаа.

Төгс Гэгээрсэн Нэгэн—*arahant*. (анг. *perfected one*; сам. *arhat*). **Арахант**; Төгс Гэгээнтэн. Төгс Гэгээрлийг олсон нэгэн. Гэгээрлийн дөрвөн зэргийн дээд зэрэг. Арахант нар бол Будда биш боловч Гэгээрлийн түвшнийхээ хувьд Буддатай дүйхүйц зэрэг. Харин Будда нар бол бүгд Арахант буюу Төгс Гэгээрсэн Нэгэн юм. Энэ утгаараа Готама Будда бол Будда бөгөөд мөн Арахант юм. Будда нар тун ховор буюу тэрбум тэрбумаар тоологдох галавт ховорхон нэг төрдөг бол, харин Арахант гэдэг нь та бид энэ насандаа Сахил болон Сургаалыг дагаснаар, чухам өөрийн хичээл зүтгэлээр хүрч болох Гэгээрлийн дээд зэрэг.

Төгс Сэрсэн Будда—*Sammāsambuddha* (сам. *Samyaksambuddha*). Мартагдсан байх Гэгээнтний Дөрвөн Үнэнийг дахин илрүүлэн, өрөөл бусдад энэ замналыг заасан Будда. (Дэлгэрэнгүйг Тайлбарт буй Будда-д үз.)

төгсгөл—*nirodha*. “Төгсгөл болохуй”, “үгүй болохуй”, Гэгээрлийг олохуйтай дүйцэх утга. (Тайлбарт Нирваан хэсгийг үз.)

төрөхүй—*jāti* (анг. *birth* эсвэл *rebirth*). Энэ хорвоод, ямар нэгэн төрөлд төрөх, мэндлэх буюу **үхэх-төрөхийн эргэлт**-д “дахин төрөх” (Энэ хорвоод төрж буй бүхэн ямар нэг төрөлд үхсэнээр, өөр нэг төрөлд дахин төрж буй тул), төрөл авах. (DN 1.5.3; DN 15.1; DN 22.4.6; Тайлбарт дэлгэрэнгүй үз.)

төөрөгдөл—*moha*. **мунхаг-төөрөгдөл**-ийн илрэл буюу тусгүй-муу үйлийг хийхэд гол шалтгаан нөхцөл болдог, сэтгэлийн гүний төөрсөн, андуурсан, сохорсон байдал. Арван **сэтгэлийн-хир**-ийн нэг болно.

тунгалаг-оюун—*sampajāno, sampajañña* (анг. *clear comprehension*). Аливааг бүрэн сэрэмжтэйгээр, эрүүл ухаантайгаар, саруул тунгалгаар харах, тийм баримжаатай байх; бясалгагч өөрийн бие, сэтгэлийн үйлээ Гэгээрэл өөд чиглэсэн зорилготойгоо уялдуулан саруул-ухаанаар, тунгалаг оюунаар илтэд харах байдал. Зарим орчуулгад "нөхцөл байдлын сэрэмж" (анг. *situational awareness*. BS). (DN 2.4.8-г үз.)

тусгүй-муу—*akusala*. **Нирваан**-ыг ухаарах замналд тусгүй муу, саад үүсгэхүйц, хор хөнөөлтэй.

тустай-сайн—*kusala*. **Нирваан**-ыг ухаарах замналд хэрэг тустай, үр өгөөжтэй, сайн нөлөөтэй.

түгшүүр-зовнил—*uddhaccakukkucca*. *uddhacca*—сэтгэлийн түгшүүр; *kukkucca*—сэтгэл зовнил.

Урсгалд Орогч—*Sotāpanna*. Гэгээрлийн дөрвөн зэргийн эхний түвшин буюу доод 3 **сэтгэлийн-хүлээс**-ийг устгасан, үхлийн дараа хүмүүний төрлөөс доош муу төрлийг дахин авахгүй, ирэх долоон төрөлдөө амжиж **Нирваан**-д одох гэгээнтэн.

уур-хилэн—*dosa*. Түлхэх, зайлуулах хандлага, дургүйцэл, ааг омог бүхий байдал. Арван **сэтгэлийн-хир**-ийн нэг.

'Ухамсар хязгааргүй.'—*'anantaṁ viññāṇan'*. "Ухамсар бол хязгаар үгүй." хэмээн оюундаа оршоон бясалгахуйг хэлсэн болно.

Учир Хамааралтай Уг Гарал Сургаал—*Paṭiccasamuppādo* (сам. *Pratītyasamutpāda*). (DN 15-г үз.)

Үзэгдэл-шинжихүй—*dhammavicaya*. **Сургаал** номын нүдээр задлан шинжихүй, ухан харахуй. (Юмс, Үзэгдэл, Жам, Сургаалыг, Туйлын Үнэнийг үүнд хамруулж ойлгоно.)

үзэл—*diṭṭhi*. Аливаа зүйлийн талаарх ямар нэг байр суурь, үзэл бодол, итгэл үнэмшил. Үзэлд автах гэдэг утгад DN 1-д гарах жаран хоёр буруу үзлийг гол төлөв хэлнэ.

үйл, үйлдэл—*kamma* (сам. *karma*). Бие, хэл, сэтгэлээр үйлдэх ямар нэг үйлдэл.

үйлийн үр—*kamma-vipāka* (сам. *karma-vipāka*). Бие, хэл, сэтгэлээр үйлдэх нэгж үйлдэл болгон үр дагавар үүсгэх ба зөвхөн тухайн үйлийн сэдлээс хамааран сайн, эсвэл муу үр дагаврыг бий болгоно. Эртний Буддизмд, үйлийн үрийн гол үндэс суурь, шалтгаан нөхцөл нь тэр үйлийг хийсэн тухайн зорилго, сэдэл, санаархал нь хамгийн чухалд тооцогдоно.

Үйлийн Үрийн Хууль—*kamma-niyāma* (анг. Law of Karma). Бие, хэл, сэтгэлээр үйлдэх үйлдэл болгон үр дагавар үүсгэх бөгөөд тухайн үйлийн зөвхөн зорилго, сэдлээс хамааран сайн, эсвэл муу үр боловсордог энэ орчлонгийн жам ёс. Энэ жам ёсыг энэ хорвоогийн ямар нэг бодгаль, бурхан, Тэнгэр удирдан залах боломжгүй. Гагцхүү удирдан залж буй зүйл нь бидний сэтгэл буюу сэдэл болно.

Үнэн—*Dhamma, saccā*. (Тайлбарт үз.)

үнэн-ном—*saddhamma*. Өөрөөр "сайны ном". Будда чухам өөрөө зааж сургасан, элдэв хольц ороогүй, үнэн зөв, өгөөжтэй сайн тэр Сургаал.

үр-дагавар—*ādīnavā*. Үгчилбэл, "аюул, хөнөөл". Хийсэн буруу үйлээс үүсэх "аюул хөнөөл", "муу үр дагавар", "сул тал".

үхэх-төрөхийн эргэлт—*saṁsāra* (сам. *saṁsāra*). Үндсэн утга "хэрэн тэнэхүй", "хорвоогийн эргэлтээр тэнэхүй" буюу "дахин дахин үхэх, төрөхийн эргэлтээр явахуй". Там, өлсгөлөн-сүнс, амьтан, асура, хүмүүн, лус, бурхан, Тэнгэр г.м. олон янз төрөлд, үйлийн үрээр зогсолтгүй үхэж төрсөөр тэнүүчлэн явахуйн эргэлт. *Saṁsaranti*—"үхэх-төрөхийн эргэлтээр тэнэхүй".

хамрын-ухамсар—*ghānaviññāṇa*. **оюун-ухамсар**-ыг үз.

хар хүн—*gahapati*. Сахилтан бус, гэр оронтой, гэр бүлтэй, ахуй амьдралтай, ажил төрөлтэй хүн; **гэр оронтой хүмүүн**.

хар-санаа—*byāpāda*. Бусдад мууг хүсэх, хор хүргэх, эс хайрласан, дайсагнасан, атгаг муу, хилэнт сэтгэл санаа.

хийд—*ārāma*. Хуврагуудын амьдрах хийд, газар, цэцэрлэгт хүрээлэн, парк.

хойрго-нойрмог—*thīnamiddha* (*thīna*—залхуу, хойрго байдал; *middha*—нойрмог, лазан, унжгар байдал).

хорвоо ертөнц—*loka*. Хорвоо, дэлхий, ертөнц, сансар огторгуй г.м.

харгис-санаа—*vihiṃsa*. Бусдад хор хүргэх, хүч хэрэглэх, гэмтээх, хохироох, харгис балмад сэтгэлийн төлөв байдал.

хөөр-баяр аз-жаргал бүхий—*pītisukha*. "Үгээр хэлэхийн аргагүй" аз жаргал гэсэн санаа буюу бясалгалаас үүсэх дээд зэргийн баяр баясал, аз жаргалантай байдал. Зарим бясалгалын уламжлалд тайлбарладгаар, бясалгагч энэ үед их хэмжээний баяр хөөрийг мэдэрснээс үүдэн асгартал уйлах нь элбэг гэдэг. **хөөр-баяр**, **аз-жаргал**-ыг тус тус үз. (DN 2.4.11-4.14 үз.)

хөөр-баяр—*pīti* (анг. *rapture* эсвэл *bliss*). I, II **даяан**-д үүсэх, мөн тустай сайн үйлээс үүсэх дээд зэргийн баяр хөөр. Аз-жаргалтай харьцуулбал хөнгөн шинж чанартай боловч "**хөөр-баяр аз-жаргал**" гэж хамтдаа хэрэглэгдэж байгаа тохиолдолд, "үгээр хэлэхийн аргагүй" аз жаргал гэсэн санааг илтгэнэ.

Хураангуй Дүрэм—*Pāṭimokkha* (сам. *Prātimokṣa*). Буддад шавь орж, хуврагийн дээд сахил авсан хүний дагах ёстой, гэгээрэлд хүргэхэд нэн тустай, 227 зүйл бүхий сахил-ухамсар, ёс зүйн дүрэм.

хүрд-эргүүлэгч хаан—*rañño cakkavattissa*. Энэ хаан бол хүчээр биш, харин Сургаалаар дэлхийг захирдаг нинжин сэтгэлтэй, зөв шударга хаан юм. Түүний засаглал нь түүний хаант улсад амар амгалан, хөгжил цэцэглэлт, ёс суртахууны дэг журмыг авчирна.

хүрд-эргүүлэгч—*cakkavatti*. Үгчилбэл, "дугуйг эргүүлэгч" боловч дугуй (хүрд) нь эзэнт гүрэн ба зөв шударга ёсны бэлгэдэл юм. Хүрд-эргүүлэгч нь хүчээр бус, ёс суртахуун болон Сургаал номын дагуу дэлхийг энх тайвны аргаар байлдан дагуулж, захирдаг их хаан бөгөөд ард олноо арван буяны үйлийг дагахыг уриална. Улс орон нь амгалан болно.

хүсэл-мөрөөсөл—*abhijjha*. Бусдын эд зүйл, эзэмшлийг хүсэх, шунах хэлбэрийн сэтгэл (ихэвчлэн сөрөг утгаар хэрэглэгдэнэ). **таван-саад**-ын нэгд орно.

хүсэл-цангаа—*taṇhā*. Үүнд: 1. мэдрэхүйн хүсэл-цангаа (*kāma-taṇhā*)—таван мэдрэхүйгээр мэдэрч болох зүйлийн хүсэл; 2. оршихуйн хүсэл-цангаа (*bhava-taṇhā*)—ямар нэг төрөл авах, эсвэл хэн нэгэн

болох хүсэл; 3. эс оршихуйн хүсэл-цангаа (*vibhava-taṇhā*)—дахин төрөл авахгүй байх эсвэл оршихгүй байх хүсэл орно.

хүсэл-эрмэлзэл—*chando*. Эерэг, сөрөг аль ч утгатай байж болох, нэгэн зорилго руу чиглэсэн хүсэл эрмэлзэл. (Сургаал номыг сурах ойлгох хүсэл-эрмэлзэл г.м.)

хүсэл шунал—*lobha*. **шунал**-ыг үз.

хэлний-ухамсар—*jivhāviññāṇa*. **оюун-ухамсар**-ыг үз.

хязгааргүй—*ananta* (анг. *infinite* эсвэл *unlimited*). Өөрөөр "хүрээ хязгааргүй", "эцэс төгсгөлгүй", "хэмжээлшгүй" г.м. орон зайн ойлголт.

хязгаартай— *anta* (анг. *finite* эсвэл *limited*). Өөрөөр "хүрээ хязгаартай", "эцэс төгсгөлтэй", "хэмжээтэй" г.м. орон зайн ойлголт.

Хязгааргүй Орон Зайн Орон—*ākāsānañcāyatana*. **Бие-бусын Орон**-ы нэг, ертөнцийн дээрээсээ 4 дэх зиндааны Тэнгэрийн орон; бясалгалын Хязгааргүй Орон Зайн Орны **даяан**. (**бие-бусын даяан**-ыг үз.)

Хязгааргүй Ухамсрын Орон—*viññāṇañcāyatana*. **Бие-бусын Орон**-ы нэг, ертөнцийн дээрээсээ гурав дахь зиндааны Тэнгэрийн орон; бясалгалын Хязгааргүй Ухамсрын **даяан**. (**бие-бусын даяан**-ыг үз.)

чандлал-хатамжлал—*saṁvara* (сам. *saṃvara*). **мэдрэхүй**-н хатуу хяналт, хамгаалан сахих; санваар; (DN 2.4.7-г үз.)

чихний-ухамсар—*sotaviññāṇa*. **оюун-ухамсар**-ыг үз.

Чөтгөр—**Маара**-г үз.

Чуулган—*Saṅgha*. Хуврагийн Чуулган; тухайн хийдийн нийт хуврагууд. (Тайлбарт дэлгэрэнгүй үз.)

шунал—*lobha*. Сэтгэлийн гүнд буй хүсэл, шунасан сэтгэл. Зарим тохиолдолд "хүсэл шунал" гэж оруулав.

шууд-билгүүн—*abhiññā*. Өөрөөр, "дээд мэдлэг", "шууд ухаарсан мэдлэг", "төгс ухаарал" г.м. Үндсэн утга нь эгэл танин мэдэхүйгээс хальсан, гэгээрлийн мөчид өөрийн биеэр шууд ухаарсан мэдлэг, ухаарал. Паали Судартг, тэр тундаа Будда болон Арахантуудын гэгээрлийг "*sayaṁ abhiññā sacchikatvā*" буюу "өөрийн биеэр шууд-билгүүнийг ухаарснаар" хэмээн, энэ үгээр хэрхэн гэгээрдгийг тодорхойлон хэлсэн байна. Англи орчуулгад "шууд мэдлэг" (анг. *direct knowledge,* BB), "ухаарал" (анг. *insight*, BS), "Төгс Билгүүн" (анг. *Perfect Wisdom*, MPA). Мьянмарын уламжлалд **ид-чадал**, зөн билэг гэж үзэж, тайлбарлах хандлага байна.

эгэл жирийн хүн—*puthujjano*. Гэгээрээгүй хүмүүс; **сэтгэлийн-хүлээс**-ээс салаагүй хүн; гэгээрээгүй хүмүүсийг нэрлэдэг тогтсон нэршил нь.

эргэлзээ-тээнэгэлзээ—*vicikiccha*. Будда, Сургаал, Гэгээрсэн хуврагууд, **Гэгээнтний Дөрвөн Үнэн**, **үйлийн үр**, **Учир Хамааралтай Уг Гарал Сургаал**, **Гэгээнтний Найман Замнал** зэрэгт үл итгэх, эргэлзэх, тээнэгэлзэх байдал гэж Эртний Буддизмд үздэг.

эргэцүүлсэн-бодол бүхий—*savicāraṁ*. **эргэцүүлсэн-бодол**-ыг үз.

эргэцүүлсэн-бодол—*vicāra*. (анг. *sustained thought* эсвэл *sustained application*). Оюун санаанд ямар нэг эргэцүүлсэн, тунгаасан бодол, санаа, мэдрэмж төрөхүй; ямар нэгэн зүйлийг эргэцүүлэх, тунгаах, бодох.

Эрхэм Багш—*bhante, āyasmā* (анг. *venerable sir*, сам. *bhadanta/bhavantaḥ, āyuṣmant*). Өөрөөр, "Эрхэм... та", "Эрхэм хүндэт..." (хувраг нэр).

язгуур дөрвөн махбод—*cātumahābhūta*. **дөрвөн язгуур махбод**-ыг үз.

ИНДЕКС

Энд Паали цагаан толгойн дараалаар бус Латин цагаан толгойн дараалаар жагсаав.

Ābhassara (“Урсгал Туяаны Орон”)—DN 1.3.2; DN 15.5.
Abhibhāyatanāni (“төгөлдөр оюуны орон”)—DN 16.18.
Abhijjha (“хүсэл-мөрөөсөл”)—олон (DN).
Abhiññā (“шууд-билгүүн”)—олон (DN).
Abrahmacariya (“ариун-бус явдал”)—DN 1.2.1; DN 2.4.4; DN 9.1.2.
Abyāsekasukha (“бохирдоогүй аз-жаргал”)—DN 2.4.7; DN 9.1.2.
Adhiccasamuppannikā (“санамсаргүй үүслийн онолчид”)—DN 1.3.5.
Ādīnavā (“үр-дагавар”)—олон (DN).
Adinnādāna (“өгөөгүй зүйлийг авах”)—DN 1.2.1; DN 2.4.4; DN 9.1.2.
Ajātasattu (“Ажаатасатту”)—DN 2.
Ajita Kesakambala (“Ажита Кесакамбала”)—DN 2.
Ājīvaka (“аажийвака”)—DN 2.1; DN 16.38.
Ajjhattabahiddhā (“дотор гадар аль аль талаас нь”)—DN 22.
Ajjhattaṁ (“дотоод талаас нь”)—DN 22.
Ākāsa (“хийсвэр хөлөгт”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2.
Ākāsānañcāyatana (“Хязгааргүй Орон Зайн Орон”)—DN 1.4.4; DN 9.1.2; DN 15.5-6; DN 16.19/36.
Ākiñcaññāyatana (“Огт-Оргүйн Орон”)—DN 15.6; DN 16.19/36.
Akusala (“тусгүй-муу”)—DN 1.3.4; DN 2.4.7; DN 9.1.2.
Āḷakamandā (“Аалакамандаа”)—DN 16.32.
Āḷāra Kālāma (“Аалаара Каалаама”)—DN 16.25.
Allakappakā bulayo (“Аллакаппагийн була нар”)—DN 16.39.
Amanussānaṁ (“хүн бусаас”)—DN 28.1.4.
Amarāvikkhepa (“эцэс төгсгөлгүй салаа утгаар хариулагч”)—DN 1.3.4.
Ambagāmo (“Манго тосгон”)—DN 16.22.
Ambalaṭṭhikā (“Амбалаттхикаа”)—DN 16.3-4.
Ambapālī (“Амбапаалий”)—DN 16.10-12.
Ambavana (“манго төгөл”)—DN 2.1-2; DN 16.4/10/11/20/23/25; DN 28.1; DN 29.
Ājīvo (“амьжиргаа”)—олон (DN).
Anagāriya (“орон гэргүй”)—DN 2.4.1-3; DN 9.1.2/2.3; DN 16.34.
Ānandatthera (“Ахмад Хувраг Аананда”)—олон (DN).
Ānande cetiye (“Баясгалант Шүтээн”)—DN 16.22.
Anantaṁ (“хэмжээ хязгааргүй”)—DN 15.2-3 г.м.
Anantaṁ viññāṇan (“ухамсар хязгааргүй”)—DN 1.4.4; DN 9.1.2; DN 15.5/6; DN 16.19.
Anantavā (“хязгааргүй”)—DN 1.4.1 г.м.
Ananto ākāso (“орон зай хязгааргүй”)—DN 1.4.4; DN 9.1.2; DN 15.5/6; DN 16.19.
Anāthapiṇḍika (“Анаатхапиндика”)—DN 9.1.

Anattā ("өөрийн-оршихуй-бус")—олон (DN).
Anavajjasukhaṁ ("буруу нь үгүй аз-жаргал")—DN 2.4.6/7; DN 9.1.2.
Aniccā ("мөнхийн-бус")—олон (DN).
Antavā ("хязгаартай")—DN 1.3.3 г.м.
Anuruddha ("Ануруддха")—DN 16.36-38.
Ārācārī ("нүглээс алс буйд")—DN 1.2.1; DN 2.4.4; DN 9.1.2.
Arahant ("Төгс Гэгээрсэн Нэгэн/Арахант")—олон (DN).
Ārāma ("төгөл/хийд")—олон (DN).
Ariyā ("Гэгээнтэн")—олон (DN).
Ariyasāvako ("Гэгээрсэн шавь")—DN 16.10/30; DN 22.4.9; DN 31.
Ariyo Aṭṭhaṅgiko Maggo ("Гэгээнтний Найман Замнал")—DN 16.20-21/34; DN 28.1.1; DN 29.6 г.м.
Arūpa ("Бие-бус")—DN 1.4.1 г.м.
Arūpaloka ("Бие-бусын Орон")—Лавлах.
Arūpo attapaṭilābhā ("бие-бус хойд дүр")—DN 9.2.2.
Asaññasattā ("танихуй-үгүй бодгалиуд")—DN 1.3.5 г.м.
Asaññasattāyatana ("Танихуй-Үгүйн Орон")—DN 15.5 г.м.
Asaññī ("танихуй-үгүй")—DN 1.3.5 г.м.
Āsava ("оюуны-хорлол")—DN 2.4.22 г.м.
Asubha ("сайхан-бус")—DN 16.3.
Asura ("асура")—олон (DN).
Attā ("өөрийн-оршихуй")—олон (DN).
Attapaṭilābha ("хойд дүр")—DN 9.2.2.
Atthi kāyo ("Бие байна")—DN 22.1.1-6.
Ātumā ("Аатумаа")—DN 16.25.
Aveccappasādena ("итгэлийг өөрийн биеэр мэдэж олсон")—DN 16.10.
Avihiṃsa ("харгис-санаа үгүй")—DN 22.4.9 г.м.
Avijjā ("мунхаг-төөрөгдөл")—DN 2.4.22; DN 16 г.м.
Āyasmā ("Эрхэм Багш")—DN 16.35 г.м.
Bahiddhā ("гадаад талаас нь")—DN 22.
Balaggaṁ ("цэргийн бэлтгэл")—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2.
Bandhujīvaka ("Бандуживака")—DN 16.18.
Bhagavā ("Ерөөлтэй Нэгэн")—олон (DN).
Bhaṇḍagāma ("Бханда тосгон")—DN 16.21.
Bhante ("Эрхэм Багш")—олон (DN).
Bhavābhava ("тийм сайн дараа төрлийг авсан...")—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2.
Bhava ("оршихуй")—DN 1.5.3; DN 15.1 г.м.
Bhikkhu ("хувраг")—олон (DN).
Bhinnathūpe ("нурсан суваргатай")—DN 29.

Bhoganagaraṁ (“Бхога хот”)—DN 16.22/23.
Bhonto, bhadanta (“лам багш”)—DN 1.2.2 г.м.
Bhūrivijjā (“шороон байшинд суугчдын тарни шившлэг”)—DN 1.2.3; DN 2.4.6; DN 9.1.2.
Bhusāgāre (“Чимэгт Өргөө”)—DN 16.25.
Bhūtavijjā (“гүйдэл, дайрлага”)—DN 1.2.3; DN 2.4.6; DN 9.1.2.
Bodhisatta (“Ирээдүйн-Будда”)—DN 16.16.
Brahmacārī (“ариун-явдалт нэгэн”)—DN 1.2.1; DN 2.4.4; DN 9.1.2.
Brahmāsahampati (“Бярман Тэнгэр Сахампати”)—DN 16.36.
Byāpāda (“хар-санаа”)—DN 2.4.10 г.м.
Cakkavatti (“хүрд-эргүүлэгч”)—DN 16.36; DN 26.
Cakkhuṁ loke (“Мэлмий”)—DN 16.27.
Cakkhuviññāṇa (“нүдний-ухамсар”)—DN 22.4.7 г.м.
Caṇḍālaṁ vaṁsaṁ dhovanaṁ (“үхэгсдийн ясыг угаах зан үйл”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2.
Candanacuṇṇāni (“Зандан”)—DN 16.26.
Cāpāla cetiya (“Каапаала бунхан”)—DN 16.13.
Cattāri ariyasaccā (“Гэгээнтний Дөрвөн Үнэн”)—DN 16.8 г.м.
Cattāro iddhipādā (“дөрвөн ид-чадал”)—DN 16.20 г.м.
Cattāro sammappadhānā (“дөрвөн зөв чармайлт”)—DN 16.20 г.м.
Cattāro satipaṭṭhānā (“дүүрэн-анхаарал суулгах дөрвөн бясалгал”)—DN 22 г.м.
Cātumahābhūta (“язгуур дөрвөн махбод”)—DN 1.4.4; DN 2.3.3/4.15; DN 22.1.5 г.м.
Cātummahārājā (“Агуу Дөрвөн Хаадын Орны”)—DN 16.17.
Cetayamāno (“санаа сэдэл”)—DN 9.1.2 г.м.
Cetopariyañāṇāya (“бусдын сэтгэлийг таних мэдлэг”)—DN 2.4.19.
Chando (“хүсэл-эрмэлзэл”)—DN 1.3.4 г.м.
Channa (“Чанна”)—DN 16.35.
Ciṅgulika (“салхин сэнс”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2.
Citta, Ceto (“сэтгэл”)—олон (DN).
Cunda (“Чунда”)—DN 16.23/25; DN 29.
Dabbihoma (“цацлаар”)—DN 1.2.3; DN 2.4.6; DN 9.1.2.
Daḷhanemi (“Далханеми”)—DN 26.2.
Dasasahassī (“арван мянган”)—DN 1.5.4 г.м.
Dasasu lokadhātūsu (“арван нарны аймгийн”)—DN 16.27 г.м.
Devā (“бурхад”)—олон (DN).
Devā ābhassarā (“Урсгал Туяаны Орон”)—DN 15.5 г.м.
Devā subhakiṇhā (“Үзэсгэлэнт Туяаны Орон”)—DN 15.5 г.м.
Dhamma (“Сургаал”)—олон (DN).
Dhammacakkaṁ (“Номын-хүрд”)—DN 16.28 г.м.
Dhammacakkhuṁ uppajjissathā (“Номын-Нүд нээгдэх”)—DN 2.5.

Dhammānusārī (“Сургаалын мэдлэг чармайлтаар гэгээрсэн нэгэн”)—DN 28.1.6.
Dhammavicaya (“Үзэгдэл-шинжихүй”)—DN 16.3; DN 22.4.4; DN 28.1.7 г.м.
Dhammavinaya (“Сургаал, Сахил”)—DN 1.2.2 г.м.
Dibbāya sotadhātuyā (“тэнгэрлэг сонорын мэдлэг”)—DN 2.4.18.
Dibbena cakkhu (“тэнгэрлэг мэлмий”)—DN 2.4.21; DN 16.7; DN 28.1.14.
Domanassa (“зовнил-гуниг”)—DN 2.4.7; DN 9.1.2; DN 16.10-12; DN 22; DN 26.1/8.
Doṇo brāhmaṇo (“бярман Дона”)—DN 16.39.
Dosa (“уур-хилэн”)—DN 1.3.4 г.м.
Duggata (“муухай газар”)—DN 2.4.21 г.м.
Dukkha (“зовлон; зовлонтой”)—DN 22.4.6 г.м.
Ekodibhāvaṁ (“оюуны-нэгдэл”)—DN 2.4.12 г.м.
Evam me suttaṃ (“би ийн сонссон юм”)—олон (DN).
Gahapati (“хар хүн; гэр оронтой хүн”)—олон (DN).
Ghānaviññāṇa (“хамрын-ухамсар”)—DN 22.4.7 г.м.
Gijjhakūṭa (“Тас Шувуудын Оргил уул”)—DN 16 г.м.
Giñjakāvasatha (“Тоосгон Танхим”)—DN 16.9/10.
Gotamadvāraṁ (“Готамагийн Хаалга”)—DN 16.7.
Gotamatitthaṁ (“Готамагийн Гарам”)—DN 16.7.
Hatthigāmo (“Заан тосгон”)—DN 16.22.
Hatthisāriputta (“Хаттхисаарипутта”)—DN 9.2.
Heṭṭhimaṁ disaṁ (“доогуур зовхист”)—DN 31.
Hiraññavatiyā (“Алтан гол”)—DN 16.26.
Hirimanā, hiri (“ёс-зүйн-ичгүүр”)—DN 16.3.
Iddhi (“ид-чадал”)—DN 2.4.16-21 г.м.
Iddhipādā (“ид-чадлын дөрвөн үндэс”)—DN 2; DN 22 г.м.
Indriya (“мэдрэхүйн-чадвар”)—DN 2.4.7 г.м.
Indriyesu guttadvāro (“мэдрэхүйн үүдээ сахин хамгаалах”)—DN 2.4.3 г.м.
Jambudīpo (“замбуу тив”)—DN 26.7.
Jambugāmo (“Хар Чавга тосгон”)—DN 16.22.
Jāti (“төрөхүй”)—DN 15.1.2 г.м.
Jhāna (“даяан”)—DN 2.4.11 г.м.
Jīvakassa Komārabhaccassa (“Жийвака Комаарабхачча”)—DN 2.1.
Jivhāviññāṇa (“хэлний-ухамсар”)—DN 22.4.7 г.м.
Jūta (“мөрийтэй тоглоомууд”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2.
Kadalimiga (“кадали буга”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2.
Kāma (“мэдрэхүйн-таашаал”)—DN 1.4.5 г.м.
Kāmacchando (“мэдрэхүйн хүсэл-эрмэлзэл”)—DN 22.4.1.
Kāmāvacaro (“Мэдрэхүйн Орон”)—DN 1.4.4 г.м.

Kāmesumicchācārā (“садар самуун”)—DN 22.4.9; DN 26.2.2; DN 31.2.
Kamma (“үйлдэл”)—DN 1.3.4 г.м.
Kammāsadamma (“Каммаасадамма”)—DN 15; DN 22.
Kaṁsakūṭa (“хуурамч зоос”)—DN 1.2.1; DN 2.4.4; DN 9.1.2.
Kapilavatthu (“Капилаваттху”)—DN 16.39.
Kappa (“галав”)—DN 1.3.1 г.м.
Karuṇā (“энэрэл нигүүлсэл”)—DN 26.9 г.м.
Kāsāyāni (“зосон”)—DN 2.4.1/3; DN 9.1.2.
Kāyānupassī (“биеийн ажиглалттай”)—DN 22 г.м.
Kāyaviññāṇa (“биеийн-ухамсар”)—DN 22.4.7 г.м.
Kāya (“бие”)—олон (DN).
Ketumatī (“Кетуматий”)—DN 26.7.
Khattiya (“язгууртнуудязгууртнууд”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2 г.м.
Kilesā (“сэтгэлийн-хир”)—DN 2.4.15 г.м.
Koṭigāma (“Коти тосгон”)—DN 16.8.
Kudrūsaka (“шар будаа”)—DN 22.1.4; DN 26.5.
Kuru (“куручууд”)—DN 15; DN 22.
Kusala (“тустай-сайн”)—DN 1.3.4 г.м.
Kusāvatī (“Кусааватий”)—DN 16.32.
Kusinārā (“Кусинаараа”)—DN 16.23 г.м.
Labuja (“лабужа мод”)—DN 2.3.1-6.
Licchavī (“личчхавий”)—DN 16.11 г.м.
Lobha (“шунал”)—DN 26.4.
Loka (“хорвоо ертөнц”)—DN 1.3.1 г.м.
Lokadhātu (“дэлхий ертөнц”)—DN 1.5.4.
Mahābrahmā (“Бярман Дээд Тэнгэр”)—олон (DN).
Mahākassapatthera (“Ахмад Хувраг Махаакассапа”)—DN 16 г.м.
Mahāpanāda (“Махаапанаада”)—DN 16.38.
Mahāsudassana (“Махаасудассана”)—DN 16.32.
Makkhali gosāla (“Маккхали Госаала”)—DN 2.1/3.2.
Makuṭabandhana (“Макутабандхана”)—DN 16.37.
Mallaputto (“малла хүн”)—DN 16.25 г.м.
Mallikā (“Малликаа хатан”)—DN 9.1.
Mandāravapupphāni (“Мандарваа цэцэг”)—DN 16.26.
Mano (“оюун-ухаан”)—DN 1.3.2; DN 2.4.7 г.м.
Manomayā (“оюунаар-бүтсэн”)—DN 1.3.2/4.4; DN 2.4.16; DN 9.1.3/2.2.
Manomayaṁ kāyaṁ (“оюунаар-бүтсэн бие”)—DN 2.4.16.
Manomayo attapaṭilābhā (“оюунаар-бүтсэн хойд дүр”)—DN 9.2.2.

Manoviññāṇa (“оюун-ухааны-ухамсар”)—DN 22.4.7 г.м.
Māra (“Чөтгөр/Маара”)—DN 2.4.3 г.м.
Māro pāpimā (“Маара чөтгөр”)—DN 16.14 г.м.
Mātulā (“Маатулаа”)—DN 26.1.
Mettā (“ивээл хайр”)—DN 26.9 г.м.
Metteyya (“Меттейяа”)—DN 26.8.
Middham (“лазан”)—DN 2.4.10 г.м.
Moha (“төөрөгдөл”)—DN 2.4.19; DN 22.3; DN 28.1.10/11; DN 29.10 г.м.
Muditā (“өрөөлийн жаргалд баярласан”)—DN 26.9 г.м.
Nāḷandā (“Нааландаа”)—DN 16.4/5; DN 28.
Nāmarūpa (“бие-сэтгэл”)—DN 15.1/8-10.
Ñāṇa (“мэдлэг ухаарал”)—DN 9.1.2 г.м.
Nātika (“Наатика”)—DN 16.9-10; DN 29.
Natthi kiñcī (“оргүй хоосон”)—DN 1.4.4; DN 9.1.2; DN 15.5/6; DN 16.19.
Nerañjarā (“Неранжараа”)—DN 16.19.
Nevasaññānāsaññāyatana (“Танихуй-Бүхий Танихуй-Үгүй Аль нь ч Бусын Орон”)—DN 1.4.4; DN 15.6; DN 16.19/36.
Nevasaññīnāsaññī (“танихуй-бүхий танихуй-үгүй аль нь ч бус”)—DN 1.4.3 г.м.
Nibbāna (“Нирваан”)—DN 16 г.м.
Nibbida (“алмайрал-үгүй”)—DN 9.1.3-2.1; DN 28.9/13/14.
Nigaṇṭha nāṭaputta (“Нигантха Наатапутта”)—DN 2.1/3.5; DN 16.34; DN 29.
Nirodha (“төгсгөл”)—DN 9.1.2 г.м.
Nīvaraṇa (“таван-саад”)—DN 2.4.10; DN 9.1.2; DN 16.4; DN 22.4.1; DN 28.1.
Opapātikā (“аяндаа төрдөг бодгаль”)—DN 1.3.4 г.м.
Ottappī (“ёс-зүйн-айдас”)—DN 16.3 г.м.
Pabbajito (“сахилтан”)—DN 2.4.1 г.м.
Paccekabuddha (“Өөрөө Сэрсэн Будда”)—DN 16.30.
Pahāna (“орхин-одуулахуй”)—DN 16.3 г.м.
Pakudha Kaccāyana (“Пакудха Каччааяана”)—DN 2.1/3.4.
Pāṇabhūta (“амьтан”)—DN 2.4.10 г.м.
Pāṇātipāta (“амьд биетийн амийг таслах”)—DN 1.2.1; DN 2.4.4; DN 9.1.2.
Pañca balāni (“Таван Хүч”)—DN 16.20; DN 28.1.1; DN 29.6.
Pañcakhandhā (“таван-цул”)—DN 9.2; DN 22.4.2/6; DN 29.9/13.
Pañcindriyāni (“Таван Чадвар”)—DN 16.20; DN 28.1.1; DN 29.6.
Paññā (“саруул-ухаан”)—DN 16 г.м.
Paribbājaka (“бадарчин”)—DN 1.1 г.м.
Parimukhaṁ (“ам хамар орчимдоо”)—DN 22.1.1 г.м.
Parinibbāna (“Эцсийн Нирваан”)—DN 16 г.м.

Parisuddhājīvo (“амьжиргаа ариусаж”)—DN 2.4.3 г.м.
Parittaṁ (“хэмжээ хязгаартай”)—DN 15.2 г.м.
Passaddhakāyo (“биеийн амар-амгалан”)—DN 2.4.10.
Passaddhi (“амар-амгалан”)—DN 16.3; DN 22.4.4 г.м.
Pāṭaligāma (“Паатали тосгон”)—DN 16.5/7.
Pāṭaliputtaṁ (“Паатали Цайз”)—DN 16.7.
Paṭhamaṁ jhānaṁ (“нэгдүгээр даянд”)—DN 2.4.11 г.м.
Pathavīsaññiniyo (“дэлхийн талаарх танин-мэдэхүйтэй”)—DN 16.27.
Paṭiccasamuppādo (“Учир Хамааралтай Уг Гарал Сургаал”)—DN 15.
Paṭigho (“зөрчил-хорсол”)—DN 1.3.4 г.м.
Paṭikūla (“бохир”)—DN 22.1.4; DN 28.1.15.
Pāṭimokkha (“Хураангуй Дүрэм”)—DN 2.4.3; DN 9.1.2.
Patta (“бадрын аяга”)—олон (DN).
Pāvā (“Паваа”)—DN 16.38; DN 29.
Pāvārika (“Паваарика”)—DN 16.4; DN 28 г.м.
Petā (“Өлсгөлөн-Сүнс”)—олон (DN).
Phassa (“мэдрэхүйн-харилцаа”)—DN 1.5.2-4; DN 15.1/1.7/8; DN 22.4.3/4.7/8; DN 28.1.2.
Phassāyatana (“мэдрэхүйн-харилцааны хүрээ”)—DN 1.5.3/4 г.м.
Piṇḍapāta (“бадар барих”)—олон (DN).
Pippalivaniyā moriyā (“Пиппаливанагийн морияа нар”)—DN 16.39.
Pīti (“хөөр-баяр”)—DN 1.3.2/4.5; DN 2.4.10-13 г.м.
Pītisukha (“хөөр-баяр аз-жаргал”)—DN 2; DN 22 г.м.
Puñña (“буян”)—DN 1.3.2; DN 2.3 г.м.
Pūraṇa Kassapa (“Пуурана Кассапа”)—DN 2.1/3.1; DN 16.34.
Puthujjano (“гэгээрээгүй хүн”)—DN 1.2.1 г.м.
Rāga (“дур-хүсэл”)—DN 1.3.4 г.м.
Rājagaha (“Раажагаха”)—DN 1.1; DN 2.1/2; DN 16; DN 31.
Rāmagāmakā koḷiyā (“Раама тосгоны колияачууд”)—DN 16.39.
Rañño cakkavatti (“хүрд-эргүүлэгч хаан”)—DN 16.29-31/37; DN 26.
Rukkhamūlaṁ (“модны хонгил”)—DN 2.4.10; DN 9.1.2; DN 22.
Rūpaloka (“Нарийн-биеийн Орон”)—Лавлах.
Rūpī (rūpa) (“Бие-дүрст”)—DN 1.4.1 г.м.
Sabrahmacārī (“ариун-сахилтан”)—DN 16.3; DN 29.5/7 г.м.
Saddhā (“итгэл-үнэмшил”)—DN 16.3 г.м.
Sādhū (“Оновчтой хэллээ!”)—DN 29.7 г.м.
Sakadāgāmī (“Нэгэнтээ Эргэн Ирэгч”)—DN 16.9; DN 28.1.10/11; DN 29.10.
Sakko devānamindo (“Бурхдын Хаан Сакка”)—DN 16.36.
Sāla (“Сал”)—DN 16.36 г.м.

Samādhi (“самади-төвлөрөл”)—DN 2.4.10-14 г.м.
Samaṇo Gotamo (“даянч Готама”)—DN 1.2.1 г.м.
Samaṇuddeso (“сурагч”)—DN 29 г.м.
Sambojjhaṅga (“гэгээрлийг-амирлуулагч”)—DN 16.3/4/20; DN 22.4.4; DN 28.1; DN 29.6.
Sammāsambuddha (“Төгс Сэрсэн Будда”)—олон (DN).
Sampajañña, Sampajāno (“тунгалаг-оюун”)—DN 2.4; DN 22 г.м.
Sampasādana (“дотоод амар-амгалан”)—DN 2.4.12 г.м.
Saṁsāra (“үхэх-төрөхийн эргэлт”)—DN 1.3.1; DN 2.3.2; DN 15.1; DN 16.8/20/21; DN 28.1.12.
Saṁvara (“чандлал-хатамжлал”)—DN 2.4.7; DN 29.8 г.м.
Saṃyojana (“сэтгэлийн-хүлээс”)—DN 16.9 г.м.
Saṅgaṇikā (“андлал нөхөрөл”)—DN 16.3 г.м.
Saṅgha (“Чуулган”)—олон (DN).
Sañjaya Belaṭṭhiputta (“Санжаяа Белаттхипутта”)—DN 2.1/3.6; DN 16.34.
Saṅkappa (сэдэл)—DN 22.4.9.
Saṅkha (“Санкха”)—DN 26.7.
Saṅkhāra (“сэдэхүй-цогцлохуй”)—DN 16.20/27/35/36/38; DN 22.4.2/6-8.
Saṅkhatā (“сэдэгдсэн-цогцолсон”)—DN 15.4; DN 16.20/31/36/38.
Saññā (“танин-мэдэхүй”)—DN 1.4.1 г.м.
Saññī (“танихуй-бүхий”)—DN 1.4.1 г.м.
Santi/Santaṁ (“амгалан”)—DN 16 г.м.
Saraṇaṃ gacchāmi (“нөмөрт очиж байна”)—DN 2.5 г.м.
Sārandada cetiya (“Саарандада бунхан”)—DN 16.2/13/20.
Sāriputta (“Саарипутта”)—DN 16.4; DN 28 г.м.
Sarīrāni (“чандар”)—DN 16.38.
Sassatavādā (“Мөнх үзэл”)—DN 1.3.1 г.м.
Sati (“дүүрэн-анхаарал”)—DN 2; DN 22 г.м.
Satipaṭṭhānā (“дүүрэн-анхаарал суулгах”)—DN 22 г.м.
Satisampajañña (“дүүрэн-анхаарал тунгалаг-оюун”)—DN 22 г.м.
Sato sattassa (“амьд биет”)—DN 1.4.4 г.м.
Sattā (“бодгаль”)—олон (DN).
Satta ratana (“долоон эрдэнэ”)—DN 26.2.
Sattasambojjhaṅga (“Долоон Гэгээрлийг-Амирлуулагч”)—DN 16; DN 22 г.м.
Sāvakasaṅgho (“шавь нарын чуулган”)—DN 16.10.
Sāvatthī (“Сааваттхий”)—DN 9.1; DN 16.32.
Savicāraṁ (“эргэцүүлсэн-бодол бүхий”)—DN 2.4.11 г.м.
Savitakkaṁ (“зурвас-бодол бүхий”)—DN 2.4.11 г.м.
Sīhanādo nadito (“агуу тунхаглалыг тунхаглав”)—DN 16.4; DN 28.
Sīla (“сахил-ухамсар”)—DN 1.2; DN 2.4.4-6 г.м.

Sotāpanna (“Урсгалд Орогч”)—DN 16.9 г.м.
Sotaviññāṇa (“чихний-ухамсар”)—DN 22.4.7-8.
Subhadda (“Субхадда”)—DN 16.34.
Sugate (“сайхан газарт”)—DN 2.4.21 г.м.
Sugata (“Зөвөөр Одогч”)—DN 16.20 г.м.
Sūkaramaddava (“зөөлрүүлж чанасан гахайн мах”)—DN 16.23.
Sukha (“аз-жаргал”)—олон (DN).
Susānaṁ (“оршуулгын газар”)—DN 2.4.10 г.м.
Sutta (“яриа, заавар, хичээл”)—олон (DN).
Taṇhā (“хүсэл-цангаа”)—DN 15 г.м.
Tāvatiṁsa (“Гучин Гурван Тэнгэрийн Орон”)—DN 16.7/11/17.
Thera (“ахмад хувраг”)—DN 16.27 г.м.
Thīnamiddha (“хойрго-нойрмог”)—DN 2.4.10 г.м.
Tiracchānakathā (“дэмий яриа”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2 г.м.
Ucchedavādā (“Мөхлийн Үзэл”)—DN 1.4.4.
Udāyī (“Удааеий”)—DN 28.2.
Udāyibhadda (“Удааеибхадда”)—DN 2.3.
Uddaka Rāmaputta (“Уддака Раамапутта”)—DN 29.5.
Uddhaccakukkucca (“түгшүүр-зовнил”)—DN 2.4.10; DN 9.1.2; DN 22.4.1.
Upādāna (“дон-шунал”)—DN 1.5.3; DN 15 г.м.
Upālitthera (“Ахмад Хувраг Упаали”)—Танилцуулга үз.
Upasama (“амгаланг-олохуй”)—DN 9.1.3; DN 28.9/13/14.
Upavāṇatthera (“Ахмад хувраг Упаваана”)—DN 16.27.
Upavattana (“Упаваттана төгөл”)—DN 16.25-27/33-37.
Upekkha (“төв-оршихуй”)—DN 2.4.13 г.м.
Uposatha (“упосатха”)—DN 2.1.
Uruvelā (“Урувелаа”)—DN 16.19.
Vajjī (“важжий”)—DN 16.
Varanasi (“Варанаси”)—DN 16.18/32; DN 26.7.
Vāseṭṭha (“ваасеттхачууд”)—DN 16.32-38.
Vassa (“борооны улирлын бясалгал”)—DN 16.12/28; DN 29.
Vatthāni (“орхимж”)—олон (DN).
Vedanā (“мэдрэмж”)—DN 15; DN 22 г.м.
Veḷuvagāmako (“Велува тосгон”)—DN 16.12.
Vesālī (“Весаалий”)—DN 16 г.м.
Veṭṭhadīpako brāhmaṇo (“бярман Веттхадийпака”)—DN 16.39.
Vicāra (“эргэцүүлсэн-бодол”)—DN 2.4.11 г.м.
Vicikiccha (“эргэлзээ-тээнэгэлзээ”)—DN 2.4.10 г.м.

Viggāhikakathā (“ном хаялцах”)—DN 1.2.2; DN 2.4.5; DN 9.1.2 г.м.
Viharati (“оршин байна”)—олон (DN).
Vihiṃsa (“харгис-санаа”)—DN 22.4.9 г.м.
Vimutta/Vimutti (“ангижрал”)—DN 2; DN 15; DN 16 г.м.
Vinaya (“Сахил”)—DN 1.2.1 г.м.
Vinayavādī (“сахил номын багш”)—DN 1.2.1 г.м.
Viññāṇa (“оюун-ухамсар”)—DN 2.4.15; DN 15 г.м.
Viññāṇañcāyatana (“Хязгааргүй Ухамсрын Орон”)—DN 1.4.4; DN 9.1.2; DN 15.5-6; DN 16.19/36.
Virāga (“салж-ангижрахуй”)—DN 16.3 г.м.
Visuddhiyā (“ариусгах”)—DN 2.3.2 г.м.
Vitakka (“зурвас-бодол”)—DN 2.4.11 г.м.
Viveka (“ганцаар-ахуй”)—DN 2.4.1 г.м.

НОМ ЗҮЙ

Доорх ном зүй нь энэхүү орчуулгын ажилд бодитоор ашигласан болон судалгааны үүднээс зайлшгүй лавлах чанартай эх сурвалжийг хамруулсан болно. Ном зүйг олон улсын Буддын судлалд түгээмэл хэрэглэгддэг *Chicago Manual of Style 17th edition* хэв маягт ойртуулан, уншигч болон судлаачдад хялбар лавлагаа болохоор эмхтгэв.

Паали Эх Сурвалж

Anderson, D., and H. Smith, eds. *Sutta Nipāta*. London: Pali Text Society, 1990.

Dhamma Society Fund, ed. *Dīgha Nikāya*. World Tipiṭaka Mahāsaṅgīti ed. 3 vols. Bangkok: M.L. Maniratana Bunnag Dhamma Society Fund, 2002.

Dhamma Society Fund, ed. *Mahāsaṅgīti Tipiṭaka*. 40 vols. Bangkok: M.L. Maniratana Bunnag Dhamma Society Fund, 2002.

Dīgha Nikāya. Chaṭṭha Saṅgāyana ed. 6 vols. Rangoon: Government of the Union of Burma, 1956.

Feer, Léon, ed. *Saṃyutta Nikāya*. 5 vols. London: Pali Text Society, 1884–1898.

Khuddaka Nikāya. London: Pali Text Society, 1881–present.

Morris, R., and E. Hardy, eds. *Aṅguttara Nikāya*. 5 vols. London: Pali Text Society, 1885–1910.

Oldenberg, Hermann, ed. *Vinaya Piṭaka*. 5 vols. London: Pali Text Society, 1879–1883.

Rhys Davids, T. W., and J. E. Carpenter, eds. *Dīgha Nikāya*. 3 vols. London: Pali Text Society, 1890–1911.

Trenckner, V., Robert Chalmers, and E. Hardy, eds. *Majjhima Nikāya*. 3 vols. London: Pali Text Society, 1888–1922.

von Hinüber, O., and K. R. Norman, eds. *Dhammapada*. London: Pali Text Society, 1994.

Англи Орчуулга

Bodhi, Bhikkhu, trans. *The Great Discourse on Causation: The Mahānidāna Sutta and Its Commentaries*. Kandy: Buddhist Publication Society, 1984.

Bodhi, Bhikkhu, trans. *The Discourse on the All-Embracing Net of Views: The Brahmajāla Sutta and Its Commentaries*. Kandy: Buddhist Publication Society, 1989.

Myanmar Pitaka Association. *Ten Suttas from Dīgha Nikāya: Collection of Long Discourses of the Buddha*. Myanmar Ministry of Religious Affairs and Culture, 2010.

Ñāṇamoli, Bhikkhu, & Bhikkhu Bodhi, trans. *The Middle Length Discourses of the Buddha: A Translation of the Majjhima Nikāya*. Boston: Wisdom Publications, 1995.

Rhys Davids, T. W., & C. A. F. Rhys Davids, trans. *Dialogues of the Buddha*. 3 vols. London: Pali Text Society, 1899–1921.

Sujato, Bhikkhu, trans. *The Long Discourses of the Buddha*. SuttaCentral, 2018–2024. https://suttacentral.net/dn

Ṭhānissaro, Bhikkhu, trans. *Dīgha Nikāya Translations*. Dhamma Talks, 2019–. https://www.dhammatalks.org/suttas/DN/index.html

Walshe, Maurice, trans. *The Long Discourses of the Buddha: A Translation of the Dīgha Nikāya*. Boston: Wisdom Publications, 1987. Revised edition 1995.

Судалгааны болон Тайлбар Бүтээл

Anālayo, Bhikkhu. *Satipaṭṭhāna: The Direct Path to Realization*. Birmingham: Windhorse Publications, 2003.

Buddhadatta, A. P. Mahāthera. *Concise Pāli-English Dictionary*. Colombo: The Colombo Apothecaries' Co., Ltd., 1957.

Buddhaghosa. *Sumaṅgalavilāsinī: Buddhaghosa's Commentary on the Dīgha Nikāya*. Vol. 1. Edited by T. W. Rhys Davids and J. Estlin Carpenter. 2nd ed. London: Pali Text Society, 1968.

Buddhaghosa. *Visuddhimagga*. Edited by Henry Clarke Warren. Cambridge, MA: Harvard University Press, 1950.

Buddhavaṃsa. *In The Minor Anthologies of the Pali Canon* (Khuddaka Nikāya), Part III. Translated by Bhikkhu Ñāṇamoli. London: Pali Text Society, 1975.

Cousins, L. S. "The Dating of the Historical Buddha." *Journal of the Royal Asiatic Society* 6, no. 1 (1996): 57–63.

Gethin, Rupert. *The Foundations of Buddhism*. Oxford: Oxford University Press, 1998.

Harvey, Peter. *An Introduction to Buddhism: Teachings, History and Practices*. 2nd ed. Cambridge: Cambridge University Press, 2013.

Ñāṇamoli, Bhikkhu. *A Pali-English Glossary of Buddhist Technical Terms.* Edited by Bhikkhu Bodhi. Kandy: Buddhist Publication Society, 1994.

Ñāṇamoli, Bhikkhu, trans. *The Path of Purification (Visuddhimagga).* Kandy: Buddhist Publication Society, 1975.

Norman, K. R. *Pāli Literature: Including the Canonical Literature in Prakrit and Sanskrit*. Wiesbaden: Otto Harrassowitz, 1983.

Thanissaro, Bhikkhu. *The Wings to Awakening: An Anthology from the Pali Canon*. Valley Center, CA: Dhamma Dana Publications, 1996.

Цахим Эх Сурвалж

Access to Insight. https://www.accesstoinsight.org

SuttaCentral. https://suttacentral.net
(Паали эхүүд болон орчин цагийн олон хэл дээрх орчуулгуудыг харьцуулан ашиглав.)

Vipassanā Research Institute. *Chaṭṭha Saṅgāyana Tipiṭaka* (CSCD). Yangon. https://www.tipitaka.org/

Тайлбар

Энэхүү ном зүй нь бүрэн хэмжээний, Буддын судлалын ерөнхий ном зүй бус, харин уг орчуулгын ажилд бодитоор ашигласан болон судалгааны хувьд зайлшгүй холбогдох эхүүдийн жагсаалт болно. Цаашид хэвлэмэл ном хэлбэрээр нийтлэх тохиолдолд ном зүйг өргөтгөн боловсруулах боломжтой.

ТӨГСГӨЛ ҮГ

Энэ орчуулгыг хийгч миний бие Theravāda Buddhism буюу эртний буддын уламжлал ёсоор буддын дээд сахил авч хувраг (*bhikkhu*) болсон нэгэн бөгөөд Мьянмар, Шри Ланка болон Тайланд зэрэг улсуудын буддын бясалгалын хийдэд шавилан сууж *samādhi* болон *vipassanā* бясалгал, Буддагийн заасан үнэн ном сургаалыг үзэж судлах ховор завшаан энэ насанд тохиосон билээ.

Нийслэлийн ерөнхий боловсролын I сургуульд орос хэл, МУИС-ийн ОУХДС-д герман хэл, АНУ болон Австрали улсад 10 гаруй жил сурч амьдран англи хэл үзсэн явдал маань Энэтхэг-Европ хэлний язгуур болох паали хэлийг анхлан судлахад багагүй суурь болж өгсөн юм. Цаашилбал Мьянмар улсын Олон Улсын Тхераваада Номлогчийн Их Сургууль (ITBMU), Шан Мужийн Буддын Их Сургууль (SSBU) болон Шри Ланк улсын Буддын Ухааны Ахисан Түвшний Паали Институт (PGIPBS)-ийн бакалаврын дараах түвшний сургалтуудыг амжилттай дүүргэж, паали болон самгарди хэлний талаарх ойлголттой болсон билээ. Мөн эдгээр нэр хүндтэй сургуулиудад сурах болсон завшаан маань уг орчуулгыг хийхэд нэмж судлах хэрэгтэй, нарийн түвшинд ухан ойлгох шаардлагатай судар ном болон арвин туршлагатай багш нар, өргөн мэдлэгтэй эрдэмтэн судлаачдын санал зөвлөмжтэй ойртуулж өгсөн юм.

Энэхүү Арван Судар орчуулгад байгаа үгийн сонголт, өгүүлбэрийн тогтолцоо, найруулга зүй зэрэгтэй санал нийлэхгүй байх, эдгээрт сэтгэл ханамжгүй байх, эсвэл утгын зөрүүтэй, орчуулгын алдаатай гэж үзэх байр суурь байж болно гэдгийг орчуулагчийн зүгээс хүлээн зөвшөөрч, ойлгож тунгаах болно гэдгээ энд тэмдэглэн хэлэх нь зүйн хэрэг болно. Судлаач орчуулагч хийгээд дээд сахилтай хувраг хүний хувьд уг номыг орчуулахдаа, санаатайгаар гаргасан алдаа гуйвуулга, ариун бус сэтгэлийн үүднээс утга санааг ташааруулсан сэдэл үгүй болно.

Хэдийгээр энэ Арван Судар номын зохиогчийн эрх бол бүх эрх нь нээлттэй (© CC0 1.0 Universal) боловч, хэрэв та үүнийг их хэмжээгээр цаасан байдлаар хэвлэж ашгийн болон ашгийн бус үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа бол орчуулагчид үүнийгээ мэдэгдвэл талархалтай хүлээж авах болно.

Та Буддагийн заасан энэ номоос багахан ч атугай зүйлийг ойлгон авч, энд заасан зүйлсийг хэзээ гэнэт дуусахыг хэн ч үл мэдэх энэхэн богинохон амьдралдаа амжиж багтаад, яг өөрийн бие дээрээ үйлдэж, сахиж, дадуулж, бясалгаж, энэ насандаа амжиж төгс ангижралын ухаарлыг олох болтугай гэж ерөөгөөд энэ номыг өндөрлөе.

Buddhasāsanaṃ Ciraṃ Tiṭṭhatu!

Buddhasāsanaṃ Ciraṃ Tiṭṭhatu!

Buddhasāsanaṃ Ciraṃ Tiṭṭhatu!

ХОЛБООС

Хуврагг Жавана Ньяана
(Bhikkhu Javana Ñāṇa)

Shan State Buddhist University

Академик холбоос:
ORCID ID: 0009-0000-6271-4162
https://orcid.org/0009-0000-6271-4162

Судалгааны ажил болон номын орчуулгатай холбоотой асуудлаар ORCID профайлаар дамжуулан холбогдох боломжтой.